БҮС НУТГИЙН УЛААН ДАНСНЫ ЦУВРАЛ

МОНГОЛ ОРНЫ ХӨХТӨН АМЬТНЫ УЛААН ДАНС БА ХАМГААЛАЛ

(Хоёрдугаар хэвлэл)








МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ

WWF

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ 1942

ЭРДЭМ

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛЬ 1951



Захиалагч:

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ

Санхүүжүүлэн зохион байгуулж, гүйцэтгэсэн:

ДЭЛХИЙН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ САН (WWF)-ИЙН МОНГОЛ ДАХЬ ХӨТӨЛБӨРИЙН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛЬ

МОНГОЛ ОРНЫ ХӨХТӨН АМЬТНЫ УЛААН ДАНС БА ХАМГААЛАЛ

Хоёрдугаар хэвлэл

Боть 17

Улаанбаатар 2025

Захиалсан: БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ

Санхүүжүүлсэн: ДЭЛХИЙН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ САН (WWF)-ИЙН МОНГОЛ ДАХЬ ХӨТӨЛБӨРИЙН ГАЗАР

Гүйцэтгэсэн: МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ, ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ, МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛЬ, ДЭЛХИЙН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ САН (WWF)-ИЙН МОНГОЛ ДАХЬ ХӨТӨЛБӨРИЙН ГАЗАР

Зохиогчид:
Лхагвасүрэн, Д., Батсайхан, Н., Шар, С., Ундрахбаяр, Э., Самъяа, Р. 2025. Жижиг хөхтөн;

Ариунболд, Ж., Мөнхнаст, Д., Батсайхан, Н., Dolch, D., Stubbe, M. 2025. Гар далавчтан;

Мөнхцог, Б., Мөнхзул, Ц., Наранбаатар, Г., Баясгалан, А., Дэлгэрчимэг, Д., Довчиндорж, Г., Цэрэннадмид, М., Александр, Ж.Ш., Гантулга, Б., Баяраа, М., Баттогтох, Н., Ууганбаяр, Г. 2025. Мах идэштэн;

Адъяа, Ян., Энхмаа., Э., Бүүвэйбаатар, Б., Адъяа, Яд., Амгалан, Л., Мөнхтогтох, О., Амгаланбаатар, С., Магсаржав, Э., Чимиддорж, Б. 2025. Туурган;

Гомбобаатар, С., Өсөхжаргал, Д., Пүрэвсүрэн, С., Лхагвасүрэн, Д., Ариунболд, Ж., Мөнхцог, Б., Адъяа, Ян. (эмхэтгэсэн). 2025. *Монгол орны хөхтөн амьтны улаан данс ба хамгаалал.* Хоёрдугаар хэвлэл. Боть 17. Монгол Улсын Их Сургууль, Дэлхийн Байгаль Хамгаалах Сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн Яам. Улаанбаатар хот, Монгол Улс.

ДАА: 590
ННА: 28.6
М-692
ISBN: 978-9919-9323-4-3

Зүйлүүдийн үнэлгээ хийсэн
(цагаан толгойн үсэг дарааллаар):

Яд.Адьяа	2.9, 2.10
Ян.Адъяа	3.31
Л.Амгалан	3.32
С.Амгаланбаатар	3.9
Л.Анхбаяр	2.7
Н.Анхзаяа	2.6
Х.Ариунбуян	3.28
Ж.Ариунболд	3.1, 3.10, 3.11, 4.12-4.20, 4.80-4.83, 4.94-4.97
Ж.Ш.Александр	2.5
С.Батдорж	3.29
Ц.Батзаяа	2.6
Н.Батсайхан	2.3, 3.2-3.4, 3.12-3.20, 3.30, 4.1-4.11, 4.21-4.69, 4.78, 4.79, 4.84-4.92
М.Баяраа	2.5
А.Баясгалан	2.2, 3.24
Б.Бүүвэйбаатар	2.8, 3.8, 3.28, 3.32
П.Бямбадорж	3.9
О.Ганбаатар	2.6, 3.26, 3.28
Б.Гантулга	2.5, 2.8, 4.77
С.Далайцэрэн	2.6
Ц.Дашпүрэв	2.6
Г.Довчиндорж	2.4, 2.9, 3.5, 3.27, 3.30
Д.Дэлгэрчимэг	2.2, 3.24
Д.Лхагвасүрэн	2.3, 2.7, 3.2-3.4, 3.12-3.20, 4.1-4.11, 4.21-4.69, 4.78, 4.79, 4.84-4.92
Э.Магсаржав	3.33
Б.Мижиддорж	2.2
Ц.Мөнхбат	2.6
Ц.Мөнхзул	3.21, 3.22, 3.25
Д.Мөнхнаст	3.1, 3.10, 3.11, 4.12-4.20, 4.80-4.83, 4.94-4.97
О.Мөнхтогтох	3.9
Б.Мөнхцог	2.1, 3.6, 4.70-4.77, 4.93
Г.Наранбаатар	2.10, 2.11, 3.24, 3.26,
Э.Нарангарав	2.6
Д.Өсөхжаргал	2.6
С.Пүрэвсүрэн	1.1, 2.2, 2.7, 2.11, 3.6, 3.7, 3.28, 3.33
Р.Самъяа	1.2, 1.3, 2.3, 3.2-3.4, 3.12-3.20, 4.1-4.11, 4.21-4.69, 4.78, 4.79, 4.84-4.92
М.Тамир	3.29
Х.Тунгалагтуяа	3.23
Ж.Төмөрсүх	2.10
Э.Ундрахбаяр	2.3, 3.2-3.4, 3.12-3.20, 4.1-4.11, 4.21-4.69, 4.78, 4.79, 4.84-4.92
Г.Ууганбаяр	3.23
М.Цэрэннадмид	2.5
Б.Чимэддорж	2.8
Б.Чойдогжамц	3.26
С.Шар	2.3, 3.2-3.4, 3.12-3.20, 4.1-4.11, 4.21-4.69, 4.78, 4.79, 4.84-4.92
Д.Энхбилэг	2.9, 2.11
Э.Энхмаа	3.8

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Ерөнхий редактор: Р.Самъяа, Ян.Адъяа, С.Гомбобаатар, Д.Батболд, Ц.Уранчимэг

Бүлгийн редактор: Р.Самъяа, С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал

Зүйлийн тархцын зургийг боловсруулсан:
С.Гомбобаатар, Д.Лхагвасүрэн, Д.Өсөхжаргал, Ж.Номундарь, Б.Гантулга

Хавтас, хавчуулга зураг © Б.Мөнхзориг/ДБХС, Р.Самъяа, ДБХС/Б.Гантулга

Гэрэл зураг:
Яд.Адъяа © *цаа буга*
С.Амгаланбаатар © *аргаль*
Ж.Ариунболд © *Амарын багваахай, сүүлэрхэг багваахай, борхон турсаахай, Уссурын сахалт багваахай, саарал соотон багваахай, Алашань турсаахай, сартгар хамарт багваахай, Стрелковын соотон багваахай, Туркмен соотон багваахай, хожуу сармаахай, шовхчихт багваахай*
Н.Батсайхан © *Дагуур огдой, хээрийн солонго, бараан хэрэм, дорнын сохдой, сохдой оготно, бозлог зурам, говийн алагдаахай, Дагуур зараа, Дагуур зурам, Козловын атигдаахай, Монгол даахай, ойн хөвхөлжин, өвхөн сүүлт атигдаахай, өргөвөнч оготно, сухайн чичүүл, Тува барагчин, хадны барагчин, урт сүүлт шишүүхэй, үлийн цагаан оготно, хөхөр олби, цомч шишүүхэй, шар ов, цөлийн алагдаахай, ширгийн оготно, элсний зусаг, хадны суусар*
С.Вандандорж © *бэсрэг атаахай*
Б.Гантулга © *ирвэс, Монгол бөхөн, цагаан зээр, жирх, цагаан үен, хулан, чандага туулай, бор туулай, мануул, хар сүүлт зээр, янгир, Дагуур огдой, асганы огдой, тагийн огдой, дорнын хандгай, хавтгай, Монгол чичүүл, шар чичүүл, голын халиу, тахь, мангис дорго, умардын оготно*
С.Гомбобаатар © *монгол тарвага, Алтайн тарвага, сүүлэрхэг зурам, хотны үен, хүдэр, бор гөрөөс, аргаль, янгир, шивэр алагдаахай*
Д.Дэлгэрчимэг © *мазаалай баавгай*
Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар © *хүрэн баавгай, нохой зээх, шивэр хандгай, саарал чоно*
Г.Жаргалсайхан © *ойн булга, халздай дорго*
Х.Золбоо © *халздай дорго*
Д.Лхагвасүрэн © *Азийн малтаахай, гозоорой зурам, зүлгийн оготно, соотон алагдаахай, Зүүнгарын даахай, нугын малтаахай, Азийн хулгана, Монгол огдой, урт сүүлт шишүүхэй, Дагуур номин, мэхээрч оготно, ойн улаан оготно, ойн хүрэн оготно, орог зусаг, Соён барагчин, тавшгар барагчин, таван хуруут атигдаахай, Төвөд ов, хөх шишүүхэй, хэрэлзий оготно, хээрийн хулгана, зэгэл алагдаагаанцар, ойн унтаахай, ойн хулгана, савагдаахай*
Д.Мөнхнаст © *хээрийн сахалт багваахай, Дорнодын уссаг багваахай, бор соотон багваахай, буурал сармаахай, Дорнын сармаахай, умрын сарсаахай, говийн сармаахай*
Р.Самъяа © *Азийн минж, бор туулай, цоохондой, морин чичүүл, Говь-Алтайн барагчин*
Г.Уганбаяр © *хярс, шилүүс, цагаан үен, саарал чоно*
Д.Өсөхжаргал © *халиун буга*
Г.Хүдэрчулуун © *Хэнтийн огдой, чандага туулай*
Б.Чимэддорж © *эрээн хүрнэ*
С.Шар © *Соколовын шишүүхэй, дэлдэн зараа, цармын атаахай, тавшгар атаахай, дэлдэн зараа, бор шишүүхэй, Монгол оготно, чигчий хулгана*
Д.Энх-Оргил © *зэрлэг гахай, аргаль*
E.Grimmberger © *давжаа алагдаахай, усч оготно, хөх ов, бараан оготно, хэвлүүн атаахай*
T.Kachanovskaya © *Алтайн чацуулин*
J. van der Kooij © *тэгш шүдэт атаахай, усч гэрэлзгэнэ, дааган атаахай, Иконниковын багваахай*
G.Leithaus © *Манжуур номин*
P.Morris © *загал элбэнх*
K.Rudloff © *үлийн бор оготно, ойн солонго*
M.Stubbe © *бүрэнхийн хонгор багваахай*
V.Yukas © *өвдсөн атаахай*
цөөвөр чонын зургийг simple-fauna.ru сайтаас

Түлхүүр үг:
Монгол, хөхтөн, улаан данс, хамгааллын төлөвлөгөө, үнэлгээ, ховордлын зэрэглэл, хамгаалал.

Бүлэг эшлэх:
Лхагвасүрэн, Д., Батсайхан, Н., Шар, С., Ундрахбаяр, Э., Самъяа, Р. 2025. Жижиг хөхтөн. *Монгол орны хөхтөн амьтны улаан данс ба хамгаалал.* Хоёрдугаар хэвлэл. Боть 17. Монгол Улсын Их Сургууль, Дэлхийн Байгаль Хамгаалах Сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн Яам. Улаанбаатар хот, Монгол Улс.

Ариунболд, Ж., Мөнхнаст, Д., Батсайхан, Н., Dolch, D., Stubbe, M. 2025. Гар далавчтан. *Монгол орны хөхтөн амьтны улаан данс ба хамгаалал.* Хоёрдугаар хэвлэл. Боть 17. Монгол Улсын Их Сургууль, Дэлхийн Байгаль Хамгаалах Сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн Яам. Улаанбаатар хот, Монгол Улс.

Мөнхцог, Б., Мөнхзул, Ц., Наранбаатар, Г., Баясгалан, А., Дэлгэрчимэг, Д., Довчиндорж, Г., Цэрэннадмид, М., Александр, Ж.Ш., Гантулга, Б., Баяраа, М., Баттогтох, Н., Уганбаяр, Г. 2025. Мах идэштэн. *Монгол орны хөхтөн амьтны улаан данс ба хамгаалал.* Хоёрдугаар хэвлэл. Боть 17. Монгол Улсын Их Сургууль, Дэлхийн Байгаль Хамгаалах Сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн Яам. Улаанбаатар хот, Монгол Улс.

Адъяа, Ян., Энхмаа., Э., Бүүвэйбаатар, Б., Адъяа, Яд., Амгалан, Л., Мөнхтогтох, О., Амгаланбаатар, С., Магсаржав, Э., Чимиддорж, Б. 2025. Тууртан. *Монгол орны хөхтөн амьтны улаан данс ба хамгаалал.* Хоёрдугаар хэвлэл. Боть 17. Монгол Улсын Их Сургууль, Дэлхийн Байгаль Хамгаалах Сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн Яам. Улаанбаатар хот, Монгол Улс.

Зүйл эшлэх загвар:
Лхагвасүрэн, Д., Шар, С., Батсайхан, Н., Ундрахбаяр, Э., Самъяа, Р. 2025. **Ойн хулгана.** *Монгол орны хөхтөн амьтны Улаан данс ба хамгаалал.* Хоёрдугаар хэвлэл. Боть 17. Монгол Улсын Их Сургууль, Дэлхийн Байгаль Хамгаалах Сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн Яам. Улаанбаатар хот, Монгол Улс.

Боть эшлэх:
Гомбобаатар, С., Өсөхжаргал, Д., Пүрэвсүрэн, С., Лхагвасүрэн, Д., Ариунболд, Ж., Мөнхцог, Б., Адъяа, Ян. (эмхэтгэсэн). 2025. *Монгол орны хөхтөн амьтны улаан данс ба хамгаалал.* Хоёрдугаар хэвлэл. Боть 17. Монгол Улсын Их Сургууль, Дэлхийн Байгаль Хамгаалах Сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн Яам. Улаанбаатар хот, Монгол Улс.

Зохиогчийн эрх:
© Монгол Улсын Их Сургууль
© Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн Яам
© Дэлхийн байгаль хамгаалах сан
(WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар

©2025. Зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан бөгөөд уг номыг худалдан борлуулахыг хориглоно. Сургалт, судалгаа, хамгаалал, сурталчилгааны чиглэлээр ашгийн бус зорилгоор эх сурвалжийг дурдаж, талархал илэрхийлэн ашиглаж болох ба зураг, газрын зураг, бичвэр, номын агуулга, бүтцийг олон нийтийн сүлжээнд байршуулах, онлайн болон оффлайн аппликейшн, бусад платформд ашиглах, зөвлөх үйлчилгээ болон бусад зорилгоор ашиглахдаа зохиогч, зохиогчийн эрх бүхий байгууллагуудаас ашиглах эсэх тухай зөвшөөрөл заавал авна. Дээрх болон бусад зорилгоор ашиглуулах, зохиогчийн эрхийн асуудлыг оролцогч талууд хамтран шийдвэрлэнэ.

Хандах хаяг:
Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Байгалийн ухааны салбарын Биологийн тэнхим
Профессор С.Гомбобаатар
Утас: +(976)-90112244
Цахим шуудан: gomboo@num.edu.mn

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар
Хаяг: Интер оффис, Амарын гудамж-4, 8-р хороо, СБД, Улаанбаатар хот 14200
Утас: +(976)-11-311659
Цахим шуудан: info@wwf.mn
Вэбсайт: https://mongolia.panda.org

Энэ ном нь цөөн тоогоор хэвлэгдсэн бөгөөд цахим хувилбарыг Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газрын дээрх вэбсайтаас үнэ төлбөргүй татаж авна уу.



ГАРЧИГ

УДИРТГАЛ 8
ӨМНӨХ ҮГ 9
ТАЛАРХАЛ 10

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. МОНГОЛ ОРНЫ ХӨХТӨН АМЬТДЫН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ХОВОРДЛЫН ШАЛТГААН 12
1.1. Танилцуулга ба тайлбар 13
1.2. Монгол орны хөхтөн амьтдын өнөөгийн төлөв байдал 27
1.3. Монгол орны хөхтөн амьтны зүйлүүдийн үнэлгээ ба ховордлын шалтгаан 28

ХОЁРДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ ОРНЫ УСТАЖ БАЙГАА (CR) БОЛОН УСТАЖ БОЛЗОШГҮЙ (EN) ХӨХТӨН АМЬТДЫН БИОЛОГИ, ЭКОЛОГИЙН ОНЦЛОГ, ХАМГААЛАЛ 37
2.1. Цөөвөр чоно 38
2.2. Мазаалай баавгай 40
2.3. Азийн минж 44
2.4. Голын халиу 48
2.5. Ирвэс 51
2.6. Тахь 57
2.7. Хүдэр 60
2.8. Монгол бөхөн 63
2.9. Хавтгай 68
2.10. Цаа буга 71
2.11. Хандгай 74

ГУРАВДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ ОРНЫ ЭМЗЭГ (VU) БОЛОН ХОВОРДОЖ БОЛЗОШГҮЙ (NT) ХӨХТӨН АМЬТДЫН БИОЛОГИ, ЭКОЛОГИЙН ОНЦЛОГ, ХАМГААЛАЛ 78
3.1. Амарын багваахай 79
3.2. Хэнтийн огдой 81
3.3. Монгол тарвага 83
3.4. Ойн унтаахай 86
3.5. Эрээн хүрнэ 88
3.6. Ойн булга 90
3.7. Мануул 93
3.8. Цагаан зээр 96
3.9. Аргаль 101
3.10. Сүүлэрхэг багваахай 105
3.11. Борхон турсаахай 107
3.12. Алтайн тарвага 109
3.13. Гозоорой зурам 112
3.14. Хөхвөр олби 114
3.15. Зүлгийн оготно 116
3.16. Соколовын шишүүхэй 118
3.17. Сухайн чичүүл 120
3.18. Ойн хулгана 122
3.19. Соотон алагдаахай 124
3.20. Зүүнгарын даахай 126
3.21. Хярс 128
3.22. Үнэг 131
3.23. Саарал чоно 133
3.24. Хүрэн баавгай 136
3.25. Халздай дорго 139
3.26. Шилүүс 141
3.27. Цоохондой 144
3.28. Хулан 146
3.29. Зэрлэг гахай 151
3.30. Бор гөрөөс 153
3.31. Халиун буга 156
3.32. Хар сүүлт зээр 160
3.33. Янгир 164

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. МОНГОЛ ОРНЫ АНХААРАЛД ӨРТӨХӨӨРГҮЙ (LC), МЭДЭЭЛЭЛ ДУТМАГ (DD) БОЛОН ҮНЭЛЭХ БОЛОМЖГҮЙ (NA) ХӨХТӨН АМЬТДЫН БИОЛОГИ, ЭКОЛОГИЙН ОНЦЛОГ, ХАМГААЛАЛ 169
4.1. Дагуур зараа 170
4.2. Дэлдэн зараа 172
4.3. Цармын атаахай 174
4.4. Дааган атаахай 176
4.5. Бэсрэг атаахай 178
4.6. Тэгш шүдэт атаахай 180
4.7. Өөдсөн атаахай 182
4.8. Тавшгар атаахай 184
4.9. Нугын малтаахай 186
4.10. Азийн малтаахай 188
4.11. Усч гэрэлзгэнэ 190
4.12. Хээрийн сахалт багваахай 192
4.13. Уссурын сахалт багваахай 194
4.14. Дорнодын уссаг багваахай 196
4.15. Саарал соотон багваахай 198
4.16. Бор соотон багваахай 200

4.17. Буурал сармаахай 202
4.18. Дорнын сармаахай 204
4.19. Умрын сарсаахай 206
4.20. Говийн сармаахай 208
4.21. Чандага туулай 210
4.22. Бор туулай 212
4.23. Дагуур огдой 214
4.24. Тагийн огдой 216
4.25. Асганы огдой 218
4.26. Монгол огдой 220
4.27. Сүүлэрхэг зурам 222
4.28. Бозлог зурам 224
4.29. Дагуур зурам 226
4.30. Жирх 228
4.31. Бараан хэрэм 230
4.32. Дагуур номин 232
4.33. Хэргэлзий оготно 234
4.34. Мэхээрч оготно 236
4.35. Өргөөнч оготно 238
4.36. Ширгийн оготно 240
4.37. Монгол оготно 242
4.38. Үлийн цагаан оготно 244
4.39. Ойн хүрэн оготно 246
4.40. Ойн улаан оготно 248
4.41. Ойн хөвхөлжин 250
4.42. Хадны барагчин 252
4.43. Соён барагчин 254
4.44. Тавшгар барагчин 256
4.45. Говь-Алтайн барагчин 258
4.46. Тува барагчин 260
4.47. Шар ов 262
4.48. Төвөд ов 264
4.49. Сохдой оготно 266
4.50. Цомч шишүүхэй 268
4.51. Хөх шишүүхэй 270
4.52. Урт сүүлт шишүүхэй 272
4.53. Бор шишүүхэй 274
4.54. Орог зусаг 276
4.55. Элсний зусаг 278
4.56. Монгол чичүүл 280
4.57. Шар чичүүл 282
4.58. Морин чичүүл 284
4.59. Чигчий хулгана 286
4.60. Хээрийн хулгана 288
4.61. Азийн хулгана 290
4.62. Цөлийн алагдаахай 292
4.63. Говийн алагдаахай 294
4.64. Шивэр алагдаахай 296
4.65. Таван хуруут атигдаахай 298
4.66. Элсч савагдаахай 300
4.67. Зэгэл алагдааганцар 302
4.68. Өөхөн сүүлт атигдаахай 304
4.69. Монгол даахай 306
4.70. Загал элбэнх 308
4.71. Нохой зээх 310
4.72. Өмхий хүрнэ 312
4.73. Хотны үен 314
4.74. Цагаан үен 316
4.75. Ойн солонго 318
4.76. Хээрийн солонго 320
4.77. Хадны суусар 322
4.78. Хэвлүүн атаахай 324
4.79. Алтайн чацуулин 326
4.80. Сартгар хамарт багваахай 328
4.81. Иконниковын багваахай 330
4.82. Бүрэнхийн хонгор багваахай 332
4.83. Хожуу сармаахай 334
4.84. Манжуур номин 336
4.85. Умардын оготно 338
4.86. Бараан оготно 340
4.87. Үлийн бор оготно 342
4.88. Хөх ов 344
4.89. Усч оготно 346
4.90. Дорнын сохдой 348
4.91. Давжаа алагдаахай 350
4.92. Козловын атигдаахай 352
4.93. Мангис дорго 354
4.94. Шовхчихт багваахай 356
4.95. Стрелковын соотон багваахай 358
4.96. Туркмен соотон багваахай 360
4.97. Алашань турсаахай 362

ЭШ ТАТСАН БҮТЭЭЛ 364

ХАВСРАЛТ 396
Хавсралт 1. Дэлхийн байгаль хамгаалах холбоо (IUCN)-ны ховордлын зэрэглэлийн үнэлгээний товч тайлбар (IUCN, 2012) 396
Хавсралт 2. Монгол орны хөхтөн амьтны зүйлүүдийн үнэлгээний нэгтгэл 398

УДИРТГАЛ

Монгол орны Сибирийн тайгаас Төв Азийн хээр, говь цөл хүртэлх өндөр уулсын өвөрмөц систем, ус, намгархаг газар зэрэг экосистемийн нэн олон янз байдал нь 145 зүйл хөхтөн, 519 зүйл шувуу, 25 зүйл мөлхөгч, 7 зүйл хоёр нутагтан, 80 зүйл загас амьдрахад тааламжтай орчныг бүрдүүлдэг.

Дэлхий нийтээр биологийн олон янз байдлын хамгаалал, нийгэм, эдийн засаг, соёлын үнэ цэнийг тогтоох, тухайн экосистем дэх оролцоог тодруулах, шинжлэх ухааны өгөгдлийг цуглуулах, нэгтгэх, ховордлын зэрэглэлийг тогтоох, хамгааллын төлөвлөгөө боловсруулах зэрэг олон талын зорилгоор Дэлхийн байгаль хамгаалах холбоо (IUCN)-ны Улаан дансны шалгуур, аргачлалыг ашиглан зүйлүүдийг үнэлдэг.

Монгол Улсад анх 2006 онд Дэлхийн банк, Нидерландын Вант Улсын санхүүжилтээр үндэсний их, дээд сургуулиуд, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд, төрийн ба төрийн бус байгууллагын эрдэмтэн, судлаачид хамтран Монгол орны загас, хоёр нутагтан, мөлхөгчид болон хөхтөн амьтдын Улаан данс болон хамгааллын төлөвлөгөөг боловсруулж байсан билээ. Улмаар 2011 онд шувууны Улаан данс болон хамгааллын төлөвлөгөөг гаргаснаар манай улс Ази тивд нугаламт амьтдыг иж бүрнээр нь үнэлсэн анхны орон болсон юм. Үүнээс хойш гуурст ба гуурсгүй ургамлын Улаан данс, хамгааллын төлөвлөгөөг боловсруулж, олон нийтийн хүртээл болгосон.

Дээрх үнэлгээний үр дүнг үндэсний хууль эрх зүйн баримт бичигтэй уялдуулах, бодлого төлөвлөлтөд тусгах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж байгаа нь судалгаа шинжилгээний байгууллага, судлаачид болон төрийн захиргааны төв байгууллагын үр өгөөжтэй хамтын ажиллагааны тод илрэл юм.

Энэхүү хамтын ажиллагааны үр дүн нь Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогын зорилтыг хэрэгжүүлэх, олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэхэд чухал хувь нэмэр үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

Энэ удаагийн амьтны улаан дансны үнэлгээ нь 19 жилийн дараа шинэчлэгдэж байгаа гэдгээрээ онцлог бөгөөд Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газрын санхүүгийн дэмжлэг, МУИС, ШУА, МУБИС, бусад төрийн болон төрийн бус байгууллагын эрдэмтэн, судлаачдын хамтын хүчин чармайлтаар Монгол орны 76 зүйл загас, 7 зүйл хоёр нутагтан, 25 зүйл мөлхөгчид, 141 зүйл хөхтөн амьтны үнэлгээг шинэчлэн хийж, анги тус бүрээр нэгтгэсэн бүтээлийг гаргаж байна. Цаашид Дэлхийн байгаль хамгаалах холбооны жишгийн дагуу зургаан жил тутам үнэлгээг шинэчилж, хамгааллын шаардлагатай арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байх нь нэн чухал юм.

Байгаль, цаг уурын эрс тэс нөхцөлтэй, экологийн хувьд эмзэг бүсэд оршдог орны хувьд зэрлэг амьтны Улаан дансны үнэлгээг шинэчлэх нь төрийн бодлого, хууль эрх зүйн орчныг сайжруулах, биологийн олон янз байдлыг хамгаалах, нөхөн сэргээх арга замыг тодорхойлох, хүн ба байгаль зэрэгцэн оршихын ач холбогдлыг олон нийтэд ойлгуулахад үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт эргэлзэхгүй байна.

Энэ бүтээлийг боловсруулж, хамтран ажилласан бүх эрдэмтэн, судлаачид, олон улсын болон дотоодын байгууллагууд, хамт олонд гүн талархал илэрхийлье.

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД

Б.БАТБААТАР

ӨМНӨХ ҮГ

Монгол орны нутаг дэвсгэр баруунаас Алтай Саяны их уулс, хойноос умардын ой тайга, дорноос Монгол Дагуурын хээр, өмнөөс Төв Азийн их говь цөлийн уулзвар заагт оршдог нь экологи, байгаль, цаг уурын хувьд ялгаатай нөхцөлд зохицсон харьцангуй ялгаатай, бас өвөрмөц хөхтний зүйлийн баялаг бүрдлийг үүсгэжээ. Иймээс манай орны төдийгүй дэлхийд ховордсон, Төв Азийн уугуул, эртний ховордсон мах идэштэн, туурайтан, туруутан, гар далавчтан, мэрэгчдийн олон зүйлийн өлгий нутаг тул дэлхийн анхаарлыг татсаар байна.

Монгол Улс одоогоор 145 зүйлийн хөхтний зүйлийг бүртгээд байна. Судалгаа шинжилгээ эрчимжиж, манай орон болон хөрш орнуудад тархсан хөхтний ангилал зүйн судалгаа улам бүр нарийсаж, олон төрөл, зүйлийг салгаж, мөн нэгтгэн ангилж байна. Бас нийгэм, эдийн засгийн эрчимтэй хөгжил, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр хөрш улсаас манай оронд үзэгдээгүй амьтны зүйл бүртгэгдэж буй нь хөхтний зүйлийн бүрдэл байнга өөрчлөгдөх шалтгаан болж буй төдийгүй ер нь энэ чиглэлийн судалгааг илүү анхаарч, тогтмол гүйцэтгэж олон улсын хамтын ажиллагааг сайжруулах нь чухал юм. Олон улсын хамтын ажиллагааны үр дүнд байгальд устсан зэрлэг адуу болох тахийг 30 жилийн туршид сэргээн нутагшуулах ажлыг амжилттай хэрэгжүүлснээр олон улсын ховордлын зэрэглэлийг хоёроор бууруулж чадсан болон үндэсний эрдэмтэн судлаачид цагаан зээр, Монгол бөхөн, хавтгайг өсгөн үржүүлж, байгальд сэргээн нутагшуулах боломжтойг батлан харуулсан нь бусад орнуудад сургамж, үлгэр дуурайл болохын сацуу аливаа зүйлийг устахаас сэргийлэх арга хэмжээ, төлөвлөгөөг хэрэгжүүлэх бодит боломжтойг нотолсон.

Монгол Улс “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”, “Биологийн олон янз байдлын тухай конвенц (CBD)” болон бусад конвенцын гишүүн улс орны хувьд нийгэм, эдийн засгийн эрчимтэй хөгжлийн үед амьтны аймгийг судлах, хамгаалах, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэн, тулгарч буй бэрхшээлийг даван туулахад дэлхийн байгаль хамгаалах байгууллагуудын хамтын ажиллагаа нэн чухал. Үүний нэг илрэл бол биологийн зүйлийн үнэлгээг гүйцэтгэхэд Дэлхийн байгаль хамгаалах холбоотой хамтран, түүний үнэлгээ, шалгуурыг ашиглан Монгол орны хөхтөн амьтдын үнэлгээг 2006 оноос хойш гүйцэтгэж, мөн 2025 оноос хөхтний зүйлийн үнэлгээг үндэсний судлаачид хамтран дахин хийж буй үйл ажиллагаа мөн.

Монгол орны биологийн олон янз байдлын чухал бүрэлдэхүүн болсон хөхтний зүйлийн бүрэлдэхүүнийг Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан дансны шалгууруар үнэлж, үнэлгээнээс гарсан үр дүнд тулгуурлан зүйлийн хамгааллын төлөвлөгөөг шинэчлэн боловсруулахад олон улсын байгууллагууд, их дээд сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэмтэн, судлаачид хамтран ажиллаж, эх орныхоо байгалийн баялаг, биологийн олон янз байдлын хамгааллын нөхцөл байдлыг дахин нэгэн шатаар ахиулж, үнэ цэнтэй мэдлэгийг бүтээж байгааг дахин дурдмаар байна.

Монгол орны хөхтний зүйлийн үнэлгээ, хамгааллын хөтөлбөр болох энэхүү бүтээл нь манай улсын төдийгүй хөрш орны хөхтөн амьтны төлөв байдлыг шинэ зууны хөгжилд нийцүүлэн сайжруулахад суурь болно гэдэгт эргэлзэхгүй байна.

Монгол орны хөхтөн амьтдын үнэлгээг дахин хийх ажлыг санхүүжүүлж, зохион байгуулсан Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газрын хамт олон, ажлыг захиалж, бодлогоор дэмжин гүйцэтгүүлж буй Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн Яам, амжилттай хэрэгжүүлж буй МУИС, ШУА, МУБИС-ийн эрдэмтэн багш нар, хамтран гүйцэтгэсэн үндэсний болон олон улсын судлаачдад гүн талархал илэрхийлье.

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН БИОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН
ПРОФЕССОР С. ДУЛАМЦЭРЭН

ТАЛАРХАЛ

Энэхүү “Монгол орны хөхтөн амьтны Улаан данс ба хамгаалал” ном нь Монголын орны хөхтөн судлаачдын биет оролцоо, дэмжлэггүйгээр гарах боломжгүй бөгөөд олон судлаачдын хамтын бүтээл юм.

Тус бүтээлд өөрсдийн олон жилийн судалгаа, шинжилгээний ажлын үр дүн, оюун ухаан, мэдлэг туршлага, үнэт цагаа сэтгэл харамгүй зарцуулж өмнөх болоод өнөө үеийн эрдэмтэн, судлаачдын судалгааны ажил, бүтээлүүдийг шүүн судалж, зүйлийн бичиглэлийг боловсруулан, үнэлгээг хийж, нэгтгэн танилцуулсан (цагаан толгойн үсэг дарааллаар) Яд. Адьяа, Ян.Адъяа, Л.Амгалан, С.Амгаланбаатар, Л.Анхбаяр, Н.Анхзаяа, Х.Ариунбуян, Ж.Ариунболд, Ц.Батзаяа, Н.Батсайхан, М.Баяраа, А.Баясгалан, Б.Бүүвэйбаатар, П.Бямбадорж, О.Ганбаатар, Б.Гантулга, С.Далайцэрэн, Ц.Дашпүрэв, Г.Довчиндорж, Д.Дэлгэрчимэг, Д.Лхагвасүрэн, Б.Мижиддорж, Ц.Мөнхбат, Ц.Мөнхзул, Д.Мөнхнаст, О.Мөнхтогтох, Б.Мөнхцог, Г.Наранбаатар, Э.Нарангарав, Д.Өсөхжаргал, С.Пүрэвсүрэн, Р.Самъяа, Х.Тунгалагтуяа, Ж.Төмөрсүх, Э.Ундрахбаяр, Г.Уганбаяр, М.Цэрэннадмид, Б.Чимэддорж, Б.Чойдогжамц, С.Шар, Д.Энхбилэг, Э.Энхмаа, J.S.Alexander, D.Dolch, профессор M.Stubbe нарт болон бүлгийг удирдаж, үнэлгээг хянасан доктор Ж.Ариунболд (гар далавчтан), доктор Д.Лхагвасүрэн (жижиг хөхтөн), доктор (Sc.D) Ян.Адъяа (туруутан), доктор Б.Мөнхцог (мах идэштэн), Л.Пүрэвжав, улаан дансны зэрэглэл, шалгуур, үнэлгээ, бичвэрийг хянасан профессор С.Гомбобаатар, доктор Д.Өсөхжаргал нарт онцгойлон талархал илэрхийлье.

Мөн Монгол орны хөхтөн амьтдын зүйлийн тархцын зургийг боловсруулах нарийн чимхлүүр ажлыг нягт нямбай гүйцэтгэсэн Ж.Номундарь, профессор С.Гомбобаатар, доктор Д.Өсөхжаргал, Б.Гантулга нарт баярлалаа.

Өөрсдийн олон жилийн хүч, хөдөлмөр, үнэт цагаа зарцуулан, сэтгэл оюунаа чилээн байж буулгасан, олдоц ховортой зүйлүүдийн гэрэл зургаа харамгүй хандивласан нэр бүхий эрдэмтэн, судлаач, гэрэл зураг сонирхогч нарт их баярлалаа.

Монгол орны хөхтөн амьтны Улаан данс ба хамгаалал бүтээлийг дэмжин ажилласан дараах байгууллагууд болон хамт олонд чин сэтгэлийн талархал илэрхийлье. Үүнд:

Монгол Улсын Их Сургууль (МУИС). Төрийн болон төрийн бус байгууллагуудын эрдэмтэн, судлаачдын хамтын ажиллагааг хангаж, удирдан зохион байгуулсан, тус төслийн удирдагч МУИС-ийн Судалгаа, хамтын ажиллагаа эрхэлсэн проректор, профессор С.Гомбобаатар, уг бүтээлийн хөхтөн амьтдын өнөөгийн төлөв байдал, ховордлын шалтгааныг нэгтгэн дүгнэсэн профессор Р.Самьяа, жижигхөхтөн амьтдыг хянан нягталсан доктор С.Шар, энэ төслийн хүрээнд шат дараатай нэгдсэн болоод бүлгийн уулзалт, хэлэлцүүлгүүдийг амжилттай зохион байгуулж, арга аргачлал, заавар мэдээллээр хангаж, зүйлийн бичвэрүүдийг нэгтгэж, хянасан МУИС-ийн Биологийн тэнхимийн багш, доктор Д.Өсөхжаргал, дэд профессор Д.Нарангарвуу, С.Сайнзаяа, Ш.Мягмарсүрэн, Т.Батчулуун, Степ форвард хөтөлбөр, уулзалт хэлэлцүүлгүүдийг зохион байгуулах бүхий л боломжоор хангаж, хамтран ажилласан тус сургууль болон нэр бүхий тэнхимийн нийт хамт олонд,

Шинжлэх Ухааны Академи (ШУА). Монгол орны хөхтөн амьтдыг улаан дансны зэрэглэл, шалгууруар үнэлэх, хэлэлцэх, нэгтгэн боловсруулах бүхий л үе шатны үйл ажиллагааг дэмжиж, арвин их мэдлэг туршлагаа хуваалцаж, идэвхтэй оролцсон ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн нийт хамт олонд,

Монгол Улсын Боловсролын Их Сургууль (МУБИС). Тус бүтээлд онцгой ач холбогдол өгч, эрдэмтэн, багш нараа өргөнөөр оролцуулж, хэлэлцүүлэг өрнүүлж, мэдлэг туршлагаа хуваалцан, идэвхтэй хамтран ажилласанд,

Дэлхийн байгаль хамгаалах холбоо (IUCN). Уг номыг туурвихад шаардлагатай холбогдох мэдээ, материал, шалгуур болон мэдээллийн санг ашиглах боломж олгож, техникийн туслалцаа үзүүлсэнд,

Хөдөө Аж Ахуйн Их Сургууль, Байгалийн түүхийн музей, Байгаль, зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг (WCS)-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар, Хустайн байгалийн цогцолборт газар, Монголын шувуу судлалын нийгэмлэг, Ирвэс хамгаалах сан, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Монголын ирвэс төв, Монголын гар далавчтан судлах төв, Монгол орны хөхтөн судлалын нийгэмлэг зэрэг байгууллага, хамт олонд тус төслийн үйл ажиллагааг дэмжиж, уулзалт, хэлэлцүүлгүүдэд зохион байгуулалттайгаар идэвх, санаачилгатай оролцож, арвин их мэдлэг туршлагаа хуваалцаж бүхий л үе шатанд хамтран ажилласанд гүн талархал илэрхийлж байна.

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар. Монгол орны хөхтөн амьтдыг улаан дансны зэрэглэл, шалгуураар дахин үнэлж, хамгаалах арга хэмжээг шинэчлэн боловсруулах санаачилгыг гаргаж, 2012 оноос хойш хөрөнгө мөнгө босгох нөр их ажил дээр хичээнгүйлэн зүтгэж, тус ажлын санхүүжилтийг бий болгож, зохион байгуулсан тус хөтөлбөрийн газрын захирал Д.Батболд, Байгаль хамгааллын захирал Б.Чимэддорж, доктор Б.Гантулга, мөн тус бүтээлийг “Монгол орны хөхтөн амьтны Улаан данс ба хамгаалал” хэмээн нэрийдэж энэ номын болон зүйлийн бичиглэлийн агуулга, чиглэлийг боловсруулах, нэгтгэн хянаж сайжруулах, хэвлэлд бэлтгэх зэргийг бүхий л үе шатанд хариуцан ажилласан зөвлөх С.Пүрэвсүрэн, ажилтан Б.Гантулга болон тус байгууллагын нийт хамт олонд тусгайлан талархсанаа илэрхийлье.

Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн Яам (БОУАӨЯ). Монгол орны хөхтөн амьтдыг улаан дансны зэрэглэл, шалгуураар дахин үнэлж, хамгаалах арга хэмжээг шинэчлэн боловсруулах ажлыг бодлогоор дэмжихийн сацуу цаг заваа зориулж, мэдлэг оюунаа чилээн олон талуудад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг уриалж, албан бичиг хүргүүлэх, уулзаж ярилцах, мөн ажлын ерөнхий чиглэлийг боловсруулан хүргүүлж захиалах, шаардлагатай баримт, материалаар хангах, санал солилцох зэргээр бүхий л үе шатанд удирдлагаар хангаж идэвхийлэн оролцож, нягт хамран ажилласан БОУАӨЯ-ны Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын газрын дарга Ц.Уранчимэг болон мэргэжилтэн Б.Хандармаа, тус яамны Байгалийн нөөцийн бодлого, зохистой ашиглалтын газрын ахлах мэргэжилтэн Ж.Мөнхдөш, яамныхаа нийт хамт олонд гүн талархал илэрхийлье.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

МОНГОЛ ОРНЫ ХӨХТӨН АМЬТДЫН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ХОВОРДЛЫН ШАЛТГААН



1.1. ТАНИЛЦУУЛГА БА ТАЙЛБАР

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 6.1-д “Байгалийн үнэ цэн, өгөөжийг үнэлэн хамгаалж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах зорилт”-ын 6.2-т “Байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээж, хомсдолыг бууруулан ашиглалтын нөөц бий болгож, байгалийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлэх зорилт”-ын хүрээнд “Амьтан, ургамлын улаан дансыг шинэчлэн шинээр бий болгож, ховордсон зүйлийн хамгааллын арга замыг тодорхойлж хэрэгжүүлнэ” хэмээн тусгаснаас гадна, Засгийн газрын 2015 оны 325 дугаар тогтоолоор батлагдсан “Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр”-т биологийн олон янз байдлын хамгаалах, зохистой ашиглах талаарх шийдвэр гаргах, олон нийтийн мэдлэг хандлагыг нэмэгдүүлэх, мөн биологийн олон янз байдлын нөөцийн талаарх шинжлэх ухааны үндэслэлд тулгуурлан зохистой ашиглах болон хамгаалах бодлогыг бий болгон хэрэгжүүлэх, тогтвортой ашиглах нөхцөлийг хангах, биологийн олон янз байдал, экосистемийн үйлчилгээг хамгаалах, ашиглах бодлого, эрх зүйн орчныг сайжруулах чиглэлийг баримтлахаар тодорхой тусгасан.

Монгол Улс нь 2025 оны байдлаар байгаль орчныг хамгаалах чиглэлийн 18 олон улсын гэрээ, конвенцод нэгдэн орсон байгаа бөгөөд тэдгээрээс дөрөв нь биологийн олон янз байдлыг хамгаалах, ялангуяа амьтны аймгийг хамгаалах, зүй зохистой ашиглахтай холбоотой гэрээ, конвенц байна. Үүнд “Биологийн олон янз байдлын тухай конвенц (CBD)”-оор өнөө болон хойч үеийнхээ тусын тулд биологийн олон янз байдлыг хамгаалах, тогтвортой ашиглах явдлыг хэлэлцэн тохиролцсон бол “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах конвенц (CMS)”-оор манай улс нь нутаг дэвсгэрийнхээ хилийн дотор амьдрах буюу нутгаар нь дамжин өнгөрч байгаа зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг ивээн хамгаалагч байх ёстойг хүлээн зөвшөөрч, “Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц (Ramsar)”-оор ус, намгархаг газар нь усны горим болон ургамал ба амьтны аймаг, ялангуяа усны шувуудын амьдрах орчны экологийн зохицуулагч болдог үндсэн үүрэгтэйг харгалзан үзэж усны шувууд улирлаар хил дамнан нүүдэллэгч учир түүнийг олон усны нөөц баялгийн нэгэн адил үзэх ёстойг хүлээн зөвшөөрч, “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-оор зэрлэг амьтан, ургамлын аймаг нь энэ ертөнцийн байгалийн тогтолцооны орлуулшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд тэдгээрийг хамгаалж өнөөгийн болоод хойч үеийнхэндээ өвлүүлэн үлдээх, түүнчлэн зэрлэг амьтан, ургамлын зарим зүйлийг олон улсын хэмжээнд хэтрүүлэн ашиглах явдлыг зохицуулахад олон улсын хамтын ажиллагаа нэн шаардлагатай байгааг хүлээн зөвшөөрч тус тус нэгдэн орж, олон улсын өмнө үүрэг хариуцлага хүлээсэн байдаг.

Түүнчлэн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт байгаль орчныг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, багц хуулийн хэрэгжилтийг хангах, амьтан, ургамлын нөөцийг зохистой ашиглах замаар экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах зэрэг зорилтуудыг тавьсан.

Тэдгээрийн хүрээнд Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн Яам, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар, их дээд сургуулиуд, эрдэм шинжилгээ судалгааны байгууллагуудтай хамтран Амьтны тухай хууль тогтоомжид болон “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ийг хэрэгжүүлэх харилцааг зохицуулсан Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль тогтоомжид удаа дараа нөлөөллийн шинжилгээ хийлгэж (2018; 2021), мөн “Монгол орны нэн ховор, ховор амьтад, тэдгээрийн эд эрхтэн, бүтээгдэхүүний хэрэглээ, худалдаа ба хуулийн хариуцлага (2021)” зэрэг бүтээлээр дамжуулан амьтныг хамгаалах талаар холбогдох харилцааг

зохицуулж буй эрх зүйн орчин нь логик холбоогүй, давхардал, хийдэл, зөрчил ихтэй бөгөөд эдгээрийг цаашид засаж сайжруулах зайлшгүй шаардлагатай байгааг тогтоож, холбогдох байгууллагуудад саналаа хүргүүлж, хамтран ажиллаж байна. Эдгээр ажлын үр дүн гарсаар байгаа бөгөөд тухайлбал, Байгаль Орчин, Аялал Жуулчлалын сайдын 2024 оны А/240 дүгээр тушаалаар Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцын үндэсний Удирдан зохицуулах зөвлөлийн ажиллах журам болон Шинжлэх ухааны зөвлөлийн ажиллах журмууд батлагдан хэрэгжиж байна.

Байгаль Орчин, Аялал Жуулчлалын сайдын 2023 оны А/158 дугаар тушаалаар Амьтны тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж, улмаар Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн сайдын 2024 оны А/808 дугаар тушаалаар ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан бөгөөд Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар нь тус ажлын хэсгийн гишүүнээр ажиллахын сацуу санхүүгийн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллаж байна. Амьтны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар Монгол орны амьтны аймгийн хамгааллын менежментийг улам боловсронгуй болгох, сайжруулахтай холбогдох нэлээд хэдэн санал дэвшүүлсний нэг нь тус хуульд тодорхойлсон нэн ховор, ховор амьтдыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шинжлэх ухааны үндэслэлтэй шалгуур үзүүлэлтээр мэргэжлийн эрдэмтэн, судлаачдын өргөн оролцоотойгоор үнэлэн тогтоож, тодорхой давтамжтайгаар (тухайлбал, 6 жил тутамд) үнэлгээг шинэчлэн хийх санал юм. Энэхүү саналыг Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн Яамнаас дэмжиж, хуульд нэмэлт өөрчлөлт оруулахад хамтран ажиллахын зэрэгцээ Монгол орны хөхтөн, мөлхөгч, хоёр нутагтан болон загасны Улаан данс (2006)-уудыг шинэчлэн боловсруулах, энэ хүрээнд амьтны зүйлүүдийн үнэлгээг дахин хийж, хамгаалах арга хэмжээг тодорхойлж, тэдгээр цуврал бүтээлүүдийг олны хүртээл болгохоор харилцан тохиролцож, улмаар Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам (хуучнаар)-ны Байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газрын даргын 2024 оны 06/2375 тоот албан бичгээр тус багц ажлын ерөнхий чиглэлийг ирүүлж, хамтран ажиллаж байна.

Дээр дурдсан үндэслэл, шаардлагын дагуу Монгол орны хөхтөн, мөлхөгч, хоёр нутагтан болон загасны зүйлүүдийг олон улсын улаан дансны шалгууруар үнэлж, хамгааллын арга хэмжээг боловсруулах багц ажлыг санхүүжүүлж, зохион байгуулсан бөгөөд олон талууд хамтран гүйцэтгэлээ. Анх 2006 онд Монгол орны хөхтөн, мөлхөгчид, хоёр нутагтан болон загасны зүйлүүдийн тархац, тоо толгой, тэдгээрт нөлөөлж буй хүчин зүйлсийг Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан дансны зэрэглэл, шалгууруар үнэлж, хамгааллын төлөвлөгөөг боловсруулсан (IUCN, 2001)-аас хойш даруй 19 жил өнгөрсөн бөгөөд тухайн хугацаанд дээрх зүйлүүдийн тархац, тоо толгой, учирч буй аюул занал ихээхэн өөрчлөгдсөн нь тодорхой тул зүйлүүдийг дахин үнэлж, хамгаалах арга хэмжээг шинэчлэв.

Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан данс нь дэлхий дээрх амьтан ургамлын зүйлүүдийн популяцийн нөхцөл байдлыг үнэлдэг, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн баримт бичиг юм (Baillie, Groombridge, 1996). Улаан данс нь ангилал зүйн хувьд өөр хоорондоо ялгаатай зүйлүүдийн устах эрсдэлийг үнэлэх чухал арга хэрэгсэл болсон төдийгүй ховордож буй зүйлд тавих анхаарлыг нэмэгдүүлэх, тэдгээрийг хамгаалахад нэн түрүүнд хийх шаардлагатай ажлыг тодорхойлох анхны арга хэмжээ болдог (Lamoreux *et al.,* 2003). Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан дансны шалгуур, зэрэглэлийг дэлхийн олон улс орнууд болон янз бүрийн байгууллагууд нийтээрээ ашиглаж байна.

Энэ удаагийн “Монгол орны хөхтөн амьтны Улаан данс ба хамгаалал” бүтээлийн зүйлийн бичиглэлийн агуулгыг боловсруулахдаа 2006 онд хэвлэгдсэн Монгол орны хөхтөн амьтны Улаан данс болон Монгол орны хөхтөн амьтны хамгааллын төлөвлөгөөний эмхэтгэл гэсэн хоёр бүтээлийн агуулгыг нэгтгэн оруулснаас гадна, зарим сэдвүүдийг нэмж, улам бүр баяжуулж нэлээд агууламжтай бүтээл болгосон. Үүнд:

Ангилал зүй. Тухайн зүйлийн монгол болон латин буюу шинжлэх ухааны нэр, мөн баг, овгийн монгол ба латин нэр, бас ижил нэр (хэрвээ тухайн зүйлийн латин, англи, монгол синоним нэр байгаа тохиолдолд таслалаар зааглаж оруулах г.м) зэргийг оруулав.

Ангилал зүйн тойм сэдэвт тухайн зүйлийн ангилал зүйд гарсан өөрчлөлтийг тоймлон бичсэн. Тухайлбал, салбар зүйлээс бие даасан зүйл болгон салгасан тухай баримт, бие даасан зүйлийг хэд хэдэн салбар зүйл болгон ялгасан тухай эсвэл тухайн зүйлийн монгол болон шинжлэх ухааны нэр өөрчлөгдсөн тохиолдолд тайлбарыг хадлаа.

Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам (хуучнаар)-аас Монгол Улсын Их Сургууль (МУИС), Шинжлэх Ухааны Академи (ШУА), төрийн ба төрийн бус байгууллагын эрдэмтэн, судлаачдын оролцоотой байгуулсан “Монгол орны Биологийн олон янз байдлын ангилал зүйн зөвлөл”-өөс нэгтгэн боловсруулж, улмаар амьтдын Монгол нэрийг өөрчлөх, шинээр оноох, тэдгээр нэрийг хянах ажлыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний бодлогын зөвлөл, Улсын нэр томьёоны комисстой хамтран гүйцэтгэсэн *“Монгол орны биологийн олон янз байдал: Нугаламгүй болон нугаламт амьтдын зүйлийн жагсаалт (Тэргүүн боть) (Редактор: С.Гомбобаатар, С.Шар, У.Айбек, Г.Гэрэлмаа, С.Баярхүү) (2019)* бүтээлийг суурь болгож, Н.Батсайхан (2019)-ын эмхэтгэснийг баримталж, тухайн зүйлийн Монгол нэр болон шинжлэх ухааны нэрийг оруулсныг дурдах нь зүйтэй.

Ер нь цаашид судалгаа, хамгаалал, бодлогын болон хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдэд энэ бүтээл дээр оноосон тухайн зүйлийн Монгол нэр (мөн шинжлэх ухааны нэр)-ийг баримталж, нэгмөр мөрдөн хэвшүүлэх нь зохистой. Учир нь эрдэмтэн, судлаачид, төрийн албан хаагчид бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрдэм шинжилгээ, судалгааны олон янзын бүтээлд нэг зүйлийг өөр өөрөөр бичих явдал түгээмэл байгааг цаашид анхаарах нь зүйтэй.

Таних шинж. Тухайн зүйлийг таних биеийн галбир, өнгө зүс, онцлог шинж болон төсөөтэй харагдах зүйлээс ялгарах шинж, мөн бие, сүүл, толгойн урт, өргөн, биеийн жин зэрэг хэмжилтүүд, тухайн зүйлийн шинжийг харуулсан гэрэл зургийг багтааснаараа бүтээл онцлог болов.

Үнэлгээ ба үндэслэл. Олон улсын үнэлгээнд Дэлхийн байгаль хамгаалах холбооны мэдээллийн сан (https://www.iucnredlist.org)-г ашигласан. Уг мэдээллийн санд Улаан дансны шалгууруар тухайн зүйлийн дэлхийн популяцийн үнэлгээ болон үндэслэлийг оруулсан байдаг.

Бүс нутгийн үнэлгээнд Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан дансны шалгуур үзүүлэлтүүдээр тухайн зүйлийн Монгол орон дахь популяцийн үнэлгээг шинэчлэн хийж, оруулав. Хэрвээ тухайн зүйлийн бүс нутгийн үнэлгээг өмнө нь хийж байгаагүй бол шинээр хийж, зөвшилцсөн болно.

Энэ удаагийн бүс нутгийн Улаан дансны үнэлгээг “Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан дансны бүс нутгийн түвшний шалгуурын удирдамж: 4.0 хувилбар” (IUCN, 2012)-ын дагуу хийв. Бүс нутгийн хэмжээнд устах эрсдэлийн үнэлгээг үнэн бодит гаргахад удирдамж нь дараах хоёр чухал үүрэгтэй. Нэгдүгээрт “Бүс нутгийн хэмжээнд устсан” болон “Үнэлэх боломжгүй” гэсэн 2 зэрэглэл нэмэгдэнэ (Хүснэгт 1). “Бүс нутгийн хэмжээнд устсан” гэсэн зэрэглэлд дэлхийд тархсан ч тухайн бүс нутагт тохиолдохгүй болсон зүйлийг багтаана. Харин “Үнэлэх боломжгүй” зэрэглэлд тухайн зүйлийн үнэлгээг хийх хангалттай мэдээ, баримт байхгүй тохиолдолд энэ зэрэглэлээр үнэлдэг.

Хүснэгт 1. *Дэлхийн байгаль хамгаалах холбоо (IUCN)-ны Улаан дансны үнэлгээнд ашиглаж буй зэрэглэлийн тодорхойлолт (IUCN, 2012)*

УСТСАН EXTINCT (EX)	Хамгийн сүүлчийн бодгаль маргаангүйгээр үхсэн бол тухайн ангилал зүйн нэгжийг Устсан гэсэн зэрэглэлээр үнэлнэ. Тухайн зүйлийн бодгаль байж болох амьдрах орчныг тохиромжтой цаг хугацаанд (өдөр, улирал, жилийн идэвхийг харгалзан) нарийн судалж, тухайн зүйлийн өмнө нь тархаж байсан бүх газар нутгаар судалгаа хийж үзээд нэг ч бодгаль илрүүлээгүй тохиолдолд тухайн зүйлийг Устсан гэсэн зэрэглэлд оруулна. Судалгааг зүйлийн амьдралын эргэлт ба амьдралын хэлбэртэй уялдсан цаг хугацаанд гүйцэтгэсэн байх ёстой.
БАЙГАЛЬД УСТСАН EXTINCT IN THE WILD (EW)	Тухайн ангилал зүйн нэгжийн бодгалиуд зөвхөн таримал байдлаар, хэрэв зэрлэг амьтан бол тэжээмэл байдлаар үржүүлж байгаа эсвэл тухайн зүйлийн популяциуд түүхэн тархац нутгийн гадна байгалийн нөхцөлд нь байгаа бол Байгальд устсан гэсэн зэрэглэлд оруулдаг. Тухайн ангилал зүйн нэгжид хамаарах бодгалиудыг тохиромжтой цаг хугацаа (өдөр, улирал, жилийн идэвхийг харгалзан)-нд нарийн судалж, мөн тухайн зүйлийн уугуул нутагт судалгаа хийсэн ч нэг бодгаль илрүүлээгүй тохиолдолд Байгальд устсан гэсэн зэрэглэлээр үнэлдэг. Судалгааг тухайн зүйлийн амьдралын эргэлт ба амьдралын хэлбэртэй уялдсан цаг хугацаанд гүйцэтгэсэн байх ёстой.
БҮС НУТГИЙН ХЭМЖЭЭНД УСТСАН REGIONALLY EXTINCT (RE)	Тухайн ангилал зүйн нэгжийн хамгийн сүүлчийн бодгаль үхсэн эсвэл үзэгдэхээ болсон бөгөөд дахин энэ нутагт шилжин ирэх боломжгүй тохиолдолд Бүс нутгийн хэмжээнд устсан гэсэн зэрэглэлд багтаадаг. Бүс нутгийн хэмжээнд устсан гэсэн зэрэглэлд тухайн зүйлийг оруулахаас өмнө цаг хугацаанд ерөнхий дүрэм тавих боломжгүй. Энэ нь зүйлийн талаарх судалгаа хэр хийгдсэнээс хамаарах болно.
УСТАЖ БАЙГАА CRITICALLY ENDANGERED (CR)	Тухайн ангилал зүйн нэгжийн талаарх бүх баримт А-аас Е хүртэлх аль нэг шалгууруар Устаж байгаа гэсэн зэрэглэлээр үнэлэгдэж байгаа бол байгальд устах эрсдэл туйлын их байгааг илтгэсэн Устаж байгаа гэсэн зэрэглэлд хамааруулна.
УСТАЖ БОЛЗОШГҮЙ ENDANGERED (EN)	Тухайн ангилал зүйн нэгжийн талаарх бүх баримт А-аас Е хүртэлх аль нэг шалгууруар Устаж болзошгүй гэсэн зэрэглэлээр үнэлэгдэж байгаа бол байгальд устах эрсдэл их байгаа гэсэн агуулгатай.
ЭМЗЭГ VULNERABLE (VU)	Тухайн ангилал зүйн нэгжийн талаарх бүх баримт А-аас Е хүртэлх аль нэг шалгууруар Эмзэг гэсэн зэрэглэлээр үнэлэгдэж байгаа бол байгальд устах эрсдэл их байгаа гэж үзэн Эмзэг гэсэн зэрэглэлд хамааруулна.

ХОВОРДОЖ БОЛЗОШГҮЙ NEAR THREATENED (NT)	Тухайн ангилал зүйн нэгжийг А-аас Е хүртэлх шалгууруар шалгаж үзэхэд, Устаж байгаа, Устаж болзошгүй, Эмзэг гэсэн ховордлын зэрэглэлээр үнэлэх боломжгүй ч богино хугацаанд ирээдүйд устаж, ховордох эрсдэл их байгааг харгалзан Ховордож болзошгүй гэсэн зэрэглэлд багтаадаг.
АНХААРАЛД ӨРТӨХӨӨРГҮЙ LEAST CONCERN (LC)	Тухайн ангилал зүйн нэгжийг А-аас Е хүртэлх шалгууруар шалгаж үзэхэд, Устаж байгаа, Устаж болзошгүй, Эмзэг эсвэл Ховордож болзошгүй зэрэг зэрэглэлийн аль нэгээр үнэлэх боломжгүй тохиолдолд Анхааралд өртөхөөргүй зүйл гэж үзнэ. Өргөн тархац нутагтай, элбэг зүйл энэ зэрэглэлд хамааруулна.
МЭДЭЭЛЭЛ ДУТМАГ DATA DEFICIENT (DD)	Тухайн ангилал зүйн нэгжийн популяцийн төлөв байдал болон тархцыг үндэслэн устах эрсдэлийг тогтоох шууд ба шууд бус үнэлгээ хийхэд мэдээ, баримт хангалтгүй байгаа нөхцөлд Мэдээлэл дутмаг гэсэн зэрэглэлд хамааруулдаг. Тухайн зүйлийн элбэгшил, тархцын талаар мэдээ, баримт дутмаг байж болно. Мэдээлэл дутмаг гэх энэ зэрэглэл нь устах, ховордох эрсдэлийг илэрхийлсэн агуулга биш юм. Зүйлийг энэ зэрэглэлд оруулах нь тухайн зүйлийн талаар илүү мэдээ, баримт хэрэгтэйг илэрхийлдэг төдийгүй тухайн зүйлийн талаар ирээдүйд судалгаа хийж, тухайн судалгаа нь тэр зүйлийг устах эрсдэлтэйг нотлох боломжтой. Өнөөгийн байгаа мэдээ, баримтыг ашигтайгаар хэрэглэх нь нэн чухал. Тухайн зүйлийг Мэдээлэл дутмаг, мөн устах эрсдэлтэйг илэрхийлсэн зэрэглэлийн алинд нь хамааруулахаа маш анхааралтай шийдэх хэрэгтэй. Хэрвээ тухайн зүйлийн тархац нутаг харьцангуй хязгаарлагдмал, тухайн зүйлийг олон жилийн тэртээд судалсан бол тэр зүйлийг ховордох, устах эрсдэлтэй зэрэглэлд оруулах нь зайлшгүй зөв шийдвэр болно.
ҮНЭЛЭХ БОЛОМЖГҮЙ NOT EVALUATED (NE)	Бүс нутгийн хэмжээнд үнэлэх шаардлага хангаагүй ангилал зүйн нэгжийг Үнэлэх боломжгүй гэсэн зэрэглэлд багтаадаг.

Үнэлгээ нь хоёр шатны үйл явцаас бүрдэх ба эхлээд Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан дансны шалгуур (IUCN, 2012)-аар тухайн популяцийг дэлхийн популяцийн төлөөлөл гэж үзэн бүс нутгийн популяцийн мэдээлэлд тулгуурлан үнэлгээ хийнэ (Хавсралт 1).

Тухайн популяцид бүс нутгийн гадна байгаа популяци нөлөө үзүүлж байвал үнэлгээг өөрчилнө. Жишээ нь, бүс нутгийн хэмжээнд ховордож байгаа тухайн зүйлийн популяци нь хөрш зэргэлдээ орноос нүүдэллэн ирдэг бодгалиудаар тэтгэгддэг бол тухайн популяцийн бүс нутгийн устах эрсдэл буурч, улмаар үнэлгээ ч мөн буурна. Хэрвээ бүс нутаг дахь тухайн зүйлийн тоо толгой болон популяцийн хэмжээ буурч байгаа бөгөөд тухайн популяци хөрш зэргэлдээ орны популяцийн бодгалиудаас сэлбэгдэх боломжгүй бол бүс нутгийн үнэлгээг ахиулж ховордлын зэрэглэлийг дээшлүүлэх зэрэг байдлаар энэ удаагийн үнэлгээг хийсэн.

Үнэлгээний үндэслэл хэсэгт дээр дурдсан Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан дансны зэрэглэл, шалгуур үзүүлэлтүүдээр тухайн зүйлийн бүс нутгийн үнэлгээг шинээр юм

уу шинэчлэн хийж, тогтоосон зэрэглэлийн үндэслэл, судалгааны тоо баримтуудыг аль болох тодорхой тайлбарлаж оруулахыг хичээсэн болно.

Үнэлгээг хийсэн эрдэмтэн, судлаач нар тухайн зүйлийн талаарх өөрсдийн судалгааны үр дүн, мөн өмнөх болон өнөө үеийн эрдэмтдийн судалгааны ажлын үр дүн, бүтээлүүдийг судлан шүүж, тухайн зүйлийн бичиглэлийг боловсруулж, үүн дээрээ үндэслэн зүйлийн бүс нутгийн үнэлгээг дээрх шалгуур үзүүлэлтүүдийн дагуу хичээнгүйлэн хийж, багаараа хэлэлцэн шийдвэрлэж, улмаар дараа дараагийн шатны үнэлгээний хяналтаар оруулан хэлэлцүүлж, хамтран ажиллалаа.

Харин үнэлгээг хянасан эрдэмтэд тухайн зүйлийн үнэлгээг хийсэн эрдэмтэн, судлаач нарын үнэлгээ, үндэслэл, судалгааны баримт, материалуудыг Дэлхийн байгаль хамгаалах холбооны мэдээллийн санд тулгуурлан олон улсын үнэлгээг нягтлан шалгаж, улмаар бүс нутгийн үнэлгээний үнэн бодит эсэхийг давхар хянан нягталж, хамтран ажиллав.

Ер нь энэ удаагийн Монгол орны хөхтөн амьтдыг Улаан дансны зэрэглэл, шалгуур үзүүлэлтүүдээр үнэлэх ажлыг зохион байгуулахдаа аль болох олон талуудыг оролцуулж, тухайн ажлын хэсгийг ангилал зүйн бүлэг (анги, баг, төрөл г.м)-үүдээр багуудад хуваан ажиллуулж, зүйл тус бүрийн үнэлгээг хийсэн бөгөөд үүний дараа тэдгээр багуудыг хариуцсан эрдэмтэд, мөн бүлгийн ахлагч нар давхар давхар үнэлгээг хянах байдлаар зохион байгуулсан тул тодорхой зүйлийн үнэлгээг хийсэн болон хянасан эрдэмтэн, судлаачид олуулаа байгааг зүйл тус бүр дээр харж болно. Тухайлбал, Монгол тарваганы үнэлгээ хийсэн Р.Самъяа, Н.Батсайхан, С.Шар, Д.Лхагвасүрэн, Э.Ундрахбаяр нар (энэ мэтчилэн үнэлгээг хийсэн зохиогчдоор тухайн зүйлийн эшлэлийг авах нь зохистой) бол үнэлгээг хянасан С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал нар гэх мэт.

Дэлхийн тархац. Дэлхийн олон оронд баримталж байгаа хэлбэр, агуулгаар баруунаас зүүн тийш чиглэсэн байдлаар тухайн зүйл тархсан улс орон, газар нутгийн нэрийг тодорхой дурдсанаас гадна, өргөн дэлгэр тархсан зарим зүйл амьтдыг тив, бүс нутгийн нэрээр тархац нутгийн тодруулан оруулсан болно.

Монгол орны тархац, амьдрах орчин. Тухайн зүйл амьтны Монгол орон дахь тархац, байршил нутгийг баруунаас зүүн тийш газар зүйн муж, уулсын систем, газар усны нэрээр тодорхой дурдаж, тайлбарлан оруулсан. Мөн өмнөх бүтээл буюу 2006 оны Монгол орны хөхтөн амьтны Улаан дансанд ашигласан Монгол Улсын физик газар зүйн зургийг үндэслэн Цэгмэд (1969), Грубов (1982), Рачковская (1993), Банников (1954) нарын ургамал, хөхтөн амьтны газар зүйн мужлалын зургаар нэмэн баяжуулж, мөн Батсайхан нар (2022)-ын бүтээлтэй харьцуулан шинэчлэн боловсруулсан Монгол орны 16 бүс бүхий газар зүйн мужаар зарим зүйл хөхтөн амьтдын тархцыг тайлбарласан болно (Зураг 1).

Зураг 1. *Монгол орны хөхтөн амьтдын тархцыг тайлбарлахад ашигласан Монгол орны газар зүйн мужууд (Цэгмид, 1969; Грубов, 1982).* 1 - Хөвсгөлийн уулс, 2 - Хэнтийн нуруу, 3 - Хангайн нуруу, 4 - Монгол Дагуурын хээр, 5 - Их Хянганы уулс, 6 - Монгол Алтайн нуруу, 7 - Төв халхын хээр, 8 - Дорнод Монгол, 9 - Их нууруудын хотгор, 10 - Олон нуурын хөндий, 11 - Умард говь, 12 - Дорнод говь, 13 - Говь Алтайн нуруу, 14 - Зүүнгарын говь цөл, 15 - Алтайн өвөр говь цөл, 16 - Алашаа говь цөл.



Зүйл тус бүрийн тархцыг сүүлийн үеийн мэдээлэл, баримтаар баяжуулж, боломжит хэмжээнд нарийвчлан газрын зургаар харуулав. Гэвч нэлээд олон зүйлийн тархцын мэдээлэл дутмаг, хангалтгүй байсныг дурдах нь зүйтэй. Газрын зургийг боловсруулахдаа тухайн зүйлийн тархцыг засаг захиргааны нэгж (аймаг) болон улсын тусгай хамгаалалттай газар нутгуудын зурагтай давхцуулан оруулж, боловсруулсан. Мөн тухайн зүйл амьтан түгээмэл тархсан байгалийн бүс, бүслүүр болон шүтэн амьдардаг амьдрах орчны хэлбэрүүдийг тодорхой тайлбарлан оруулласа. Дэлхийн байгаль хамгаалах холбооноос боловсруулсан амьдрах орчны төрөл (Habitat type)-үүдийг кодын хамт оруулсан. Тухайлбал, ой (1.1), нуур, голын хөвөө орчмын чийглэг нуга (5.1) гэх мэт.

Амьдралын онцлог. Тухайн зүйлийн амьдралын хэлбэр, идэвхжил, идэш тэжээл, ороо хөөцөө, үржил хөгжил, ичээлэх хугацаа зэрэг онцлогуудын талаар судалгааны мэдээ, баримтад тулгуурлан тодорхой тайлбарлав. Гэвч зарим зүйл амьтдын хувьд маш бага судлагдсан эсвэл судлагдаагүй учир судалгааны мэдээ, баримт маш хомс, тодорхойгүй байсныг дурдах нь зүйтэй.

Тоо толгой, нягтшил. Тухайн зүйлийн бүс нутгийн популяцийн хэмжээ, тоо толгой, нягтшил, нөөцийн талаарх мэдээ, баримтыг судалгааны бүтээл, ном зохиол болон бусад баталгаатай эх сурвалжийг ашиглаж, тоо баримттай тайлбарлан (тухайн зүйл амьтны популяцийн хэмжээ, тусгаар популяциудын нөхцөл байдал, популяци/иудын өсөх, буурах, тогтвортой байдал, хандлага г.м) оруулахыг хичээв. Гэвч зарим зүйл амьтдын хувьд мэдээ, баримт тун хомс.

Харин тухайн зүйлийн дэлхийн тархац, популяцийн хэмжээ, тоо толгой, төлөв байдал, хандлагын талаарх мэдээ, баримтад Дэлхийн байгаль хамгаалах холбооны мэдээллийн сан, бүтээлүүдийг ашигласан болно.

Ховордлын шалтгаан. Тухайн зүйл амьтны тоо толгой, тархац нутаг, нүүдэл шилжилт, амьдрах орчинд сөргөөр нөлөөлж, ховордуулж буй гол шалтгаануудын талаарх мэдээллийг судалгааны бүтээл, ном зохиол, эх сурвалжийг ашиглаж, тодорхой тайлбарлан оруулахад анхаарав. Мөн түүнчлэн Дэлхийн байгаль хамгаалах холбооноос боловсруулсан аюул заналын жагсаалт (threats list)-аас аль тохирохыг нь сонгож кодын хамт оруулсан. Тухайлбал, энэ зүйл нь хязгаарлагдмал тархац нутагтай, тусгаарлагдмал популяци тул ашигт малтмалын олборлолт (1.3.1), зам, тээвэр (1.4.4), түймэр (7.4), ус чийгийн хомсдол, намгархаг газруудын хаталт, хуурайшилт (7.4; 7.7) зэргээс шалтгаалан тархац нутаг нь хумигдаж, тоо толгой нь буурах магадлалтай.

Хамгаалсан байдал. Тухайн зүйл амьтан “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”, “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)” болон олон улсын бусад гэрээ, конвенц, баримт бичгүүдэд хэрхэн үнэлэгдэж, хэддүгээр хавсралтад нь бүртгэгдсэнийг тодруулж, оруулав. Үүнд Монгол оронд одоогоор тэмдэглэгдээд буй 80-аад зүйл загаснаас Шивэр хилэм, Амар мөрний хилэм хэмээх хоёр зүйл дээрх нэр бүхий 2 конвенцын II хавсралтад тус тус бүртгэгдсэн байдаг.

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцын англи хэл дээрх товчлол болох CITES гэсэн нэрээр олны танил болсон байдаг. Энэ конвенц нь тодорхой зүйл болон тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүний олон улсын худалдааг хянахад чиглэнэ. Конвенцод хамаарах зүйлүүдийн импорт, экспорт, ре-экспорт нь эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөл, үе шатны дагуу хийгдэх ёстой. Конвенцод нэгдэн орсон тал, нэгдэж ороогүй аль нэгэн улстай зэрлэг амьтан, ургамлын ховордсон зүйл, тэдгээрийн гаралтай эд зүйлсийн худалдаа хийх тохиолдолд энэ конвенцын заалтыг мөрдөх үүрэг хүлээдэг.

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц” нь дараах гурван хавсралттай бөгөөд хавсралт бүр нь ховордсон ургамал, амьтны зүйлийг агуулна. Үүнд:

CITES I ХАВСРАЛТ	Олон улсын худалдаа нь тухайн зүйлийн оршин тогтноход нөлөө үзүүлж байгаа эсвэл нөлөө үзүүлж болох, устах аюулд орсон бүх зүйл хамаарна. Энэ конвенцын I хавсралтад орсон зүйлийн худалдааг хатуу хяналт зохицуулалттайгаар явуулдаг бөгөөд арилжааны зорилгоор худалдаалахыг үндсэндээ хориглож, судалгаа шинжилгээний зорилгоор экспортлох болон импортлоход экспорт, импортын баримт бичиг бүрдүүлэхийг шаарддаг.
CITES II ХАВСРАЛТ	Эдүгээ устах аюулд ороогүй ч тухайн зүйлийн цаашид оршин тогтноход харшлахаар ашиглалт явуулахгүй байх үүднээс олон улсын худалдааг хяналт зохицуулалттай явуулахгүй бол устах аюулд орж болзошгүй зүйлүүд багтана. Энэ конвенцын II хавсралтад багтсан зүйлүүдийг арилжааны зорилгоор худалдаалж болох бөгөөд экспортлох, импортлоход экспортлогч улсын экспортын зөвшөөрлийг шаарддаг.
CITES III ХАВСРАЛТ	Аль нэгэн тал өөрийн улсын нутаг дэвсгэрийн дотор зохицуулах шаардлагатай гэж тодорхойлсон ба тэдгээрийн худалдааг хянахад бусад талуудтай хамтран ажиллах шаардлагатай хэмээн үзэж байгаа зүйлүүд багтана. Экспортлох, импортлоход гарал үүслийн гэрчилгээ болон тухайн зүйлийг энэ хавсралтад оруулсан улсаас экспортолж байгаа тохиолдолд экспортлогч улсын экспортын зөвшөөрлийг шаарддаг.

Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенцыг анх талуудын уулзалтыг зохион байгуулсан газрын нэрээр Боннын конвенц хэмээн товчлох бөгөөд тус конвенцын хүрээнд нэгдэн орсон талууд өөрийн улсын нутаг дэвсгэрт амьдардаг, мөн дайран өнгөрдөг шувууд, далай тэнгисийн болон хуурай газрын зүйлүүдийг амьдрах орчных нь хүрээнд хамгаалах үүрэг хүлээнэ. Уг конвенцод одоогоор 133 тал (132 улс, Европын холбоо) нэгдэн ороод байна (www.cms.int/en). Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенцын I ба II хавсралтуудыг тайлбарлавал:

ЗЭРЛЭГ АМЬТДЫН НҮҮДЛИЙН ЗҮЙЛҮҮДИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ КОНВЕНЦ (CMS) I ХАВСРАЛТ	Тархац нутагтаа эсвэл тодорхой нэг хэсэгт нь устаж үгүй болох аюул нүүрлэсэн нүүдлийн зүйлүүдийг энэ конвенцын I хавсралтад оруулдаг. Аливаа улс эдгээр амьтад болон амьдрах орчныг хамгаалах, нөхөн сэргээх, нүүдэллэхэд нь саад болдог бэрхшээлийг багасгах, мөн тэдэнд аюул болж болохуйц бусад хүчин зүйлийг хянах ёстой байдаг.
ЗЭРЛЭГ АМЬТДЫН НҮҮДЛИЙН ЗҮЙЛҮҮДИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ КОНВЕНЦ (CMS) II ХАВСРАЛТ	Тодорхой нэг зүйл амьтныг хамгаалах үйл ажиллагаанд олон улсын хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай тохиолдолд тухайн зүйлийг энэ конвенцын II хавсралтад оруулдаг. Иймээс уг конвенцын зүгээс II хавсралтад орсон нэг зүйл эсвэл ихэвчлэн нэг хэсэг бүлэг зүйлийн хамгаалал болон менежментийн асуудлыг үр дүнтэй хэрэгжүүлэх ажлыг хангах зорилгоор дэлхийн хэмжээний эсвэл бүс нутгийн хэмжээний гэрээ, хэлэлцээр байгуулан ажиллахыг шаарддаг.
Шаардлагатай бол зарим зүйлийг I ба II хавсралтын хоёуланд нь оруулж болдог.	

Хөхтөн амьтад нь Монгол орны амьтны аймгийн салшгүй бүрэлдэхүүн бөгөөд экологи, генетик, шинжлэх ухаан, соёл боловсрол, аялал жуулчлал, амралт, гоо зүй, агнуурын үлэмж ач холбогдол бүхий амьтад юм.

Амьтны тухай хуулиар тэдгээрийн нөөцийг зохистой ашиглах, өсгөн үржүүлэх, хамгаалах, Генетик нөөцийн тухай хуулиар амьтны генетик нөөцийг хамгаалах, судлан хөгжүүлэх, ашиглах, мөн Зөвшөөрлийн тухай хуулиар амьтан, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох, импортлох зэрэг харилцааг зохицуулсан бол Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, бусад хууль тогтоомжид ч амьтны аймагтай холбогдох заалтууд бий.

Амьтны тухай хуулийг голлон баримталж, тухайн зүйлийн хамгааллын статус, ашиглах зориулалт, зөвшөөрөл, агнах, барихыг хориглосон хугацаа болон амьтныг агнах, барихад хориглох арга, зэвсэг хэрэгсэл, амьтны аймагт учирсан хохирол, нөхөн төлбөр, хариуцлага зэргийг товчхон тайлбарлав. Ингэхдээ энэ хуулиас бүрэн эхийг нь дэлгэрүүлэн уншихад хялбар байлгахыг зорьж хуулийн зүйл, хэсэг, заалтыг хураангуйлж хашилтад “()” дотор бичсэн болно.

Амьтны тухай хуулийн 6 дугаар зүйлд амьтны хэвийн өсөлт үржилтийг хадгалах, тархац нутгийг хамгаалах, нүүдлийн замыг чөлөөтэй байлгах (6.1.3), амьтны удмын санг хамгаалах, үр хөврөлийг хадгалах (6.1.4), үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны явцад амьтан устахаас урьдчилан сэргийлэх (6.1.7), амьтныг хамгаалах арга хэмжээний үндэслэлийг

гаргахад чиглэсэн эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх (6.1.10), иргэдийг амьтанд энэрэнгүй ханддаг үзлээр хүмүүжүүлэх, амьтныг хамгаалах үйл ажиллагааг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах (6.1.11) зэрэг хэлбэрээр хамгаална гэжээ. Мөн өвчилсөн, гамшигт, аюулт үзэгдэлд нэрвэгдсэн амьтанд тусламж үзүүлэх, авран хамгаалах (6.1.9)-аар заасан байдаг бөгөөд энэ хүрээнд “Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах аргачлал (2021)” хэмээх тусгайлсан гарын авлага боловсруулж, олны хүртээл болгосон. Үүнээс гадна, “Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаа” үндэсний багц (4) стандартыг боловсруулж, батлуулсан бөгөөд тэдгээрээс “MNS 6943:2021. Зэрэг амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаа. Ерөнхий шаардлага (20 хуудас)”, “MNS 6944:2021. Зэрэг амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаа. Хөхтөн амьтдад тавих тусгай шаардлага (19 хуудас)” гэсэн хоёр стандарт нь хөхтөн амьтадтай холбоотой юм.

Амьтны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан нэн ховор амьтанд хавтгай, соргог бөхөн, Монгол бөхөн, хүдэр, цаа буга, хандгай, тахь, ирвэс, голын халиу, мазаалай баавгай, цөөвөр чоно, Зүүнгарын даахай, давжаа алагдаахай, сухайн чичүүл, Азийн минж, ойн унтаахай, гозоорой зурам, Алтайн чацуулин зэрэг 18 зүйл хөхтөн орсон бол энэ хуулийн 7 дугаар зүйлийн 7.6-д заасны дагуу Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор баталсан Ховор амьтны жагсаалтад аргаль, янгир, хар сүүлт зээр, халиун буга, зэгсний зэрлэг гахай, хулан, говийн шилүүс, ойн булга, хадны суусар, эрээн хүрнэ, хүрэн баавгай, соотон алагдаахай, Козловын атигдаахай, Дорнын сармаахай хэмээх 14 зүйл хөхтөн орсон байна.

Нэн ховор амьтныг төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр зөвхөн эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх зориулалтаар агнаж, барьж болох (7.2) бөгөөд энд зааснаас бусад зориулалтаар нэн ховор амьтныг агнаж бэлтгэсэн арьс, яс, бусад түүхий эдийг худалдах, худалдан авахыг хориглосон (7.3). Мөн (7.4) нэн ховор амьтны амьдрах нутагт хүнд үйлдвэр, цахилгаан станц, химийн үйлдвэр байгуулах, авто болон төмөр зам тавих, уул уурхайн олборлолт явуулах, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх асуудлыг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлтийг үндэслэн Засгийн газар шийдвэрлэдэг.

Ховор амьтныг төрийн захиргааны төв байгууллагаас олгосон зөвшөөрлөөр (7.5) судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, эмчилгээний зориулалтаар (7.5.1), Монгол Улсын болон гадаадын иргэн тусгай төлбөр төлсөн (7.5.2), мөн тодорхой нутаг дэвсгэрт амьтны сүргийн бүтцийг зохицуулах болон халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх зорилгоор (7.5.3) зөвхөн агнаж, барьж болно.

Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д агнуурын амьтныг ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон хугацааг зүйл тус бүрээр тогтоож, мөн (7.5) төрийн захиргааны төв байгууллагаас олгосон зөвшөөрлөөр ховор амьтныг олзворын ангийн зориулалтаар агнахыг хориглох хугацаа (9.7) болон ховор амьтныг судалгаа, шинжилгээнээс бусад тусгай зориулалтаар амьдаар барихыг хориглох хугацааг (9.8) тус тус тогтоосон байдаг. Энэ талаар тухайн зүйл тус бүр дээр тайлбарлан оруулсан болно.

Энэ хуулийн 10 дугаар зүйлд зааснаар (10.1.1) химийн болон тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглах, (10.1.2) агнуурын амьтны жим дээр нүх ухах, буу сойх, занга, сааль тавих, (10.1.3) туурайтан амьтныг агнахад цасанд умбуулах, мөсөнд халтиргах, хясаа, эрэг, ганга руу нисгэх, хавх тавих, (10.1.4) тарвагыг нүхэнд нь утах, ус цутгах, хавх, урхи тавих, нохойгоор зориудаар бариулах, (10.1.5) агнуурын амьтныг агаарын болон авто тээврийн хэрэгслээр хөөх, гэрэлтүүлэх, (10.1.8) ан агнах зориулалтын бус буу, сум хэрэглэх зэрэг арга, зэвсэг хэрэгслээр агнуурын амьтныг агнах, барихыг хориглосон бол энэ хуулийн 11 дүгээр зүйлд зааснаар (11.1.1) шуурга, ган, зуд, үер, мөндөр, түймэр зэрэг гамшигт нэрвэгдсэн болон гол, мөрөн, намаг, шаварт орох зэрэг биеэ хамгаалах чадваргүй болсон агнуурын амьтныг

агнах, барих, (11.1.2) булаг, шанд, хужир марааНд ирж буй амьтныг отож агнах, (11.1.3) өөр нутагт шилжин байршиж байгаа агнуурын амьтныг агнах, барих, (11.1.4) агнуурын амьтны үүр, ичээ ухах, гэмтээх, (11.1.5) агнуурын амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх зорилго бүхий байр, саравч, тэжээл мараа, бусад байгууламжийг эвдэж гэмтээх, устгах, (11.1.6) агнуурын амьтныг сайн танилгүй буюу анир чимээнээр таамаглаж буудах, (11.1.7) агнуурын амьтны үр төлийг агнах, шувууны өндгийг түүх, гэмтээх, устгах, (11.1.8) ангийн буу, агнуурын амьтан агнах, барих гэрээ, зөвшөөрөл, эрхийн бичгийг бусдад шилжүүлэх, (11.1.9) тарвага, зурам, тэдгээрийн түүхий мах, нойтон болон халдваргүйжүүлээгүй арьсыг хот, тосгонд оруулах, (11.1.10) хот, тосгоны ногоон бүсэд судалгаа шинжилгээ, халдварт өвчний голомт эрүүлжүүлэх, ан амьтны тоо толгойг зохицуулахаас бусад зорилгоор агнуурын амьтан агнах, барих, (11.1.12) эрх бүхий мэргэжлийн байгууллагаар агнуур зохион байгуулалтын ажлыг хуульд заасан хугацаанд нь хийлгээгүй аймаг, сум, нийслэл, дүүргийн нутагт агнуурын амьтан агнах, барих, (11.1.13) агнахыг хориглосон ан амьтны ангийн гаралтай түүхий эдийг худалдах, худалдан авах зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглосон.

Амьтны тухай хуулийн 25 дугаар зүйлд (25.1) иргэн ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад эрхийн бичиг, иргэн, хуулийн этгээд тусгай болон үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад тусгай зөвшөөрөл авч, гэрээ байгуулахаар, (25.3) ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тухайн сум дахь байгаль хамгаалагч гарал үүслийн тодорхойлолт олгохоор тус тус заасан байна.

Мөн энэ хуулийн 28 дугаар зүйлд зааснаар ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад зөвшөөрөл бүхий иргэн (28.1) зохих төлбөр төлж, сумын Засаг даргаас авсан эрхийн бичгийн дагуу агнуурын ховор амьтнаас бусад амьтныг өөрийн ахуйн зориулалтаар агнаж, барьж болох бөгөөд (28.2) ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнах, барих эрхийн бичигт иргэний овог, эцгийн нэр, нэр, агнах, барих агнуурын амьтны зүйл, тоо, агнах, барих хугацаа, газар, төлбөр, хураамжийн хэмжээг нарийвчлан заана гэжээ. Мөн (28.3) ахуйн зориулалтаар агнуурын амьтныг агнах, барих нэг удаагийн эрхийн бичгийг Монгол Улсын иргэнд (28.3.1) шувуу, тарвага агнаж, загас барихад гурав хүртэл хоног, (28.3.2) энэ хуулийн 28.3.1-д зааснаас бусад агнуурын амьтан агнах, барихад тав хүртэл хонгийн хугацаагаар олгох бөгөөд (28.4) энэ хуулийн 28.3-т заасан иргэнд нэг удаагийн эрхийн бичгээр агнах, барихыг зөвшөөрөх агнуурын амьтны тоо хэмжээ нь туурайтан амьтан нэг, тарвага тав, бусад үслэг ан нэг, хөтүү, ятуу, ногтруу шувуу тус бүр арав, ой, хээр, ус, намгийн бусад агнуурын шувуу тав, бусад агнуурын загас арван ширхгээс илүүгүй байна, мөн (28.5) Монгол Улсад түр буюу байнга оршин суугаа гадаадын иргэн Монгол Улсын иргэний адил хэмжээний төлбөр төлж, ахуйн зориулалтаар зөвхөн загас барьж болно хэмээн тус тус заажээ.

Амьтны тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас амьтны аймагт учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлдэг (37.1) бөгөөд энэ нөхөн төлбөрийн хэмжээг Засгийн газраас тогтоосон амьтны экологи-эдийн засгийн үнэлгээг хоёр дахин өсгөж тогтоох (37.2) ба энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг (39.2) байна.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-нд 144 зүйл (үүнд зарим амьтдыг салбар (дэд) зүйл тус бүрээр нь экологи-эдийн засгийн үнэлгээг тогтоож оруулжээ) хөхтний экологи-эдийн засгийн үнэлгээг тогтоож, батлуулсан байгаа нь тун сайшаалтай байлаа. Ингэснээр, амьтны нөөц ашигласны төлбөр, хураамж, амьтны аймагт учруулсан хохирол, нөхөн төлбөрийг тооцох суурь үнэ цэн болох зэрэг олон талын ач холбогдолтой.

Иргэд, олон нийт хамгийн түгээмлээр ашигладаг зориулалтыг харгалзан **Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн** 17 дугаар зүйлийн 17.1.2-т зааснаас зөвхөн ахуйн

зориулалтаар агнасан амьтны төлбөрийг тухайн амьтны толгой тутмын экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийн доод, дээд хязгаарын хувь, хэмжээг тогтоох заалтыг баримталж, тайлбарласан болно. Тухайлбал, Монгол тарваганы экологи-эдийн засгийн үнэлгээ 410,000 төгрөг бөгөөд ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө гэх мэт.

Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт хугацаа дууссан гэрээ, зөвшөөрлөөр эсхүл гэрээ, зөвшөөрөлгүйгээр амьтныг (1.1) ашигласан, (1.2) барьсан, (1.3) агнасан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно хэмээн тус тус заажээ.

Мөн энэ хуулийн 7.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт амьтныг ашиглах, барих, агнах зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

3 дахь хэсэгт ан агнах, загас барих гэрээ, тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг бусдад шилжүүлсэн, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ан агнасан, барьсан, зохих гэрээ байгуулахгүйгээр үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнасан, барьсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

4 дэх хэсэгт агнуурын бүс нутгаас бусад газарт, эсхүл амьтныг агнах хориотой үед, эсхүл хориглосон хугацаанд, эсхүл хориглосон арга хэрэгслээр амьтныг барьсан, агнасан, тээвэрлэсэн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

5 дахь хэсэгт агнуурын амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийн зүйлийг тусгай зөвшөөрөл, гарал үүслийн бичиг, дагалдах тодорхойлолтгүйгээр худалдсан, худалдан авсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно хэмээн тус тус заажээ. Түүнчлэн Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт амьтныг зөвшөөрөлгүйгээр нутагшуулсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

7 дахь хэсэгт харь амьтныг зөвшөөрөлгүйгээр нутагшуулсан, өсгөж үржүүлсэн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

8 дахь хэсэгт энэ зүйлийн 5 дахь хэсэгт зааснаас бусад амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг гарал үүслийн тодорхойлолтгүйгээр худалдсан, худалдан авсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан

хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

9 дэх хэсэгт амьтны хүрээлэн ажиллуулахад тавигдах шаардлагыг зөрчсөн бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор тус тус заасныг анхаарах нь зүйтэй.

Үүнээс гадна, Зөрчлийн тухай хуулийн 7.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсын хуулиар ховор, нэн ховор амьтны жагсаалтад ороогүй боловч Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд хамгаалах тухай Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, эсхүл тэдгээрийн гаралтай эд зүйлийг зохих зөвшөөрөлгүйгээр улсын хилээр нэвтрүүлсэн бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэжээ.

Эрүүгийн хуулийн 24.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт улсын тусгай хамгаалалттай газар нутагт зөвшөөрөлгүйгээр амьтан агнасан, барьсан, эсхүл ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр агнасан, барьсан, зориудаар тэжээж гаршуулсан, үржүүлсэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн зүйлийг хадгалсан, худалдсан, худалдан авсан, тээвэрлэсэн, гадаад улсад гаргасан, ховор амьтны чихмэл, эд, эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх,

2 дахь хэсэгт нэн ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүй агнасан, барьсан, зориудаар гаршуулан тэжээсэн, амьдрах орчныг алдагдуулсан тэдгээрийн түүхий эдийг бэлтгэсэн, тээвэрлэсэн, хадгалсан, худалдсан, худалдан авсан, гадаад улсад гаргасан, нэн ховор амьтны чихмэл, түүхий эд, эд, эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр тус тус заасныг анхаарууштай.

Манай зарим сониуч иргэд зараа, атаахай, туулайн бүжин гэх мэт амьтдыг өхөөрдөн тэжээх, амьтны дэлгүүрүүдээр худалдаалах, өөр хоорондоо солилцох, мөн зээр, аргаль, янгир, буга, бор гөрөөсний янзагануудыг олж гаршуулан тэжээх (энэ нь уулан амьтныг авран хамгаалж байгаа сайн үйлс тул аль болох богино хугацаанд асарч тэнхрүүлээд хүнд тасгахгүйгээр ижил сүрэгт нь нийлүүлж, буцаан тавих учиртай) явдал байх бөгөөд тэдгээр нь тодорхой зөвшөөрөлтэй явагдах үйл ажиллагаа гэдгийг анхаарвал зохистой.

Амьтны тухай хуульд заасанчлан(4.1.24) амьтны жам ёсны эрхийг дээдэлж идэш тэжээлээ олох, амьдрах идээшил, тархац нутгаа сонгох, үржил хөөцөөнд орж, үр төлөө үлдээх, бүл сүрэгтэй дасан ижилсэх, айдас цочрол, хомроглон устгагдахаас ангид байлгах зарчмыг хүндэтгэн үзэж, (34.2) амьтныг агнах, барих, тавих, арчилж тордох, ачиж тээвэрлэхдээ эрүүл ахуй, осол аюулгүйн шаардлагыг хангасан арга технологи, багаж хэрэгсэл, байр сав, тохиромжтой цаг хугацаа, зориулалтын тоноглосон тээврийн хэрэгсэл ашиглаж, мэргэшсэн хүмүүсийг ажиллуулж, зөвлөгөө тусламж авч, хамтран ажиллах нь зүйтэй.

Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.1-д заасан нэн ховор амьтныг амьдаар нь гадаад улсад гаргах зөвшөөрлийг Засгийн газар, харин 1.3-д заасан амьтан, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох, импортлох, 1.8 дахь генетикийн нөөц, генетикийн нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглах, 1.15 дахь ховор амьд амьтны цуглуулга хийх тусгай зөвшөөрлүүдийг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгодог бол энэ хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.20-д заасан олон улсын хэмжээнд хамгаалах тухай конвенцын хавсралтад заасан амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг

экспортлох, реэкспортлох, импортлох тусгай зөвшөөрлийг конвенцын Удирдан зохицуулах зөвлөл олгодог.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийг онцгойлон авч үзэж, энэ хуульд заасан ангиллаар тухайн зүйлийн тархац нутгийн тодорхой хувь эсвэл бүхэлдээ юм уу хэсэгчлэн улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдсан эсэхийг тодорхой оруулахыг хичээсэн. Тухайлбал, хавтгайн тархац нутаг бүхэлдээ Говийн Их дархан цаазат газрын "А" хэсэгт хамрагдан хамгаалагджээ гэх мэт. Ингэж тухайн зүйлийн тархац нутаг нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдсан эсэхийг онцгойлон авч үзсэний учир нь нэн ховор, ховор амьтан эсэхээс үл хамааран дээр дурдсанчлан Эрүүгийн хуулийн 24.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт *"улсын тусгай хамгаалалттай газар нутагт зөвшөөрөлгүйгээр амьтан агнасан, барьсан ... бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ"* хэмээн заасан бөгөөд гэмт хэргийн шинжийг агуулах тул үүнийг олон нийтэд анхааруулж, ойлгуулахыг зорьсон хэрэг.

Дээр дурдсан холбогдох хууль тогтоомжуудад Монгол орны хөхтөн амьтдыг ашиглах зориулалт, хэлбэр, зөвшөөрөл, төлбөр хураамж, хамгаалах хэлбэр, агнах, барихыг хориглосон хугацаа болон агнах, барихад хориглох арга, зэвсэг хэрэгсэл, амьтны аймагт учирсан хохирол, нөхөн төлбөр, хариуцлага зэргийн талаар нэлээд тодорхой заасан байх бөгөөд хуулиас дэлгэрүүлэн үзэж, олон нийтэд сурталчлан таниулах нь тун чухал.

Монгол Улсын Улаан ном (1987; 1997; 2013; 2016)-д тухайн зүйл амьтан орсон эсэхийг шүүн үзэж, хэрвээ орсон байвал тэр тухай дурдсан. Тухайлбал, хавтгайн Монгол Улсын Улаан номын бүх хэвлэлд нэн ховор зүйлээр бүртгэгджээ (Шагдарсүрэн нар, 1987; Шийрэвдамба нар, 1997; 2016) гэх мэтээр оруулав.

Хамгаалах арга хэмжээ. Монгол орон дахь тухайн зүйлийн ховордлын шалтгааныг бууруулах, ирээдүйд тус зүйлийг өсөн үржих, тархац нутгаа тэлэх боломжийг хангахад чиглэгдсэн хамгаалллын арга хэмжээг оруулахдаа Дэлхийн байгаль хамгаалах холбооноос боловсруулсан Үндэсний түвшинд авч хэрэгжүүлэх хамгаалллын арга хэмжээнүүдийн жагсаалт (Conservation actions)-аас тухайн зүйлийн хамгаалалд илүү нийцэх эсвэл хамгийн чухал гэсэн арга хэмжээнүүдийг түүвэрлэн авч, кодын хамт оруулсан. Тухайлбал, бүс нутгийн Улаан дансны үнэлгээгээр "Эмзэг" гэж үнэлсэн зүйлийг хамгаалах эрх зүйн баримт бичгийг бодлогын түвшинд боловсруулах (1.2.1.2), ангилал зүй (3.1), популяцийн динамик (3.2), биологи, экологийн (3.3) онцлог, түүний амьдрах орчинд (3.4) учирч буй сөрөг нөлөөллийг нарийвчлан судалж, улмаар шинжлэх ухаанд тулгуурласан хамгаалллын зүй зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэх, гений сан бүрдүүлэх (5.7.2), энэ зүйлийг хамгаалахад чиглэсэн мэдлэг, боловсролыг албан ба албан бус сургалтаар олгох (2.1), олон нийтийн мэдээллийн хэрэгслээр (2.2; 2.3) өргөн олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай гэх мэтээр санал дэвшүүлэв.

Энэ бүтээлийг улсын орны хэмжээнд болон орон нутгийн түвшинд бодлогын баримт бичиг, хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж буй төрийн албан хаагчид, их дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудын эрдэмтэн, судлаач, багш нар, оюутан, сонсогч, залуус, хууль сахиулах болон байгаль орчны байгууллагуудын албан хаагчид, мэргэжилтэн, улсын байцаагч, байгаль хамгаалагч нарт болон аливаа төслийн техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийж буй мэргэжилтэн, экспертүүд, дэлгэр сайхан Монгол орныхоо амьтны аймгийг сонирхон судлагч хүн бүхэнд зориулав.

1.2. МОНГОЛ ОРНЫ ХӨХТӨН АМЬТДЫН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Монгол орны хөхтөн амьтны ховордлын зэрэглэлийг Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан дансны стандарт аргачлалын шинэчилсэн хувилбарыг ашиглан гүйцэтгэсэн хоёр дахь удаагийн хэвлэл нийтийн хүртээл болж байна.

Өмнөх хэвлэл 2006 онд гарахдаа манай оронд амьдардаг уугуул 128 зүйлийг хамруулан авч үзэж байсан бол энэ удаагийн үнэлгээнд хамрагдсан хөхтөн амьтны зүйлийн тоо 141 хүрээд байгаа нь өмнөх үнэлгээнээс хойш манай орны хөхтөн амьтны бүлэгт 12 зүйл хөхтөн амьтан нэмэгдсэнтэй холбоотой. Энэ нь олон шалтгаантай.

Өнгөрсөн хугацаанд манай орны нутаг дэвсгэрээс хоёр зүйл сарьсан багваахай (говьсог соотгой (*Plecotus gobiensis)*, борхон турсаахай (*Hypsugo stubbei)*) шинжлэх ухаанд шинээр бүртгэгдэв. Үүний цаана 14 зүйл амьтан манай орны хөхтөн амьтны жагсаалтад шинээр оржээ. Үүнд: шавж идэштэн (хэвлүүн атаахай (*Sorex araneus)*, нугын малтаахай (*Crocidura suaveolens*), Азийн малтаахай (*C. Shantungensis*)); сарьсан багваахай (шивэр ацмар (*Murina hilgendorfi*), шовхчихт багваахай (*Myotis blythii*), амарын багваахай (*M.bombinus*), хээрийн багваахай (*M.davidi*), сүүлэрхэг багваахай (*M.longicaudatus*), саарал соотгой (*Plecotus kozlovi*), бор соотгой (*P. Ognevi*), хиргис соотгой (*P.strelkovi*)), мэрэгч амьтад (умардын оготно (*Alexandromys middendorffii*), дорнын сохдой (*Ellobius (talpinus) orientalis*), ойн хулгана (*Apodemus uralensis*)) зэрэг хөхтөн жижиг амьтад багтана.

Өмнөх үнэлгээнд орсон малтаахайн нэг зүйл (*Cricidura sibiricus*)-ийн оронд одоо 2 зүйл бичигдэж байгаа, багваахайн *Myotis* төрөлд бичигдэж байсан дөрвөн зүйлийн нэршил, статус өөрчлөгдөж, одоо энэ төрөл 7 зүйлтэй болсон, соотгой буюу *Plecotus* төрөлд урьд өмнө 2 зүйл багтаж байсан бол одоо 4 зүйл болж нэмэгдсэн, ангилал зүйн сүүлийн үеийн судалгаагаар, сохдой оготнын тархалтын зүүн хэсгийн популяцийг *Ellobius (talpinus) orientalis* хэмээн үзэх болсон (Lebedev *et al.,* 2020), хэвлүүн атаахай (Базардорж нар, 1976; Соколов и Орлов, 1980; Батсайхан нар, 2022), ойн хулгана (Батсайхан нар, 2022), умардын оготно (Moroldoev, 2024) манай орны нутаг дэвсгэрт шинээр бүртгэгдсэн зэргийг нэгтгэж үзвээс нийт 10 зүйл болно.

Шинжлэх ухаанд шинээр бүртгэгдсэн 2 зүйл, ангилал зүйн сүүлийн үеийн судалгаагаар, нэршил болон ангилал зүйн статус нь өөрчлөгдсөн 6 зүйл, манай орны нутаг дэвсгэрт шинээр бүртгэгдсэн 4 зүйл, нийт 12 зүйл амьтнаар өмнөх жагсаалт баяжсан байна. Өмнөх үеэс хөхтөн амьтны зүйлийн тоо нэмэгдсэн нь судалгааны цар хүрээ өргөжсөн, түүнчлэн зарим бүлгийн амьтдын ангилал зүйн статус, нэршил өөрчлөгдсөнтэй холбоотой.

Ангилал зүйн шинэчлэлээс үүдэн багагүй өөрчлөлт орсон бүлэгт шавж идэштэн болон гар далавчтаны баг хамаарна. Ялангуяа гар далавчтаны ангилал зүй, филогенетикийн судалгаанд молекул биологийн арга нэвтэрч эхэлснээр сүүлийн жилүүдэд ангилал зүйн уламжлалт төсөөлөл ихээхэн өөрчлөгдөх болов. Үүнээс үүдэн өмнөх нэршил өөрчлөгдөх, эс бөгөөс нэг зүйл хэд хэдэн зүйл болж салах гэх мэт өөрчлөлт гарснаар өмнөх үнэлгээнд ороогүй олон зүйл манай орны амьтны аймагт шинээр нэмэгдэж байна.

1.3. МОНГОЛ ОРНЫ ХӨХТӨН АМЬТДЫН ЗҮЙЛИЙН ҮНЭЛГЭЭ БА ХОВОРДЛЫН ШАЛТГААН

Ангилал зүйн судалгааны сүүлийн үеийн шинэлэг үр дүнг өөрийн орны хөхтөн амьтны Улаан дансны үнэлгээнд баримтлах нь бидний зайлшгүй дагаж мөрдөх зарчим мөн.

Үнэлгээ хийсэн 141 зүйл хөхтөн амьтны дотор бүс нутгийн хэмжээнд Устсан (RE) 1 зүйл, Устаж байгаа (CR) 1 зүйл, Устаж болзошгүй (EN) 9 зүйл, Эмзэг (VU) 15 зүйл, Ховордож болзошгүй (NT) 18 зүйл, Анхааралд өртөхөөргүй (LC) 76 зүйл, Мэдээлэл дутмаг (DD) 16 зүйл, Үнэлэх боломжгүй (NA) 4 зүйл хэмээн үнэлгджээ (Хүснэгт 1; График 1).

Хүснэгт 1. *Монгол орны хөхтөн амьтдын үнэлгээний зэрэглэл*

№	Зэрэглэл	Зүйлийн тоо	Эзлэх хувь
1	**БҮС НУТГИЙН ХЭМЖЭЭНД УСТСАН (RE)**	1	0.7%
2	**УСТАЖ БАЙГАА (CR)**	1	0.7%
3	**УСТАЖ БОЛЗОШГҮЙ (EN)**	9	6.4%
4	**ЭМЗЭГ (VU)**	15	10.6%
5	**ХОВОРДОЖ БОЛЗОШГҮЙ (NT)**	18	12.8%
6	**АНХААРАЛД ӨРТӨХӨӨРГҮЙ (LC)**	77	54.6%
7	**МЭДЭЭЛЭЛ ДУТМАГ (DD)**	16	11.3%
8	**ҮНЭЛЭХ БОЛОМЖГҮЙ (NE)**	4	2.8%
	Нийт	**141**	**100.0**

Цөөвөр чоныг хоёр удаагийн үнэлгээгээр Бүс нутгийн хэмжээнд Устсан хэмээн үзсэн боловч манай орны өмнөд хилийн ойролцоо Хятадын Ганьсу мужийн Алтан ууланд автомат камерт бүртгэгдсэн баттай мэдээ сүүлийн жилүүдэд гарсан (Xue *et al.,* 2015) нь энэ зүйл манай орны нутагт илрэх боломжтой болохыг илтгэнэ.

График 1. *Монгол орны хөхтөн амьтдын ховордлын зэрэглэл (тоо ба хувиар харуулав)*



Устаж байгаа, Устаж болзошгүй, Эмзэг гэх гурван зэрэглэлийг хамтад нь ховордлын зэрэглэлтэй буюу устах эрсдэлтэй түвшний бүлэгт хамааруулдаг. Өмнөх үнэлгээгээр энэ 3 зэрэглэлд 22 зүйл хөхтөн хамрагдаж байсан бол энэ удаад 25 зүйл болж өсөв. Өөрөөр хэлбэл, манай орны нийт хөхтөн амьтны дотор устах эрсдэлд өртөх магадлалтай зүйлийн эзлэх хувь хэмжээ 2006 оны үнэлгээгээр 17.1% байсан бол одоо 17.7% болж өссөн байна.

Ховордож болзошгүй зэрэглэлд өмнө 7 зүйл байсан бол одоо 18 зүйл болжээ (Хүснэгт 2). Ховордож болзошгүй зэрэглэл бол анхаарал хандуулахгүй бол устах эрсдэлд өртөх магадлал хамгийн ойр байгаа дараагийн шатны зэрэглэл болно. Ховордож болзошгүй зэрэглэлд орсон зүйлийн тоо олон болсон нь хоёр үндсэн шалтгаантай. Үүнд хамгааллын арга хэмжээний үр дүнд ховордлын дээд түвшний зэрэглэлээс зарим зүйлийн зэрэглэл буурч Ховордож болзошгүй зэрэглэлд шилжсэн. Тухайлбал, хулан Устаж болзошгүй зэрэглэлээс Ховордож болзошгүй зэрэглэлд шилжсэн байна. Өөр нэг шалтгаан бол Мэдээлэл дутмаг гэж үнэлэгдэж байсан олон зүйлийн талаар судалгааны мэдээлэл нэмэгдэж, зарим зүйлийн (хөхвөр олби, хүрэн баавгай, голын халиу, цоохондой г.м) ховордлын зэрэглэл тодорхой болж байгаатай холбоотой.

Хүснэгт 2. *Монгол орны хэмжээнд Устаж байгаа, Устаж болзошгүй, Эмзэг болон Ховордож болзошгүй хөхтөн амьтад*

Устаж байгаа (CR)	Устаж болзошгүй (EN)	Эмзэг (VU)	Ховордож болзошгүй (NT)
Мазаалай баавгай	Азийн минж	Амарын багваахай	Сүүлэрхэг багваахай
	Голын халиу	Хэнтийн огдой	Борхон турсаахай
	Ирвэс	Монгол тарвага	Алтайн тарвага
	Тахь	Ойн унтаахай	Гозоорой зурам
	Хүдэр	Эрээн хүрнэ	Хөхвөр олби
	Монгол бөхөн	Ойн булга	Зүлгийн оготно
	Хавтгай	Мануул	Соколовын шишүүхэй
	Цаа буга	Аргаль	Сухайн чичүүл
	Хандгай	Цагаан зээр	Ойн хулгана
		Хүрэн баавгай	Соотон алагдаахай
		Саарал чоно	Зүүнгарын даахай
		Шилүүс	Хярс
		Халиун буга	Үнэг
		Хар сүүлт зээр	Халздай дорго
		Янгир	Цоохондой
			Хулан
			Зэрлэг гахай
			Бор гөрөөс

Гэтэл энэ харьцаа ангилал зүйн бүлэг бүрд харилцан адилгүй. Тухайлбал, тууртан (салаа туруутан, битүү туурайтан) амьтдад хамаарах 14 зүйлийн дотор Ховордож болзошгүй зүйл 3 байгаа ба үлдэх 11 зүйл нь ховордлын зэрэглэлтэй (Устаж болзошгүй, Эмзэг).

Түүнчлэн мах идэштний багт хамаарах 23 зүйлийн дотор бүс нутгийн хэмжээнд Устсан нэг зүйл (цөөвөр чоно), Устаж байгаа 1 зүйл (мазаалай) байгаа нь анхаарал татаж байна. Нэг зүйлийн ховордлын зэрэглэл ахиж Ховордож болзошгүй зэрэглэлээс Эмзэг зэрэглэлд орсон нь мануул, саарал чоно, шилүүс. Эдгээр 3 зүйл махчдын экологийн зарим судалгаа хийгдсэн,

тархалт өргөн боловч тоо толгойн мэдээлэл тун хомс, учрах аюул нэмэгдсэний үрээр ховордлын зэрэглэлд өөрчлөлт орж байна. Энэ бүлгийн мангис доргын мэдээлэл дутмаг, дөнгөж 7 зүйл л Анхааралд өртөхөөргүй зэрэглэлд орсон ч эдгээр нь ихэнхдээ суусрын овгийн жижиг биетэй төлөөлөгчид (хотны үен, цагаан үен, ойн солонго, хээрийн солонго, өмхий хүрнэ, хадны суусар) байна. Эдгээр зүйлийн тархалт харьцангуй өргөн боловч, экологи, тоо толгойн талаар зүйл бүрд хамаарах тодорхой мэдээлэл дутагдалтай хэвээр. Өргөн тархдаг учраас л Анхааралд өртөхөөргүй зэрэглэлээр үнэлсэн гэж дүгнэхээр байгаа ч экологийн судалгааг нарийвчлан хийх аваас дараагийн үнэлгээнд мануулын жишгээр өөрчлөлт гарч таарна. Энэ үүднээс суусрын овгийн жижиг биетэй төлөөлөгчдийг онцгойлон анхаарч, дагнан судлах нь ойрын хугацааны зорилт байхаар байна.

Тууртан болон мах идэшт амьтад бэлчээр нутгаар шахагдах, хууль бусаар агнах, тоо толгойг нь зориуд цөөрүүлэх зэрэг сөрөг нөлөө багагүй байгаагаас энэ хоёр багийн төлөөлөгчид дунд устах эрсдэл өндөртэй зүйл олон байна. Гэвч хүний болон аж ахуйн нөлөөлөлд хамгийн их өртөмтгий мах идэшт амьтдаас ирвэс, тууртан амьтдаас хулан, халиун бугын зэрэглэл хоёр шатаар, тахь, цагаан зээр, аргаль зэрэг амьтдын ховордлын зэрэглэл нэг шат буурсан нь сайшаалтай хэрэг. Энэ нь юуны өмнө эдгээр зүйлийн хамгаалалд томоохон ахиц дэвшил гарсан, түүнчлэн зарим зүйлийн экологи, популяцийн төлөв байдлын судалгааны үр дүн улам бүр тодорхой болж, үнэлгээ илүү бодит болж байгаатай холбон тайлбарлах нь зүйд нийцнэ.

Энэ удаагийн үнэлгээнд амьдрах орчны хэв шинж, зүйлийн оршихуйд учирч байгаа дарамт, хамгааллын арга хэмжээг томьёолохдоо стандартчилсан кодыг бүх зүйлд нэгэн жигд ашигласан нь онцлог болов. Байгальд Устсан нэг зүйл болон ховордлын зэрэглэл (Устаж байгаа, Устаж болзошгүй, Эмзэг)-тэй 25 зүйл, Ховордож болзошгүй 18 зүйлийн ховордлын шалтгаанд дүн шинжилгээ хийж үзвээс, ховордолд хүргэж байгаа нийтлэг шалтгаанд уур амьсгалын өөрчлөлт (21), бэлчээрийн доройтол (25), ой хээрийн түймэр (8), тасархайтсан жижиг популяци (15), агнуур (15), хүний нөлөө (10), шугаман дэд бүтэц (3), өвчин эмгэг (4), үлийн цагаан оготнын хор (2), уул уурхай (10) зэрэг болж байгаа бол 13 зүйлийн хувьд ховордож буй шалтгаан нь тодорхойгүй ажээ.

Өмнөх 2006 оны үнэлгээгээр, Монгол орны ховордож буй хөхтөн амьтдын 57% нь агнууpаас үүдэлтэйгээр хорогдож байна хэмээн үзэж байсан бол 2025 онд хууль бус агнуур 12% болтлоо буурсан (График 2) нь хууль сахиулах байгууллагууд энэ чиглэлд нэлээд анхаарал хандуулах болж хуулийн хэрэгжилт болон талуудын хамтын ажиллагаа (улсын болоод орон нутгийн түвшинд) сайжирсан, мөн энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх мэдээлэл, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах болсон, улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөхөд анхаарч ажилласан зэрэг олон зүйлс нөлөөлсөн байх боломжтой.

Тухайн үед уур амьсгалын өөрчлөлт 5 зүйлийн хувьд ховордуулах шалтгаан болж байсан бол өдгөө 21 (17%) зүйлд учирч буй аюул болж 4 дахин нэмэгдэж, үүнийг дагаад амьдрах орчны доройтол, хомсдолын нөлөөлөл ч нэмэгджээ. Доорх хүснэгтээр зүйл тус бүрийн ховордлын анхдагч, хоёрдогч болон гуравдагч шалтгаануудыг харуулав (Хүснэгт 3).

График 2. *Ховордлын ангилалд орсон Монгол орны 44 зүйл хөхтөн амьтдад учирч буй аюул занал (хувиар харуулав)*



Хүснэгт 3. *Ховордлын ангилалд орсон Монгол орны 44 зүйл хөхтөн амьтдад учирч буй аюул занал, бэрхшээл (тод хар нь анхдагч, хар саарал нь хоёрдогч, цайвар саарал нь гуравдагч эрэмбийн аюул занал)*

№	Зүйлийн нэр (Монгол)	Зэрэглэл (2025)	Тасархайтсан жижиг популяци	Уур амьсгалын өөрчлөлт	Агнуур	Амьдрах орчны доройтол	Амьдрах орчны хомсдол	Хүний нөлөө	Үлийн цагаан оготны хор	Шугаман дэд бүтэц	Уул уурхай	Гал түймэр	Өвчин эмгэг	Тодорхойгүй
1	Цөөвөр чоно	Бүс нутагт устсан (RE)												
2	Мазаалай баавгай	Устаж байгаа (CR)												
3	Азийн минж	Устаж болзошгүй (EN)												
4	Голын халиу	Устаж болзошгүй (EN)												
5	Ирвэс	Устаж болзошгүй (EN)												
6	Тахь	Устаж болзошгүй (EN)												
7	Хүдэр	Устаж болзошгүй (EN)												
8	Монгол бөхөн	Устаж болзошгүй (EN)												
9	Хавтгай	Устаж болзошгүй (EN)												
10	Цаа буга	Устаж болзошгүй (EN)												
11	Хандгай	Устаж болзошгүй (EN)												
12	Амарын багваахай	Эмзэг (VU)												
13	Хэнтийн огдой	Эмзэг (VU)												

14	Монгол тарвага	Эмзэг (VU)												
15	Ойн унтаахай	Эмзэг (VU)												
16	Эрээн хүрнэ	Эмзэг (VU)												
17	Ойн булга	Эмзэг (VU)												
18	Мануул	Эмзэг (VU)												
19	Цагаан зээр	Эмзэг (VU)												
20	Аргаль	Эмзэг (VU)												
21	Саарал чоно	Эмзэг (VU)												
22	Хүрэн баавгай	Эмзэг (VU)												
23	Шилүүс	Эмзэг (VU)												
24	Халиун буга	Эмзэг (VU)												
25	Хар сүүлт зээр	Эмзэг (VU)												
26	Янгир	Эмзэг (VU)												
27	Сүүлэрхэг багваахай	Ховордож болзошгүй (NT)												
28	Борхон турсаахай	Ховордож болзошгүй (NT)												
29	Алтайн тарвага	Ховордож болзошгүй (NT)												
30	Гозоорой зурам	Ховордож болзошгүй (NT)												
31	Хөхвөр олби	Ховордож болзошгүй (NT)												
32	Зүлгийн оготно	Ховордож болзошгүй (NT)												
33	Соколовын шишүүхэй	Ховордож болзошгүй (NT)												
34	Сухайн чичүүл	Ховордож болзошгүй (NT)												
35	Ойн хулгана	Ховордож болзошгүй (NT)												
36	Соотон алагдаахай	Ховордож болзошгүй (NT)												
37	Зүүнгарын даахай	Ховордож болзошгүй (NT)												
38	Хярс	Ховордож болзошгүй (NT)												
39	Үнэг	Ховордож болзошгүй (NT)												
40	Халздай дорго	Ховордож болзошгүй (NT)												
41	Цоохондой	Ховордож болзошгүй (NT)												
42	Хулан	Ховордож болзошгүй (NT)												
43	Зэрлэг гахай	Ховордож болзошгүй (NT)												
44	Бор гөрөөс	Ховордож болзошгүй (NT)												

Тасархайтсан жижиг популяци бий болсон суурь нөхцөл амьдрах орчны хуваагдал, хомсдол, дороитол зэрэг бусад шалтгаантай ямар нэг байдлаар холбогдоно. Түүхэн үүднээс тасархайтаж үлдсэн жижиг популяцид Азийн минж, мазаалай, ойн унтаахай, Монгол бөхөн, цаа буга зэргийг хамааруулж болно. Бусад цөөнгүй зүйлийн тухайд (хүдэр, Монгол тарвага, ойн булга, аргаль, хярс, үнэг, чоно, цоохондой, зэрлэг гахай г.м) агнуур зохих нөлөөтэй хэвээр байгаа нь илт байна.

Уур амьсгалын өөрчлөлт ховордлын шууд шалтгаан болох нь бага ч түүнийг баталсан нотолгоо хомс. Харин уур амьсгалын өөрчлөлтийн улмаас хуурайшилт ихсэж амьдрах орчны чанар муудаж, тархац нутаг хумигдах, ойн болон тал хээрийн түймрийн давтамж нэмэгдэх зэргээр ховордлын хоёрдогч болон гуравдагч шалтгааны үндэс болох нь түгээмэл байна. Тасархайтсан жижиг популяци, амьдрах орчны хомсдол, дороитол гэдэг нь биологийн олон янз байдлын дороитлыг бий болгож байгаа үндсэн 5 бүлэг шалтгааны хамгийн их нөлөөтэйд нь тооцогдох газар ашиглалт (МА, 2005)-ын янз бүрийн илрэл, түүний үр дагавар юм.

Зэрлэг амьтны амьдрах орчин мал аж ахуйн бэлчээр, хадлан, ойн болон усан сангийн талбайтай давхацна. Иймээс мал аж ахуй, газар тариалан, усан сан, ойн сан бүгд нэгэн зэрэг зэрлэг хөхтөн амьтан амьдрах орон зай буюу амьтдын амьдрах орчин болно. Бэлчээрийн талхагдал, ойн зохисгүй ашиглалт, гадаргын усны бохирдол, хомсдол зэрэг амьдрах орчны чанарт хамаарах бүлэг шалтгаан манай орны хөхтөн амьтан устах, ховордох эрсдэлд орох шалтгааны зонхилох хувийг (56.8%) эзэлнэ.

Бэлчээрийн мал аж ахуй голлон эрхэлдэг манай орны нөхцөлд зэрлэг амьтны амьдрах орчин хуваагдах, хомсдолд орох, тархац хумигдах, дороитолд орох суурь үндэс нь малын тооны өсөлтөөс үүдэн гарч байгаа бэлчээрийн дороитол юм. Бэлчээр талхлагдаж, дороитолд орсноос зэрлэг амьтан бэлчээрээр шахагдах, хуурай, гандуу бүс нутгийн гадаргын ил задгай усыг хүн, мал эзэмшсэнээр зэрлэг амьтан усаар гачигдах хандлага газар авч байна.

Бэлчээр талхлагдсанаас мал аж ахуй эрхлэхэд хүндрэл учирч байгаа бол энэ нөхцөл байдал зэрлэг амьтдад бүр хүндээр тусна. Энэ байдал манай орны уулын туруутан болон түүнээс хамааралтай том биетэй мах идэшт амьтдын амьдрах орчин хумигдах байдлаар хамгийн тод илэрдэг. Тал хээрийн зэрлэг туруутан амьтдаас цагаан зээрийн тогтвортой популяци түүхэн тархац нутгийнхаа ихэнх хэсэгт мөхөж, тэд одоо Дорнод хээрийн багахан нутагт амьдарна. Саяхан НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцоос Даян дэлхийн газрын төлөв байдал: Бэлчээр ба нүүдлийн мал аж ахуй тайланг бэлтгэн гаргав. Энэ тайланд дурдсанаар "... бэлчээр нь эх газрын нийт гадаргын 54%-ийг эзлэх бөгөөд дэлхийн хүнсний үйлдвэрлэлийн 1/6, эх дэлхийн нүүрстөрөгчийн шингээлтийн 1/3-ийг бүрдүүлдэг, ...дэлхийн хэмжээгээр бэлчээр нутгийн 50% дороитолд орсон" гэж дүгнэжээ. НҮБ-ын цөлжилттэй тэмцэх конвенцын ерөнхий нарийн бичгийн дарга Ибрахим Тиав дээрх тайлангийн оршилд өгүүлэхдээ "Бид ойг огтлоход эсвэл 100 жилийн настай модыг тайрч унагахыг хараад өөрийн эрхгүй харамсах сэтгэл төрдөг. Гэтэл эрт үеэс бэлчээрээр ашиглаж ирсэн газар нутгийг "чимээгүйхэн" хувирган ашиглахад хүмүүс бараг л тоодоггүй. Үүгээр ч зогсохгүй бэлчээрээс хамааралтай байж, амьжиргаагаа залгуулж ирсэн нүүдлийн мал аж ахуй эрхлэгчид үүнээс ч дор үнэлэгдэх нь бүр ч харамсалтай" гэжээ. Монгол Улс 2026 онд НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцын талуудын 17-р хурлыг эх орондоо зохион байгуулах ба тус жилийг НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас Монгол Улсын санаачилгаар "Бэлчээр ба нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийн Олон улсын жил" болгон зарласан ажээ.

Бэлчээр, хөдөө аж ахуй, манай орны хувьд нүүдлийн мал аж ахуй эрхлэх үндсэн орчин байхын зэрэгцээ дэлхийн хэмжээнд биологийн олон янз байдлын чухал газруудын 33% бэлчээрт ноогдоно. Доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх нь манай орны хувьд байгаль хамгаалал, хөгжлийн бодлогын гол зангилаа сэдэв юм. Доройтсон бэлчээрийг сэргээснээр мал аж ахуй эрхлэх нөхцөл сайжрахаас гадна, зэрлэг амьтдын амьдрах нөхцөл ч сайжирч, улмаар уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад чухал нөлөөтэй. Доройтсон хээрийн бэлчээр нүүрсхүчлийн хийг шингээгч бус, харин ялгаруулагч нөлөөтэй болохыг судалгааны үр дүн тодорхой харуулдаг (Vetter, 2016).

Манай орны хэмжээнд эзэлж байгаа талбайн хэмжээгээр хамгийн уудам хээрийн экосистемийг хамгаалах, нөхөн сэргээх нь уур амьсгалын өөрчлөлтийг саармагжуулах, биологийн олон янз байдлыг хамгаалах талаар даяан дэлхийн хэмжээнд дэвшүүлж байгаа зорилготой нийцнэ.

Саяхан Биологийн олон янз байдлын тухай конвенц (CBD)-ын талуудын бага хурлаас "Куньмин-Монреалын биологийн олон янз байдлын хамрах хүрээ" баримт бичиг батлан гаргав. Одоо энэ баримт бичгийн дагуу үндэсний хэмжээний биологийг олон янз байдлын стратеги төлөвлөгөө боловсруулах ажил ид өрнөж байна. Энэ баримт бичигт дэвшүүлсэн 3 зорилго, 23 зорилтын дотор газар нутгийн 30%-ийг хамгаалалтад авах, доройтсон орчны 30%-ийг нөхөн сэргээх зорилт бий. Манай орон тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээгээр дэлхийн хэмжээнд тэргүүлэх байр эзлэх боловч хамгаалалтад авсан газар нутгийн үр нөлөө ямар байгаа нь хараахан тодорхой биш байна. Газар нутгийг тусгай хамгаалалтад авахаас гадна, доройтсон орчныг нөхөн сэргээх нь манай орны хэмжээнд онцгой анхаарал хандуулах шаардлагатай чиглэл. Доройтсон орчин гэдэгт манай орны нөхцөлд бэлчээрийн талхагдал зүй ёсоор орно. Ойрын ирээдүйд доройтсон бэлчээрийг сэргээх чиглэлээр бодит ажил өрнүүлэх нь зэрлэг амьтны амьдрах орчныг тэтгэн дэмжихэд нэгэн адил эерэг нөлөө үзүүлнэ.

Улам бүр нэмэгдэж байгаа шугаман дэд бүтцийг зэрлэг амьтанд ээлтэй бус арга, технологиор хэрэгжүүлэх аваас зэрлэг амьтны тархалт, тоо толгойд сөрөг нөлөө үзүүлнэ. Энэ бол манай орны нөхцөлд зэрлэг хөхтөн амьтны популяцид сөрөг нөлөө үзүүлэх болсон шинэ төрлийн дарамтын нэг юм. Үүний тодорхой баталгаа бол хулан, хар сүүлт зээр, ойн унтаахайн тархалт хязгаарлагдах хоёрдогч шалтгаанд шугаман дэд бүтэц орж байна.

Улаанбаатар хотоос зүүн урагш 1950-аад онд барьж байгуулсан анхны төмөр зам, түүний хоёр талаар татсан төмөр торон хашаа цагаан зээрийн шилжилт хөдөлгөөнд ямар их хор хөнөөл учруулсан болохыг бид их л хожуу ухаарлаа. Сүүлийн жилүүдэд тал хээр, говийн тууртан амьтдыг орчин үеийн аргаар судалж эдгээр амьтдын шилжилт хөдөлгөөн, хүний гараар бий болсон хаалт, саадыг даван туулах зан төрх, орон зайн байршил, түүний жилийн болон улирлын өөрчлөлтийн талаар олон шинэ мэдлэг бий болж байна.

Дорнод Монголын тусгаарлалт багатай буюу тасралтгүй үргэлжилсэн хялганат хээрт хүзүүвчилсэн 22 зээрийн 1-3 жилийн судалгааны баримтаар энэ зүйл байгалийн анхдагч төрх нь өөрчлөгдсөн орчноос зайлсхийдэг, өвөлждөг нутаг нь жил бүр харилцан адилгүй, нэг бодгалийн эзэмшил нутгийн хэмжээ жил бүр хэлбэлздэг бөгөөд дунджаар 19,000 км^2 хүрдэг, аль ч тусгай хамгаалалтай газрын нутаг дэвсгэрийн хэмжээ зээрийн нэг жилд ашиглах нутгийг бүрэн төлөөлж чадахгүй болохыг, шугаман саад тотгор тухайлбал, хилийн тор цагаан зээрийн шилжилт хөдөлгөөнд саад болохыг тус тус тогтоосон байна. Хүзүүвч зүүсэн зээрийн 80% хилийн шугамд тулж очоод дээд тал нь 11 км зайг хилийн торны дагуу туулжээ (Nandintsetseg *et al.,* 2019). Энэ нь хилийн торон хаалт тал хээрийн тууртан амьтны байгалийн нүүдэл, шилжилт хөдөлгөөнд таагүй нөлөө үзүүлдэг болохыг батална.

2023 оны 3-р сард Чойр-Замын-Үүд хүртэлх төмөр зам дагуух торон хашааны дагуу хийсэн нэг удаагийн хяналтаар нийтдээ 1,947 ш цагаан зээр, хар сүүлт зээрийн зэм бүртгэгдсэн. Үүнээс цагаан зээрийн сэг зэм 1,899 ш, хар сүүлт зээрийн сэг зэм 48 ш байсан ба ихэнх (1,326 ш) нь Дорноговь аймгийн нутагт олджээ (Д.Лхагвасүрэнгийн аман мэдээ). Энэ бол зөвхөн нэг удаагийн бүртгэл бөгөөд торонд орооцолдож гэмтэж бэртсэн амьтад, торонд орж үхсэн зарим амьтныг замаас алсад зайлуулсан, зэмийг мах идэшт амьтан идэж устгасан зэргийг тооцож үзэх аваас нэг жилд олон мянган зээр эндэж байгаа нь илт байна.

Шугаман дэд бүтцийн бүтээн байгуулалтыг байгаль, зэрлэг амьтанд ээлтэй гүйцэтгэхийн тулд амьтны шилжилт хөдөлгөөнийг дэмжих зориулалтаар хийх гарц, замын дагуух хориг хашаанд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг тусгасан стандартыг холбогдох салбарын мэргэжилтнүүд хамтран боловсруулж, түүнээ мөрдөн ажиллаж байна. Улс орны хөгжилд дэд бүтцийн хэрэгцээ, шаардлага зайлшгүй боловч бий болгосон бүтээн байгуулалт бүхэн байгаль, зэрлэг амьтандаа ээлтэй байх нь хөгжлийн бодлогын гол зорилт болж байна.

Зэрлэг амьтны зүйлийн бүрдэл, тархалт, байршил экологийн бүс нутаг бүрд харилцан адилгүй тул бүх нутагт нэг ижил стандарт байх боломжүй. Энэ талаар Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар ихээхэн санаачилга гарган ажиллаж байгааг тэмдэглэн хэлэх нь зүйтэй. Энэ байгууллагын санаачилга, идэвхтэй үйл ажиллагааны үр дүнд манай орны хэмжээнд хамгийн эхлээд “Тал хээр, говь цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтанд зориулсан гарц” стандартыг 2015 онд, “Уулархаг нутгийн зам, замын байгууламжийн нүүдлийн зэрлэг амьтдад зориулсан гарцын стандарт”-ыг 2018 онд, “Төмөр зам болон хурдны авто замын хориг хашааны стандарт”-ыг 2024 онд тус тус батлан гаргасан нь одоо шугаман дэд бүтцийн бүтээн байгуулалтад мөрдөгдөж байна. Стандартыг шинээр тавьж байгаа хурдны авто болон төмөр замын бүтээн байгуулалтад мөрдөн ажиллахын зэрэгцээ хуучин байгууламжид стандартын дагуу өөрчлөлт хийх шаардлага ч үүснэ. Энэ стандартыг мөрдлөг болгож гэмээн зэрлэг амьтны тархалт, тоо хэмжээнд сөрөг нөлөө үзүүлэх болсон шинэ төрлийн дарамт саармагжих боломжтой болно. Эдгээр стандарт нь нэг талаас тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, нөгөө талаас зэрлэг амьтны нүүдэл, шилжилт хөдөлгөөнийг дэмжиж, байгалийн экосистемийн нэгдмэл байдал, хэвийн үйл ажиллагааг хадгалах гэсэн хоёр өөр ашиг сонирхлыг харилцан уялдуулахад үйлчилнэ. Чухам үүнд стандарт гаргах нэг чухал өнцөг болох “... хамаарал бүхий ашиг сонирхолтой талуудын харилцан зөвшилцөж боловсруулсан” шалгуур үзүүлэлтийг дагаж мөрдөх хэрэгсэл болох стандартын ач холбогдол оршино. Хамаарал бүхий талууд гэвэл нэг талд шугаман дэд бүтцийн байгууламж, түүний ашиглалт, аюулгүй байдлыг хариуцсан зам тээврийн яамны харьяа төв, орон нутгийн байгууллагууд байх бол нөгөө талд байгалийн унаган төрхийг хадгалах, экосистемийн үйл ажиллагааны нэгдмэл байдал, зэрлэг амьтдын шилжилт хөдөлгөөнийг хангах үүрэг хүлээсэн байгаль хамгааллын төрийн болон төрийн бус байгууллага, амьтан хамгааллын мэргэжлийн байгууллага байна. Стандартын дагуу гарц байгуулах цэг, гарцын хэмжээ, хийцийг тухайн газрын нөхцөл, амьтны шилжилт хөдөлгөөний давтамж зэрэг үзүүлэлтийг харгалзан хамтран төлөвлөж, хэрэгжилтийг нь хангуулж, ашиглалтад хяналт тавьж, үр дүнг хамтран хүлээнэ.

Улаан дансны үнэлгээнд тухайн бүс нутаг, улс орны хэмжээнд тархан амьдардаг уугуул зүйл амьтдыг л хамруулдаг бодлогын улмаас гэрийн хулгана, бор харх, усны булга, заарт харх зэрэг 4 зүйл амьтныг үнэлгээнд оруулаагүй болохыг тэмдэглэх нь зүйтэй. Түүнчлэн хөхтөн амьтны зарим салбар (дэд) зүйлийн дотроос зөвхөн мазаалай баавгай, Монгол бөхөнг үнэлгээнд оруулж, зэгсний гахай, буган хандгай (Дорнын хандгай), говийн шилүүсийг тусад нь үнэлээгүй болно.

Монгол орны хөхтөн амьтны Улаан дансны хоёрдох хэвлэлээс наашгай олон үр дүн харагдаж байна. Юуны өмнө манай орны хөхтөн амьтны талаар судалгааны мэдээ сайжирч байна. Олон зүйл тууртан амьтны ховордлын зэрэглэлд ахиц гарсан байна. Энэ бол улаан дансны анхны үнэлгээ хийсэн 2006 онтой харьцуулахад байгалийн зэрлэг амьтны хамгаалалд багагүй ахиц дэвшил гарсны илэрхийлэл. Улаан дансны үнэлгээ бол зэрлэг амьтны популяцийн төлөв байдлын талаар гарч байгаа шинжлэх ухааны гол баримт бичиг болохын хувьд хамгаалал, ашиглалттай холбоотой арга хэмжээг хэрэгжүүлэх бодлогод тулгуур үндэслэл болох учиртай. Үүний учир улаан дансны эрх зүйн статусыг тодорхой болгох шаардлагатай. Улаан ном болон Улаан данс хоёр нэг агуулгын хоёр өөр илрэл гэдгийг одоо хүн бүр мэдэх болсон. Манай орны байгаль, зэрлэг ургамал, амьтны хамгааллын холбогдолтой эрхийн актуудад байгаа нэн ховор, ховор, элбэг хэмээх олон улсад үл ойлгогдох зэрэглэлийг халах, үгүй бол улаан дансны үнэлгээтэй дүйцүүлэх, улмаар цаашдаа улаан дансны үнэлгээний зэрэглэлийг хууль эрхийн актуудад тусгах шаардлага бий.

Хөхтөн амьтны улаан дансны үнэлгээний ажилд идэвхийлэн оролцож, сэтгэл гарган ажилласан мэргэжил нэгт нөхдөдөө талархал илэрхийлье.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

МОНГОЛ ОРНЫ УСТАЖ БАЙГАА (CR) БОЛОН УСТАЖ БОЛЗОШГҮЙ (EN) ХӨХТӨН АМЬТДЫН БИОЛОГИ, ЭКОЛОГИЙН ОНЦЛОГ, ХАМГААЛАЛ



2.1. ЦӨӨВӨР ЧОНО

Cuon alpinus (Pallas, 1811)

Баг: Мах идэштэн (Carnivora)
Овог: Чоно (Canidae)
Англи нэр: Dhole or Red Wolf
Ижил нэр: Шарнад цөөвөр (Дуламцэрэн, 2003).



Ангилал зүйн тойм. Мах идэштэн багийн хөхтөн амьтан бөгөөд *Cuon* төрлийн цорын ганц зүйл. Дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн гурван салбар зүйлтэйгээс гадна, өөр өөр өнгө зүс, хэмжээтэй гэсэн үндэслэлээр хэд хэдэн салбар зүйлийг санал болгосон (*Воценкрафт,* 2005). Энэ бүс нутагт *Cuon alpinus fumosus* гэх салбар зүйл нь тархжээ.

Таних шинж. Биеийн урт 110 см, сүүлний урт 50 см. Биеэр саарал чононоос жижиг, үнэгнээс том. Зүс тод улаан зээрд. Хэвэл, суга, цавь, чихний дотор тал цайвар. Сүүл саарал чононыхоос урт, сагсгар, үнэгнийхээс арай богино, жигд улаан буурал. Завж, багалзуурын үс урт.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Устаж болзошгүй (EN).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд бүс нутагт Устсан (RE) (Clark *et al.,* 2006).

2025 онд бүс нутагт устсан (RE). Өмнөговийн Зөөлөн ууланд 1969 онд нэг бодгаль хавханд орсон нь Монгол оронд байгааг нотолсон баримт юм (Шийрэвдамба нар, 2013). Үүнээс хойш огт биечлэн харагдаагүй тул бүрэн устсан гэж үзэх үндэстэй ч Монгол Улсын хилийн цаахнатай Хятадын нутаг дэвсгэрт судалгааны зориулалтаар тавьсан автомат камерт орсон.

Үнэлгээ хийсэн: Б.Мөнхцог (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Бутан, Камбож, Хятад, Энэтхэг, Индонез, Лаос, Малайз, Мьянмар, Непал, Тайланд (Kamler *et al.,* 2015).

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол бол дэлхийн тархцын хойд зах юм. Өнгөрсөн зуунд Хэнтий, Хөвсгөл орчмын уулс, Хангай, Монгол Алтай, Алтайн өвөр говь, Өмнөговийн уулсаар ховор биш тохиолддог байжээ. 1930 онд Өмнөговийн Ноён, Сэврээ, Нэмэгт ууланд агнаж, 1940-өөд онд Цагаан богд, Эдрэнгийн нуруу, Суман хаданд үзсэн мэдээ бий. 1950 онд Монгол Алтайд устаж, Хөвсгөл орчимд алга болж, Өмнөговь, Алтайн өвөр говь, Говь Алтайн уулсаар ховор үзэгдэх больсон. Сэгс Цагаан Богдод 1967 онд хэд хэдэн удаа үзэгдсэн ба 1968 онд Өмнөговийн Алтан ууланд хавханд орсон байсныг нутгийн иргэд тухайн үед мэдээлсэн. Өмнөговийн Зөөлөн ууланд 1969 онд хавханд орсон нь Монголд байдгийг нотлох сүүлчийн баримт болов. 1991 оны өвөл Тува-Монголын хил орчимд энэ зүйлийг харсан хоёр тохиолдол бий. 1988 онд Монголын хил залгаа Тес-Хеймийн районд 4 бодгаль 2 хонь барьж, Цагаан толгойн Заставын офицер Гаврилов энэ зүйлийг үзсэн гэх баримт бий. 1995-1996 онд Байгалийн чанадын өмнөд бүс нутгаас улаан чонын 4 арьс бэлтгэсэн. Үүнээс хойш энэ чоныг үзсэн, олдсон бодитой баримтгүй. Одоо зөвхөн Алтайн өвөр говьд Аж Богдын нуруунаас Тост уул хүртэл, ялангуяа Цагаан Богд орчим, Өмнөговь, Хөвсгөлийн уулсаар тохиолдож магадгүй хэмээн судлаачид үздэг.



Амьдралын онцлог. Аргаль, янгир, туулай элбэгтэй говийн хад, цохиот уулс, бор гөрөөс, хүдэр, буга нутагладаг Хөвсгөлийн тайгын ян сарьдагт байршдаг байжээ. Сүрэглэн, идэш тэжээл бологч амьтдаа хоморголж барина. Гөрөөсний сэг зэм иднэ. Өнгөрсөн зуунд малд байнга довтолдог байсныг нутгийн иргэд нотолдог. Өмнөговийн Ноён оргилд агуйд үүрлэж, 2 бэлтрэг гаргасныг нутгийн мэдээлсэн. 1, 2-р сард отолж, 4-р сард бэлтрэгтэй байсан тухай мэдээ ч байдаг.

Тоо толгой, нягтшил. Монголд хамгийн сүүлд 1969 онд хавхаар агнасан тухай мэдээ бий ба тоо толгой, нягтшилын тухай мэдээ, баримт нэн хомс.

Ховордлын шалтгаан. Нутгийн малчдын малыг идэх тул авладаг, идэш тэжээл бологч зүйлүүд нь ховордож цөөрсөн, чоно, ирвэстэй идэш тэжээлийн өрсөлдөөнд ордог зэрэг хүчин зүйлс энэ зүйлийн ховордолд сөргөөр нөлөөлжээ.

Хамгаалсан байдал. Манай оронд 1973 оноос хуулиар агнахыг хориглож (Шийрэвдамба нар, 2013), улмаар Амьтны тухай хуульд нэн ховор амьтнаар оруулсан бөгөөд төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр зөвхөн эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх зориулалтаар агнаж, барьж болно (7.2). Үүнээс бусад зориулалтаар нэн ховор амьтныг агнаж бэлтгэсэн арьс, яс, бусад түүхий эдийг худалдах, худалдан авахыг хориглодог (7.3). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр цөөвөр чоно 2,280,000 төгрөг ба уг хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцын II хавсралтад бүртгэгдсэн (Чимэддорж нар, 2018). Монгол Улсын Улаан номд нэн ховор зүйлээр бүртгэгджээ (Шийрэвдамба нар, 2013). Тархаж байсан нутаг нь бүхэлдээ улсын тусгай хамгаалалттай газарт багтдаг.

Хамгаалах арга хэмжээ. Монгол орон дахь түүхэн тархац нутаг болон дамжин гүйдэлдэг юм уу түр шилжин ирж байршдаг байж болзошгүй гэх нутгуудад тусгайлан судалгааны ажлыг зохион байгуулж, устсан эсэхийг үнэлэн тогтоох, сэргээн нутагшуулах эсэх асуудлаар шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт саналыг боловсруулах, удмын санг хадгалах арга хэмжээ авах нэн шаардлагатай.

2.2. МАЗААЛАЙ БААВГАЙ

Ursus arctos gobiensis (Sokolov and Orlov, 1992)

Баг: Мах идэштэн (Carnivore)
Овог: Баавгай (Ursidae)
Англи нэр: Gobi Bear
Ижил нэр: *Ursus arctos pruinosus, U. a. Isabellinus.*



Ангилал зүйн тойм. Монгол Улсын Шинжлэх ухааны хүрээлэнгийн 1943 оны судалгаагаар албан ёсоор тусгай хэлбэр гэж үзсэн (Банников, 1954), мөн Соколов, Орлов нар (1992) *Ursus gobiensis* гэсэн бие даасан зүйл гэж тодорхойлсон ч цөөн бодгаль дээр морфологийн шалгууруар гаргасан дүгнэлт тул асуудалтай хэвээр (Schaller *et al.,* 1993; McCarthy, 1999) байна. Энэ салбар зүйлийг *U. a. pruinosus* Blyth, 1854 гэж дахин тодорхойлсон ч хожим нь энэ салбар зүйлийн газарзүйн тархцад Монгол орон хамаарахгүй гэж үзсэн. Соколов, Орлов нар 1980 онд энэ салбар зүйлийг *U. a. isabellinus* гэж үзсэн ба энэ салбар зүйлийн тархац нутагт саяхан хийсэн генетик судалгаагаар, Монгол орны мазаалайг энэ салбар зүйлийн хэлбэр гэж үзсэн (Tumendemberel *et al.,* 2021; 2023) бөгөөд *U. a. gobiensis* салбар зүйл нь уг салбар зүйлийг дагалдах синоним байх боломжтой. Геномын судалгааны үр дүнгээр мазаалай баавгай нь 0.32–1.21 сая жилийн өмнө бие даасан зүйл болон салж хөгжсөн болохыг тогтоосон (Odbayar *et al.,* 2024).

Таних шинж. Хумс цагаан, шулуун. Хүзүүний 2 талаар өргөн цагаан, босоо судал бие гүйцсэн бодгальд ч илэрнэ. Дал ба түүнээс доогуур бор хүрэн, мундаа, зоо нуруу, ууц бараан хүрэн, хавирга, бөөр, гуяны урд хэсэг бор хүрэн, хэвлий хонгор, хонго шаргалдуу бор хүрэн, дөрвөн мөч хар хүрэн, уруул хар ба нүд шар хүрэн (Болд, 1967). Шармаахайн биеийн урт 165 см, өндөр 70-80 см, жин 104 кг. Эвшийн биеийн урт 145 см, өндөр 65-68 см, жин 76 кг (Дэлгэрчимэг, 2020).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Устаж байгаа (CR) (D).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Устаж байгаа (CR), D (Clark *et al.,* 2006).

2025 онд Устаж байгаа (CR), D1; C2A. Энэ зүйлийн популяци нь маш бага бөгөөд 50-аас цөөн бодгаль байгааг генетикийн судалгаагаар тогтоосон (Tumendemberel *et al.,* 2019). Популяцийн хэмжээ 1970 оноос хойш тогтвортой байгаа ч жижиг популяцид тохиолддог цус ойртолт болон үржлийн хэмжээ бага зэрэг ховордлын хэд хэдэн шалтгаан байна. Тоо толгойн 50-аас цөөн үржлийн бодгалиас бүрдсэн популяци учраас D болон C шалгууруар үнэлэн Устаж байгаа зэрэглэлд оруулж, энэ салбар зүйлийн бүс нутгийн шалгуурын дээрх үнэлгээг хэвээр үлдээв.

Үнэлгээ хийсэн: Д.Дэлгэрчимэг, Б.Мижиддорж, А.Баясгалан, С.Пүрэвсүрэн (2025).

Хянасан: Б.Мөнхцог, С.Гомбобаатар (2025).

Дэлхийн тархац. Монгол орны Алтайн өвөр говьд тархсан. Мөн Хятад улстай хил залгаа нутаг руу шилжинэ (Дэлгэрчимэг, 2020).

Монгол орон дахь тархац, амьдрах орчин. Энэ зүйлийн тархац нутаг нь Алтайн өвөр говиос зүүн тийш Тост уул (Банников, 1954) хүртэл 45,000 км^2 өргөн уудам нутгийг хамарч байсан (Тулгат, 1995) боловч 1940 оноос хойш хүний хүчин зүйлсийн нөлөөгөөр аажмаар хумигдаж, 1970 он гэхэд тархцынхаа хойд хагаст үзэгдэхгүй болж хоёр дахин багассан ба 1975 онд түүний тархац нутгийг бүхэлд нь хамруулж улсын тусгай хамгаалалтад авч Говийн Их дархан цаазат газрыг байгуулснаар 1970-1990 онд харьцангуй тогтворжиж, 2000 оны эх хүрэхэд тархцынхаа өмнөд болон зүүн талдаа бага зэрэг тэлэх хандлагатай болсон. Говийн Их дархан цаазат газрын “А” хэсэгт 18,000 км^2 нутагт тархаж байв (Мижиддорж, 2006). Тархцынхаа зүүн хэсэгт Тост, Нэмэгт, Алтан ууланд гүйдлээр тохиолдож, мөн Шаригийн ганг орчимд зарим жил ичдэг байж магадгүй (Мижиддорж, 2018). Өнөөгийн байдлаар тархац нутаг нь зүүн талдаа Тост, Тосонбумба, Нэмэгт уул, баруун талдаа Шар Ухаа, Нарийн тоорой орчимд гүйдлээр хүрч тодорхой хугацаагаар байрших бөгөөд 20,000 км^2 уудам нутагт байна (Ариунбуян, 2024). Тархац нутгаасаа баруун тийш гүйдлээр Хятадын нутаг Харлаг тагийн нуруу, зүүн тийш Тост, Тосонбумбын нуруу, Алтан уул хүртэл шилждэг болохыг сансрын дохиолол бүхий хүзүүвчний мэдээллээр илрүүлсэн (Дэлгэрчимэг, 2020).

Алтайн өвөр говийн хэт гандуу цөл нь ургамалгүй нүцгэн гадарга, хуурай сайр, гаммад ихтэй тул хөрс их халж, агаарын халалт зуны улиралд ихэснэ. Уулархаг нутгаараа арай сэрүүвтэр. Мазаалай зун ихэвчлэн өглөө, үдэш, шөнийн идэвхжил сайн, бага үдээс үд хэвийх хүртэл сэвшээ салхитай, өндөрлөг, сэрүүн газруудаар хэвтэж өнгөрүүлнэ (Мижиддорж, 2013).



Амьдралын онцлог. Мазаалай баавгайн идэш тэжээлд ургамал зонхилдог ч, холимог идэштэн. Ургамлаас намхан гишүүнэ, хармаг, зээргэнэ зэрэг 33 зүйл, мөн мэрэгчид, том хөхтөн, шувуу, мөлхөгчид зэрэг 18 зүйл сээр нуруутан улирлын онцлогоос хамаарч харилцан адилгүй байх ба хааяа шавжаар хооллох нь тохиолдоно (Мижиддорж, 2006). Ичээндээ 11-р сарын эхээр орж, 3-р сарын сүүлч, зарим тохиолдолд 2-р сард ичээнээсээ гарна. Эвш ичээндээ 1-2-р сард 1-2 бамбарууш төрүүлнэ. Орооны үе нь 5-6-р сард болно (Болд, 1976; Мижиддорж, 2013). Хадны агуй, хонгил эсвэл өтгөн шигүү ургасан зэгс, сухайн ширэнгэд ичээлэх (Болд, 1967) ба сухай, шар мод, зээргэнэ, хулсны иш мөчрөөр дэвсгэр хийнэ. Харуй бүрий, шөнийн идэвхтэй боловч өдрийн цагаар хааяа тохиолдоно. Хадархаг газрууд тухайлбал, хад цохиот уулс, хадан хавцал, хадархаг уулын орой (6), агуйг (7.1) шүтэн байршина.

Тоо толгой, нягтшил. Монгол орны мазаалай баавгайн популяцийн тоо толгойн талаарх баримтуудаас дурдвал, А.Болд нар (1967) 17 бодгаль, С.Дуламцэрэн нар (1981) 20, Бугаев (1985) 22, Жирнов (1986) 50, G.Schaller (1993) 28, Б.Мижиддорж (1998) 20, Батсайхан нар (2004) 25, Н.Баттогтох (2018) 36, Т.Одбаяр нар (2019) 29, Хятадын Шинжлэх ухааны академи (2022) 50 бодгаль байна хэмээн тус тус тооцоолсон байдаг бөгөөд сүүлийн үеийн судалгааны үр дүнд, манай оронд мөн адил 50 орчим бодгаль мазаалай баавгай амьдарч байгааг тогтоосон.

Ховордлын шалтгаан. Мазаалай баавгайн тархац нутаг 1940-өөд оны үетэй харьцуулахад, өнөөгийн байдлаар 2.5 дахин (65%-аар) хумигдсан нь говь цөл нутагт хүн амын суурьшил, өсөлт, хөл хөдөлгөөн, мал аж ахуй, газар тариалан эрхлэх зэрэг аж ахуйн үйл ажиллагаа нэмэгдсэнтэй холбоотой. Үүнээс шалтгаалан мазаалай баавгай хүнгүй зэлүүд газар руу шахагдаж, шилжилт нь хязгаарлагдах болсон.

Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт, хуурайшилт, жил дараалсан ган гачгийн улмаас ургамлын гарц муудаж, түүний идэш тэжээл хомсдох, мөн ундаалдаг булаг шанд, баянбүрдүүд хатаж, ширгэж байгаа нь амьдрах орчныг доройтолд оруулж, шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, үхэл хорогдлыг нэмэгдүүлж, үржил хөгжилд нь сөргөөр нөлөөлж байж болзошгүй. Тухайлбал, Говийн Их дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны мониторинг судалгаагаар, 1992 оноос хойш энэ бүс нутагт ган гачиг болж, жилийн хур тунадасны хэмжээ 100 мм-ээс 50 мм хүртэл буурсан (Мижиддорж, 2013) ажээ.

Мөн Говийн Их дархан цаазат газрын “А” хэсгийн орчны бүсэд олон тооны уул уурхайн ашиглалтын болон хайгуулын лиценз олгогдож, үүгээр зогсохгүй Бургастай болон Шивээхүрэн хилийн боомтуудыг холбох төмөр замын бүтээн байгуулалтыг төлөвлөж буй зэрэг нь мазаалай баавгайн тархац нутгаа тэлэх боломжийг хязгаарлаж, тасархайтуулах, улмаар түүний амьдрах орчны чанарыг алдагдуулах, доройтуулах, хумигдах эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Мазаалай баавгайн нялх бамбарууштай эвш жил өнжиж үржилд ордог тул өсөлт удаантай амьтан. Энэ зүйлийн популяцид эм бодгалиуд цөөрч хүйсийн харьцаа алдагдаж байгаа нь мазаалай баавгайн популяцийн өсөлтийг удаашрахад нөлөөлж байна (Tumendemberel *et al.,* 2021). Генийн олон янз байдлын бууралт, үр төлөрхөг чанар доройтох, үр төлийн мэнд үлдэх чадвар муудах, цус ойртолт, зүйлийн дотоод өрсөлдөөн ихсэж, ялангуяа эмэгчний төлөөх өрсөлдөөн ширүүсэж нэг нэгнээ гэмтээх, барих зэргээр цөөн тооны бодгальтай популяцид тулгардаг олон эрсдэл үүсэж байж болзошгүй тул урт хугацааны тогтвортой цогц судалгааны хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх нь зохистой.

Хамгаалсан байдал. Монгол Улс 1953 оноос хойш мазаалай баавгай агнахыг хуулиар хориглож иржээ (Шийрэвдамба нар, 2013). Амьтны тухай хуульд нэн ховор амьтнаар оруулсан бөгөөд төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр зөвхөн эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх зориулалтаар агнаж, барьж болно (7.2). Үүнээс бусад зориулалтаар нэн ховор амьтныг агнаж бэлтгэсэн арьс, яс, бусад түүхий эдийг худалдах, худалдан авахыг хориглосон (7.3). Мөн (7.4) нэн ховор амьтны амьдрах нутагт хүнд үйлдвэр, цахилгаан станц, химийн үйлдвэр байгуулах, авто болон төмөр зам тавих, уул уурхайн олборлолт явуулах, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх асуудлыг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлтийг үндэслэн Засгийн газар шийдвэрлэдэг.

Тус хуулинд (11.1.2) булаг, шанд, хужир марааНД ирж буй амьтныг отож агнах, (11.1.3) өөр нутагт шилжин байршиж байгаа агнуурын амьтныг агнах, барих, (11.1.4) амьтны үүр, ичээ ухах, гэмтээх, (11.1.5) агнуурын амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх зорилго бүхий байр, саравч, тэжээл мараа, бусад байгууламжийг эвдэж гэмтээх, устгах, (11.1.7) амьтны үр төлийг агнах, шувууны өндгийг түүх, гэмтээх, устгах зэрэг олон үйл ажиллагааг хориглосон. Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр

мазаалай баавгай 37,000,000 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу).

Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ын I хавсралтад бүртгэгдсэн (Чимэддорж нар, 2018; http://checklist.cites.org). Мөн Монгол Улсын Улаан номын бүх хэвлэлд нэн ховор зүйлээр бүртгэгджээ (Шагдарсүрэн нар, 1987; Шийрэвдамба нар, 1997; 2016).

Энэ зүйлийн өнөөгийн үндсэн тархац нутаг нь Говийн Их дархан цаазат газрын “А” хэсэгт хамаарах боловч түүний тархцын зүүн (Тост уул), зүүн хойд зах (Нэмэгт уул) нь Тост, Тосонбумбын нурууны байгалийн нөөц газар болон Говь Гурвансайханы байгалийн цогцолборт газар зэрэг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдсан.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилга, Засгийн газрын 2023 оны 437 дугаар тогтоолоор мазаалай баавгайг “Үндэсний бахархалт амьтан”-аар зарлан тунхаглаж, жил бүрийн 2 дугаар сарын 28-ны өдрийг “Мазаалай баавгайн өдөр” болгон тэмдэглэж байхаар шийдвэрлэсэн.

Хамгаалах арга хэмжээ

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгын хүрээнд урт хугацааны цогц судалгаа, шинжилгээ бүхий хамгааллын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх нь зүйтэй.
- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/208 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Мазаалай баавгай хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөө (2025-2028)-ний хэрэгжилтийг хангаж, ажиллах
- Мазаалай баавгайг “Үндэсний бахархалт амьтан”-аар зарлан тунхагласныг олон улсад сурталчлан таниулж, олны анхааралд хүргэх, санал санаачилгыг дэмжих, хөрөнгө босгох, талуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх
- Энэ зүйлийн тархац, шилжилт хөдөлгөөн, коридор нутаг (4.3), ангилал зүй (3.1), популяцийн хэмжээ, төлөв байдал, хандлага (3.2), биологи, экологи (3.3), генетик, аюул занал (3.5), өвчин, эмгэг үүсгэгч, шимэгч (5.5), гений сан бүрдүүлэх (5.7.2) боломж зэргийг багтаасан урт хугацааны цогц судалгаа шинжилгээний хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх, үүний үндсэн дээр хамгааллын менежментийг төлөвлөх
- Мазаалай баавгайг авран хамгаалах санал, санаачилгыг олон улсын түвшинд (1.2.1.1) болон улс орны хэмжээнд өрнүүлж, олон нийтийн анхаарлыг татахад чиглэсэн мэдээлэл (2), сурталчилгааны ажлуудыг тогтмол зохион байгуулах
- Мазаалай баавгайг “Үндэсний бахархалт амьтан”-аар зарлан тунхагласныг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр (2.2, 2.3) өргөн олон нийтэд тогтмол сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, мөн энэ зүйлийг хамгаалахад чиглэсэн мэдлэг, боловсролыг албан болон албан бус сургалтаар олгох (2.1) ажлыг эрчимжүүлэх шаардлагатай.
- Мөн нэмэлт тэжээлийн чанарыг сайжруулах, тэжээлийн байнгын нөөцийг бий болгох, өнөөгийн нэмэлт тэжээл тавьж буй цэгүүдийн тоог нэмэгдүүлж, тэлэх
- Энэ зүйлийн үндсэн тархац болон коридор нутгуудад задгай ус гаргаж, усны хүртээмжийг нэмэгдүүлэх, баянбүрд, булаг шандын бут сөөг, зэгс хулсан ширэнгийг цөлжилт, хуурайшилт, хүний зохисгүй нөлөөллөөс хамгаалж, нөхөн сэргээх зэргээр амьдрах орчин нөхцөлийг сайжруулах, тэтгэх, тэлэх боломжийг эрэлхийлсэн олон янзын арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

2.3. АЗИЙН МИНЖ

Castor fiber (Linnaeus, 1758)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Минж (Castoridae)
Англи нэр: Eurasian Beaver
Ижил нэр: Голын минж*, C. birulai*, *C. bindai*, *C. flavus* (Wilson and Reeder, 2005).



Ангилал зүйн тойм. Монгол болон Хятадын хил дамжин урсах Булган голын сав, түүний зарим цутгал голуудад үлдэж хоцорсон Азийн минж (*C. f. birulai*) энэ зүйлийн цөөн тооны автохтон популяцийн нэг. Энэ салбар зүйл Монголд тархсан ба Хятадад байх боломжтой. Сүүлийн үеийн молекул биологи, филогенетикийн судалгаагаар, Азийн минжний хоёр бүлгийг ялгасан бөгөөд зүүн хэсэгт хамаарах Сибирь, Монголын минж түүхэн урт хугацаанд тусгаарлагдсан өвөрмөц генофонд бүхий салбар зүйлүүд болохыг баталжээ (Ducroz *et al.,* 2005; Durka *et al.,* 2005; Munclinger *et al.,* 2022).

Таних шинж. Нас гүйцсэн минжний жин 22.5 кг, сүүлний урт 29.5 см, өргөн нь 15.3 см. Монгол орны хамгийн том биетэй мэрэгч. Бие бахим, бөгтөрдүү, толгой их бие рүү шууд үргэлжилсэн мэт харагдах тул хүзүү тод ялгарч харагдахгүй. Зүс жигд хүрэн бор. Үсэн бүрхүүл нь урт сор, өтгөн ноолууртай. Нүд жижиг, чих хулгар, дугариг. Усанд сэлэхэд зохилдож хойд хөлийн хуруунууд

хоорондоо арьсаар холбогдож сэлүүрийн үүрэг гүйцэтгэнэ. Сүүл угаараа үстэй боловч ихэнх хэсэг нүцгэн, хайрсаар хучигдаж, хавтгай болсон. Аюул тохиолдох үед хавтгай сүүлээрээ ус алгадан бусдадаа чимээ өгөөд өөрөө усанд шумбана. Усанд шумбах үед хамрын сүв, чих хаагдаж ус орохоос хамгаална.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Ховордож болзошгүй (NT).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Устаж болзошгүй (EN), B1ab (iii) (Clark *et al.,* 2006).

2025 онд Устаж болзошгүй (EN), B1ab (iii). Энэ зүйлийн тархац нутгийн хэмжээ хязгаарлагдмал. Одоогоор өөр хоорондоо тусгаарлагдсан 3 популяци бий (үүний 2 нь нутагшуулсан). Булган голын автохтон, Ховд голын нутагшсан минжний амьдрах орчны чанар буурч байгаагаас уг зүйлийг B1ab (iii) шалгууруар үнэлж, Устаж болзошгүй зэрэглэлд оруулав. Нутагшуулсан зарим нутаг тухайлбал, Тэс голд минжний популяци өсөж байгаа ч Булган, Ховд голын минжний тоо толгой, тархацын хэмжээ хязгаарлагдмал байгааг үндэслэн ховордлын зэрэглэлийг хэвээр үлдээв.

Үнэлгээ хийсэн: Р.Самъяа, Н.Батсайхан, С.Шар, Д.Лхагвасүрэн, Э.Ундрахбаяр (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Атлантын далайн эргээс Байгаль нуур хүртэл Евразийн уудам нутагт тархаж байгаад өнгөрсөн зууны эхэн үе болоход цөөхөн газар үлдэж хоцорсон бол одоо олон оронд минж амьдарч байна. Минж одоогоор Австри, Беларусь, Бельги, Болгар, Герман, Дани, Их Британи, Казахстан, Латви, Лихтенштайн, Литва, Молдова, Монгол, Нидерланд, Норвег, Орос, Польш, Словак, Серби, Словени, Финлянд, Франц, Хятад, Хорват, Швед, Швейцар, Чех, Унгар, Украйн, Эстони (Zahler *et al.,* 2005) зэрэг оронд тархсан бөгөөд ихэнх оронд шинээр сэргээн нутагшуулжээ.

Монгол орны тархац, амьдрах орчин. Өнгөрсөн зууны эхний хагаст цөлөрхөг нутгаар урсдаг Булган голын сав газар багахан хэмжээний популяци үлдэж хоцорсон байв. Монгол-Германы хамтарсан экспедиц 1974, 1975, 1978 онд Ховд голд, 1985, 1988, 2002 онд Тэс голд шилжүүлэн нутагшуулжээ. Эдгээрийг Булган голоос шилжүүлэн нутагшуулсан нь Төв Азийн дотоодын урсгалтай усан санд Булган голын минжний генийн санг цэврээр хадгалах зорилготой (Stubbe, Dawaa 1983; Самъяа нар, 2012). Оросын Воронежийн нөөц газраас Ерөө голд минж нутагшуулах оролдлого амжилтгүй болсон (М.Штуббе, аман мэдээ). Тэсийн голд нутагшуулсан минжний тархалтын хамгийн дээд цэг Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумаас 45 км орчим зайд Тэс голын эхэнд бүртгэгджээ (Э. Магсаржавын аман мэдээ). Булган голын эхэнд Баян-Өлгий аймгийн Булган сумын төвөөс дээш 15 орчим км-т минжний суурьшил бүртгэгдсэн (Самъяа нар, 2012). Одоо Алтайн нурууны өвөрөөс гадагш урсгалтай Булган голд автохтон популяци, Ховд, Тэс голуудад сэргээн нутагшуулсан минжний шинэ популяци бий болоод байна. Туул голын сав газар нутагшуулж байгаа минж Оросын Воронеж, Германы Баваар мужаас гаралтай тул филогенетикийн үүднээс баруун хэсэгт хамаарах генефондтой. Минж амьдрах үндсэн орчин намуухан урсгалтай уулын гол, томоохон голын хажуугийн татуурга, голын адаг (5.1), нам дор тэгш газрын нуурын зах (5.5), намгархаг газар (5.3) юм.



Амьдралын онцлог. Ус, хуурай газрын амьдралтай. Аюулгүй байдлаа хамгаалах, идэш тэжээлээ хялбар зөөвөрлөх, нөөцлөхийн тулд голын гүн цүнхээл устай, өндөр эрэгтэй хэсэгт тогтмол байрлах үүр, овоохойгоо барина. Бүлээр амьдарна. Голын эргийн дагуу эзэмшил нутгаа тогтоож

хилийн заагаа байнга тэмдэглэнэ. Хавар 3, 4-р сард ороо нийллэг болж, хээлээ 100 орчим хоног тээнэ. 2-3 дүдэр гаргана. Гачууртын минж үржүүлгийн төвд нэг удаа 5 дүдэр төрүүлсэн тохиолдол бий. Дулааны улиралд зарим ургамлын ногоон навчаар хооллох ч хамгийн дуртай идэш тэжээл нь бургас, улиас зэрэг навчит модны шинэхэн найлзуурын навч, хальс, модлогийн зөөлөн хэсэг юм. Өвлийн тэжээлийн бүрэлдэхүүнд целлюлоз зонхилох үүрэг гүйцэтгэнэ. Голын эрэгт өвөл хэрэглэх модыг нөөцөлнө. Голын урсгал тогтуун цүнхээл хэсэгт намар мөс тогтохоос өмнө урт бургасны оройн шүүслэг, залуу найлзууртай хэсгийг усруу оруулан зэрэгцүүлж овоолно. Мөс хөлдсөн үед усан доогуур явж мөсөн доогуур орсон бургас, улиасны мөчрийг тайрч иднэ. Нарийнхан мөчир, найлзуурын хальсыг хуулж идэх дуртай. Минжтэй газар хавар мөс хайлах үед цайтал мөлжсөн нарийн тайрдаснууд голын захаар хөвөх нь элбэг тохиолдоно. Голын эрэгт үүрнийхээ дээр овоохой барина. Усны түвшнийг тогтмол барихын тулд голын салаа, цутгал голуудыг хааж далан барина.

Тоо толгой, нягтшил. Нэн ховор амьтан болох Булган голын минжний автохтон популяци, Ховд, Тэсийн голд сэргээн нутагшуулснаар шинээр үүсэж байгаа минжний популяцийн өсөлтийн төлөв байдлыг урт хугацаанд тасралтгүй хянах судалгаа хийгдээгүй. Хамгийн сүүлийн судалгаа 2014 онд зөвхөн Ховд голын дагууд хийгджээ. Энэ судалгаанаас үзвэл, Ховд голын дагууд амьдарч байгаа минжний нийт тоог 100 орчим гэж тооцсон (Шар, 2014) нь өмнөх үеэсээ буурсан үзүүлэлт болно. Увс аймгийн Тэс голд нутагшуулсан минжний популяци тогтвортой өсөж байгаа бөгөөд энд 1,359.3 км^2 нутагт тархсан хоёр гол байршил илрүүлжээ. Увс аймгийн нутагт хамаарах доод байршилд 12 бүл, 60 бодгаль, Завхан аймгийн Баянтэс сумын нутгийн дээд байршилд 80 орчим бодгаль амьдарч байна (Saveljev *et al.,* 2015). Үүний илрэл бол тархац нутгийн дээд цэг Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутагт хүрч, голын татуургад далан барьсан баримт юм.

Ховордлын шалтгаан. Булган, Ховд голын сав дагуу нутагладаг айл өрхийн ахуйн түлшний хэрэгцээ, гэрийн мод бэлтгэх зорилгоор минжний гол тэжээл болох бургасыг огтлох (1.3.3.1), тэмээ, ямаа зэрэг гэрийн мал бургасыг идэж гэмтээх (1.1.4.1) зэргээр орчны хомсдол дорoйтол үүсгэж байна. Булган голын Хятад дахь талд усан цахилгаан станцын даланг барьснаас тухайн бүс нутгийн минжний шилжилт хөдөлгөөнд саад үүсэж популяци тусгаарлалтад орсноос (9.1) эзэмшил нутаг хумигдах (9.9), үүнээс үүдэж цус ойртох, генетик хувьсал буурах (9.4) зэрэг нь ховордлын шалтгаан болно (М. Штуббе, аман мэдээ). Ховд голын минжний байршил голын дагуу улам доошилж эсвэл дээш өгсөж Сэжигтийн хавцал хүрч дундуураа багасаж байгаа (Шар, 2014) нь энэ хэсэгт хүн, малын нөлөө их байгааг илтгэж байна.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, өсгөн үржүүлэх, хамгаалах харилцааг зохицуулсан. Энэ хуульд нэн ховор амьтнаар орсон бөгөөд төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр зөвхөн эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх зориулалтаар агнаж, барьж болно (7.2). Үүнээс бусад зориулалтаар нэн ховор амьтныг агнаж бэлтгэсэн арьс, яс, бусад түүхий эдийг худалдах, худалдан авахыг хориглосон (7.3). Мөн (7.4) нэн ховор амьтны амьдрах нутагт хүнд үйлдвэр, цахилгаан станц, химийн үйлдвэр байгуулах, авто болон төмөр зам тавих, уул уурхайн олборлолт явуулах, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх асуудлыг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлтийг үндэслэн Засгийн газар шийдвэрлэдэг.

Үүнээс гадна, (11.1.2) булаг, шанд, хужир мараанд ирж буй амьтныг отож агнах, (11.1.3) өөр нутагт шилжин байршиж байгаа агнуурын амьтныг агнах, барих, (11.1.4) амьтны үүр, ичээ ухах, гэмтээх, (11.1.5) агнуурын амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх зорилго бүхий байр, саравч, тэжээл мараа, бусад байгууламжийг эвдэж гэмтээх, устгах, (11.1.7) амьтны үр төлийг агнах, шувууны өндгийг түүх, гэмтээх, устгах зэрэг олон үйл ажиллагааг хориглодог. Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан

“Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Азийн минж 3,000,000 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу).

Мөн Монгол Улсын Улаан номд Азийн минж (*Castor fiber birulai*) нь нэн ховор зүйлээр бүртгэгдсэн (Шагдарсүрэн нар, 1987; Шийрэвдамба нар, 1997; 2013).

Энэ зүйлийн тархац нутаг нь Булган гол-Их Онгогийн байгалийн цогцолборт газар (Булган голын ай сав дагуу энэ зүйлийн автохтон популяци амьдардаг бөгөөд энэ цогцолборт газарт нийт тархац нутгийнхан 26% хамгаалагдсан), мөн Тэсийн голын байгалийн нөөц газар зэрэг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Булган голын автохтон, Ховд, Тэс голуудад нутагшуулсан минжний шинээр үүссэн популяцийн тархац, популяцийн бүтэц, өсөлтийн чиг хандлага, тоо хэмжээг үнэлэх судалгааны ажил (3.2) хийж, хамгаалах арга хэмжээг оновчтой төлөвлөх (3.8) шаардлагатай. Минж нутагшуулсан Ховд голын дагуу бургас тариалж амьдрах орчны чанарыг тэтгэх (4.2), минжний амьдрах орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд орон нутгийн иргэдийн санаачилгыг (4.5) өрнүүлэх нь зүйтэй.

2.4. ГОЛЫН ХАЛИУ

Lutra lutra (Linnaeus, 1758)

Баг: Мах идэштэн (Carnivora)
Овог: Суусар (Mustelidae)
Англи нэр: Eurasian Otter
Ижил нэр: *Lutra indica, Lutra kutab, Lutra plendida* (Wilson and Reeder, 2005); *Lutra lutra* (Linnaeus, 1758) (http://checklist.cites.org).



Ангилал зүйн тойм. Ангилал зүйн өөрчлөлтийн талаарх мэдээлэл бага.

Таних шинж. Биеийн урт 60-90 см, сүүл 30-55 см, жин 6-17 кг. Эр халиу эмээс биеэр том (Цагаан, 1977). Бие гонзгой сунагар, цээж рүүгээ шувтан. Том хамар, жижиг нүд, үсэн бүрхүүлээс цухуйх төдий жижиг дугариг чихтэй. Толгой жижиг, тавшгар, өргөн, хавтгайдуу бөгөөд усыг зүсэж хурдан хөвж сэлэхэд илүү зохилдсон. Жигд тачирхан үстэй. Урд хөл бахим, богино ба хойд хөлийн хуруунууд хоорондоо сарьсаар холбогдсон. Халиу урт, нарийхан, угаараа бүдүүн, үзүүр тийшээ шувтан үсэрхэг сүүлтэй. Хошууны эргэн тойронд урт мэдрүүл үстэй. Махилзаж суналзсан өвөрмөц хөдөлгөөнтэй. Зүс ихэвчлэн хар хүрэн ба зарим бодгаль нойтон үедээ бараг хар харагдана. Зоо нуруу, хавирга, сүвээ орчмоороо бараан хүрэн, хэвлий мөнгөлөг цайвар. Харин толгойн дээд тал, сүүл, хөл нь хар хүрэн. Ширүүн, урт, гялалзсан хар сортой, бүх биеийн дагууд маш нягт өтгөн ургасан торгомсог зөөлөн ноолууртай (Довчиндорж нар, 2023).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Ховордож болзошгүй (NT).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Clark *et al.,* 2006).

2025 онд Устаж болзошгүй (EN), B1ab (ii,iii); B2ab (ii,iii); C. Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй. Бүс нутгийн популяцийн хэмжээ тодорхойгүй. Тархац нутгийн хэмжээ 5,000 км^2-аас бага, Монгол орны хувьд арваас цөөн цэгт тархалттай, үржлийн насны бодгалийн тоо 250-аас цөөн тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Г.Довчиндорж (2025).

Үнэлгээг хянасан: Б.Мөнхцог, С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Энэ зүйлийн түүхэн тархац нь Евразийн ихэнх газар нутгийг хамарч байжээ (Nowak, 1991).

Монгол орны тархац, амьдрах орчин. Баян-Өлгий аймгийн Даян нуурын сав газар (Самъяа, Шар, 2008; Шар, Самъяа, 2011), Хөвсгөл аймгийн Дархадын хотгор, Шишхэд голын сав дагуу (Цагаан, 2015), Дархан уул аймгийн Хонгор сумын нутаг Хүйтний гол (Цэнджав, 2005), Хэнтий аймгийн Дадал сумын нутагт Онон голын ай савд хамаарах Балж гол (Батсайхан нар, 2008), Дорнод аймгийн Халх гол сумын нутагт Халх, Нөмрөгийн сав газар (Цагаан, 2015; Shar et al., 2018) зэрэг газарт тархсан. Монгол орны баруун, хойд, зүүн хойд, зүүн хэсгийн хил орчмын хүн, мал сийрэг, багахан нутагт цэнгэг устай, өвөл харзалдаг, загас элбэгтэй гол нууруудад тархжээ (Довчиндорж нар, 2023).



Амьдралын онцлог. Ус, хуурай газрын амьдралтай, амьдралын ихэнх хэсгийг усанд өнгөрөөнө. Нуугдмал амьдралтай, шөнийн идэвхтэй. Өвөлд харз элбэгтэй голуудын мөсөн дор амьдарна. Өдөртөө ихэвчлэн нүх ба модны үндэсний хөндийд байршина. Хаяа чулуу юм уу усанд унасан модны ишин дээр хэвтэж биеэ наранд ээнэ. Өглөө орой, үдшийн бүрэнхийгээр ангуучилна. Дулааны улиралд уснаас ил гарсан хад чулуун дээр нарлаж хэвтэх ба өдрийн цагаар ихэвчлэн үүр, нүхэндээ амарч хэвтэнэ. Сартай шөнө голын тохой, усны эргүүлэг, харзанд бүлээрээ тоглох нь үзэгдэнэ. Халиу нь хаяа чанга исгэрэх дуу гаргана. Голын халиу ганц нэгээрээ амьдардаг ч заримдаа эх, төлүүд нийлсэн бүл үүсгэнэ (Цагаан, 1977). Халиуны тэжээлийн үндсэн хэсгийг тухайн нутагт байгаа төрөл бүрийн загас, хавч, усны шувууд, жижиг мэрэгчид эзэлдэг (Цагаан, 2015; Шагдарсүрэн нар, 1987; Шийрэвдамба нар, 1997; 2016). Өвлийн улиралд хагас ичмэл байдалд орсон мэлхийгээр хооллосон байхыг судлаачид тэмдэглэжээ (Довчиндорж нар, 2023).

Тоо толгой, нягтшил. Манай оронд 1970-аад оны сүүлчээр 20 гаруйхан бодгаль байв. Халх гол, Дархадын хотгорт 1985 онд хийсэн судалгаагаар, нийтдээ 100 орчим толгой халиу байгааг тогтоожээ. Хөвсгөлд 1,200 км^2 талбайд 50±10 бодгаль, Халх гол, түүний салаа, Нөмрөг гол, түүний салаа (Бүрийн гол, Галдастай, Нарийн, Тулт гол) болон Дэгээ голын 600 км^2 талбайд 20±5 бодгаль, Баян-Өлгий аймагт 200 км^2 -д 10±5 толгой байна (Цагаан, 2015). Нөмрөгийн дархан цаазат газрын Гурван гол, Нөмрөгийн гол, Хэрээ уул орчимд 90 га талбайд хамгийн багадаа 5≤ тооны халиу байна (Довчиндорж нар, 2023).

Ховордлын шалтгаан. Үхэл хорогдлын талаар хэвлэгдсэн баримт хомс (Шагдарсүрэн нар, 1987; Шийрэвдамба нар, 1997; 2016). Гэрийн нохойд бариулж хорогдсон тохиолдлын тухай судлаачид тэмдэглэжээ (Батсайхан нар, 2008; Самъяа нар, 1995; Цагаан, 2015). Тухайлбал, Батсайхан нар (2008) Онон-Балж голын сав нутагт үхсэн халиу олдсон 3 тохиолдол бүгд нохойд баригдсаныг

онцлов. Мөн Халх гол сумын иргэд гэрийн нохой үхсэн халиу зууж ирсэн 2 тохиолдлыг бүртгэсэн. 2022 оны 7-р сард Халх гол сумын төвийн орчим айлын нохойд бариулсан бие гүйцсэн халиуг цуглуулгад авсан. Гэхдээ гэрийн нохой үхсэн халиуг олж ирсэн үү эсвэл түүнийг барьж хороосон уу гэдэг тодорхой бус (Довчиндорж нар, 2023).

Хамгаалсан байдал. Монгол Улс 1930 оноос хойш голын халиу агнахыг хуулиар хориглож иржээ (Шийрэвдамба нар, 2013). Улмаар Амьтны тухай хуульд нэн ховор амьтнаар оруулсан бөгөөд төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр зөвхөн эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх зориулалтаар агнаж, барьж болно (7.2). Үүнээс бусад зориулалтаар нэн ховор амьтныг агнаж бэлтгэсэн арьс, яс, бусад түүхий эдийг худалдах, худалдан авахыг хориглосон (7.3). Мөн (7.4) нэн ховор амьтны амьдрах нутагт хүнд үйлдвэр, цахилгаан станц, химийн үйлдвэр байгуулах, авто болон төмөр зам тавих, уул уурхайн олборлолт явуулах, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх асуудлыг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлтийг үндэслэн Засгийн газар шийдвэрлэдэг.

Үүнээс гадна, (11.1.3) өөр нутагт шилжин байршиж байгаа агнуурын амьтныг агнах, барих, (11.1.4) амьтны үүр, ичээ ухах, гэмтээх, (11.1.7) амьтны үр төлийг агнах, шувууны өндгийг түүх, гэмтээх, устгах зэрэг олон үйл ажиллагааг хориглосон. Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр голын халиу 4,600,000 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу).

Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ын I хавсралтад бүртгэгдсэн (Чимэддорж нар, 2018; http://checklist.cites.org). Мөн Монгол Улсын Улаан номын бүх хэвлэлд нэн ховор зүйлээр бүртгэгджээ (Шагдарсүрэн нар, 1987; Шийрэвдамба нар, 1997; 2016).

Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд (тухайлбал, Алтай Таван Богд, Хөвсгөл, Тэнгис-Шишгэдийн голын ай савын болон Онон-Балжийн байгалийн цогцолборт газрууд, Нөмрөгийн дархан цаазат газар г.м) хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ

- Шинжлэх ухаанд тулгуурласан хамгааллын арга хэмжээ авахад түүний популяцийн тоо толгой болон тархац нутгийн хэмжээ, биологи, экологийн судалгааг нарийвчлан гүйцэтгэх шаардлагатай.
- Олон улсын халиу хамгаалах сан (IOSF)-аас 2009 онд жил бүрийн 5-р сарын сүүлчийн Лхагва гарагийг “Дэлхийн халиуны өдөр” болгох санаачилгыг анх гаргаж, улмаар 2016 оноос албан ёсоор олон улсын хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлдэг болсон. Энэ өдрийг Монгол орны халиу тархсан бүх газрын орон нутгийн сургуулийн сурагчид, иргэд, олон нийт хамтран халиуны биологи, экологи, хамгааллын чиглэлээр олон талт үйл ажиллагаа зохион байгуулж, тэмдэглэн өнгөрүүлж заншихыг зүйтэй.

2.5. ИРВЭС

Panthera uncia (Schreber, 1775)

Баг: Мах идэштэн (Carnivora)
Овог: Мий (Felidae)
Англи нэр: Snow Leopard
Ижил нэр: *Цоохор ирвэс (Дуламцэрэн, 2003); U. irbis*, *U. schneideri*, *U. uncioides* (Wilson and Reeder, 2005).



Ангилал зүйн тойм. Ангилал зүйн чиглэлээр гарсан өөрчлөлт, маргаан бага.

Таних шинж. Хамрын үзүүрээс сүүлний уг хүртэлх урт 110 см, сүүлийн урт 90 см, сэрвээний өндөр 65 см, биеийн дундаж жин 40 кг (Johansson *et al.,* 2022b; Fox *et al.,* 2024). Өндөр уулын хад асга бүхий орчинд дасан зохицсон морфологи бүтэцтэй. Эрийн биеийн жин эм бодгалиас дунджаар 10% буюу 3-5 кг илүү (Johansson *et al.,* 2022b). Нурууны зүс ихэвчлэн бор болон шаргал туяатай цайвар саарлаас үнсэн хар саарал хүртэл ба толгой, хүзүү, хөлийн гадна хэсэг бараан бор, хар олон жижиг толботой. Нуруу, хажуу хэсэг битүү болон хагас цагариг маягийн харьцангуй том хэмжээтэй олон толботой бөгөөд түүний хэлбэр зөвхөн бөөрөнхий бус урт сунасан, олон цүлхэн үүсэн янз бүрийн хэлбэртэй (Kitchener *et al.,* 2016). Эдгээр толбо бодгаль бүрд өөр байх бөгөөд бодгалийг таних үндсэн шинж болдог. Хэвлий, сүвээ, цээж орчмын зүс цулгуй цагаан, орчноосоо хамааран нуруу биеийн бусад хэсэгтэй адил бор саарал болон шаргал туяатай. Улирлаас хамааран үсний урт өөрчлөгдөнө (Kitchener *et al.,* 2016). Гавлын яс бусад мийн овгийн зүйлүүдтэй харьцуулахад илүү өргөн, богино, том дугариг хэлбэртэй. Бахим, навтгар бие

бүтэцтэй, дөрвөн мөч богино, булчинлаг. Энэ нь биеийн хүндийн төвийг доор байлгах зохилдлого бөгөөд огцом налуу газар хөдлөхөд тустай (Fox *et al.,* 2024). Урд мөчийн савар нь хойд хосоос том ба огцом налуу газар шилжин шилжин хөдлөхөд дэмтэй. Биеийн урт, сүүлний харьцаа нь бусад мийн овгийн зүйлүүдтэй харьцуулахад хамгийн урт бөгөөд налуу, уулархаг орчинд шилжин хөдлөхөд биеийг тэнцвэржүүлнэ.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Эмзэг (VU).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Устаж болзошгүй (EN), C1 (Clark *et al.,* 2006).

2025 онд Устаж болзошгүй (EN), C1.

Монгол орны ирвэсийн тархац, тоо толгойг тогтоох хамтарсан 2017-2020 оны судалгааны үр дүнд 806-1,127 бодгаль бие гүйцсэн ирвэс Монгол Улсын нутаг дэвсгэрт байна гэж тооцсон (Bayandonoi *et al.,* 2021). Дээрх судалгааны үр дүнд үндэслэвэл Улаан дансны C1 (тоо толгой нь буурч байгаа тусгаарлагдсан популяциуд) буюу жижиг популяцийн хэмжээ шалгуур үзүүлэлтээр “Устаж болзошгүй” гэх зэрэглэлийг хангаж буй тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Хэдийгээр популяцийн хэмжээний бууралтын талаар тодорхой мэдээлэл байхгүй боловч үнэлгээ хийсэн судлаачид Монгол орны ирвэсийн популяцийн хэмжээ хууль бус ан, ирвэс хүн хоорондын зөрчил, амьдрах орчны алдагдлаас шалтгаалан 20 жил эсвэл 5 үе удмын хугацаанд 20%-аас илүү байсан байж болзошгүй гэж үзсэн. Аюул заналын нөлөөг үнэлэх тодорхой мэдээлэл олох, бүртгэх нь хүндрэлтэй тул баримтаар батлах боломж одоогоор байхгүй байна. Гэвч Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн “Хууль бусаар ан агнах гэмт хэргийн мэдээлэлд хийсэн дүн шинжилгээний тайлан (2024)”-д үндэслэн популяцийн хэмжээ буурч байх магадал өндөр гэж үзэв.

Популяцийн хэмжээ болон боломжит бууралтаас гадна, ирвэсийн амьдрах орчны хуваагдал энэ зүйлийн зэрэглэлд томоохон нөлөө үзүүлж байна. Ирвэс нь Монгол орны уулархаг Монгол Алтайн, Говь Алтайн нуруу, тэдгээрийн салбар уулс, Хангайн нуруу, Соёны нуруунд алслагдан тусгаарлагдсан жижиг популяциудыг үүсгэн амьдардаг. Эдгээр уулархаг бүс нутаг нь уул уурхай, хүн амын суурьшил, хүний үйл ажиллагааны нөлөө, малын тоо толгойн өсөлт, түүнээс улбаалсан бэлчээрийн доройтол, шугаман дэд бүтэц зэргийн нөлөөнд өртөж байгаа нь ирвэс болон түүний идэш бологч зүйлүүдийн тасархайтсан жижиг популяциуд, тэдгээрийн хооронд бодгалиуд чөлөөтэй шилжин нүүдэллэх боломжийг бууруулж байна. Энэ нь дээрх тасархайтсан жижиг популяциудыг хоорондоо тусгаарлагдах, үүнээс шалтгаалсан цус ойртолтыг бий болгож, устах эрсдэлийг нэмэгдэж байна. Мөн түүнчлэн дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй амьдрах орчны доройтол, идэш бологч амьтдын тоо толгойн бууралт нь ирвэсийн тасархайтсан популяциудын урт хугацааны оршин тогтнолд аюул учруулахаар байна.

Үнэлгээ хийсэн: Ж.Ш.Александр, Б.Гантулга, М.Цэрэннадмид, М.Баяраа (2025).

Үнэлгээг хянасан: Б.Мөнхцог, Л.Пүрэвжав, С.Гомбобаатар (2025).

Дэлхийн тархац. Орос, Казахстан, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан, Хятад, Энэтхэг, Киргизстан, Балба, Бутан болон Монголд тархжээ.

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол орны ирвэсийн тархац, тоо толгойг тогтоох 2017-2020 оны хамтарсан судалгааны үр дүнд Монгол Улсын нутаг дэвсгэрт Монгол Алтайн нурууны Алтай Таван Богдоос Говь Алтайн нуруу, тэдгээрийн салбар уулс, Хөрхийн нуруу хүртэл бүх уулс, Хөрхийн нурууны ойр орчмын жижиг уулс, Байтаг Богд, Хавтагийн нуруу, Тахийн шар нуруу, Хөвчийн нуруу, Алтайн өвөр говийн Атас богдоос Сэгс цагаан богд хүртэлх уулс, Хан хөхийн нуруунаас Бага Аргалан уул хүртэлх Хангайн нурууны баруун болон өвөр хэсгийн ихэнх уулс, хойшоо Улаан тайга, Их Соёны нуруу, Хорьдол сарьдгийн нуруу дамнан 326,617 км^2 талбайд тархсан (Bayandonoi *et al.,* 2021). Ирвэс нь д.т.д 900-3,500 м өндөрлөг уулархаг бүс нутгийн хад асга ихтэй, хадархаг амьдрах орчинд голчлон байрших бөгөөд Монгол орны хэмжээнд өргөн тал, хөндий,

хоолойгоор тусгаарлагдсан уулсын системд харьцангуй тасархайтсан жижиг популяциуд үүсгэн амьдарна.



Амьдралын онцлог. Ороо нийллэг 1-3-р сард болж, 4-6-р сард төрнө (Johansson *et al.,* 2021). Гинс хүрэхэд хэцүү хад цохио бүхий орчинд бусад махчид болон цаг агаарын нөлөөнөөс нөмөр газар, хадны хөндийд үүрлэнэ. Гинс гүемээ 1.5 сартай болтол үүрнээсээ ихэвчлэн 3 км-ээс илүүгүй зайд ангуучилна (Fox *et al.,* 2024). Гинс 18-22 сарын турш гүемүүдтэйгээ хамт байж өсгөнө. 2 дахь жилээс гинсийн үржлийн мөчлөг ойртох үед гүемүүд эхээсээ салж бие даан амьдарч эхэлнэ. Залуу ирвэсүүд эхээсээ салсны дараа өөрийн эзэмшил нутагтай болох шаардлагатай ч гурван нас хүртлээ үржилд орох нь тун цөөн (Johansson *et al.,* 2021). Зуны улиралд өдрийн сэрүүнд, өвлийн улиралд өдрийн дулаан үед идэвхжил өндөртэй (Johansson *et al.,* 2022). Ялангуяа шөнө, үүр, бүрийгээр илүү идэвхтэй (Johansson *et al.,* 2022). Эр бодгаль буюу гэндүүдийн эзэмшил нутаг бараг давхацдаггүй бол гинсийн эзэмшил нутаг зэрэгцээ орших гэндийн эзэмшил нутагтай давхцаж болох ба гэндийн эзэмшил нутгаас харьцангуй жижиг. Жишээлбэл, Тостын нуруунд хийгдсэн судалгаагаар, гинсийн эзэмшил нутгийн дундаж хэмжээ 129 км^2, гэндийнх 220 км^2 байжээ (Johansson *et al.,* 2016). Эзэмшил нутгаа бумбаа, самардас, үнэртэн цацах зэргээр тэмдэглэнэ. Эдгээр ул мөр популяцийн мониторинг хийх гол хэрэглэгдэхүүн болдог (Bayandonoi *et al.,* 2021). Байгальд 10-13 жил насалж буйг Тостын нуруунд хийсэн судалгаагаар тодорхойлсон. Ихэвчлэн янгираар хооллоно. Тарвага, гэрийн мал, бор гөрөөс, халиун буга, зэрлэг гахай, туулай, хойлог зэрэг амьтдыг ангуучилна. Түүнчлэн хуурай говь, цөлөрхөг газар газрын доорх усыг ухаж гаргана. Бусад зүйл амьтад дээрх ил гаргасан усаар ундаалж буйгаас ирвэсийг хулан шиг экологийн инженер зүйл гэж болно (Nyam *et al.,* 2024).

Тоо толгой, нягтшил. Монгол оронд 1970-аад оны сүүлчээр 700 гаруй, 1980-аад оны дундуур 2000 орчим ирвэс (Даш, 1979; Амарсанаа, 1985), 1990-ээд оны дундуур 10 аймгийн 107 сумын 160,000 км^2 нутаг дэвсгэрт 100 км^2 нутагт 0.8 бодгаль ноогдох нягтшилтайгаар 1,700 орчим ирвэс (Амарсанаа, 1995), зарим судлаачид 100 км2 нутагт 1.1 бодгаль ноогдох нягтшилтайгаар 1,000 орчим ирвэс (Schaller *et al.,* 1994), 2000 онд 103,000 км^2 нутаг дэвсгэрт 100 км^2 нутагт 1-1.5 бодгаль ноогдох нягтшилтайгаар 800-1,500 ирвэс байна (McCarthy, 2000) хэмээн тус тус үзжээ.

Монгол орны ирвэсийн тархац, тоо толгойг тогтоох 2017-2020 оны хамтарсан судалгааны үр дүнд дундажаар 953 буюу 806-1,127 бодгаль бие гүйцсэн ирвэс байгааг тогтоосон бөгөөд манай орны хэмжээнд ирвэсийн тархац нутагт ирвэсийн нягтшил өндөр (дундаж нягтшил: 0.61 бодгаль/100км2) газар 48,290 км^2, дундаж нягтшил (дундаж нягтшил: 0.35 бодгаль/100км2) бүхий газар 153,840 км^2, бага нягтшил (дундаж нягтшил: 0.09 бодгаль/100км2) бүхий газар 124,487 км^2 талбайг тус тус эзэлнэ (Bayandonoi et al., 2021). Эдгээрээс өндөр нягтшил бүхий тархац нутагт ирвэс байнга байршдаг бөгөөд судалгааны явцад бодит ул мөрөөр батлагдсан. Дундаж нягтшил бүхий тархац нутгийн зарим хэсэгт ирвэс байнга байрших ба бусад хэсэгт эзэмшил нутагтай ирвэс тохиолдох өндөр магадлалтай. Бага нягтшил бүхий тархац нутаг нь ирвэс нүүдэллэх, шилжих, шинэ эзэмшил нутаг эрэн хайх үед тохиолдож болох байнгын эзэмшил нутаггүй газар нутаг гэж үзэж болно (Bayandonoi *et al.,* 2021). Алс хол шилжин эзэмшил нутаг хайж нүүдэллэх үедээ дээрх судалгаагаар тогтоосон тархац нутгийн гадна идэш тэжээл элбэг нутагт түр байршина. Тухайлбал, нэг бодгаль ирвэс 2021-2022 онд Их Нартын байгалийн нөөц газар (Wingard *et al.,* 2023), өөр нэг ирвэс Хустайн нурууны байгалийн

цогцолборт газарт 2021-2023 онд байршиж байсныг тогтоосон (Uuganbayar *et al.,* in preview).

Ховордлын шалтгаан. Монгол орны ирвэс нь хүний үйл ажиллагаа, экологийн өөрчлөлтөөс үүдэлтэй олон тооны аюул заналтай тулгардаг. Эдгээр аюулыг ерөнхийд нь амьдрах орчны хомсдол, доройтол, идэш бологч амьтдын тоо толгойн бууралт, өширхөн хороох, хууль бус ан агнуур, худалдаа, дэд бүтцийн хөгжил, уул уурхайн нөлөөлөл, уур амьсгалын өөрчлөлт зэрэгт ангилж болно (Sharma *et al.,* 2014; Johansson *et al.,* 2015; Alexander *et al.,* 2021; Lukargahso, 2020; 2024).

Томоохон аюулын нэг бол бэлчээрийн даац хэтэрч малын тоо толгой өссөнөөс үүдэн амьдрах орчин доройтож, алдагдах явдал юм (Мөнхцог нар, 2024). Мал аж ахуй эрчимтэй хөгжсөн 1990-ээд оноос хойш малын тоо эрс нэмэгдэж 2022 онд 71 сая гаруй толгойд хүрсэн нь бэлчээрийн доройтолд хүргэж, малыг ирвэсийн амьдрах орчин руу түрж, нөөцийн төлөөх өрсөлдөөнийг үүсгэсэн (Berger *et al.,* 2013; Munkhtsog *et al.,* 2024).

Мөн малын тоо хэт олширсноор зэрлэг туурайтан амьтдыг амьдрах орчноосоо дайжихад хүргэдэг. Идэш тэжээлийн чухал эх үүсвэр болох зэрлэг амьтад нутгаасаа дайжиж, ирвэсийн хувьд идэш бологч зэрлэг амьтдын олдоц багасдаг (Johansson *et al.,* 2015). Зэрлэг тууртан амьтдын тоо толгой буурах нь ирвэс гэрийн малыг барихад хүргэж, хүн-ирвэс хоорондын зөрчил нэмэгдэнэ. Цоохор ирвэсийг малчид малыг нь идсэн хэмээн өширхөн хороох нь ноцтой аюул юм (Johansson *et al.,* 2015; Alexander *et al.,* 2021). Гэрийн малыг ирвэс барих нь малчдад эдийн засгийн хохирол учруулж, улмаар хариу арга хэмжээ авч ирвэсийг хороох нь элбэг. Хууль бус агнуур, худалдаа нь ирвэсийн популяцид шууд аюул учруулж байна (Мөнхцог нар, 2024).

Дорнын уламжлалт анагаах ухаанд ирвэсийн яс болон биеийн бусад хэсгийг, зарим тохиолдолд барын эдийг орлуулагч болгон ашигладаг бөгөөд арьс нь тансаг үслэг эдлэлд тооцогдох тул өндөр үнэлгээтэй. Монгол Улсын хууль сахиулах байгууллагууд 2014-2018 онд ирвэс хууль бусаар агнаж, худалдаалсан 8 хэрэг албан ёсоор бүртгэсэн бол 2019-2023 онд энэ тоо 18 болж нэмэгдсэн нь Монгол Улсад ирвэсийг хууль бусаар агнах, худалдаалах томоохон аюул байсаар байгааг харуулж байна (Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар, 2024).

Дэд бүтцийн хөгжил, уул уурхайн үйл ажиллагаа нь ирвэсийн популяцид сөргөөр нөлөөлж, амьдрах орчны хуваагдал, доройтолд хүргэнэ. Монгол Улсын эдийн засаг сүүлийн жилүүдэд өссөн нь үндсэндээ ашигт малтмалын олборлолтоос олсон орлогоос (нүүрс, зэс, алт, бусад ашигт малтмалууд г.м) үүдэлтэй. Эдийн засгийн хөгжлийг дэмжихийн тулд Засгийн газар дэд бүтцийн бүтээн байгуулалтыг нэн тэргүүнд тавин ажиллаж байна. Гэсэн хэдий ч энэхүү хурдацтай дэд бүтцийн хөгжил нь ирвэс амьдардаг эмзэг экосистемд ихээхэн аюул учруулж болзошгүй. Авто зам, төмөр зам барих зэрэг дэд бүтцийн төслүүд нь амьдрах орчин, ирвэс болон түүний гол идэш бологч уулын туурайтан амьтдын популяцийг хэсэгчлэн хувааж, урьд нь алслагдсан бүс нутгуудад хүн нэвтрэх боломжийг нэмэгдүүлж, улмаар хууль бус ан хийх эрсдэлийг нэмэгдүүлдэг. Мөн түүнчлэн уурхайн үйл ажиллагаа нь амьдрах орчны доройтол, алдагдалд хүргэж, ирвэс болон тэдгээрийн идэш бологч зүйлд аюул учруулна.

Уур амьсгалын өөрчлөлт нь ирвэсийн амьдрах орчин, идэш тэжээлийн динамикийг өөрчилдөг. Энэ зууны эцэс гэхэд Монгол Улсын нутаг дэвсгэрт агаарын температур +4С хэм хүртэл нэмэгдэнэ гэж таамаглаж байна. Температур нэмэгдэж, хур тунадасны хэв маягийг урьдчилан таамаглах аргагүй болж байгаа нь цоохор ирвэсийн оршин тогтноход нэн чухал зүйл болох янгир, аргаль зэрэг гол идэш бологч амьтдын тоо толгой буурахад хүргэж болзошгүй юм. Мөн түүнчлэн ган, зуд зэрэг цаг уурын эрс тэс үзэгдлүүд бэлчээрт нөлөлж ирвэсийн идэш бологч өвсөн тэжээлт амьтдын тоо толгойд

сөргөөр нөлөөлж байна. Уур амьсгалын өөрчлөлт нь амьдрах орчны хуваагдал, хүн ба зэрлэг амьтдын хоорондын зөрчлийг нэмэгдүүлэх зэргээр одоо байгаа аюул заналыг улам хурцатгах магадлалтай.

Хамгаалсан байдал. Монгол Улс 1972 оноос ирвэс агнахыг хуулиар хориглож, 1993 оноос олзворын ангийн зориулалтаар тусгай зөвшөөрөл олгодог явдлыг зогсоож (Шийрэвдамба нар, 2013; Мөнхцог нар, 2024), улмаар Амьтны тухай хуульд нэн ховор амьтнаар оруулсан бөгөөд төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр зөвхөн эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх зориулалтаар агнаж, барьж болно (7.2). Үүнээс бусад зориулалтаар нэн ховор амьтныг агнаж бэлтгэсэн арьс, яс, бусад түүхий эдийг худалдах, худалдан авахыг хориглосон (7.3). Мөн (7.4) нэн ховор амьтны амьдрах нутагт хүнд үйлдвэр, цахилгаан станц, химийн үйлдвэр байгуулах, авто болон төмөр зам тавих, уул уурхайн олборлолт явуулах, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх асуудлыг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлтийг үндэслэн Засгийн газар шийдвэрлэдэг.

Үүнээс гадна, (11.1.3) өөр нутагт шилжин байршиж байгаа агнуурын амьтныг агнах, барих, (11.1.4) амьтны үүр, ичээ ухах, гэмтээх, (11.1.7) амьтны үр төлийг агнах, шувууны өндгийг түүх, гэмтээх, устгах зэрэг олон үйл ажиллагааг хориглосон. Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр ирвэс 22,000,000 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу).

Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)-ын I хавсралт, мөн Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ын I хавсралтад тус тус бүртгэгдсэн (Чимэддорж нар, 2018; http://checklist.cites.org). Ирвэс нь 2008 оны Бар болон Азийн бусад том муурын тухай (CMS) 9.3 зөвлөмжид багтсан бөгөөд энэ нь бүс нутгийн хэмжээнд Азийн бүх том муурын төрөл зүйлийг хамгаалах чиглэлээр хил дамнасан хамтын ажиллагааг сайжруулах, тухайн улсуудыг нутаг дэвсгэртээ хамгаалах шаардлага тавьдаг байна. 2014 онд бий болсон CMS-ын Төв Азийн хөхтөн амьтдын санаачилга (CAMI) нь цоохор ирвэс, түүний идэш тэжээлийн нэг зүйл аргаль зэрэг 15 зүйлийг хамардаг. Цоохор ирвэсийг хамгаалах CAMI хөтөлбөрийн үйл ажиллагааг Дэлхийн цоохор ирвэс ба экосистемийг хамгаалах хөтөлбөр (GSLEP)-ийн хамгаалах хүчин чармайлттай уялдуулах зорилгоор тусгайлан боловсруулжээ.

Мөн Засгийн газрын 2015 оны 325 дугаар тогтоолоор батлагдсан “Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр (2016-2025)”, Монгол орны цоохор ирвэсийг хамгаалах менежментийн төлөвлөгөө (1999), Увс аймгийн цоохор ирвэсийг хамгаалах менежментийн төлөвлөгөө (2000), Монгол орны цоохор ирвэсийг хамгаалах үндэсний хөтөлбөр (2006), Засгийн газрын 2011 оны 277 дугаар батлагдсан “Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөр (2011-2021)”, хамгийн сүүлд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/208 дугаар тушаалын 5 дугаар хавсралтаар батлагдсан “Цоохор ирвэс хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөө (2025-2028)” зэрэг нь ирвэсийг хамгаалахад онцгой ач холбогдолтой юм.

Монгол Улсын Улаан номд нэн ховор зүйлээр бүртгэгдсэн (Шийрэвдамба нар, 2013). Энэ зүйлийн тархац нутгийн 29.7% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд (тухайлбал, Тост, Тосонбумбын нурууны байгалийн нөөц газар, Говь Гурвансайхан, Хар-Ус нуурын байгалийн цогцолборт газрууд, Цагаан Шувуутын нурууны дархан цаазат газар г.м) хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ

- Монгол орны ирвэсийг хамгаалах нь төрийн бодлого, олон нийтийн оролцоо санаачилга, шинжлэх ухааны судалгаа,

олон улсын хамтын ажиллагааг нэгтгэсэн олон талт ажил юм (Munkhtsog *et al.,* 2024).

- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/208 дугаар тушаалын 5 дугаар хавсралтаар батлагдсан Цоохор ирвэс хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөө (2025-2028)-ний хэрэгжилтийг хангаж, ажиллах
- Засгийн газраас нэн ховор, ховор амьтдыг хамгаалах үйл ажиллагаанд гол үүрэг гүйцэтгэдэг тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг бий болгон ажиллаж байна. Одоогоор нийт 52 улсын тусгай хамгаалалттай газар нутагт ирвэсийн гол тархац нутаг хамрагдаад байна. Мөн олон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг нь ирвэсийн амьдрах орчинтой давхацдаг бөгөөд тэдгээр тусгай хамгаалалттай газруудад ирвэс болон түүний идэш бологч амьтдын томоохон популяциуд оршин амьдардаг. Цаашдаа Засгийн газар ирвэсийг хамгаалах чиглэлээр тусгай хамгаалалттай газар нутгийг өргөтгөх арга хэмжээ авах нь зүйтэй.
- Орон нутгийн бэлчээрийн мал аж ахуйн хамтын ажиллагаа нь Монгол орны ирвэсийг хамгаалах чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Олон нийтэд түшиглэсэн хөтөлбөрүүд нь хүн ба зэрлэг амьтдын сөрөг нөлөөллийг бууруулах, байгаль хамгаалахад үзүүлэх орон нутгийн дэмжлэгийг нэмэгдүүлэх зорилготой. Хөтөлбөрүүдэд ирвэсийн идэш тэжээлийн улмаас малчдад учирсан малын хохирлыг нөхөн төлдөг малын даатгалын тогтолцоо багтсан болно (Alexander *et al.,* 2021). Мал хамгаалах арга хэмжээнээс гадна, малчдын амьжиргааг дээшлүүлэх, байгаль хамгаалах хамтын хүчин чармайлтыг дэмжих зорилгоор олон нийтэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, орон нутгийн эдийн засагт туслах нэмэлт орлого бий болгоход анхаарч байна. Үүнд мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг нэмүү өртөг шингээн боловсруулах, орлогын өөр урсгалыг хөгжүүлэх, нутгийн иргэдэд тулгуурласан аялал жуулчлалыг хөгжүүлэх, өөр ажлын байр санал болгох, байгаль хамгаалахад олон нийтийн дэмжлэгийг нэмэгдүүлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх хэрэгтэй.
- Судалгаа, мониторинг нь байгаль хамгаалах стратегийн чухал үндэс суурь болдог. Тостын нуруунд хийгдэж байгаа урт хугацааны судалгаа нь ирвэсийн үржил, амьдрах орчин, зан төрх, популяцийн динамикийн талаар мэдээлэл цуглуулахад маш чухал.
- Улсын хэмжээнд ирвэсийн тархац, тоо толгойн судалгааг ул мөрд суурилсан тохиолдцын магадлалын судалгаа, автомат камер ашиглан популяцийн тоо толгойг тодорхойлох судалгаа зэргээр гүйцэтгэж ирвэсийн тархцыг илүү нарийвчилсан зураглал үйлдсэн бөгөөд популяцийн хэмжээг анх удаа нарийвчлал сайтай тооцоолов (Bayandonoi *et al.,* 2021). Хил дамнасан популяцийг судлах, хамгаалах санаачилга нь ирвэсийн хил дамнасан популяциуд, цөм популяциас хамааралтай жижиг популяциуд урт хугацаанд оршин тогтноход чухал ач холбогдолтой (Munkhtsog *et al.,* 2024). Монгол Улс нь энэ чиглэлээр хөрш улсууд болох Орос, Хятадтай хамтран ажиллаж байна. Увс нуурын хотгорын хил дамнасан тусгай хамгаалалттай газрууд байгуулагдан хамгааллын нэгдсэн менежмент хэрэгжүүлж байгаа бөгөөд Сийлхэмийн нуруу-Сайлюгемийн тусгай хамгаалалттай газрууд хоорондын хамтын ажиллагаа эрс сайжирсан.

2.6. ТАХЬ

Equus ferus przewalskii (Groves, 1986)

Баг: Туурайтан (Perissodactyla)
Овог: Адуу (Equidae)
Англи нэр: Przewalski's Horse
Ижил нэр: *Тахь адуу; Equus przewalskii* Poliakov, 1881 (Поляков, 1881; Банников, 1954; Болд, *Цэвэгжав, 1963; Довчин, 1969; Дуламцэрэн, 1970*; 1991; Шагдарсүрэн, 1974; Громов и Баранова, 1981; Климов, 1990), *Equus caballus* Linnaeus, 1758 (Linnaeus, 1758; Bennet and Hoffmann, 1999; Wilson and Reeder, 2005), *Equus ferus* Boddaert, 1785 (King *et al.,* 2015); Asian or Asiatic Wild Horse, Mongolian Wild Horse (Wakefield *et al.,* 2002; King *et al.,* 2015).



Ангилал зүйн тойм. Ангилал зүй нь маргаантай хэвээр. Гэрийн адууг дээж болгож *Equus caballus* гэж нэрлээд түүнээс хойш шинжлэх ухаанд нээсэн зүйлүүдийг илтэд ялгаатай биш бол гэрийн адууны салбар зүйл хэмээн үзэх болсон. Бид Дэлхийн байгаль хамгаалах холбооны салбар комисс (SSC)-ийн Адууны овог судлаачид (ESG)-ын санал (Wakefield *et al.,* 2002), Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц, Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц зэргийг харгалзаж *Equus ferus przewalskii* Groves, 1986 гэх шинжлэх ухааны нэршлийг хэрэглэв (Groves, 1986; Wakefield *et al.,* 2002).

Таних шинж. Биеийн урт 220-280 см, мундаа орчим чац нь 134-146 см, хялгастай сүүлний урт 92-111 см, чихний урт 14-18 см, биеийн жин 275-325 кг. Хул зүстэй, улирал болон бодгалиас хамаарч ухаа хонгор, цайвар хул, бор хул зүстэй ч тохиолдоно. Хэвлий, суга, цавь орчмоороо биеийн үндсэн зүснээс цайвар. Мундаанаас зоо дагуу сүүлний цацаг хялгас хүртэл бор хүрэн судалтай. Зарим бодгаль хаандаа хэмжээ, хэлбэрээр ялгаатай бидэртэй. Дэл босоо, ахар, ихэвчлэн хар, хөхөл, сойлгогүй. Сүүлний уг орчим уртааш хялгасгүй год, үлдсэн хэсэг урт хар цацаг хялгастай. Толгой данхар, хүзүү бахим, богино. Өвдөг, борвиноос доош хар, олонх бодгаль өвдөг, борвины дотор

талд хөндлөн хар, богино судалтай (Groves, 1986; Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Устаж болзошгүй (EN).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Устаж байгаа (CR), D (Clark *et al.,* 2006).

2025 онд Устаж болзошгүй (EN), B1(a), (b), (i,iv); (C). Үржлийн насны тахь Хустайн байгалийн цогцолборт газарт 150 км^2-д 281 бодгаль, Говийн Их дархан цаазат газрын "Б" хэсэгт 4,000 км^2-д 222 бодгаль, Хомын талын байгалийн цогцолборт газарт 100 км^2-д 110 бодгаль, нийт 4,250 км^2-д 613 бодгаль байгаа нь тархац нутаг <5,000 км^2-аас бага (B1) (b),(i), тасархайтсан популяци ≤5-аас цөөн (b)(iv), үржлийн насны бодгаль <2,500-аас цөөн (C) шалгууртай дүйцсэн учир энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Д.Өсөхжаргал, О.Ганбаатар, Ц.Дашпүрэв, Ц.Мөнхбат, Ц.Батзаяа, С.Далайцэрэн, Н.Анхзаяа, Э.Нарангарав (2025).

Үнэлгээг хянасан: Ян.Адъяа, С.Гомбобаатар (2025).

Дэлхийн тархац. Монгол, Хятад, Казахстан, Орост сэргээн нутагшуулж байна (Kaczensky *et al.,* 2014; King *et al.,* 2015).

Монгол орны тархац, амьдрах орчин. Сэргээн нутагшуулж буй тахь Говь-Алтай аймгийн Бижийн голд Зүүнгарын говь цөл (8.3), цөлөрхөг хээрийн өдлөг хялгана-хөмүүл, баглуур-бударганат бэсрэг уулсын бэл, хөндий, нам аараг, толгод, уудам хотос, хоолой, сайр, садарга, талбиу дэнжээр байдаг бол харин Төв аймгийн Хустайн нуруунд элдэв үетэн, алаг өвст уулын хээр (4.4), ойт хээрт (1.4), мөн Завхан аймгийн Хомын талд Завхан голын хөндийд (5.13) бэлчээрлэнэ (Батсайхан нар, 2022).



Амьдралын онцлог. Хивдэггүй учир хоногийн дийлэнхийг идээшилж өнгөрүүлнэ. Дулааны улиралд үүрээр ус руу бууж, нар хөөрч, агаар, хөрсний хэм нэмэгдэхэд уулын оройгоор даган идээшилж, өдрийн ид халуунд уул, шилийн сэрвэн салхи, хад, цохио, модны сүүдэрт зогсож, үдшийн сэрүүнд дахин ус руу бууна. Өвөл шилжилт хөдөлгөөн бага, цасны нимгэнийг даган нам дор идээшилнэ. Орооо нийллэг нь 5-7-р сард үргэлжилнэ. Хээлээ 11 сар буюу 327-357 орчим хоног тээж (Roberts, 1986), хээлтэй гүүний 90% нь 4-6-р сард, үлдсэн нь 7, 8-р сард нэг унага төрүүлнэ. Гүү анх 2-3 насандаа азарганд гарснаас хойш 5-15 насанд ид унагалж, 16-аас дээш насанд цөөрч, 20-оос дээш насанд ховор унагална (Өсөхжаргал, 2021). Үрээ 4-5 насанд бэлэг боловсорч гүү хээлтүүлэх чадвартай ч, үржлийн систем (mating system)-ийн өрсөлдөөнтэй холбоотойгоор харьцангуй хожуу сүрэг бүрдүүлнэ. Тахь нь "Азарга адуун бүл"-ийн сонгодог төлөөлөгч юм. Энэ нь нэг эрэгчин нэгээс олон эмэгчнийг харьцангуй урт хугацаанд тогтвортойгоор хурааж, бусад эрэгчинтэй үржилд орохыг хязгаарлаж, хамтдаа бүллэдэг бүтэцтэй. Хамгийн цөөхөндөө 2, хамгийн олондоо 30 гаруй бодгалиар сүрэглэнэ. Сэргээн нутагшуулсан тахь 27 насалсан нь бий.

Тоо толгой, нягтшил. Сэргээн нутагшуулж буй тахь Хустайн байгалийн цогцолборт газарт 1 км^2-д 2.07 бодгаль ногдох нягтшилтайгаар 150 км^2-д 311 (Батзаяа, Дашпүрэв, 2025), Говийн Их дархан цаазат газрын "Б" хэсэгт 1 км^2-д 0.07 бодгаль ноогдох нягтшилтайгаар 4,000 км^2-д 298 (Анхзаяа, Ганбаатар, 2025), Хомын талын байгалийн цогцолборт газарт 1 км^2-д 1.53 бодгаль ногдох нягтшилтайгаар 100 км^2-д 153 тахь (Нарангарав, Мөнхбат, 2025) тус тус амьдарч байна.

Ховордлын шалтгаан. Говь цөлийн задгай ус, булаг шандыг хүн, мал эзэгнэн ус бэлчээргүйдүүлж, дархалсан хууль дүрэм гарахаас өмнө хэт их агнаж, нутгийнханд галт зэвсэг дэлгэрч, бэлчээр ус сайтай хээр, хуурай хээрээс говь цөл рүү түрэгдэж, 1940-1950 онд БНМАУ-ын хилийн ойролцоо нутаглаж байсан Оспан гэгчээр толгойлуулсан хасгийн босуул зэвсэгт хүмүүст хайр гамгүй хядуулж, 1944-1945 оны зудад хиарч, 1898-1903 оны унага барих бүдүүлэг арга, аргачлалт ажилд өртсөнөөр байгальд зэрлэгээрээ

үлдсэн цөөн тооны тахь 1940-1960-аад онд бүрмөсөн устжээ (Болд ба Цэвэгжав, 1963; Довчин, 1969; Дуламцэрэн, 1991; Bouman and Bouman, 1994). Сэргээн нутагшуулж буй тахь ган, зуд (7), хачгийн халуун өвчин (8.5), чонын халдлага (8.2; 8.3)-д өртдөг. Хэт өсөж, төвлөрсөн малд бэлчээр, усаар шахагдах (1.1.4.1; 9.1; 9.9), уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарал (6.1.1)-ын улмаас гадаргын урсацтай булаг шанд шургах, хатах, ширгэх, ус, амьдрах орчин хомсдох, гэрийн адуутай ойртож халдварт өвчинд нэрвэгдэх (8.5), эрлийзжих (8.4), зан төрхийн санамсаргүй үйл явц (9.1) зэрэг нь хүчин зүйлс нөлөөлдөг унагална (Өсөхжаргал, 2021).

Хамгаалсан байдал. Монгол Улс 1930 оноос тахь агнахыг хуулиар хориглож иржээ (Шийрэвдамба нар, 2013). Улмаар Амьтны тухай хуульд нэн ховор амьтнаар оруулсан бөгөөд төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр зөвхөн эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх зориулалтаар агнаж, барьж болно (7.2). Үүнээс бусад зориулалтаар нэн ховор амьтныг агнаж бэлтгэсэн арьс, яс, бусад түүхий эдийг худалдах, худалдан авахыг хориглосон (7.3). Үүнээс гадна, (11.1.3) өөр нутагт шилжин байршиж байгаа агнуурын амьтныг агнах, барих, (11.1.4) амьтны үүр, ичээ ухах, гэмтээх, (11.1.5) агнуурын амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх зорилго бүхий байр, саравч, тэжээл мараа, бусад байгууламжийг эвдэж гэмтээх, устгах зэрэг олон үйл ажиллагааг хориглосон. Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр тахь 21,700,000 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS) -ын I хавсралт, мөн Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ын I хавсралт (Чимэддорж нар, 2018; http://checklist.cites.org), түүнчлэн Монгол Улсын Улаан номын бүх хэвлэлд нэн ховор зүйлээр (Шагдарсүрэн нар, 1987; Шийрэвдамба нар, 1997; 2016) тус тус бүртгэгджээ. Энэ зүйлийн тархац нутаг бүхэлдээ улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд (Говийн Их дархан цаазат газрын “Б” хэсэг, Хустай болон Хомын талын байгалийн цогцолборт газруудад) хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ

- Бодлого боловсруулалтад суурилсан үйл ажиллагаа (1), хууль эрхзүй (1.2), хэрэгжилт (1.2.1.2), олон нийтийн удирдлага (1.3), мэдээлэл, сургалт (2), чадавхжуулах (2.3) үйл ажиллагааг зохион байгуулах шаардлагатай.
- Судалгаанд суурилсан хамгааллын менежмент хэрэгжүүлэх (3), популяцийн тоо толгойн хэлбэлзэл (3.2), биологи, экологи (3.3), амьдрах орчны тэтгэх даац (3.4), аюул занал (3.5) зэргийг нарийвчлан тогтмол судалж, үүний үр дүнд түшиглэн хамгаалах арга хэмжээ авах нь зүйтэй.
- Одоогоор тахь сэргээн нутагшуулж буй газрууд тоо толгойн хэлбэлзэл, түүнд нөлөөлөгч хүчин зүйлс, мах идэштний халдлага, өвчин эмгэг, амьдрах орчны чанарыг нарийвчлан судалж, үр дүнг менежментэд тусган ажиллаж байна. Уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарлын улмаас гадаргын урсацтай булаг, шанд, горхи шургаж, хатаж, ширгэж буйн учир усны эхийг хашаалан хамгаалах, нэг үе чулуун далан барьж үерт дарагдахаас сэргийлэх, үерийн усны урсцыг удаашруулж хөрсөнд шингээж гүний усны төвшин нэмэгдүүлэх, худаг, хөв байгуулж тархцыг тэлэн нягтшилыг бууруулах, ган, зудын үед нэмэлт тэжээл, хужир тавьж эрдсээр хангах зэрэг үйл ажиллагааг тасралтгүй хийсээр байна. Сэргээн нутагшуулж буй бүх газарт нутгийн иргэдэд түшиглэсэн байгаль хамгаалал, орон нутгийн удирдлага, иргэдийн оролцоог хангах үүднээс менежментийн төлөвлөгөөний боловсруулалт, хэрэгжүүлэлт, үнэлгээнд байнга хамтран ажиллах хэрэгтэй.
- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/208 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан Тахь хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөө (2025-2028)-ний хэрэгжилтийг хангаж, ажиллах зэрэг болно.

2.7. ХҮДЭР

Moschus moschiferus (Linnaeus, 1758)

Баг: Туруутан (Artiodactyla)
Овог: Хүдэр (Moschidae)
Англи нэр: Siberian Musk Deer or Musk Deer
Ижил нэр: Баданга хүдэр, *Moschus sibiricus* Pallas, 1779.



Ангилал зүйн тойм. Ангилал зүйн асуудал өнөөг хүртэл бүрэн шийдэгдээгүй маргаантай хэвээр. Тухайлбал, бугын овгоос (*Cervidae* Gray, 1821) салган хүдрийг тусдаа бие даасан овог (*Moschidae* Gray, 1821) болгон тодорхойлон бичсэн (Flerov, 1960; Webb and Taylor, 1980; Groves and Grubb, 1987; Janis and Scott, 1987). Одоогоор хүдрийн 5 салбар зүйл байгаагаас Монгол оронд *M. m. moschiferus* гэх салбар зүйл тархжээ.

Таних шинж. Биеийн урт 85-100 см, сүүл 4-6 см, сэрвээний өндөр 55-69 см, хондлой орчмоор 67-80 см, жин 10-17 кг. Мөч 4 хуруутай ба хажуугийн хоёр хуруу нь зогсож байх үед газарт хүрэхгүй. Биеийн хажуу, зоо хондлойгоороо бүдэг цайвар шаргалдуу толбо бүхий хүрэн бор, бараан хүрэн. Эрүү доороос өехий дагасан хос цайвар судалтай (Батсайхан нар, 2010).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Эмзэг (VU), A1acd.

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Устаж болзошгүй (EN), A3d (Clark *et al.,* 2006).

2025 онд Устаж болзошгүй (EN), A3d. Монгол орны хүдрийн популяцийн хэмжээ 1970 онд 60,000-80,000-д хүрч байсан (Дуламцэрэн, 1977). Улмаар 1986 онд ШУА-ийн Биологийн хүрээлэнгээс 6 аймгийн 63 сумын нутгийг хамруулсан судалгаагаар 44,000 бодгаль байв (Дуламцэрэн, 1989). Түүнээс хойш буурсаар 2010 онд буюу хамгийн сүүлд хийсэн түүний тоо толгой,

нөөцийн судалгаагаар 6,525 бодгаль болж буурсан (Биологийн хүрээлэн, 2010). Nowak (1991) хүдрийн нэг үе удмын хугацааг зургаан жил гэж тогтоосон. Хараа хяналтгүй агналт нь энэ зүйлийн популяцийн буурах гол шалтгаан болж дараагийн гурван үе удмын хугацаанд 50% хүртэл буурна гэж үзээд A3d шалгуурт үндэслэн Устаж болзошгүй гэсэн зэрэглэлээр үнэлэв. Оросын популяциас дэмжигдэх боломжтой ч хууль бус агнуур, самар бэлтгэх иргэдийн шууд, дам нөлөө буураагүйг харгалзан үнэлгээг өөрчлөөгүй.

Үнэлгээ хийсэн: Д.Лхагвасүрэн, Л.Анхбаяр, С.Пүрэвсүрэн (2025).

Үнэлгээг хянасан: Ян.Адъяа, С.Гомбобаатар (2025).

Дэлхийн тархац. Орос (Сибирь, Алс Дорнод), Казахстаны зүүн хойд хэсэг, Хятадын зүүн хойд болон баруун хойд нутаг, Монгол, Солонгосын хойгт тархсан (Цэнджав, 2002).

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол Алтайн хойд хэсгийн ой (Тогтохбаяр нар, 2000), Хөвсгөл, Хэнтий, Хангайн тайгын ой (Сосорбарам, 1970; Дуламцэрэн, 1977; Дуламцэрэн нар, 1989), Хан Хөхийн уулсын баруун хойд хөвчөөр тархсан (Дуламцэрэн нар, 1989; Wemmer, 1998; Цэнджав, 2002).



Амьдралын онцлог. Сүрэглэхгүй. Голдуу ганцаараа эзэмшил газартаа тогтвортой байршина (Батсайхан нар, 2022). Уулын царамд ургасан хушин ойд амьдарна. Өвслөг ургамал, хаг, хөвд, шилмүүсээр хооллоно. Эрийг гирээ, эмийг нь гэрэгчин, төлийг нь шовшоорой гэнэ. Орос нийллэг 12-р сарын дундаас орж, дараа зуны 6-р сарын сүүлч, 7-р сарын эхний хагаст голдуу ихэр шовшоорой гаргана. Шовшоорой 7-10 хоног эхийнхээ нуусан газар босолгүй хэвтэнэ (Самъяа нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Монгол орны хүдрийн популяцийн хэмжээ 1970 онд 60,000-80,000 хүрч байсан бөгөөд үүнээс 44,000 орчим нь Хэнтий (1000 га-д 21-35 бодгаль ноогдох нягтшилтай) болон Хангайн (1000 га-д 6-8 бодгаль ноогдох нягтшилтай) нуруунд бүртгэгдэж (Дуламцэрэн, 1977) байжээ. Мөн 1986 онд ШУА-ийн Биологийн хүрээлэнгээс 6 аймгийн 63 сумын нутгийг хамруулсан судалгаагаар 44,000 бодгаль байв (Дуламцэрэн, 1989). Түүнээс хойш энэ зүйлийн популяцийн хэмжээ эрс буурсан бөгөөд 1990-2000 оны хооронд 1 км^2 талбайд 1.2-оос 0.2 бодгаль ноогдох нягтшилтай болтлоо буурсан (Цэнджав, Бүжинханд, 2000; Цэнджав, 2002). 2008 онд Биологийн хүрээлэнгийн судлаачид Хан Хэнтийн дархан цаазат газрын баруун хэсгийн 13,713 км^2 нутагт 420 толгой хүдэртэй (Лхагвасүрэн нар, 2008), мөн 2010 онд тус дархан цаазат газрын 5,776 км^2 талбайд 1000 га-д 0.9 бодгаль ноогдох нягтшилтайгаар 557 толгой хүдэр бий хэмээн тус тус үнэлжээ.

2010 онд ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн гүйцэтгэсэн “Монгол орны ойн туруутны популяцийн үнэлгээний тайлан”-д Монгол орны 34,796 км^2 нутагт 1000 га-д 1.9 бодгаль ноогдох нягтшилтайгаар 6,525 толгой хүдрийн нөөцтэй хэмээн тогтоосон бөгөөд энэ нь 1980-1990 оны судалгааны үр дүнтэй харьцуулахад, энэ зүйлийн нягтшил 50 дахин буурсан үзүүлэлт юм. Үүнээс хойш Монгол орны хүдэр тархан амьдрах боломжит нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд хийсэн судалгааны мэдээ, баримт хомс байна.

Ховордлын шалтгаан. Гирээний заарыг авахын тулд хууль бусаар агнах нь ховордлын гол шалтгаан болж байна. Тухайлбал, 1996-2001 оны хооронд хамгийн багадаа 2,000 бодгаль гирээг хууль бусаар агнасан (Homes, 2004) гэжээ. Монгол орны хэмжээнд сүүлийн 11 (2013-2023) жилийн хугацаанд хууль бус агнуурын 8 хэрэг хууль сахиулах байгууллагуудад бүртгэгдсэн (Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар, 2024).

Д.Цэнджав (2002) ойн түймэр нөхөн үржихүйд экологийн их хязгаарлалт, дарамтлах хүчин зүйл болдог. Хууль бус агнуур, ойн түймрээс бусад сав, шим ертөнцөөс нөлөөлөх сөрөг холбогдол бага, хүдрийн байршил орчин, улирлын аясаар хувьсан өөрчлөгдөвч түүний амьдралын мөчлөгүүдэд зохистой, тааламжтай нөхцөлийг бүрдүүлэх ба түүхэн

хувьсах хөгжлийн явцад хүдэр өөрөө экологийн эрс тэс үзэгдлүүдэд дасан нийцэж амьдралынхаа мөчлөгийг бүрэн тохируулж чадсан амьтан бөгөөд ган, зуд мэт тухайн жилийн цаг агаарын түр зуурын зохисгүй нөлөөг ажирдаггүй (Цэнджав, 2002). Тэрээр 1990-ээд оноос хойш Хангай, Хэнтийн нуруунд хэдэн жил дараалан үргэлжилсэн ойн түймэр хүдрийн үндсэн байршил нутгийг алдагдуулж, таатай орчныг нь улам бүр хумигдуулж, тоо толгойн цөөрөхөд хүчтэй нөлөөлж байсан гэжээ. Тухайлбал, 1995-2000 оны хооронд Хан Хэнтийн дархан цаазат газар, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газарт хийж байсан мониторинг судалгаагаар, 1995 онд 200-500 га хушин ойд 4-8 толгой хүдэр ноогдох нягтшилтай байсан бол 1996 оны хаврын түймрийн дараа 0.5-1 толгой ноогдох нягтшилтай болтол эрс буурснаас гадна, байршил нутаг нь өөрчлөгдөж байсан (Цэнджав, 2002). Хүдрийн тоо, өсөлтөд амьд байгалиас нөлөөлөх сөрөг хүчин зүйлс бий. Чоно, нохой зээх, шилүүс, үнэг, ойн суусар, баавгай иднэ. Нялх үр төлийг нь махчин шувууд хөнөөнө (Дуламцэрэн, 1989; Цэнджав, 2002)

Хамгаалсан байдал. Монгол Улс 1953 оноос агнахыг хуулиар хориглож иржээ. Улмаар Амьтны тухай хуульд нэн ховор амьтнаар оруулсан бөгөөд төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр зөвхөн эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх зориулалтаар агнаж, барьж болно (7.2). Үүнээс бусад зориулалтаар нэн ховор амьтныг агнаж бэлтгэсэн арьс, яс, бусад түүхий эдийг худалдах, худалдан авахыг хориглосон (7.3). Нэн ховор амьтны амьдрах нутагт хүнд үйлдвэр, цахилгаан станц, химийн үйлдвэр байгуулах, авто болон төмөр зам тавих, уул уурхайн олборлолт явуулах, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх асуудлыг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг үндэслэн Засгийн газар шийдвэрлэдэг.

Үүнээс гадна (11.1.2) булаг, шанд, хужир мараанд ирж буй амьтныг отож агнах, (11.1.3) өөр нутагт шилжин байршиж байгаа агнуурын амьтныг агнах, барих, (11.1.4), агнуурын амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх зорилго бүхий байр, саравч, тэжээл мараа, бусад байгууламжийг эвдэж гэмтээх, устгах, (11.1.7) амьтны үр төлийг агнах зэрэг олон үйл ажиллагааг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр хүдэр 5,880,000 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг.

Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцын II хавсралтад бүртгэгдсэн (Чимэддорж нар, 2018). Мөн Монгол Улсын Улаан номын бүх хэвлэлд нэн ховор зүйлээр оржээ (Шагдарсүрэн нар, 1987; Шийрэвдамба нар, 1997; 2016).

Архангай аймгийн Бөхөн шарын нуруунд 2019 оноос хүдэр сэргээн нутагшуулж байна.

Хамгаалах арга хэмжээ

- Тархац нутаг, популяцийн хэмжээ, төлөв байдал, хандлага (3.2), биологи, экологи (3.3) болон аюул занал (3.5) зэргийг нарийвчлан судалж, үүний үндсэн дээр хамгаалллын менежментийн арга хэмжээг (3.8) хэрэгжүүлэх нь зохистой.
- Хууль бус агнуураас урьдчилан сэргийлж, бууруулахын тулд хууль сахиулах, байгаль орчны байгууллагууд, нутгийн иргэд, малчдын хамтын ажиллагаа, оролцоог сайжруулж, санаачилгыг өрнүүлэх, дэмжиж хамтрах нь зүйтэй.
- Байгаль хамгаалагч, улсын байцаагч нарыг чадавхжуулах сургалтыг тогтмол зохион байгуулах, хяналт шалгалтын ажлыг тогтмол зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, нутгийн иргэдийн бүлэг, нөхөрлөлтэй хамтран ажиллах нь чухал.
- Хүний санамсар болгоомжгүй үйлдлээс үүдэлтэй ойн түймрээс (10.5) урьдчилан сэргийлэх ажлыг хавар, намрын хуурайшилттай үед нутгийн иргэд, малчид, олон нийтэд хүртээмжтэй байдлаар зохион байгуулах нь нэн чухал.
- Зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2), өсгөн үржүүлэх, сэргээн нутагшуулах хөтөлбөрийг (5.1) хэрэгжүүлэх.
- Хамгаалахад чиглэсэн мэдлэг, боловсролыг албан болон албан бус сургалтаар олгох (2.1), олон нийтийн мэдээллийн хэрэгслээр (2.2, 2.3) өргөн олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх .
- Баданга хүдэр хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөө (2025-2028)-ний хэрэгжилтийг хангах нь чухал.

2.8. МОНГОЛ БӨХӨН

Saiga tatarica mongolica (Bannikov, 1946)

Баг: Туруутан (Artiodactyla)
Овог: Тугалмайтан (Bovidea)
Англи нэр: Mongolian Saiga or Saiga Antilope
Ижил нэр: Бөхөн, Татаар бөхөн, Монгол бөхөн; *Saiga tatarica tatarica, Saiga tatarica mongolica, Saiga borealis, Saiga borealis borealis, Saiga borealis Prisca, Saiga borealis mongolica*.



Ангилал зүйн тойм. Өнөөгийн байдлаар дэлхий дээр соргог бөхөн (*Saiga tatarica tatarica* Linnaeus, 1776), Монгол бөхөн (*Saiga tatarica mongolica* Bannikov, 1946) гэх хоёр салбар зүйлийн бөхөн бий гэж судлаачид үздэг. Одоогоор бөхөнгийн 5 үндсэн популяци оршин тогтнож буй бөгөөд Орост соргог бөхөнгийн нэг, Казахстанд соргог бөхөнгийн гурав, Монголд Монгол бөхөнгийн нэг популяци байна (Chimeddorj *et al.,* 2024).

Таних шинж. Биеийн урт 110-116 см, сэрвээний өндөр 60-67 см, сүүлний урт 8-13 см, жин 26-32 кг. Хөл, хүзүү нарийн, толгой том, өвөрмөц монхор хамартай, хамрын нүх маш том. Хэржин 22 см хүртэл урт (эврийн 3/1-ээс 2/1 хүртэлх 4-5 төвгөр үетэй), цайвар шаргал хос, шоорон эвэртэй. Эврийн диаметр 2.8 см хүрнэ. Хэрэгчин эвэргүй. Зун улбардуу бор шаргал, өвөлдөө цайвардуу бор саарал, нялх янзага бор хүрэн. Сэрвээнээс сүүлний уг хүртэл зоо дагасан нарийхан бор судалтай. Хэвэл гуяны дотор тал цайвар. Хүзүүгээ урагш сунган, толгойгоо гудайлган бөхийж, цагт 60-90 км хүртэл хурдлан хатирдаг (Chimeddorj *et al.,* 2024). Ороо нийллэгийн үед хондлой дээрх үс босож овоолсон мэт харагдана.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Ховордож болзошгүй (NT)

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Устаж болзошгүй (EN), A2acde (Clark *et al.,* 2006).

2025 онд Устаж болзошгүй (EN), A4acde; B2bc; C2aiib.

Энэ зүйлийн тоо, нөөцийн үнэлгээг 1998 оноос хойш тасралтгүй хийж ирсэн бөгөөд энэхүү 26 жилийн судалгаанаас харахад, хамгийн багадаа 2003 онд 750 бодгаль,

хамгийн ихдээ 2024 онд 23,215 бодгаль байна. Ган, зуд, халдварт өвчний нөлөөгөөр тоо толгойн хэлбэлзэл өндөр бөгөөд 2003 онд 75%, 2016 онд 31.9%, 2018 онд 80%-аар тус тус буурч байв. Хэдийгээр тоо толгой 2019 оноос хойш тогтвортой өсөж байгаа ч байгаль, цаг агаарын тааламжгүй нөлөө, халдварт өвчин, хууль бус агнуурын уршгаар тоо нь 50%-аас дээш буурах эрсдэлтэй хэмээн үзэж A4acde, бэлчээр, усны хомсдолын нөлөөгөөр амьдрах орчны доройтол гүнзгийрэх, тааламжит амьдрах орчин хумигдах эрсдэл өндөр гэж үзэн B2bc, бие гүйцсэн бодгалийн тоо, эзлэх хувь 95-100%-аар буурах эрсдэлтэй гэж үзэн C2aiib шалгуураар Устаж болзошгүй гэсэн зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Б.Чимэддорж, Б.Бүүвэйбаатар, Б.Гантулга (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Ян.Адъяа (2025).

Дэлхийн тархац. Оросын бөхөнгийн популяци Халимагийн нутагт буюу Каспийн тэнгисийн баруун хойд хээрт болон хил залгаа Астрахан мужийн нутагт тархсан (Smelyansky *et al.,* 2022; 2023). Казахстаны баруун хойд хэсэгт Уралын популяци, төв хэсэгт Бетпакдала популяци, өмнөд хэсэгт Устюртийн популяци орших бөгөөд Казахстаны өмнөд хэсгийн популяци өвлийн улиралд Узбекистан, Туркменистан хүрч нүүдэллэнэ. Гэсэн хэдий ч хил дамнасан нүүдэл хумигдаж, Туркменистанд сүүлийн жилүүдэд бөхөн тэмдэглэгдээгүй (Milner-Gulland and Mallon, 2024). Монгол орны хувьд соргог бөхөн (*Saiga tatarica tatarica* Linnaeus, 1776) нь Зүүнгарын говьд Монгол Алтай нурууны бэлээс урагш, Хөвчийн нуруу, Булган голын хооронд өндөр уул, говиор хязгаарлагдмал хэсэгхэн нутагт XX зууны эх хүртэл олноор байршиж байв (Банников, 1954; Дуламцэрэн, 1970; Намнандорж, 1976). Тархац, тоо толгой харьцангуй түргэн хомсдож, 1950-аад онд зөвхөн Хавтаг, Байтаг уул хавь, Борзонгийн говьд цөөн үзэгдэж байснаа тавиад оны дундаас үзэгдэхээ больжээ (Банников, 1954; Дуламцэрэн, 1970). 1970 оны сүүлчээр Аргалант уулын орчим 4 бөхөн байснаас хойш дахин үзэгдээгүй (Жирнов, 1977). Энэ салбар зүйлийн тархац, нөөц, биологийг судлаагүй. Хорь гучаад онд Дундад Азид соргог бөхөн ховордсоноос Монгол орон дахь тархцын хамгийн зүүн захын популяци эх сүргээсээ тасран тоо толгойгоо нөхөн сэлбэх боломжгүй болсон ба байгаль, хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллийн улмаас устсан (Шийрэвдамба нар, 2013) ажээ.

Монгол орон дахь тархац, амьдрах орчны онцлог. Монгол бөхөнгийн тархац нутгийн хойд хязгаар нь хойд өргөргийн 48°30', зүүн зах нь дорнод уртрагийн 96°30' солбицолд хүрч, Их нууруудын хотгорыг бүхэлд нь хамарч оршино. Монгол бөхөн 4 аймгийн 18 сумын нутаг дэвсгэрийг хамран 40,006 км^2 газар нутагт тархжээ. Энэ нь Монгол бөхөнгийн түүхэн тархац нутгийн 36.3%-ийг хамарна. Өнөөгийн тархац нутгийн ихэнх хэсэг буюу 21,346 км^2 газар нутаг Говь-Алтай аймгийн нутагт хамаарах бөгөөд үлдсэн хэсэг нь Ховд, Увс, Завхан аймгийн нутагт хамаарна. Говь-Алтай аймгийн Шарга, Хөхморьт, Баян-Уул, Дарив, Ховд аймгийн Чандмань, Дарив зэрэг сумдын нийт газар нутгийн 60-аас дээш хувьд нь Монгол бөхөн тархан байршдаг тул энэ зүйлийн хамгаалалд чухал бүс нутагт тооцогдож байна.



Түүнчлэн Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газраас сүүлийн 26 жил бөхөн хамгааллын олон талт үйл ажиллагааг тасралтгүй авч хэрэгжүүлсний үр дүнд бөхөнгийн тоо толгой өсөж, тархац нутгаа тэлж байна. Тодруулбал, Монгол бөхөнгийн үндсэн тархац нутаг Шаргын говь, Хүйсийн говь, Дөргөний хүрэн талаас хальж, Завхан аймгийн Дөрвөлжин сумын Хомын тал, Ховд аймгийн Дөргөн сумын Аргалант уул, Завхан голын хөндий, Увс аймгийн Завхан, Наранбулаг сумын Сангийн далай нуур, Татаалын хэв, Хяргас нуурын баруун талын хөндийгөөр шинээр тархан байршиж байна.

Монгол бөхөнгийн үндсэн тархац нутаг болох Их нууруудын хотгор нь уур амьсгалын нэн хуурай, дулаан мужийн нэн хүйтэн дэд мужид хамрагдана (БНМАУ-ын уур амьсгал, гадаргын усны нөөцийн атлас, 1985). Өндөр уул, гүвээ толгод, уулс хоорондох өргөн, нарийн хөндий, тал хосолсон гадаргын хувьд олон янз тогтоцтой нь бичил цаг уурын өвөрмөц байдлыг үүсгэнэ. Улирлаас хамааран цөөн тоогоор болон сүргээрээ бэлчээрийн соргог, усны олдцыг даган шилжилт хийх бөгөөд цөлөрхөг хээрийн болон цөлийн харьцангуй нам дор байрлалтай (д.т.д. 1,100-1,800 м) хөндийд гол төлөв байршина. Говийн болон сайрын хялгана, таана, хөмүүл, баглуур, улаан бударгана, үетэн зонхилсон тачир сийрэг ургамалжилттай, тэгшивтэр гадаргуутай газарт цөөн тоогоор сүрэглэж, тогтмол нүүдэллэж бэлчээрийн шилжилт хөдөлгөөн хийж амьдарна (Баяртогтох нар, 2021). Хүйтэн, цастай өвөл эсвэл гантай зун нөмөр, бэлчээр дагаж уулсын ам хөндий, толгодоор бэлчинэ (Амгалан нар, 2008). Эгц, цавчим бартаат уулсаас зайлсхийнэ. Сэрүүн бүсийн үетэн давамгайлсан ургамалжилттай хээр (4.4), сэрүүн цөл (8.2) нь бөхөнгийн үндсэн амьдрах орчин болно.

Амьдралын онцлог. Сүрэглэж амьдарна, сүргийн хэмжээ жилийн турш харилцан адилгүй ба нэг сүрэгт дунджаар 6.5 бодгаль ногдох бөгөөд 1-5 бодгальтай сүрэг хамгийн элбэг тохиолдоно. Улирлын шинжтэйгээр сүргийн хэмжээ өөрчлөгдөх бөгөөд төллөх үе буюу 6-р сард сүрэг задарч, үржлийн үе болох 12-р сард хамгийн том сүрэг үүсгэнэ. Зуны улиралд өглөө эрт, оройн цагаар идээшлэх бөгөөд өвөлд өдрийн турш идээшилнэ (Батсайхан нар, 2010).

Таана, хөмүүл, баглуур, говийн хялгана, шаваг, шарилж зэрэг 21 төрөлд хамаарах 48 зүйлийн өвслөг ургамлаар хооллоно (Chuluunbat *et al.,* 2024). Өвс, ус дагаж бэлчээрээ ойр зуурхан сэлгэнэ. Хэрэгчин голдуу 7 сартайдаа, хэржин 19 сартайдаа үржилд орж эхэлнэ (Дуламцэрэн нар, 1989). Ороо нийллэгт 12-р сарын дунд үед болно. 6-р сарын эхээр төллөлт эхлэх ба 6-р сарын дунд үед төллөлт оргилдоо хүрнэ. Жилийн хур тунадас, температурын хэлбэлзлийн нөлөөнөөс хамаарч ихэрлэлтийн хувь өөрчлөгддөг ба нийт төллөж буй хэрэгчний 25-65% орчим нь ихэрлэнэ. 2008-2010 онд хийсэн янзаганы мэнд үлдэлтийн судалгааны дүнгээс үзэхэд, эр янзаганы жин эмийнхээс, нэгээр төрсөн янзаганы биеийн жин ихэр янзаганыхаас ямагт илүү байв. Дөнгөж төрсөн янзаганы жин дунджаар 2.5 кг (Chimeddorj *et al.,* 2024).

Бөхөнгийн шилжилт хөдөлгөөний хэв маягийг “хэрмэл” хэмээн ангилж болох бөгөөд учир нь жил бүр тогтмол ашигладаг өвөл болон зуны байршил нутаг үгүй юм.

Ховордлын шалтгаан. Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газраас олон улсын хэмжээнд өргөн ашиглаж буй “Нээлттэй стандарт” байгаль хамгааллын төлөвлөлт хийх аргачлалын дагуу үнэлж үзэхэд, ган, зуд зэрэг байгалийн хүчин зүйлсээс гадна, бэлчээрийн доройтол, зэрлэг амьтанд ээлтэй бус шугаман дэд бүтэц, уст цэг, булгийн ойролцоох хүний суурьшил, халдварт өвчин зэрэг аюул занал хамгийн их нөлөөтэй байсан бол хууль бус агнуур, худалдаа, уул уурхай, хариуцлагагүй аялал жуулчлал, байгалийн нөөцийн зохисгүй ашиглалт (бутлаг ургамал, шаваг г.м) зэрэг хүний хүчин зүйлс бага болон дунд нөлөөтэй хэмээн үнэлэгджээ.

Бөхөнд ган, зудын нөлөө голлох аюул занал үүсгэнэ. Их хэмжээний цас орж, хэт хүйтэрснээс эсвэл цас орохгүй хэт хүйтэрснээс идэш тэжээлийн хомсдолд орох, осгох, идэш тэжээл хайж, хол зайд шилжин нүүдэллэх шаардлагатай болж физиологийн хүнд ачаалал бич болсноор олон зуугаар хорогддог. Гантай зуны дараах зуд, зудын дараах гангын нөлөө бөхөнд маш том сорилт үүсгэнэ. 1999-2002 онд тохиосон ган, зудын нөлөөгөөр бөхөнгийн тоо толгой 75%-аар буюу 5,000 бодгалиас 750 болтлоо буурч байжээ.

Нийт тархац нутгийнхаа хүрээнд гэрийн малтай зэрэгцэн оршсоор ирсэн бөгөөд манай орны малын тоо 1970-аад оноос хойш (2000 болон 2010 оны зудын хорогдлыг эс тооцвол) тогтвортой өсжээ. Сүүлийн жилүүдэд дэлхийн хэмжээнд ноолууран бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэж байгаатай холбоотойгоор ноолуурын үнэ өсөж, үүний улмаас ямааны тоо огцом нэмэгдэж байна (Berger *et al.,* 2013). 2020 оны байдлаар

бөхөнгийн тархац нутгийн хэмжээнд нийт 1.2 сая орчим толгой мал тоологдсоноос ямаа 55.6%, хонь 35.2%, адуу 4.4%, үхэр 2.9%, тэмээ 1.9%-ийг тус тус эзэлж байна (Үндэсний статистикийн хороо 2020, www.1212.mn). Энэ нь тархац нутгийнхаа хэмжээнд 8,000 орчим бөхөн 1.2 сая гаруй малтай идэш тэжээлээр өрсөлдөж байна.

Үүнээс гадна, малын тоо толгой их өсөх нь ургамлын биомассыг, бууруулж, бэлчээрийн чанарыг доройтуулах төдийгүй зарим тохиолдолд бэлчээрийн даац хэтэрснээр ургамлын бүлгэмдэл эргэлт буцалтгүйгээр өөрчлөгддөг. Түүнчлэн бөхөн айл, мал, гэрийн нохойноос дайжин амьдрах орчны тааламжгүй хэсэг рүү шахагдаж байна. Мөн малын хөлийн нөлөөгөөр зарим булаг, шандын эх талхлагдан урсац нь багасав.

Нүүдлийн мал аж ахуй бол Монголчуудын уламжлалт соёл, аж ахуй төдийгүй эдийн засгийн чухал салбаруудын нэг тул түүний экосистем болон бөхөнгийн популяцид үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгахын тулд бэлчээрийн менежментийг өнөөгийн нийгэм, эдийн засгийн хөгжилтэй уялдуулан зайлшгүй сайжруулах шаардлагатай. Бэлчээрийн хэт ашиглалт, ялангуяа булаг, уст цэгт үзүүлэх бэлчээрийн дарамт нь бөхөнгийн амьдрах орчны доройтлыг нэмэгдүүлж байна. 1990 оны байдлаар бөхөнгийн тархац нутагт 548 булаг, уст цэг байснаас хуурайшилт, булаг орчимд айл мал шавах, малын хөлийн нөлөөгөөр ундарга нь дарагдах, булаг орчмын бэлчээрийн хэт ашиглалт зэрэг шалтгааны улмаас 80 гаруй булаг, уст цэг сүүлийн арван жилд хатаж, ширгэсэн байна (www.1212.mn).

Түүний тоо толгойн бууралтад хууль бус агнуур багагүй сөрөг нөлөө үзүүлнэ. Хууль бус агнуурт хэржин их хэмжээгээр өртөж байсан бөгөөд хэржингийн 1 кг эвэр (~3 хос эвэр) 2000-аад оны үед Хятадын зах зээл дээр дунджаар 100 долларын үнэтэй байсан бол олон улсын зах зээл дээр нэг хос эвэр 500-600$ хүрч байжээ (Bekenov *et al.,* 1998; Milner-Gulland *et al.,* 2001). Монгол орны хэмжээнд сүүлийн 11 (2013-2023) жилийн хугацаанд хууль бус агнуурын 11 хэрэг хууль сахиулах байгууллагуудад бүртгэгдсэн (Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар, 2024).

Хорогдолд хүчтэй нөлөөлдөг өөр нэг хүчин зүйл бол халдварт өвчин, ялангуяа бог малын мялзан төст өвчин (peste-des-petits-ruminants, PPR) бөгөөд уг өвчнөөр халдварласан амьтдын 90% хүртэл нь хорогдсон. Энэ өвчин 2016 оны төгсгөл 2017 оны эхээр Монгол бөхөнгийн тархац нутгийн 60-70%-ийг хамран тархсан. Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар болон Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг (WCS)-ээс орон нутгийн байгаль орчны байгууллагуудтай хамтран 2017 оны 3-р сард шугаман трансектийн аргаар хийсэн бөхөнгийн тооллогоор, нийт 4,961 бодгаль бүртгэгджээ. Энэ нь өвчин гарахаас өмнө буюу мөн оны 1-р сард хийсэн тооллогын дүнтэй (10,907 бодгаль) харьцуулахад, бөхөнгийн тоо толгойн хэмжээ 54.5%-аар буурсан үзүүлэлт юм. Өвчний халдвараар хэржин болон янзага олноор хорогдсон ба тухайлбал, бөхөнгийн популяцийн нийт хэржингийн 20% орчим нь, янзаганы 11% нь хорогдсон байна (Chimeddorj and Buuveibaatar, 2017).

Хамгаалсан байдал. Монгол Улс 1930 оноос агнахыг хуулиар хориглож иржээ (Шийрэвдамба нар, 2013). Улмаар Амьтны тухай хуульд нэн ховор амьтнаар оруулсан бөгөөд төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр зөвхөн эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх зориулалтаар агнаж, барьж болно (7.2). Үүнээс бусад зориулалтаар нэн ховор амьтныг агнаж бэлтгэсэн арьс, яс, бусад түүхий эдийг худалдах, худалдан авахыг хориглосон (7.3). Мөн (7.4) нэн ховор амьтны амьдрах нутагт хүнд үйлдвэр, цахилгаан станц, химийн үйлдвэр байгуулах, авто болон төмөр зам тавих, уул уурхайн олборлолт явуулах, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх асуудлыг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлтийг үндэслэн Засгийн газар шийдвэрлэдэг.

Үүнээс гадна (11.1.2) булаг, шанд, хужир мараанд ирж буй амьтныг отож агнах, (11.1.3) өөр нутагт шилжин байршиж байгаа агнуурын амьтныг агнах, барих, (11.1.5) агнуурын амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх зорилго бүхий байр, саравч, тэжээл мараа, бусад байгууламжийг эвдэж гэмтээх, устгах, (11.1.7) амьтны үр төлийг агнах, шувууны өндгийг түүх, гэмтээх, устгах зэрэг олон үйл

ажиллагааг хориглосон. Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Монгол бөхөн 8,700,000 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг.

Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)-ын I хавсралт, мөн Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ын II хавсралт (Чимэддорж нар, 2018; http://checklist.cites.org), түүнчлэн дэлхийн ховордсон 100 амьтны жагсаалтад (Zahler et al., 2004; Isaac et al., 2007) тус тус бүртгэгджээ. 2019 онд зохион байгуулагдсан Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ын оролцогч талуудын 18 дугаар бага хурлаар (CoP18) бөхөнг тус конвенцын II хавсралтад хэвээр үлдээсэн ч түүний эвэр болон бусад эд эрхтэн, дагалдах бүтээгдэхүүний олон улсын худалдаанд хориг тавьсан. Монгол Улсын Улаан номд нэн ховор, унаган зүйлээр бүртгэгдсэн (Шийрэвдамба нар, 2013).

Тархац нутгийн 33.17% (12,250 км^2 нутаг дэвсгэр) нь нийт есөн улсын тусгай хамгаалалттай нутагт хамрагдсан. Мөн Бөхөн хамгаалах зорилгоор УИХ-ын 1993 оны 83 дугаар тогтоолоор Шарга, Манханы байгалийн нөөц газрыг байгуулсан бөгөөд Ховд аймгийн Буянт, Манхан сумдын нутгийг хамарсан Манханы хэсэг (759 км2), Говь-Алтай аймгийн Шарга, Төгрөг, Тонхил, Халиун, Дарви сумдын нутгийг хамарсан Шаргын хэсэг (3,126 км2) гэсэн хоорондоо холбоогүй 200 км зайтай тусгаарлагдсан нийт 3,885 км2 талбай бүхий байгалийн нөөц газар юм. Хамгийн сүүлд “Бөхөн” хэмээх орон нутгийн тусгай хамгаалалттай газрыг 2021 онд Хяргас нуурын хөндийд байгуулсан.

Хамгаалах арга хэмжээ. Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)-ын хүрээнд бөхөн тархсан 5 орны Засгийн газар болон хамтран ажилладаг 9 байгууллага нийлж “Бөхөнгийн популяцийг хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой ашиглах тухай харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг 2006 онд байгуулсан. Уг санамж бичгийн хүрээнд бөхөн хамгаалах дунд хугацааны хөтөлбөр (Medium-Term International Work Programme)-ийг боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллаж ирсэн бөгөөд бөхөн хамгаалах дунд хугацааны хөтөлбөрийг бөхөн тархсан улс орнуудын 2025-2030 оны үйл ажиллагааны төлөвлөөгөг 2025 онд шинэчлэн боловсруулж мөрдөн ажиллаж байна.

Түүнчлэн Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/208 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар Монгол бөхөнг хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөө (2025-2028) батлагдсан. Энэ төлөвлөгөөнд тусгагдсан дараах зорилтуудын хэрэгжилтийг хангахад талуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, хөрөнгө босгох ажилд анхаарал хандуулах шаардлагатай. Үүнд:

- Зорилт 1: Амьтны тухай хууль, эрх зүйн орчныг сайжруулах, амьтан хамгааллын асуудлыг бусад салбарын хууль эрх зүйн орчин, орон нутгийн бодлого төлөвлөлттэй уялдуулах.
- Зорилт 2: Байгалийн жамаар өсөж үржих тааламжтай нөхцөлийг хангах зорилгоор тэдгээрийн тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулж, хамгааллын менежментийг сайжруулах.
- Зорилт 3: Нэн ховор, ховор амьтдыг сэргээн нутагшуулах, генетик олон янз байдлыг нэмэгдүүлэх замаар тэдгээрийн тоо толгойн тогтвортой өсөлтийг хангах
- Зорилт 4: Амьдрах орчныг тэтгэх, холбоос нутгийг (нүүдлийн зам) хамгаалах замаар уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадварыг нэмэгдүүлэх.
- Зорилт 5: Судалгаа шинжилгээний ажлыг тогтмолжуулах, шинжлэх ухааны дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, нэгдсэн мэдээллийн сан бий болгох.
- Зорилт 6: Нэн ховор, ховор амьтдын байгаль орчин, нийгэм, соёл, эдийн засгийн ач холбогдол, хамгааллын үнэ цэнийг олон нийтэд түгээх, соён гэгээрүүлэх.
- Зорилт 7: Байгалийн нөөцийн хамтын менежментийг сайжруулах (нутгийн иргэд, үр өгөөж) зэрэг болно.

2.9. ХАВТГАЙ

Camelus ferus (Przewalski, 1878)

Баг: Туруутан (Artiodactyla)
Овог: Тэмээ (Camelidae)
Англи нэр: Wild Camel
Ижил нэр: Хавтгай тэмээ (Дуламцэрэн, 2003), Зэрлэг тэмээ.



Ангилал зүйн тойм. Тэмээний овгийн цор ганц бие даасан зэрлэг зүйл. 3-4 сая жилийн тэртээ хойд Америкаас Берингийн хоолойгоор дамжин Еврази тивийн эх газарт ирсэн. Гэрийн тэмээг одоогоос 4,000 жилийн өмнөөс гаршуулж ирсэн боловч хавтгай нь тусдаа төрөл зүйл байсан тул гаршуулахаас зайлсхийж байсан гэж үздэг. Хавтгай нь дэлхий дээрх бүх тэмээний өвөг бөгөөд 700,000 жилийн өмнө байсан тэмээний бусад төрлөөс тусгаарлагдан хөгжиж, өнөөг хүртэл байгаль дээр зэрлэгээрээ үлдсэн бие даасан зүйл юм.

Таних шинж. Биеийн урт дунджаар 345 см, сүүл 55 см, хүзүү 74 см урт, сэрвээ 210 см, хондлой 220 см, бөхний өндөр 35 см, жин 550 кг орчим (Бадамханд, Тулгат, 1990). Өндөр зэгзгэр биетэй, урд хөлийн өвдөгт сайргүй, бөх намхан, үсэн бүрхүүл тачирдуу, нэгэн жигд элсэн шаргал зүстэй, хоншоор хавтгай, чих богино (Пржевальский, 1978). Биеийн галбир гэрийн хоёр бөхт тэмээтэй төсөөтэй ч бие гоолиг, бөх жижиг, шовгор, үргэлж босоо, хөл, хүзүү урт нарийн, тавхай ялимгүй бага, гонзгойдуу, дөрвөлжин, хавтгай, духны хэсэг нь шулуун хавтгай, хошуу шөмбөгөр, уруул нимгэн. Өрөвлөг, бөхний сагсаг, шил, өвдөгний зогдрын хялгас богино сийрэг, эм ноос тачир, шингэн. Ингэ нь шаргал бор, буур нь ялимгүй бараан. Сүүл нарийн, цацаг үс улаан шаргал. Өвдөг тойг өвчүүний саарь бараг мэдэгдэхгүй (Шагдарсүрэн, 1962; Бадамханд, Тулгат, 1990).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Устаж байгаа (CR), A3de; A4ade.

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Устаж болзошгүй (EN), C1 (Clark *et al.,* 2006).

2025 онд Устаж болзошгүй (EN), C1.
Монгол орны популяцийн хэмжээ нь 463±92 үржлийн бодгалиас бүрддэг (Адъяа, 2005). Мөн 2019-2021 оны автомат камерын судалгаагаар, 650 орчим хавтгай байгааг тогтоосон (WCPF camera trapping report, 2023). Энэ зүйлийн тархац нутаг хязгаарлагдмал, Говийн Их дархан цаазат газрын хамгаалалтын бүс дотор байгаа хэдий ч хууль бус алт олборлолт, эрлийзжилт зэрэг хүний шууд, дам сөрөг нөлөө байсаар байна.
Үнэлгээ хийсэн: Яд.Адьяа, Д.Энхбилэг, Г.Довчиндорж (2025).
Үнэлгээ хянасан: Ян.Адьяа, С.Гомбобаатар (2025).

Дэлхийн тархац. Хятад, Монголын нутаг дэвсгэрт хавтгайны дараах дөрвөн жижиг хязгаарлагдмал популяци бий. Үүнд: Хятадын Гансу мужийн Гашуун говийн популяци; Хятадын Шинжан мужийн Таклимакан цөлд буй популяци (энэ популяци маш ихээр цөөрсөн, одоо бараг устсан); Хятадын Аржиншань уулын умард бэл, түүнтэй хил залгаа Лоб нуурын Хавтгайн байгалийн нөөц газарт байрших популяци; Монголын Хятадтай хил залгаа орших Говийн Их дархан цаазат газрын “А” хэсгийн популяци (Reading *et al.,* 1999; Adiya *et al.,* 2016; 2019).

Монгол орны тархац, амьдрах орчин. Энэ зүйлийн тархац нутаг нь Алтайн өвөр говийн Эдрэнгийн нурууны бэлээс Шивээт улаан, Улсын хилийн ... тоот багана, мөн зүүн урагш Хөх төмөртийн нуруу, Цулбуурын нуруу, Хуцын шанд, Угалзын нуруунаас урагш улсын хилийн ... тоот багана хүрнэ (Адъяа нар, 2004; 2005; 2016; 2019). Төв Азийн жинхэнэ болон хэт хуурай цөлийн агаарын температур -33^{0}C – 40^{0}C, хөрсний температур -33^{0}C-70^{0}C хэм хүрсэн орчинд амьдардаг тэсвэртэй амьтан. Намхан толгод, уулс хоорондын тэгш газраар баглуур болон шар модот хэвшилтэй бүлгэмдэл, ургамалжилт маш сийрэг орчинд амьдарна. Уулын бэл хормойн тэгш газар, гадагш урсгалгүй хотгор, жижиг толгодуудад ихэнхдээ зуны улиралд байршина. Харин өвөл, намар ихэнхдээ уулын хавцал, уулс хоорондын хөндий, модлог бутлаг ургамал бүхий баянбүрдээр илүүтэй байршина. Хавтгай зөвхөн бэлчээрийн төлөв байдал төдийгүй түүний нуугдах халхлагдах боломжит байдал, булаг болон түр зуурын бороонд тогтоол зэрэг усны хүртээмжтэй эх үүсвэр бий эсэхээс хамааран тухайн нутагт байршина (Адьяа, 2013).



Амьдралын онцлог. Сүрэглэж амьдардаг ба сүрэг дэх бодгалийн тоо, хүйсийн харьцаа улирлаас хамааран харилцан адилгүй. Буурт 12-р сарын дундаас орооны зан төрх тод илрэх бөгөөд хүйтний эрч чангарах тусам илүү идэвхтэй болно. 1-р сарын эхээс 2-р сарын сүүлч хүртэл буурын ороо хамгийн идэвхтэй орох ба зан төрх нь илүү догшин болж, амнаасаа хөөс цахруулж, шүдээ байнга хавирч дуу гаргах, хойд хоёр хөл дээрээ оцойн сууж шавна. Нийллэгт орж буй ингэ харьцангуй тайван зан төрхтэй ба бууруа дагах, шөргөөх, үе үе шээс алдах, хэвтэх зан төрх гаргана. Хээл тээх хугацаа 420-460 орчим хоног ба 3-р сарын сүүлчээс 4-р сарын сүүлч хүртэл ботголно (Адьяа, 2005). Байгаль дээр дунджаар 15-20 жил насалдаг ба гаршуулсан ингэ 30 нас хүрсэн тохиолдол бий (Адьяа, 2005).

Тоо толгой, нягтшил. Монгол болон Хятадын цөлийн бүсэд 1,000 хүрэхгүй тоо толгой бий (Adiya *et al.,* 2019). Алтайн өвөр говийн популяцийн тоо 1990 онд 450, 1991 онд 415, 1992 онд 320, 1993 онд 320, 1994 онд 345 бодгаль байсан (Тулгат, 2002) бол 2005 онд Монгол орны популяци нь 463±92 үржлийн бодгаль (Адъяа, Довчиндорж, 2005), харин 2012 онд 1000 га-д 0.29 ноогдох нягшилтайгаар 815 (95% CI=561-1,069) бодгаль байна (Адьяа, 2017).

Ховордлын шалтгаан. Хууль бусаар алт олборлох явдал түүний амьдрах орчинд сөргөөр нөлөөлж байна. Гэрийн тэмээтэй эрлийзжих нь хавтгайн гений санд аюул

учруулж байгаа бөгөөд Говийн Их дархан цаазат газрын орчны бүсийн сум болон Өмнөговь, Баянхонгор аймгийн говийн сумдад эрлийзжүүлэх асуудал байсаар байна (Адьяа нар, 2016).

Гэрийн тэмээ тус дархан цаазат газарт нэвтэрч буй үзэгдэл олон удаа тохиолдож байгаа нь халдварт өвчин тархах, эрлийзжих боломжийг бүрдүүлж болох юм (Walzer and Kaczensky, 2005). Хүний сөрөг нөлөө, орчны хомсдол зэрэг нь хавтгайд сөргөөр нөлөөлнө (Адьяа нар, 2019). Алтны уурхайд төмрийн хүдрийг ялгахад цианит ашигласнаас усны нөөцийг нь бохирдуулж байна (Hare, 2006). Хятад, Монголын хилийн дагуух торон хашаа хавтгайн нүүдэл, хөдөлгөөнд саад болж улмаар Хятадын популяцитай генийн солилцоонд орох боломжийг тусгаарлана (Adiya, 2023). Ботго руу саарал чоно халдаж, барьж иддэг нь жижиг популяцийн өсөлтийг бууруулах гол шалтгаан болно (Адьяа нар, 2005; 2016; 2019). Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийн улмаас булаг шанд, баянбүрд, уст цэгүүд хатаж, хуурайшиж буй нь түүний амьдралд сөргөөр нөлөөлдөг.

Хамгаалсан байдал. Монгол Улс 1930 оноос хавтгай агнахыг хуулиар хориглож иржээ (Шийрэвдамба нар, 2013). Улмаар Амьтны тухай хуульд нэн ховор амьтнаар оруулсан бөгөөд төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр зөвхөн эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх зориулалтаар агнаж, барьж болно (7.2). Үүнээс бусад зориулалтаар нэн ховор амьтныг агнаж бэлтгэсэн арьс, яс, бусад түүхий эдийг худалдах, худалдан авахыг хориглосон (7.3). Мөн (7.4) нэн ховор амьтны амьдрах нутагт хүнд үйлдвэр, цахилгаан станц, химийн үйлдвэр байгуулах, авто болон төмөр зам тавих, уул уурхайн олборлолт явуулах, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх асуудлыг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлтийг үндэслэн Засгийн газар шийдвэрлэдэг.

Үүнээс гадна, (11.1.2) булаг, шанд, хужир мараанд ирж буй амьтныг отож агнах, (11.1.3) өөр нутагт шилжин байршиж байгаа агнуурын амьтныг агнах, барих, (11.1.4) амьтны үүр, ичээ ухах, гэмтээх, (11.1.5) агнуурын амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх зорилго бүхий байр, саравч, тэжээл мараа, бусад байгууламжийг эвдэж гэмтээх, устгах, (11.1.7) амьтны үр төлийг агнах, шувууны өндгийг түүх, гэмтээх, устгах зэрэг олон үйл ажиллагааг хориглосон. Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр хавтгай 38,900,000 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг.

Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенцын I хавсралт (Чимэддорж нар, 2018), Монгол Улсын Улаан номын бүх хэвлэлд нэн ховор зүйлээр (Шийрэвдамба нар, 1997; 2016) оржээ.

Тархац нутаг бүхэлдээ Говийн Их дархан цаазат газрын “А” хэсэгт хамрагдан хамгаалагдсан. Уг зүйлийг уугуул тархац нутаг, амьдрах орчинд нь зориудаар өсгөн үржүүлэх, хамгаалан авч үлдэх ажил амжилттай хэрэгжиж байгаа ба 40 орчим бодгальтай үржлийн сүргүүд бий болжээ.

Хамгаалах арга хэмжээ

- Хавтгайг хамгаалахтай холбоотой олон улсын гэрээ конвенц, хууль тогтоомжуудын хэрэгжилтийг сайжруулж, мөрдүүлэх нь нэн чухал.
- Популяцийн мониторинг хөтөлбөр бий болгох, хамгааллын асуудлаар орон нутаг, орчны бүсийн иргэдэд хавтгай болон бусад нэн ховор, ховор амьтад ба экологийн мэдлэг, боловсрол олгох сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах нь зүйтэй.
- Хамгаалалтай газар нутагт болон орчны бүсэд хавтгай, түүний амьдрах орчинд нөлөөлж буй хүний сөрөг хүчин зүйлсийг багасгах, арилгах арга хэмжээг тодорхой төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлагатай.
- Хавтгайн гол гол байршил нутгуудад задгай ус бий болгох, хуучин уст цэгүүдийг сэргээх эсвэл шинээр гаргах боломжийг байнга судалж, хэрэгжүүлэх нь зүйтэй.
- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/208 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан Хавтгай тэмээ хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөө (2025-2028)-ний хэрэгжилтийг хангаж, ажиллах зэрэг болно.

2.10. ЦАА БУГА

Rangifer tarandus (Linnaeus, 1758)

Баг: Туруутан (Artiodactyla)
Овог: Буга (Cervidae)
Англи нэр: Reindeer
Ижил нэр: Цаа буга, Буган цаа, Зэрлэг цаа. Дархад, урианхай иргэд цаа бугыг халиун бугаас ялгахын тулд зүсний цагаан өнгийг харгалзан “Цагаан буга” гэдэг агуулгаар “Цаа буга” гэдэг байжээ.



Ангилал зүйн тойм. Монголд зэрлэг цаа бугын тусгаарлагдсан хоёр популяци байдаг тухай Литвинов, Базардорж (1992) нарын бүтээлд дурджээ. Манай оронд Валетены цаа буга буюу *Rangifer tarandus* Valentinae Flerov. 1933 гэдэг салбар зүйл байх боломжтой (Дуламцэрэн, 1970) ба өнөөгийн байдлаар Монголд нэг зүйл буган цаа (*R. tarandus* Linnaeus,1758) бий (Дуламцэрэн, 2003). Түүхийн хуудсыг сөхвөл 1764 онд Дархан шавийн тоо бүртгэлийн дансанд 192 бодгаль бүртгэгдсэнээр Монгол бичгийн хэлэнд цаа буга гэдэг нэр хэрэглэх болсон ба тэд ян сарьдаг, тайгын байршилтай (Аюурсэд, 1996).

Таних шинж. Тайгын бүсэд бэлчээрлэх цаа буга нь үнэхээр цагаан өнгөөрөө ялгардаг. Ялангуяа өвлийн улиралд тарга тэвээрэг сайн авч, үсэн бүрхүүл сорлох үед алсаас цагаан зүс нь тодорно. Морфологийн хувьд гэрийн цаа бугатай ойролцоо ч биеийн хэмжээгээр ялимгүй том, өндөр, гадаад зүс бор цайвар, үсний сор цагаан болон эврийн хэмжээ цалгар том (Адьяа, 2013). Мөн гэрийн тэжээвэр популяциас генетикийн хувьд ялгаатай (Geptner *et al.,* 1961).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Эмзэг (VU), D1 (Clark *et al.,* 2006).

2025 онд Устаж болзошгүй (EN), B1a, D1. Монгол орны популяци 140-200 бодгалиас бүрддэг. Энэ зүйлийг хараа хяналтгүй ихээр агнаж байгаа нь аюул учруулж байгаа ч орчны доройтол, эрлийзжилт зэрэг удаах аюул нүүрлэж байна. Энэ жижиг популяцийг B1a болон D1 шалгуураар үнэлэн Устаж болзошгүй гэсэн зэрэглэлд хэвээр үлдээв.

Үнэлгээ хийсэн: Г.Наранбаатар, Ж.Төмөрсүх, Яд.Адьяа (2025).

Үнэлгээг хянасан: Ян.Адьяа, С.Гомбобаатар (2025).

Дэлхийн тархац. Хойд Европ, Сибир, Хойд Америкийн тайга болон тундрийн бүс, хойд туйл орчмын бүсээр тархсан (Corbet, 1978; Hall, 1981; Koubek and Zima, 1999; Wilson and Ruff, 1999). Тасархай дэд популяцийн тархалт нь Норвег (Свабардын арлууд, тэнд тусгай салбар зүйл болох *R. t. platyrhynchus* бий), Финланд ба Орос (Новая Земля болон нутгийн уугуул салбар зүйл *R. t. pearsoni* байдаг)-д тархсан (Herre, 1986; Koubek and Zima, 1999). Финландын баруун болон зүүн хэсэгт цааны хоёр тусгаар салбар зүйл бий. Одоогоор Канад, АНУ, Гринланд, Норвег, Финланд, Орос болон Монголд тархсан (IUCN, 2010).

Монгол орны тархац, амьдрах орчин. Хөвсгөлийн уулсын Жодог, Хэвэн, Залуу үүр голын эх орчим, Бяранга, Тэнгис, Шарга голын эх орчмын өндөр уулын тайгын нутгаар тархмал (Банников, 1954; Намнандорж, 1976; Базардорж, Сүхбат, 1984; Литвинов, Базардорж, 1992; Адьяа нар, 2013). Хойд өргөргийн 50° хүртэл буюу Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Хөг, Тунай голын эх, Улаан тайгын нуруу, Мөрөнгийн эх, Ренчинлхүмбэ сумын Тэнгэс, Шарга голын эх, Бяранга, Хуулгын нуруу, Хөвсгөл нуурын зүүн хэсэгт Хэвэн, Жодог, Залуу, Хөгшин үүр голын эхний ян сарьдгаар байрших бөгөөд дэлхийн цааны тархцын хамгийн өмнөд хил нь болно (Адьяа, 2013). Цааны байршил нь хил орчмын нутагт, тодорхой хугацаанд хилийн наана, цаана гарч шилжилт хөдөлгөөн хийнэ. Тодруулбал, Цагааннуур сумын Монгол шарын даваа, Тэнгисийн эх орчмын буган цаа Оросын Тувагийн Хамсура, Азас орчимд, Цагаан-Үүр сумын Хэвэнгийн эх, Залуу үүр, Хөгшин үүр, Саравслаг орчмынх Оросын Бурядын Тункинскийн районы Хамар даваа орчимд хоорондоо чөлөөтэй нүүдэл хөдөлгөөн хийдэг байх боломжтой (Адьяа, 2013). Амьдрах орчин нь д.т.д 2,500-3,500 м өндөрт өргөгдөж хаг, хөвд бүхий бэлчээртэй, ян сарьдаг, тайгад амьдарна. Ян сарьдгийн нүцгэн өлөн, ширэг зонхилсон үет өвслөг ургамал, намхан ургасан хар харгана зэрэг ургамал бүхий орчинд бэлчээрлэнэ. Цаа буга нь өндөр уулын тайга, тагийн бүсийн амьтан юм.



Амьдралын онцлог. Зун нүцгэн царам, сарьдгийн зоонд бэлчин ногоон ургамлаар хооллох ба өвөл цас их орох үед цармаас бууж хушин тайгын дээд хэсэг, торлог, давжаа хус, хуштай орчинд бэлчээрлэнэ (Дуламцэрэн, 1970).

Тоо толгой, нягтшил. Тоо толгойн хувьд 1960-аад оны үед нэлээд элбэг, тархац нутаг нь харьцангуй өргөн байв. 1970 оны сүүлчээс эхлэн цаа бугын тоо толгой цөөрч, тархац нутаг багассан нь махчин амьтад болон хулгайн анчид ихээр нөлөөсөн (Базардорж нар, 1984). Судалгааны явцад цуглуулсан мэдээ, баримтуудыг нэгтгэн үзвэл, Хөвсгөл нуурын баруун хэсэгт (Бяран, Тэнгис, Жүгнэг, Шарга, Хороо орчимд) 80-100 орчим, зүүн хэсэгт (Нарийн Ханхын эх, Хэвэн, Өлгий гол, Залуу үүрийн эх орчим) 60-80 орчим, нийт 140-200 орчим бодгаль улсын хил орчмын нутгаар байршин амьдарч байна (Адьяа, 2013).

Ховордлын шалтгаан. Цагааннуур сумын Хар бяран, Жосимд цааны популяцийн тархац байршил нутагт хулгайн ан, хууль бус алт олборлолт, мод бэлтгэл, Шарга голын эх орчимд гэрийн мал зэрэг хүний сөрөг нөлөө их байна (Адьяа, 2013). Арьс, махыг нь ашиглах зорилгоор хууль бусаар агнах явдал эрс ихэссэн нь түүний популяцийн бууралтад ихээр нөлөөлж, ховордуулах гол шалтгаан болж байна. Зарим газар малын тоо толгой өссөнөөс бэлчээрийн талхагдал бий болсны уршгаар орчны доройтол нүүрлэж байна. Гэрийн тэжээвэр цаатай эрлийзжих аюул бий бөгөөд эрлийзжилт ямар түвшинд байгааг тогтоогоогүй (Адьяа, 2013) байна.

Хамгаалсан байдал. Манай оронд 1953 оноос цаа буга агнахыг хуулиар хориглож (Шийрэвдамба нар, 2013), улмаар Амьтны тухай хуульд нэн ховор амьтнаар оруулсан бөгөөд (7.2) төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр зөвхөн эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх зориулалтаар агнаж, барьж болно. Үүнээс бусад (7.3) зориулалтаар нэн ховор амьтныг агнаж бэлтгэсэн арьс, яс, бусад түүхий эдийг худалдах, худалдан авахыг хориглосон. Мөн (7.4) нэн ховор амьтны амьдрах нутагт хүнд үйлдвэр, цахилгаан станц, химийн үйлдвэр байгуулах, авто болон төмөр зам тавих, уул уурхайн олборлолт явуулах, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх асуудлыг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлтийг үндэслэн Засгийн газар шийдвэрлэдэг.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр цаа буга 19,600,000 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу).

Монгол Улсын Улаан номд нэн ховор зүйлээр бүртгэгдсэн (Шийрэвдамба нар, 1997; 2016). Энэ зүйлийн тархац нутгийн ихэнх хэсэг нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд (Улаан тайгын дархан цаазат газар, Тэнгис-Шишгэдийн голын ай сав болон Хөвсгөлийн байгалийн цогцолборт газруудад) хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ

- Энэ зүйлийн ангилал зүй (3.1), популяцийн хэмжээ, төлөв байдал, хандлага (3.2), биологи, экологи (3.3), учирч болзошгүй эрсдэл, аюул занал (3.5), генетикийн талаар урт хугацааны тогтвортой тусгайлсан судалгааг хийж, үүний үндсэн дээр хамгаалах арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх нь зохистой. Мөн зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2) арга хэмжээг зохион байгуулах нь зүйтэй.
- Экосистемийн түлхүүр зүйл болохын хувьд цаа бугын популяцийн тогтвортой байх баталгааг хангасан орон зай буюу амьдрах орчныг хамгаалах нь тайгын бүсийн өвөрмөц ландшафт, түүний ургамал, амьтны аймгийн үл давтагдах тогтолцоог цогцоор нь хамгаалах учир хууль тогтоомжийн хэрэгжилт, хяналтыг сайжруулж, хамгааллын менежментийг цогцоор нь төлөвлөж, хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй.

2.11. ХАНДГАЙ
Alces alces (Linnaeus, 1758)

Баг: Туруутан (Artiodactyla)
Овог: Буга (Cervidae)
Англи нэр: Moose
Ижил нэр: *A. americanus, A. columbae, A. pfizenmayeri, A. a. pfizenmayeri* (Geist, 1998); Elk, Eurasian Elk (Wilson and Reeder, 2005).





Ангилал зүйн тойм. Хандгай нь эволюцийн хувьд харьцангуй залуу зүйл бөгөөд түүний өвөг болох *Alces* төрлийн анхны чулуужсан ул мөр ойролцоогоор 2 сая жилийн өмнө (Thouveny and Bonifay, 1984), орчин үеийн хандгайн чулуужсан үлдэгдэл 100,000 жилийн өмнөөс тэмдэглэгдсэн (Lister, 1993). Өнөөгийн байдлаар дэлхий дээр хандгайн төрөлд багтах 8 салбар зүйл байгаагаас 4 нь Евразид, 4 нь Хойд Америкт тархсан (Peterson, 1955) ч энэ ангилал нь өнөөг хүртэл маргаантай хэвээр. Geist (1987a; 1998) нь морфологийн шинжид тулгуурлан Европын болон Америкийн 2 үндсэн хэлбэр байна гэж дүгнэн Зүүн Азийн *A. a. burturlini*, *A. a. Pfizenmayeri* салбар зүйлүүдийг Америкийн хэлбэрт багтана гэж дүгнэжээ. Түүнчлэн, Geist (1998) нь Европын хандгайг *A. a. alces*, харин Зүүн Азийн ба Хойд Америкийн хандгайг *A. a. americana* гэж нэрлэх нь зүйтэй гэсэн бөгөөд Хятад, Монгол болон Оросын зүүн өмнөд хэсэгт тархсан *A. a.*

cameloides салбар зүйлийг бүс нутгийн эхэн үеийн фауны нэгэн төлөөлөгч хэмээн үнэлж, тусдаа салбар зүйл гэж хүлээн зөвшөөрсөн ч Америк төрлийн хандгайд багтана гэжээ (Geist 1998).

Монгол оронд газар зүйн тархалтын хувьд алслагдсан, мөн бие болон эврийн хэмжээ, хэлбэрээрээ ялгаатай Шивэр хандгай (*Alces alces pfizenmayeri* Zukowski,1910), Дорнын хандгай (*Alces alces cameloides* Milne-Edwards, 1867) гэх хоёр салбар зүйл амьдардаг.

Таних шинж. Шивэр хандгайн бие харьцангуй богино, том, лагс. Мөчид болон чих урт, сүүл богино. Дээд уруул доод уруулаа бүрхэж унжина. Хоолойдоо арьсан унжлага буюу сүүхтэй. Мэнжийн сүүх сүндэснийхээс том. Мэнж олон салаалсан том эвэртэй. Эврийн уг богино, бүдүүн, дундаа хавтгай, зөвхөн дээд захаараа олон салаатай. Зүс жигд хар халтар бараан, хөл, хоншоор цайвар (Гептнер нар, 1961; Банников, 1954; Соколов нар, 1983; Дуламцэрэн, 1989). Биеийн урт 300 см, сэрвээний өндөр 240 см, жин 570 кг хүрнэ (Гептнер нар, 1961). Шивэр хандгайн толгойн яс бусад хэлбэрээсээ том (Батсайхан нар, 2010).

Харин Дорнын хандгайн бие бахим, мөч урт. Биеэр шивэр хандгайнаас арай жижиг. Ерөнхий зүс жигд бараан, мөчид арай цайвар. Өнгө зүс нь нас, улирлаар өөрчлөгдөнө. Эр, эм хоёул бугынх шиг эвэртэй ч салаа нь хоорондоо нийлсэн. Эвэр жижиг, хөнгөн, дунд хэсэгтээ хавтгай далбан байхгүй. Энэ хэсгээр эврийн хөндлөн огтлол бугынхтай адил дугариг (Чимэддорж нар, 2017). Биеийн урт 276 см, сэрвээний өндөр 195 см, жин 400 кг хүрнэ (Гептнер нар 1961).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Устаж болзошгүй (EN), A2cd; A3d (Clark *et al.,* 2006). **2025 онд Устаж болзошгүй (EN) A1; C1.** Хангай, Хэнтийд 1989 онд 10,000 гэж тоологдсон ба энэ нь популяцийн 70% юм. Nowak (1991) энэ зүйлийн үе удмын хугацааг 9 жил гэж тогтоосон. Орчны хомсдол, бохирдол, хараа хяналтгүй агнуураас шалтгаалан өмнөх гурван үе удмын туршид популяци 50% буурсан гэж үзээд энэ зүйлийг A2cd шалгууруар үнэлэн Устаж болзошгүй гэсэн зэрэглэлд 2006 онд оруулжээ. Монгол орны хувьд хандгайн үндсэн байршил нутагт тооцогдох Хан Хэнтий, Зэд Хантайн нуруунд 2019 онд хийсэн тархац популяцийн үнэлгээнээс үзвэл популяцийн тоон хэмжээ нийт тархац нутгийнхаа 70%-д дундажаар 1,524 бодгаль буюу 1989 оны тоо толгойн үнэлгээтэй харьцуулахад популяцийн хэмжээ 4 үеийн хугацаанд барагцаагаар 78%-аар буурсан, нийт популяцийн хэмжээ үржлийн насны 2,500 бодгалиас бага байх бүрэн боломжтой тул 2006 оны үнэлгээг хэвээр үлдээв.

Үнэлгээ хийсэн: Г.Наранбаатар, Д.Энхбилэг, С.Пүрэвсүрэн (2025).

Үнэлгээг хянасан: Ян.Адъяа (2025).

Дэлхийн тархац. Канад, Америк, Норвег, Чех, Словени, Хорват, Швед, Польш, Унгар, Словак, Финланд, Румын, Латви, Литва, Эстони, Украйн, Беларусь, Орос, Казахстан, Хятад, Монголд тархсан (Hundertmark *et al.,* 2002).

Монгол орны тархац, амьдрах орчин. Шивэр хандгай Хэнтийн уулархаг нутгийн Онон, Хэрлэн, Туул, Хараа, Ерөө, Минж голын тайга, Хөвсгөл орчимд Улаан тайга, Хорьдолын нуруу, Үүр голын сав, Умард Хангайд Бүтээлийн нуруу, Бүрэнгийн нурууны зүүн хэсэгт тархана (Банников, 1954; Дуламцэрэн, 1970; Намнандорж, 1976; Соколов нар, 1983; Базардорж нар, 1984; Шагдарсүрэн нар, 1987). Ой, тайгын амьтан (Батсайхан нар, 2010). Гол, горхины хөндий, ам татмын чийгтэй бургас, сөөгөн хус торлогон шугуйт намгархаг нуга, уулын хажуугийн торлог ихтэй үргэлжилсэн ойд нутаглана. Гол, горхи, нуур усны ойролцоо байх дуртай. Өвөл, зуны байршил нутаг бараг адилхан. Хэнтийн нуруунд өвөл 2000 м өндөр уулсын ойн дээд зах хүртэл бэлчиж, зун заримдаа уулын тагд үзэгддэг (Банников, 1954; Дуламцэрэн, 1970; 1989; Намнандорж, 1976; Базардорж нар, 1984).

Дорнын хандгай нь Монгол орны Халх гол,

түүний цутгал Дэгээ, Нөмрөг голын савд тархсан. Хүйтэн, сэрүүний улиралд баруун тийш Гүү азаргын манхан, Авдрантын булаг хүртэл үзэгдэнэ. Зун татмын бургас, монос, өрөл зэрэг бутан шугуй бүхий өтгөн өндөр өвс, зэгстэй намаг нугад идээшилнэ. Өвөл нарсан төгөл, мод сөөгт элсэн довцог, хоолойн зэгс, шугуйд нутаглана (Гептнер нар, 1961; Шагдарсүрэн нар, 1974; Шийрэвдамба нар, 2013).



Амьдралын онцлог. Шивэр хандгай ороо нийлэгт 9-р сард орж, 5-р сарын сүүлч 6-р сарын эхээр сүндэс 1-2 ходол төрүүлнэ. Голдуу ганц хоёроороо тааралдана. Хаяа бүлээрээ 6 хүртэл толгойгоор сүрэглэнэ (Банников, 1954; Дуламцэрэн, 1989). Бие гүйцсэн манж ганцаар явна. Зун төрөл бүрийн ургамал, өлөн, хөвд, найлзуураар идээшилнэ. Өвөл бут сөөгийн нахиа найлзуур, мөчир, хөвд зонхилон иднэ. Зун намар мараа долооно. Өглөө, үдэш, шөнө идэвхтэй (Банников, 1954; Намнандорж, 1976; Базардорж нар, 1984).

Дорнын хандгай ороо нийлэгт 9-р сарын сүүлээр орж, 5-р сарын сүүлчээр 1-2 ходол төрүүлнэ. Орооны үед мэнж 1-2 сүндэс дагана. Ороонооос бусад үед мэнж ганцаар явна. Сүндэс, ходол, залуу эр, эм бодгаль бүхий 6 хүртэл тоогоор сүрэглэх нь бий. Улирлаар нутаг бэлчээрээ ойр зуур сэлгэнэ. Зун мараанд ирнэ (Лхагвасүрэн, 2016).

Бэлэг 2-3 насанд боловсорч үржилд орох ба 15-17 нас хүртлээ үржлийн идэвхтэй. Байгальд 20 орчим насална (Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Хэнтий, Хангайн уулархаг нутгийн шивэр хандгайн тархац нутгийг 1980-аад оны эхээр тоймлон 1,000 га ноогдох тоо толгой Хэнтийн Минж голын савд 1-2, Захар, Хэрлэнгийн эхэнд 3-5, Ерөөгийн эх Шарланд 3-4, Хангайн Бүрэнгийн нурууны зүүн хэсэгт, Ононы эх Тарс орчимд 10 км-т тус бүр нэг тохиолдож, бүх тархац нутагтаа 10,000 гаруй толгой байсны 70% Хэнтий, Хангайн уулархаг нутагт тохиолдож (Соколов и др., 1982; Дуламцэрэн нар, 1977, 1989; Шийрэвдамба нар, 1997) байжээ.

Хан Хэнтийн дархан цаазат газрын баруун хэсэгт 5,921.7 км^2 нутагт 1,000 га тутамд 0.2 бодгаль ноогдох нягтшилтай 122±6 бодгаль байгааг тогтоожээ (Биологийн хүрээлэн, 2008). Мөн 2010 онд хийсэн судалгаагаар, Хан Хэнтийн дархан цаазат газарт 1,000 га-д 0.5 бодгаль ноогдох нягтшилтайгаар 9,813 км нутагт 518 (95% CI=175-803) шивэр хандгайтай хэмээн үнэлэгджээ. Тухайн үед Зэд-Хантай-Бүтээлийн нуруу нь улсын тусгай хамгаалалтад хамрагдаагүй байсан бөгөөд өнөөгийн дархан цаазат газрын нутаг дэвсгэр болох Хантай болон Бүтээлийн нурууны 4,392 км^2 нутагт 1,000 га-д 1.0 толгой ноогдох нягтшилтайгаар 496 (95% CI=141-1560) шивэр хандгайтай (Биологийн хүрээлэн, 2010) хэмээн үнэлжээ. Улмаар 2019 онд хийсэн судалгаагаар, Хан Хэнтийн дархан цаазат газрын 13,768.61 км^2 нутагт 1,000 га-д дунджаар 0.6 бодгаль ноогдох нягтшилтайгаар 826 (95% CI=440-1734) шивэр хандгай, Зэд-Хантай-Бүтээлийн нурууны дархан цаазат газрын 5,237.88 км^2 нутагт 1,000 га-д 1.1 бодгаль ноогдох нягтшилтайгаар 620 (95% CI=357-1,033) шивэр хандгай, мөн Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын 95.97 км^2 нутагт дунджаар 1,000 га-д 0.8 (95% CI=0.2-3.4) бодгаль ноогдох нягтшилтайгаар 78 (95% CI=19-333) шивэр хандгай байгааг тус тус тогтоожээ.

Харин Дорнын хандгай манай оронд 1970-аад онд Нөмрөг гол, Соёлз уул хавьд 1000 га-д 3-4 тоо толгой тэмдэглэгдэж байсан бол 1990-ээд оны эхээр нийт тархац нутагтаа 70-80 толгой орчим байжээ (Шагдарсүрэн нар, 1974; Цэвээнмядаг, Мөнхсайхан, 1993). 2004 онд Нөмрөгийн дархан цаазат газарт 73 бодгаль тэмдэглэгдсэн (Clark *et al.,* 2006).

Дорнын хандгай байршил нутаг, тэжээлээр халиун буга, бор гөрөөс, зэрлэг гахайтай давхацна.

Ховордлын шалтгаан. Дэлхийн дулаарал (6.1.1), уул уурхай (1.3.1), дэд бүтцээс (1.4) хамаарсан амьдрах орчны доройтол (1), тархац нутгийн хумигдал (9.1) зэрэг хүчин зүйл, мөн ахуйн зориулалтаар (3.4.1) хэрэглэх зэргээс шалтгаалан тоо толгой нь цөөрч байна. Ой хээрийн түймэрт амьдрах орчин ихээр сүйддэг. Чоно ходол, залуу хандгайг барьж идэхээс гадна, ялангуяа цас ихтэй өвөл бие гүйцсэн амьтдыг хүртэл хорооно. Хулгайгаар агнана (Намнандорж, 1976; Шийрэвдамба нар, 1997). Устах аюулд орсон зүйл. Монгол орны хэмжээнд сүүлийн 11 (2013-2023) жилийн хугацаанд хууль бус агнуурын 12 хэрэг хууль сахиулах байгууллагуудад бүртгэгдсэн (Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар, 2024).

Хамгаалсан байдал. Монгол Улс 1953 оноос хандгай агнахыг хуулиар хориглож иржээ (Шийрэвдамба нар, 2013). Улмаар Амьтны тухай хуульд нэн ховор амьтнаар оруулсан бөгөөд төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр зөвхөн эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх зориулалтаар агнаж, барьж болно (7.2). Үүнээс бусад зориулалтаар нэн ховор амьтныг агнаж бэлтгэсэн арьс, яс, бусад түүхий эдийг худалдах, худалдан авахыг хориглосон (7.3). Мөн (7.4) нэн ховор амьтны амьдрах нутагт хүнд үйлдвэр, цахилгаан станц, химийн үйлдвэр байгуулах, авто болон төмөр зам тавих, уул уурхайн олборлолт явуулах, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх асуудлыг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлтийг үндэслэн Засгийн газар шийдвэрлэдэг.

Үүнээс гадна, (11.1.2) булаг, шанд, хужир мараанд ирж буй амьтныг отож агнах, (11.1.3) өөр нутагт шилжин байршиж байгаа агнуурын амьтныг агнах, барих, (11.1.4) амьтны үүр, ичээ ухах, гэмтээх, (11.1.7) амьтны үр төлийг агнах, шувууны өндгийг түүх, гэмтээх, устгах зэрэг олон үйл ажиллагааг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-нд хандгайн хоёр салбар зүйлийн үнэлгээг тус тусад нь тогтоосон байх ба үүнд Шивэр хандгай 19,700,000 төгрөг, харин Дорнын хандгай 21,000,000 төгрөг байна. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу).

Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ын I хавсралтад бүртгэгдсэн (Чимэддорж нар, 2018; http://checklist.cites.org). Мөн Монгол Улсын Улаан номын бүх хэвлэлд Шивэр хандгай, Дорнын хандгай гэх хоёр салбар зүйлийг тус тусад нь нэн ховор зүйлээр бүртгэн оруулжээ (Шагдарсүрэн нар, 1987; Шийрэвдамба нар, 1997; 2016).

Шивэр хандгайн тархац нутгийн ихэнх хэсэг Улаан тайга, Хорьдол Сарьдаг, Зэд-Хантай-Бүтээлийн нуруу, Хан Хэнтийн дархан цаазат газрууд болон Тэнгис-Шишгэдийн голын ай сав, Хөвсгөл, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрууд зэрэг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдсан бол Дорнын хандгайн үндсэн тархац нутаг нь бүхэлдээ Нөмрөгийн дархан цаазат газарт хамгаалагджээ. Энэ нь хандгайн хамгаалалд төдийгүй тухайн бүс нутгийн биологийн төрөл зүйлийн хамгаалал болон экосистемийн тогтвортой байдлыг хангахад чухал хувь нэмэр оруулж байна. Тухайлбал, 2019 оны судалгаагаар, Хан Хэнтийн дархан цаазат газрын хандгайн тархац нутгийн хэмжээ 21.6%-аар нэмэгдсэн бол Зэд-Хантай-Бүтээлийн нурууны хандгайн тархац нутаг 16.1%-аар, нөөцийн хэмжээ нь 20%-аар тус тус нэмэгджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн ангилал зүй, популяцийн тоо толгой, хэмжээ, хандлага (3.2), биологи, экологийн (3.3.) судалгааг нарийвчлан хийж, шинжлэх ухаанд тулгуурласан хамгаалллын арга хэмжээг тусгайлан боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай. Мөн энэ зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2) арга хэмжээг зохион байгуулах нь зүйтэй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

МОНГОЛ ОРНЫ ЭМЗЭГ (VU) БОЛОН ХОВОРДОЖ БОЛЗОШГҮЙ (NT) ХӨХТӨН АМЬТДЫН БИОЛОГИ, ЭКОЛОГИЙН ОНЦЛОГ, ХАМГААЛАЛ



3.1. АМАРЫН БАГВААХАЙ
Myotis bombinus (Thomas, 1906)

Баг: Гардалавчтан (Chiroptera)
Овог: Багваахай (Vespertilionidae)
Англи нэр: Far Eastern Myotis
Ижил нэр: *Myotis amurensis* Ognev, 1927, *Myotis nattereri bombinus, Myotis nattereri amurensis.*



Ангилал зүйн тойм. Энэ зүйлийг *Myotis nattereri* (Kuhl, 1817)-аас салгаж тусдаа бие даасан зүйл *Myotis bombinus* болгосон (Simmons, 2005; Кожурина, 2009).

Таних шинж. Монголоос барьсан бодгалийн биеийн урт 46.8-50.0 мм, шууны урт 39.9-41.4 мм, жин 4.4-7.5 г. Бусад зүйлээс сүүлний сарьсны ирмэгээр өтгөн, урт, хатуу сормууслаг үстэй байдгаараа ялгарна. Хоншоор урт, нүүрний хэсэг нүцгэн, ягаан. Далавч өргөн, сарьсны хормой хойд хөлийн хуруугаар холбогдоно. Унжир үгүй (Ариунболд, 2018; Dolch *et al.,* 2021a).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Ховордож болзошгүй (NT).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Монголд бүртгэгдээгүй байсан.

2025 онд Эмзэг (VU), B1ab(ii, iii). Монгол орны хувьд баруун болон зүүн Хэнтийд гурван цэгт тэмдэглэгдсэн. Horaček нар (2000) ховор тохиолддог зүйл гэжээ. Тархац нутгийн хэмжээ 20,000 км^2-аас ихгүй тул энэ зэрэглэлээр үнэлэв. Өмхөрсөн болон хөгшин ойг устгасан, өвөлждөг агуй нь хүний нөлөөнд өртсөний улмаас түүний тоо толгой буурсан (Fukui *et al.,* 2019b) гэж үздэг.

Үнэлгээ хийсэн: Ж.Ариунболд, Д.Мөнхнаст (2025).
Үнэлгээг хянасан: Н.Батсайхан (2025).

Дэлхийн тархац. Зүүн өмнөд Сибирь, Алс Дорнод, Зүүн хойд Хятад, Өмнөд Солонгос, Японд навчит болон холимог ойд ховор тохиолдоно (Horaček *et al.,* 2000).

Монгол орны тархац, амьдрах орчин. Хэнтийн нуруунд Балж голын сав (Ариунболд нар, 2008; Dolch *et al.,* 2021a), Хараа голын эх орчмоос (Ариунболд, 2018), Сэлэнгийн Хангайн даваа зэрэгт тэмдэглэсэн (хэвлэгдээгүй судалгааны мэдээ). Балж голын татмын нугын сибирь шинэс (*Larix sibirica*), ойн нарс (*Pinus sylvestris*), хавтага навчит хус (*Betula platyphylla*), улиангар (*Populus tremula*), улиас (*Populus sp.*), Азийн монос (*Padus asiatica*), боролж (*Betula fusca*), Дагуур тэрэлж (*Rhododendron dauricum*), бургас (*Salix sp.*) бүхий д.т.д 927 м өндөр орчинд тохиолдсон бол Хараа голын савд сибирь шинэс (*Larix sibirica*), хавтага навчит хус (*Betula platyphylla*), бургас (*Salix sp.*) бүхий д.т.д 1,052 м өндөр орчинд тэмдэглэгдсэнээс үзэхэд, сэрүүн бүсийн навчит болон шилмүүст ойд амьдарч (1.4) өвлийн улиралд агуйд (7.1) ичээлдэг байна (Ариунболд, 2018).



Амьдралын онцлог. Агуйд голдуу орогнож, цөөн тоогоор бөөгнөрөл үүсгэн, ойр зайд нүүж шилжинэ (Smith *et al.,* 2010). Монгол оронд Амарын багваахайн биологи судлагдаагүй.

Тоо толгой, нягтшил. Монгол орон дахь энэ зүйлийн популяцийн тоо толгой, нягтшилын талаарх судалгааны мэдээ, баримт хомс. Харин Хараа голын савд 2005 оноос хойш жил бүрийн хавар судалгаа хийсэн хугацаанд ердөө хоёр бодгаль баригдсан нь энэ зүйл тархац нутагтаа цөөн тоотой ховор тохиолддог болохыг харуулна.

Ховордлын шалтгаан. Манай орны ойн сангийн хэмжээ буурч, ойн түймэр, цэвэрлэгээ, хөнөөлт шавжтай химийн аргаар тэмцэж буй зэрэг нь сөрөг нөлөө үзүүлж байх боломжтой. Суурин амьдралтай бөгөөд агуйд ичээлэн амьдрах энэ зүйлд мод огтлолт (1.3.3), хортон устгал (5.1), дэлхийн дулаарал (6.1.1), агаарын хэмийн огцом өөрчлөлт (7.3), ойн түймэр (7.4), агуйн эвдрэл (7.7) зэргээс улбаатай амьдрах орчны алдагдал, мөн аялал жуулчлал (10.1) зэрэг нь сөрөг нөлөө үзүүлж байж болзошгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Амарын багваахай 4,500 төгрөг.

Энэ зүйлийн тархац нутгийн 10% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд (тухайлбал, Хан Хэнтийн дархан цаазат газар, Онон-Балжийн байгалийн цогцолборт газар г.м) хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ.

- Үндэсний түвшинд бодлогод чиглэсэн зүйлийг хамгаалах эрх зүйн баримт бичгийг боловсруулах (1.2.2.2) шаардлагатай.
- Шинжлэх ухаанд тулгуурласан хамгаалллын арга хэмжээ авахад түүний популяцийн хэмжээ, төлөв байдал, хандлага (3.2), биологи, экологи (3.3), аюул заналын (3.5) чиглэлээр мониторинг судалгааг (3.9) нарийвчлан хийх хэрэгтэй.
- Тодорхой газруудыг шинээр хамгаалалтад авах, хамгаалалд чиглэсэн үйл ажиллагаа (4.4.1) шаардлагатай.
- Зүйлд чиглэсэн өвчин, эмгэг үүсгэгч, шимэгчид (5.5), гений санг бүрдүүлэх (5.7.2) арга хэмжээг зохион байгуулах нь зүйтэй.

3.2. ХЭНТИЙН ОГДОЙ

Ochotona hoffmanni (Formozov, Yakhontov, Dmitriev, 1996)

Баг: Туулай хэлбэртэн (Lagomorpha)
Овог: Огдой (*Ochotonidae*)
Англи нэр: Hoffmann's Pika



Таних шинж. Биеийн урт 194-208 мм, тавхайн урт 30-32 мм, чихний урт 20-22 мм, биеийн жин 260-310 г. Бие бахим, төрөл дотроо том биетэйд тооцогдоно. Нуруу улаавтар бараан, хэвлий ухаа саарал, шанаа улаавтар. Сүүлгүй. Чих том дугариг, цайвар эмжээртэй. Тавхай бор үсээр хучигдсан (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Устаж болзошгүй (EN), B2ab(ii,iii,v).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Үнэлгээ хийгдээгүй.

2025 онд Эмзэг (VU), B2ac (ii, iv). Хэнтийн нурууны хээр рүү түрсэн өмнөд салбар уулсын царам хэв шинжтэй армаг тармаг мод эсвэл сөөгт асга, нураг, том хадтай орчинд амьдардаг. Энэ огдойн идээшил амьдрах орчин нь өөр хоорондоо харьцангуй зайтай, тасархайтсан алаг цоог байршилтай. Популяцийн элбэгшил, нягтшил хэлбэлздэг.

Үнэлгээ хийсэн: Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, Р.Самъяа, Э.Ундрахбаяр, С.Шар (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Монгол, Оросын Чита мужид тархсан.

Монгол орны тархац, амьдрах орчин. Өмнөд Хэнтийн салбар уулс Дэлгэрхан, Баян-Улаан, Баянхан уулсын армаг тармаг холимог ойн төгөлтэй газар тохиолдоно. Хэнтийн огдой умард сэрүүн бүсийн холимог сийрэг, ялангуяа хусан төгөлтэй (1.4) зэрэгцэн орших хад, байц, асга, нурагтай (6) элдэв сөөг, модлог ургамалтай (3.4) газар байршина (Батсайхан нар, 2022).



Амьдралын онцлог. Бүлээр амьдарна. Өдөр, бүрэнхий, үүрээр идэвхтэй. Элдэв зүйл алаг өвс, жижиг дэгнүүлт үетэн, сөөг, бутны үр, ургал болон цэцэгт хэсгээр голчлон хооллоно. Хөөе бэлтгэж, хадны завсар хураана. Үржил 5-р сарын дунд үеэс 8-р сар хүртэл үргэлжилнэ. Нялх бодгаль 6-р сарын дунд үеэс үүрний гадаа үзэгдэнэ (Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Энэ зүйл огдойн элбэгшил, нягтшил хэлбэлздэг ба тоо толгой, нягтшилын тухай баримт хомс.

Ховордлын шалтгаан. Тодорхой бус. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө (7.1, 7.3) боломжит шалтгаан байж болно.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Хэнтийн огдой 4,000 төгрөг. Энэ зүйлийн өнөөгийн мэдэгдэж буй тархац нутаг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдаагүй.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн популяцийн төлөв байдал (3.2), биологи, экологи (3.3), учирч болзошгүй эрсдэл, аюулын (3.5) талаар нарийвчилсан судалгаа хийж, үүний үндсэн дээр хамгаалах арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлагатай. Мөн Засгийн газраас тогтоосон Хэрлэн-Баян-Улаан отрын бүс нутагт буй тусгай хэрэгцээний газрыг цуцалж, тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулах нь зүйтэй (4.4.1, 4.4.3).

3.3. МОНГОЛ ТАРВАГА

Marmota sibirica (Radde, 1862)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Хэрэм (Sciuridae)
Англи нэр: Siberian or Mongolian Marmot
Ижил нэр: *M. caliginosus*, *M. dahurica* (Wilson and Reeder, 2005; Павлинов и Лисовский, 2012)



Ангилал зүйн тойм. Монголд *M. s. sibirica*, *M. s. caliginosus* гэх салбар зүйлүүд бий.

Таних шинж. Биеийн урт 65 см, тарга тэвээрэг гүйцсэн намрын үед тарваганы дундаж жин 10 кг хүрнэ (Адъяа, 2024). Төгсгөл хэсэг нь бараан 90-160 мм сүүлтэй. Зулай, дагзны хэсэг бараан, чих хулгар. Урд мөч 5, хойд мөч 4 хуруутай. Хумс нь хурц. Биеийн нуруу хэсгийн дэвсгэр зүс хул, бор шаргал, сор үсний үзүүр бараан. Шанаа цайвар. Шанаа, хоншоор, эрүү, нүдний орчим байрлах 6 хүртэл см урт мэдрүүл үс нүх, хонгилын харанхуй орчинд баримжаалахад тустай. Хараа, сонсгол, үнэрлэх эрхтэн сайн хөгжсөн.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Устаж болзошгүй (EN).
Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Устаж болзошгүй (EN) (Clark *et al.,* 2006).
2025 онд Эмзэг (VU), A2, ad. Тархац нутгийн нийт талбайн хэмжээ өргөн дэлгэр, тархац нутгийн багагүй хэсэгт тарваганы тоо толгой тогтворжиж, зарим газар өсөж буй, популяцид бага насны эзлэх хувь нэмэгдэж байгаа боловч ихэнх нутагт хууль бус агнуурын дарамт их байгаа, газрын доройтол нэмэгдэж байгааг үндэслэн Эмзэг зэрэглэлд оруулав.
Үнэлгээ хийсэн: Р.Самъяа, Н.Батсайхан, С.Шар, Д.Лхагвасүрэн, Э.Ундрахбаяр (2025).
Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Хятадын зүүн хойд хэсгийн хээр (Smith and Yan, 2013), Оросын Тува, Буриадын өмнөд захын уулын хээр, хээр (Павлинов и Лисовский, 2012) болон Монголд тархсан (Адъяа, 2024).

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол Алтай, Говь Алтайн баруун хэсэг, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутаг, төв болон зүүн хагасын тал хээрийн бүсээр тархана (Адъяа, 2000). Монгол тарвага тал газар, нам уулс, толгод, ухаа гүвээрхэг гадаргатай

хээр (4.4), ойт хээр (3.4), уулын хээр, өндөр уулын энгэр бэл, таг, жалга судаг дагаж үетэн, бушилз, алаг өвст орчинд байршина.



Амьдралын онцлог. Бүл, нутаг бүл үүсгэнэ. Өдрийн идэвхтэй. Өвөл ичнэ. Ичээ намар 9-р сарын сүүлээс дараа жилийн 3-р сарын сүүлч хүртэл 6 сар үргэлжилнэ. Тарвага амьдралынхаа нийт хугацааны 87%-ийг нүхэндээ өнгөрүүлнэ. Олон зүйл үетэн, цэцэгт ургамлын боловсроогүй үр, навч, нахиа, цэцэг зэрэг хурдан боловсрох шүүслэг, шимт хэсгээр хооллоно. Хэрэгцээт усаа ургамлаар дамжуулан авна. Ичээнээс гарсны дараа ороо нийллэг 2 орчим долоо хоног үргэлжилнэ. Тарч 35 хоног хээлээ тээж, дунджаар 5-7 мөндөл төрүүлнэ. Мөндөл нүцгэн төрөх ба 7 хоногийн настайд үсэн бүрхүүлтэй болж, 14-15 хоногтоо нүдээ нээж, 20-25 хоногтойдоо өвсөн тэжээлд орно. Хөхүүл үе 35 хоног үргэлжилнэ. Тарвага 2-3 насандаа үржилд орно. Байгалийн нөхцөлд 10 орчим жил, амьтны хүрээлэнд 16 хүртэл жил насална (Адъяа, 2024).

Тоо толгой, нягтшил. Монгол орны хэмжээнд сүүлийн жилүүдэд хийсэн тарваганы нөөцийн нэгдсэн судалгаа ховор. Хамгийн сүүлд 2010 онд иргэдийн оролцоотой хийсэн тарваганы үнэлгээгээр, манай орны хэмжээнд 135,698.39 км^2 талбайд тарвага тархсан бөгөөд үүнийг 1990 онтой харьцуулахад 52.8% багассан үзүүлэлт юм (Тодгэрэл, Жавзмаа, 2010). Тарваган тахлын голомт бүхий 13 аймгийн 127 сумаас авсан мэдээгээр, Баян-Өлгий, Ховд, Завхан аймгуудад 1 га дахь тарваганы нягтшил 2-3 буюу хамгийн өндөр, бусад аймгийн нутагт 0.5-1.8 буюу бага, дунд нягтшилтай байна (Байгальмаа нар, 2018). Тарвага хамгийн элбэг Хэнтий аймгийн тарваганы нягтшил Ж.Батболд (2000) нарын судалгаагаар, 1990 онд судалгаанд хамрагдсан сумдын 1 км^2 талбайд 70.5 бодгаль ноогдох нягтшилтай байсан бол 2010 онд 35.61 бодгаль ноогдох нягтшилтай болж өмнөхөөсөө 49%-аар буурчээ (Тодгэрэл, Жавзмаа, 2010). ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн хийсэн судалгаагаар (2024), Говь Алтай аймгийн Дарвийн нуруунд 1 км^2 талбайд 26 бодгаль, Увс аймгийн Хархираа, Түргэн, Цагаан Шувуутын нуруунд тарваганы тархац нутгийн хэмжээ 31.2%-аар, нөөц 10.4%-аар тус тус нэмэгдэж 3,314.20 км^2 талбайд 69,970±3,498 тарвага идээшиж байгааг тогтоожээ.

Ховордлын шалтгаан. Тарваганы тоо толгой огцом буурсан нь зүй бус агналт (3.1.1, 3.1.3), хэд хэдэн жил дараалсан гантай жилүүдэд тарга тэвээрэг гүйцэт авч чадалгүй ичээндээ эндсэн (7.1) зэрэг байгалийн болон хүний хүчин зүйлийн хам үйлдэлтэй холбоотой (Адъяа, 2024).

Тоо мэдээлэл цэгцтэй байсан 1940-1990 онд жилд хамгийн багадаа (1985) 763,300 ш, хамгийн ихдээ (1948) 2,550,616 ш тарваганы арьс улсын бэлтгэлд тушааж байжээ. Үүний цаана арьсыг нь ахуйн зориулалтаар ашигласан тарваганы тоо нэмэгдэнэ. Зах зээлийн харилцаанд шилжсэн үеэс тарвага агналтын албан ёсны нэгдсэн мэдээ тасарсан бөгөөд гаалийн бүрэн бус мэдээгээр, 1995-2002 онд тарваганы элдсэн арьс 909,680 ш экспортолжээ (Адъяа, 2024).Зэлүүд тал-2 судалгааны тайланд худалдаачдын дунд тарваганы арьс авах эрэлт хэрэгцээ их хэвээр байгаа, тарвага ховордсоноос эрэлт буюу үнэ өссөн (Wingard *et al.,* 2017) хэмээн дүгнэсэн байна. Баруун аймгуудын зарим бүс нутгуудад хийсэн судалгаагаар жишээ нь, Дарвийн нуруу, Хасагт Хайрханы нуруу орчимд элбэг тархацтай нутгийн хэмжээ буурч байгаа нь хууль бус агнуур буурахгүй байгаатай холбоотой. Монгол орны хэмжээнд сүүлийн 11 (2013-2023) жилийн хугацаанд хууль бус агнуурын 35 хэрэг хууль сахиулах байгууллагуудад бүртгэгдсэн (Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар, 2024) боловч дээрх тоо бодит байдал дээр харьцангуй их байх магадлал өндөр.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, өсгөн үржүүлэх, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд тухайлбал, энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3-д зааснаар тарвагыг жил бүрийн 10 дугаар сарын 16-ны өдрөөс дараа оны 8 дугаар сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон. Үүнээс гадна, (10.1.4) тарвагыг нүхэнд нь утах, ус цутгах, хавх, урхи тавих, нохойгоор зориудаар бариулах, (10.1.5) амьтныг агаарын болон авто тээврийн хэрэгслээр хөөх, гэрэлтүүлэх, (10.1.8) ан агнах зориулалтын бус буу, сум хэрэглэх зэрэг арга, зэвсэг хэрэгслээр агнах, барихыг хориглож, мөн (11.1.3) өөр нутагт шилжин байршиж байгаа агнуурын амьтныг агнах, барих, (11.1.4) амьтны үүр, ичээ ухах, гэмтээх, (11.1.7) агнуурын амьтны үр төлийг агнах, шувууны өндгийг түүх, гэмтээх, устгах, (11.1.8) ангийн бус, агнуурын амьтан агнах, барих гэрээ, зөвшөөрөл, эрхийн бичгийг бусдад шилжүүлэх, (11.1.9) тарвага, зурам, тэдгээрийн түүхий мах, нойтон болон халдваргүйжүүлээгүй арьсыг хот, тосгонд оруулах, (11.1.10) хот, тосгоны ногоон бүсэд судалгаа шинжилгээ, халдварт өвчний голомт эрүүлжүүлэх, ан амьтны тоо толгойг зохицуулахаас бусад зорилгоор агнуурын амьтан агнах, барих, (11.1.12) эрх бүхий мэргэжлийн байгууллагаар агнуур зохион байгуулалтын ажлыг хуульд заасан хугацаанд нь хийлгээгүй аймаг, сум, нийслэл, дүүргийн нутагт агнуурын амьтан агнах, барих зэрэг үйл ажиллагааг хориглосон байдаг.

Мөн түүнчлэн энэ хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д зааснаар (25.3) ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тухайн сум дахь байгаль хамгаалагч гарал үүслийн тодорхойлолт олгох бөгөөд энэ тодорхойлолт аваагүй амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах, худалдан авахыг хоригложээ.

Иргэн ахуйн зориулалтаар гурав хүртэл хонгийн хугацаатай (28.3.1), таван ширхгээс илүүгүй (28.4) тарвага агнах нэг удаагийн эрхийн бичиг авах боломжтой. Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Монгол тарвага 410,000 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Дашрамд дурдахад, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар 2017 оноос хойш тарвагыг ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар агнахыг түр хугацаагаар удаа дараа хориглож ирсэн боловч тус сайдын 2023 оны А/453 дугаар тушаалаар хүчингүй болгосон.

Энэ зүйлийн тархац нутгийн 13% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ

- Орон даяар тарвага агнахыг хориглосон боловч тарваганы хууль бус агналт бүрмөсөн зогсоогүй. Энэ нь монголчуудын дунд уламжлагдаж ирсэн ахуйн соёлтой уялдан тарваганы махны эрэлт хэрэгцээ буурахгүй байгаатай холбоотой. Монгол орны тарваганы популяцийн өсөлтийн хандлагыг тогтоосон судалгаа хомс байгаа учир тархац, тоо толгойн нэгдсэн судалгаа хийх (3.2), түүний үр дүнг үндэслэн ахуйн зориулалтаар тарвага агнах эрх зүйн орчныг (1.2.1.2) боловсронгуй болгох, хуулийн тогтоомжийн хэрэгжилтийг хангах арга хэмжээг (1.2.2.2) орон нутагт зохион байгуулах шаардлагатай.
- Сүүлийн жилүүдэд тарвага сэргээн нутагшуулах (5.1) ажил орон даяар өрнөж байна. Тарваганы тоо толгой тогтвортой байгаа бүс нутагт тарвага агнах агнуурын бүс нутгийг тогтоож, орон нутгийн иргэд түүнийхээ ашиглалт, хамгааллыг хариуцан ажиллах зохицуулалтад шилжвэл тарвага хариуцах эзэнтэй болж, боломжтой нөөцийг урт хугацаанд тогтвортой ашиглах боломж бүрдэнэ (5.3.1).
- Агналтыг зохистой тоо хэмжээнд зөв аргаар гүйцэтгэх нөхцөлд байгалийн голомтот өвчний тархалтыг хязгаарлахаас гадна, орон нутгийн иргэдийн орлого нэмэгдэнэ.

3.4. ОЙН УНТААХАЙ

Dryomys nitedula (Pallas, 1778)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Унтаахай (Gliridae)
Англи нэр: Forest Dormouse
Ижил нэр: Ойч унтаахай (Дуламцэрэн, 2003); *D. obolenskii*, *D. ognevi*, *D. pallidus* (Wilson and Reeder, 2005).



Ангилал зүйн тойм. Монгол орны Булган голын сав дагуу тархсан зүйлийг *Dryomis nitedula angelus* гэх салбар зүйл гэж үзсэн (Stubbe *et al.,* 2012).

Таних шинж. Биеийн урт 8-12 см, сүүл 7-11 см, жин 60 г хүрнэ. Нуруу амьдарч байгаа орчноосоо хамаарч үнсэн саарлаас бараан хүрэн хүртэл хувьсана. Хэвлий цайвар, шаргалдуу туяатай цайвар. Нүд дайрсан хар зураас чихэнд хүрнэ. Сүүл сахлаг, бүдэг саарал. Нүд бүлтгэр (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл
Олон улсын үнэлгээ: Ховордож болзошгүй (NT).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Clark *et al.,* 2006).
2025 онд Эмзэг (VU), D2. Энэ зүйл зөвхөн Булган голын сав дагуу тархсан бөгөөд тархац нутаг нэн хязгаарлагдмал. Зүйлийн байршдаг бургасан шугуй нь малын бэлчээрлэлт, боомтуудыг холбосон засмал зам, гүүрэн байгууламж зэрэг хүний нөлөөллөөс гадна, хаврын цасны үер гэх мэт байгалийн хүчин зүйлсээс шалтгаалан тоо толгойн буурах хандлагатай байгааг үндэслэн Эмзэг зэрэглэлээр үнэлэв.
Үнэлгээ хийсэн: Э.Ундрахбаяр, Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, С.Шар, Р.Самъяа (2025).
Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Австри, Азербайжан, Албани, Афганистан, Беларусь, Болгар, Босни Херцеговин, Герман, Грек, Гүрж, Израил, Иран, Ирак, Итали, Казахстан, Киргизстан, Латви, Лихтенштайн, Македон, Молдова, Монтенегро, Орос, Пакистан, Польш, Румын, Серби, Сири, Словак, Тажикстан, Турк, Туркменистан, Украйн, Унгар, Хорват, Хятад, Чех, Швейцар болон Монголд тархсан (Kryštufek *et al.,* 2016)

Монгол орны тархац, амьдрах орчин. Дэлхийн тархцын зүүн хязгаар болох Зүүнгарын говийн умард хэсэг Булган голын савд бутлаг ургамал зонхилсон намгархаг газар (5.3) болон байнгын урсгалтай гол мөрний сав дагуу тусгаарлагдсан популяци оршино (Clark et *al.,* 2006; Stubbe *et al.,* 2012). Голын хөндийн улиангар, улиас, бургасан шугуй, навчит ой, сөөг, төгөлд тохиолдоно.



Амьдралын онцлог. Шөнийн идэвхтэй. Мод, бургасны хонгил, мөчир дээр 4 орчим метрийн өндөрт үүр засах ба зарим тохиолдолд шувууны үүр ашиглана (Stubbe *et al.,* 2012). Өвөл ичнэ. Шавж, түүний авгалдай, шөнийн эрвээхэй, ургамлын үр жимс, нахиагаар хооллоно. Үржлийн үе 5-8-р сард тохионо. Хээл тээх хугацаа 23-25 хоног. Жилд 1-3 удаа нэг удаад 2-8 гөлчгий гаргана.

Тоо толгой, нягтшил. Дэлхийд өргөн тархацтай боловч Монгол орны хэмжээнд ховор тохиолдоно. Жил жилээр тоо толгойн ихээхэн хэлбэлзэнэ. Тухайлбал, 1973 онд цөөн байснаа 1974, 1975 онд нэлээд элбэг болж, 1984, 1985 оны зуны үерийн дараа ихээхэн ховордсон байв (Дорж, 1981; Штуббе нар, 1986). Элбэгшсэн үедээ Булган голын татмын 1 га талбайд дунджаар 20±5 бодгаль тохиолддог (Stubbe *et al.,* 2012) гэжээ.

Ховордлын шалтгаан. Хавар, зуны үржлийн үетэй уулын цасны үер давхцаж, голын татам усанд автсанаас хорогдоно (Дорж, 1981; Штуббе нар, 1986). Голын бургасан шугуйг ихээр огтолж хэрэглэснээс орчны хомсдол бий болох, хүн амын суурьшил (1.4.2) нэмэгдэхийн хэрээр малын тоо толгойн нөлөө (1.1.4) ихсэж, мөн улс хоорондын боомтуудыг холбосон авто зам, гүүр, далан (1.4.6) баригдаж тээвэр, хүн амын хөдөлгөөн эрс нэмэгдсэн (10.4) зэрэг нь энэ зүйлд сөргөөр нөлөөлж болзошгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, өсгөн үржүүлэх, хамгаалах харилцааг зохицуулсан. Уг хуульд нэн ховор амьтнаар орсон бөгөөд төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр зөвхөн эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх зориулалтаар агнаж, барьж болно (7.2). Үүнээс бусад зориулалтаар нэн ховор амьтныг агнаж бэлтгэсэн арьс, яс, бусад түүхий эдийг худалдах, худалдан авахыг хориглосон (7.3). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр ойн унтаахай 8,000 төгрөг ба хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг. Монгол Улсын Улаан номд нэн ховор бөгөөд устах аюулд орсон зүйлээр бүртгэгдсэн (Шийрэвдамба нар, 2013). Тархац нутгийн ихэнх хэсэг улсын тусгай хамгаалалттай газар (Булган гол-Их Онгогийн байгалийн цогцолборт газар г.м)-т хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн тархац нутаг, амьдрах орчин (3.4) популяцийн хэмжээ, төлөв байдал, хандлага (3.2), биологи, экологи (3.3), учирч болзошгүй эрсдэл, аюул заналын (3.5) талаар нарийвчилсан судалгааг хийж, үүний үндсэн дээр хамгаалах арга хэмжээг тусгайлан боловсруулж, хэрэгжүүлэх нь нэн чухал. Ялангуяа Булган голын дагуух бургасан шугуйг огтолж хэрэглэх, талхлагдахаас урьдчилан сэргийлж, хамгаалах, улмаар түүний амьдрах орчныг нөхөн сэргээх, хэвийн өсөж үржих нөхцөлийг бүрдүүлэх, гений санг хадгалах арга хэмжээг авах шаардлагатай.

3.5. ЭРЭЭН ХҮРНЭ

Vormela peregusna (Gueldenstaedt, 1770)

Баг: Мах идэштэн (Carnivora)
Овог: Суусар (Mustelidae)
Англи нэр: Marbled Polecat
Ижил нэр: *V. euxina, V. negans, V. ornata.*



Ангилал зүйн тойм. Ангилал зүйн судалгаа нь зөвхөн арьсан дээж дээр үндэслэгдсэн тул нарийвчилсан дүгнэлт гаргахад хангалтгүй (Abramov *et al.,* 2016).

Таних шинж. Биеийн урт 27-25 см, сүүлний урт нийт биеийн уртын хагастай тэнцэнэ. Биеийн жин 370-715 г. Зүс өвөрмөц. Биеийн нуруу, хажуу хэсгийн хар, хар хүрэн дэвсгэр дээр том, жижиг шар, цайвар толботой. Хошуу, хоншоор болон хэвлий хар бараан. Чихний ирмэг цайвар. Өтгөн сахлаг сүүлтэй (Батсайхан нар, 2022). Хүзүү халтар бараан. Хоолойноос завж нүдийг дайрсан өргөн бараан зурвастай. Чихалзуур нүд, чихний завсраар шургасан тууш, тод цагаан зурвас бий. Уруул, эрүү, чихний урд тал цагаан. Сүүлэндээ 4-5 цагариг хар судалтай бөгөөд үзүүр нь бараан. Ерөнхий зүс эрээн. Мөчид богинохон (Адъяа, 2024).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Эмзэг (VU).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Clark *et al.,* 2006).

2025 онд Эмзэг (VU), A2c. Энэ зэрэглэлээр үнэлэхэд сүүлийн 10 жилийн хугацаанд амьдрах орчны хомсдолоос үүдсэн популяцийн бууралттай холбоотой. Дэлхийн тархцын хүрээндээ амьдрах орчин их хэмжээгээр алдагдсан тул сүүлийн арван жилд популяцийн хэмжээ дор хаяж 30%-аар буурсан гэж дүгнэх үндэслэлтэй. Ийм бууралт ирээдүйд үргэлжлэх магадлалтай гэж уур амьсгалын өөрчлөлтийн загварчлал болон газар ашиглалтын өөрчлөлтүүдээс харж болно. Гэсэн хэдий ч энэ бууралтын хурд яг ижил хэмжээгээр үргэлжлэх эсэхийг урьдчилан таамаглахад хүндрэлтэй (Abramov *et al.,* 2016). Монгол орны хувьд хоорондоо алслагдаж тасархай 10

гаруйхан цэгт тохиолдлоор тэмдэглэгдсэн (Дуламцэрэн нар, 2008). Уул уурхай, бэлчээрийн талхагдал, цөлжилт, ган зэрэг хүчин зүйлийн нөлөөгөөр устаж болзошгүй зүйл юм (Шийрэвдамба нар, 2013).
Үнэлгээ хийсэн: Г.Довчиндорж (2025).
Үнэлгээг хянасан: Б.Мөнхцог, С.Гомбобаатар (2025).

Дэлхийн тархац. Грек, Болгар, Румын, Македон (хуучнаар Югославын бүрэлдэхүүнд байсан), Серби, Монтенегро, Армени, Гүрж, Азербайжан, Турк, Сири, Ливан, Израил, Египет, Ирак, Афганистан, Пакистан, Казахстан, Узбекистан, Туркменистан, Украин, Орос, Хятад болон Монголд тархсан (Дуламцэрэн нар, 2008; Abramov *et al.,* 2016).

Монгол орны тархац, амьдрах орчин. Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, Говийн бүсээр тархсан (Батсайхан нар, 2022). Заг, хармаг, сухай бүхий дов сондуулт хотгор, харгана, хялганат элсэрхэг хээр, заримдаа уулын бэлийн хадтай толгод, сайр, сархиа, задгай ус, баянбүрдийн ойролцоо элдэв мэрэгч, ялангуяа чичүүл, огдойн үлий элбэгтэй газар амьдарна (Дуламцэрэн нар, 1989; Адъяа, 2024).



Амьдралын онцлог. Шөнө ба бүрэнхийн идэвхтэй. Өдөр нүхэнд орогнох ба зурам, чичүүлийн нүх ашиглана. Голдуу жижиг мэрэгчдээр, ялангуяа чичүүлээр хооллох ба гүрвэл шавж, хааяа жижиг шувуу ч иднэ (Дуламцэрэн нар, 1989; Батсайхан нар, 2022). Сэг зэмээр ч хооллоно. Жинхэнэ хээл тээх хугацаа 2 сар орчим боловч урт хугацааны далд үетэй. Нэг удаа 3-8 зулзага төрүүлнэ. Төллөх хугацаа 5-6-р сард тохионо. Аюул тохиолдсон үед үсээ сэгсийлгэж, сүүлээ өргөн, шүдээ ярзайлгаж, хурц, эвгүй үнэрээ цацна (Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Монгол орны хэмжээнд энэ зүйлийн тоо толгойн талаарх мэдээ, баримт хомс (Адъяа, 2024).

Ховордлын шалтгаан. Энэ зүйлийн тоо толгой, тархац мэрэгчдийн олон цөөнөөс шалтгаалан тогтворгүй. Тусгайлан агнадаггүй ч анчдын тавьсан хавханд орно (Clark *et al.,* 2006; Дуламцэрэн нар, 2008; Шийрэвдамба нар, 2013). Идэш тэжээлээр өмхий хүрнэ, үнэг, хярс, цагаан үентэй давхацна (Гептнер нар, 1967). Уул уурхайн үйл ажиллагаа, бэлчээрийн талхагдал, цөлжилт, ган зэрэг хүчин зүйлийн нөлөөгөөр устаж болзошгүй зүйл (Шийрэвдамба нар, 2013). Гэрийн нохой барих ба махчин шувууд ч иднэ (Дуламцэрэн нар, 2008).

Хамгаалсан байдал. Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор баталсан Ховор амьтны жагсаалтад орсон бөгөөд ховор амьтныг төрийн захиргааны төв байгууллагаас олгосон зөвшөөрлөөр (7.5.1) судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, эмчилгээний зориулалтаар агнаж, барьж болно. Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр эрээн хүрнэ 117,000 төгрөг ба хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг. Монгол Улсын Улаан номын бүх хэвлэлд ховор бөгөөд Устаж болзошгүй зүйлээр бүртгэгдсэн (Шагдарсүрэн, 1987; Шийрэвдамба нар, 1997; 2016). Тархац нутгийн 19% орчим нь улсын тусгай хамгаалалттай газарт хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн тархац нутаг, амьдрах орчин (3.4) популяцийн хэмжээ, төлөв байдал, хандлага (3.2), биологи, экологи (3.3), учирч болзошгүй эрсдэл, аюул заналын (3.5) талаар нарийвчилсан судалгааг хийж, хамгаалах арга хэмжээг тусгайлан боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай.

3.6. ОЙН БУЛГА

Martes zibellina (Linnaeus, 1758)

Баг: Мах идэштэн (Carnivora)
Овог: Суусар (Mustelidae)
Англи нэр: Sable
Ижил нэр: *M. brachyura* (Wilson and Reeder, 2005).



Таних шинж. Урт, өтгөн, сахлаг, торгомсог үсэн бүрхүүлтэй. Өнгө зүс хувьсамтгай. Элсэн шаргал, шаргалдуу бороос бараан бор, буурал сортой хар хүртэл олон янз. Толгойн өнгө их биеэс ямагт цайвардуу. Мөч богино, бахим. Хөлийн ул өвлийн улиралд өтгөн үсээр хучигдана. Өвхийдөө шаргалдуу толботой байх боловч хааяа толбо илрэхгүй байж болно. Биеийн урт 35-53 см, сүүл 11-19 см, биеийн жин 1.1-1.8 кг (Батсайхан нар, 2010).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Эмзэг (VU), A3cd (Clark *et al.,* 2006).

2025 онд Эмзэг (VU), A3cd. Энэ зүйлийн популяцийн тоо толгой, хэмжээ, хандлагын талаарх судалгааны мэдээ, баримт хомс ч 1966-1968 онд Төв Хэнтийд 1000 га-д 11.7 бодгаль ноогдох нягтшилтай байсан (Stubbe, Chotolchu, 1968) бол 1970-аад онд энэ бүс нутагт 10,000 бодгаль байгааг тогтоожээ (Хотолхүү, 1982). Мөн 2000-2003

онд Биологийн хүрээлэнгээс Хан Хэнтийн дархан цаазат газрын орчны бүсэд хийсэн судалгаагаар, 12,754 км^2 нутагт нийтдээ 795 толгой, харин 2008 онд 4406 км^2 нутагт 1,000 гаруй толгой ойн булга байна (Наранбаатар, 2016) хэмээн үнэлсэн зэргээс үзвэл, энэ зүйлийг хууль бусаар агнах явдал багасаж тоо толгойн тогтворжиж байх магадлалтай боловч ойн түймэр, самар жимс түүгчдийн сөрөг нөлөөлөл эрсдэл үүсгэж байж болзошгүй тул дээрх үнэлгээг хэвээр үлдээв. *Үнэлгээ хийсэн:* С.Пүрэвсүрэн, Б.Мөнхцог (2025).
Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Финланд, Орос, Хятад, Монгол, Хойд Солонгос болон Японд тархсан.

Монгол орны тархац, амьдрах орчин. Хэнтий, Хөвсгөл, Соён, Алтай, Булган голын эхний ой тайга, хад, аса бүхий нутагт тархсан жинхэнэ ой тайгын амьтан (Банников, 1954; Дуламцэрэн,1970; Хотолхүү, 1982; Батсайхан нар, 2010). Хэд хэдэн салбар зүйл (Хөвсгөлийн уулсын зүүн хэсгээр *M.z.sajanensis*, Хэнтийн нуруу, Монгол дагуурын хээрээр *M.z.princeps*, Монгол Алтайн нуруугаар *M.z.averini*) тархсан байх боломжтой ч энэ зүйлийн ангилал зүйн судалгаа бага хийгдсэн (Хотолхүү, 1982; Clark *et al.,* 2006).



Тархац нутгийнхаа бартаа ихтэй хуш, хуш шинэсэн ой, шинэсэн ойд орогнон байрших (Дуламцэрэн,1970; Хотолхүү, 1982) бөгөөд хушин ой нь булга зэрэг ойн жижиг махчдын тэжээлийн зонхилох хувийг эзлэх төрөл бүрийн жигүүртэн орогнон байрших нөхцөлийг бүрдүүлнэ. Голын хөндийн шинэс, улиас, гацууран төгөл болон торлогон ширэнгэ бүхий газарт булганы мөр хааяа тааралдах боловч энэ нь түүний гөрөөлөх нутаг болно (Хотолхүү, 1982).

Амьдралын онцлог. Өдөр, шөнийн аль ч үед идэвхтэй. Элдэв идэштэн. Идэш тэжээлд нь ойн улаан, хүрэн оготно зэрэг жижиг мэрэгч зонхилно. Түүнчлэн хэрэм, хурын овгийн шувуу (хөтүү, хур, сойр), ойн жижиг шувууд, самар, жимс ч иднэ. Оroo хөөцөө 6-7-р сард болно. Хээл тээх хугацаа 253-297 хоног үргэлжлэх ба үүнээс 7-9 сар орчим нь хөврөлийн тайван үед хамаарна. Хөврөлийн хөгжил үндсэндээ 25-40 хоног үргэлжилнэ. Хавар 3-4-р сард 3-4, хааяа 7 хүртэл тооны хойв гаргана. Намар болоход залуу булга бие гүйцсэн бодгалийн хэмжээнд хүрнэ. Үржлийн идэвх 12 нас хүртэл хадгалагдана. Ихэвчлэн газар дээр идэвхтэй байна. Өвөлд гүн сэвсгэр цасыг ярган явна. Цас орж эрс хүйтрэх үеэр үүрнээсээ гадагш гарахгүй хэдэн хоногоор ч бүгнэ. Суурин амьдралтай. Эзэмшил нутгаа тэмдэглэнэ (Батсайхан нар, 2010).

Тоо толгой, нягтшил. Энэ зүйлийн популяцийн тоо толгой, хэмжээ, хандлагын талаарх судалгааны мэдээ, баримт хомс. 1966-1968 онд Төв Хэнтийд 1000 га-д 11.7 бодгаль ноогдох нягтшилтай байсан бөгөөд 1970-аад онд энэ бүс нутагт 10,000 бодгаль байжээ (Хотолхүү, 1982). Мөн 2000-2003 онд Биологийн хүрээлэнгээс Хан Хэнтийн дархан цаазат газрын орчны бүсэд хийсэн судалгаагаар, 12,754 км^2 нутагт нийтдээ 795 толгой, харин 2008 онд 4406 км^2 нутагт 1,000 гаруй толгой ойн булга байна (Наранбаатар, 2016) хэмээн үнэлжээ.

Ховордлын шалтгаан. Олон улсын хэмжээнд арьсыг худалдаалдгаас хараа хяналтгүй болон хууль бусаар агнадаг (Clark *et al.,* 2006) ажээ. Хэнтий, Хөвсгөл, Саяны уулсаас 1910-1920 онд 4,000-5,000 ш булганы арьс бэлтгэж байсан (Намнандорж, 1976) бол 1920-оод оны сүүлчээс агналт нь буурч 1927-1929 онд жилд 300-500 ш булганы арьс бэлтгэж байжээ (Банников, 1954). Гэвч сүүлийн жилүүдэд булганы арьсыг их хэмжээгээр бэлтгэж, экспортолсон тухай

баттай мэдээ баримт хангалтгүй.
Монгол орны хэмжээнд сүүлийн 11 (2013-2023) жилийн хугацаанд хууль бус агнуурын 3 хэрэг хууль сахиулах байгууллагуудад бүртгэгдсэн (Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар, 2024) боловч бодит байдал дээр илүү өндөр байх магдалал их.

Өнөө үед энэ зүйлийн тархац нутаг, популяцийн өөрчлөлтөд дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтөөс улбаатай байгалийн түймэр, ган зуд, хуурайшилт болон хүний санамсар болгоомжгүй үйлдлээс алдсан ойн түймэр, мод бэлтгэл, самар жимс түүх зэрэг нь түүний амьдрах орчныг доройтуулж, сөргөөр нөлөөлж байж болзошгүй.

Хамгаалсан байдал. Монгол Улс 1953 оноос хуулиар агнахыг хориглож иржээ (Шийрэвдамба нар, 2013). Өдгөө Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, өсгөн үржүүлэх, хамгаалах харилцааг зохицуулж байна. Энэ хуульд заасны дагуу Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор батлсан Ховор амьтны жагсаалтад ойн булга орсон бөгөөд ховор амьтныг төрийн захиргааны төв байгууллагаас олгосон зөвшөөрлөөр (7.5.1) судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, эмчилгээний зориулалтаар агнаж, барьж болдог. Гэхдээ энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2-т зааснаар ойн булгыг жил бүрийн 2 дугаар сарын 11-ний өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд агнах, барихыг хоригложээ.

Үүнээс гадна, (10.1.2) агнуурын амьтны жим дээр нүх ухах, буу сойх, занга, сааль тавих, (10.1.5) амьтныг агаарын болон авто тээврийн хэрэгслээр хөөх, гэрэлтүүлэх, (10.1.8) ан агнах зориулалтын бус буу, сум хэрэглэх зэрэг арга, зэвсэг хэрэгслээр агнах, барихыг хориглодог. Мөн амьтныг (11.1.1) шуурга, ган, зуд, үер, мөндөр, түймэр зэрэг гамшигт нэрвэгдсэн болон гол, мөрөн, намаг, шаварт орох зэрэг биеэ хамгаалах чадваргүй болсон үед агнах, барих, (11.1.3) өөр нутагт шилжин байршиж байгаа агнуурын амьтныг агнах, барих, (11.1.4) амьтны үүр, ичээ ухах, гэмтээх зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглосон.

Мөн Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр ойн булга 880,000 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу).

Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд (тухайлбал, Алтай Таван Богд, Чигэртэйн голын ай сав, Тэнгис-Шишгэдийн голын ай сав, Хөвсгөлийн байгалийн цогцолборт газрууд болон Улаан тайга, Хорьдол Сарьдаг, Хан Хэнтийн дархан цаазат газрууд г.м) хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн тархац нутаг, амьдрах орчин (3.4) популяцийн хэмжээ, төлөв байдал, хандлага (3.2), биологи, экологи (3.3), учирч болзошгүй эрсдэл, аюул заналын (3.5) талаар нарийвчилсан судалгааг хийж, үүний үндсэн дээр хамгаалах арга хэмжээг тусгайлан боловсруулж, хэрэгжүүлэх, ховордлын зэрэглэлийг ахиулах юм уу бууруулах эсэх талаар дахин үнэлгээ хийх шаардлагатай. Мөн зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2) арга хэмжээг зохион байгуулах нь зүйтэй.

3.7. МАНУУЛ

Otocolobus manul (Pallas, 1776)

Баг: Мах идэштэн (Carnivora)
Овог: Мий (Felidae)
Англи нэр: Pallas's Cat
Ижил нэр: Мануул мий (Дуламцэрэн, 2003); *Otocolobus ferrugineus, Otocolobus mongolicus, Otocolobus nigripectus, Otocolobus satuni* (Wilson and Reeder, 2005), *Otocolobus manul* (Pallas, 1776) (http://checklist.cites.org).



Ангилал зүйн тойм. Мануулын 3 салбар зүйл бий (Строганов, 1962) гэж үздэг. Тэдгээр нь өөр хоорондоо газар нутаг, өнгө зүсээрээ ялгарах ба газарзүйн мужууд түүний өнгө зүсний хувьслын гол нөхцөл болдог (Строганов, 1962; Гептнер, Слудский, 1972; Павлинов, Россолимо, 1987) ажээ. Үүнд Сибирийн мануул (*O. m. manul* Pallas, 1776) ерөнхий үсэн бүрхүүл нь хөх саарал боловч мэдэгдэхүйц шаргал-улаан шар үстэй. Нурууны доод хэсгээр харавтар хөндлөн судалгүй юм уу сул илэрнэ. Хамрын яс уг руугаа нэгэн жигд нарийссан (Банников. 1954). Байгалийн Чанад, өмнөд Алтай, Казахстан, Монгол, түүний хил залгаа Хятадын зарим нутагт тархсан (Строганов, 1962). Каспийн мануул (*O. m. ferrugineus* Ognev, 1842) ерөнхий төрх байдлын хувьд улаан шаргал өнгөтэй гэрийн мууртай төстэй. Гавлын ясны бүтэц, хэмжээ нь сибирийн салбар зүйлтэй адилхан. Өмнөд Туркмен (Копетдаг, Их Балхан, Кушка), баруун Таджикстан, өмнөд Узбекистан, Какавказ, Орос, хойд Ирак, Афганистанд тархсан (Гептнер, Слудский, 1972). Төвдийн мануул (*O. m. nigripectus* Hodgs, 1842) үсэн бүрхүүл нь хөхөвтөр, цээж, сүүл, толгой нь хар толботой, хамрын яс дунд орчимдоо хэд хэд нарийссан байдгаараа бусад салбар зүйлүүдээсээ ялгарна. Төвд, Кашемирийн нутгаар тархсан (Строганов, 1962) ажээ. Монгол оронд *O. m. manul* Pallas, 1776 гэх салбар зүйл нь тархжээ (Дуламцэрэн, 1970).

Таних шинж. Биеийн урт 50-72 см. Биеийн төрх, хэмжээний хувьд гэрийн мууртай ойролцоо, жижиг биетэй зэрлэг муур. Мөч богино, бахим. Зун бараавтар хөхвөр шаргал,

өвөлдөө цайвардуу хөх-шаргал. Өтгөн урт, зөөлөн үстэй, үсний үзүүр мөнгөлөг цагаан тул буурал харагдана. Дух цайвар хөх, жижиг хар толбуудтай. Эрүү, цээж, хэвлий цагаан. Сүүл богино, хар бараан гархи маягийн хөндлөн судалтай, үзүүр нь хар. Нуруундаа хөндлөн хар судлуудтай. Биеийн хэмжээ, галбир, зүсэнд хүйсийн ялгаа илрэхгүй (Мөнхцог нар, 2005а).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Ховордож болзошгүй (Clark et al., 2006).

2025 онд Эмзэг (VU), A3cd. Тархац нутаг уудам, популяцийн хэмжээ тодорхойгүй боловч уур амьсгалын өөрчлөлт, уул уурхай, дэд бүтцийн хөгжил, суурьшлаас хамааран түүний амьдрах орчин доройтож, тархац нутаг нь хумигдан тасархайтаж, популяци буурах хандлага байж болзошгүй байгаагаас гадна, энэ зүйлийн өвчин эмгэг, байгалийн гамшигт үзэгдэлд өртөмтгий, тоо толгойн хэлбэлзэл ихтэй байдал зэргийг харгалзан үзэж Эмзэг зэрэглэлээр үнэлэв. Цаашид Монгол орны хэмжээнд энэ зүйлийн тархац нутаг, популяцийн хэмжээг үнэлж, мэдээ баримт цуглуулан ховордлын зэрэглэлийг бууруулах юм уу ахиулах боломжтой.

Үнэлгээ хийсэн: С.Пүрэвсүрэн (2025).

Үнэлгээг хянасан: Б.Мөнхцог, Л.Пүрэвжав (2025).

Дэлхийн тархац. Орос, Армен, Иран, Казахстан, Туркменистан, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан, Хятад, Энэтхэг, Киргизстан болон Монголд тархсан (Clark *et al.,* 2006; Moroldoev, 2019; Greenspan and Giordano, 2021).



Амьдралын онцлог. Ганц нэгээрээ тохиолддог, нуугдмал амьдралтай. Өвлийн улиралд үүрийн бүрэнхийгээс бага үд хүртэл, дулааны улиралд өглөө 2-10 цаг, орой 18-22 цагт хамгийн их идэвхтэй байх бөгөөд өдрийн цагаар ч тохиолдоно (Мөнхцог нар, 2005б). Төв Монголын хээрт энэ зүйлийн идэш тэжээлийн 81.3%-ийг жижиг амьтад, 3.7%-ийг жижиг шувууд бүрдүүлэх бөгөөд түүний өвлийн идэш тэжээлд дагуур огдой (65.5%) зонхилж, үлийн цагаан оготно (15.4%), чичүүл (11.5%) оролцож байсан бол дулааны улиралд дагуур огдой (39.1%), чичүүл (9.2%), хадны барагчин (4.5%) зэргээр хооллоно (Мөнхцог нар, 2005в). Тарваганы орхисон нүх, хад чулууны хонгил, ангал, жижиг агуй зэрэгт үүрлэнэ (Ross *et al.*, 2010; Пүрэвсүрэн нар, 2013а). Гуужилт 3-р сарын сүүлчээр эхэлж 6-р сарын эхээр дуусна. Ороо хөөцөө 2-р сарын сүүлч 3-р сарын эхээр болно. Мигүү (эмэгчин) хээлээ 60 гаруй хоног тээх бөгөөд 2-6, хааяа 8 ногоолой төрүүлнэ (Пүрэвсүрэн нар, 2013а). Хоёр настай бэлэг боловсорно. Байгальд 10 хүртэл жил насална (Батсайхан нар, 2010).

Тоо толгой, нягтшил. Энэ зүйлийн тархалт уудам газар нутгийг хамрах бөгөөд популяцийн хэмжээ тодорхойгүй. Баянхонгор, Архангай, Завхан, Говь-Алтай аймгийн нутагт элбэг ба дунджаар 1,000 га эдэлбэр нутагт 1-2, Дархадын хотгорт дээд хэмжээ нь 1,000 га-д 4-6, хамгийн бага нь 0.4-1.2 толгой байна. Дорнод Монголын талд 1,000 га–д 0.8–1, Алтайн цаадах говь, Зүүнгарын говь, Өмнийн говиудад ховор тохиолддог бөгөөд Төв, Дундговь, Сүхбаатар аймгийн тал хээрийн сумдад 2,000–3,000 га-д 1-2 бодгаль ноогдох нягтшилтай (Сүхбат, Шагдарсүрэн, 1990). Төв аймгийн 10 км^2 нутаг дэвсгэрт 2000, 2001 онд дунджаар 0.6 бодгаль нягтшилтай байсан ба тоо толгойн хэлбэлзэл ихтэй (Пүрэвсүрэн нар, 2013б).

Ховордлын шалтгаан. Мануулын арьсыг олон улсын зах зээл дээр худалдаалдаг байсан бөгөөд тухайлбал, Монгол Улсын 1927-1980 оны арьс бэлтгэлийн баримтаас үзвэл, 1928 онд 8,400 ш, 1958-1966 онд жил бүр 5,300-8,432 ш буюу хамгийн олон арьс бэлтгэж байсан бол 1933-1953 онд жил бүр 450-1,000 ш буюу хамгийн цөөхөн арьс

бэлтгэж байжээ. 1969 онд 6,000 гаруй арьс бэлтгэж, түүнээс хойш арьс бэлтгэл тогтмол багассан нь түүний тоо толгой буурсаар байсныг илэрхийлж байж болзошгүй юм (Пүрэвсүрэн нар, 2013б; Пүрэвсүрэн нар, 2013в). Говь Гурвансайханы байгалийн цогцолборт газарт 2020 онд хийсэн судалгаагаар, сүүлийн 30 жилийн хугацаанд тус бүс нутагт мануулын тархалт 15%-аар багассан байна (Chimed *et al.*, 2021). Ер нь Монголчууд мануулын арьсыг ахуйн хэрэгцээнд хэрэглэхээс гадна, түүний өөх, мах зэргийг уламжлалт ангаах ухаанд (3.2) хэрэглэж ирсэн боловч энэ нь түгээмэл биш. Гэрийн нохой, махчин шувууд (8.3) түүний гол дайсан амьтад юм. Үлийн цагаан оготны тоо толгойг зохицуулах зорилгоор хор цацах нь мануулын тоо толгойд сөргөөр нөлөөлдөг. Өдгөө дэлхийн дулаарал (6.1.1), уур амьсгалын өөрчлөлтөөс улбаатай ган зудын давтамж нэмэгдэж, мөн уул уурхай (1.3.1), дэд бүтцийн хөгжил (1.4), суурьшлаас хамааран түүний амьдрах орчин доройтох (1), эрсдэл нэмэгдэж байгаа зэрэг нь энэ зүйлд сөргөөр нөлөөлнө. Мөн энэ зүйл нь өвчин эмгэг, шимэгчид (8.5), махчин шувууд (8.3), цаг агаарын өөрчлөлт, байгалийн гамшигт үзэгдэлд (цагаан зуд, ган гачиг г.м) (7.7) өртөмтгий, тоо толгойн хэлбэлзэл ихтэй (9.8) амьтан.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2-д зааснаар мануулыг жил бүрийн 2 дугаар сарын 11-ний өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосноос гадна, (10.1.2) агнуурын амьтны жим дээр нүх ухах, буу сойх, занга, сааль тавих, (10.1.5) агнуурын амьтныг агаарын болон авто тээврийн хэрэгслээр хөөх, гэрэлтүүлэх, (10.1.8) ан агнах зориулалтын бус буу, сум хэрэглэх зэрэг арга, зэвсэг хэрэгслээр агнах, барихыг хориглодог. Мөн амьтныг (11.1.1) шуурга, ган, зуд, үер, мөндөр, түймэр зэрэг гамшигт нэрвэгдсэн болон гол, мөрөн, намаг, шаварт орох зэрэг биеэ хамгаалах чадваргүй болсон үед агнах, барих, (11.1.3) өөр нутагт шилжин байршиж байгаа агнуурын амьтныг агнах, барих, (11.1.4) амьтны үүр, ичээ ухах, гэмтээх, (11.1.7) амьтны үр төлийг агнах, шувууны өндгийг түүх, гэмтээх, устгах зэрэг үйл ажиллагаа явуулахыг хоригложээ.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр мануул 850,000 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу).

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-ын II хавсралтад бүртгэсэн (Чимэддорж нар, 2018; http://checklist.cites.org).

Энэ зүйлийн тархац нутгийн 12% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ

- Сүүлийн 25 жилд энэ зүйлийн судалгааг тодорхой бүс нутгуудад эрчимтэй хийж, олон арван өгүүлэл гадаа, дотоодод хэвлэгдэж, нэлээд мэдээ, баримт цуглажээ. Гэвч Монгол орны өргөн уудам нутагт тархсан энэ зүйлийн тархац нутаг, популяцийн хэмжээ, төлөв байдал, хандлага (3.2), биологи, экологи (3.3) болон аюул занал (3.5) зэргийг өргөн хүрээнд тусгайлан судалж, үүний үндсэн дээр шинжлэх ухаанд тулгуурласан хамгааллын арга хэмжээг тодорхой төлөвлөж, хэрэгжүүлэх нь зүйтэй.
- Мөн энэ зүйл нь бэлчээрийн хортон мэрэгчдийн тоо толгойг зохицуулах, бэлчээрийг хамгаалж, тариалангийн ургацыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой, хээрийн экосистемд чухал үүрэгтэй амьтан гэдгийг иргэд, малчид, аж ахуйн, байгууллагуудад сайтар ойлгуулах, мэдээллээр хангаж сурталчлах нь нэн чухал.

3.8. ЦАГААН ЗЭЭР

Procapra gutturosa (Pallas, 1777)

Баг: Туруутан (Artiodactyla)
Овог: Тугалмайтан (Bovidae)
Англи нэр: Mongolian Gazelle
Ижил нэр: *P. g. altaica, Antelope gutturosa, Antelope orientalis, Procapra altaica*; Dzeren, White-tailed Mongolian Gazelle.



Ангилал зүйн тойм. А.Г. Банников (1954) Монгол орны хэмжээнд олон тооны цагаан зээрийн толгойн яс болон арьсны дээжийг цуглуулж, харьцуулан судалсан бөгөөд цагаан зээрийн салбар зүйл тогтоогдоогүй тухай “Млекопитающие Монгольской народной республики” бүтээлдээ тэмдэглэжээ.

Таних шинж. Биеийн ерөнхий урт 105-148 см, сэрвээний өндөр 62-84 см, сүүлний урт 9-12 см байх ба жин 20-39 кг. Эвэр хар саарлаас тосон хар. Биеэр том биш, галбир сайтай, нарийхан зэгзгэр хөлтэй. Цавинд байх том булчирхай ба гавлын ясны хэмжээгээр ижил төрлийн зүйлүүдээс ялгарна (Sokolov *et al.,* 1997). Өвлийн улиралд элсэн саарал, 3-5 см урт сахлаг үстэй. Зуны улиралд шаргал, улбар шаргал, 1.5-2.5 см урт үстэй. Ооно нь шаргачнаас биеэр том төдийгүй эвэртэй, хүзүүний төвөнхийн өргөссөн хэсэг болох “хүхээг”-тэй байдгаараа ялгарна (Адъяа, 2025).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Устаж болзошгүй (EN), A4cde (Clark *et al.,* 2006).

2025 онд Эмзэг (VU), A2c; B2b (ii, iii).

Монгол оронд XX зууны эхэнд ойролцоогоор 4.75 сая орчим цагаан зээр байв (Milner-Gulland and Lhagvasuren, 1998). Харин 1990-ээд оны сүүлч хүртэлх хугацаанд олон янзын аргаар (аман судалгаа, газрын болон агаарын тооллого г.м) түүний тархац

нутгийг хэсэгчлэн хамарсан судалгаануудыг хийж, цагаан зээрийн популяцийг харилцан адилгүй үнэлсэн байх бөгөөд эдгээрээс харахад, цагаан зээрийн популяцийн хэмжээ 150,000-2,700,000 бодгалийн хооронд хэлбэлзэж байна (Olson, 2010).

Илүү системтэй судалгааг 2000–2002 онд Дорнод, Сүхбаатар аймгийн 80,000 км² нутагт шугаман трансектийн аргаар хийж, популяцийн хэмжээг 800,000–900,000 бодгаль гэж үнэлсэн (Olson *et al.,* 2005a) бөгөөд тус судалгааг 2005 онд өргөжүүлэн Улаанбаатар–Замын-Үүдийн төмөр замаас зүүн тийших 275,000 км² нутагт хийж, нийт 1.12 сая орчим зээр байгааг тогтоосон (Olson *et al.,* 2011).

Хамгийн сүүлд буюу 2020 онд Монгол орны хэмжээнд хийсэн судалгаагаар, нийт тархац нутаг (681,863 км²)-ийн хэмжээнд 2.1 сая орчим цагаан зээр байна (Buuveibaatar *et al.,* 2024) байна хэмээн үнэлсэн.

Цагаан зээрийн гол тархац нутаг болох Дорнод, Сүхбаатар аймгуудын нутгаар 800 км гаруй урт төмөр зам тавихаар төлөвлөсөн (Dejid *et al.,* 2024). Хэрэв эдгээр төмөр замууд баригдан хоёр талаар нь өргөст тор татсан нөхцөлд цагаан зээрийн гол амьдрах орчныг хуваах, улмаар тааламжтай амьдрах орчин буурах эрсдэл бий учраас зэрэглэлийн B2b ii, iii-д хамруулав. Цаашлаад энэхүү амьдрах орчны хуваагдал, доройтлын улмаас цагаан зээрийн тоо толгой 3 үеийн турш буюу ирэх 15 жилд ≥30%-аар буурах эрсдэлтэй (A2c) хэмээн үнэлж “Эмзэг” гэсэн зэрэглэлд оруулав.

Үнэлгээ хийсэн: Б.Бүүвэйбаатар, Э.Энхмаа (2025).

Үнэлгээг хянасан: Ян.Адъяа (2025), С.Гомбобаатар (2025).

Дэлхийн тархац. Монгол, Орос, Хятадад тархсан (Odonkhuu *et al.,* 2009; Buuveibaatar *et al.,* 2024).

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол орны говь, хээрийн бүс болон түүнтэй залгаа Хятадын хойд болон Оросын зүүн өмнөд хэсгээр тархсан туруутан. Түүхэн цаг хугацаанд энэ зээр Монгол орны хээр болон цөлөрхөг хээрийн бүс нутгаар өргөн тархаж, тархац нутаг нь 780,000 км² орчим байжээ (Банников, 1954). Дэлхий дээрх цагаан зээрийн өнөөгийн нийт тархац нутгийн хэмжээ 746,281 км² бөгөөд үүний 91% нь Монголд (681,863 км²), 5% нь Хятадад (34,718 км²), 4% нь Орост (29,700 км²) оршиж байна (Buuveibaatar *et al.,* 2024). Харин сүүлийн жилүүдэд хүн болон байгаль цаг уурын нөлөөгөөр тархац нутаг нь хумигдан, өнөөдөр Дорнод Монгол, Төв Халх, Умард говь, Дорнод говь, Нууруудын хөндийн зүүн хэсгээр тархаж байна (Lkhagvasuren *et al.,* 2001). Сүүлийн жилүүдэд энэ зээр өвлийн улиралд Дорнод болон Хэнтий аймгуудын хойд хэсгийн ой бүхий нутгуудаар байршиж, зарим нь суурьших болсон. Мөн 1980-аад оны сүүлч 1990-ээд оны эхэн үед Монголын баруун хэсэгт орших Хомын талд зүүн бүсээс цагаан зээрийн янзага тээвэрлэн авчирч нутагшуулсны үр дүнд энэхүү тусгаар популяци оршин тогтнож байгаа төдийгүй тоо толгой нь өсөж байна. Орост 1970-аад оны эхээр энэ зээр бүрэн устсан хэдий ч 2000-аад оноос хойш хамгааллын арга хэмжээ хэрэгжүүлсний үр дүнд Монголоос нүүдэллэн очсон зээр Дагуурын дархан цаазат газарт суурьших болсон. 2019 оноос хойш Орост өвөлжих цагаан зээрийн тоо нэмэгдэх болсон бөгөөд зарим жилд 100,000 хүрэх болжээ (Kirilyuk, 2021).



Амьдралын онцлог. Амьдрах орчны идэш тэжээл, усны хүртээмж нь хур тунадаснаас шалтгаалан орон зай, цаг хугацаанд байнга өөрчлөгддөг (Mueller *et al.,* 2008; Ito *et al.,* 2018). Иймээс соргог бэлчээр, усны эх үүсвэрт хүрэх, мөн байгаль цаг уурын тааламжгүй нөхцөлөөс зайлсхийхийн тулд өргөн уудам нутагт байнгын шилжилт хөдөлгөөн хийдэг (Ito *et al.,* 2005; Olson *et al.,* 2010; Nandintsetseg *et al.,* 2019a). Энэхүү

онцлог нь тэдгээрийг дэлхий дээр хамгийн хол зайд шилждэг хуурай газрын хөхтөн амьтдын нэг болгож байна (Joly *et al.,* 2019; Tucker *et al.,* 2019). Тогтсон нүүдлийн замгүй төдийгүй өвөл, зуны байршил нутаг нь жил бүр өөрчлөгддөг тул тэдгээрийн шилжилт хөдөлгөөнийг “хэрмэл” хэв маягтай гэж тодорхойлдог (Mueller and Fagan, 2008). Сансрын дохиололтой хүзүүвч зүүсэн шаргачин 5 жилийн хугацаанд 18,000 км гаруй зайг туулсан бөгөөд өвөл болон зуны байршил нутаг нь жил бүр өөр байв (Dejid *et al.,* 2020). Байршил нутгийн хэмжээ нь идэш тэжээлийн хүрэлцээ, тухайн бодгалийн нас, хүйсээс хамаарч харилцан адилгүй бөгөөд нэг цагаан зээр бүхий л амьдралын хугацаанд 100,000 км² хүртэлх газар нутгийг ашиглана (Imai *et al.,* 2017; Nandintsetseg *et al.,* 2019b).

Зээрийн сүрэглэлт, сүргийн сарнилт жилд 2 удаа буюу төллөх болон ороony үед болно. Сүрэг дэх бодгалийн тоо хэдэн арваас хэдэн арван мянгад хүрэх бөгөөд 200,000-аас дээш тоотой үлэмж сүрэг үүсгэн идэш тэжээл сайтай бүс нутагт бөөгнөрч байсан тохиолдол бий (Odonkhuu *et al.,* 2009; Olson *et al.,* 2009). Шаргачин хээлээ 5 сар гаруй тээж 6-р сарын сүүлээр төллөж голдуу нэг, зарим тохиолдолд ихэр янзага төрүүлнэ. Төллөх хугацаа ойртоход ихэнхдээ 6-р сарын сүүлчээр хээлтэй шаргачнууд ганц нэг, хэд гурваар тасарч сүргийн доторх тооны харьцаа өөрчлөгдөнө (Адъяа, 2025).

Үржлийн өндөр чадамжтай бөгөөд бие гүйцсэн шаргачны 92% нь хээл авна (Olson *et al.,* 2005b). Янзага 10 гаруй хоноод өвсөн тэжээлд орох боловч 8-р сарын сүүлч хүртэл эхээ хөхнө. Янзаганы мэнд үлдэлт өндөр буюу эхний жилдээ 71% орчим байна (Olson *et al.,* 2005b). Харин бие гүйцсэн цагаан зээрийн мэнд үлдэлт жилд дунджаар 66% бөгөөд энэ нь голчлон хүний хүчин зүйл тухайлбал, агнууртай холбоотой. Хүний нөлөө байхгүй нөхцөлд цагаан зээр 8 жил хүртэл насалдаг (Olson *et al.,* 2014). Цагаан зээр генетик олон янз олон байдлаар баялаг бөгөөд төмөр замаас үүдэлтэй сөрөг нөлөө одоогоор илрээгүй байна (Okada *et al.,* 2015).

Түүний идэш тэжээлд хялгана, таана, хиаг, дэрс, шарилж, харгана, бор шаваг, шарилж, сэдэргэнэ, бударгана зэрэг ургамлууд улирлаар ээлжлэн солигдож оролцоно (Olson *et al.,* 2010b; Sugimoto *et al.,* 2018).

Тоо толгой, нягтшил. Монгол оронд ойролцоогоор 1940-өөд оны эхэн үед 4.75 сая орчим цагаан зээр байсан гэж үздэг (Milner-Gulland and Lkhagvasuren, 1998). Харин 1978, 1979 онд популяцийн хэмжээг 250,000–270,000 гэж тогтоосон (Sokolov and Lushchekina, 1997). 1980 онд тохиосон ган гачиг болон өвчний улмаас энэ зээрийн тоо толгой 150,000–180,000 хүртэл буурсан. Үүний дараа, 1981 онд популяцийн тоо толгой нэмэгдэж 300,000–400,000 орчим толгой болжээ (Лущекина и др., 1983).

1990-ээд оны дунд үед цагаан зээрийн популяцийн үнэлгээг онгоцоор гүйцэтгэж, Монголд ойролцоогоор 2.7 сая орчим цагаан зээр байна (Reading *et al.,* 1998) хэмээн тооцжээ. Гэсэн хэдий ч тухайн үеийн судалгааны арга зүй, хамрах хүрээ нь харилцан адилгүй байсан тул судалгааны үр дүнгүүд нэлээд зөрүүтэй байсныг анхаарах хэрэгтэй (Milner-Gulland and Lkhagvasuren, 1998).

Харин 2000–2002 онд Дорнод, Сүхбаатар аймгийн 80,000 км² нутагт шугаман трансектийн аргаар нэлээд системтэй судалж, популяцийн хэмжээг 800,000–900,000 гэж үнэлсэн (Olson *et al.,* 2005a) бөгөөд тус судалгааг 2005 онд өргөжүүлэн Улаанбаатар–Замын-Үүдийн төмөр замаас зүүн тийших 275,000 км² нутагт гүйцэтгэж, нийт 1.12 сая орчим цагаан зээр байгааг тогтоосон (Olson *et al.,* 2011).

Хамгийн сүүлд буюу 2020 онд цагаан зээрийн тоо толгойг дэлхийн хэмжээнд тогтоох зорилготой судалгааг гүйцэтгэсэн бөгөөд Монгол оронд ойролцоогоор 2.1 сая, Орост 30,000 орчим, Хятадад 8,000 орчим цагаан зээр байна (Buuveibaatar *et al.,* 2024) хэмээн тус тус тооцоолжээ. Энэхүү судалгааны үр дүн нь дэлхий дээрх нийт цагаан зээрийн 99% нь Монгол оронд тархаж байгааг харуулсан юм.

Ховордлын шалтгаан. Өнгөрсөн цаг хугацаанд албан ёсны агнуурын тооноос хууль бус агнуурын хэмжээ давж, өргөн цар хүрээгээр агнаж байсан нь ховордлын гол шалтгаан болж байсан (Lkhagvasuren and Milner-Gulland, 1997). Milner-Gulland, Lkhagvasuren (1998) нарын гаргасан агнуурын загвар нь нэг сая толгой бүхий популяциас жилд 60,000 толгойг агнах даацтай гэж үзсэн ч агнасан хэмжээ нь 300 гаруй хувиар давж байсан (Wingard and Zahler, 2006). Дорнод Монголд 1977 оны өвөл 70,000 орчим цагаан зээр бэлтгэж байсан (Sokolov and Lushchekina, 1997) бол 2004 онд энэ тоо 250,000 болж өссөн (Wingard and Zahler, 2006).

Сүүлийн жилүүдэд шугаман дэд бүтэц тухайлбал, төмөр зам болон хилийн дагуух хамгаалалтын торон хашаа нь зээрийн байгалийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлаж, хорогдолд нөлөөлөх хамгийн том аюул занал болж байна. Тодруулбал, Улаанбаатар-Замын-Үүд (УБТЗ) чиглэлийн төмөр зам 1950-аад оны сүүлээр хориг хашаатай баригдсанаар Монгол орны цагаан зээрийн тархац нутгийг зүүн, баруун хоёр хэсэгт хуваасан (Reading *et al.,* 1998). 2002–2012 онд хийсэн судалгаагаар, УБТЗ дагуух өргөст хашаа нь хүзүүвчтэй зээрүүдийн шилжилтийг бүрэн хязгаарлаж байсан (Ito *et al.,* 2013). Жил бүрийн өвөл олон тооны зээр урагш нүүдэллэн ирж, УБТЗ-ын өргөст торон хашаанд тулан улмаар давж гарахыг оролдох үедээ ороцолдож эсвэл өлгөгдөж үрэгддэг (Ito *et al.,* 2008).

Зээрийн хорогдол цас ихтэй зудтай өвөл улам нэмэгддэг. 2016 оны өвөл зүүн аймгуудад цас их орсны улмаас зээр баруун тийш нүүдэллэн төмөр замын торонд тулж улмаар 5,000 гаруй зээр торонд өлгөгдөж, ороцолдож хорогдсон. Мөн Дорнод аймгаас 2014-2015 онд хүзүүвчилсэн 22 зээрийн 80% нь Монгол-Хятадын хилийн өргөст торонд тулж байршсан хэдий ч хөндлөн гарч чадаагүй (Nandintsetseg *et al.,* 2019b). Үүнээс гадна, 2023 оны хавар түймрээс дайжсан зээр олноороо тус хилийн торонд тулан гарч чадалгүй шатаж үхсэн тохиолдол бүртгэгдсэн.

Бусад дэд бүтцийн хөгжлөөс үүдэлтэй дарамтууд ч нэмэгдэж байна. Автозамын сүлжээ өргөжиж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нэмэгдсэнтэй холбоотойгоор цагаан зээрийн 16 хоногт туулж буй зай 2007–2021 онд 142 км-ээс 92 км болж 36%-аар буурсан байна (Mednge*n et al.,* 2023). Мөн цагаан зээрийн зарим тархцын бүс нутагт уул уурхайн үйл ажиллагаа тухайлбал, газрын тосны олборлолт нэмэгдэж, амьдрах орчинд нь сөргөөр нөлөөлж байна (Nandintsetseg нар, 2019b).

Мөн зээрийн сүргийн дотор цусан халдвар, мялзан, ханиад, шүлхий, цэцэг, годрон, боом, зэрэг гоц халдварт өвчин гарч олноор хорогдох тохиолдол элбэг (Bolortsetseg *et al.,* 2012).

Хүн ам, малын нягтшил их бүс нутгуудад бэлчээрийн доройтол нэмэгдэж, улмаар зээрийг идэш тэжээлээр шахаж буй нь ховордлын бас нэгэн шалтгаан болж байна (Yoshihara *et al.,* 2008; Sugimoto *et al.,* 2018).

Бүс нутгийн хэмжээнд өргөн уудам орон зайд шилждэг тул жилийн ихэнх хугацаанд тусгай хамгаалалттай газар нутгуудын хилийн гадна байршиж байгаа нь аливаа хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй сөрөг нөлөөнд өртөмтгий байдлыг нэмэгдүүлж байна (Batsaikhan *et al.,* 2014; Nandintsetseg *et al.,* 2019b).

Хамгаалсан байдал. Монгол Улс 1932 оноос хойш цагаан зээрийн агнуурыг хяналттай зохион байгуулж, орон нутгийн хэмжээнд ахуйн хэрэгцээнд агнах тоо хэмжээг тогтоож иржээ. Өдгөө Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, өсгөн үржүүлэх, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд тухайлбал, энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1-д цагаан зээрийг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний өдрөөс дараа оны 8 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Үүнээс гадна, (10.1.2) агнуурын амьтны жим дээр нүх ухах, буу сойх, занга, сааль

тавих, (10.1.5) амьтныг агаарын болон авто тээврийн хэрэгслээр хөөх, гэрэлтүүлэх, (10.1.8) ан агнах зориулалтын бус буу, сум хэрэглэх зэрэг арга, зэвсэг хэрэгслээр агнах, барихыг хориглож, мөн (11.1.1) шуурга, ган, зуд, үер, мөндөр, түймэр зэрэг гамшигт нэрвэгдсэн болон гол, мөрөн, намаг, шаварт орох зэрэг биеэ хамгаалах чадваргүй болсон агнуурын амьтныг агнах, барих, (11.1.2) булаг, шанд, хужир мараанд ирж буй амьтныг отож агнах, (11.1.3) өөр нутагт шилжин байршиж байгаа агнуурын амьтныг агнах, барих, (11.1.7) амьтны үр төлийг агнах, шувууны өндгийг түүх, гэмтээх, устгах, (11.1.8) ангийн буу, агнуурын амьтан агнах, барих гэрээ, зөвшөөрөл, эрхийн бичгийг бусдад шилжүүлэх, (11.1.12) эрх бүхий мэргэжлийн байгууллагаар агнуур зохион байгуулалтын ажлыг хуульд заасан хугацаанд нь хийлгээгүй аймаг, сум, нийслэл, дүүргийн нутагт агнуурын амьтан агнах, барих зэрэг үйл ажиллагааг хориглосон байдаг.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр цагаан зээр 997,000 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу).

Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)-ын II хавсралтад орсон бөгөөд энэ конвенцын хүрээнд шугаман дэд бүтцийн нөлөөллийг бууруулах олон улсын зөвлөмжийг 2014 онд боловсруулсан (Wingard *et al.,* 2014). Мөн Төв Азийн хөхтөн амьтдыг хамгаалах санаачилга (CAMI)-ын хүрээнд хамгаалагджээ. Цагаан зээрийн шилжилт хөдөлгөөнийг чөлөөтэй нэвтрүүлэх, популяцийн хорогдлыг бууруулах зорилгоор “Тал хээр, говь цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуух зэрлэг амьтдад зориулсан гарц (MNS 6515:2015)”, “Төмөр зам болон хурдны авто замын хориг хашаа (MNS 7042:2024)” зэрэг үндэсний стандартуудыг боловсруулан баталж, хэрэгжүүлж байна.

Цагаан зээрийн тархац нутгийн 12%, голомт нутгийн 14% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдсан боловч энэ нь хэрмэл амьдралтай, өргөн уудам нутагт тархсан уг зүйлийг хамгаалахад хангалтгүй юм.

Хамгаалах арга хэмжээ

Энэ зүйл зээрийг хамгаалахын тулд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

- Хууль бус агнуурын хяналт шалгалтыг эрчимжүүлж, орон нутгийн иргэдийн мэдлэг, оролцоог нэмэгдүүлэх.
- Чухал амьдрах орчин тухайлбал, шилжилт хөдөлгөөний холбоос нутаг болон төллөдөг газруудыг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах.
- Одоогийн тусгай хамгаалалттай газар нутгуудын менежментийг сайжруулах замаар эргүүл хяналт, судалгаа мониторингийг үр дүнтэй зохион байгуулах.
- Шугаман дэд бүтцийн (авто зам, төмөр зам) дагуух зээрийн шилжилт хөдөлгөөнийг тасралтгүй хангах зорилгоор гүүрэн гарц, нүхэн гарц, нэг түвшний гарцыг төлөвлөж, стандартад нийцүүлэн байгуулах.
- Төмөр замын дагуух өргөст хашааг зээр олноор хорогддог газруудад зэрлэг амьтдад ээлтэй болгон өөрчлөх.
- Тоо толгой, тархац, шилжилт хөдөлгөөний судалгаа, мониторингийн ажлыг тогтмол зохион байгуулж, үр дүнг бодлогын төлөвлөлтөд тусгах.
- Уур амьсгалын өөрчлөлтөөс цагаан зээрийн популяцид үзүүлэх нөлөөллийг судалж, эрсдэлд суурилсан хамгааллын арга хэмжээг боловсронгуй болгох.
- Сургалт, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд цагаан зээрийн биологи, экологи, хамгааллын ач холбогдлыг таниулах.
- Хил дамнасан судалгаа, хамгааллын ажлуудыг хэрэгжүүлэх хүрээнд Орос болон Хятадтай хамтын ажиллагааг өргөжүүлэх шаардлагатай.

3.9. АРГАЛЬ

Ovis ammon (Linneaus, 1758)

Баг: Туруутан (Artiodactyla)
Овог: Тугалмайтан (Bovidae)
Англи нэр: Argali
Ижил нэр: Аргаль хонь; *Ovis ammon (Ovis ammon ammon), Ovis darwini* (*Ovis ammon darwini*); *O. a. altaica, ammonoides, argali, asiaticus, darwini, dauricus, kozlovi, mongolica, przevalskii*; Argali wild sheep (Wilson and Reeder, 2005).





Ангилал зүйн тойм. Дэлхийд зэрлэг хонины 9 зүйл байгаагаас Монгол оронд тархсан нь аргаль хонь бөгөөд n=56 хромосомтой. Монголд *Ovis ammon ammon, Ovis ammon darwini* гэх 2 салбар зүйл бий (Банников, 1954; Mallon *et al.,* 1997; Федосенко, 2000; Geist, 1971; Дуламцэрэн, 1970; Соколов, 1980; Амгаланбаатар, 2013; Чимэддорж нар, 2019; CITES, 2024). Генетикийн судалгаагаар Монгол орны бүх аргаль хонь нэг салбар зүйлд (*Ovis ammon ammon*) хамаарна (Tserenbataa *et al.,* 2004) гэх судалгаа бий. Аргаль хонины салбар зүйлийн тухайд нэгдмэл ойлголтод хүрээгүй, тодорхойгүй хэвээр тул генетикийн судалгааг нарийвчлан хийж баталгаажуулах шаардлагатай.

Таних шинж. Биеийн урт нас, хүйсээсээ хамааран 130-186 см, угалзын биеийн жин дунджаар 100-155 кг. Сэрвээний өндөр

110-125 см. Угалз, хом хоёулаа эвэртэй бөгөөд угалзын эврийн урт дунджаар 101-138 см (Амгаланбаатар, 2013; Буянжаргал, 2016). Хаяа 170 см хүрнэ (Батсайхан нар, 2010). Угалзын эврийн угийн бүдүүн 44-57 см. Хомын эвэр харьцангуй богино бөгөөд нарийн, дунджаар 30-51 см урт (Амгаланбаатар, 2013). Өвлийн үс цайвар, зуны үс хүрэвтэр бор, цайвар (Батсайхан нар, 2010). 6-р сард гуужна.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Ховордож болзошгүй (NT).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Устаж болзошгүй (EN), A2acde; A3cde (Clark *et al.,* 2006).

2025 онд Эмзэг (VU), A2cde; B2b (iii; v). Монгол орны баруун бүсэд тархац нутгийн хэмжээ нь 2020 оны судалгаагаар, бодит байдлаас илүү тодорхойлогдсон талаарх баримт бий. Хэрвээ тархац нутгийн хэмжээ нь бодит байдлаас илүү том зураглагдаж үнэлэгдсэн бол төдий хэмжээгээр нөөц нь буруу үнэлэгдэнэ. Иймд 2020 оны судалгаагаар, тогтоогдсон нөөцийг харьцуулалт хийх боломжгүй, Монгол орны аргалийн нөөц сүүлийн 10 жилд хэрхэн өөрчлөгдсөн нь тодорхойгүй, нөөц нь өссөн гэх нотолгоогүй. Угалз агнуурын нэлээд олон бүс нутагт нөөц нь буруу тогтоогдож байсан баримт бий (БОАЖЯ, 2024).

Үнэлгээ хийсэн: С.Амгаланбаатар, О.Мөнхтогтох, П.Бямбадорж (2025).

Үнэлгээг хянасан: Ян.Адъяа (2025), С.Гомбобаатар.

Дэлхийн тархац. Орос, Казахстан, Узбекистан, Афганистан, Киргизстан, Пакистан, Тажикстан, Хятад, Энэтхэг, Балба, Бутан болон Монголд тархсан (Шагдарсүрэн нар, 1987; Шийрэвдамба нар, 1997; 2013).

Монгол орны тархац, амьдрах орчин. Одоогоор энэ зүйл говийн бүсийн умард хэсгээс хээр, ойт хээр, уулын тайгын өмнөд хэсэг хүртэлх Монгол Алтай, Говийн Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говийн уулс, Алашань говь, Дорнод говийн бэсрэг уулсаар тархсан (Банников, 1954; Соколов и Орлов, 1980). Мөн Төв халх, Дагуурын хээрийн зарим уулс, Хан Хөхийн нуруу, Хангайн нуруу, Хөвсгөлийн Арсайн гол орчим тасархайтсан популяциуд бий (Дуламцэрэн, 1970; Соколов и Орлов, 1980; Reading *et al.,* 1997). Монгол орны ихэнх нутгаар тасархайтсан байдлаар уулархаг нутаг, дов толгодоор тархсан. Энэ тархац нь өнгөрсөн хэдэн арван жил нэлээд тасархайтсан байна (Mallon *et al.,* 1997; Amgalanbaatar, Reading, 2000).



Аргаль нь хад асга багатай өндөр уулс, ухаа толгод, нам уулсаар байршина. Голлон үетэн, элдэв зүйлийн өвслөг ургамал, сонгинолог ургамлаар идээшилнэ. Өвлийн улиралд бутлаг, сөөглөг ургамал, хаг өвс иднэ (Амгаланбаатар, 2013).

Амьдралын онцлог. Өвлийн улиралд өдрийн турш, хавар намар, зуны улиралд өглөө оройд идээшилнэ. Сүрэглэн амьдарна. Намрын сүүл, өвлийн эхэн сард ороо хөөцөөний үедээ илүү олноор сүрэглэнэ. 10-11-р сард ороонд орох ба хээлээ тээх хугацаа нь 150 орчим хоног. Жилд нэг удаа төллөх ба ихэвчлэн 1, хааяа ихэр хурга гаргана. Бэлэг боловсролт 2-3 насандаа эхэлнэ. Байгалийн нөхцөлд 10-18 насална (Батсайхан нар, 2010).

Тоо толгой, нягтшил. 2006 оны үнэлгээнээс хойш Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газрын дэмжлэгээр 2009 онд зохион байгуулсан аргалийн нөөцийн судалгаагаар, Монгол орны хэмжээнд 50,215.3 км^2 нутаг дэвсгэрт тархсан бөгөөд 1,000 га-д 3.60 бодгаль нягтшилтайгаар 18,140 толгой нөөцтэй (Биологийн хүрээлэн, 2009; Амгаланбаатар нар, 2012) гэж үнэлжээ.

Мөн 2020 онд Монголын анчдын нийгэмлэгийн хийсэн судалгаагаар, Монголын орны 67,390.9 км^2 тархац нутагт 1,000 га-д 2.92 бодгаль нягтшилтай 19,691±814 толгой аргаль байгаа бөгөөд өмнөх 2009 оны судалгаатай харьцуулахад тархац нутгийн хэмжээ 34.2%-аар тэлж, тоо толгойн 8.6%-аар нэмэгдэж, нягтшил нь 0.7 бодгалиар буурсан (Монголын анчдын нийгэмлэг, 2020) гэж дүгнэжээ.

Аймгуудын хэмжээнд болон агнуурын бүс нутгуудад мэргэжлийн байгууллагууд хийдэг судалгааны явцад аргалийн нөөц тогтоосон байдал нь ихэнх тохиолдолд эргэлзээтэй. Ялангуяа Алтайн аргалийн тархац нутагт хийгдсэн мэргэжлийн байгууллагуудын хийсэн нөөцийн үнэлгээг магадлах шаардлага их гарч байгаагаас нөөцийн үнэлгээг тодорхой бус гэж үзэх үндэслэлтэй (Амгаланбаатар нар, 2000; БОАЖЯ, 2024).

Ховордлын шалтгаан. Хууль бус агнуур, тусгай зориулалтын агнуурын шинжлэх ухааны үндэслэлгүй ашиглалт энэ зүйлийн ховордлын гол шалтгаан болж байна (Amgalanbaatar *et al.,* 2000; БОАЖЯ, 2024). Түүний ховордлын зэргийг үл тоомсорлосноос угалзын олзворын агнуурын зөвшөөрлийн тоо өссөөр байна (Zahler *et al.,* 2004). Хууль бус агнуурын ихэнх хувийг нохойтой агналт эзэлж байна (Reading *et al.,* 2003, 2005; Julie *et al.,* 2011).
Монгол орны хэмжээнд сүүлийн 11 (2013-2023) жилийн хугацаанд хууль бус агнуурын 19 хэрэг хууль сахиулах байгууллагуудад бүртгэгдсэн (Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар, 2024).

Ган, зудаас шалтгаалан олон тоогоор хорогддог. Мөн малын тоо толгой өссөнөөр бэлчээр нутаг нь хумигдаж, талхлагдаж буй нь ховордлын шалтгааны нэг болж байна. Байгалийн нөөцийн олборлолтын үйл ажиллагаа (хариуцлагагүй уул уурхай) ихэссэнээс орчны хомсдол бий болж байгаа бөгөөд эдгээр нь аргальд ямар нөлөөлөл үзүүлж буйг нарийвчлан судлах шаардлагатай (Reading *et al.,* 2005; Wingard, 2010).

Хамгаалсан байдал. Монгол Улс 1953 оноос аргаль агнахыг хуулиар хориглож иржээ (Шийрэвдамба нар, 2013). Өдгөө Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, өсгөн үржүүлэх, хамгаалах харилцааг зохицуулж байна. Энэ хуульд заасны дагуу Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор баталсан Ховор амьтны жагсаалтад орсон бөгөөд ховор амьтныг (7.5) төрийн захиргааны төв байгууллагаас олгосон зөвшөөрлөөр (7.5.1) судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, эмчилгээний зориулалтаар, мөн (7.5.2) Монгол Улсын болон гадаадын иргэн тусгай төлбөр төлж, харин онцгой тохиолдол буюу (7.5.3) тодорхой нутаг дэвсгэрт амьтны сүргийн бүтцийг зохицуулах болон халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх зорилгоор тус тус агнаж, барьж болдог.

Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.7.1-д зааснаар угалзыг жил бүрийн 10 дугаар сарын 01-ний өдрөөс дараа оны 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд олзворын ангийн зориулалтаар агнах, мөн (9.8.1) аргалийг жил бүрийн 10 дугаар сарын 20-ны өдрөөс дараа оны 8 дугаар сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд судалгаа, шинжилгээнээс бусад тусгай зориулалтаар амьдаар барихыг тус тус хориглосон.

Мөн энэ хуулийн 10 дугаар зүйлд зааснаар (10.1.2) агнуурын амьтны жим дээр нүх ухах, буу сойх, занга, сааль тавих, (10.1.5) амьтныг агаарын болон авто тээврийн хэрэгслээр хөөх, гэрэлтүүлэх, (10.1.8) ан агнах зориулалтын бус буу, сум хэрэглэх зэрэг арга, зэвсэг хэрэгслээр амьтан агнах, барихыг хориглосон. Мөн (11.1.1) шуурга, ган, зуд, үер, мөндөр, түймэр зэрэг гамшигт нэрвэгдсэн болон гол, мөрөн, намаг, шаварт орох зэрэг биеэ хамгаалах чадваргүй болсон агнуурын амьтныг агнах, барих, (11.1.2) булаг, шанд, хужир мараанд ирж буй амьтныг отож агнах, (11.1.3) өөр нутагт шилжин байршиж байгаа агнуурын амьтныг агнах, барих, (11.1.7) амьтны үр төлийг агнах, шувууны өндгийг түүх, гэмтээх, устгах зэрэг олон үйл ажиллагааг хориглосон байдаг.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр аргаль 22,200,000 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу).

Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ын II хавсралт, Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)-ын II хавсралтад тус тус бүртгэгдсэн (Чимэддорж нар, 2018; http://checklist.cites.org). Мөн Монгол Улсын Улаан номд ховор зүйлээр оруулсан (Шийрэвдамба нар, 2013).

Төв Азийн орнуудын аргалийг хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан (UNEP/CMS, 2024) байдаг бөгөөд энэ төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/208 тоот тушаалаар “Аргаль хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөө (2025-2028)”-г батлуулжээ.

Энэ зүйлийн тархац нутгийн 30% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдсан.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийг хамгаалахын тулд дараах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Амьтны тухай хуульд өөрчлөлт оруулах замаар хамгаалах, зүй зохистой ашиглахтай холбоотой зохицуулалтыг орчин үед тавигдаж буй шаардлагад нийцүүлэх.
- Үндэсний түвшинд бодлогод чиглэсэн зүйлийг хамгаалах эрх зүйн баримт бичгийг боловсруулах.
- Аргалийг хамгаалах үндэсний менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг мэргэжлийн судлаачдын удирдлагаар хэрэгжүүлэх.
- Хамгааллын арга хэмжээг шинжлэх ухаанд тулгуурлан хэрэгжүүлэх, аргалийн популяцийн нөөц, байршил, биологийн болон экологийн судалгааг бүс нутаг бүрт хийх.
- Салбар зүйлүүдэд генетикийн судалгааг экологийн бүс бүрээс дээж авч хийх, гений санг бүрдүүлэх арга хэмжээг зохион байгуулах.
- Угалзыг тусгай зориулалтаар агнуулах тоо хэмжээг (квот) шинжлэх ухааны үндэслэлтэй, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх ан амьтны мэргэжлийн зөвлөлийн гаргасан дүгнэлт, саналыг харгалзан тогтоох, тухайлсан газарт тодорхой хугацаагаар хориглох.
- Агнуурын бүс нутгийн менежментийн үр ашигт байдал, өгөөжийн үнэлгээг жил бүр хийх, олон нийтэд танилцуулах.
- Ан агнуурт оролцогч талуудын ёс зүйн асуудалд анхаарах хэрэгтэй.

3.10. СҮҮЛЭРХЭГ БАГВААХАЙ

Myotis longicaudatus (Ognev, 1927)

Баг: Гардалавчтан (Chiroptera)
Овог: Багваахай (Vespertilionidae)
Англи нэр: Long-tailed Myotis
Ижил нэр: *Myotis frater longicaudatus*



Ангилал зүйн тойм. Өмнө нь *Myotis frater longicaudatus* гэх салбар зүйлээс бие даасан зүйл гэж үзэн салгасан *(Ruedi et al., 2015). M. l. longicaudatus* (Ognev, 1927), *M. l. eniseensis* (Tsytsulina and Strelkov, 2001), *M. l. kaguyae* (Imaizumi, 1956) салбар зүйлүүдтэй.

Таних шинж. Биеийн урт 45.0-51.1 мм, сүүлний урт 45.0-49.1 мм, шууны урт 38.8-40.3 мм, жин 7.0-7.8 г. Энэ зүйл багваахайн нуруу хүрэн бор, хэвлий бор саарал сортой бор, толгойн нүүрний хэсэг үсэрхэг (Ариунболд, 2018).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Монголд бүртгэгдээгүй байсан.

2025 онд Ховордож болзошгүй (NT). Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгой, хандлага, учирч буй аюул заналын талаарх мэдээлэл дутмаг. Популяцийн хэмжээ тодорхойгүй. Kazakov нар (2025) энэ

багваахай нь Палеарктикийн хамгийн ховор гардалавчтаны нэг гэж тэмдэглэжээ. Тархац нутгийн хэмжээ 20,000 км^2-аас ихгүй тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Ж.Ариунболд, Д.Мөнхнаст (2025).

Үнэлгээг хянасан: Н.Батсайхан (2025).

Дэлхийн тархац. Алтай, Сибирь, Байгаль нуур, Алс Дорнодын баруун Бурея гол, зүүн хойд Хятад, Солонгосын хойг, Хоккайдо аралд тархсан. *M. l. eniseensis* салбар зүйл нь Новосибирск орчим, Алтай, Красноярскын хязгаар, Хакаси, Тува, өвөр Байгаль орчимд тархдаг (Кожурина, 2009).

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол орны хувьд Хэнтий, Хангайд цөөн бодгаль бүртгэжээ. Ерөө голын саваас 2011 онд анх тэмдэглэснээс хойш Ивэнг болон Ерөө гол, Ноён уул, Балж голын савд энэ зүйлийг тэмдэглээд байна (Ариунболд, 2018; Dolch *et al.,* 2021а). Сэлэнгийн Шаамараас барьж тэмдэглэсэн (Росина, 2013). Сибирь шинэс (*Larix sibirica*), хавтага навчит хус (*Betula platyphylla*), азийн монос (*Padus asiatica*), бургас (*Salix sp.*), улиангар (*Populus tremula*),



улиас (*Populus sp.*) бүхий д.т.д 884-1,086 м өндөр орчинд тэмдэглэгдсэн. Ойт нутгуудаар (1.4) тархацтай бөгөөд ой тайга, ойт хээрт, голын хөндийн хадан хавцал, бургас дагаж амьдарна (Ариунболд, 2018).

Амьдралын онцлог. Биологи судлагдаагүй. Уулын тайгад амьдарч, агуйд ичээлнэ (Tsytsulina *et al.,* 2001).

Тоо толгой, нягтшил. Монгол оронд популяцийн тоо хэмжээ, нягтшилын судалгаа үгүй.

Ховордлын шалтгаан. Манай орны ойн сангийн хэмжээ буурч, ойн хөнөөлт шавжтай химийн аргаар тэмцэж байгаа нь сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Суурин амьдралтай, агуйд ичээлдэг энэ зүйлд мод огтлолт (1.3.3), хортон устгал (5.1), дэлхийн дулаарал (6.1.1), ойн түймэр (7.4), агуйн эвдрэлээс (7.7) үүдэлтэй амьдрах орчны алдагдал, эмгэг үүсгэгч (8.5), аялал жуулчлал (10.1) зэрэг нь сөрөг нөлөө үзүүлэх боломжтой.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн 25% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд (тухайлбал, Хан Хэнтийн дархан цаазат газар, Ноён уулын байгалийн нөөц газар, Онон-Балжийн байгалийн цогцолборт газар г.м) хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгой, хэмжээ (3.2), биологи, экологи (3.3), аюул занал (3.5), өөрчлөлтийн чиг хандлагын мониторинг судалгааг (3.9) нарийвчлан хийх шаардлагатай. Мөн тодорхой газруудыг шинээр хамгаалалтад авах, хамгаалалд чиглэсэн үйл ажиллагааг (4.4.1) зохион байгуулах нь зүйтэй.

3.11. БОРХОН ТУРСААХАЙ

Hypsugo stubbei (Dolch, Batsaikhan, Stubbe, Steinhauser, 2021)

Баг: Гардалавчтан (Chiroptera)
Овог: Багваахай (Vespertilionidae)
Англи нэр: Stubbe's Pipistrelle
Ижил нэр: Ижил нэр үгүй.



Ангилал зүйн тойм. Турсаахайн төрөлд Монгол орны баруун хэсгээс шинжлэх ухаанд шинээр тэмдэглэгдсэн зүйл. Генетикийн хувьд Палеарктикийн баруун, зүүн хэсэгт тархсан *H. alaschanicus, H. savii* зүйлийн популяциас 8-11%-ийн ялгаатай нь нотлогдсон (Dolch *et al.,* 2021c). Монгол дахь энэ зүйлийн биологи, экологи, этологи, салбар зүйлийн судалгааг лавшруулах шаардлагатай.

Таних шинж. Биеийн урт 55 мм, шууны урт 33-36 мм. Биеийн хэмжээгээр Алшаа турсаахайгаас бага зэрэг том боловч бусад нийтлэг гадаад шинж, толгойн яс үл ялгарна. Чих, хоншоор, сарьс хар хүрнээс хар. Чих өндгөрхүү, ирмэг дугариг. Нуруун талын үс элсэн шаргал, өехий цагаан саарлаас цагаан ба үсний уг харавтар. Морфологийн ялгаа байхгүй учир Алшаа турсаахайгаас ялгахад хэцүү (Dolch *et al.,* 2021c).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Үнэлгээ хийгдээгүй.

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Монголд бүртгэгдээгүй байсан.

2025 онд Ховордож болзошгүй (NT). Монгол орны амьтны аймагт шинээр нэмэгдэж буй зүйл бөгөөд Монгол орны баруун хэсэгт цөөн байршилд тэмдэглэгдсэн. Тархац, популяцийн хэмжээ, хандлага, учирч буй аюул заналын талаарх мэдээлэл дутмаг. Говь цөлийн баянбүрд, булаг шандаас ундаалах тул гадаргын усны хомсдол тоо толгойд нь нөлөөлнө.

Үнэлгээ хийсэн: Ж.Ариунболд, Д.Мөнхнаст (2025).

Үнэлгээг хянасан: Н.Батсайхан (2025).

Дэлхийн тархац. Казахстанаас тэмдэглэгдсэн *Hypsugo savii caucasicus* салбар зүйл нь Монголд тархсан *Hypsugo stubbei* байж болох хэдий ч генетикийн дүн шинжилгээний мэдээлэл дутагдалтай. Одоогоор зөвхөн Монгол оронд тархсан (Dolch *et al.,* 2021c).

Монгол орны тархац, амьдрах орчин. Манай орны баруун хэсэгт Булган гол, Хар-Ус нуур, Монгол Алтайн уулс, Алтайн өвөр говь, Зүүнгарын говь орчимд тархана. Цөлөрхөг хээр, хээр (4.4.) болон өндөр уулсын экосистемд улиас, бургас (3.4.) бүхий амьдрах орчинд тархана. Хойд Цэнхэрийн агуй (7.1) нь энэ зүйл турсаахайн ичээ байх магадлалтай. Энэ зүйлийн тархац Алшаа турсаахайн тархац нутагтай зарим хэсэгт давхацна (Dolch *et al.,* 2021c).



Амьдралын онцлог. Хээрийн судалгааны явцад 7-р сарын дунд 10 хоногт Монгол орны баруун хэсэгт эр бодгалиудын бөөгнөрөл бүртгэгдсэн. Хойд Цэнхэрийн агуй орчимд дан ганц бие гүйцсэн эр бодгалиуд баригдсан. Мөн зулзагалсан эм бодгаль болон залуу эм турсаахай тэмдэглэгдсэн нь тархац нутгийнхаа хүрээнд үржлийн популяци байгааг илтгэнэ. Агуйд ичээлдэг эсэх нь тодорхойгүй. Зун буюу 7-р сард эр, эм бодгалиуд тусдаа амьдардаг бололтой. Биологи, экологийн талаарх мэдээлэл дутмаг бөгөөд судлах шаардлагатай.

Тоо толгой, нягтшил. Монгол оронд 4 ялгаатай байршилд 11 бодгаль тэмдэглэгдсэн. Манай оронд цөөн тоогоор тэмдэглэгдсэн, хязгаарлагдмал тархалттай, ховор зүйл (Dolch *et al.,* 2021c) бөгөөд Монгол дахь популяцийн хэмжээ, хандлага тодорхойгүй.

Ховордлын шалтгаан. Амьдрах орчны алдагдал (1), уул уурхай (1.3.1), дэлхийн дулаарал (6.1.1), ган (7.1), шуурга (7.2), гадаргын усны хомсдол (7.7), аялал жуулчлал (10.1.) зэрэг нөлөөлөх боломжтой. Учирч буй аюул занал, ховордлын шалтгаан бүрэн тодорхой болоогүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн 25% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд (тухайлбал, Говийн Их дархан цаазат газар, Булган гол-Их Онгог, Мөнххайрхан, Хар-Ус нуурын байгалийн цогцолборт газрууд г.м) хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгой, хэмжээ (3.2), биологи, экологи (3.3), аюул занал (3.5), өөрчлөлтийн чиг хандлагын мониторинг судалгааг (3.9) нарийвчлан хийх шаардлагатай. Мөн тодорхой газруудыг шинээр хамгаалалтад авах, түүнд чиглэсэн үйл ажиллагааг (4.4.1) хэрэгтэй.

3.12. АЛТАЙН ТАРВАГА

Marmota baibacina (Kastschenko, 1899)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Хэрэм (Sciuridae)
Англи нэр: Altai Marmot
Ижил нэр: Grey Marmot



Ангилал зүйн тойм. Ангилал зүй өөрчлөгдөөгүй.

Таних шинж. Биеийн урт 65 см, сүүлний урт 13 см, хойд хөлийн тавхайн урт 7-9 см, жин 6-8 кг. Биеийн гадаад төрхөөрөө Монгол тарвагатай төстэй бөгөөд харьцангуй бие томтой. Зулай, шанаа нь хар бараан. Үс ноолуур өтгөн, сахлаг, сор үсний үзүүр нь тод бараан харагдана. Сүүлний дээд хэсгийн зүс нурууны өнгөтэй ижил зэрэг шинжүүдээр Монгол тарваганаас ялгагдана.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Ховордож болзошгүй (NT).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Clark *et al.,* 2006).

2025 онд Ховордож болзошгүй (NT). Сүүлийн 4 жилд тоо толгой нэмэгдсэн тухай судалгааны мэдээ бий. Мөн Монгол Алтайн өндөр уулсын хээрт тоо толгой элбэг, нягтшил өндөр боловч бага хэмжээний нутагт хязгаарлагдмал тархацтайг үндэслэн энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: С.Шар, Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, Э.Ундрахбаяр, Р.Самъяа (2025).
Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Хятад (Шинжаан), Казахстан, Киргизстан, Орос, Монгол Алтайд тархсан (Batbold *et al.,* 2016).

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол орны баруун бүсэд хязгээрлагдмал тархсан, энэ зүйлийн тархац нутаг нь *M. sibirica* зүйлийн тархац нутгаас Буянт голоор тусгаарлагдана. Монгол Алтайн Булган голын сав, Улаагчны даваа, Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын Буянт гол, Ховд голын сав, Ачит нуур, Бөхмөрөн сумаас баруун ба баруун урагш тархсан (Дуламцэрэн нар, 1989). Өндөр уулын хээр (6), тагийн нуга (3.4), уулс хоорондын хөндий зэргээр байршина (Адъяа, 2000).



Амьдралын онцлог. Бүлийн амьдралтай, өдрийн идэвхтэй. Ургамлын ногоон хэсгээр хооллоно. Өвлийн улирлыг ичээндээ өнгөрүүлнэ. Ороо нийллэг 3-р сарын дунд үед ичээнээс гарсны дараа 1-2 долоо хоног үргэлжилнэ. Тарч 30-35 хоног хээлээ тээж, дунджаар 4-5 мөндөл төрүүлнэ. Бэлгийн боловсролт 3-4 настайдаа гүйцнэ. Алтайн тарвага 5 жил орчим насална. Хошхирох дуу нь нарийн шингэн.

Тоо толгой, нягтшил. Баян-Өлгий аймгийн Хатуугийн нуруу болон Сайр хайрхан уулын тарвага тархсан 131,406 га талбайд 33,720 тарвага тархан байршиж байгааг 2020 онд тогтоожээ. Харин 2024 онд энэ тоо 105,645 га талбайд 37,690 бодгаль болж өөрчлөгдсөн байна (Биологийн хүрээлэн, 2024). Элбэг тархацтай нутгийн 9 дээж талбайн 100 га тутамд дунджаар 46 бүл, нэг бүлд дунджаар 1.8 бодгаль тархсан нягтшилтай байжээ. Ховор буюу 100 га талбайд 1-10 бүлтэй ангилалд нийт 126 дээж талбайн 100 га тутамд 6 бүл, нэг бүлд дунджаар 1.4 бодгаль оногдох нягтшилтай байв (Биологийн хүрээлэн, 2024). Харин 2024 оны хээрийн судалгаагаар, элбэг тархацтай нутгийн 10 дээж талбайн 100 га тутамд дунджаар 41 бүл, нэг бүлд дунджаар 1.75 бодгаль тархсан нягтшилтай, мөн ховор тархацтай нутгийн 100 га талбайд 4.6 бүл, нэг бүлд дунджаар 2.1 бодгаль оногдох нягтшилтай болж өөрчлөгдсөн байна (Адъяа нар, 2024).

Ховордлын шалтгаан. Арьс, махыг хэрэглээний зорилгоор олон улсад худалдаалдаг бөгөөд 2004 онд 66,000 толгойг агнасан тухай баримт бий (Wingard and Zahler, 2006). Өнөө үед арьсыг олон улсад худалдаалахгүй ч уламжлалт анагаах ухаанд (3.2.1) цөсийг, махыг нь хүнсэнд (3.1.1) ашиглах зорилгоор хараа хяналтгүй хууль бусаар агнана (3.1). Малын тоо толгой өссөнөөс бэлчээр талхлагдаж (1.1.4.1) түүний амьдрах орчин доройтох (1.1.4) хандлагатай. Ирвэс, үнэг, чоно, гэрийн нохой, цармын бүргэд зэрэг байгалийн махчин амьтад (8.2) энэ зүйлийн өсөлтөд нөлөөтэй.

Монгол орны хэмжээнд сүүлийн 11 (2013-2023) жилийн хугацаанд хууль бус агнуурын 39 хэрэг хууль сахиулах байгууллагуудад бүртгэгдсэн (Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар, 2024).

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, өсгөн үржүүлэх, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд тухайлбал, энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3-д зааснаар тарвагыг жил бүрийн 10 дугаар сарын 16-ны өдрөөс дараа оны 8 дугаар сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон.

Үүнээс гадна, (10.1.4) тарвагыг нүхэнд нь утах, ус цутгах, хавх, урхи тавих, нохойгоор зориудаар бариулах, (10.1.5) амьтныг агаарын болон авто тээврийн хэрэгслээр хөөх, гэрэлтүүлэх, (10.1.8) ан агнах зориулалтын бус буу, сум хэрэглэх зэрэг арга, зэвсэг хэрэгслээр агнах, барихыг хориглож, мөн (11.1.3) өөр нутагт шилжин байршиж байгаа агнуурын амьтныг агнах, барих, (11.1.4) амьтны үүр, ичээ ухах, гэмтээх, (11.1.7) агнуурын амьтны үр төлийг агнах, ангийн буу, агнуурын амьтан агнах, барих гэрээ, зөвшөөрөл, эрхийн бичгийг бусдад шилжүүлэх, (11.1.9) тарвага, зурам, тэдгээрийн түүхий мах, нойтон болон халдваргүйжүүлээгүй арьсыг хот, тосгонд оруулах, (11.1.10) хот, тосгоны ногоон бүсэд судалгаа шинжилгээ, халдварт өвчний голомт эрүүлжүүлэх, ан амьтны тоо толгойг зохицуулахаас бусад зорилгоор агнуурын амьтан агнах, барих, (11.1.12) эрх бүхий мэргэжлийн байгууллагаар агнуур зохион байгуулалтын ажлыг хуульд заасан хугацаанд нь хийлгээгүй аймаг, сум, нийслэл, дүүргийн нутагт агнуурын амьтан агнах, барих зэрэг үйл ажиллагааг хориглосон байдаг.

Мөн түүнчлэн энэ хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д зааснаар (25.3) ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тухайн сум дахь байгаль хамгаалагч гарал үүслийн тодорхойлолт олгох бөгөөд энэ тодорхойлолт аваагүй амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах, худалдан авахыг хоригложээ.

Иргэн ахуйн зориулалтаар гурав хүртэл хонгийн хугацаатай (28.3.1), таван ширхгээс илүүгүй (28.4) тарвага агнах нэг удаагийн эрхийн бичиг авах боломжтой. Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Алтайн тарвага 460,000 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Дашрамд дурдахад, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар 2017 оноос хойш тарвагыг ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар агнахыг түр хугацаагаар удаа дараа хориглож ирсэн боловч тус сайдын 2023 оны А/453 дугаар тушаалаар хүчингүй болгожээ.

Энэ зүйлийн тархац нутгийн 25% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн тоо толгой, нягтшилын мониторинг судалгаа (3.9), популяцийн тоо, хэмжээ (3.2) зэргийг үндэслэн хамгаалах арга хэмжээг тодорхойлох шаардлагатай. Тархац нутаг багатай тул хэт агналтаас үүдэн популяцийн хэмжээ багасаж тоо толгойн цөөрөх эрсдэлтэй.

3.13. ГОЗООРОЙ ЗУРАМ

Spermophilus alashanicus (Buechner, 1888)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Хэрэм (Sciuridae)
Англи нэр: Alashan Ground Squirrel
Ижил нэр: *S. dilutus*, *S. obscurus*, *S. siccus* (Wilson and Reeder, 2005).



Ангилал зүйн тойм. Монголд *S. a. dilutus* салбар зүйл тохиолдоно. Төв Азийн эндемик зүйл.

Таних шинж. Биеийн урт 230 мм, сүүл 70 мм (Батсайхан нар, 2022). Биеийн галбир, төрхөөрөө бусад зурмын адил. Сүүл ойролцоогоор биеийн уртын 1/3-д хүрнэ. Зоо нурууны зүс бор сааралдуу шаргал. Биеийн хажуу, хэвлий, шанаа цайвар бор, сор үсний төгсгөл бор. Сүүлний дээд хэсэг нэгэн жигд цайвар шаргал, төгсгөл хэсэг нь захаараа цайвар эмжээртэй. Хойд тавхай сийрэг үсээр бүрхэгдсэн.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Устаж болзошгүй (EN) (Clark *et al.,* 2006).
2025 онд Ховордож болзошгүй (NT). Тархац нутаг хязгаарлагдмал, өөр хоорондоо тусгаарлагдсан боловч тархац нутгийнхаа хүрээнд тоо толгой ховор биш учир Ховордож болзошгүй гэж үнэлэв.
Үнэлгээ хийсэн: Р.Самъяа, Н.Батсайхан, С.Шар, Д.Лхагвасүрэн, Э.Ундрахбаяр (2025).
Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Төв Хятадын хойд хэсэг (Smith and Yan 2013), Зүүн Нань Шань, Алашаа цөлийн хойд, зүүн хэсэг (Соколов и др., 1996) болон Монголд тархсан (Банников, 1954; Даваа, 1972).

Монгол орны тархац, амьдрах орчин. Говь Алтайн нурууны Их, Бага Богд, Арц, Гурвансайхан, Нууруудын хөндий рүү түрж орсон Өшөг уулсаар тархсан (Банников, 1954; Даваа, 1972). Өмнөговь аймгийн Тэс сумын Тост, Ноён сумын Саран хөндийд (Ундрахбаяр, аман мэдээ) бүртгэгджээ. Говь цөлийн дундах өндөр уулын хуурай хээр, хээрийн (4.4, 8.2) дэгнүүлт үетэн, алаг өвс, шарилж зонхилсон хад чулуурхаг энгэр бэлээр амьдарна.



Амьдралын онцлог. Ихэвчлэн ганцаар, эргэн тойрондоо дошгүй ганц амсартай нүхэнд амьдарна. Гозоорой зурам дуу гаргахгүй учир анзаарагдах нь бага. Нүхний амсрыг өвсөөр далдлах нь бий. Намар 10-р сараас дараа оны 4-р сар хүртэл ичнэ. Ичээнээс гарсны дараа үржилд орж, хээлээ 28 орчим хоног тээгээд 4-6 гөлчгий төрүүлнэ. Хоёр настайгаасаа үржилд орно. Сонгинолог ургамлаар голлон хооллоно. Идэш тэжээлийн бүрэлдэхүүнд шавж орно. Машинд дайрагдсан огдойн зэмээр хооллох тохиолдол Гурвансайханд ажиглагдаж байв.

Тоо толгой, нягтшил. Тархац нутгийнхаа аль ч хэсэгт цөөн тохиолдох ховор зүйл. Тоо толгой, нягтшилын холбогдолтой мэдээлэл хомс.

Ховордлын шалтгаан. Ховордлын шалтгааныг илэрхийлэх бодит мэдээлэл, судалгаа одоогоор дутмаг (1.4.10) байна. Мах идэшт амьтдын тоо толгой өссөний улмаас нягтшил багатай энэ зүйл золиос болох нь элбэг (8.3) учир ховордлын нэг шалтгаан байж болзошгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуульд нэн ховор амьтнаар орсон бөгөөд төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр зөвхөн эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх зориулалтаар агнаж, барьж болно (7.2). Үүнээс бусад зориулалтаар нэн ховор амьтныг агнаж бэлтгэсэн арьс, яс, бусад түүхий эдийг худалдах, худалдан авахыг хориглодог (7.3).

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр гозоорой зурам 7,500 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Мөн Монгол Улсын Улаан номд нэн ховор зүйлээр бүртгэгджээ (Шийрэвдамба нар, 2013).

Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд (тухайлбал, Тост, Тосон бумбын нурууны байгалийн нөөц газар, Их Богд уул болон Говь Гурвансайханы байгалийн цогцолборт газруудад) хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн популяцийн төлөв байдал, үржил, амьдрах орчны талаарх судалгааг (3.2-3.5) нарийвчлан хийх шаардлагатай.

3.14. ХӨХВӨР ОЛБИ

Pteromys volans (Linnaeus 1758)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Хэрэм (Sciuridae)
Англи нэр: Siberian Flying Squirrel
Ижил нэр: *P. ognevi*, *P. russicus*, *P. Sibiricus* (Wilson and Reeder, 2005). *P. anadyrensis* Ognev, 1940; *P. arsenjevi* Ognev, 1935; *P. athene* Thomas, 1907; *P. gubari* Ognev, 1935; *P. incanus* Miller, 1918; *P. ognevi* Stroganov, 1936; *P. sibiricus* Desmarest, 1822 (pro volans Linnaeus); *P. turovi* Ognev, 1929; *P. vulgaris* Wagner, 1842 (Павлинов и Лисовский, 2012).



Ангилал зүйн тойм. Ангилал зүйн өөрчлөлтийн талаарх баримт байхгүй.

Таних шинж. Биеийн урт 130-205 мм, сүүлний урт 90-140 мм, тавхайн урт 30-39 мм, жин 90-170 г. Галбир төрх хэрэмтэй төсөөтэй. Нүд бүлтгэр. Биеийн хажуугаар хойд, өмнөд мөчдийг холбосон сул арьсан унжлагатай. Зоо нуруу мөнгөлөг бор саарал, хэвлий цайвар. Сүүл саглагар, дээд тал нь улбар саарал. Чих хулгар, үзүүртээ урт үсгүй.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Ховордож болзошгүй (NT).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Clark *et al.,* 2006).

2025 онд Ховордож болзошгүй (NT). Популяцийн тоо толгойн өөрчлөлтийн талаарх мэдээлэл хангалтгүй байна. Хөхвөр олбийн амьдрах гол орчин болох хушин ойд самар түүх, ойн цэвэрлэгээнд өртөх зэргээр хүний үйл ажиллагааны хөндлөнгийн нөлөө ихсэж байгааг үндэслэн Ховордож болзошгүй гэж үнэлэв.

Үнэлгээ хийсэн: С.Шар, Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, Э.Ундрахбаяр, Р.Самъяа (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Беларусь, Хятад, Эстони, Финлянд, Япон, Өмнөд Солонгос, Хойд Солонгос, Латви болон Монголд тархсан (Hanski *et al.,* 2016).

Монгол орны тархац, амьдрах орчин. Хэнтий, Хангай, Хөвсгөл, Монгол Алтайн баруун хэсгийн ойд тархана (Дуламцэрэн нар, 1989). Монгол орны ой, тайга (1.1), хуш, шинэсэн ой, хус улиангарт холимог ойд байршмал.



Амьдралын онцлог. Бүрэнхий, харанхуйд идэвхтэй. Өвөл ичдэггүй. Модлог ургамлын нахиа, найлзуур, самар, боргоцойн үр, хус, улиангарын холтос зэргээр хооллох ба өвлийн нөөц тэжээлд хусны үр голчлон хураана. Хөгшин бүдүүн модны хонгилд тоншуул, хэрэмний орхисон үүрэнд орогноно. Ихэвчлэн шинэс, хус, улиангард оромж нь тохиолдоно. 3-р сард үржилд орно. Жилд нэг удаа 2-4 гөлчгий төрүүлнэ. Байгалийн нөхцөлд 5 хүртэл жил амьдарна (Соколов, 1973; Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Тоо толгой, нягтшилын мэдээ хангалттгүй.

Ховордлын шалтгаан. Энэ зүйлийн тархцын зарим нутагт байгалийн (7.4) болон хүний тавьсан түүмэр (10.5), ойн сийрэгжүүлэх тайралтаас (1.3.3.3) үүдсэн амьдрах орчны хомсдол (1.1.1.3) бий болжээ. Сүүлийн жилүүдэд самар түүгчид (3.1.3) амьдрах орчинд нь сөрөг нөлөө үзүүлж байна.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр хөхвөр олби 5,000 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 36% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Популяцийн төлөв, үржил, амьдрах орчин (3.1-3.5), тоо толгойн өөрчлөлтийн хандлагыг судалж (3.9), хамгаалах арга хэмжээг боловсруулах шаардлагатай. Мөн энэ зүйлийн тархац нутаг нь ойн тархацтай давхацдаг тул ой хамгаалах, нөхөн сэргээх (4.2) менежменттэй уялдуулан хамгаалах нь чухал.

3.15. ЗҮЛГИЙН ОГОТНО

Alexandromys limnophilus (Buechner, 1889)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Шишүүхэй (Cricetidae)
Англи нэр: Lacustrine Vole
Ижил нэр: *Microtus limnophilus*



Ангилал зүйн тойм. Өмнө нь энэ зүйл *Microtus* төрөлд хамаардаг байсан бөгөөд одоо *Alexandromys* төрөлд хамаарах болсон (Liu *et al.,* 2016).

Таних шинж. Биеийн урт 98-129 мм, сүүл 32-47 мм, жин 60 г. Биеийн нуруун тал боровтор туяатай цайвар саарал, шаргалдуу саарал эсвэл шаргал туяатай бор саарал. Сүүлний дээд, доод талын өнгө үл мэдэг ялгаатай (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Clark *et al.,* 2006).

2025 онд Ховордож болзошгүй (NT). Энэ зүйлийн тархац хязгаарлагдмал, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хомс.

Ус, намгархаг, чийглэг газрын ойролцоо тархах бөгөөд хуурайшилт, бэлчээр ашиглалтын нөлөө их тул Ховордож болзошгүй гэж үнэлэв.
Үнэлгээ хийсэн: Э.Ундрахбаяр, Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, С.Шар, Р.Самъяа (2025).
Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Хятад болон Монголд тархсан (Batsaikhan and Smith, 2016; Stubbe, 2016).

Монгол орны тархац, амьдрах орчин. Их нуурын хотгор, Нууруудын хөндий, Монгол Алтай, Говь Алтайн нурууны зааг, Алтайн өвөр говь, Зүүнгарын говьд тархсан (Clark *et al.,* 2006; Батсайхан нар, 2022). Хуурай хээр, цөлжүү хээр, хэт гандуу цөлийн (8.3) хотгор, цайдам зэрэг нам дор газар тохиолдоно.



Амьдралын онцлог. Цөлөрхөг, цөлжүү хээрийн нуур, булаг, шанд, баянбүрд орчмын чийглэг, хужирлаг хөндий, цайдам дагаж амьдарна. Ургамлын ногоон хэсгээр хооллоно. Хээл тээх хугацаа 21-23 хоног.

Эхний төл тэр жилдээ үржилд орж, дунджаар 4-6 гөлчгий гаргана. Нийлмэл бүтэцтэй нүхэнд орогноно (Батсайхан нар, 2022).

Тоо, толгой, нягтшил. Энэ зүйлийн тоо толгой, нягтшилын талаар мэдээлэл хангалтгүй.

Ховордлын шалтгаан. Малын тоо толгой өссөнөөр бэлчээр талхлагдаж, улмаар орчны доройтол нүүрлэж байна. Уул уурхайн үйл ажиллагаанаас (1.3.1) үүдэлтэй орчны бохирдол, дэлхийн дулаарлаас (6.1.1) шалтгаалсан ган гачиг (7.1), булаг шанд хатаж, ширгэх нь тус зүйлд сөргөөр нөлөөлнө

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр зүлгийн оготно 3,800 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 29% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн биологи, экологийн (3.3) судалгаан дээр үндэслэн популяцийн тоо толгой, хэмжээ, хандлага (3.2), амьдрах орчны статус (3.4) зэргийг тогтоох, мөн амьдрах орчныг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагааг (4) хэрэгжүүлэх нь чухал.

3.16. СОКОЛОВЫН ШИШҮҮХЭЙ

Cricetulus sokolovi Orlov and Malygin, 1988

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Шишүүхэй (Cricetidae)
Англи нэр: Sokolov's Dwarf Hamster
Ижил нэр: Бүрдийн шишүүхэй



Ангилал зүйн тойм. Ангилал зүйн өөрчлөлтийн талаарх мэдээлэл байхгүй.

Таних шинж. Биеийн урт 77-114 мм, сүүлний урт 18-32 мм, хойд тавхайн урт 13-18 мм, чихний урт 13-18.5 мм. Биеийн жин 60 г хүрнэ. Биеийн нуруун тал шаргалдуу туяа бүхий саарал, хэвлий нь цайвар-саарал, хэвлийн үсний уг бараавтар-саарал. Сүүлний дээд тал нурууны өнгөтэй ижил, доод тал цагаан бөгөөд тэдгээрийн хил хязгаар тодорхой ялгагдахгүй. Хойд тавхайн ул цагаан бөгөөд нүцгэн (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Clark *et al.,* 2006).

2025 онд Ховордож болзошгүй (NT). Нууруудын хөндийгөөс Дорнод говь хүртэл харьцангуй уудам нутагт тархах боловч энэ зүйлийн популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаар судалгааны баримт бага.

Үнэлгээ хийсэн: Э.Ундрахбаяр, Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, С.Шар, Р.Самъяа (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Хятад болон Монголд тархсан (Batsaikhan and Smith, 2016).

Монгол орны тархац, амьдрах орчин. Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, Умард говь, Алашань говь, Дорнод говиос олдсон (Орлов и Мальгин, 1988). Цөл, цөлжүү хээр (8.2), хуурай хээрийн экосистемд амьдрах бөгөөд элсэрхэг хөрстэй аараг толгод, хотгор, цайдам, баянбүрд, хөндий, тэгш газар бараадан амьдарна (Батсайхан нар, 2022).



Амьдралын онцлог. Говь цөлийн бүсэд задгай усны ойролцоох дэрс, харгана бүхий ургамалжилттай газруудад байршина. Шөнийн идэвхтэй. Хоёр амсартай гүн биш нүхэнд орогноно. Өвөл ичихгүй ба их хэмжээний хөөе хураана. Өвслөг ургамлын үр, шавжаар хооллоно.

Жилд 2-3 удаа төрнө. Төрөх бүрдээ 4-9 гөлчгий төрүүлнэ. Байгалийн нөхцөлд 2 жил орчим амьдарна (Батсайхан нар, 2022).

Тоо, толгой, нягтшил. Энэ зүйлийн тоо толгой, нягтшилын талаарх баримт хомс.

Ховордлын шалтгаан. Булаг шандын ширгэлт, татралт, ган гачиг энэ зүйлийн хорогдлын шалтгаан болно. Мөн дэлхийн дулаарал (6.1.1), уул уурхайн үйл ажиллагаа (1.3.1), түүнийг дагасан хүний сөрөг нөлөө нэмэгдэж болзошгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Соколовын шишүүхэй 4,000 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 14% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн популяцийн хэмжээ, хандлага, учирч буй аюулыг нарийвчлан судлах, мөн уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой амьдрах орчны статус (3.4) хэрхэн өөрчлөгдөж байгааг биологи, экологийн (3.3) судалгаа дээр үндэслэн тодорхойлох шаардлагатай.

3.17. СУХАЙН ЧИЧҮҮЛ

Meriones tamariscinus (Pallas, 1773)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Хулгана (Muridae)
Англи нэр: Tamarisk Gerbil
Ижил нэр: Ижил нэргүй.



Ангилал зүйн тойм. Дэд төрлийн ялгарал нь эр бодгалийн үржлийн эрхтний морфологи онцлогоор илэрхийлэгдэх (Tsytsulina *et al.,* 2016) бөгөөд нийт 4-5 салбар зүйлтэй.

Таних шинж. Биеийн урт 180 мм, сүүл 160 мм, жин 160 г. Зоо нуруу, хажуу талаар бор шаргал, хул хонгор, хэвлий цагаан. Сүүлний дээд, доод өнгө тод ялгардаг. Сүүлний үзүүрийн үс бийр маягийн цацаг үүсгэнэ. Тавхайн үс бараан. Нүдний дээр том цагаан толботой. Төрөл дотроо бие томтой зүйл (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Устаж болзошгүй (EN) (Clark *et al.,* 2006).

2025 онд Ховордож болзошгүй (NT). Сүүлийн жилүүдэд энэ зүйл чичүүлийн талаар мэдээ баримт нэмэгдэж байна. Мөн тархац нутаг дотроо тоо толгой хэвийн боловч түүний тархац нутаг нь хязгаарлагдмал тул ховордож болзошгүй гэж үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Э.Ундрахбаяр, Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, С.Шар, Р.Самъяа (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Казахстан, Киргизстан, Орос, Тажикстан, Туркменистан, Узбекистан, Хятад болон Монголд тархсан (Tsytsulina *et al.,* 2016).

Монгол орны тархац, амьдрах орчин. Зүүнгарын говьд Булган гол, Бодончийн голын адаг, Ёлхон, Тахийн ус, Мянган, Алтайн өвөр говийн Аж Богдын баруун бэл зэрэг цөөн газраас олдсон (Дуламцэрэн, 1969; 1970; Соколов и Орлов, 1980; Самъяа нар, 1993). Хээржүү цөл, хэт гандуу цөлийн (8.3) дагжуур хөрстэй баянбүрд, заг, сухайн төгөл нь энэ зүйлийн гол амьдрах орчин болно (Соколов и Орлов, 1980).



Амьдралын онцлог. Өвөл өдөр, зун шөнийн идэвхтэй. Үржлийн насны бодгалиуд тусдаа амьдарна. Дулааны улиралд ургамлын ногоон, шүүслэг хэсгээр хооллоно. Өвөл, хавар, намар орой үндэс, иш, үрээр хооллоно. Үржлийн үе хавар 3-4-р сараас намар 9-р сар хүртэл үргэлжилнэ. Жилд 2-3 төрөх бүртээ 4-7 гөлчгий гаргана. Мод, сөөгийн доогуур олон амсартай нийлмэл нүх ухаж орогноно (Батсайхан нар, 2022).

Тоо, толгой, нягтшил. Энэ зүйлийн тоо толгой, нягтшилын талаар мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Говь цөлийн бүсийн баянбүрдийг бараадсан уламжлалт нүүдлийн мал аж ахуй (1.1.4.1) нь сөргөөр нөлөөлж байгаа бөгөөд ялангуяа тэмээ зэрэг амьтад нь сухайн бутыг идэж цөлмөх, талхлах зэргээр амьдрах орчны хомсдолыг бий болгож байна. Мөн заг, сухай, харгана зэрэг модлог, бутлаг ургамлыг түүж түлшинд хэрэглэх (1.3.3.1) нь мөн сөрөг нөлөөтэй. Дэлхийн дулаарлаас (6.1.1) үүдэлтэй ган гачиг (7.1), булаг, шанд хатаж, ширгэх нь энэ зүйлийн хорогдлын гол шалтгаан болж байна.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан. Энэ хуульд нэн ховор амьтнаар оруулсан бөгөөд төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр зөвхөн эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх зориулалтаар агнаж, барьж болно (7.2). Үүнээс бусад зориулалтаар нэн ховор амьтныг агнаж бэлтгэсэн арьс, яс, бусад түүхий эдийг худалдах, худалдан авахыг хориглосон (7.3).

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр сухайн чичүүл 7,000 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу).

Мөн Монгол Улсын Улаан номд нэн ховор зүйлээр бүртгэгдсэн (Шийрэвдамба нар, 2013). Энэ зүйлийн тархац нутгийн 54% орчим нь улсын тусгай хамгаалалтай газар нутгийн сүлжээнд (тухайлбал, Говийн Их дархан цаазат газрын “Б” хэсэг г.м) хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн тархац нутаг, популяцийн хэмжээ, хандлага (3.2), биологи, экологи (3.3), амьдрах орчны сонголт, статус (3.4) зэргийг нарийвчлан судалж, үүний үндсэн дээр хамгааллын менежментийн арга хэмжээг тодорхой төлөвлөж, хэрэгжүүлэх тухайлбал, тусгай хамгаалалттай газар нутгийн хууль, эрх зүйн орчин, онгон төрхийг хадгалах, ховор амьтдыг хамгаалахын ач холбогдлыг сурталчлан таниулахад чиглэсэн мэдлэг, боловсролыг нутгийн иргэд, олон нийтэд олгох (2.2), түгээн дэлгэрүүлж соён гэгээрүүлэх шаардлагатай.

3.18. ОЙН ХУЛГАНА

Apodemus uralensis (Pallas, 1811)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Хулгана (Muridae)
Англи нэр: Ural Field Mouse
Ижил нэр: Уралын хулгана, *Mus uralensis*; Herb Field Mouse.



Ангилал зүйн тойм. Ангилал зүйн хувьд *A. peninsulae, A. sylvaticus* зүйлтэй андуурагдах нь түгээмэл (Kryštufek *et al.,* 2016).

Таних шинж. Биеийн урт 120 мм, сүүл 110 мм, бие гүйцсэн бодгалийн жин 60 г. Төрөл дотроо биеэр бага. Нуруун талын өнгө бор хүрэн, хааяа саарал дэвсгэр өнгөтэй ижил элсэн шаргал, хэвлий цагаан. Хэвлийн үс угаараа цайвар. Хумс нь цайвардуу шар. Сүүл их биеийн нурууны хэсэгтэй адил бөгөөд нэгэн жигд. Сүүлний төгсгөлд цацаг үс муу илэрнэ. Хойд тавхай уландаа үстэй. Сонсголын хэнгэрэг яс сайн хөгжсөн (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Монголд бүртгэгдээгүй байсан.

2025 онд Ховордож болзошгүй (NT). Энэ зүйлийн манай орны нутагт хамаарах тархац хязгаарлагдмал боловч тархаж байгаа нутагтаа элбэг тохиолдоно. Популяцийн хэмжээ, өөрчлөлт, хандлага, учирч буй аюул заналын талаарх мэдээлэл одоогоор хангалтгүй байгаа учир ховордож болзошгүй зэрэглэлд үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Д.Лхагвасүрэн, С.Шар, Н.Батсайхан, Э.Ундрахбаяр, Р.Самъяа (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Армен, Австри, Азербайжан, Беларусь, Болгар, Хятад, Хорват, Чех, Эстони, Гүрж, Унгар, Энэтхэг, Иран, Исламын Бүгд Найрамдах Улс, Казахстан, Киргизстан, Латви, Литва, Молдова, Монтенегро, Балба, Польш, Румын, Орос, Серби, Словак, Турк, Украин, Монголд тархсан (Kryštufek *et al.,* 2016).



Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол Алтай, Зүүнгарын говийн уулсын сийрэг шинэсэн ойн төгөл (1.4) болон голын шугуйгаар тархжээ (5.1). Ойн цоорхой, огтолсон ой, бут сөөгтэй газар илүү байршина. Өвлийн улиралд орон байр, агуулахад орогнох нь элбэг (Батсайхан нар, 2022).

Амьдралын онцлог. Ургамлын үр, жимсээр голчлон хооллоно. Идэш тэжээлээ нөөцөлж, далдална. Жилд 2-3 удаа төллөж, нэг удаад 4-6 зулзага төрүүлнэ. 3 сарын дараа бэлэг боловсорно. Өвөл ичээлэхгүй (Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Тоо толгой, нягтшилын талаарх судалгаа мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Тодорхойгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр ойн хулгана 3,600 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 93% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн популяцийн тоо толгой, нягтшил (3.2), ангилал зүй (3.1), биологи, экологи (3.3) болон аюул заналын (3.5) нарийвчилсан судалгааг хийх шаардлагатай.

3.19. СООТОН АЛАГДААХАЙ

Euchoreutes naso (Sclater, 1891)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Алагдаахай (Dipodidae)
Англи нэр: Long-eared Jerboa
Ижил нэр: *Eu. alashanicus, Eu. yiwuensis*



Ангилал зүйн тойм. Ангилал зүйн талаар нэмэлт өөрчлөлт байхгүй.

Таних шинж. Биеийн урт 74-110 мм, сүүлний урт 131-185 мм, тавхайн урт 36-61 мм, чихний урт 34-51 мм. Жин 23-45 г хүрнэ. Чихний урт биеийн уртын хагастай дүйнэ. Зоо нуруу халиун саарал, биеийн хажуу тал болон хэвлий цагаан. Сүүлний үзүүрийн цацаг үсний уг болон үзүүр нь цагаан, дунд хэсэг нь хар бараан. Хойд мөчид 5 хуруутай (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Эмзэг (VU) (Clark *et al.,* 2006).

2025 онд Ховордож болзошгүй (NT). Монгол орны өмнөд нутагт илрэх хэт гандуу цөл, жинхэнэ цөлийн экосистемд тохиолддог. Элбэг бус бөгөөд харьцангуй хязгаарлагдмал тархац нутагтай. Сайрга, чулуут цөлийн өвөрмөц амьдрах орчин шүтэн амьдардаг, тархац нутгийн нэлээд хэсэг нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдсан тул ховордож болзошгүй зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, Р.Самъяа, Э.Ундрахбаяр, С.Шар (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Хятад болон Монголд тархсан (Clark *et al.,* 2006).



Монгол орны тархац, амьдрах орчин. Алтайн өвөр говь болон Алашань цөлд тархсан. Жинхэнэ цөл, хэт гандуу цөлийн (8.3) сайрга, чулуут сийрэг элдэв сөөг зонхилсон сайр хоорондын тэгш дэнж, нам уулс болон толгод хоорондын хөндий, хармагийн сондуулт цайдам хотгорт тохиолдоно (Батсайхан нар, 2022).

Амьдралын онцлог. Бүрэнхий, шөнө идэвхтэй. Өвөл ичээлнэ. Нүх ухаж орогноно. Идэш тэжээлийн зонхилох хэсгийг хатуу далавчтан шавж, тэдгээрийн авгалдай бүрдүүлнэ. Жилд нэг удаа төрж 2-6 зулзага төрүүлнэ (Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Монгол орны хэт гандуу болон жинхэнэ цөлийн экосистемд тархсан, харьцангуй элбэг тохиолдох зүйл.

Ховордлын шалтгаан. Цөлийн бүсийн уул уурхайн үйл ажиллагаа (1.3.1), уур амьсгалын өөрчлөлтөөс улбаатай жил дараалсан ган гачиг (7.1) нөлөөлж байж болзошгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр соотон алагдаахай 7,000 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд (тухайлбал, Говийн Их дархан цаазат газрын “А” хэсэг, Тост, Тосонбумбын нурууны байгалийн нөөц газар, Говийн Бага дархан цаазат газрын “А” хэсэг г.м) хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Түүний тархац нутгийн хүрээг тэлэх боломжтой тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд өргөтгөл хийх (4.4.4) нь хамгааллын чухал арга хэмжээ болно.

3.20. ЗҮҮНГАРЫН ДААХАЙ

Stylodipus sungorus (Sokolov and Shenbrot, 1987)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Алагдаахай (Dipodidae)
Англи нэр: Mongolian Three-toed Jerboa
Ижил нэр: Three-toed Jerboa



Ангилал зүйн тойм. Зүүнгарын даахайн араа шүдний эгнээний урт болон суурь хэсгийн өргөн, сонсголын хэнгэргийн хэмжээ зэрэг үзүүлэлтээр *Stylodipus telum* зүйлээс ялгаатай (Holden and Musser, 2005).

Таних шинж. Биеийн урт 125-130 мм, сүүлний урт 150-165 мм, хойд тавхайн урт 54-58 мм, жин 85-90 г. Нуруун тал бараавтар элсэн саарал бөгөөд ийм зүс нь биеийн хойд хэсэгт илүү тодорхой ажиглагдана. Хэвлий цагаан. Сүүлний дээд тал сааралдуу шаргал, нурууны өнгөнөөс тод. Сүүлний үзүүрийн цацаг бор саарал. Хойд тавхайн дээд тал нь богино цагаан үстэй, доод тал нь хар бараан. Чихний арын цагаан толбо, гуяны цагаан зурвас зэрэг нь даахайг таних чухал шинж болно (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Устаж болзошгүй (EN) (Clark *et al.,* 2006).

2025 онд Ховордож болзошгүй (NT). Зүүнгарын цөлд харьцангуй уудам тархацтай, элбэг зүйл бөгөөд тархац нутгийн дийлэнх хэсэг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдсан зэрэг үзүүлэлтийг үндэслэн, ховордож болзошгүй хэмээн үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, Р.Самъяа, Э.Ундрахбаяр, С.Шар (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Хятад болон Монголд тархсан (Clark *et al.,* 2006).

Монгол орны тархац, амьдрах орчин. Зүүнгарын говь тархсан. Элсэрхэг, хайргалаг хөрстэй, сийрэг ургамалтай сөөгт цөл, цөлжүү хээрийн экосистемд (8.3) амьдарна (Батсайхан нар, 2022).



Амьдралын онцлог. Шөнө идэвхтэй. 5-6 м орчим урттай нүх ухаж орогноно. Өвөл ичээлнэ. Идэш тэжээлийн зонхилох хэсгийг ургамлын үр, шавж эзэлнэ. Ичээнээс гарсны дараа үржилд орно. Жилд 1 удаа төрж 3-4 зулзага төрүүлнэ (Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Зүүнгарын даахайн тархац нутаг уудам, элбэг зүйл.

Ховордлын шалтгаан. Ховордох шалтгаан тодорхой бус.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуульд нэн ховор амьтнаар орсон бөгөөд төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр зөвхөн эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх зориулалтаар агнаж, барьж болно (7.2). Үүнээс бусад зориулалтаар нэн ховор амьтныг агнаж бэлтгэсэн арьс, яс, бусад түүхий эдийг худалдах, худалдан авахыг хориглосон (7.3). Мөн (7.4) нэн ховор амьтны амьдрах нутагт хүнд үйлдвэр, цахилгаан станц, химийн үйлдвэр байгуулах, авто болон төмөр зам тавих, уул уурхайн олборлолт явуулах, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх асуудлыг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлтийг үндэслэн Засгийн газар шийдвэрлэдэг.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Зүүнгарын даахай 7,200 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Мөн Монгол Улсын Улаан номд нэн ховор, унаган зүйлээр бүртгэгдсэн (Шийрэвдамба нар, 2013).

Энэ зүйлийн тархац нутгийн 77% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд (тухайлбал, Говийн Бага дархан цаазат газрын “Б” хэсэг г.м) хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн тархац нутгийн хүрээг тэлэх боломжтой улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд өргөтгөл хийх (4.4.4) нь хамгаллын чухал арга хэмжээ болно.

3.21. ХЯРС

Vulpes corsac (Linnaeus, 1758)

Баг: Мах идэштэн (Carnivora)
Овог: Чоно (Canidae)
Англи нэр: Corsac Fox
Ижил нэр: Хярс үнэг (Дуламцэрэн, 2003); *V. kalmkorum*, *V. nigra*, *V. scorodumovi*, *V. turkmenica* (Wilson and Reeder, 2005).



Таних шинж. Биеийн урт 50-60 см, сүүлний урт 25-36 см, чихний урт 6-9 см, жин 2-3 кг. Зүс хул шаргалдуу саарал. Сор үсний үзүүр цагаан тул мөнгөлөг туяатай. Нуруун тал нь хүрэвтэр. Өвчүү болон хэвлий шаргал туяа бүхий цайвар. Сүүл богино, үзүүр нь хар. Чихний ар тал биеийн зүстэй ижил. Өвлийн үс тод улаан шаргал, зуны үс улбар цайвар. Эр, эм бодгалийн биеийн хэмжээ, жин ялгаатай (Мөнхзул, 2013).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Ховордож болзошгүй (NT) (Clark *et al.,* 2006).

2025 онд Ховордож болзошгүй (NT). Монгол оронд нэлээд өргөн тархсан зүйл бөгөөд тархац нутгийн хэмжээнд хараа хяналтгүй агналт их (Wingard and Zahler, 2006) ба одоогийн популяцийн хэмжээ, хандлагын

талаарх мэдээ баримт хомс. Nowak (1991) энэ зүйлийн нэг үе удмын үргэлжлэх хугацаа дөрвөн жил, хил залгаа улсаас мэдэгдэхүйц нүүдэл, суурьшил тодорхойгүй тул 2006 онд ховордож болзошгүй хэмээн үнэлж байсан. Харин 2025 онд бүс нутгийн популяцийн хэмжээ тодорхойгүй ч хулгайн агнуурт ихээр өртдөг болон ховордлын шалтгаан хэсэгт дурдсан хүчин зүйлсээс хамааран тоо толгой нь буурах эрсдэл их байгаа тул дээрх үнэлгээг хэвээр үлдээв.

Үнэлгээ хийсэн: Ц.Мөнхзул (2025).

Үнэлгээг хянасан: Б.Мөнхцог (2025).

Дэлхийн тархац. Орос, Иран, Казахстан, Туркменистан, Узбекистан, Афганистан, Тажикстан, Хятад, Киргизстан болон Монголд тархсан (Nowak, 1991).

Монгол орон дахь тархац, амьдрах орчин. Монгол орны ихэнх нутгаар өргөн тархсан бөгөөд хээр, цөлөрхөг хээрийн бүсээр их тохиолдоно. Алтайн өвөр говь, Зүүнгарын говь, Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, Хангай, Хөвсгөл, Дорнод Монгол, Дундад Халх, Дагуур, Дорнод говьд хааяагүй тархсан. Бүх хэв шинжийн хуурай хээр, цөлөрхөг хээрийн шилжилтийн хэв шинж бүхий дэрст сайр, хад чулуут бэсрэг уулсын сайр, цөлөрхөг хээр, цөлжүү хээр, цөлийн экосистемд түгээмэл тохиолдоно (Мөнхзул, 2013).



Амьдралын онцлог. Голдуу бүрэнхийн гүйдэлтэй ч идэш тэжээл дутмаг, өвлийн ид хүйтэн, төл бойжуулах үедээ өдрөөр ч тохиолдоно. Хосоор амьдарна. Монгол тарвага, доргоны эзэнгүй нүх ашиглана. Жижиг хөхтөн ялангуяа, үлийн цагаан оготно, жижиг шувууд, тарваганы мөндөл, туулай, огдой, түүнчлэн шулуун далавчит шавж зэргээр хооллоно. Өвлийн улиралд хярсны идэш тэжээлд сэг зэмийн эзлэх хувь ихэснэ. Бие гүйцсэн хярсны эзэмшил нутгийн дундаж хэмжээ 4.52 ± 0.75 км^2. Эр, эмийн байршил нутгийн хэмжээ улирал, жилээр өөрчлөгдөнө (Мөнхзул, 2013). Ороо нийллэг 2-р сард болно. Хээл тээх хугацаа 50-60 хоног. Жилд нэг удаа төрж дунджаар 3-6 гавар төрүүлнэ. Гаврууд намар болтол эхтэйгээ амьдарч бүл сална. Гуужилт 3-4-р сард эхэлж, 10-11-р сард үс хөрс бүрэн гүйцэж ноолууржина. Байгалийн нөхцөлд 6-7 жил насална. Хярсны төллөх, гавраа бойжуулах үе нь үлийн цагаан оготнын үржлийн үетэй давхацдаг тул уг оготнын хэт олшролыг хязгаарлах, экосистемийн тогтвортой байдлыг хадгалахад чухал үүрэгтэй (Цэнджав, 1974).

Тоо толгой, нягтшил. Тоо толгой, нягтшилын талаарх мэдээ баримт хомс.

Ховордлын шалтгаан. Үслэг арьс, мах, зарим эд эрхтнийг хараа хяналтгүй худалдаалах, хууль бус агнуур, халдварт өвчин, амьдрах орчны доройтол зэргээс шалтгаалан цөөрсөөр байна (Wingard and Odgerel, 2001). Амьтны тухай хуулиар хярсыг намрын сүүлчээс өвлийг дуустал зөвшөөрдөг ч улирал харгалзахгүй агнасаар байна (Wingard *et al.,* 2019). Уул уурхайн үйл ажиллагаа өргөжсөнөөс амьдрах орчны хомсдол бий болж байна.

Мөн дэлхийн дулаарал, бүс нутгийн байгалийн онцлогоос шалтгаалсан олон сараар үргэлжлэх шороон шуурга, тарваганы хэт агналтаас үүдэн амьдралын зарим мөчлөгт нүхний хамааралтай амьдардаг амьтдын нүх оромж нь элс шороогоор дүүрч, битүүрэх явдал ихээхэн ажиглагдах болсон. Энэ нь хярс үүрлэн орогнох, дайсан амьтнаас биеэ хамгаалах, үржлийн идэвхтэй үедээ ашигладаг амьдралын таатай орчных нь нэгээхэн хэсэг дам байдлаар устаж үгүй болж байна (Myagmarjav *et al.,* 2016). Гэрийн нохойнд дайруулахаас гадна, галзуу, хамуу өвчинд нэлээд өртөмтгий (Гептнер и др., 1967; Мөнхзул, 2013).

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан. Тухайлбал, энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2-т зааснаар хярсыг жил бүрийн 2 дугаар сарын 11-ний өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон. Үүнээс гадна, (10.1.2) агнуурын амьтны жим дээр нүх ухах, буу сойх, занга, сааль тавих, (10.1.5) амьтныг агаарын болон авто тээврийн хэрэгслээр хөөх, гэрэлтүүлэх, (10.1.8) ан агнах зориулалтын бус буу, сум хэрэглэх зэрэг арга, зэвсэг хэрэгслээр агнах, барихыг хориглодог. Мөн амьтныг (11.1.1) шуурга, ган, зуд, үер, мөндөр, түймэр зэрэг гамшигт нэрвэгдсэн болон гол, мөрөн, намаг, шаварт орох зэрэг биеэ хамгаалах чадваргүй болсон үед агнах, барих, (11.1.3) өөр нутагт шилжин байршиж байгаа агнуурын амьтныг агнах, барих, (11.1.4) амьтны үүр, ичээ ухах, гэмтээх зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглосон.

Амьтны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д зааснаар (21.1) ан агнах зөвшөөрөл бүхий иргэн зохих төлбөр төлж, сумын Засаг даргаас авсан эрхийн бичгийн дагуу агнуурын ховор амьтнаас бусад амьтныг өөрийн ахуйн зориулалтаар агнаж, барьж болно. Гэхдээ энэ хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д зааснаар (25.3) ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тухайн сум дахь байгаль хамгаалагч гарал үүслийн тодорхойлолт олгодог бөгөөд энэ тодорхойлолт аваагүй амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах, худалдан авахыг хориглосныг анхаарах нь зүйтэй.

Мөн Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр хярс 190,000 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу).

Энэ зүйлийн тархац нутгийн 12% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдсан. 2000 оны эхээр үлийн цагаан оготнын тоо толгойг зохицуулахад хэрэглэж байсан бромадиолон зэрэг химийн хорт бодист дам өртөж хорогдох нь элбэг байсан бол 2004 онд энэ төрлийн химийн бодисын хэрэглээг хязгаарлах зөвлөмж гарснаар (Долгормаа, 2004) энэхүү шалтгаанаар хорогдох эрсдэлийг эрс бууруулсан.

Хамгаалах арга хэмжээ. Хамгаалах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Энэ зүйлийн тархац нутаг, популяцийн тоо толгой, хэмжээ, хандлага (3.2), биологи, экологийн (3.3.) судалгааг нарийвчлан хийж, шинжлэх ухаанд тулгуурласан хамгаалллын арга хэмжээг тусгайлан төлөвлөж, хэрэгжүүлэх нь зүйтэй.
- Зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2) арга хэмжээг зохион байгуулах, мөн хууль бус агнуурыг хянах тогтолцоог сайжруулах, энэ зүйлийн экосистемд үзүүлэх ач холбогдлын талаар сурталчлан таниулах
- Энэ зүйлийг хамгаалах, тархац нутгийг нь тэлэх нэг боломж нь тарвага нутагшуулах ажил юм. Хярсны амьдрах орчны сонголт тарваганы хуучин нүх, айлын байршлаас шууд хамааралтай. Тарваганы хуучин нүх нь хярсны үүрлэх, дайсан амьтнаас амиа хамгаалах, үүрний орчинд ургах бут сөөгтэй газар нь нуугдах хоргодоход таатай орчин болдог (Мөнхзул, 2013) тул тарваганы популяцийг хамгаалах, нөхөн сэргээх арга замаар энэ зүйлийг хамгаалах боломжтой (Murdoch *et al.,* 2009).
- Мэрэгчид, хортон шавжийн тоо толгойн хэт олшролыг хязгаарлаж, тогтвортой байлгах, хадлан бэлчээрийг хамгаалах, тариалангийн ургацыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой амьтан тул энэ зүйлийн тоо толгойг тогтмол тодорхойлж, улмаар зүй зохистой хамгаалах арга хэмжээг авч байх чухал.

3.22. ҮНЭГ

Vulpes vulpes (Linnaeus, 1768)

Баг: Мах идэштэн (Carnivora)
Овог: Чоно (Canidae)
Англи нэр: Red Fox
Ижил нэр: Шар үнэг; *V. alba*, *V. barbarus*, *V. Fulvus* (Wilson and Reeder, 2005).



Таних шинж. Биеийн урт 70-90 см, сүүлний урт 40-60 см чихний урт 9-11см, жин 5-10 кг. Сүүл урт, өтгөн үстэй, үзүүр нь цагаан. Хоншоор урт, шөвгөр. Чих соотон бөгөөд үзүүр нь шовх, чихний ар тал хар. Өвлийн үс улаан шаргал, зуны үс цайвардуу саарал. Өвчүү, хэвлий цагаан. Мөчид харьцангуй урт, бараан зүстэй. Эр, эм нь биеийн хэмжээ, жингээрээ ялгаатай (Мөнхзул, 2013).

Үнэлгээ ба үндэслэл
Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).
Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Ховордож болзошгүй (NT) (Clark *et al.,* 2006).
2025 онд Ховордож болзошгүй (NT). Монгол оронд нэлээд өргөн тархсан зүйл бөгөөд тархац нутгийн хэмжээнд хараа хяналтгүй агналт их байгаа (Wingard and Zahler, 2006) ба одоогийн популяцийн талаарх баримтгүй. 2025 онд бүс нутгийн популяцийн хэмжээ тодорхойгүй ч ховордлын шалтгаан бүлэгт дурдсан шалтгаануудын улмаас тоо толгойн буурах эрсдэл их тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Ц.Мөнхзул (2025).
Үнэлгээг хянасан: Б.Мөнхцог (2025).
Дэлхийн тархац. Евроази, Африкийн хойд хэсэг, Канад, Америкт тархсан (Nowak, 1991).

Монгол орон дахь тархац, амьдрах орчин. Монгол оронд өргөн тархсан ч сийрэг нягтшилтай. Хэнтий, Хөвсгөлийн уулархаг нутаг, Хангайн нурууны баруун өмнөд болон зүүн хойд хэсэг, Орхон, Сэлэнгэ голын сав, Дорнод Монголын хээр, Монгол Алтай, Говь Алтай нуруугаар их элбэг тохиолдоно (Банников, 1954; Дуламцэрэн, 1970; Соколов и Орлов, 1980; Мөнхзул, 2013).



Амьдралын онцлог. Өдөр шөнө аль ч үед ч тохиолдох боловч үүр бүрэнхийд гүйдэлтэй. Ихэвчлэн тарвага, хярс, доргоны эзэнгүй нүх, хадны хонгил зэрэгт хорогдоно. Жижиг хөхтөн ялангуяа, үлийн цагаан оготно, жижиг шувууд, тарваганы мөндөл, туулай, огдой, түүнчлэн шулуун далавчит шавж зэргээр хооллоно. Ороо нийллэг сэрүүн бүсэд 4-р сард, говь цөлийн бүсэд 2-3-р сард болно. Хээл тээх хугацаа 49-58 хоног. Жилд нэг удаа төллөж дунджаар 4-6 гавар төрүүлнэ. Гаврууд намар болтол эхтэйгээ амьдарч бүл сална. Төллөх, гавраа бойжуулах хугацаа нь үлийн цагаан оготнын үржлийн хугацаатай давхацдаг (Цэнджав, 1974). Гуужилт 3-р сараас эхэлж, 10-11-р сард үс хөрс бүрэн гүйцэж ноолууржина. Бие гүйцсэн бодгалийн эзэмшил нутгийн дундаж хэмжээ 15.44 ± 2.16 км^2. Эр, эмийн байршил нутгийн хэмжээ нас, улирал, жилээр ялгаатай (Мөнхзул, 2013). Байгалийн нөхцөлд 6-7 жил насална.

Тоо толгой, нягтшил. Тоо толгой, нягтшилын талаарх тодорхой мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Үслэг арьс, мах, зарим эд эрхтнийг хараа хяналтгүй худалдаалах, хууль бус агнуур, халдварт өвчин, амьдрах орчны доройтол зэргээс шалтгаалан цөөрсөөр байна. Дэлхийн дулаарал, дэд бүтцийн хөгжил, уул уурхайн үйл ажиллагаа өргөжсөнөөр түүний тархац, амьдрах орчинд сөргөөр нөлөөлөх болсон. Гэрийн нохойнд дайруулахаас гадна, галзуу, хамуу өвчинд нэлээд өртөмтгий (Гептнер и др., 1967; Мөнхзул, 2013).

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2-т зааснаар үнэгийг жил бүрийн 2 дугаар сарын 11-ний өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдөр ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон. Агнуурын амьтны жим дээр нүх ухах, буу сойх, занга, сааль тавих, (10.1.5) амьтныг агаарын болон авто тээврийн хэрэгслээр хөөх, гэрэлтүүлэх, (10.1.8) ан агнах зориулалтын бус буу, сум хэрэглэх зэрэг арга, зэвсэг хэрэгслээр агнах, барихыг хориглодог. Мөн амьтныг (11.1.1) шуурга, ган, зуд, үер, мөндөр, түймэр зэрэг гамшигт нэрвэгдсэн болон гол, мөрөн, намаг, шаварт орох зэрэг биеэ хамгаалах чадваргүй болсон үед агнах, барих, (11.1.3) өөр нутагт шилжин байршиж байгаа агнуурын амьтныг агнах, барих, (11.1.4) амьтны үүр, ичээ ухах, гэмтээх зэрэг үйл ажиллагааг хоригложээ. Амьтны тухай хуулийн 28.1-д зааснаар (21.1) ан агнах зөвшөөрөл бүхий иргэн зохих төлбөр төлж ахуйн зориулалтаар агнаж, барьж болно. Гэхдээ энэ хуулийн 12.1-д зааснаар (25.3) ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах, худалдан авахыг хориглосон. Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр үнэг 220,000 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг. Тархац нутгийн 13% орчим нь улсын тусгай хамгаалалттай газарт хамрагдсан. Үлийн цагаан оготнын тоо толгойг зохицуулахаар хэрэглэсэн бромадиолон зэрэг химийн хорт бодист дам өртөж хорогдох нь элбэг байсан бол 2004 онд энэ төрлийн химийн бодисын хэрэглээг хязгаарлах зөвлөмж гарснаар (Долгормаа, 2004) тус шалтгаанаар хорогдох эрсдэлийг эрс бууруулсан.

Хамгаалах арга хэмжээ. Хамгаалах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Тархац нутаг, популяцийн тоо толгой, хэмжээ, хандлага (3.2), биологи, экологийн (3.3.) судалгааг нарийвчлан хийж, хамгааллын арга хэмжээг тусгайлан төлөвлөж, хэрэгжүүлэх нь зүйтэй.
- Зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2) арга хэмжээг зохион байгуулах, мөн хууль бус агнуурыг хянах тогтолцоог сайжруулах, энэ зүйлийн экосистемд үзүүлэх ач холбогдлын талаар сурталчлан таниулах нь зүйтэй.

3.23. СААРАЛ ЧОНО

Canis lupus (Linnaeus, 1758)

Баг: Мах идэштэн (Carnivora)
Овог: Чоно (Canidae)
Англи нэр: Grey Wolf
Ижил нэр: *C. albus*, *C. ater*, *C. chanco* (Wilson and Reeder, 2005).





Таних шинж. Биеийн урт 100-160 см, сүүлний урт 35-50 см, чихний урт 9-12 см, жин 18-80 кг. Монгол орны саарал чоно үл мэдэг шаргал туяа бүхий цайвар саарал. Нурууны голыг дагасан хар бараавтар сор үстэй. Бадриун зэгзгэр мөчтэй. Шүд нь нэлээд том, хүчирхэг, ялангуяа соёо сайн хөгжсөн (Батсайхан нар, 2022). Бие гүйцсэн эрэгчин нь эмэгчнээсээ биеийн хэмжээ, жингээр илүү (Ууганбаяр, 2024).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Ховордож болзошгүй (NT) (Clark *et al.,* 2006).

2025 онд Эмзэг (VU). Популяцийн нягтшил, тархац, эзлэн амьдрах нутгийн хэмжээ тодорхойгүй (Wingard and Zahler, 2006). Nowak (1991) чонын нэг үе удмын хугацааг 6 жил гэж тогтоожээ. Популяцийн хэмжээний бууралт нь ихэнхдээ хараа хяналтгүйгээр агнах, халдварт өвчинд нэрвэгдэх шалтгаанаас үүсэлтэй. Энэ зүйлийн тоо толгойн буурч буй нь тодорхой боловч хэдий хэмжээгээр буурч байгааг тодорхойлох нь нэлээд төвөгтэй.

Харин 2025 онд Монгол орны нийт нутгаар тархсан. Популяцийн хэмжээ тодорхойгүй ч буурах хандлагатай. Хамгаалллын арга

хэмжээ авч хэрэгжүүлэхгүй бол хэсэгчлэн устах эрсдэл өндөр. Тал, хээрийн чонын популяци эрс буурч зарим нутагт үзэгдэхээ больсон. Хүн болон чонын зөрчил их, мөн түүнчлэн жил бүр 200-300 чонын арьс, эд эрхэн болон бүтэн чоныг хөлдөөсөн байдлаар хилээр гаргахыг завддаг, чонын авын уралдаан зарлагддаг зэргийг үндэслэн энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Г.Уганбаяр, Х.Тунгалагтуяа (2025).

Үнэлгээг хянасан: Б.Мөнхцог, С.Гомбобаатар (2025).

Дэлхийн тархац. Голдуу Ази, Европ, Америк, Канадын онгон зэрлэг зэлүүд нутгаар тархжээ (Mech and Boitani, 2004).

Монгол орон дахь тархац, амьдрах орчин. Монгол орны ихэнх нутгаар өргөн тархсан бөгөөд Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Их Хянган, Монгол Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, Дорнод говь, Говь Алтайн нуруу, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь болон Алашань говийн бүс нутагт тархжээ. Зэрлэг туурайтан, малын бэлчээрийг дагаж улирлаар байршлаа сэлгэнэ. Гэвч ихэвчлэн хүний нөлөөнөөс зайдуу бартаа хоргодоц сайтай газар байршин амьдарна (Батсайхан нар, 2022). Уулын харанхуй бөглүү хөвч тайгаас бут сөөгт цөл хүртэл хаана ч амьдарч чадах боловч тоо толгой хувьд хамгийн элбэг өсөх нь ойт хээр болон тал хээр юм (Банников, 1954).



Амьдралын онцлог. Гэрийн мал, зэрлэг туруутан, мэрэгчид, туулайтан, жижиг шувууд, тэдгээрийн өндөг, ангаахай, дэгдээхэй, амьтны сэг зэм, ургамлын үр жимс зэргээр хооллоно. Ороо нийллэг өвөл ид хүйтнээр эхэлж, орооны үед нэг гичийг хэд хэдэн азарган чоно дагана. Гичий хээлээ 62-65 хоног тээнэ. 5, 6-р сард тусгайлан зассан нүх буюу хадны хонгил, агуйд дунджаар 6-8 бэлтрэг төрүүлнэ. Ихэвчлэн үүрийн бүрэнхий, харанхуйгаар гөрөөлнө. Байгалийн нөхцөлд 15-16 хүртэл жил насална (Батсайхан нар, 2022). Говийн бүсэд хийсэн судалгаагаар, бие гүйцсэн азарган чоно 26,619 км^2, бие гүйцсэн гичий чоно 6,670 км^2 нутаг эзэмшдэг (Kaczensky *et al.,* 2004) бол уулын хээр, хээрийн бүсэд бие гүйцсэн азарган чоно 2,035 ± 1,386 км^2, бие гүйцсэн гичий чоно 615±744 км^2 нутаг эзэмшиж байлаа (Уганбаяр, 2024).

Тоо толгой, нягтшил. ШУА-ийн Биологийн хүрээлэн 1980-аад онд Монгол орны хэмжээнд 40 гаруй мянга саарал чоно бий хэмээн тооцоолж байсан бол сүүлд Монгол оронд 10,000-аас цөөн бодгаль байж болох юм (Mech and Boitani, 2004) гэж үзсэн. Чонын тоо толгой хэт олширч мал аж ахуйд ихээхэн хохирол учруулж, зарим тохиолдолд хүн рүү дайрах аюултай боллоо хэмээн малчид гомдол гаргаж, зарим аймагт саарал чоныг хоморголон агнахыг орон нутгийн засаг захиргаанаас зохион байгуулах болсон тул Монгол Улсын хэмжээгээр экосистемд чухал ач холбогдолтой энэхүү амьтны нийт тархац нутагт судалгаа хийж тоо толгойг нь нарийвчлан тодорхойлж, улмаар зохистой ашиглах, хамгаалах арга хэмжээг нягтлан төлөвлөх шаардлагатай.

Ховордлын шалтгаан. Монголчуудын голлох амин зуулга болох малд халдан довтолж малчдын амьжиргаанд сөргөөр нөлөөлнө. Үүнээс үүдэн ихэвчлэн хууль бусаар агнадаг. Сүүлийн үед зарим аймгууд нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд чонын популяцийн судалгаа хийсэн ч тухайн судалгаанд зөв арга зүй ашигласан эсэх нь тодорхойгүй. Аймгийн байгаль орчны газар тэрхүү чонын тоо толгойн үр дүнг үндэслэн аймгийнхаа хэмжээнд агнуур зохион байгуулах нь түгээмэл болоод байна. Малын тоо толгой огцом өссөнөөр зэрлэг амьтад бэлчээрээс шахагдаж, чонын ангуучлах амьтдын (халиун буга, хандгай, бор гөрөөс, аргаль, цагаан

зээр, тарвага, хулан, хар сүүлт зээр г.м) тоо толгой буурсан нь түүний идэш тэжээлийн нөөцөд сөргөөр нөлөөлөх болсон. Галзуу, хамуу, боом зэрэг зоонозын өвчнүүд нь зарим популяцид нөлөөлөх аюултай. Ийм өвчин тархсан үед тухайн бүсийн чонын тоо огцом буурдаг. Монгол дахь чонын экологи, генетик олон янз байдлын талаар хангалттай нарийвчилсан судалгаа хийгдээгүй байгаа нь хамгааллын үр дүнтэй бодлого боловсруулахад хүндрэл учруулж байна.

Монгол орны хэмжээнд сүүлийн 11 (2013-2023) жилийн хугацаанд хууль бус агнуурын 8 хэрэг хууль сахиулах байгууллагуудад бүртгэгдсэн (Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар, 2024) боловч бодит байдал дээр хууль бусаар агнагдсан чонын тоо харьцангуй их байх өндөр магадлалтай.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд тухайлбал, энэ хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2-т агнуурын амьтны жим дээр нүх ухах, буу сойх, занга, сааль тавих, (10.1.5) амьтныг агаарын болон авто тээврийн хэрэгслээр хөөх, гэрэлтүүлэх, (10.1.8) ан агнах зориулалтын бус буу, сум хэрэглэх зэрэг арга, зэвсэг хэрэгслээр агнах, барихыг хориглосон. Мөн (11.1.1) шуурга, ган, зуд, үер, мөндөр, түймэр зэрэг гамшигт нэрвэгдсэн болон гол, мөрөн, намаг, шаварт орох зэрэг биеэ хамгаалах чадваргүй болсон агнуурын амьтныг агнах, барих, (11.1.3) өөр нутагт шилжин байршиж байгаа агнуурын амьтныг агнах, барих, (11.1.4) амьтны үүр, ичээ ухах, гэмтээх, (11.1.7) амьтны үр төлийг агнах, шувууны өндгийг түүх, гэмтээх, устгах зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглодог. Амьтны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д зааснаар (21.1) ан агнах зөвшөөрөл бүхий иргэн зохих төлбөр төлж, сумын Засаг даргаас авсан эрхийн бичгийн дагуу агнуурын ховор амьтнаас бусад амьтныг өөрийн ахуйн зориулалтаар агнаж, барьж болно. Гэхдээ энэ хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д зааснаар (25.3) ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тухайн сум дахь байгаль хамгаалагч гарал үүслийн тодорхойлолт олгодог бөгөөд энэ тодорхойлолт аваагүй амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах, худалдан авахыг хориглосныг анхаарах нь зүйтэй. Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр саарал чоно 1,130,000 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн 13% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдсан. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ын II хавсралтад бүртгэгдсэн (Чимэддорж нар, 2018; http://checklist.cites.org).

Хамгаалах арга хэмжээ

- Монгол Улсад чоныг агнахыг зөвшөөрдөг ч хяналт сул байдгаас хууль бус агнуурт ихээхэн өртөж байна. Иймээс байгаль орчныг хамгаалах болон биологийн олон янз байдлын хамгааллын бодлогод чиглэсэн зүйлийг хамгаалах эрх зүйн баримт бичгийг боловсруулах шаардлагатай.
- Малчидтай хамтран ажиллаж, чонын халдлагаас сэргийлэх арга хэмжээг (жишээлбэл, хамгаалалтын хашаа, гэрэлтүүлэг, бод малаа сансрын долгион дамжуулагч бүхий хүзүүвчээр хүзүүвчлэх, хариулах, саарал чонын эзэмшил нутгаас татаж авах г.м) хэрэгжүүлэх шаардлагатай.
- Шинжлэх ухаанд тулгуурласан хамгааллын арга хэмжээ авахад түүний популяцийн тоо толгой болон хэмжээ, биологи, экологийн тогтмол судалгааг нарийвчлан хийж, мөн гений санг бүрдүүлэх арга хэмжээг зохион байгуулах зэрэг нь цаашдын хамгааллын бодлого боловсруулахад чухал.
- Хамгаалах талаар орон нутгийн иргэдийн мэдлэгийг дээшлүүлж, тэдний оролцоог хангах нь хамгааллын үр дүнг сайжруулах болно.

3.24. ХҮРЭН БААВГАЙ

Ursus arctos (Linnaeus, 1758)

Баг: Мах идэштэн (Carnivora)
Овог: Баавгай (Ursidae)
Англи нэр: Brown Bear
Ижил нэр: *U. baikalensis*, *U. collaris*, *U. dalli* (Wilson and Reeder, 2005).



Ангилал зүйн тойм. Хүрэн баавгайн ангилал эцэслэн тодорхойлогдоогүй. Зарим системээр 90 хүртэл салбар зүйл ялгадаг бол орчин үеийн ДНХ-ийн судалгаагаар, 5 салбар зүйлийг л ялгажээ (U.S. Fish and Wildlife Service, 2006).

Таних шинж. Биеийн урт 244 см. Сэрвээний өндөр 185 см, биеийн жин 400 кг. Үсний өнгө нь тод хар хүрнээс цайвардуу хүрэн, саарал. Том, хурц, махир хүрэн буюу хар хумстай (Болд, 1967; Дуламцэрэн, 1970). Бие үлэмж, лагс. Мөч бахим, тавхай үстэй, таван хуруу нь хүчирхэг бор хумстай. Толгой данхар, хоншоор богино. Хүзүү богино, бүдүүн. Чих намхан, дугариг. Сүүл ахар, үснээс бараг цухуйхгүй. Зүс бараан хүрэн, цайвар хүрэн, хар хүрэн, бор хул ч тохиолдоно. Зарим баавгай цагаан цээжтэй байх нь бий. Биеийн урт 180-240 см, сэрвээ орчмын өндөр 90-150 см, хойд тавхайн урт 13-30 см, сүүлний урт 6-21 см, жин 150-300 кг хүрнэ.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Clark *et al.,* 2006).

2025 онд Эмзэг (VU). Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн талаарх мэдээлэл хангалтгүй, уг зүйлийн амьдралын мөчлөг урт, өсөлт үржлийн эрчим удаан, мөн амьдрах орчны доройтол, ойн түймэр, үндсэн идэш тэжээлийн нэг болох хуш модны самарын хууль бус олборлолт, хууль бус агнуурын хэмжээ их зэрэг шалтгаанаар энэ зэрэглэлээр үнэлэв.
Үнэлгээ хийсэн: Д.Дэлгэрчимэг, А.Баясгалан, Г.Наранбаатар (2025).
Үнэлгээг хянасан: Б.Мижиддорж, Б.Мөнхцог, Р.Самъяа (2025).

Дэлхийн тархац. Канад, Хойд Америк, Испани, Франц, Норвег, Итали, Австри, Чех, Словени, Хорват, Швед, Польш, Босни Херцеговин, Серби Монтенегро, Словак, Албани, Финланд, Грек, Румын, Македон, Латви, Эстони, Украйн, Болгар, Беларусь, Турк, Орос, Сири, Ирак, Гүрж, Иран, Азербайжан, Казахстан, Туркменистан, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан, Хятад, Энэтхэг, Монгол, Хойд Солонгос, Японд тархжээ.

Монгол орон дахь тархац, амьдрах орчин. Хөвсгөл орчим, Хэнтийн нурууны зүүн бие, Монгол Дагуурын хээрийн Улз, Онон гол, Монгол Алтайн баруун хойд хэсэг, Их Хянганы салбар уулс зэрэг тайга, ойт уулсаар тархсан (Банников, 1954; Дуламцэрэн, 1970; Соколов и Орлов, 1980).



Амьдралын онцлог. Холимог идэштэн. Ихэнхдээ ургамлын ногоон хэсэг, элдэв жимс, хушны самар, шавж ялангуяа, шоргоолж, зөгийн бал, ойн туруутны нялх төл, жижиг хөхтөн амьтан, сэг зэм ч иднэ. Ороо нийллэг 6, 7-р сард болно. Эвш хээлээ 180-220 орчим хоног тээж, ичээндээ голдуу ихэр, хаяа 4 хүртэл бамбарууш төрүүлнэ. Бамбарууш төрөх үедээ 350-500 г жинтэй, нүдээ нээгээгүй, нүцгэн байна. Нэг эсвэл 2-3 жил өнжиж төллөнө. Таван нас хүрч үржилд орно. Намар орой 10-р сарын сүүлч 11-р сард ичээнд орж, хавар 3-р сараас 5-р сард ичээнээс гарна. Байгалийн нөхцөлд 20-30 жил, тэжээвэр нөхцөлд 40 хүртэл насална. Хойд мөч дээрээ босоо зогсож ойр орчноо харуулдана (Батсайхан нар, 2022). Хоногийн турш идэвхтэй. Бамбарууштай эвшээс бусад нь ганц, нэгээр амьдарна. Модны мөчир, хөвд, өвс зэргээр дэвсэг бэлтгэж, бүдүүн модны үндсэн доор, унанги мод, хадны ангалд ичээлнэ.

Тоо толгой, нягтшил. Монгол орны хэмжээнд популяцийн тоо толгой, нягтшилын талаарх мэдээ, баримт хомс. ШУА-ийн Биологийн хүрээлэн 1980-аад оны дундуур Монгол орны 50,000 км^2 нутагт ойролцоогоор 500 орчим хүрэн баавгай бий гэж тооцоолсон байх ба үүнээс хойш түүний тоо толгойн талаар ямар нэгэн судалгаа, мэдээлэл үгүй байна.

Ховордлын шалтгаан. Сүүлийн жилүүдэд ойн түймэр их гарч, хүмүүс их хэмжээгээр хуш модны самар, жимс түүж, малын тоо толгой өссөнөөр түүний амьдрах орчныг доройтуулах, байршил нутгийг нь алдагдуулах, идэш тэжээлийн хомсдуулах зэргээр хүний сөрөг нөлөөлөл ховордлын гол шалтгаан болж байна. Олон улсын хэмжээнд уламжлалт эмнэлэгт хүрэн баавгайн доньд, соёо, савар зэрэг эд эрхтнийг нь хэрэглэдэг тул хараа хяналтгүй болон хууль бусаар агнадаг (Wingard and Zahler, 2006). Монгол орны хэмжээнд сүүлийн 11 (2013-2023) жилийн хугацаанд хууль бус агнуурын 50 хэрэг хууль сахиулах байгууллагуудад бүртгэгдсэн (Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар, 2024).
Хэнтийн нуруунд зарим жилүүдэд самар жимс ургаагүй, алаг цоог гарсан жилд тухайлбал, 1962, 1971, 1988 онд өлсгөлөнд нэрвэгдэж “хорхойтсон” баавгай идэш хоол хайж тэнүүчлэн, төв суурин газруудад ойртож, мал, амьтан барих нь ихэсдэг байсныг амьтан судлаачид (Дуламцэрэн,

Ганбат, 2000) тэмдэглэжээ. Ийм байдал 2015 оноос хойш дахин давтагдах болж Сэлэнгэ, Булган, Хэнтий, Завхан, Дорнод, Төв аймгийн нутагт хүрэн баавгай хүн амын суурьшлын бүсэд орж ирэн айлын гэр, амбаар савыг ухах, мал, амьтан барих, тэрчлэн хүн рүү довтлох тохиолдол гарах болсон байна. ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн судлаачид 2019 оны намар асуулга судалгааны аргаар, Хэнтийн нуруу тойрсон 3 аймгийн 26 сумдын суурьшлын бүсэд тэнүүчлэн явсан хүрэн баавгайн 133 тохиолдлыг бүртгэжээ. Тэдгээр нь айлын гэр амбаар, зөгийн үүр 51-ийг эвдлэн сүйтгэж, малчдын үхэр, хонь, ямаа нийлээд 155 малыг барьж, 15 удаа айлын аарц, ааруул, өөх, тос, гурилыг авч явсан байна. Мөн гэртээ байсан 2 хүний амь насанд халдсан харамсалтай хэрэг гарсан байна (Баттогтох нар, 2020). Хэвлэлийн мэдээгээр идэш тэжээлийн хомсдолоос шалтгаалж суурьшлын бүс рүү орж ирсэн, хүн, мал руу дайрсан тохиолдол 2019-2021 онд 3 жилийн хугацаанд 257 тохиолдол тэмдэглэгджээ. Мөн энэ хугацаанд баавгайн бамбарууш айлын хотонд орж ирсэн 10 гаруй тохиолдол бүртгэгдсэнээс 5 нялх бамбарууш хүний асаргаанд орж тэжээгдэж байсан баримт бий.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан. Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор батлагдсан Ховор амьтны жагсаалтад орсон бөгөөд ховор амьтныг (7.5) төрийн захиргааны төв байгууллагаас олгосон зөвшөөрлөөр (7.5.1) судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, эмчилгээний зориулалтаар агнаж, барьж болдог. Харин Амьтны тухай хуулийн 10 дугаар зүйлд зааснаар (10.1.2) агнуурын амьтны жим дээр нүх ухах, буу сойх, занга, сааль тавих, (10.1.5) амьтныг агаарын болон авто тээврийн хэрэгслээр хөөх, гэрэлтүүлэх, (10.1.8) ан агнах зориулалтын бус буу, сум хэрэглэх зэрэг арга, зэвсэг хэрэгслээр амьтан агнах, барихыг хориглосон. Мөн (11.1.3) өөр нутагт шилжин байршиж байгаа агнуурын амьтныг агнах, барих, (11.1.4) амьтны үүр, ичээ ухах, гэмтээх, (11.1.7) амьтны үр төлийг агнах, шувууны өндгийг түүх, гэмтээх, устгах зэрэг үйл ажиллагаа явуулахыг хоригложээ. Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр хүрэн баавгай 12,450,000 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ын II хавсралт (Чимэддорж нар, 2018; http://checklist.cites.org), мөн Монгол Улсын Улаан номд ховор зүйлээр (Шийрэвдамба нар, 2013) тус тус бүртгэгдсэн.

Энэ зүйлийн тархац нутгийн 21% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд (тухайлбал, Алтай Таван Богд, Чигэртэй голын ай савын байгалийн цогцолборт газрууд, Улаан тайга, Хорьдол Сарьдаг, Хан Хэнтийн дархан цаазат газрууд г.м) хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ

- Монгол оронд хүрэн баавгайн биологи, экологийн судалгаа шинжилгээний ажил маш бага хийгдсэн, мэдээлэл дутмаг. Иймд самар жимсээр хооллодог хүрэн баавгай зэрэг амьтдын тархац, байршил нутагтаа хэвийн амьдрах нөхцөлийг хангахын тулд тодорхой хугацаагаар хуш модны самар бэлтгэх, түүх, худалдаалах явдлыг хориглох, хууль бусаар самар түүх үйлдэлд тавих хяналтыг чангатгах шаардлагатай.
- Хууль бусаар агнах, тээвэрлэх, борлуулах хэрэг зөрчилд тавих хяналтыг сайжруулах нь зүйтэй.
- Энэ зүйлийн тархац, тоо толгой, амьдрах орчин, идэш тэжээл, үржил, нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар мэдээлэл маш хомс байгааг харгалзан энэ чиглэлээр нарийвчилсан судалгаа явуулах, гений санг бүрдүүлэх, судалгааны үр дүнд үндэслэн хамгаллын арга хэмжээний төлөвлөгөө болон гэрийн мал барих, хүн рүү довтолж амь эрсдэхээс урьдчилан сэргийлэх стратеги, тактик боловсруулж мөрдүүлэх, нутгийн иргэд, малчдад экологийн боловсрол олгох, мэдээлэл сурталчилгаа явуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх явдал зайлшгүй чухал байна.

3.25. ХАЛЗДАЙ ДОРГО
Meles leucurus (Hodgson, 1847)

Баг: Мах идэштэн (Carnivora)
Овог: Суусар (Mustelidae)
Англи нэр: Eurasian Badger
Ижил нэр: *M. alba*, *M. heptneri*, *M. vulgaris* (Wilson and Reeder, 2005).





Ангилал зүйн тойм. Энэ зүйлийн *M. m. leptorhynchus* хэмээх салбар зүйл тархсан гэж үздэг ба нарийвчлан судлах шаардлагатай.

Таних шинж. Биеийн урт 65-90 см (Цэвэгмэд, Цэнджав, 1988). Сүүл 15-20 см, жин 10-18 кг. Бие лагс, мөч богино, хүчирхэг. Толгой шаантаг хэлбэртэй. Нуруугаараа мөнгөлөг саарал, хэвлий бараан. Толгой цайвар, хүрэн. Энэ суурь өнгө дээр нүд дайрсан тод хар судалтай. Сор үс нь урт, ширүүн.

Үнэлгээ ба үндэслэл
Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).
Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).
2025 онд Ховордож болзошгүй (NT). Монгол оронд нэлээд өргөн тархсан, тоо толгой элбэг, популяцийн тоо хэмжээ буураагүй гэж өмнө нь үнэлж байсан. Гэвч сүүлийн үед энэ зүйлийн эд эрхтэн, түүний гаралтай бүтээгдэхүүнийг уламжлалт ангаах ухаанд хэрэглэх зорилгоор худалдаалах, хууль бусаар агнах явдал нэлээд тохиолдох болсон. Үүний улмаас түүний тоо толгой буурах эрсдэл их хэмээн үзэж ховордож болзошгүй зэрэглэлээр үнэлэв.
Үнэлгээ хийсэн: Ц.Мөнхзул (2025).
Үнэлгээг хянасан: Б.Мөнхцог (2025).

Дэлхийн тархац. Европ, Ази, зүүн тийш Япон, өмнө тийш Палестин, Иран, Төвд, Хятадын өмнөд нутагт тархсан (Corbet, 1978).

Монгол орон дахь тархац, амьдрах орчин. Монгол Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтий, Монгол Дагуур, Дундад Халхын хээр,

Зүүнгарын говийн Булган гол, Дорнод говь, Умард говьд тархсан. Ой, бүх хэв шинжийн цөлжүү хээр, чийглэг, нам дор газар, голын хөндийгөөр амьдарна (Батсайхан нар, 2022).



Амьдралын онцлог. Шөнө болон бүрэнхийн идэвхтэй. Элдэв идэштэй. Идэш тэжээлийн бүрэлдэхүүнд шавж, жижиг хөхтөн амьтны үлдэгдэл, шувуу, хоёр нутагтан, ургамлын үлдэгдэл болон хүний хог хаягдал тохиолдоно (Murdoch *et al.,* 2010). Ичээнд орохын өмнө их хэмжээний өөх хуримтлуулна. Намар 10-р сараас дараа оны 4-р сар хүртэл ичээлнэ. Ичээндээ төрнө. Нэг төрөлтөөр 1-6 ганьс гаргана. Төрсний дараахан ороо орно. Орооны үе хавраас намар хүртэл үргэлжилнэ. Хээл тээх хугацаа урт. Далд үетэйгээ нийлээд хээл тээх хугацаа 10 сар орчим (Батсайхан нар, 2022). Гуужилт 3-4-р сард эхэлж, 11-р сард хөрс гүйцнэ.

Тоо толгой, нягтшил. Тархац нутаг уудам, тоо толгой элбэг зүйл боловч Монгол орны бусад ихэнх зүйл хөхтөн амьтдын нэгэн адил сүүлийн 60 жил тооллого хийж, түүний тоо толгой, нягтшилыг тодорхойлоогүй.

Ховордлын шалтгаан. Уламжлалт анагаах ухаанд энэ зүйлийн бүх эд эрхтэн, арьсыг нь ашигладгаас хараа хяналтгүй, хууль бусаар агнадаг. Агнуурын бэлтгэлийн мэдээгээр, 1958-1960 онд жил бүр 1,500-аас 1,800 бодгалийг агнасан (Stubbe, 1965). Олон улсын хэмжээнд бага хэмжээгээр худалдаална. Зах зээлийн судалгааны явцад доргоны тосыг тодорхой нэгжээр үнэ тогтоон зарж байгааг тогтоосон бөгөөд мөн онлайнаар зарж борлуулна (Wingard *et al.,* 2019). Гэрийн нохой барина.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулийн 9.1.5-д зааснаар халздай доргыг жил бүрийн 11 сарын 15-ны өдрөөс дараа оны 01 сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосноос гадна, (10.1.2) агнуурын амьтны жим дээр нүх ухах, буу сойх, занга, сааль тавих, (10.1.5) амьтныг агаарын болон авто тээврийн хэрэгслээр хөөх, гэрэлтүүлэх, (10.1.8) ан агнах зориулалтын бус буу, сум хэрэглэх зэрэг арга, зэвсэг хэрэгслээр амьтан агнах, барихыг хориглодог. Мөн амьтныг (11.1.1) шуурга, ган, зуд, үер, мөндөр, түймэр зэрэг гамшигт нэрвэгдсэн болон гол, мөрөн, намаг, шаварт орох зэрэг биеэ хамгаалах чадваргүй болсон үед агнах, барих, (11.1.3) өөр нутагт шилжин байршиж байгаа агнуурын амьтныг агнах, барих, (11.1.4) амьтны үүр, ичээ ухах, гэмтээх зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр халздай дорго 995,000 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг.

Тархац нутгийн 12% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ

- Хууль бусаар агнах, тээвэрлэх, худалдан борлуулах зэрэг үйлдэлд тавих хяналтыг сайжруулах нь зүйтэй.
- Энэ зүйлийн тархац, тоо толгой, амьдрах орчин, идэш тэжээл, үржил, нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар мэдээлэл хомс байгааг харгалзан энэ чиглэлээр нарийвчилсан судалгаа явуулах, үр дүнд үндэслэн хамгаалллын арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай.
- Мөн нутгийн иргэд, малчдад экологийн боловсрол олгох, мэдээлэл сурталчилгаа явуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх нь чухал.

3.26. ШИЛҮҮС

Lynx lynx (Linnaeus, 1758)

Баг: Мах идэштэн (Carnivora)
Овог: Мий (Felidae)
Англи нэр: Eurasian Lynx
Ижил нэр: Шилүүс мий, *L. l. isabellina, L. l. wrangeli, L. l. lynx* (Wilson and Reeder, 2005)



Ангилал зүйн тойм. Ангилал зүй нь өнөөг хүртэл маргаантай бөгөөд түүнийг дэд овгийн түвшинд дангаар эсвэл мийн бусад зүйлтэй хамтатган авч үзсээр иржээ (Haltenorth, 1957; Kratochvil, 1982).

Шилүүсний төрөлд Канадын шилүүс (*Lynx canadensis* Kerr, 1792), улаан шилүүс буюу бобкат (*L. rufus* Schreber, 1777), Иберийн шилүүс (*L. pardinus* Temminck, 1827), Евразийн шилүүс (*L. lynx* Linnaeus, 1758) гэсэн 4 зүйл багтдаг болохыг гавлын яс, араг яс, арьсны бүтэц дээр тулгуурлан тогтоосон (Johnson *et al.,* 2006; Матюшкин и Вайсфелд, 2003). Европт хийсэн шилүүсийн морфологийн ялгаа, зоо-географи болон палеонтологийн судалгааны үр дүнгээс үзвэл (Arx *et al.,* 2004), Евразийн бүс нутгийн хэмжээнд *L. lynx* (Европийн хойд хэсэг, баруун Сибирь); *L. carpathicus* (Карпатын уулс); *L. martinoi* (Балканы хойг); *L. dinniki* (Кавказ), *L. isabellinus* (Төв Ази); *L. wardi* (Алтайн нуруу); *L. kozlovi* (Саяны уулс); *L. wrangeli* (зүүн Сибирь); *L. stroganovi* (Оросын Алс дорнод) зэрэг 9 салбар зүйл байгааг тогтоожээ. Сүүлийн үеийн судалгаагаар салбар зүйлд тооцож байсан *L. l. wardi* Lydekker, 1904; *L. l. kozlovi* Fetisov, 1950; *L. l. stroganovi* Heptner, 1969 нь газарзүйн тусгаарлалтад орсон популяциуд болохыг тогтоосон (Breitenmoser *et al.,* 2015).

Таних шинж. Биеийн урт 820-910 см, сүүл 20-31 см байх ба эр нь эмээсээ том (Банников, 1954). Өндөр хөл, богино биетэй, дунд зэргийн хэмжээтэй. Чих том, өргөн суурьтай, үзүүр дээрээ 50 мм хүртэл урт отогтой байхаас гадна, хүзүүний өвлийн ноолуур үс ихээхэн уртсаж чихнээс хүзүү чиглэсэн “өрөвлөг”-ийг үүсгэн толгойн ясыг өвөрмөц хэлбэртэй харагдуулдаг (Werdelin, 1981; Гептнер и Слудский, 1972). Сүүл харьцангуй богино, их биеийн уртын 1/3 юмуу ¼-ээс хэтрэхгүй, дийлэнх тохиолдолд түүний 20%-тай тэнцүү байх ба үслэг бүдүүн төгсгөлтэй, үзүүрээсээ 1/3 хүртэл хар (Дуламцэрэн, 1970; Соколов и Орлов, 1980).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Ховордож болзошгүй (NT) (Clark *et al.,* 2006).

2025 онд Эмзэг (VU). Бүс нутгийн популяцийн хэмжээ тодорхойгүй. Ангуурт их өртдөг, тоо толгой буурах их эрсдэлтэй байгааг харгалзан үзэж энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Г.Наранбаатар, Б.Чойдогжамц, О.Ганбаатар (2025).

Үнэлгээг хянасан: Б.Мөнхцог (2025).

Дэлхийн тархац. Европын баруун хэсгээс эхлэн Сибирь, Гималай хүртэлх өргөн уудам нутагт идэш тэжээл элбэгтэй ойт нутгаас Төв Азийн говь цөлд ч тохиолдоно (Milner and Irvine, 2015; von Arx *et al.,* 2004). Манай хөрш зэргэлдээх Оросын ойт болон уулын бүсэд орших ихэнх нутагт тархсанаас гадна, Атлантын эргээс хойд зүгт Скандинавын хойг хүртэл, өмнө зүгт Испани, Итлаи, Балкан хүртэл, Бага Азийн Иракийн хойд болон зүүн хэсэг, Ираны баруун хойд хэсэг, Афганистаны уулархаг хэсэг, Кашмир, Памир-Алая уулсын систем, Тянь Шань, Төвд, Төвдийн зүүн хэсэгт Сычуань, Куньлунь, Монгол (Монгол Алтай, Говь Алтай, Хангай, Хэнтийн нуруу, Их хянганы тойрог), Хятадын баруун хойд

хэсэг, Жилин хүртэл тархана. Төвдийн тархац нутгийн зүүн хэсэг болох Хэбэй орчимд тархах боломжтой (Clark *et al.,* 2006; Гептнер и Слудский, 1972).

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол орны Хэнтий ба Хөвсгөлд шилүүс нь ойт нутагт, Умард Хангайн хувьд энэ амьтан ой модыг шүтэхээсээ илүү хад чулуурхаг газрыг эрхэмлэдэг бол Төв Хангайн хувьд ойн дээд хэсэг, тагийн бүслүүрт, Монгол ба Говь Алтайд жинхэнэ хад асгатай, армаг тармаг бут сөөгт газарт, харин Алтайн өвөр говьд хад чулуурхаг газар бараадан, газрын намд бууж бут сөөгт, тооройн шугуйд амьдарна (Банников, 1954).



Матюшкин, Вайсфелд (2003) нар Монгол орны шилүүсний тархац нутаг нь Хангай, Хэнтийн уулсын системийг бүхэлд нь хамарсан ч Хан Хөхийн нурууны дундаж болон нам өндөрлөгтэй уулсаас зүүн зүгт Эрээний нуруу хүртэл, мөн нутгийн зүүн өмнөд хэсэгт Их Хянганы нам уулсаар, баруун болон баруун өмнөд хэсэгт өндөр уулс бүхий нутгийг хамарсан Монгол-Алтайн хэлбэрүүд гэсэн 3 үндсэн тасархайтсан арал хэлбэртэйгээр тархсан гэж дүгнэжээ.

Монгол орны ой тайга (1.1), ойт хээр, уулын хээр, говь цөлийн (6, 8.3) бүсэд түгээмэл тархацтай, говийн бүсийн бэсрэг уулс, ааараг толгод, бэлийн сайр садарга, бут сөөгт тал, уулсын хоорондох хотгор хоолойд цөөн тоотой тохиолдох элбэг зүйл (Дуламцэрэн, 1970; Дуламцэрэн, Цэнджав, 1989; Соколов и Орлов, 1980).

Амьдралын онцлог. Идэш тэжээлийн олдоц, цаг уурын байдлаас хамааран байршлаа бага зэрэг өөрчилнө (Дуламцэрэн, Цэнджав, 1989). Голдуу залуу бор гөрөөс, хүдэрт барьж идэхээс гадна, туулай, үхэр оготно, шувуугаар хооллоно. Гэхдээ Алтай болон Алтайн өвөр говьд хахилаг барихын зэрэгцээ залуу янгир, аргальд довтолдог бол баруун өмнөд Хангайн ой модгүй газруудад зун цагаар жижиг мэрэгчдээр голлон хооллож, өвөлдөө туулай, хойлог барьж иднэ (Банников, 1954) гэжээ. Үүнээс үзэхэд, түүний идэш тэжээлийн бүрэлдэхүүн байгалийн бүс, бүслүүрээс хамааран өөрчлөгддөг болохыг илтгэнэ. 1990-ээд оны сүүлээр хийсэн судалгаагаар, шилүүсний идэш тэжээлийн бүрэлдэхүүнд туулай (21.0%), тарвага, зурам зэрэг мэрэгчид, хөтүү хахилаг, хур сойр зэрэг ойн шувууд (6.2%), суусрын овгийн болон нохдын овгийн махчид (8.8%), бага насны хандгай, халиун буга, бор гөрөөс, зэрлэг гахай зэрэг туруутан амьтад (64.3%) тус тус эзэлж (Sunde and Kvam, 1997) байжээ.

Монголд энэ амьтны үржлийн тухай мэдээ хомс. Дуламцэрэн нар (1989) ороо хөөцөө 3-4-р сард болж, 5-6-р сард гол төлөв 2-3, заримдаа 5 ногуул мод, хадны ан завсарт үүрээ засаж төрүүлдэг гэжээ. Нутгийн анчдын аман мэдээлэлд тулгуурлан уг амьтны ороо хөөцөө, өсөлт үржлийн талаар А.Г. Банников (1954) дүгнэхдээ Говь Алтайд 5-р сарын эхээр зулзаган муур үзэгдэнэ. Хээл тээх хугацаа нь 9-10 долоо хоног ба эхний арав хоногоос зулзага биежнэ. Монгол Алтайн хувьд бойжсон зулзагууд 6-р сараас эхийн хамт ан хөөж эхэлдэг тухай дурдсан байдаг.

Тоо толгой, нягтшил. Монгол орон даяар нэгтгэн гаргасан популяцийн хэмжээ, нягтшилын талаарх мэдээ, баримт хомс. 1970-аад оны сүүлчээр судалгааны үр дүн, арьс бэлтгэлийн мэдээнд үндэслэн Монгол орны 16 аймгийн 187 сумын 100,000 км^2 нутаг дэвсгэрт 10,000 орчим шилүүс байх боломжтой (Даш и Хрусталев, 1979) хэмээн тооцоолсноос хойш түүний тоо толгой, хөдлөл зүйтэй холбогдох мэдээ, баримт өнөөг хүртэл дутагдалтай хэвээр байна.

Ховордлын шалтгаан. Арьсыг олон улсын зах зээл дээр худалдаалдаг (3.4.3). Монгол орны шилүүсний арьс бэлтгэлийн тоон мэдээллээс харвал, 1908 онд 3,997

(Банников, 1954; Свечников, 1912), 1909 онд 4,000 орчим (Блохин, 1936), 1920 он гэхэд ердөө хэдхэн зуугаар (800 хүртэл) хэмжигдэж байжээ. Харин 1958-1975 онд жил бүр дунджаар 458 шилүүсний арьс бэлтгэж байснаас 87%-ийг ойт нутгаас, үлдсэн 13%-ийг ойгүй нутгаас олзворлож байв (Даш ба Хрусталев, 1979). Говь Алтай болон Алтайн өвөр говийн тодорхой хэсгийг хамран орших Баянхонгор аймгийн хойд хэсгийн Хангайн нуруунаас 1960-1970-аад оны үед жил бүр 12-29 шилүүсний арьс, улсын хэмжээнд 1970-аад оны эхний хагаст жилд дунджаар 512 арьс бэлтгэн нийлүүлж байсан (Даш и Хрусталев, 1979) бөгөөд 18 аймгаас Хангайн ойт хээрийн бүсэд орших 5 аймаг нь тал орчим хувийг буюу 232 арьс бэлтгэсэн дүн бий (Дмитриев и др., 1992). Хөвсгөл орчимд нуурын зүүн урд хэсэгтэй хил залган орших, уулын ойт хээрийн бүсийн Чандмань-Өндөр сумаас ихэнх арьсыг бэлтгэж байжээ (Литвинов и Базардорж, 1992). Монгол орны хэмжээнд сүүлийн 11 (2013-2023) жилийн хугацаанд хууль бус агнуурын 6 хэрэг хууль сахиулах байгууллагуудад бүртгэгдсэн (Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар, 2024).

Дэлхийн дулаарал (6.1.1), уул уурхай (1.3.1), мод бэлтгэл (1.3.3), дэд бүтцээс (1.4) үүдэлтэй амьдрах орчны доройтол (1), тархац нутгийн хумигдал (9.1) зэрэг хүчин зүйлс, мөн ахуйн зориулалтаар (3.4.1) агнаж, хэрэглэдэг зэргээс шалтгаалан тоо толгой нь цөөрч байна.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан. Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор баталсан Ховор амьтны жагсаалтад Говийн шилүүс (*Lynx lynx isabellina*) хэмээх салбар зүйл орсон бөгөөд ховор амьтныг (7.5) төрийн захиргааны төв байгууллагаас олгосон зөвшөөрлөөр (7.5.1) судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, эмчилгээний зориулалтаар агнаж, барьж болдог. Харин Амьтны тухай хуулийн 10 дугаар зүйлд зааснаар (10.1.2) агнуурын амьтны жим дээр нүх ухах, буу сойх, занга, сааль тавих, (10.1.5) амьтныг агаарын болон авто тээврийн хэрэгслээр хөөх, гэрэлтүүлэх, (10.1.8) ан агнах зориулалтын бус буу, сум хэрэглэх зэрэг арга, зэвсэг хэрэгслээр амьтан агнах, барихыг хориглосон. Мөн (11.1.3) өөр нутагт шилжин байршиж байгаа агнуурын амьтныг агнах, барих, (11.1.4) амьтны үүр, ичээ ухах, гэмтээх, (11.1.7) амьтны үр төлийг агнах, шувууны өндгийг түүх, гэмтээх, устгах зэрэг үйл ажиллагаа явуулахыг хоригложээ.

Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2-т зааснаар шилүүсийг жил бүрийн 2 дугаар сарын 11-ний өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон. Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр шилүүс (*Lynx lynx*) 4,500,000 төгрөг бол түүний салбар зүйл болох Говийн шилүүс (*Lynx lynx isabellina*) 6,100,000 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ын II хавсралт (Чимэддорж нар, 2018; http://checklist.cites.org), мөн Монгол Улсын Улаан номд Говийн шилүүс (*Lynx lynx isabellina*) хэмээх салбар зүйл нь ховор зүйлээр (Шийрэвдамба нар, 2013) тус тус бүртгэгдсэн.

Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд (тухайлбал, Говийн Их болон Бага дархан цаазат газруудын “А”, “Б” хэсэг, Говь Гурвансайхан, Алтай Таван Богд, Тарвагатайн нурууны байгалийн цогцолборт газрууд, Улаан тайга, Хорьдол Сарьдаг, Нөмрөг, Хан Хэнтийн дархан цаазат газрууд г.м) хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн тархац нутаг, популяцийн тоо толгой, хэмжээ, хандлага (3.2), биологи, экологи (3.3), түүнд нүүрлэж буй аюул занал зэргийн судалгааг урт хугацаанд тогтмол хийж, шинжлэх ухаанд тулгуурласан хамгаалллын арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай. Мөн зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2) арга хэмжээг зохион байгуулах нь зүйтэй.

3.27. ЦООХОНДОЙ

Felis silvestris (Schreber, 1775)

Баг: Мах идэштэн (Carnivora)
Овог: Мий (Felidae)
Англи нэр: Wild Cat
Ижил нэр: Цоохондой мий; *Felis ferus, Felis. kozlovi, F. libyca* (Wilson and Reeder, 2005).





Ангилал зүйн тойм. Монгол дахь салбар зүйл *F. s. shawiana*, Евроази, Африкийн популяциудын ангилал зүй, мөн *F.libyca* болон *F.silvestris* зүйлүүдийн ангилал зүй, удам төрлийн холбоо нь тодорхойгүй.

Таних шинж. Биеийн урт 57-59 см, сүүл 21-24 см, жин 2.7-3.1 кг (Мөнхцог *et al.,* 2003). Цоохондой биеэр гэрийн муураас ялимгүй том. Зоо нуруугаараа өргөн бараан хүрэвтэр, бор судалтай. Биеийн дээд хэсэгтээ жижигхэн дугуй толбонуудтай. Өвдөгний дотор тал толбогүй, цайвар, бараг цагаан. Сүүлний үзүүр бараан, 4-5 тод бөгжилсөн бараан бүслүүртэй (Батсайхан нар, 2022). Өнгөний хувьд маш хувьсамтгай (Мөнхцог *et al.,* 2003). Эм нь эрээсээ жин багатай.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC)

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Clark *et al.,* 2006).

2025 онд Ховордож болзошгүй (NT). Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгой, өөрчлөлт хандлага, учирч буй аюулын талаарх мэдээ, баримт бага. Энэ зүйлийн тоо толгойд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар ховордлын шалтгаан хэсэгт бичсэн бөгөөд тэдгээрийн нөлөөгөөр түүний тоо толгой цөөрөх өндөр эрсдэл байгааг харгалзан энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Г.Довчиндорж, С.Пүрэвсүрэн (2025).

Үнэлгээг хянасан: Б.Мөнхцог (2025).

Дэлхийн тархац. Бүх Европ, Төв Ази, Африкаар тархсан (Nowak, 1991).

Монгол орны тархац, амьдрах орчин. Их Нууруудын хотгор, Нууруудын хөндий, Дорнод говь, Алашань говь (Дуламцэрэн нар, 1995), Шаргын говь, Умард говь, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь зэрэг цөл, цөлөрхөг тал хээрийг хамарсан өргөн уудам нутагт алаг цоог тархсан (Банников, 1954). Дэлхийн тархалтын зүүн хойд хил нь Монгол болдог. Энэ зэрлэг муур нь сухай, заг, хармаг бүхий элсэн довцог, хотгор хоолой, тойром, голын хаяа, баянбүрд, нам аараг, сайр дагаж байршина (Шагдарсүрэн нар, 1987).



Амьдралын онцлог. Ганц нэгээр амьдарна. Шөнийн амьдралтай. Сонсгол сайтар хөгжсөн. Жилд хоёр удаа хавар, намар гуужина. Манай орны нөхцөлд өвлийн улирлын идэш тэжээлийн бүрэлдэхүүнд 7 зүйл шувуу, 1 зүйл мэрэгч тэмдэглэгдэж зонхилох хэсгийг (82.9%) жижиг шувууд эзэлнэ. Цас ихтэй хүйтэн өвөл элдэв сэг зэмээр хооллоно (Мөнхцог нар, 2003).

Тоо толгой, нягтшил. Монгол орон даяар нэгтгэн гаргасан популяцийн тоо толгой, хэмжээ, нягтшилын талаарх мэдээлэл хомс. Алтайн өвөр говийн Захуйн баянбүрдэд хийсэн судалгаагаар, хаврын улиралд 24 км^2 талбайд 4-5 бодгаль тоологдож байсан (Довчиндорж, 2002).

Ховордлын шалтгаан. Үнэг, чоно агнах зорилгоор тавьсан хавханд орж хууль бус агнуурт өртөнө. Зөвхөн Захуйн говьд 2 жилийн дотор 7 бодгаль ийм байдлаар хорогдсон судалгаа бий (Мөнхцог нар, 2003). Мөн хүний суурьшил бүхий томоохон баянбүрдүүдэд гэрийн мууртай эрлийзжих эрсдэлтэй (Довчиндорж, 2002).

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан. Тухайлбал, энэ хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2-т зааснаар агнуурын амьтны жим дээр нүх ухах, буу сойх, занга, сааль тавих, (10.1.5) амьтныг агаарын болон авто тээврийн хэрэгслээр хөөх, гэрэлтүүлэх, (10.1.8) ан агнах зориулалтын бус буу, сум хэрэглэх зэрэг арга, зэвсэг хэрэгслээр амьтан агнах, барихыг хориглосон. Мөн амьтныг (11.1.1) шуурга, ган, зуд, үер, мөндөр, түймэр зэрэг гамшигт нэрвэгдсэн болон гол, мөрөн, намаг, шаварт орох зэрэг биеэ хамгаалах чадваргүй болсон үед агнах, барих, (11.1.3) өөр нутагт шилжин байршиж байгаа агнуурын амьтныг агнах, барих, (11.1.4) амьтны үүр, ичээ ухах, гэмтээх зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглосон. Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр цоохондой 1,680,000 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ын II хавсралт (Чимэддорж нар, 2018; http://checklist.cites.org), мөн Монгол Улсын Улаан номд ховор зүйлээр (Шийрэвдамба нар, 1997; 2016) тус тус бүртгэгдсэн. Тархац нутгийн 19% орчим нь тусгай хамгаалалттай газар (Говийн Их болон Бага дархан цаазат газруудын “А”, “Б” хэсэг, Тост, Тосонбумбын нурууны байгалийн нөөц газар, Говь Гурвансайхан байгалийн цогцолборт газар г.м) хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн тархац нутаг, популяцийн тоо толгой, хэмжээ, хандлага (3.2), биологи, экологи (3.3), түүнд нүүрлэж буй аюул занал зэргийн судалгааг урт хугацаанд тогтмол хийж, шинжлэх ухаанд тулгуурласан хамгааллын арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай байна. Мөн зүйлийн гений санг бүрдүүлэх (5.7.2) арга хэмжээг зохион байгуулах нь зүйтэй.

3.28. ХУЛАН

Equus hemionus (Pallas, 1775)

Баг: Тууpайтан (Perissodactyla)
Овог: Адуу (Equidae)
Англи нэр: Asiatic Wild Ass
Ижил нэр: Хулан адуу (Дуламцэрэн, 2003); *E. bedfordi*, *E. castaneus, E. finschi, E. luteus* (Wilson and Reeder, 2005).



Ангилал зүйн тойм. *E. h. hemionus*, *E. h. luteus* гэдэг ч одоогоор эдгээр салбар зүйлийг синоним гэж үздэг (Oakenfull *et al.,* 2000).

Таних шинж. Биеийн урт дунджаар 220 см, мундааны өндөр 140 см, сүүлний урт 50 см, жин ойролцоогоор 200 кг. Толгой том, адуутай харьцуулахад чих харьцангуй урт, босоо. Биеийн ерөнхий зүс хул шаргал, хэвлий, суга, цавь илүү цайвар, цагаан. Улирлаас хамааран зундаа арай цайвардуу, өвөлдөө сааралдуу туяатай. Мундаанаас сүүлний уг хүртэл нуруу дагуу тууш хүрэн бор судалтай. Сүүл угаас дунд өнгөртлөө год, үзүүртээ шингэн хар цацаг хялгастай.

Үнэлгээ ба үндэслэл
Олон улсын үнэлгээ: *E. hemionus* Эмзэг (VU), A3bcd ба C1 үнэлэгдсэн. *E. h. hemionus, E. h. luteus* Эмзэг (VU), C1 нарийвчлагдан үнэлэгдсэн. 2008 онд A2abc, 3bd шалгуураар “Устаж болзошгүй гэж үнэлэгджээ.

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Устаж болзошгүй (EN) (Clark *et al.,* 2006).
2025 онд Ховордож болзошгүй (NT). Жилд хууль бусаар 3,000 гаруй хулан агнадаг (Wingard and Zahler, 2006) ба үүн дээр үндэслэн жилд 5% буурч, өнгөрсөн 20 жилийн хугацаанд түүний популяцийн хэмжээ 60% гаруй буурсан бөгөөд энэ популяцийн бууралт дараагийн гурван үе удмын хугацаанд 50% буурна хэмээн үзэж A4abd шалгуураар Устаж болзошгүй зэрэглэлд оруулж (Clark *et al.,* 2006) байжээ. Гэвч сүүлийн жилүүдэд Монгол орны нийт хулангийн 80% гаруй нь орших Өмнийн говьд хулангийн популяци өсөх хандлагатай

(Buuveibaatar *et al.,* 2017). Хамгийн сүүлд буюу 2023 онд хийсэн судалгаагаар, тус бүс нутгийн хэмжээнд 80,000 (95% CI = 56,422-121,160) гаруй хулантай гэж үнэлжээ (WCS, 2023). Үүнд хуулийн хэрэгжилт сайжирч, хяналт шалгалт эрчимжсэн, мөн сургалт, сурталчилгаа тогтмол зохион байгуулсан, иргэдийн амьжиргаа дээшилсэн зэрэг олон эерэг зүйлс нөлөөлсөн байж болох ч гол нь хулангийн хууль бус агнуур сүүлийн жилүүдэд мэдэгдэхүйц буурсан (WCS, 2024a) ажээ. Гэсэн хэдий ч Өмнийн говьд уул уурхай эрчимтэй өргөжиж, 2020–2022 онд нийт 930 км урт гурван төмөр зам шинээр баригдсан нь түүний шилжилт хөдөлгөөнийг хязгаарлаж, үхэл хорогдолд нөлөөлж эхлээд байна (Kaczensky *et al.,* 2024). Харин Зүүнгарын говийн хулангийн тархац нутаг бүхэлдээ Говийн Их дархан цаазат газрын “Б” хэсэгт багтдаг бөгөөд аливаа уул уурхай болон шугаман дэд бүтцийн нөлөөнд өртөөгүй (Kaczensky *et al.,* 2020). Зүүнгарын говийн хулангийн популяцийн судалгаагаар, 2010 онд 5,671 (95% CI = 3,611-8,907), 2015 онд 9,337 (95% CI = 5,337-16,334), 2022 онд 5,204 (95% CI = 2,121-12,771) хулантай хэмээн тус тус үнэлжээ (Kaczensky *et al.,* 2017; Vogler *et al.,* 2022). Эндээс харахад, Зүүнгарын говийн хулангийн тоо 2015-2022 онд буурсан бөгөөд энэ нь уур амьсгалын хүчин зүйлс (ган, зуд)-тай холбоотой (Vogler *et al.,* 2022). Харин Алтайн өвөр говьд хулангийн популяцийн төлөв байдлын судалгаа 2000-аад оноос хойш хийгдээгүй (Kaczensky *et al.,* 2020). Иймд шугаман дэд бүтцийн хурдацтай хөгжил, уур амьсгалын өөрчлөлттэй уялдан ирэх гурван үе удмын хугацаанд хулангийн тоо толгой 20 буюу түүнээс дээш хувиар буурах эрсдэлтэй гэж үзэн Ховордож болзошгүй (NT) зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Б.Бүүвэйбаатар, О.Ганбаатар, Х.Ариунбуян (2025).

Үнэлгээг хянасан: Ян.Адъяа, С.Гомбобаатар (2025).

Дэлхийн тархац. Одоогоор дэлхий дээр хулангийн есөн популяци байгаа бөгөөд тэдгээрийн тав нь уугуул нутагтаа тархаж байна. Үүнд: 1) Монголын Говь, 2) Хятадын Каламали, 3) Ираны Туран, 4) Бахрам-е-Гор, 5) Энэтхэгийн Качийн Жижиг Ран багтана. Харин сэргээн нутагшуулах үйл ажиллагааны үр дүнд бий болсон дөрвөн популяци нь: 1) Израилийн Негев цөл, 2) Казахстаны Алтан Эмээл, 3) Барса Кельмэс, 4) Узбекистан, Туркменистан, Казахстан улсуудын хилийн заагт орших Устюрт зэрэг бүс нутагт оршиж байна (Kaczensky *et al.,* 2015; 2020; 2025).

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол орны Алтайн өвөр говь, Өмнийн говь, Зүүнгарын говь зэрэг бүс нутагт тархсан бөгөөд эдгээр нь хоорондоо шилжилт хөдөлгөөнөөр холбогддоггүй, тусгаар орших популяциуд юм (Reading *et al.,* 2001; Kaczensky *et al.,* 2011a). Тархац нутгийн баруун хязгаар нь Зүүнгарын говь, өмнөд хязгаар нь Монгол–Хятадын хил, зүүн хэсэг нь Улаанбаатар–Замын-Үүдийн төмөр зам (УБТЗ)-аар хязгаарлагддаг (Linnell *et al.,* 2016; Kaczensky *et al.,* 2011a; 2015). Идэш тэжээлийн хүртээмж болон байгаль цаг уурын нөхцөлөөс хамааран зарим жилүүдэд хойш Их Нартын байгалийн нөөц газар, Их газрын чулууны байгалийн цогцолборт газар хүртэл нүүдэллэнэ. Сүүлийн үеийн судалгаагаар, 2022, 2023 оны өвлийн улиралд хулангийн сүргүүд Монгол–Хятадын хилийн дагуу шилжин, Замын-Үүдийн боомт орчмоор төмөр замыг баруунаас зүүн тийш хөндлөн гарсан тохиолдол бүртгэгджээ. 2024 оны 11-р сард хийсэн хээрийн судалгаагаар, төмөр зам (УБТЗ)-ын зүүн талд ойролцоогоор 380 хулан бүртгэгдсэн нь түүхэн тархац нутгаа дахин ашиглаж эхэлж буйг харуулна (WCS, 2024b). Монгол орны хулангийн тархац нутгийн хэмжээ ойролцоогоор 262,000 км² бөгөөд энэ нь түүхэн тархац нутгийн ердөө 20% орчмыг хамарна (Kaczensky *et al.,* 2020).



Амьдралын онцлог. Улирлын тогтсон нүүдэл хийдэггүй, харин ус, бэлчээрээ даган байнга шилждэг “хэрмэл” амьтан (Mueller and Fagan, 2008; Nandintsetseg *et al.,* 2016; 2019;

Teitelbaum and Mueller, 2019). Хулангийн байршил нутгийн хэмжээ нэг жилийн хугацаанд хамгийн ихдээ 70,000 км хүрдэг (Kaczensky *et al.,* 2011a) бөгөөд энэ нь дэлхий дээр одоогоор судлагдсан хуурай газрын хөхтөн амьтдыг тэргүүлж байна (Tucker *et al.,* 2018; Joly *et al.,* 2019). Түүнчлэн хүн, малын нөлөө багатай, бартаа саадгүй газар нутгийг илүү сонгон байршина (Kaczensky *et al.,* 2008; Buuveibaatar *et al.,* 2016).

Тахь, гэрийн адуутай адил үетнээр голчлон хооллодог хэдий ч идэш тэжээлийн бүрэлдэхүүн улирлаар өөрчлөгдөнө (Xu *et al.,* 2012; Burnik-Šturm *et al.,* 2017). Сүүлийн үед хийсэн идэш тэжээлийн судалгаагаар, заг (*Haloxylon ammodendrum*), *Artemisia* spp. болон *Anabasis* spp. зэрэг *бутлаг* ургамлууд түүний идэш тэжээлд голлох байрыг эзэлж байна (Burnik-Šturm *et al.,* 2021). Энэ нь гэрийн адууг бодвол идэш тэжээлийн өргөн сонголттой болохыг харуулна. Уснаас ихээхэн хамааралтай, 1-2 хоног тутамд ундаалдаг ба усанд орох давтамж нь тухайн жилийн хур тунадас болон температураас ихээхэн хамаарна (Payne *et al.,* 2020). Өвлийн улиралд ашиглах боломжтой бэлчээр нутгийн хүрэлцээ нэмэгдэж, жилийн хамгийн хахир хатуу нөхцөлийг бэрхшээл багатай давах боломж бүрдэнэ (Kaczensky *et al.,* 2011b). Харин цас багатай өвөл цөөн хэдэн уст цэгүүд бүхэлдээ хөлдөж, хүрэлцээ багасах бөгөөд энэ нь гантай зунаас ч илүү хүнд нөхцөлийг үүсгэнэ (Kaczensky *et al.,* 2010; Payne *et al.,* 2020). Хуурай сайр малтаж ус гаргаж ундаалах чадвартай.

Тогтвортой сүрэг үүсгэдэггүй, сүргийн хэмжээ байнга өөрчлөгдөж байдгаараа тахь болон гэрийн адуунаас ялгаатай (Kaczensky *et al.,* 2008; Rubenstein *et al.,* 2015; Sanderson *et al.,* 2007). Ихэвчлэн 10 хүртэлх тоогоор сүрэглэн явах нь элбэг хэдий ч зарим тохиолдолд сүргүүд нэгдэж, хэдэн зуу, мянгаар тоологдох томоохон сүрэг үүсгэх нь бий (Buuveibaatar *et al.,* 2017; Kaczensky *et al.,* 2015). Ийм том сүргүүд ихэвчлэн уст цэгийн орчим эсвэл бэлчээрийн гарц сайтай нутагт тохиолдоно (Feh *et al.,* 2001).

Монгол орны говиос цуглуулсан олон тооны толгойн ясны үүдэн шүдийг зүсэж цагариг тоолсон судалгаагаар, 29 хүртэл насалдаг болохыг тогтоожээ (Lkhagvasuren, 2015). Гүү 3 наснаас, азарга 5 наснаас үржилд орж эхэлнэ (Ransom *et al.,* 2016). Хээлээ ойролцоогоор 11.5 сар тээж нэг унага төрүүлнэ (P.Kaczenksy, аман мэдээ). Гүү 6-р сарын дундаас 8-р сарын эхэн хүртэл унагалах бөгөөд хүйсийн харьцаа 50:50 байна (Saltz and Rubenstein, 1995; Volf, 2010). Гүү унагалснаас хойш 1-2 долоо хоногт ороо нь орох ба дахин үржилд ороход бэлэн болно (Ransom *et al.,* 2016).

Тоо толгой, нягтшил. Говь Гурвансайханы байгалийн цогцолборт газарт 1995–1997 онд газрын болон агаарын тооллогыг хослуулан гүйцэтгэж хулангийн популяцийг 1,750 (95% CI = 1,000-2,500) бодгаль хэмээн тооцсон байна (Reading *et al.,* 2001). Харин 1997 онд Алтайн өвөр говийн 40,000 км² талбайд хийсэн агаарын судалгаагаар, 1,674 (95% CI = 926-3,025) хулантай гэжээ (Reading *et al.,* 2001). Зүүнгарын говьд 11,027 км² талбайд цэгэн тооллого судалгааг анх 2010 онд хийж, 5,671 (95% CI = 3,611–8,907) бодгаль байгааг үнэлсэн (Kaczensky *et al.,* 2016). Уг судалгааг үргэлжлүүлэн гүйцэтгэж 2015 онд 9,337 (95% CI = 5,337–16,334), 2022 онд 5,204 (95% CI = 2,121–12,771) хулантай хэмээн тус тус үнэлжээ (Vogler *et al.,* 2022). Өмнийн говийн хулангийн популяцийн мониторинг судалгааг анх 2012 онд 78,717 км² талбайд шугаман трансектийн аргаар гүйцэтгэж тоо толгойг 39,602 (95% CI = 29,638–52,916) гэж үнэлсэн (Buuveibaatar *et al.,* 2017). Үүнээс хойш тогтмол мониторинг хийж байгаа бөгөөд хамгийн сүүлийн 2023 оны судалгаагаар, Өмнийн говийн 116,160 км² талбайд 80,000 (95% CI = 56,422–121,160) гаруй хулан байгааг тогтоожээ (WCS, 2023).

Ховордлын гол шалтгаан. Хулангийн популяцид малын тоо толгойн хэт өсөлт, дэд бүтцийн тэлэлт, уул уурхайн олборлолт, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй олон төрлийн хүчин зүйлс нөлөөлж байна (Kaczensky *et al.,* 2020).

Малын тоо 2022 онд 71 саяд хүрсэн нь улсын хэмжээнд бэлчээрийн даацыг хэтрүүлж, шим тэжээл багатай ургамал давамгайлах нөхцөл бүрдүүлсэн бөгөөд энэ нь хулан болон бусад зэрлэг туурайтан амьтдын тэжээлийн нөөцөд ноцтой өрсөлдөөн үүсгэж байна (Šturm *et al.,* 2017; Kaczensky *et al.,* 2020). Малын

тоо толгойн өсөлт, бэлчээрийн ашиглалтын ачаалал нь ялангуяа өвлийн улиралд нөхцөл байдлыг хүндрүүлж, хулангийн амьдрах орчныг хязгаарлана (Payne and Kaczensky, 2019). Усны хүртээмж буурч, малчид ус тээвэрлэх, шинэ худаг гаргах замаар улам алслагдсан бүс рүү нэвтрэх нь хулангийн үлдсэн амьдрах орчныг улам шахсаар байна (Kaczensky *et al.,* 2025).

Дэд бүтцийн хурдацтай хөгжил, тэр дундаа төмөр замын сүлжээ нь хулангийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлаж, амьдрах орчныг хэсэгчлэн хуваах гол шалтгаан болов (Lkhagvasuren *et al.,* 2011; Olson, 2012; Batsaikhan *et al.,* 2014). Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн төмөр зам 1956 онд ашиглалтад орсноос хойш зүүн тийш чиглэсэн хулангийн шилжилт хөдөлгөөнийг бүрэн хязгаарласан (Kaczensky *et al.,* 2006). 2020-2022 онд Өмнийн говьд нийт 930 км урт гурван шинэ төмөр зам баригдсан бөгөөд тэдгээрээс Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн төмөр зам бүрэн, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам хэсэгчилсэн, харин Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр зам одоогоор хориг хашаагүй байна (Kaczensky *et al.,* 2024). Эдгээр төмөр замууд хориг хашаатай болсон нөхцөлд хулангийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлаж үхэл хорогдлыг нэмэгдүүлнэ (Kaczensky *et al.,* 2025). Үүнээс гадна, уул уурхайн олборлолт, тэр дундаа хууль бус алт олборлолт нь хамгаалалттай бүс нутаг руу хүний нөлөөллийг тэлж, бэлчээр доройтуулах, усны эх үүсвэрийг бохирдуулах, хулгайн ан нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлж байна (Kaczensky *et al.,* 2015; 2020; 2025).

Хүнсний хэрэгцээнд зориулан хулгайгаар агнах явдал 2000-аад оны эхээр оргилдоо хүрсэн (Stubbe *et al.,* 2012; Lkhagvasuren *et al.,* 2013; Strindberg and Buuveibaatar, 2018). Сүүлийн жилүүдэд хууль бус агнуур буурсан хэдий ч эдийн засгийн тогтворгүй байдал, инфляцын өсөлт зэрэг нь хулгайн ан дахин сэргэх эрсдэл үүсгэж байна (Kaczensky *et al.,* 2025). Тухайлбал, COVID-19 цар тахлын үед хулангийн уушгийг уламжлалт эмчилгээний зориулалтаар борлуулж байсан тохиолдол бүртгэгдсэн (WCS, 2024).

Монгол орны хэмжээнд сүүлийн 11 (2013-2023) жилийн хугацаанд хууль бус агнуурын 35 хэрэг хууль сахиулах байгууллагуудад бүртгэгдсэн (Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар, 2024).

Малчдын дунд хулан бэлчээр сүйтгэдэг гэсэн ойлголт түгээмэл бөгөөд өвөлжөөний бэлчээрийг хамгаалахын тулд хөөх нь ердийн үзэгдэл (Kaczensky *et al.,* 2020). Автомашин, мотоциклийн хэрэглээ нэмэгдсэнтэй холбоотойгоор хөөх, мөшгөх зэрэг хүний оролцоо, стрессийг нэмэгдүүлэх болов. Хулан өдөр бүр ундаалах шаардлагатай амьтан бөгөөд усны эх үүсвэрийн ойролцоох хүн, малын хэт ачаалал нь тэдний усны хэрэглээнд шууд саад болж, ихэнх тохиолдолд шөнийн цагаар усанд орж байна (Kaczensky *et al.,* 2010; Payne *et al.,* 2020). Энэ нь цөөн хэдэн уст цэгт амьтад олноор бөөгнөрөх шалтгаан болж, улмаар өвчин, паразит дамжих эрсдэлийг нэмэгдүүлдэг (Soilemetzidou *et al.,* 2020).

Уур амьсгалын өөрчлөлт нь дээрх нөхцөл байдлыг улам хүндрүүлж, гантай зун, зудтай өвлийн давтамж, далайц нэмэгдсэнээр хулан олноороо хорогдох эрсдэлийг бий болгож болзошгүй (Kaczensky *et al.,* 2020). Үүн дээр нэмэгдээд хурдацтай өргөжин тэлж буй шугаман дэд бүтцүүд хуланг уст цэгтээ хүрэх боломжийг хязгаарлаж байна. Эдгээр бэрхшээлүүдийг шийдвэрлэхэд шаардлагатай ландшафтын түвшний төлөвлөлт, нэгдсэн бодлого, мөн хулан хамгааллыг тогтвортой хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилт, хүний нөөц хомс байна (Wingard *et al.,* 2014).

Хамгаалсан байдал. Монгол Улс 1953 оноос хулан агнахыг хуулиар хориглож иржээ (Шийрэвдамба нар, 2013). Улмаар Амьтны тухай хуульд заасны дагуу Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор батлагдсан Ховор амьтны жагсаалтад орсон бөгөөд ховор амьтныг (7.5) төрийн захиргааны төв байгууллагаас олгосон зөвшөөрлөөр (7.5.1) судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, эмчилгээний зориулалтаар, мөн (7.5.2) Монгол Улсын болон гадаадын иргэн тусгай төлбөр төлж, харин онцгой тохиолдолд буюу (7.5.3) тодорхой нутаг дэвсгэрт амьтны сүргийн бүтцийг зохицуулах болон халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх зорилгоор тус

тус агнаж, барьж болдог. Харин Амьтны тухай хуулийн 10 дугаар зүйлд зааснаар (10.1.2) агнуурын амьтны жим дээр нүх ухах, буу сойх, занга, сааль тавих, (10.1.3) туурайтан амьтныг агнахад цасанд умбуулах, мөсөнд халтиргах, хясаа, эрэг, ганга руу нисгэх, хавх тавих, (10.1.5) амьтныг агаарын болон авто тээврийн хэрэгслээр хөөх, гэрэлтүүлэх, (10.1.8) ан агнах зориулалтын бус буу, сум хэрэглэх зэрэг арга, зэвсэг хэрэгслээр агнуурын амьтан агнах, барихыг хориглосон.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр хулан 19,430,000 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу).

Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ын I хавсралт, Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)-ын II хавсралтад тус тус бүртгэгдсэн (Чимэддорж нар, 2018; http://checklist.cites.org). Мөн Төв Азийн хөхтөн амьтдыг хамгаалах санаачилга (CAMI)-ын хүрээнд хамгаалагджээ. Түүнчлэн хулангийн нүүдлийг дэмжих, шилжилт хөдөлгөөнд нь саад учруулахгүйн тулд 2014 онд Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)-ын хүрээнд шугаман дэд бүтцийн нөлөөллийг бууруулах олон улсын зөвлөмжийг боловсруулж, улмаар эдгээр зөвлөмжид тулгуурлан Монгол Улс “Тал хээр, говь цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан гарц (MNS 6515:2015)» үндэсний стандартыг баталж, хэрэгжүүлэн ажиллаж байна (MASM, 2015).

Монгол Улсын Улаан номд ховор зүйлээр бүртгэгдсэн (Шийрэвдамба нар, 2013). 2024 онд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас жил бүрийн 10 дугаар сарын 25-ны өдрийг “Хулан хамгаалах өдөр” болгон зарласан (Buuveibaatar *et al.,* 2025).

Тархац нутгийн 42% орчим нь улсын тусгай хамгаалалттай газарт хамрагдсан. 2019 онд Говийн Их дархан цаазат газрын “Б” хэсгийг өргөтгөн 9,600 км^2 нутаг дэвсгэрийг нэмж тусгай хамгаалалтад авчээ.

Хамгаалах арга хэмжээ. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/208 тоот тушаалын “Нэн ховор, ховор хөхтөн амьтдыг хамгаалах төлөвлөгөө”-ний 7 дугаар хавсралтаар “Хулан хамгаалах 2025-2028 оны үйл ажиллагааны төлөвлөгөө” батлагдсан. Тус төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэхэд талуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг бий болгоход анхаарч ажиллах шаардлагатай. Үүнд:

- Амьтны тухай хууль, эрх зүйн орчныг сайжруулж, хулан хамгааллын асуудлыг бусад салбарын хууль эрх зүйн орчин, орон нутгийн бодлого төлөвлөлттэй уялдуулах.
- Байгалийн жамаар өсөж үржих тааламжтай нөхцөлийг хангах зорилгоор хулангийн тархац нутгийг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулж, хамгааллын менежментийг сайжруулах.
- Нэн ховор, ховор амьтдыг сэргээн нутагшуулах, генетик олон янз байдлыг нэмэгдүүлэх замаар тэдгээрийн тоо толгойн тогтвортой өсөлтийг хангах.
- Хулангийн амьдрах орчныг тэтгэх, холбоос нутгийг хамгаалах замаар уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадварыг нэмэгдүүлэх.
- Судалгаа шинжилгээний ажлыг тогтмолжуулах, шинжлэх ухааны дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, нэгдсэн мэдээллийн сан бий болгох.
- Хулангийн байгаль орчин, нийгэм, соёл, эдийн засгийн ач холбогдол, хамгааллын үнэ цэнийг олон нийтэд түгээх, соён гэгээрүүлэх.
- Байгалийн нөөцийн хамтын менежментийг сайжруулах замаар нутгийн иргэдийн хүртэх үр өгөөжийг нэмэгдүүлэх зэрэг болно.

3.29. ЗЭРЛЭГ ГАХАЙ

Sus scrofa (Linnaeus, 1758)

Баг: Туруутан (Artiodactyla)
Овог: Гахай (Suidae)
Англи нэр: Wild Boar
Ижил нэр: *S. barbarus, S. ferus, S. japonica* (Wilson and Reeder, 2005).



Ангилал зүйн тойм. Зэгсний гахайн ангилал зүйн асуудал одоог хүртэл тодорхойгүй.

Таних шинж. Биеийн урт 125-180 см, сэрвээ 80-100 см орчим өндөр, сүүлний урт 20-30 см, жин 125-200 кг. Эрийг бодон, эмийг мэгж, төлийг тоорой гэнэ. Их азарган гахайг хаван, хамгийн том бодонг ногтмол бодон, түүний дараа хангал бодон, хязаалан хадаргаа бодон, соёолон залуу бодон гэх мэтээр нэрлэнэ. Хоёр настай тооройг ховс, гурван настай тооройг шавшуурга гэнэ. Бараан хүрэн, бор саарал. Урт, өтгөн ширүүн үстэй. Хоншоор урт, хүзүү богино, сүүл богино. Бодон ил гарсан хүчирхэг махир соёотой. (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Ховордож болзошгүй (NT) (Clark *et al.,* 2006).

2025 онд Ховордож болзошгүй (NT). Популяцид нөлөөлөх хүчин зүйлсийн талаар доор ховордлын шалтгаан хэсэгт бичсэн бөгөөд тэдгээрийн нөлөөгөөр тоо толгой цөөрөх өндөр эрсдэл байгааг харгалзан энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: С.Батдорж, М.Тамир (2025).



Үнэлгээг хянасан: Ян.Адъяа (2025).

Дэлхийн тархац. Афганистан, Албани, Алжир, Андорра, Армени, Австри, Азербайжан, Бангладеш, Беларусь, Бельги, Бутан, Босни Херцеговин, Болгар, Камбож, Хятад, Хорват, Кипр, Чех, Эстони, Финлянд, Франц (Корсик), Гүрж, Герман, Грек, Хонг Конг, Унгар, Энэтхэг, Индонез, Иран, Исламын Бүгд Найрамдах Улс, Ирак, Израил, Итали (Сардини), Япон, Иордан, Казахстан, Хойд Солонгос, Өмнөд Солонгос, Киргизстан, Лаос, Латви, Ливан, Лихтенштайн, Литва, Люксембург, Малайз, Молдова, Монако, Монгол, Монтенегро, Марокко, Мьянмар, Балба, Нидерланд, Умард Македон, Пакистан, Палестин, Польш, Португал, Румын, Орос, Сан Марино, Серби, Словак, Словени, Испани, Шри Ланка, Швейцар, Сири, Тайван, Хятад, Тажикстан, Тайланд, Тунис, Туркменистан, Турк, Украин, Узбекстан, Вьетнамд тархсан (IUCN, 2025).

Монгол орны тархац, амьдрах орчин. Хөвсгөл, Хангай, Хэнтий, Монгол Алтайн уулс, Дорнод Монголын хамгийн дорнод этгээд, Хянганы салбар уулсын хөвч тайга, холимог ой, шинэсэн ой, томоохон гол, өтгөн шигүү торлог, сөөгт ургамалтай газарт тархсан (Адьяа нар, 2024). *S. s. nigripes* нь Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, Зүүнгарын говийн ихэнх нуурын эрэг, голын татам, баян бүрдийн бургас, улиас, тоорой, харгана, сухай, дэрс, хулсан шугуй, Хар ус, Хар нуурын эргийн зэгсэн шугуй, Ховд, Булган, Зэрэг, Бөхмөрөн, Тэс, Нарийн голуудын татам шугуйд тархжээ (Шийрэвдамба нар, 2013). Сэрүүн бүсийн ой хээр (1.4), улирлын чанартай (тогтмол урсгалгүй) байгын бус гол (горхи) гуу жалга (5.2), тариалангийн талбай (11.1), бэлчээрийн талбайд (11.2) тохиолдоно.

Амьдралын онцлог. Сүргээр амьдардаг, элдэв идэшт амьтан. Гол төлөв ургамлын ногоон хэсэг, үндэс, хушны самар, элдэв үр жимс, булцуу, жижиг нугаламгүй амьтан, чийгийн улаанаас өгсүүлээд элдэв төрлийн шавж, мэлхий, үхэр огдойг хүртэл иднэ. Хэвтрийг логш гэх бөгөөд ихэвчлэн мөчир навчаар засна. Ороо нийллэг нь 11-р сараас 1-р сар хүртэл явагдаж, 5-6-р сард 3-8 тоорой төрүүлнэ (Адьяа нар, 2024).

Тоо толгой, нягтшил. Монгол орны 10 аймгийн 97,808 км^2 нутагт 1,000 га-д 3.2 бодгаль ноогдох нягтшилтайгаар 35,220 толгой нөөцтэй (Ойн туруутны популяцийн үнэлгээ, 2010) .

Ховордлын шалтгаан. Махыг нь хүнсэнд хэрэглэх зорилгоор хууль бусаар агнадаг нь энэ зүйлийг ховордох үндсэн шалтгаан юм. Малын тоо толгой өссөнөөс бэлчээр, нутаг хомсдох, байгалийн болон хүний нөлөөтэй ой, хээрийн түймэр, байгалийн нөөцийн олборлолт зэрэг нь түүний амьдрах орчныг доройтуулдаг (Адьяа нар, 2024). Монгол оронд сүүлийн 11 (2013-2023) жилийн хугацаанд хууль бус агнуурын 50 хэрэг хууль сахиулах байгууллагуудад бүртгэгдсэн (Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар, 2024).

Хамгаалсан байдал. Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор баталсан Ховор амьтны жагсаалтад зэгсний зэрлэг гахай (*Sus scrofa nigripes*) хэмээх салбар зүйл орсон бөгөөд ховор амьтныг (7.5) төрийн захиргааны төв байгууллагаас олгосон зөвшөөрлөөр (7.5.1) судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, эмчилгээний зориулалтаар агнаж, барьж болдог. Амьтны тухай хуулийн 10 дугаар зүйлд зааснаар (10.1.2) агнуурын амьтны жим дээр нүх ухах, буу сойх, занга, сааль тавих, (10.1.5) амьтныг агаарын болон авто тээврийн хэрэгслээр хөөх, гэрэлтүүлэх, (10.1.8) ан агнах зориулалтын бус буу, сум хэрэглэх зэрэг арга, зэвсэг хэрэгслээр амьтан агнах, барихыг хориглосон. Өөр нутагт шилжин байршиж байгаа агнуурын амьтныг агнах, барих, (11.1.4) амьтны үүр, ичээ ухах, гэмтээх, (11.1.7) амьтны үр төлийг агнах, шувууны өндгийг түүх, гэмтээх, устгах зэрэг үйл ажиллагаа явуулахыг хоригложээ. Амьтны тухай хуулийн 9.1.1-д зааснаар зэрлэг гахайг жил бүрийн 12 сарын 01-ний өдрөөс дараа оны 8 сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд ахуй, тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон. Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр зэрлэг гахай (*Sus scrofa*) 1,400,000 төгрөг бол түүний салбар зүйл болох зэгсний зэрлэг гахай (*Sus scrofa nigripes*) 5,690,000 төгрөг ба энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг. Монгол Улсын Улаан номын бүх хэвлэлд зэгсний зэрлэг гахай (*Sus scrofa nigripes*) хэмээх салбар зүйл нь ховор зүйлээр бүртгэгдсэн (Шагдарсүрэн нар, 1987; Шийрэвдамба нар, 1997; 2016). Тархац нутгийн 19.9% нь тусгай хамгаалалттай газарт хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн ангилал зүй ялангуяа, салбар зүйлийн ангилал зүйг нарийвчлан тодруулах, амьдрах орчныг хамгаалах, биологи, экологийн судалгааг тусгайлан хийж, үүний үндсэн дээр хамгаалах арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх, мөн манай орны хувьд байгаль хамгааллын статусыг шинэчлэн тодорхойлох шаардлагатай.

3.30. БОР ГӨРӨӨС
Capreolus pygargus (Pallas, 1771)

Баг: Туруутан (Artiodactyla)
Овог: Буга (Cervidae)
Англи нэр: Siberian Roe Deer
Ижил нэр: *Capreolus bedfordi* Thomas, 1908; *Capreolus capreolus ssp. ochracea* Barclay, 1935; *Capreolus melanotis* Miller, 1911; *Capreolus pygargus var. caucasica* Dinnik, 1910; *Capreolus pygargus var. ferganicus* Rasewig, 1909; *Capreolus tianschanicus* Saturnin, 1906.





Ангилал зүйн тойм. Европын *Capreolus capreolus* зүйлээс салгаж, бие даасан зүйл гэдгийг хүлээн зөвшөөрсөн (Sokolov *et al.,* 1985; Sokolov and Gromov, 1990; Hewison and Danilkin, 2001; Lorenzini *et al.,* 2014).

Таних шинж. Биеийн урт 127-137 см, жин 28-40 кг. Дөнгөж төрсөн янзага 1.4-2.5 кг. Зүс хувьсамтгай. Өвөлдөө зүс бараан саарал, толгой, нуруу, биеийн хажуу бор шаргал, хэвлий, хөлийн дотор тал цайвар шаргал. Зун зүс бүхэлдээ улбардуу бор шаргал. Тана цагаан. Тана өвөл тодорч зундаа бүдгэрнэ. Янзаганы нуруу толботой. Гурын эвэр суурь хэсгээрээ бахим, дунджаар 28-33 см урт, эврийн цалгай (эврийн төгсгөл хоорондын зай) 17-26 см хүрнэ. Бие гүйцсэн гурын эвэр 3 салаатай (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC)

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).

2025 онд Ховордож болзошгүй (NT).

Тархац нутаг уудам хэдий ч харьцангуй элбэгшил популяци бүрд харилцан адилгүй. Жилийн турш агнуурын дарамтад өртдөг (Вингард нар, 2017). Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсэд хууль бус агнуурт өртөх эрсдэлтэй газар өндөр нягтшилтай (Хөхтөн амьтны экологийн нийгэмлэг, 2015). Уудам орон зайд дэгдсэн хээрийн түймэр тоо толгойг цөөрүүлнэ (Довчиндорж, 2023).

Үнэлгээ хийсэн: Г.Довчиндорж, Н.Батсайхан (2025).

Үнэлгээг хянасан: Ян.Адъяа (2025).

Дэлхийн тархац. Казахстан, Хятад, Орос, Монгол, Хойд Солонгос, Өмнөд Солонгост тархсан (Lovari *et al.,* 2016).

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол орны умардын (1.1) ба сэрүүн бүсийн ойн (1.4) экосистем илэрдэг нутагт тархсан (Банников, 1954; Дуламцэрэн нар, 1989; Соколов и Орлов, 1980). Монгол Алтайн баруун этгээд, Хөвсгөл, Хангай, Хэнтий, Дагуур, Дорнод Монголын өмнөд этгээд, Хянганы салбар уулсаар тархсан. Тархалтын өмнөд зах ойн бүсийн өмнө хилтэй давхцах ба манай орны дорнод хязгаарт сөөглөг ургамал, одой хус, бургас, өндөр ургамалтай, зэгстэй голын хөндий, нуурын хөвөө даган хээрийн бүс рүү нэвтэрнэ. Халх, Нөмрөг, Дэгээ голын сав газар, тарамцаг элстэй (10.2), нарстай газар болон ухаа гүвээт хуурай хээр, нугажуу хээрийн экосистемд (4.4) элбэг тохиолдоно (Батсайхан нар, 2022).



Амьдралын онцлог. Идэш тэжээлд нь хоёр үрийн талт өвслөг болон модлог ургамал зонхилох ба нэг үрийн талт ургамлыг голдуу өвөл иднэ. Бугын овгийн амьтад дотроос зөвхөн бор гөрөөсөнд хөврөлийн хөгжлийн далд үе илэрнэ. Зүр 6-7-р сард 1-2 янзага төрүүлнэ. Ороо хөөцөө 7-8-р сард болно. Хөврөлийн хөгжил өвөл эрчимжих ба хээл тээх хугацаа далд үетэйгээ нийлээд 295-300 орчим хоног үргэлжилнэ. Гур өвлийн эхээр эврээ гээх ба сар орчмын дараагаас шинэ эвэр ургаж эхэлнэ (Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Монгол орны ой, түүнтэй хиллэн орших хээрийн экосистемд хийсэн судалгаагаар, 108,537 км² нутагт бор гөрөөсний нягтшил 1,000 га-д 2.4 бодгаль, нийт тоо 29,120 (95% магадлал: 18,845–45,164) гэж үнэлэгдсэн (Биологийн хүрээлэн, 2010) бөгөөд 15 жилийн тэртээ үеэс хойш давтан хийсэн судалгааны мэдээ үгүй тул дээр дурдсан суурь мэдээг ашиглав. Үүнээс хойш хийгдсэн судалгаанууд нь аргазүйн хувьд ялгаатай, харьцангуй бага хэмжээний газар нутгийг хамарсан, нягтшил, тоо толгойн хувьд харилцан адилгүй үр дүнтэй тул хожуу үеийн судалгааны бодит мэдээг тусгах боломж хомс, бэрхшээлтэй. Хээрийн популяцийн хувьд Нөмрөгийн дархан цаазат газар ба түүний орчны бүсэд 1,000 га-д дунджаар 9.6 бодгаль ноогдох нягтшилтайгаар 1,088,927 га талбайд 10,453 орчим бодгаль бор гөрөөс байх боломжтой (Довчиндорж, 2018). Хээрийн популяци Монгол орны ойт нутгийн популяцитай харьцуулахад элбэгшил өндөр. Уудам нутгийг хамарсан их түймрийн нөлөөгөөр энэ популяцийн тоо толгой эрс цөөрсөн (Довчиндорж, 2023).

Ховордлын шалтгаан. Орон нутгийн хэмжээнд мах, эврийг нь ашиглах зорилгоор хяналтгүй агнана. Одоогоор ховордох шалтгаан бага байгаа ч малын тоо толгойн өсөлтөөс (1.1.4.1) улбаатай газрын доройтол болон байгалийн баялгийн нөөцийн олборлолтын (1.3.1) идэвхтэй үйл ажиллагааны уршгаас амьдрах орчны доройтол, хүний сүйтгэл нүүрлэх боломжтой (Батсайхан нар, 2022). Махыг хүнсэнд хэрэглэж ялангуяа, хаврын цагт тамир тэнхээ нэмэх сэлбэх “цус уух” зорилгоор (3.5.1) хууль бусаар олноор агнаж байна (Адъяа, 2024). Мөн түүнчлэн зөвшөөрсөн улирал хамаарахгүйгээр (бор гөрөөсийг зөвхөн намар агнахыг зөвшөөрдөг) бүтэн жилийн турш (3.5.1) агнадаг (Вингард нар, 2017). Нэг анчин жилд дунджаар 2.7 бор гөрөөс агнадаг гэсэн судалгаа бий (Wingard and Zahler, 2006). Улсын хэмжээнд 2015 онд 10 бодгаль бор гөрөөс агнах хяналтын тоо буюу квот тогтоожээ. Гэтэл судалгааны үр дүнгээс харахад, 11,000 орчим анчин

тухайн онд нийт 16,500 орчим бор гөрөөс агнасан (3.4.1) (Wingard and Zahler, 2006). Энэ мэдээ баримт нь улсын хэмжээнд 29,120 бодгаль (Биологийн хүрээлэн, 2010) бөйх тухай популяцийн үнэлгээний 56.6% нь хууль бус агнуурт өртөж байгааг илэрхийлнэ. Хээрийн популяцийн хувьд ховордлын үндсэн шалтгаан нь байгалийн (7.4) болон хүний (10.5) санамсаргүй үйлдлээс улбаатай богино хугацаанд, өргөн нутгийг хамарсан түймэр юм (Довчиндорж, 2023). Хээрийн популяци тоо толгойн хувьд хэлбэлзэл ихтэй (9.8). Ойн цэвэрлэгээ, хууль бус мод бэлтгэл болон нутаг сэлгэх, шилжин нүүхэд нь уул уурхайн олборлолт, тээвэрлэлт саад болж болзошгүй (10.4). Засгийн газраас жил бүр гаргадаг хяналтын агнуурын квотын тоог судалгаанд суурилсан, үндэслэл сайтай тогтоох шаардлагатай (5.3.1). Монгол орны хэмжээнд сүүлийн 11 (2013-2023) жилийн хугацаанд хууль бус агнуурын 94 хэрэг хууль сахиулах байгууллагуудад бүртгэгдсэн (Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар, 2024).

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, өсгөн үржүүлэх, хамгаалах харилцааг зохицуулсан. Энэ хуулийн 9.1.1-д зааснаар бор гөрөөсийг жил бүрийн 12-р сарын 01-ний өдрөөс дараа оны 8-р сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон. Мөн энэ хуулийн (10.1.2) агнуурын амьтны жим дээр нүх ухах, буу сойх, занга, сааль тавих, (10.1.5) амьтныг агаарын болон авто тээврийн хэрэгслээр хөөх, гэрэлтүүлэх, (10.1.8) ан агнах зориулалтын бус буу, сум хэрэглэх зэрэг арга, зэвсэг хэрэгслээр агнах, барихыг хориглодог. Амьтныг (11.1.1) шуурга, ган, зуд, үер, мөндөр, түймэр зэрэг гамшигт нэрвэгдсэн болон гол, мөрөн, намаг, шаварт орох зэрэг биеэ хамгаалах чадваргүй болсон үед агнах, барих, (11.1.2) булаг, шанд, хужир мараанд ирж буй амьтныг отож агнах, (11.1.3) өөр нутагт шилжин байршиж байгаа агнуурын амьтныг агнах, барих, (11.1.4) амьтны үүр, ичээ ухах, гэмтээх зэрэг үйл ажиллагаа явуулахыг хоригложээ. Уг 28.1-д зааснаар (21.1) ан агнах зөвшөөрөл бүхий иргэн зохих төлбөр төлж, сумын Засаг даргаас авсан эрхийн бичгийн дагуу агнуурын ховор амьтнаас бусад амьтныг өөрийн ахуйн зориулалтаар агнаж, барьж болно. Гэхдээ энэ хуулийн 12.1-д зааснаар (25.3) ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тухайн сум дахь байгаль хамгаалагч гарал үүслийн тодорхойлолт олгох ба энэ тодорхойлолт аваагүй амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах, худалдан авахыг хориглосныг анхаарах нь зүйтэй. Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр бор гөрөөс 645,000 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг. Тархац нутгийн 21% (23,399 км^2) нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд, 11% (11,532 км^2) орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт тус тус хамрагдсан (Хөхтөн амьтны экологийн нийгэмлэг, 2015).

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийг хамгаалах чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Бэлчээрийн менежментийг сайжруулах замаар идээшил нутгийг тэтгэх (4.4.3).
- Өндөр нягтшилтай байгаа тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний орчны бүсэд хамгааллын горимыг сайжруулах (4.4.3).
- Хаврын улиралд гөрөөсний цус уухын эсрэг сурталчилгаа, танин мэдэхүйг нэмэгдүүлж, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх (2.2).
- Хүний суурьшлын бүс (1.2.1.3) орчимд хашааны шинээр батлагдсан стандартыг мөрдүүлэх ажлыг эрчимжүүлэх.
- Золбин нохойн хяналт, зохицуулгын ажлыг тогтвортой гүйцэтгэх (4.4.3).
- Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг хамруулан, тэдгээрийн хооронд холбоос нутаг бий болгох (4.3).
- Хууль бус агнууртай тэмцэх нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, сүлжээг сайжруулах (2.3).
- Түймрийн менежментийг сайжруулах шаардлагатай.

3.31. ХАЛИУН БУГА

Cervus canadensis (Erxleben, 1777)

Баг: Туруутан (Artiodactyla)
Овог: Буга (Cervidae)
Англи нэр: Wapiti
Ижил нэр: *C. alashanicus, C. hagenbecki, C. maral* (Wilson and Reeder, 2005), Alashan Wapiti, Izubra/Manchurian Wapiti, McNeill's Deer, Merriam's Wapiti, Shou, Siberian Wapiti, Tien Shan Wapiti, Tule Elk.



Ангилал зүйн тойм. Алтай, Хангай, Хөвсгөл орчим, Хэнтийд шивэр халиун буга *C. e. sibiricus* Severtzov, 1872 бий. Хэнтийн зүүн зах, Хянганы салбар уулсаар улаавтар халиун буга *C. e. xanthopygus* Milne-Edwards, 1867, зүүн өмнөд тал хээр Лхачинвандан ууланд Алашаа халиун буга *C. e. alaschanicus* Bobrynskoy and Flerov, 1935 байж магадгүй (Дуламцэрэн, 1970). Сүүлийн үеийн ном бүтээлд Монголд *Cervus canadensis* Erxleben, 1777 хэмээх биеэ даасан зүйл тархсан (Mattioli, 2011) гэж үзэх болсон. Хил залгаа Орост тархсан халиун бугын генетикийн болон дуу авианы судалгааны дүнг үндэслэн Европын халиун буга (*C. elaphus*), дорнын халиун буга (*C. canadensis*) хэмээх 2 зүйл байгааг тогтоож, филогеографийн бүтэц, генетик олон янз байдлын дүн шинжилгээгээр, Алтай Саяны бүс нутаг Дорнын халиун бугын тархалтын төв (Голосова и др., 2022; Голосова, 2024).

Таних шинж. Биеийн урт 237-270 см, сэрвээний өндөр 115-155 см, жин 250-350 кг. Сүүл богино, 20 см хүрнэ. Монгол орны халиун бугын бие, эврийн жин, салааны тоо Монгол Алтайгаас Хянганы салбар уулс чиглэлд аажим багасна. Зүс мөн чиглэлээр үл мэдэг өвөл цайвар, зун улаавтар болно. Эрийг даарь, эмийг согоо, төлийг илий, нэг настайг зоргол, хоёр настайг соёндой, гурван настайг цөх, дөрөвтэйг таргалтар, хоёроос дээш настай эмийг согоо гэдэг. Халиун буга нэг талдаа 5-7 салаа 1 м хүрэх урт, хосоор 5-10 кг хүнд эвэртэй, согоо мухар.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Устаж байгаа

(CR), A2acd; A3d (Clark *et al.,* 2006).

2025 онд Эмзэг (VU).

1986 онд Монгол орны 115,000 км^2 нутаг дэвсгэрт 130,000 халиун буга байсан (Дуламцэрэн нар, 1989) бол 2004 онд 15 аймгийн хэмжээнд 8,000-10,000 бодгаль болж сүүлийн 18 жилийн дотор 92% буурсан (Zahler *et al.,* 2004). Nowak (1991) энэ зүйлийн үе удмын хугацааг 6 жил гэж тогтоосон. Хараа хяналгүй агналт зэргээс популяци дараагийн гурван үе удмын хугацаанд үргэлжлэн буурна гэж үзээд A3d шалгууруар үнэлэн Устаж байгаа гэсэн зэрэглэлд 2006 онд оруулжээ. 2010 онд хийсэн судалгаагаар, 14 аймгийг хамарсан нийт 124,612 км^2 нутаг дэвсгэрт 1000 га-д 2.1 бодгаль ноогдох нягтшилтайгаар 16,350 толгой халиун буга (Биологийн хүрээлэн, 2010), мөн 2020-2021 онд МУИС, ШУА-ийн судлаачдын баг 15 аймгийн 192,000 км^2 нутагт тархсан бөгөөд дунджаар 55,200 толгой байгааг тус тус тогтоосон. Эдгээрийг харьцуулан үзвэл, 2010 оныхоос тархац нутаг нь 70,000 орчим км^2-аар, тоо толгойн даруй 3 дахин өссөн. Энэ нь сүүлийн жилүүдэд уг зүйлд үзүүлэх агнуурын шууд дарамт буурсантай холбоотой ч Дуламцэрэн нарын 1970-аад оны сүүлчээр хийсэн үнэлгээнээс даруй 50% бага байна. Иймээс дээрх баримт, мэдээллүүдийг үндэслэн Эмзэг зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Ян.Адъяа.(2025)

Үнэлгээг хянасан: Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Канадын өмнөд хэсэг, Америкийн ихэнх хэсэг, Мексикийн хойд нутаг, баруун хойд Африк, баруун болон зүүн Европ, Бага Ази, Сибирийн өмнөд хэсэг, Кавказ, Төв Ази, Хятадын хойд болон баруун хэсэг, Гималайн бүс нутаг, Монгол, Өмнөд Солонгост тархсан (Nowak, 1991).

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол угсаатан эрт дээр үеэс бугыг мэддэг, агнан олборлодог байсныг гэрчлэх буган чулуун хөшөөнөөс эхлээд Хараагийн Ноён уулан дахь Хүн улсын үеийн булшнаас бугын дүрс оёсон ширдэг (Сономцэрэн, 1972), Тамсаг булаг хавьд манай эриний өмнөх дөрвөн мянган жилийн тэртээх булшнаас бугын соёо хэлхэж хийсэн хүзүүний зүүлт (Дорж, 1969) олсон зэрэг археологийн олдвор, олон түүхэн баримт мэдээ сурвалж бий (Адъяа, 2024).



Хөвсгөл, Хангай, Хэнтийн нурууд, Их Хянганы уулс, Монгол Алтайн, Говь Алтайн нурууд, тэдгээрийн салбар уулсын ойт хээр, уулын тайгын бүсийн ой модтой амьдрах орчныг халиун буга шүтэн амьдардаг онцлогтой хэдий ч 1970-аад оны үеэс улиангар хус, торлогон шугуй бүхий уулс, голын дагуух бургасан шугуй, ширэнгэ бүхий хээр тал, бут бүхий нүцгэн уулсаар тархан байрших болсон, тархцын зүүн урд нутагт XIIX зуунд ойтой байсан уул толгодоор нутагшуулсан тусгаарлагдсан популяци бий (Соколов и др., 1982; Дуламцэрэн нар, 1989). Хангай, Хэнтийн нуруунд Монгол орны халиун бугын нийт нөөцийн 74% байршиж байгаа нь эдгээр уулсын систем халиун бугын тохиромжтой амьдрах орчин болохыг нотолно.

Амьдралын онцлог. Зүйл бүрийн өвс, мод, бутны залуу мөчир, навч нахиа, самраас гадна, хаг, хөвд, мөөг иднэ. Өвөл цас зуд, зун ялаа, шумуул, халуунаас зайлж, ууланд улирлын чанартай өгсөж уруудан шилжиж, зайцан байршина. Хоногийн идэвхэд улирал, цаг уур, орчны бусад нөлөө их хамааралтай. Зун сэрүүн сүүдэрлэг, ой ширэнгэ эсвэл салхитай хяр, таг дээр өдрийг өнгөрөөж, үүр, өглөө, үдэш, шөнөөр идээшлэнэ. Сэрүүн салхитай, бүрхэг, зөөлөн шиврээ бороотой бол өдөр ч бэлчинэ. Зун бугын идээшлэх ерөнхий хугацаа өвөл, хаврынхаас арай урт. Бугын арьсанд биеийн бүхий л гадаргууд тархсан дулаан зохицуулах, ялгаруулах үүрэг бүхий хөлсний хэмээх хоолой хэлбэрийн булчирхайтай, мөн өвөрмөц үнэр, өнгө бүхий шүүрлийн бүтээгдэхүүн ялгаруулж зан төрхөд нөлөөлдөг зовхины, нүдний урд талын, уруул, хоншоорын, шулуун гэдэсний төгсгөл, сүүл, үржлийн эрхтний орчмын, турууны завсрын шилбэний зэрэг арьсны 10 өвөрмөц булчирхайг судлан тогтоосон.

Ороо нийллэгээс бусад үед даарь согоо

тусдаа тасран хэд хэдээрээ сүрэглэн бэлчинэ. Эр зоргол согоотой хамт бэлчдэг. Орооны үе 9-р сарын 15-аас даарь, согооны сүрэг задарч нэг даарь ихэвчлэн 3-8 согоо хурааж хээлтүүлнэ. Ороо хөөцөө дууссаны дараа даарь, согоо ялгаран сүрэглэнэ. Хаврын сүүл зуны эхэн сард согоо сүргээсээ ганц нэгээрээ салж төллөнө. Согоо ихэвчлэн ганц илий гаргана. Бүтэн нэг наснаасаа эхлэн эр зоргол 35-40 см, салаагүй шорон эвэртэй, нас нэмэх дутам эврийн салаа нэмэгдэнэ. Гуужилт 4-5-р сард эхэлнэ (Адъяа, 2024).

Тоо толгой, нягтшил. Хэнтий, Хангайн мужид 1966-1975 онд хийсэн судалгаагаар, 107,000 толгой, мөн 2010 онд 14 аймгийг хамарсан нийт 124,612 км^2 нутаг дэвсгэрт 1000 га-д 2.1 бодгаль ноогдох нягтшилтайгаар 16,350 толгой (Биологийн хүрээлэн, 2010), түүнчлэн 2020-2021 онд МУИС, ШУА-ийн судлаачдын баг 15 аймгийн 192,000 км^2 нутагт тархсан бөгөөд дунджаар 55,200 толгой халиун буга байгааг тус тус тогтоосон бөгөөд нягтшил өндөр, байнга үржиж төллөдөг голомт нутаг нь 77,600 км^2 хэмжээтэй.

Ховордлын шалтгаан. Мах, арьс, цусан эврийг ашиглах зорилгоор агнана. Хаясан ясан эврийг нь түүж ашигладаг. Олон жил бүгын цусан эвэр, чив, засаа, сүүл, согооны хээлийг дорно дахины эмнэлэгт ашиглах зорилгоор эрчимтэй агнасан, байгалийн эрсдэлт зарим хүчин зүйлээс шалтгаалан бүгын популяцийн сүргийн зөв бүтэц алдагдаж, нөөц багассан. Дэд бүтэц, хүн амын өсөлт, хөгжил, эрдэс баялгийн ашиглалт, уул уурхайн үйл ажиллагаа зэргээс шалтгаалсан амьдрах орчны хомсдол, хуваагдал, хүний шууд дам нөлөө зэрэг нь ховордуулах шалтгаан болно. Монгол орон XX зууны гучаад он хүртэл дорно дахинд бүгын цусан эвэр бэлтгэн худалддаг гол газар байв. Монголоос 1880-аад оны үеэс Хөх хотын худалдааны яармагт жил бүр 4,000 гаруй хос цусан эвэр аваачдаг (Волосатов, 1890) байсан ба 1908 онд мөн тэнд 4,000 гаруй хос цусан эвэр худалдсан (Свечинков, 1912). 1920-1930-аад оны үеэс Хэнтий, Хангай, Хөвсгөлийн зөвхөн хамгийн зэлүүд ой тайгаас бусад ихэнх нутагт ховордон жилд 200-500 хос цусан эвэр бэлтгэдэг болов (Банников, 1954). 1920-оод оны үед Монгол дахь гадаадын худалдааны пүүс бүгын 12 салаа цусан эврийг хэд хэдэн шар үхрийн үнээр авдаг байжээ (Намнандорж, 1964). Халиун бүгыг тусгай төлбөртэйгөөр дотоод, гадаадын анчдад 1,500 орчим толгойг агнуулах зөвшөөрлийг 1994-2023 онд олгожээ (Адъяа, 2024). Монгол орны хэмжээнд сүүлийн 11 (2013-2023) жилийн хугацаанд хууль бус агнуурын 94 хэрэг хууль сахиулах байгууллагуудад бүртгэгдсэн (Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар, 2024).

Хамгаалсан байдал. Үндэсний ардчилсан хувьсгал ялж, ардын засаг тогтсоны дараахан 1926 онд гарсан агнуурын хуульд бүгыг тодорхой хугацаанд агнахаар зааж, согоог төллөх үеэр агнахыг, 1930-аад оноос цусан эвэр бэлтгэхийг хатуу хоригложээ. 1953 оноос эхлэн буга агнахыг бүрэн хориглон дархалснаар улсын хэмжээгээр буга өсөх нөхцөл бүрдсэн ажээ.

Улс орон зах зээлийн тогтолцоонд шилжсэн 1990-ээд оноос дорнын зах зээлд өндөр үнэлэгдэж өргөн хэрэглэдэг эмийн түүхий эд-цусан ба ясан эвэр, чив засаа, сүүл, согооны хээл, мах өөхийг ашиглах зорилгоор нас, хүйс ялгалгүй хууль бусаар агнах нь ихэссэн, турж эцсэн, хээл томорсон үржлийн үед нь идээшин дассан байршил нутгаас хөөн дайжуулсан зэрэг шалтгаанаар ихэнх тархац нутагтаа эрс ховордсон тул Засгийн газрын 1995 оны 152 дугаар тогтоолоор халиун бүгыг “ховор” амьтны жагсаалтад бүртгэсэн. Монгол Улсын Их Хурлын 2000 оны 31 дүгээр тогтоолоор “Халиун бүгын үндэсний хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлэв. Байгалийн жамаар хэвийн өсөж үржих нөхцөлийг хангах, зориудаар үржүүлж, цөм сүргийг хамгаалах замаар тэдгээрийн тоо толгойг нэмэгдүүлэн зохистой ашиглалт явуулах зорилго бүхий Халиун бүгын үндэсний хөтөлбөрийг хоёр үе шаттайгаар 2000-2006 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын 2000 оны 88 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлсэн. Түүний тоо толгой өсөж, зарим нутагт тархац нутгаа тэлж, агнуур ашиглалтын сөрөг нөлөө харьцангуй багассан тул 2013 онд хэвлэгдсэн Монгол Улсын Улаан номд оруулаагүй.

Монголд анх 1961 онд Богд уулын дархан цаазат газрын Түргэний аманд халиун бүгын цусан эврийн фермийг туршлагын журмаар

байгуулж, Сайд нарын Зөвлөлийн 1964 оны 392 дугаар тогтоолоор бугын аж ахуй болон өргөжиж, жил бүр 300-500 кг хатсан цусан эвэр бэлтгэж, улсад 80-100 мянган ам.долларын орлого оруулж байсан бөгөөд 1968 оноос халиун бугын сангийн аж ахуй болон өргөжин хөгжжээ. 1970 онд Булган аймгийн Хишиг-Өндөр суманд Жагайтын бугын ферм, 1987 онд Могод суманд Дулааны бугын фермийг тус тус байгуулж, 1990-ээд онд эдгээр 3 аж ахуй жилд 600 гаруй буга эвэрлэж, 1,200-1,600 кг нойтон цусан эвэр бэлтгэж байв. 1994-1998 оны үед улсын хэмжээгээр 10 гаруй бугын аж ахуй байгуулагдав (Адъяа, 2024).

Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, өсгөн үржүүлэх, хамгаалах харилцааг зохицуулж байна. Тухайлбал, энэ хуулийн 9.7.4-д зааснаар халиун бугыг жил бүрийн 9 сарын 30-ны өдрөөс дараа оны 6 сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд олзворын ангийн зориулалтаар агнахыг, мөн (9.8.3) жил бүрийн 10 сарын 20-ны өдрөөс дараа оны 6 сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд судалгаа, шинжилгээнээс бусад тусгай зориулалтаар амьдаар барихыг тус тус хориглосон. Үүнээс гадна (10.1.2) агнуурын амьтны жим дээр нүх ухах, буу сойх, занга, сааль тавих, (10.1.5) амьтныг агаарын болон авто тээврийн хэрэгслээр хөөх, гэрэлтүүлэх, (10.1.8) ан агнах зориулалтын бус буу, сум хэрэглэх зэрэг арга, зэвсэг хэрэгслээр агнах, барихыг хориглодог. Амьтныг (11.1.1) шуурга, ган, зуд, үер, мөндөр, түймэр зэрэг гамшигт нэрвэгдсэн болон гол, мөрөн, намаг, шаварт орох зэрэг биеэ хамгаалах чадваргүй болсон үед агнах, барих, (11.1.2) булаг, шанд, хужир мараанд ирж буй амьтныг отож агнах, (11.1.3) өөр нутагт шилжин байршиж байгаа агнуурын амьтныг агнах, барих зэрэг үйл ажиллагаа явуулахыг хорихыг хоригложээ. Уг хуульд заасны дагуу Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор баталсан Ховор амьтны жагсаалтад халиун буга орсон бөгөөд ховор амьтныг төрийн захиргааны төв байгууллагаас олгосон зөвшөөрлөөр (7.5.1) судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, эмчилгээний зориулалтаар, (7.5.2) Монгол Улсын болон гадаадын иргэн тусгай төлбөр төлсөн, онцгой тохиолдол буюу (7.5.3) тодорхой нутаг дэвсгэрт амьтны сүргийн бүтцийг зохицуулах болон халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх зорилгоор тус тус агнаж, барьж болно. Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр халиун буга 12,700,000 төгрөг. Хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг. Тархац нутгийн 20.8% нь улсын тусгай хамгаалалттай газарт 9.5% нь орон нутгийн тусгай хамгаалалттай нутагт тус тус хамрагджээ. БОУАӨ-ийн сайдын 2025 оны А/208 тоот тушаалаар “Халиун буга хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөө (2025-2028)” хэрэгжиж байна.

Хамгаалах арга хэмжээ. Амьдрах орчин, тархац, нөөцийг хамгаалах, биологийн нөөцийг тогтвортой, иж бүрэн ашиглах чиглэлээр доор дурдсан арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Хамгаалах ажлын зохион байгуулалт, эрх зүй, эдийн засгийн үндсийг боловсронгуй болгох.
- Тархац, байршил, тоо толгой, сүргийн бүтэц, нөхөн үржил, агнуурын нөөцийг судлан тогтоох, тэдгээрийг хамгаалах, өсгөн үржүүлэх, нөөцийг тогтвортой ашиглах шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулах.
- Тархац нутгийг орон нутгийн болон улсын тусгай хамгаалалтад хамруулж, хамгаалах менежментийг сайжруулах.
- Тархац нутгийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тодорхой нөхцөл, болзолтойгоор гэрээний үндсэн дээр ашиглуулах ажлыг зохион байгуулах.
- Зориудаар өсгөн үржүүлэх, түүхий эд бүтээгдэхүүнийг иж бүрэн ашиглах арга технологи, стандартыг боловсруулж нэвтрүүлэх, түүхий эдийг иж бүрэн боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагааг дэмжиж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх
- Бугын аж ахуй өндөр хөгжсөн зарим оронд мэргэжилтэн бэлтгэх, боловсон хүчнийг дотоод, гадаадад давтан сургах зэрэг болно.

3.32. ХАР СҮҮЛТ ЗЭЭР

Gazella subgutturosa (Gueldenstaedt, 1780)

Баг: Туруутан (Artiodactyla)
Овог: Тугалмайтан (Bovidae)
Англи нэр: Goitered Gazelle
Ижил нэр: Хар сүүлтий (Дуламцэрэн, 2003); *G. s. subgutturosa, G. s. hillieriana;* Black-tailed Gazelle.





Ангилал зүйн тойм. Дэлхийн тархац нутгийн хэмжээнд 4 салбар зүйл бий (Kingswood *et al.,* 1996). Монгол орны хар сүүлт зээрийг А.Банников (1954), С.Дуламцэрэн (1970), Kingswood and Blank нар (1996) *G. s. hillieriana* (Heude, 1894) хэмээх салбар зүйлд хамааран гэжээ.

Таних шинж. Биеийн урт 97-118 см, сэрвээгээрээ 61-77 см өндөр, жин 19-30 кг. Сүүл 16-24 см. Сүүл хар, хар хүрэн. Танын дээд зах сүүлний уг хүрнэ. Зун зоо нуруу улбардуу бор шаргал, хоолой, хэвэл тод цагаан, өвөл цайвар шаргал, хэвэл цайвар. Эвэр дээд хэсгээрээ цалгайрч, үзүүр нь урагш, дотогш эргэсэн байдалтай (Амгалан, 2021).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Эмзэг (VU), A4cde.

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Эмзэг (VU), A4cde (Clark *et al.,* 2006).

2025 онд Эмзэг (VU). Тархац нутаг тасархайсан байдалтай байгаа хэдий ч өнөөгийн тархац 536,407 км^2 (WCS 2023). Сүүлийн 10-аад жилд хар сүүлт зээрийн чухал амьдрах орчинд шугаман дэд бүтцийн бүтээн байгуулалт эрчимтэй хийгдэж байгаа бөгөөд тухайн дэд бүтцүүд хар сүүлт зээр болон бусад нүүдлийн туруутан амьтдын амьдрах орчинг хуваан чөлөөтэй нүүдэллэх боломжийг эрс хумиж байгаа. Мөн түүнчлэн хууль бус ан байсаар байгаа явдал нь энэ зүйлийн тоо, толгой, тархац нутаг ирээдүйд буурах эрсдлийг үүсгэж байна. Мөн түүнчлэн

байгаль цаг уурын өөрчлөлт, ган, зудын давтамж ойртсон, ундны усны хомсдол, уул уурхайн үйл ажиллагаа, малын тоон өсөлт зэрэг нь амьдрах орчны доройтол, хомсдлыг бий болгож байна. Дээрх аюул заналууд нь популяцийн өсөлтийг хязгаарлаж байгаа тул Эмзэг (VU) зэрэглэлийг хэвээр үлдээв.

Үнэлгээ хийсэн: Л.Амгалан, Б.Бүүвэйбаатар (2025).

Үнэлгээг хянасан: Ян.Адъяа, С.Гомбобаатар (2025).

Дэлхийн тархац. Ази тивд Арабын хойгоос Монголын зүүн өмнө хэсэг хүртэл өргөн уудам нутагт тархсан зүйл. Йемен, Туркийн зүүн хэсэг, Өвөр Кавказ, Туркмен, Казахстан, Хятадын баруун хойд, хойд хэсэг хамрагдана (Harrison and Bates, 1991). Гүрж (Флинт и Присажников, 1986), Ирак, Кувейт, Сири, Йемений нутагт устаж, Иорданы популяци устах эрсдэлтэй учирч буй (East, 1992) бол Афганистаны баруун өмнө нутаг, Пакистанд жижиг тасархайтсан популяциуд үлдэж хоцорчээ. Харин Туркийн зүүн өмнө, Саудын арабын хойд, Оманы хэсгийн популяциуд тоо толгойн өсөх хандлагатай байна (Mallon, 1985; Thouless *et al.,* 1991; East, 1992; Ogurlu, 1992).

Монгол орны тархац, амьдрах орчин. Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Өмнөговь, Дорноговь, Дундговь, зүүн тийш Сүхбаатар аймгийн нутаг хүртэл тархсан (Банников, 1954; Дуламцэрэн, 1970). Харилцан адилгүй цаг хугацаанд түүний тархцыг газрын зурагт тэмдэглэснийг харьцуулан үзвэл, 1950-аад онд манай орны нутаг дэвсгэрийн 31.4%-д байсан (Банников, 1954) бол жараад оны дундуур тархац нь 13.6% хүртэл багасжээ (Шагдарсүрэн, 1966). Их нууруудын хотгор, Нууруудын хөндийд 1970-аад оны сүүлээр үзэгдэхээ байж, зөвхөн Шаргын говьд үлдсэн тухай тэмдэглэжээ (Соколов, 1980). Тархцын өмнөд зах нь улсын хилтэй давхцах ба хойд захыг нь зүүн талаасаа Сүхбаатар аймгийн Онгон сумын Хар говь, Төхмийн говь, Онгон элс, Баяндэлгэр сумын Хонгор багийн Цайдмын говь, Халзан сумын Өөшийн цагаан нуур, баруун тийш Түвшинширээ сумын нутгаар дайрч, Дорноговь аймгийн Сайншанд сумын хойгуур, Дундговь аймгийн Өндөршил, Өлзийт сумын төвөөс урдуур, Өвөрхангай аймгийн Төгрөг сумын нутаг Хонгорын элс, Өшигийн нурууны бэлээр, баруун тийш нууруудын хөндийгөөр Бөөнцагаан нуур хүртэл тархцын хойт зааг үргэлжлэх бөгөөд Бигэр нуурын хотгор, Халиуны хоолой, Шаргын говь, Хүйсийн говь, Жаргалант хайрханы өвөр бэл, Хомын тал, Завхан, Хүнгүй голын адаг зэрэг болно. Увс аймгийн Бөхмөрөн сумын нутаг Ачит нуурын Хотгорын талд үлдэж хоцорсон цөөн тасархай сүрэг одоо Монгол орны төдийгүй дэлхийн хар сүүлт зээрийн тархцын хамгийн хойд хязгаар болно.



Монгол орон дахь тархац нутгийнхаа хэмжээнд нэн олон янзын биотопд байршина. Түүний байршил нутгийг тодорхойлогч гол хүчин зүйл нь идэш тэжээлийн олдоц, хүрэлцээ, улирал, цаг уурын өөрчлөлт, усан хангамж, цасны зузаан, хоргодох хамгаалах нөхцөл, хүний шууд болон дам нөлөө зэрэг болно. Хамгийн тохиромжтой нутаг нь говь цөлийн задгай тал, шил, бэл, толгод, хөндий, хотос, хоолой газар амьдрах ч хүний нөлөөнөөс болж бартаа саадтай машин явж болохооргүй газарт байршдаг болж өөрчлөгдсөн (Амгалан, 2000). Улирлын шилжилт хөдөлгөөн нь тархац нутгийнхаа ихэнх хэсэгт тогтмол бус нүүдэл шилжилттэй (Соколов, 1959). Тогтмол байрших нутаг, шилжих хөдөлгөөнийг урьдчилан таах аргагүй (Горелов, 1980).

Амьдралын онцлог. Түүний идэш тэжээлд 16 овог, 54 төрөлд хамаарах 88 зүйл ургамал оролцоно (Амгалан, 2000). Монгол орны нөхцөлд 12-р сарын сүүлийн хагаст ороо нийлэг эхэлж 1-р сарын дунд хүртэл үргэлжилнэ. Ихэвчлэн 5-6-р сар төллөх

боловч тархац нутгийнхаа хэмжээнд харилцан адилгүй хугацаанд төллөнө. Гантай зун хожуу, зуншлага сайн бол эрт төллөх байдал ажиглагдана. Өмнөговьд шаргачны 80% орчим нь ихэрлэж, намар шаргачны 65% ихэр янзагатай байжээ (Сосорбарам, 1967; Шагдарсүрэн, 1974). Бие гүйцсэн шаргачин голдуу ихэр, хаяа ганц янзага гаргана (Бадамханд, 1984; Жирнов и др., 1985).

Тоо толгой, нягтшил. Монгол орны нөөцийг 50,000 толгой (Амгалан, 1986; Сүхбат, 1990), 100,000 (Zhirnov and Lushchekina, 1992), 60,000 бодгаль (Лхагвасүрэн нар, 1999), Говийн Их дархан цаазат газрын "А" хэсэгт 1997 оны 3-р сард агаараас хийсэн тооллогоор, 100 км^2 нутагт 15.17±3.5 ногдох нягтшилтай 6,046±1,398 толгой байна (Reading *et al.,* 1999) хэмээн тус тус тооцоолж байв. Үүнээс гадна, 1980-аад оны дундуур Монголд барагцаагаар 76,000-100,000 толгой буюу дэлхийн хар сүүлт зээрийн тоо толгойн үндсэн хэсэг нь байна (Соколов и Жирнов, 1986) хэмээн дүгнэж байв. Мөн 1994 онд агаараас хийсэн тооллогоор, Монгол орны хар сүүлт зээрийн тархцын зүүн хэсэг буюу Даланзадгадаас зүүн тийш Дорноговь, Дундговь, Сүхбаатар аймгийн нутагт 275,400 км^2 талбайд 1000 га-д 0.1-15.2 толгой ноогдох нягтшилтайгаар 90,000 орчим хар сүүлт зээр байгааг тогтоосон (Reading *et al.,* 1999). Дээрх судалгаануудыг нэгтгэн 2000 оны байдлаар Монгол оронд 140,000 орчим хар сүүлт зээр 343,900 км^2 нутаг дэвсгэрт байгааг тооцож гаргасан (Амгалан, 2000). Сүүлийн үеийн тооллого, үнэлгээний үр дүнгүүдээр Дорнод болон Галбын говийн 116,158 км2 талбайд 2023 онд шугаман трансектын аргаар хавар 5 сард хийгдсэн судалгааны үр дүнд дундажаар 94,350 (CI 95%: 72,577-122,650) бодгаль (WCS 2023), 2025 онд дээрх 116,158 км2 талбайд ижил аргаар, ижил хугацаанд тооллого хийхэд дундажаар 96,384 (CI 95%: 73,598–126,220) бодгаль (Biological Resource Conservation Center, 2025), Говийн Их ДЦГ-ын Б хэсгийн 19,000 км2 талбайд 2022 онд цэгэн тооллогын аргаар хийгдсэн судалгаагаар дунаджаар 10,980 (CI 95%: 7,743-16,132) бодгаль (Vogler et al., 2022), Хөхөлзэхийн говьд 5,184 км2 талбайд 2017 онд шугаман трансектын аргаар хийгдсэн судалгаагаар 2,785 (CI 95%: 1,964-3,951) бодгаль (Гүнбат 2017) үнэлэгджээ. Эдгээр гурван судалгаа нь тухайн зүйлийн Монгол орны нийт тархац нутгийн 26%-ийг хамарсан бөгөөд нийт үнэлэгдсэн тоо толгой нь 108,115 бодгаль байна. Эндээс үзэхэд Монгол орны хар сүүлт зээрийн популяцийн хэмжээ өндөр байх бүрэн боломжтой.

Ховордлын шалтгаан. Өмнөговь аймгийн орон нутаг судлах кабинетаас гаргасан албан мэдээгээр тус аймаг 1950-1961 онд улсын хөлдүү түүхий эдийн бэлтгэл болон амин хувийн хэрэгцээнд агнасан мэдээнээс үзэхэд, 129,42 тонн мах буюу 80,505 толгой хар сүүлт зээрийн гулууз тушааж байжээ. Судалгаа гаргасан хүмүүс бэлтгэлд нийлүүлсэн маханд ноогдох толгойн тоон дээр мөн бэлтгэлд нийлүүлсэн арьсны тоог нэмж 10 жилийн хугацаанд агнасан бүх толгойн тоог 267,775 гэж мэдээлсэн (Мангалжав, 1961). Сүүлийн жилүүдийн ховордлын гол шалтгаан нь байгаль цаг уурын өөрчлөлт, ган, зудын давтамж ойртсон, ундны усны хомсдол зэрэг болно. Үүний зэрэгцээ хар сүүлт зээрийн тархац нутагт уул уурхайн үйл ажиллагаа эрс нэмэгдэж ихээхэн бэлчээр нутгийг эзлэх болсноор амьдрах орчны хомсдолд орох, төмөр зам, авто замын сүлжээ нь нүүдэл шилжилт хөдөлгөөнийг хязгаарлаж, тусгаарлах үзэгдэл түгээмэл байна.
Монгол орны хэмжээнд сүүлийн 11 (2013-2023) жилийн хугацаанд хууль бус агнуурын 43 хэрэг хууль сахиулах байгууллагуудад бүртгэгдсэн (Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар, 2024).

Хамгаалсан байдал. Монгол Улс 1965 оноос хар сүүлт зээр агнахыг хуулиар бүрмөсөн хориглосон (Шийрэвдамба нар, 2013). Улмаар Амьтны тухай хуульд заасны дагуу Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор баталсан Ховор амьтны жагсаалтад орсон бөгөөд ховор амьтныг (7.5) төрийн захиргааны төв байгууллагаас олгосон зөвшөөрлөөр (7.5.1) судалгаа,

шинжилгээ, соёл, урлаг, эмчилгээний зориулалтаар, мөн (7.5.2) Монгол Улсын болон гадаадын иргэн тусгай төлбөр төлж, харин онцгой тохиолдолд буюу (7.5.3) тодорхой нутаг дэвсгэрт амьтны сүргийн бүтцийг зохицуулах болон халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх зорилгоор тус тус агнаж, барьж болно.

Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.7.3-д зааснаар хар сүүлт зээрийн ооныг жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрөөс дараа оны 8 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд олзворын ангийн зориулалтаар агнахыг хориглосноос гадна, (9.8.2) хар сүүлт зээрийг жил бүрийн 10 дугаар сарын 15-ны өдрөөс дараа оны 7 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд судалгаа, шинжилгээнээс бусад тусгай зориулалтаар амьдаар барихыг хориглосон. Мөн энэ хуулийн 10 дугаар зүйлд зааснаар (10.1.2) агнуурын амьтны жим дээр нүх ухах, буу сойх, занга, сааль тавих, (10.1.5) амьтныг агаарын болон авто тээврийн хэрэгслээр хөөх, гэрэлтүүлэх, (10.1.8) ан агнах зориулалтын бус буу, сум хэрэглэх зэрэг арга, зэвсэг хэрэгслээр амьтан агнах, барихыг хориглосон. Мөн (11.1.1) шуурга, ган, зуд, үер, мөндөр, түймэр зэрэг гамшигт нэрвэгдсэн болон гол, мөрөн, намаг, шаварт орох зэрэг биеэ хамгаалах чадваргүй болсон агнуурын амьтныг агнах, барих, (11.1.2) булаг, шанд, хужир мараанд ирж буй амьтныг отож агнах, (11.1.3) өөр нутагт шилжин байршиж байгаа агнуурын амьтныг агнах, барих, (11.1.4) агнуурын амьтны үүр, ичээ ухах, гэмтээх, (11.1.7) амьтны үр төлийг агнах, шувууны өндгийг түүх, гэмтээх, устгах зэрэг олон үйл ажиллагааг хориглосон байдаг.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр хар сүүлт зээр 3,330,000 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Монгол Улсын Улаан номд ховор зүйлээр бүртгэгджээ (Шийрэвдамба нар, 2013).

Энэ зүйлийн тархац нутгийн 20.1% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд (тухайлбал, Говийн Их дархан цаазат газрын “А”, “Б” хэсэг, Говь Гурвансайханы байгалийн цогцолборт газар, Говийн Бага дархан цаазат газрын “А”, “Б” хэсэг г.м) хамрагдсан бөгөөд үүн дотор дархан цаазат газар 2, байгалийн цогцолборт газар 2, байгалийн нөөц газар 4 байдаг.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийг хамгаалах чиглэлээр дараах арга хэмээг авах нь зүйтэй. Үүнд:

- Хууль бус агнуурт тавих хяналтыг эрчимжүүлж, хуулийн хэрэгжилтийг сайжруулах нь зүйтэй.
- Уул уурхайн нөлөөллийг үнэлж, хохирлыг тооцон зүйлийн хамгаалалд зарцуулах хэрэгтэй.
- Төмөр зам, авто замын төслүүдийн техник-эдийн засгийн үндэслэл боловсруулахаас эхлэн мэргэжлийн байгууллагаар амьтны гарц, гарам хийх цэгүүдийг тодорхойлуулж “Тал хээр, говь цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан гарц MNS 6515:2015” стандартын дагуу тухайн бүс нутгийн газар зүйн байршил, газар нутгийн онцлогт тохируулан гүүрэн гарц, нүхэн гарц, нэг түвшний гарцуудыг стандарт хэмжээний дагуу байгуулах зураг төсөв боловсруулж батлуулах, улмаар хэрэгжилтийг ханган ажиллах зайлшгүй шаардлагатай.
- Увс, Хяргас, Ачит нуур, Хүйсийн говьд хар сүүлт зээрийг сэргээн нутагшуулах шаардлагатай бөгөөд ингэснээр нэр бүхий нутгуудад тусгаарлагдаж, тасархайтсан популяциудыг устахаас аврах, хамгаалах нэг арга зам болно.

3.33. ЯНГИР

Capra sibirica (Pallas, 1776)

Баг: Туруутан (Artiodactyla)
Овог: Тугалмайтан (Bovidae)
Англи нэр: Siberian Ibex
Ижил нэр: Янгир ямаа, *C. altaica, C. hagenbecki, C. wardi* (Wilson and Reeder, 2005); *Capra sibirica* (Pallas, 1776).





Ангилал зүйн тойм. Алтайн янгир *C. s. sibirica,* говийн янгир *C. s. hagenbecki* гэх мэт олон ижил нэр бий (Wilson and Reeder, 2005). Олон судлаачид эдгээр салбар зүйлүүдийг синионим гэдэг бөгөөд ангилал зүйг нарийвчлан судлах шаардлагатай (Mallon *et al.,* 1997; Shackleton, 1997). Янгир нь бусад ямааны зүйлээс салбарласан эсэх нь одоог хүртэл тодорхойгүй бөгөөд зарим судлаачид *Capra sibirica* нэрийг баримталдаг (Shackleton, 1997). Мөн Гептнер нар (1961)-ын бүтээлийг баримтлан Wilson, Reeder нар (2005) энэ зүйлийг бие даасан салангид зүйл хэмээн үзжээ.

Таних шинж. Хүнд лагс биетэй. Хөл богино, сахал урт, эвэр хүнд. Биеийн урт 130-165 см, сэрвээний өндөр 70-110 см, сүүлний урт 10-18 см. Чихний урт 14-16 см. Тэх, ямаа хоёулаа эвэртэй. Тэх гэдрэгээ махийсан

сэлэм хэлбэртэй, бүдүүн, олон төвөнх үе бүхий 74-139 см урт эвэртэй, ямааны эвэр богино, нарийн, 16-38 см урт. Тэхийн биеийн жин 45-153 кг, ямааных 29-90 кг. Залуу бодгаль ихэвчлэн улаавтар, идэр насных хар хүрэн, хар халтар, хөгшрөх үедээ цайвар халтар зүстэй болно. Тэхийн сахал өтгөн, урт (Намнандорж, 1976; Батсайхан нар, 2010; Адъяа, 2016).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Ховордож болзошгүй (NT) (Clark *et al.,* 2006).

2025 онд Эмзэг (VU). Энэ зүйлийн тархац нутаг, амьдрах орчин, популяцийн тоо толгойд нөлөөлж буй сөрөг хүчин зүйлсийн талаар ховордлын шалтгаан хэсэгт бичсэн бөгөөд тэдгээрийн нөлөөгөөр Монгол орны янгирын популяцийн хэмжээний талаар тодорхой мэдээлэл сүүлийн 16 жилд байхгүй бөгөөд аюул заналаас шалтгаалан тоо толгой нь буурах өндөр эрсдэл байгааг харгалзан энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Э.Магсаржав, С.Пүрэвсүрэн (2025).

Үнэлгээг хянасан: Ян.Адъяа (2025).

Дэлхийн тархац. Орос, Казахстан, Узбекистан (Shackleton, 1997), Афганистан, Пакистан, Хятад (Гансу, Шинжан), Тажикстан (Wilson and Reeder, 2005), Энэтхэг (Химикал Прапеш, Жамму-Кашмир), Киргизстан болон Монголд тархсан.

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол Алтай, Говь Алтайн нуруу, тэдгээрийн салбар уулс, Зүүнгарын говь, Алтайн өвөр говийн уулс, Хангайн нурууны Отгонтэнгэрийн өндөрлөгөөс зүүн тийш Орхоны өндөрлөг хүртэл, Хан-Хөхий, Хорьдол Сарьдаг, Улаан тайгын нуруу, Дундговь, Дорноговь аймгийн цөл, цөлөрхөг хээрийн бүсийн зарим уулсаар алаг цоог тархана (Банников, 1954; Дуламцэрэн, 1970; Соколов и др., 1980; Адьяа, 2016). Богдхан уул, Архангай аймгийн Булган, Цогт уул, Хөвсгөл аймгийн Жаргалант сумын Их, Бага хэцүүгийн ууланд сэргээн нутагшуулсан (Магсаржав нар, 2025).

Бэсрэг уулсын бэл энгэр, аараг толгод, өндөр уулын эгц цавчим хад цохио, нуранги асга бүхий давчхан хавцал, ой модгүй газарт нутаглана (Адъяа, 2016). Өндөр уулсын цавчим хадтай газарт байршин амьдрах боловч улирлаар бэлчээрээ сэлгэж байрлана (Батсайхан нар, 2010).



Амьдралын онцлог. Өндөр ууланд 3-40 толгойгоор сүрэглэн амьдарна. Намар, өвөлд олноороо сүрэглэнэ. Зун өглөө болон оройд, өвөлд өдөржин идээшилнэ. Элдэв зүйлийн өвслөг ургамал иднэ. Ороо хөөцөлдөөнд 11-р сарын сүүлч 12-р сарын эхээр орно. Хээл тээх хугацаа 140-175 хоног. Ямаа 4-р сарын сүүлчээр 1 ишиг төрүүлнэ. Хааяа ихэрлэнэ. Хөхүүл үе нь хагас жил шахам үргэлжилнэ. Бэлгийн боловсролт 2 настайгаасаа эхэлнэ. Байгалийн нөхцөлд 12-18 жил насална (Дуламцэрэн, 1970; Батсайхан нар, 2010).

Тоо толгой, нягтшил. Хөвсгөлийн Хорьдол Сарьдаг, Улаан тайгын нуруунд 1980 оны эхээр 1000 гаруй, улсын хэмжээнд 80 орчим мянган толгой байв. 2009 оны судалгаагаар, Монгол орны хэмжээнд 55,985.8 км^2 нутагт тархсан бөгөөд 36.0 мянга орчим янгирын нөөцтэй гэж үнэлжээ. Хэнтийн нурууны баруун өмнөд захын цэг Богдхан ууланд 10 гаруй янгир нутагшуулж, одоо 30 орчим толгой болтлоо өссөн (Адъяа, 2016; Шийрэвдамба нар, 2013).

Улаан тайгын дархан цаазат газар орчмын 900 км^2 нутагт 1,000 га тутамд 0.82 бодгаль ноогдох нягтшилтайгаар 100 орчим толгой янгир, Отгонтэнгэр уулын дархан цаазат газрын орчмын 577,1 км^2 нутагт 1,000 га-д 0.43 бодгаль ноогдох нягтшилтайгаар 25±5 толгой янгир, Тарвагатайн нурууны

байгалийн цогцолборт газрын 735 км^2 нутагт 1,000 га-д 2.04 бодгаль ноогдох нягтшилтайгаар 150 толгой янгир тус тус тархан байршиж байна. Зарим тусгай хамгаалалттай газар нутгуудад 2019 оны судалгааны үр дүнгээр Улаан тайгын дархан цаазат газрын янгирын популяцийн хэмжээ 2016 оныхоос 44.2%-аар, Тарвагатайн нурууны байгалийн цогцолборт газрынх мөн оныхтой харьцуулахад 34.6%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна (Адъяа нар, 2020).

Баянхонгор аймгийн янгир тархсан 11,288 км^2 нутагт 1,000 га-д 2.1 бодгаль ноогдох нягтшилтайгаар 2,493±360 толгой янгир, Баян-Өлгий аймгийн янгирын тархац нутгийн 60% орчим буюу 8,550 гаруй км^2 нутагт 4,156±624 орчим бодгаль, Говь-Алтай аймгийн янгир тархсан 50 гаруй байршилд 10,234 км^2 нутагт 1,000 га-д 3.9 бодгаль ноогдох нягтшилтайгаар 4,032±970 толгой янгирын нөөцтэйг тус тус тогтоожээ (Магсаржав нар, 2024).

Янгирын популяцийн хэмжээ 2024 оны хавар хос ажиглагчын аргаар хийсэн судалгаагаар Дарвийн нуруунд 1,697 км^2 нутагт 100 км^2 талбайд 3.9 бодгаль ноогдох нягтшилтайгаар 67 (CI95%: 50-125) бодгаль янгир, Хасагт Хайранд 4,098 км^2 нутагт 100 км^2 талбайд 7 бодгаль ноогдох нягтшилтайгаар 284 (CI95%: 231-433) бодгаль, Сайр ууланд 769 км^2 нутагт 100 км^2 талбайд 17.8 бодгаль ноогдох нягтшилтайгаар 137 (CI95%: 124-259) бодгаль, Хүнгийн нуруунд 2,037 км^2 нутагт 100 км^2 талбайд 40.2 бодгаль ноогдох нягтшилтайгаар 819 (CI95%: 718-1,157) бодгаль, Цагаан шувуут ууланд 1,005 км^2 нутагт 100 км^2 талбайд 48.8 бодгаль ноогдох нягтшилтайгаар 490 (CI95%: 453-694) бодгаль, Хархираа-Түргэний уулсад 5,686 км^2 нутагт 100 км^2 талбайд 24.7 бодгаль ноогдох нягтшилтайгаар 1,404 (CI95%: 1,248-1,736) бодгаль, Мөнххайрхан ууланд 7,381 км^2 нутагт 100 км^2 талбайд 32.2 бодгаль ноогдох нягтшилтайгаар 2,373 (CI95%: 2,294-2,931) бодгаль хэмээн тогтоогдсон (ДБХС-ийн судалгааны тайлан).

Ховордлын шалтгаан. Дээр үеэс тогтмол агнаснаас түүний тоо толгой цөөрч, тархац нутаг нь тасархайтан хумигдаж байна. Хууль бус агнуур одоо ч элбэг. Түүний байршил нутгийн ус, бэлчээр гэрийн малтай байнга давхацна (Адъяа, 2016). Ирвэс, чоно, шилүүс ялангуяа өвөл, хавар турж эцсэн амьтдыг идэхээс гадна, ишгийг чоно, бүргэд барина (Дуламцэрэн нар, 1989; Соколов, Орлов, 1980). Хамуугаар өвчлөх, гуур, хачиг мэтийн цус сорогч шавж шимэгчлэх, зудад олноор хорогдох зэрэг шалтгаануудын улмаас түүний тоо толгой буурсаар байна (Намнандорж, 1976; Адъяа, 2016; Шийрэвдамба нар, 2013). Монгол орны хэмжээнд сүүлийн 11 (2013-2023) жилийн хугацаанд хууль бус агнуурын 42 хэрэг хууль сахиулах байгууллагуудад бүртгэгдсэн (Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар, 2024).
Мөн малын тоо толгой өссөнөөр бэлчээр нутаг нь хумигдаж, талхлагдаж буй нь ховордлын шалтгааны нэг болж байна. Байгалийн нөөцийн олборлолтын (уул уурхай) үйл ажиллагаа ихэссэнээс орчны алдагдал үүсэх бөгөөд эдгээрийн янгирт үзүүлж буй сөрөг нөлөөг нарийвчлан судлах шаардлагатай (Reading *et al.,* 1997; 2003; 2005; Wingard, 2005). Бүс нутагт мах болон арьсыг худалдаалах, гадаадын анчдад агнуулах, мөн хууль бус болон хяналтгүй агнах нь хорогдлын гол шалтгаан болсоор байна.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуульд заасны дагуу Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор баталсан Ховор амьтны жагсаалтад орсон бөгөөд ховор амьтныг (7.5) төрийн захиргааны төв байгууллагаас олгосон зөвшөөрлөөр (7.5.1) судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, эмчилгээний зориулалтаар, мөн (7.5.2) Монгол Улсын болон гадаадын иргэн тусгай төлбөр төлж, харин онцгой тохиолдол буюу (7.5.3) тодорхой нутаг дэвсгэрт амьтны сүргийн бүтцийг зохицуулах болон халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх зорилгоор тус тус агнаж, барьж болдог.

Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.7.2-т зааснаар тэхийг жил бүрийн 10 дугаар сарын 16-ны өдрөөс дараа оны 7 дугаар сарын 14-ний өдөр хүртэлх хугацаанд

олзворын ангийн зориулалтаар агнах, мөн (9.8.1) янгирыг жил бүрийн 10 дугаар сарын 20-ны өдрөөс дараа оны 8 дугаар сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд судалгаа, шинжилгээнээс бусад тусгай зориулалтаар амьдаар барихыг тус тус хориглосон.
Мөн энэ хуулийн 10 дугаар зүйлд зааснаар (10.1.2) агнуурын амьтны жим дээр нүх ухах, буу сойх, занга, сааль тавих, (10.1.5) амьтныг агаарын болон авто тээврийн хэрэгслээр хөөх, гэрэлтүүлэх, (10.1.8) ан агнах зориулалтын бус буу, сум хэрэглэх зэрэг арга, зэвсэг хэрэгслээр амьтан агнах, барихыг хориглосон. Мөн (11.1.1) шуурга, ган, зуд, үер, мөндөр, түймэр зэрэг гамшигт нэрвэгдсэн болон гол, мөрөн, намаг, шаварт орох зэрэг биеэ хамгаалах чадваргүй болсон агнуурын амьтныг агнах, барих, (11.1.2) булаг, шанд, хужир мараанд ирж буй амьтныг отож агнах, (11.1.3) өөр нутагт шилжин байршиж байгаа агнуурын амьтныг агнах, барих, (11.1.4) амьтны үүр, ичээ ухах, гэмтээх, (11.1.7) амьтны үр төлийг агнах, шувууны өндгийг түүх, гэмтээх, устгах зэрэг олон үйл ажиллагааг хориглосон байдаг.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр янгир 5,300,000 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Монгол Улсын Улаан номд ховор зүйлээр бүртгэгдсэн (Шийрэвдамба нар, 2013).

Энэ зүйлийн тархац нутгийн 14% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд (тухайлбал, Алтай Таван Богдын байгалийн цогцолборт газар, Улаан тайга, Хорьдол Сарьдаг, Отгонтэнгэр уулын дархан цаазат газрууд, Тарвагатайн нурууны байгалийн цогцолборт газар, Говийн Их дархан цаазат газрын “А” хэсэг, Говь Гурвансайханы байгалийн цогцолборт газар г.м) хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ

- Энэ зүйлийн тархац нутаг, популяцийн тоо толгой, хэмжээ, хандлага (3.2), биологи, экологи (3.3), түүнд нүүрлэж буй аюул занал зэргийн судалгааг урт хугацаанд тогтмол хийж, шинжлэх ухаанд тулгуурласан хамгааллын арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай.
- Популяцийг тогтвортой хамгаалахын тулд шинжлэх ухаанд тулгуурласан ашиглалт, хамгааллын тусгай сонирхлын агнуурын менежмент төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлэх нь зүйтэй.
- Хуулийн хэрэгжилт, хяналтыг сайжруулж, хууль бус агнуурын эсрэг үр дүнтэй арга хэмжээ авах, орон нутгийн иргэд, малчдад хуулийг сурталчлах арга хэмжээг тогтмол зохион байгуулах хэрэгтэй.
- Мөн урт хугацааны тогтмол судалгааны үндсэн дээр зориудаар өсгөн үржүүлэх, тохиромжтой газруудад сэргээн нутагшуулах, амьдрах орчныг тэлэх, хамгаалах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй.
- Зарим гадаргын ус хомс бүс нутгуудын булаг шанд, баярбүрдийг хамгаалах, сэргээх, задгай ус бий болгох, булаг шандаас чөлөөтэй ундаалах нөхцөлийг бүрдүүлэх нь чухал.
- Энэхүү үйл ажиллагаанд орон нутгийн иргэд, төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран оролцсоноор янгирын популяцийг тэтгэн хамгаалж, тэдний экосистемд гүйцэтгэх үүргийг хадгалах боломж бүрдэнэ.



ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

МОНГОЛ ОРНЫ АНХААРАЛД ӨРТӨХӨӨРГҮЙ (LC), МЭДЭЭЛЭЛ ДУТМАГ (DD) БОЛОН ҮНЭЛЭХ БОЛОМЖГҮЙ (NA) ХӨХТӨН АМЬТДЫН БИОЛОГИ, ЭКОЛОГИЙН ОНЦЛОГ, ХАМГААЛАЛ



4.1. ДАГУУР ЗАРАА

Mesechinus dauuricus (Sundevall, 1842)

Баг: Шавж идэштэн (Eulipotyphla)
Овог: Зараа (Erinaceidae)
Англи нэр: Daurian Hedgehog
Ижил нэр: *Erinaceus dauuricus* (Банников, 1954; Орлов и Соколов, 1980), *M. manchuricus*, *M. przewalskii*, *M. sibiricus* (Wilson and Reeder, 2005), *Hemiechinus* (*Mesechinus*) *dauuricus* Sundevall, 1841 (Павлинов и Лизовский, 2012).



Ангилал зүйн тойм. Зарим шинжээрээ ердийн болон дэлдэн зарааны завсрын шинжтэй учир бие даасан төрөл (*Mesechinus*)-д хамааруулсан ч ангилал зүй нь бүрэн шийдэгдээгүй. Молекул биологийн судалгаагаар, дагуур болон дэлдэн зараа өөр хоорондоо ихээхэн төсөөтэй болохыг тогтоожээ (Зайцев и др., 2014).

Таних шинж. Биеийн урт 230-270 мм, сүүл 24-38 мм, жин 600-800 г. Нуруу, биеийн хажуугийн үсэн бүрхүүл өргөслөг. Хэвлийн зөөлөн үсэн бүрхүүл голын хэсгээрээ цайвар саарал, захаараа буурал сортой боровтор. Мөч богино. Чих богино, чихний дэлбээ өргөслөг бүрхүүлээс илүү гарахгүй ба урт нь 29-34 мм (Батсайхан нар, 2022). Өтгөн хүрэн, цайвар бор өргөс бараан бүслүүртэй, үзүүрийн хэсэг цайвар. Цав цагаан өргөсгүй (Зайцев и др., 2014).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Тархац нутаг уудам, тоо толгой элбэг, популяцийн хэмжээ буурсан тухай баримтгүй тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Р.Самъяа, Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, Э.Ундрахбаяр, С.Шар (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Оросын Байгалийн чанадах хээр, ойт хээр, Хятадын хойд, зүүн хойд нутаг, Монголд тархсан (Батсайхан нар, 2022; Зайцев и др., 2014; Павлинов и др., 2012; Smith and Yan, 2013).

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол орны зүүн хойд хэсгийн ойт хээр, хээр тухайлбал, Хангайн нурууны зүүн бие Орхон, Сэлэнгэ мөрний хөндий, Хэнтий, Дундад халхын хээр (Банников, 1954; Соколов и Орлов, 1980; Дуламцэрэн нар, 1989), Монгол Дагуур болон Дорнодын хээр, Хянганы салбар уулсын зүүн зах Нөмрөг, Дэгээ, Халх голоор тархана. Дорноговийн Их Нартын байгалийн нөөц газарт дагуур болон дэлдэн зараа хамтдаа тохиолдоно (Batdorj *et al.,* 2018). Сэрүүн бүсийн ойт хээр (1.4), хээрийн (4.4) голын хөндий, нуур, намгархаг газрын ойролцоо (5.1, 5.3) зөөлөн хөрстэй, алаг өвс, үетэн давамгайлсан хээрт амьдарна. Дохиолол дамжуулагч зүүж эзэмшил нутгийг тогтоосон судалгаанд бүртгэгдсэн цэгүүдийн 68% бутлаг ургамалтай хад чулуурхаг (5.3, 6), 21% хад чулуунд (6), 8% таана давамгайлсан бэлчээр (4.4), 3% элсэрхэг (10.2) орчинд бүртгэгджээ (Batdorj *et al.,* 2018).



Амьдралын онцлог. Үдшийн бүрэнхий, шөнө, үүрээр идэвхтэй. Өвөл ичнэ. Өөрөө нүх ухах боловч тарвага, зурам, дагуур огдой зэрэг хээрийн мэрэгч амьтдын эзгүй нүхэнд орогноно (Батсайхан нар, 2022). Хад чулуу, унасан мод, өндөр өвс, сөөг, сөөгөнцөр ургамлын дунд нуугдана. Хоногийн 13 цагт нь идэвхгүй, үлдсэн хугацаанд идэвхтэй. Намар 9-р сарын 20-29 ичээнд орж, 4-р сарын сүүлчээр ичээнээс гарч, үржлийн үе эхэлнэ. Дохиолол бүхий 2 эм зараа 2 удаа төл өгсөн тохиолдол бий. Эм нь идэш тэжээл хайж үүрээ орхин явах үедээ амсрыг нь өвсөөр хучиж далдална. Хоногт нэг бодгалийн явах хамгийн их зай 12.9 ±2.2 км хүрнэ. Эр, эмийн эзэмшил нутаг давхацна. Их Нартын байгалийн нөөц газарт ихэнх зараа хадны доогуур үүр бэлтгэж ичээлнэ. Шавжаар голчлон хооллоно. Их Нартын байгалийн нөөц газарт хийсэн судалгаагаар, 8 овог, 18 төрлийн шавж идэш тэжээлийн үлдэгдлээс илрүүлсний 89.5% хар цохны овгийн (Tenebrionidae) зүйлүүд байв (Batdorj *et al.,* 2018). Мөн энэ нутагт гүйцэтгэсэн судалгаагаар, энэ зүйлийн байршил нутаг хамгийн бага гүдгэр олон өнцөгтөөр тооцвол 64.01 км^2 (39.3 км^2 Kernel), түүний дотор идээшил нутаг 5.6 км^2, харин энэ утга эр, эмnay хувьд болон үржлийн идэвхжлийн үед ялгаатай (Batdorj et al., 2018).

Тоо толгой, нягтшил. Хэнтий аймгийн Норовлин сумын Далт багийн орчим тарважи бүргэдийн үүрэнд энэ зүйлийн арьс олон байснаас үзвэл Улз голын дагуу элбэг тархана (Самъяа нар, 2014). Байгалийн чанад нутгийн зүүн хэсгээр 0.1 км^2 нутагт 0.2-5 бодгаль тохиолдоно (Зайцев и др., 2014).

Ховордлын шалтгаан. Орон нутагт уламжлалт эмчилгээнд ашиглах зорилгоор бага хэмжээгээр олборлоно (3.1.1). Гэнэтийн хорогдол, олшрол зэрэг тоо толгойн хэлбэлзэл илрэхгүй. Уул уурхайн үйлдвэрлэл эрчимжих (1.3.1), малын тоо толгой өссөнөөс бэлчээрийн доройтол (1.1.4.1) бий болж байгаа, хүний санамсаргүй үйлдлээс болж үе үе гарах хээрийн түймэр (7.4) зэрэг нь энэ зүйл амьтны амьдрах орчинд сөрөг нөлөөтэй. Хатуу хучилттай зам дээр тээврийн хэрэгсэлд дайруулна (1.4.4).

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Дагуур зараа 52,000 төгрөг. Монгол Улсын Улаан номд ховор зүйлээр бүртгэгдсэн (Шийрэвдамба нар, 1997). Энэ зүйлийн тархац нутгийн 9% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдсан.

Хамгаалах арга хэмжээ. Тархац нутгийн хэмжээнд бэлчээр ашиглалтыг зохистой болгох (4.2) нь энэ зүйлийн амьдрах орчны чанарыг хадгалах гол арга хэмжээ болно.

4.2. ДЭЛДЭН ЗАРАА

Hemiechinus auritus (Gmelin, 1770)

Баг: Шавж идэштэн (Eulipotyphla)
Овог: Зараа (Erinaceidae)
Англи нэр: Long-eared Hedgehog
Ижил нэр: *H. alaschanicus*, *H. microtus*, *H. caspicus* (Wilson and Reeder, 2005). *Erinaceus auritus* Gmelin, 1770 (Банников, 1954; Соколов и Орлов, 1980). *H. aegyptius* Fischer,1829; *H. albulus* Stoliczka, 1872; *H. caspicus* Sundevall, 1842; *H. minor* Satunin, 1907 (Павлинов и Лисовский, 2012).



Ангилал зүйн тойм. Төрлийн нэрийг *Erinaceus* хэмээн нэрлэж байсан бөгөөд ангилал зүйн хэд хэдэн удаа өөрчлөгдсөн. Тухайлбал, *Erinaceus* нь Павлинов, Россолимо (1987) болон Corbet (1988) нар *Hemiechinus*-ийн салбар төрөл гэж үзэж байв. Харин сүүлийн үед бие даасан төрлийн түвшинд ангилсан (Frost *et al.,* 1991; Hutterer, 2005; Павлинов и др., 1995; Gould, 1995; Павлинов и Россолимо, 1998). Молекул генетикийн судалгаагаар, *H. auritus* болон *M. dauricus* нь *Erinaceus* төрөлд багтах төсөөтэй зүйлүүд болохыг тогтоосон (Банникова и др., 1995, 2003; Bannikova and Lebedev, 2007).

Таних шинж. Биеийн урт 127-183 мм, сүүлний урт 17-23 мм, тавхайн урт 31-37 мм. Биеийн гадаад төрхөөр дагуур зараатай адил. Гэхдээ чих харьцангуй урт, 37-45 мм. Жин 400-700 г. Биеийн хажуу болон нуруу өргөстэй. Мөчид богино, бахим. Хэвлий дун цагаан, урт шөвгөр хоншоортой. Энэ зүйлийн өргөсний үзүүр ямагт цагаан ба өргөсөнд 1-2 хөндлөн хар бүслүүртэй байдгаар бусад зүйлээс ялгарна. Монгол оронд тархсан Дагуур болон дэлдэн зарааны морфологийн харьцуулсан судалгаагаар, дэлдэн зараа чихний уртаас бусад морфометрийн хэмжээ болон биеийн жингийн хувьд дагуур зараанаас эрс бага байдгийг статистик үзүүлэлт харуулсан (Reading *et al.,* 2010).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Монгол орны говь, цөлийн бүсэд өргөн тархсан, тоо толгой элбэг, популяцийн хэмжээ буураагүй тул анхааралд өртөхөөргүй гэж үнэлэв.

Үнэлгээ хийсэн: С.Шар, Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, Р.Самъяа, Э.Ундрахбаяр (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Араб, Грек, Египет, Кипр, Турк, Израил, Ливан, Палестин, Сири, Ирак, Иран, Туркменистан, Азербайжан, Орос, Украйн, Казахстан, Узбекстан, Афганистан, Пакистан, Тажикстан, Хятад, Киргизстан, Монголд тархсан (Stubbe *et al.,* 2021).

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол орны өмнөд, баруун, баруун умард нутгийн цөл, цөлөрхөг хээрийн бүс нутгаар тухайлбал, Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, Зүүнгарын говь, Говь Алтайн нуруу, Умард говь, Дорнод говь, Алтайн өвөр говь, Алашань говьд тархжээ (Соколов и Орлов, 1980; Дуламцэрэн нар, 1989; Батсайхан нар, 2022). Монгол орны жинхэнэ цөл (8), цөлжүү хээр, хээржүү цөлд харьцангуй өндөр ургамалтай, зүйлийн баялаг арвинтай орчныг сонгож амьдардгаар дагуур зарааны амьдрах орчноос ялгаатай (Batdorj *et al.,* 2018).



Амьдралын онцлог. Үдшийн бүрий, шөнө, үүрээр идэвхтэй. Өвөл ичээлнэ. Морин чичүүл, зурам, огдойн нүхэнд орогноно. Голдуу шавж, жижиг хөхтөн амьтан, гүрвэл, бах зэргээр идэш хийнэ. Идэш тэжээлд хатуу далавчтан, шулуун далавчтан, хагас хатуу далавчтан зонхилох ба ходоодны задлан шинжилгээний үр дүнгээс үзэхэд, мөлхөгч, хоёр нутагтан, шувууны өд, жижиг хөхтний үлдэгдэл ч илэрч байжээ (Зайцев и др., 2014). Шавж сонгож иддэг стенофаг амьтан (Batdorj *et al.,* 2018). Өндөр ургамалжилтай, ургамлын бүрхэвч баялагтай газруудыг сонгож амьдрах бөгөөд Их Нартын байгалийн нөөц газарт хийсэн 4 жилийн хээрийн судалгааны явцад түүний амьдрах орчинд 16 зүйлийн ургамал бүртгэгдсэн (Batdorj *et al.,* 2018). Намар 9-р сарын 20-29 хооронд ичээнд орж байв (Batdorj *et al.,* 2018). Зун 6-7-р сард 4-7 зулзага төрүүлнэ. Хээл тээх хугацаа 35-40 хоног. Байгалийн нөхцөлд 6 жил орчим насална (Соколов, 1973).

Тоо толгой, нягтшил. Монгол орны говь, цөлийн бүсэд өргөн тархсан, тоо толгойн хувьд элбэг тохиолдох ердийн зүйл.

Ховордлын шалтгаан. Говь, цөлийн бүсэд нүүрс, алт зэрэг газрын доорх нөөц баялгийг олборлох (1.3.1), мал аж ахуйн бэлчээр ашиглалтын (1.1.4.1) үйл ажиллагааны улмаас түүний амьдрах орчны хомсдох байдал сүүлийн 10 жилд эрс нэмэгдсэн. Түүнчлэн цардмал зам дээр автомашинд дайруулан (4) осолдох тохиолдол жил бүр нэмэгдэж байна.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр дэлдэн зараа 43,000 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 26% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Монгол орны говийн бүсэд уул уурхайн үйл ажиллагаа эрхлэх, цардмал зам тавих (4.2) зэрэг үйл ажиллагааны өмнө энэ зүйлд нөлөөлөх нарийвчилсан үнэлгээг (3.2) хийж тухайн нутаг дахь тоо толгой, нягтшилыг үнэлж байх шаардлагатай.

4.3. ЦАРМЫН АТААХАЙ

Sorex tundrensis (Merriam, 1900)

Баг: Шавж идэштэн (Eulipotyphla)
Овог: Атаахай (Soricidae)
Англи нэр: Tundra Shrew
Ижил нэр: *S. amazari*, *S. baikalensis*, *S. borealis* (Hutterer, 2005) зэрэг олон ижил нэр бий.



Ангилал зүйн тойм. Дийлэнх судлаачид царамын атаахайг *Sorex arcticus* зүйлээс ялгаатай бие даасан зүйл гэж үздэг (Hutterer, 2005).

Танихшинж. Толгойноос сүүлийгоролцуулаад дунджаар 48-77 мм, сүүл 20-47 мм, хойд тавхайн урт 9-13 мм, жин 6-10 г. Толгойн ясны суурийн хэсгийн (кондилобазаль) урт 15.7-18.3 мм. Нуруу нь бараан, хэвлий нь цайвардуу саарал. Нуруу болон хэвлийн өнгөний зааг тод илэрнэ. Толгойн ясны тархины хэсэг нь өргөвтөр боловч нүүрний хэсгийн яс уртас ч нарийссан. Шүдний орой улаан (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Энэ зүйл атаахайн тархац уудам, элбэг тул анхааралд өртөхөөргүй хэмээн үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, Р.Самъяа, Э.Ундрахбаяр, С.Шар (2025).
Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Орос, Хятад, Америк, Канад, Монголд тархсан.

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтий, Монгол Дагуур, Дорнод Монгол, Хянганы өрнөд этгээдээр тархсан. Элдэв янзын амьдрах орчинд тохиолдоно. Голын хөндий, татмын нуга, умардын болон сэрүүн бүсийн элдэв хэв шинжийн ой (1.4), хээрийн экосистемд (4.4) ч тохиолдоно. Гол төлөв нуур, гол, горхины хөвөө орчмын чийглэг нугад байршин амьдарна (Батсайхан нар, 2022).



Амьдралын онцлог. Шөнө болон бүрэнхийд идэвхтэй. Өөрсдөө нүх ухахаас гадна, бусад амьтдын нүхийг ашиглана. Нугаламгүй амьтад болон шавжаар (ялангуяа хатуу далавчтан) хооллоно. Хаяа ургамлын навч идэх тохиолдол бий. Ороо нийллэг 4-5-р сараас эхэлж, үржлийн үе 5-9-р сар хүртэл үргэлжлэн 2-3 удаа төрж, тухай бүрдээ 6-11 гөлчгий гаргана. Байгальд 12-20 сар насална (Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Монгол оронд уудам тархацтай, харьцангуй элбэг зүйл.

Ховордлын шалтгаан. Тархац нутгийн зарим хэсэгт уул уурхай (1.3.1), усны бохирдол (6.3), дэд бүтцийн хөгжил (1.4), эрчимтэй мод бэлтгэлээс (1.3.3) үүдэн хүний нөлөө (1.1.1.3) ихсэж байна. Малын бэлчээрлэлтээс улбаатай газрын доройтол, уур амьсгалын өөрчлөлтийн улмаас амьдрах орчин нь хомсдож болзошгүй. Байгалийн (7.4) болон хүний санамсаргүй өдөөсөн түймэр (10.5) элбэгшилд нөлөөлөх боломжит шалтгаан байж болно.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр цармын атаахай 5,400 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 21% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Бэлчээрийн зохистой менежмент, түймрийн хяналтыг сайжруулах (4.1, 4.2) чиглэлээр тодорхой үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлэх нь зүйтэй.

4.4. ДААГАН АТААХАЙ

Sorex caecutiens (Laxmann, 1788)

Баг: Шавж идэштэн (Eulipotyphla)
Овог: Атаахай (Soricidae)
Англи нэр: Laxmann's Shrew
Ижил нэр: *Sorex buxtoni* Allen, 1903; *Sorex macropygmaeus* Miller, 1901 (Henttonen *et al.,* 2016).



Таних шинж. Биеийн урт 50-70 мм, сүүлний урт 31-51 мм, хойд тавхайн урт 10.4-13 мм, жин 3.5-10.7 г. Нуруу нь хүрэн бор, биеийн хажуу хэсэг нь нуруунаас цайвар, харин хэвлийн хэсэг нь цайвар саарал. Чих үснээс цухуйх төдий. Сүүлний урт нь биеийн уртын хагасаас илүү (ихэвчлэн 75% ба түүнээс их). Шүдний оройн хэсэг улаан (Зайцев и др., 2014; Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Тархац нутаг уудам, тоо толгой элбэг, популяцийн төлөв байдал хэвийн бөгөөд тоо толгой буураагүй хэмээн үзэж энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Д.Лхагвасүрэн, Н.Батсайхан, Э.Ундрахбаяр, Р.Самъяа, С.Шар (2025).
Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Беларус, Хятад, Эстони, Финланд, Япон, Казахстан, Хойд Солонгос, Латви, Норвег, Польш, Орос, Швед, Украйн, Монголд тархжээ (Henttonen *et al.,* 2016).

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол Алтайн уулсын ой, голын хөндий, Хэнтий, Хангайн нуруу, Хөвсгөлийн хөвч тайга, ойт хээрийн бүс, Монгол Дагуурын хээр болон Их Хянганы салбар уулсын голын хөндийн олон янз амьдрах орчинд тохиолдоно. Тухайлбал, ой (1.1), ойт хээрийн бүслүүрийн голын хөндий, өндөр уулын таг болон шинэсэн ойд тохиолдоно. Гол төлөв нуур, голын хөвөө орчмын чийглэг нугад (5.1) байршин амьдарна (Соколов и Орлов, 1980; Mallon, 1985; Дмитриев и др., 1992; Самъяа нар, 2002; Lhagvasuren *et al.,* 2021; Stubbe *et al.,* 2021).



Амьдралын онцлог. Харуй бүрий, шөнийн идэвхтэй. Өөрсдөө нүх ухахаас гадна, бусад амьтдын нүхийг ашиглана. Нугаламгүй амьтад, шавжаар (ялангуяа хатуу далавчтан, хос далавчтан) хооллоно. Ороо нийллэг 4-р сараас эхэлж, 9-р сар хүртэл үргэлжлэх ба 2-3 удаа төрнө. 1 удаад 5-11 гөлчгий төрүүлнэ. Хээл тээх хугацаа 18-28 хоног. Байгалийн нөхцөлд 12-20 сар орчим насална (Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Монгол орон дахь популяцийн тоо толгой, нягтшил бүс нутгаар харилцан адилгүй. Тухайлбал, Баян-Өлгий аймгийн Сагсай сумын Сонгинотын гол, түүний орчим 100 амьд баригч/хоногт 0.35±0.3 бодгаль, мөн Цэнгэл сумын Сыргаль, Бага түргэний гол орчимд 100 амьд баригч/хоногт 1.25±0.72 бодгалийн нягтшилтай тохиолдож байв (Лхагвасүрэн нар, 2022).

Ховордлын шалтгаан. Уул уурхай (1.3.1), хууль бус мод бэлтгэл (1.3.3.1) зэрэг байгалийн нөөцийг тогтворгүй олборлох үйл ажиллагаа ихэссэний уршгаар амьдрах орчин нь устах, усны бохирдол (6.3.7), хүний шууд болон дам нөлөө нь түүний тоо толгой хорогдоход нөлөөлнө.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр дааган атаахай 5,400 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 18% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Популяцийн тоо толгой, нягтшил (3.2), биологи, экологи (3.3), аюул заналын (3.5) судалгааг нарийвчлан хийх шаардлагатай. Доройтсон болон шатсан ойн талбайг нөхөн сэргээх хамгаалах (4.2) зайлшгүй шаардлагатай.

4.5. БЭСРЭГ АТААХАЙ

Sorex daphaenodon (Thomas, 1907)

Баг: Шавж идэштэн (Eulipotyphla)
Овог: Атаахайн (Soricidae)
Англи нэр: Siberian Large-toothed Shrew
Ижил нэр: *S. orii*, *S. sanguinidens*, *S. scaloni* (Wilson and Reeder, 2005).



Ангилал зүйн тойм. *Stroganovia*-ын салбар төрөл гэж үзээд *Daphaenodon, Sanguinidens* ба *Scaloni* гэсэн гурван салбар зүйлд ангилжээ (Yudin, 1989).

Таних шинж. Биеийн урт нь толгойн хамт 64-78 мм, залуу бодгалийн биеийн урт 54-65 мм. Нуруу нь бараан, хэвлийн хэсэг нь бараан саарал. Тавхайн ул хэсэг хар бараан. Чих үснээс цухуйх төдий. Шүдний оройн улаан нь атаахайн бусад зүйлээс мэдэгдэхүйц өргөн бөгөөд лав байна (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Тархац нутаг уудам, тоо толгой элбэг бөгөөд популяцийн хэмжээ буурааагүй хэмээн үзэж энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Э.Ундрахбаяр, Н.Батсайхан, С.Шар, Д.Лхагвасүрэн, Р.Самъяа (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Орос, Казахстан, Хятад, Монголд тархсан (Stubbe *et al.,* 2016).

Монгол орны тархац, амьдрах орчин. Төв Халх, Дорнод Монгол, Монгол дагуурын хээр (Bannikov, 1953; Соколов и Орлов, 1980), Хангайн нурууны дорнод, Сэлэнгийн сав, Хэрлэн голын дунд урсгал болон эхэн (Самъяа нар, 2002), Их Хянганы салбар уулс зэрэг сэрүүн бүсийн ой (1.4), тайгын бутлаг ургамал бүхий газар (3.3) болон бутлаг ургамал зонхилсон намгархаг газар (5.3) тархсан зүйл (Дмитриев и Таракановский, 1984; Clark *et al.,* 2006; Батсайхан нар, 2022).



Амьдралын онцлог. Ой болон ойт хээрийн бүсийн чийглэг нугуудад байршина. Бүрэнхий, шөнийн идэвхтэй. Өөрсдөө нүх ухахаас гадна, бусад амьтдын нүхийг ашиглана. Хорхой, олон хөлтөн зэрэг сээр нуруугүй амьтад болон шавжаар (хааяа хатуу далавчтанаар) хооллоно. Хээлтэй эмэгчин 6-8-р сард 4-9 хөврөлтэй байсан тохиолдол бий (Дуламцэрэн, 1970; Батсайхан нар, 2022). Жилд 2-3 удаа төрнө. Байгальд 12-20 сар насална (Батсайхан нар, 2022).

Тоо, толгой, нягтшил. Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт хийсэн судалгаагаар, 2008 онд 100 конус/хоногт 0.9, 2009 онд 100 конус/хоногт 2.0, 2010 онд 100 конус/хоногт 2.6 бодгаль тус тус баригдаж (Самъяа нар, 2011) байжээ.

Ховордлын шалтгаан. Түүний тархац нутгийн хүрээнд ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар мод бэлтгэх (1.3.3), мөн дэлхийн дулаарал (6.1.1) түүнээс үүдэлтэй байгалийн түймрийн (7.4) давтамж ихсэх зэрэг хүний болон байгалийн хүчин зүйлсийн нөлөөлөл ховордлын гол шалтгаан болно.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр бэсрэг атаахай 5,400 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 16% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Ахуйн болон үйлдвэрийн зориулалтаар мод боловсруулах зэрэг байгалийн баялгийг ашиглах (1.3) явцад хяналт тавих, мөн биологи, экологи (3.3), амьдрах орчны статусыг тодорхойлоход чиглэсэн судалгаа (3.4) хийх шаардлагатай.

4.6. ТЭГШ ШҮДЭТ АТААХАЙ

Sorex isodon (Turov, 1936)

Баг: Шавж идэштэн (Eulipotyphla)
Овог: Атаахай (Soricidae)
Англи нэр: Even-toothed or Taiga Shrew
Ижил нэр: *S. gravesi, S. princeps*, *S. ruthenus, S. montanus*, *S. sachalinensis* (Wilson and Reeder, 2005; Павлинов и Лисовский, 2012).



Ангилал зүйн тойм. Зүйлийн *isodon* нэрийг 1936 оноор авах нь зөв (1924 оны бичиглэл бөгөөд олон улсын Амьтан судлалын нэр томьёоны дүрэм зөрчсөн) ба *gravesi* Goodwin, 1933 нэрийн синоним ч эхний нэр нь түгээмэл хэрэглэж заншсан тул энэ хэвээр үлдээх нь зүйтэй (Павлинов и Лисовский, 2012).

Таних шинж. Төрөл дотроо том, бадриун биетэй. Биеийн урт 54-90 мм, сүүлний урт 34-55 мм, жин 7-14 г (n=38) (Tserendavaa *et al.,* 2023). Толгой нь духны хэсгээрээ өргөн. Нүдний орчим нарийсалт илрэхгүй. Сүүл харьцангуй урт, залуу бодгалийн сүүл үсээр бүрхэгдсэн ба төгсгөлдөө цацаг үүсгэдэг бол бие гүйцсэний сүүлний үс тачир, хайрсархуу, төгсгөлдөө цацаггүй. Үсэн бүрхүүл нэгэн жигд өтгөн хүрэн бор. Биеийн нуруу болон хэвлийн өнгөний тод ялгарал илрэхгүй. Залуу бодгалийн хэвлий арай цайвардуу. Сүүлний үсэн бүрхүүлийн дээд, доод тал ихэвчлэн ялгарах ч зарим тохиолдолд зөвхөн суурь хэсгээрээ өнгөний ялгарал илрэх ба төгсгөл хэсэгтээ ижил.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Манай орны ойтой нутгаар нэлэнхийдээ тархах боломжтой болох нь сүүлийн үеийн судалгаагаар тодорхой болж байгаа учир энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Р.Самъяа, Н.Батсайхан, С.Шар, Д.Лхагвасүрэн, Э.Ундрахбаяр (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Норвег, Швед, Финланд, Орос, Украин, Беларусь, Казахстан, Солонгосын хойг, Хятад (Павлинов и др., 2002; Павлинов и Лисовский, 2012; Зайцев и др., 2014; Smith and Yan 2013), Монголд тархжээ.

Монгол орны тархац, амьдрах орчин. Хэнтий нурууны баруун өмнөд нутгаас Сөгнөгөр голын сав, Хэнтий нурууны дорнод нутагт Зүүнбүрх орчим (Соколов и др., 1980), Хэнтий нурууны баруун нутаг Ерөө голын эхэнд (Самъяа нар, 2002), Монгол Алтайн нурууны Сонгинотын гол дагуух гацууран ойд бүртгэгдсэн (Лхагвасүрэн нар, 2022). Мөн Монгол Дагуурын зарим нутгаар тохиолдоно. Монгол орон бол энэ зүйлийн дэлхийн тархцын өмнөд зах болно. Сэрүүн бүсийн хөвдөн бүрхүүл сайтай өтгөн шилмүүст ойд (1.4) амьдарна. Энэ зүйлийн тархалт сэрүүн бүсийн шилмүүст ойн хилээс гадагш гарахгүй.



Амьдралын онцлог. Түүний идэш тэжээлд чийгийн улаан хорхой, хос далавчтаны авгалдай зонхилно. Хаяа аалз, хайрсан далавчтаны авгалдай илэрнэ. Приморийн хязгаарт идэш тэжээлд нь олон хөлтөн зонхилох боловч цох огт илрээгүй (Зайцев и др., 2014). Үржил нь бусад зүйлээс хожуу эхэлнэ. Жилд 3 хүртэл төллөнө. Төлөрхөг байдал үржлийн нэг улиралд төллөх бүрийд буурдаг бол тархалтын өмнөд захаас хойш шилжих бүр нэмэгдэнэ. Дунджаар 7.6 зулзага төрүүлнэ (Зайцев и др., 2014).

Тоо толгой, нягтшил. Ерөө голын эхний Хонин нуга судалгааны суурингийн жижиг хөхтөн амьтан барихад зориулсан 2,400 конус/хоногийн барилтад 66 бодгаль баригдсан бөгөөд элбэгшлээрээ шавж идэштэн дотроо гуравт бүртгэгджээ. Хонин нугад нэгэн ижил амьдрах орчинд олон жил дараалан (2002, 2003, 2007-2011) хийсэн судалгаагаар, энэ зүйл огт илрээгүй боловч 2006 онд хамгийн элбэг (Tserendavaa *et al.,* 2023) баригдсанаас үзвэл, байгалийн нөхцөлд энэ зүйлийн тоо толгойн хэлбэлзэл их байж болзошгүйг илэрхийлнэ.

Ховордлын шалтгаан. Ховордлын шалтгааны талаарх мэдээлэл хангалтгүй боловч шилмүүст ойн ашиглалт (1.3.3.1; 1.3.3.3), байгалийн түймэр (7.4) зэрэг хүчин зүйлс түүний амьдрах орчинд сөрөг нөлөө үзүүлнэ.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр тэгш шүдэт атаахай 5,400 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 28% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Хүний үйл ажиллагааны нөлөөгөөр ойн түймэр гарахаас (10.5) сэргийлэх, ой ашиглах явцад (1.3.3.1, 1.3.3.2) технологийн горим чанд баримталж их хэмжээний хөвдөн бүрхүүл гэмтэхээс сэргийлэх (4.1, 4.2) шаардлагатай.

4.7. ӨӨДСӨН АТААХАЙ

Sorex minutissimus (Zimmermann, 1780)

Баг: Шавж идэштэн (Eulipotyphla)
Овог: Атаахай (Soricidae)
Англи нэр: Eurasian Least Shrew
Ижил нэр: *S. barabensis*, *S. minimus*, *S. ussuriensis* (Wilson and Reeder, 2005). *S.abnormis* Stroganov, 1949; *S.barabensis* Stroganov, 1956; *S. burneyi* Thomas, 1915; *S. caudata* Yudin, 1964; *S. czekanovskii* Naumov, 1933; *S. karelicus* Stroganov, 1949; *S. minimus* Gmelin, 1793; *S. neglectus* Ognev, 1922; *S. stroganovi* Yudin, 1964; *S. tsherskii* Ognev, 1914; *S. ussuriensis* Ognev, 1922 (Павлинов и Лисовский, 2012).



Ангилал зүйн тойм. Ангилал зүйн хувьд маргаантай. Морфологи шинжээр нь *caecutiens*-ийн бүлэгт оруулж (Долгов, 1985; Павлинов и Россолимо, 1987, 1998; Zima *et al.,* 1998; Hutterer, 2005) байсан ч бөөмийн ДНХ-ийн судалгааны үр дүнд *minutus*-ийн бүлэгт хамруулах болсон (Bannikova and Kramerov, 2005). Гэвч митохондрийн ДНХ-ийн судалгааны дүнд энэ бүлгийн аль ч зүйлтэй ойрын холбоогүй гэж үзсэн (Ohdachi *et al.,* 2006).

Таних шинж. Биеийн урт толгойн хамт 30-53 мм, сүүлний урт 13-17 мм, хойд тавхайн урт 6.8-9.8 мм, жин 1.4-4.5 г. Монгол орны хамгийн жижиг биетэй хөхтөн амьтан. Харьцангуй богино хошуутай, нурууны хэсэг бор хүрэн бөгөөд хэвлий цайвар. Биеийн

нуруун тал хэвлийн тал хоорондын зааг тодорхой ялгарахгүй, сүүл үл мэдэг 2 өнгөтэй, чив ясны толгой бортого хэлбэртэй, 3.7-6.1 мм урт, сууриараа 0.5-1.1мм (Зайцев и др., 2014). Чих үснээсээ цухуйх төдий. Шүдний орой улаан байдгаараа малтаахайгаас хялбархан ялгагдана.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Энэ зүйлийн тархац уудам, популяцийн тоо хэмжээ, төлөв байдал хэвийн хэмээн үзэж энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: С.Шар, Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, Э.Ундрахбаяр, Р.Самъяа (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Норвег, Швед, Финланд, Эстони, Орос, Хятад, Хойт Солонгос, Япон, Америк, Канад, Монголд тархсан (Henttonen *et al.,* 2016).



Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол Алтайн уулс, Их нууруудын хотгор, Хөвсгөл, Хангай болон Хэнтий нуруу, Монгол Дагуурын хээрт бүх биотопод, ялангуяа голын татамд тархсан. Мөн Төв Халхын хээр, Монгол орны зүүн хэсгийн Их Хянганы уулст тэмдэглэгдсэн байна (Соколов и др., 1985; Дмитриев и др., 1992; Литвинов и Базардорж, 1992; Батсайхан нар, 2022). Монгол орны ус намгархаг газрууд (5.1), цэнгэг устай гол горхи, баянбүрд (5.13; 5.9), бутлаг ургамал элбэгтэй орчинд (3.3) амьдарна.

Амьдралын онцлог. Бүрэнхий, шөнийн идэвхтэй. Хатуу далавчит элдэв цохоор голчлон хооллоно. Ороо нийллэг 5-8-р сард болж, хээлээ 18-28 хоног тээнэ. Жилд 2-3 удаа төрөх ба нэг удаад 4-7 гөлчгий гаргана. Байгальд 12-20 сар насална (Соколов, 1973).

Тоо толгой, нягтшил. Монгол оронд өргөн тархацтай, тоо толгойн хувьд элбэг зүйл.

Ховордлын шалтгаан. Тархац нутгийн зарим хэсэгт уул уурхай (1.3.1), усны бохирдол (6.3), дэд бүтцийн хөгжил (1.4), эрчимтэй мод бэлтгэлээс (1.3.3) үүдэн хүний нөлөө (1.1.1.3) ихсэж байна. Малын хөлөөр амьдрах орчин нь доройтох боломжтой. Байгалийн (7.4) болон хүний тавьсан түймэр (10.5) мөн ховордуулах шалтгаан болно.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр өөдсөн атаахай 5,400 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 17% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн тархац нутаг өргөн, тоо толгой элбэг боловч түүний тоо толгой, популяцийн нягтшилын судалгааг тусгайлан хийх шаардлагатай.

4.8. ТАВШГАР АТААХАЙ

Sorex roboratus (Hollister, 1913)

Баг: Шавж идэштэн (Eulipotyphla)
Овог: Атаахай (Soricidae)
Англи нэр: Flat-skulled Shrew
Ижил нэр: *S. dukelskiae*, *S. jacutensis*, *S. platycranius*, *S. thomasi*, *S. tomensis*, *S. turuchanensis* (Hutterer, 2005).



Ангилал зүйн тойм. Тавшгар атаахайг өмнө нь *Sorex vir* хэмээн нэрлэж байв. Харин эдүгээ дийлэнх судлаачид *Sorex roboratus* нэрийг хүлээн зөвшөөрдөг (Hutterer, 2005).

Таних шинж. Биеэр харьцангуй том. Биеийн урт нь толгойн хамт 54-83 мм, сүүлний урт 30-50 мм, хойд тавхайн урт 11-15 мм, жин 7-15 г. Толгойн ясны кондилобазаль урт 19-21.6 мм. Харьцангуй урт хошуутай, завсрын шүдний орчимд илт өргөссөн. Нурууны хэсэг бор, хэвлий цайвар саарал. Чих үснээсээ цухуйх төдий. Шүдний оройн хэсэг улаан өнгөтэй. Дээд эрүүний 1-р үүдэн шүд нь 2 ба 3 дахиасаа нэлээд том, урт (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл
Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Clark *et el.,* 2006).
2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Энэ зүйл атаахайн тархац нутаг уудам, тоо толгой элбэг тул анхааралд өртөхөөргүй хэмээн үнэлэв.
Үнэлгээ хийсэн: Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, Р.Самъяа, Э.Ундрахбаяр, С.Шар (2025).
Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Орос болон Монголд тархсан.

Монгол орны тархац, амьдрах орчин. Хөвсгөл, Хэнтий, Дагуур, Дорнод Монголд тархжээ. Элдэв хэв шинжийн ой (1.4), гол, горхи хөвөөлсөн чийглэг татмын нуга (5.1) зэрэг экосистемд байршин амьдарна (Батсайхан нар, 2022).



Амьдралын онцлог. Бүрэнхий, шөнийн идэвхтэй. Нугаламгүй амьтад, гол төлөв шавжаар хооллоно. Орооо нийллэг 5-8-р сард болж, хээлээ 18-28 хоног тээнэ. Жилд 2-3 удаа төрж, нэг удаад 6-15 гөлчгий гаргана. Байгальд 12-20 сар насална (Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Монгол оронд уудам тархацтай, хааяагүй элбэг зүйл.

Ховордлын шалтгаан. Тархац нутгийн зарим хэсэгт уул уурхай (1.3.1), усны бохирдол (6.3), дэд бүтцийн хөгжил (1.4), эрчимтэй мод бэлтгэлээс (1.3.3) үүдэн хүний нөлөө (1.1.1.3) ихсэж байна. Мал бэлчээрлэлтээс улбаатай газрын доройтол, уур амьсгалын өөрчлөлтийн улмаас амьдрах орчин нь доройтож болзошгүй. Байгалийн (7.4) болон хүний санамсаргүй өдөөсөн түймэр (10.5) элбэгшилд нөлөөлөх боломжит шалтгаан байж болно.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр тавшгар атаахай 5,400 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 28% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Бэлчээрийн зохистой менежмент, түймрийн хяналтыг сайжруулах (4.1, 4.2) чиглэлээр тодорхой ажил төлөвлөж, хэрэгжүүлэх нь зүйтэй.

4.9. НУГЫН МАЛТААХАЙ

Crocidura suaveolens (Pallas, 1811)

Баг: Шавж идэштэн (Eulipotyphla)
Овог: Атаахайн (Soricidae)
Англи нэр: Lesser White-toothed Shrew
Ижил нэр: Малтаахай жөвүү (Дуламцэрэн, 2003); *C. s. shantungensis, C. s. suaveolens* (Батсайхан нар, 2022).



Ангилал зүйн тойм. Ангилал зүйн хувьд *gmelini*-д хамаарах бөгөөд өмнө нь *gueldenstaedtii* зүйл гэж үздэг байсан (Saeedzadeh *et al.,* 2017).

Таних шинж. Биеийн урт 49-58 мм, сүүлний урт 29-32 мм. Атаахайтай харьцуулахад чих том бөгөөд үснээс цухуйж харагдана. Сүүлэндээ богиновтор, жигд, урт сийрэг үстэй. Сүүлний урт нь биеийн уртын хагасаас хэтрэхгүй. Нурууны хэсэг хүрэвтэр туяа бүхий саарал, хэвлийн хэсэг цайвар. Дээд эрүүндээ цагаан өнгийн 3 завсрын шүдтэй (Тэдгээр шүдний орой улаан өнгөгүй) (Дуламцэрэн, 1970; Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Монголд бүртгэгдээгүй байв.

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Тархац нутаг уудам, тоо толгойн элбэг зүйл бөгөөд популяцийн тоо хэмжээ буураагүй хэмээн үзэж энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Э.Ундрахбаяр, Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, Р.Самъяа, С.Шар (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Афганистан, Беларусь, Хятад, Иран, Казахстан, Орос, Тажикстан, Туркменистан, Украйн, Монголд тархсан (Kryštufek and Gazzard, 2023).

Монгол орны тархац, амьдрах орчин. Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, Зүүнгарын говь, Алтайн өвөр говийн баянбүрд, Алашань говь, Дорнод говийн булаг, голын хөндий (Банников, 1953; Батсайхан нар, 2022) зэрэг бүс нутгийн бутлаг ургамалтай (1.4), үетэн давамгайлсан ургамалжилттай (4.4), гол, нуурын татмын намгархаг газар (5.1), түүнчлэн цөл, цөлөрхөг хээрийн (8.3) олон янзын экосистемд тохиолдоно.



Амьдралын онцлог. Хээр, цөлжүү хээр зэрэг олон ялгаатай амьдрах орчинд тохиолдох бөгөөд бүрэнхий, шөнийн идэвхтэй. Элдэв зүйлийн нугаламгүй амьтад болон шавжаар хооллоно. Малтаахай 5-8-р сард үржилд орж, 5-10 гөлчгий гаргана (Батсайхан нар, 2022).

Тоо, толгой, нягтшил. Энэ зүйлийн тоо толгой, нягтшилын талаарх мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Ховордлын шалтгааны талаарх мэдээлэл хангалтгүй байгаа хэдий ч дэлхийн дулаарлаас (6.1.1) үүдэлтэй ган (7.1), байгалийн түймэр (7.4) болон хүний нөлөөтэй түймэр (10.5) зэрэг нь сөрөг нөлөө үзүүлнэ.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр нугын малтаахай 5,400 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 23% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Харьцангуй бага судлагдсан зүйл тул түүний популяцийн тоо толгой, тархац, (3.2), биологи, экологийн (3.3) судалгааг тусгайлан хийж, үүний үр дүнд үндэслэн хамгааллын арга хэмжээг (3.8) төлөвлөх нь зүйтэй.

4.10. АЗИЙН МАЛТААХАЙ

Crocidura shantungensis (Miller, 1901)

Баг: Шавж идэштэн (Eulipotyphla)
Овог: Атаахай (Soricidae)
Англи нэр: Asian Lesser White-toothed Shrew
Ижил нэр: *C. ognevi* (Wilson and Reeder, 2005)



Ангилал зүйн тойм. Өмнө нь 40 хромосом бүхий политип зүйл *Crocidura sauvolens*-д хамааруулж байсан бол сүүлийн үед манай орны Хэнтий, Халх гол орчмын азийн малтаахайнаас цуглуулсан дээжийн генетик шинжилгээний үр дүнд *C. schantungensis* зүйлд хамааруулах болсон (Bannikova *et al.,* 2009).

Таних шинж. Жижиг биетэй. Биеийн урт 68-72 мм, сүүлний урт 24-27 мм, жин 6.5-7.2 г (Батсайхан нар, 2022; Tserendavaa *et al.,* 2023). Нуруу болон хэвлийн үсэн бүрхүүлийн өнгө ялгаатай. Гялалзсан тачир үсэн бүрхүүлийн өнгө цайвардуу элсэн шаргалаас бор саарал болтлоо янз бүр. Хэвлий илүү цайвар. Сүүлний нийт уртын дагуу сийрэг байрших урт үс тод ялгарна.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Монголд бүртгэгдээгүй байв.

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Тархац уудам, популяцийн төлөв байдал

хэвийн, ховордолд хүргэх онцгой шалтгаан үгүй тул энэ зэрэглэлээр үнэлэв.
Үнэлгээ хийсэн: Р.Самъяа, Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, Э.Ундрахбаяр, С.Шар (2025).
Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Оросын Приморийн хязгаар, Байгалийн чанадах нутаг, Зүүн хойд Хятад болон түүний ойролцоох Тайван, Чежу (Солонгос) арлууд (Павлинов и Лисовский, 2012; Зайцев и др., 2014, Smith and Yan 2013) болон Монголд тархсан.

Монгол орны тархац, амьдрах орчин. Энэ зүйлийн дэлхийн тархалтын хамгийн баруун зах манай орны Хэнтийн нурууны баруун хэсэг, Туул голын саваас зүүн тийш Улз, Хэрлэн голын сав дагуу, Халх, Нөмрөг гол, Буйр нуурын эрэг (Р.Самъяа, аман мэдээ) орчмоор тархана (Bannikova *et al.,* 2009; Tserendavaa *et al.,* 2023). Ойт хээр (1.4), хээрийн (4.4) ойн цоорхой болон захаар, мөн гол, нуур, ус намгархаг газрын (5.1) ойролцоох үетэн, алаг өвст нугаар амьдарна.



Амьдралын онцлог. Бага судлагдсан. Приморийн хязгаарт жилд 3 хүртэл төллөж, нэг удаад 3-7 гөлчгий гаргана. Гөлчгий 3 хоногтойдоо биеийн бүх хэсэг үсээр хучигдах ба 9 хоногтоо нүдээ нээж, 14 хоног эхээ хөхнө. Гөлчгий 20 хоногийн настайдаа бие гүйцсэн бодгалийн хэмжээнд хүрнэ (Зайцев и др., 2014). Түүний идэш тэжээлд шавж давамгайлна.

Тоо толгой, нягтшил. Тоо толгойн үнэлгээ хийсэн баримт ховор. Тархалтын аль ч нутагт нягтшил багатай (Зайцев и др., 2014). Хэнтийн нурууны баруун хэсэг Ерөө голын эх Хонин нугад хийсэн судалгаагаар, жижиг мэрэгч, шавж идэштэн барьсан 2,400 конус/хоногт азийн малтаахай дөнгөж 4 удаа баригдсанаас (Tserendavaa *et al.,* 2023) үзвэл, энэ нутгийн шавж идэштний дотор хамгийн цөөн тохиолдох зүйлийн нэгэнд орно.

Ховордлын шалтгаан. Популяцийн төлөв байдал, ховордлын талаар мэдээлэл хомс, ховордлын шалтгаан тодорхой бус.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Азийн малтаахай 5,400 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 16% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ Түүний тархац нутаг, амьдрах орчин, үржил, нягтшилын (3.2, 3.4) талаар нарийвчилсан судалгаа хийх, мөн голын хөндий, нуур, ус намгархаг газрын бэлчээрийг зохистой ашиглах (4.2) нь энэ зүйлийн амьдрах орчныг хамгаалахад дэмжлэг болно.

4.11. УСЧ ГЭРЭЛЗГЭНЭ

Neomys fodiens (Pennant, 1771)

Баг: Шавж идэштэн (Eulipotyphla)
Овог: Атаахай (Soricidae)
Англи нэр: Eurasian Water Shrew
Ижил нэр: *N. aquaticus*, *N. daubentonii*, *N. orientalis* (Wilson and Reeder, 2005). *N. argenteus* Ognev, 1922; *N. orientis* Thomas, 1914; *N. watasei* Kuroda, 1941 (Павлинов и Лисовский, 2012).



Ангилал зүйн тойм. Ангилал зүйн өөрчлөлт, асуудал байхгүй.

Таних шинж. Биеийн урт нь толгойн хамт 69-94 мм, сүүлний урт 44-80 мм, хойд тавхайн урт 17-21 мм, жин дунджаар 14 г. Гадаад төрх атаахай, малтаахай зэрэгтэй төсөөтэй боловч хэмжээний хувьд мэдэгдэхүйц том. Нурууны хэсэг хар, боровтор хар бөгөөд энэ нь түүний мөнгөлөг цагаан хэвлийгээс эрс ялгарна. Сүүлний дээд ба доод тал мөн ийм эрс ялгарсан. Урд, хойд тавхай нь хоёул өтгөн үстэй, хойд тавхай нь хэмжээгээр урт, харьцангуй урт үстэй. Сүүлний доод тал урт, өтгөн үстэй, энэ нь усанд сэлэхэд чухал үүрэгтэй. Дээд эрүүндээ 4 завсрын шүдтэй, тэдгээрийн орой нь улаавтар өнгөтэй зэрэг шинжээр атаахай, малтаахайгаас ялгарна. Ихэнх бодгаль чихний ард мэдэгдэхүйц том цагаан толботой (Зайцев и др., 2014).

Үнэлгээ ба үндэслэл
Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark et al., 2006).
2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Монгол орны ус, намгархаг газарт өргөн тархсан, тоо толгойн элбэг зүйл тул анхааралд өртөхөөргүй гэж үнэлэв.
Үнэлгээ хийсэн: С.Шар, Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, Э.Ундрахбаяр, Р.Самъяа (2025).
Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Испани, Франц, Их Британи, Бельги, Нидерланд, Герман, Норвег, Лихтенштайн, Швейцар, Люксембург, Итали, Дани, Австри, Чех, Словени, Хорват, Швед, Польш, Босни Херцеговин, Унгар, Серби, Монтенегро, Словак, Албани, Финланд, Грек, Румын, Македон, Латви, Болгар, Беларусь, Турк, Орос, Казахстан, Киргизстан, Хятад, Хойт Солонгос, Монголд тархсан. Хятадын хойд хэсэг Шинжаанд байж болзошгүй (Зайцев и др., 2014; Hutterer *et al.,* 2016; https://www.mammaldiversity.org/).

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол орны умард нутгийн гол мөрний саваар ихэд тархсан. Хэнтий нуруунд Хараа голд, Монгол Алтайд Ховд голын эх (Соколов и Орлов, 1980), Хангайн нурууны баруун умард нутагт Тэс, Завхан голын сав (Банников, 1954; Дуламцэрэн нар, 1989), Хангайн нурууны дорнод нутагт Орхон, Сэлэнгийн дагуу нутгаас (Соколов и др., 1985) тус тус олджээ. Их нууруудын хотгорын өрнөд нутагт Чоно харайх голд хожуухан тэмдэглэгдсэн (Samiya *et al.,* 1993). Ховд аймгийн Чандмань сумын Хойт голд 2010 онд тэмдэглэжээ (С.Шар, В.Лебедев нарын аман мэдээ).Монгол орны ус намгархаг (5.1) болон гол горхины бутлаг ургамал бүхий чийглэг газруудад (5.3) тохиолдоно.



Амьдралын онцлог. Газар, усны амьдралтай, усанд сайн сэлэх, шумбах чадвартай. Бүрэнхий, шөнө идэвхтэй. Элдэв зүйлийн усны шавж, усны сээр нуруугүй амьтад, хавч хэлбэртэн, хоовгоно ба ялааны авгалдай, эрэг орчмын хуурай газраас чийгийн хорхой, зөөлөн биетэн, загасны түрс, жараахай, хоёр нутагтан зэргээр хооллоно. Усны 50-70 см гүнээс хоолоо олох чадвартай. Шүлс нь хоол бологч амьтнаа муужруулах чадвартай (Зайцев и др., 2014). Оroo нийллэг 5-8-р сард болж, хээлээ 24 хоног тээнэ. Жилд 2 удаа төрөх ба тухай бүрдээ 4-14, дунджаар 6-8 гөлчгий гаргана. Байгалийн нөхцөлд 19 сар орчим хугацаанд амьдрах ба лабораторийн нөхцөлд 3-4 жил амьдарч байжээ (Зайцев и др., 2014).

Тоо толгой, нягтшил. Монгол орны ус, намгархаг орчинд өргөн тархацтай, тоо толгой элбэг зүйл. Амьдрах орчин таатай нөхцөлд тоо толгойн хэлбэлзэл багатай (Зайцев и др., 2014).

Ховордлын шалтгаан. Уул уурхай (1.3.1), мод бэлтгэл (1.3.3) зэрэг байгалийн нөөц олборлох үйл ажиллагаа ихэссэний уршгаар усны бохирдол (6.3), малын нөлөө (1.1.4), хүний үйл ажиллагааны сөрөг нөлөө (10) ихсэж байна.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр усч гэрэлзгэнэ 5,400 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 19% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Тоо толгой, нягтшилын судалгааг (3.3) тусгайлан хийж, ус намгархаг газрыг хамгаалах, нөхөн сэргээх (4.2) зэрэг амьдрах орчинд тулгуурласан хамгаалах арга хэмжээг боловсруулах шаардлагатай.

4.12. ХЭЭРИЙН САХАЛТ БАГВААХАЙ

Myotis davidii (Peters, 1869)

Баг: Гардалавчтан (Chiroptera)
Овог: Багваахай (Vespertilionidae)
Англи нэр: David's Myotis
Ижил нэр: Хээрийн багваахай, *Myotis mystacinus przewalskii* Bobrinskii, 1926; *M. nipalensis przewalskii* Bobrinskii, 1926; *Vespertilio davidii* Peters, 1869; Steppe Whiskered Bat.



Ангилал зүйн тойм. Хээрийн сахалт багваахайг удаан хугацааны туршид *Myotis mystacinus* зүйлд хамааруулж байсан (Банников, 1954; Соколов и Орлов, 1980). Benda, Tsytsulina нар (2000) бүтээлдээ *Myotis aurascens* Kuzyakin, 1935-ийг бие даасан зүйл болгож Монголд тархсан *Myotis mystacinus* зүйлийг үүнд хамааруулсан. *Myotis aurascens, M. nipalensis* зүйлийг *M. davidii* (Peters, 1869) зүйлд багтаан ангилсан (Benda *et al.,* 2012) боловч *M. aurascens*-ийг *M. davidii*-ээс тусдаа бие даасан зүйл хэмээн судлаачид үзэх болсон.

Таних шинж. Зүс маш хувирамтгай (Банников, 1954). Жижиг биетэй, жин 4.0-10 г. Нуруун тал бор шаргалаас элсэн, алтлаг, цайвар шаргал, хэвлий нь бор шаргалаас бараг цагаан. Далавчны хормой нь хойд хөлийн гадна талын хурууны угаар юм уу түүний ойролцоо нийлэх бөгөөд унжир үгүй (Ариунболд, 2018).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Монголд бүртгэгдээгүй байв.

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Монгол орны хувьд өргөн тархалттай, тоо толгойн элбэг зүйл юм.

Үнэлгээ хийсэн: Ж.Ариунболд, Д.Мөнхнаст (2025).

Үнэлгээг хянасан: Н.Батсайхан, С.Гомбобаатар (2025).

Дэлхийн тархац. Зүүн өмнөд Европоос (Волга мөрөн, Кавказ) Байгаль нуур, Монголын хээр, баруун болон хойд Хятад, Солонгос, урагш Гималай хүртэл үргэлжилнэ (Tsytsulina *et al.,* 2012). Иран, Гүрж, Украин, Казахстан, Киргизстан, Туркменистан, Өмнөд Солонгос, Молдова, Орос (Тува, Волгоград, Ставропольск, Ростов) (Benda *et al.,* 2012), төв болон өмнөд Хятад (Хайнан арал), Хонг Конгод тархжээ (Jiang *et al.,* 2019).

Монгол орны тархац, амьдрах орчин. Монголд тархсан багваахайнуудаас хамгийн өргөн тархацтай зүйл бөгөөд гүн их хөвчөөс бусад бүх нутагт тархсан (Дуламцэрэн, 1970). Хангай, Хөвсгөл, Хэнтийн нуруу, Их нуурын хотгор, Нууруудын хөндий (Батсайхан нар, 2004), Алтайн өвөр говь, Алашань говь, Зүүнгарын говь, Монгол Алтай, Говь Алтайн нуруу, Дорнод говьд тархсан (Банников, 1954; Stubbe and Chotolchu, 1968; Соколов и Орлов, 1980; Ариунболд, 2018). Дээврийн хөндий, хадны ангалд хоргодон голдуу усны ойр хавь, хүний ойролцоо байршина (Соколов и Орлов, 1980). Зуны улиралд модны хөндий, бургасан шугуй (1.4), хадны ангал, агуй (7.1), байшингийн дээвэр, гүүрний доорх хөндий, малын хашааны саравч, худаг (11.5) зэрэгт орогноно (Ариунболд, 2018).



Амьдралын онцлог. Харьцангуй өндөр температуртай орчинд тархдаг байж магадгүй (Tsytsulina *et al.,* 2012). Эмэгчин 7-р сарын эхэн хагаст бөөгнөж нэг зулзага төрүүлнэ. Энэ үед эрэгчнүүд цөөн тоогоор сүрэглэн, тусдаа амьдарна (Ариунболд, 2018). Өвлийн улиралд говийн гүн агуйд ичээлнэ (Ariunbold, 2016a). Шар шувууны гулгидаснаас олдсон тохиолдол байгаагаас үзэхэд, энэ багваахай мах идэшт шувууны идэш тэжээлд оролцдог (Шар, 1999).

Тоо толгой, нягтшил. Монгол орны популяцийн тоо хэмжээ, нягтшилын талаар судалгааны мэдээ, баримт байхгүй.

Ховордлын шалтгаан. Амьдрах орчны алдагдал, мод огтлол (1.3.3), уул уурхай (1.3.1), тохиолдлын үхэл хорогдол (4.1), хордуулах (4.1.2.3), ган гачиг (7.1), шуурга (7.2), гал түймэр (7.4), махчид (8.2), аялал жуулчлал (10.1) зэрэг нь сөрөг нөлөө үзүүлдэг бололтой. Бэлчээрийн доройтол, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор тал хээр, говь цөлийн бүсэд агуйн ам элс, шороо, цасаар тагларч ичээнээсээ гарч чадалгүй 2000 орчим хээрийн сахалт багваахай үхсэн баримт бий (Dalannast *et al.,* 2024). Мөн агуйн орчимд жонш зэрэг ашигт малтмал олборлож тэсэлгээ хийснээс агуйд эвдрэл үүсэж гар далавчтан орогнох орчноо алдаж, үхэх шалтгаан болж байна.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр хээрийн сахалт багваахай 4,700 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 19% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ

- Шинжлэх ухаанд тулгуурласан хамгааллын арга хэмжээ авахад түүний популяцийн тоо толгой, хэмжээ (3.2), биологи, экологи (3.3), аюул занал (3.5), өөрчлөлтийн чиг хандлагын мониторинг судалгааг (3.9) нарийвчлан хийх шаардлагатай.
- Хамгаалалтад тухайлсан газруудыг авах, түүнд чиглэсэн үйл ажиллагаа (4.4.1) шаардлагатай.
- Байгальд гүйцэтгэх үүрэг, ач холбогдлыг олон нийтэд сурталчлан таниулах замаар үржлийн үеийн бөөгнөрлийг хамгаалах үйл ажиллагаа хэрэгжүүлэх нь зүйтэй.

4.13. УССУРЫН САХАЛТ БАГВААХАЙ

Myotis sibiricus (Kastschenko, 1905)

Баг: Гардалавчтан (Chiroptera)
Овог: Багваахай (Vespertilionidae)
Англи нэр: Siberian Myotis
Ижил нэр: Ойсог багваахай, *Myotis brandtii gracilis* Ognev, 1927; *Myotis mystacinus gracilis* Ognev, 1927.



Ангилал зүйн тойм. *Myotis mystacinus*–ийн салбар зүйлээс тусдаа бие даасан *M. brandtii* зүйл болгосон (Hanák 1970, 1971; Gauckler and Kraus, 1970; Corbet, 1978). *M. brandtii* гэх зүйлийн энэ салбар зүйлийг *Myotis gracilis* Ognevi, 1927 бие даасан тусгаар зүйл болгосон (Horaček *et al.,* 2000). Монголд тархах *M. brandtii gracilis* салбар зүйлийг бие даасан *Myotis gracilis* Ognevi, 1927 зүйлд хамааруулна (Dolch *et al.,* 2007). Зүүн Палеарктикын энэ багваахайн нэршлийг *Myotis sibirica* Kastschenko, 1905 хэмээн бичжээ (Kruskop *et al.,* 2012; Pavlinov *et al.,* 2012).

Таних шинж. Биеийн урт 34.3-53.2 мм, сүүлний урт 29.7-43.5 мм, шууны урт 33.5-39.4 мм, жин дунджаар 3.9-9.5 г. Нуруу нь хар бараан, хүрэн улаан, хэвэл тал нь саарал хүрэн, түүгээрээ хээрийн багваахайгаас ялгарна (Соколов и Орлов, 1980). Уссурын сахалт багваахай нь унжиргүй, эрийн үржлийн эрхтэн төгсгөл хэсэг рүүгээ томорсон (Ариунболд, 2018).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд мэдээлэл дутмаг (DD) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Энэ

зүйлийн тархац, популяцийн тоо толгойн өөрчлөлт, хандлага, учирч буй аюул заналын талаарх мэдээлэл дутмаг хэвээр байна. Тархац нутгийн хэмжээ 400,000 км^2 орчим тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Ж.Ариунболд, Д.Мөнхнаст (2025).
Үнэлгээг хянасан: Н.Батсайхан (2025).

Дэлхийн тархац. Зүүн Палеарктикын Байгаль нуураас Уссурын хязгаар, Сахалины арал, Камчаткын хойг, Курилын арлууд, Амар мөрний сав, Солонгос, Японы Хоккайда арал, Казахстан, Монголд тархжээ (Horaček *et al.,* 2000; Datzman *et al.,* 2012).

Монгол орны тархац, амьдрах орчин. Монголын төв болон умард хэсэг, Хянганы салбар уулс, Халх гол, Сэлэнгийн Ибциг гол, баруун Хангайд Улиастай, өмнөд Хэнтийн Зуун мод, Улаанбаатар зэрэг ойт нутгуудаар гол ус бараадан тархсан (Банников, 1954). Хангайн хойд Тамирын татмын бургасан шугуй (Stubbe and Chotolchu, 1968), Сэлэнгийн дунд хэсэг Амарбаясгалан хийдээс тэмдэглэсэн (Соколов и др., 1985). Монголын ойд өргөн тохиолдох (Соколов и Орлов, 1980) ба Тэсийн гол, Хангай, Хэнтийн нуруу, Хөвсгөл, Хянганы уулсаар тархсан (Dolch *et al.,* 2007; Ариунболд, 2018). Мөн бургас, улиас бүхий голын хөндий, ойн цоорхой, тал хээрт усны ойролцоо амьдарна. Зун модны хөндийд, хааяа байшин барилгад өдрийг өнгөрөөнө. Өвөл газар доорх агуй (7.1), уурхай, хонгил, хөндийд өвөлжинө (Ариунболд, 2018).



Амьдралын онцлог. 7-р сарын эхээр төрнө. Шинэ төрсөн зулзага нэг сарын дараанаас нисэж эхэлнэ. Ганц нэгээрээ болон цөөн хэдээрээ нийлж 2-4 м өндөрт нисэж ангуучилна (Ариунболд, 2018).

Тоо толгой, нягтшил. Дархадын хотгорын Хуйтын агуйд 2010 оны намар 38 бодгаль, 2012 оны намар 3 бодгаль, 2016 оны хавар 17 бодгаль, 2017 оны өвөл 22 бодгалийг ичээний үед нь тоолж бүртгэсэн (Ариунболд, 2018). Үүнээс өөр популяцийн тоо, нягтшилын судалгааны баримт байхгүй.

Ховордлын шалтгаан. Манай орны ойн сангийн хэмжээ буурч, ойн түймэр, хөнөөлт шавжтай химийн аргаар тэмцэж буй зэрэг нь сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Суурин амьдралтай, агуйд ичээлдэг энэ зүйлд амьдрах орчны алдагдал, мод огтлол (1.3.3), хортон устгал (5.1), гал түймэр (7.4), агуйн эвдрэл (7.7), эмгэг үүсгэгч (8.5), аялал жуулчлал (10.1) нь сөрөг нөлөө үзүүлнэ. Гэвч мэдээ, баримт хангалтгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Уссурын сахалт багваахай 4,700 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 30% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ

- Үндэсний түвшинд бодлогод чиглэсэн зүйлийг хамгаалах эрх зүйн баримт бичгийг боловсруулах (1.2.2.2)
- Шинжлэх ухаанд тулгуурласан хамгааллын арга хэмжээ авахад түүний популяцийн тоо толгой, хэмжээ (3.2), биологи, экологи (3.3), аюул занал (3.5), өөрчлөлтийн чиг хандлагын мониторинг судалгааг (3.9) нарийвчлан хийх шаардлагатай.
- Зүйлд чиглэсэн өвчин, эмгэг үүсгэгч, шимэгчдийн менежментийн үйл ажиллагаа (5.5), гений санг бүрдүүлэх (5.7.2) арга хэмжээг зохион байгуулах нь зүйтэй.

4.14. ДОРНОДЫН УССАГ БАГВААХАЙ
Myotis petax (Hollister, 1912)

Баг: Гардалавчтан (Chiroptera)
Овог: Багваахай (Vespertilionidae)
Англи нэр: Eastern Water Myotis
Ижил нэр: Уссаг багваахай, усны багваахай; *Myotis abei* Yoshikura, 1944.



Ангилал зүйн тойм. Энэ зүйл багваахайг өмнө нь *Myotis daubentonii* (Kuhl, 1817)-д хамааруулж байв. Хожим *Myotis daubentonii petax* салбар зүйлийг бие даасан зүйл болгосон (Matveev *et al.,* 2005).

Таних шинж. Жижиг биетэй, шууны урт 34-41 мм, жин 7.0-11.5 г. Биеийн дээд тал нь хүрэн эсвэл хүрэн улаан, далавчны хормой нь хойд хөлийн шилбэ сарвууны үеэс яльгүй доогуур, гадаад хуруугаа угаас арай дээгүүр хойд хөлтэй нийлнэ (Ариунболд, 2018).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Тархац нутаг уудам, тоо толгой элбэг, популяцийн тоо хэмжээ буураагүй хэмээн үзэж энэ зэрэглэлээр үнэлэв. Тоо толгойн өөрчлөлт, хандлага, учирч буй аюул заналын талаарх мэдээлэл дутмаг хэвээр байна. Тархац нутгийн хэмжээ нь 700,000 км^2-аас ихгүй.

Үнэлгээ хийсэн: Ж.Ариунболд, Д.Мөнхнаст (2025).
Үнэлгээг хянасан: Н.Батсайхан (2025).

Дэлхийн тархац. Монгол, Орос, Солонгос, Япон, Хятадын зүүн хойд хэсэг хүртэл тархсан (Tiunov, 1997).

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол орны Их Нууруудын хотгор, Хар-Ус нуур, Ачит нуур, Өгий нуур, Далай нуур, Хөвсгөл, Хангай, Хэнтийн ой, Ховд, Чоно-Харайх, Идэр, Үүр, Уйлган, Орхон, Хараа, Дэлгэрмөрөн, Чулуут, Ерөө, Шоргоолж, Цөх, Эг, Эрэнгэ, Хөг, Хэрлэн, Онон, Балж, Халх, Нөмрөг голын сав дагуух бургас, улиас бүхий элдэв шугуй (1.4), хад чулуутай газарт түгээмэл тархсан. Өвлийн улиралд агуй (7.1), уурхай, хонгил модны хөндийд өвөлжинө (Ариунболд, 2018; Батсайхан нар, 2022; Dolch *et al.,* 2007).



Амьдралын онцлог. Ихэнхдээ усны гадарга орчмоор нисэж олон зүйл хос далавчтан, хайрсан далавчтан, хаварч, мөхөөлж, хоовгоно, цох зэрэг жижиг нисдэг шавжийг зонхилон ангуучилна. Бусдаас удаан тайван нисдэг, эр, эм багваахайнууд нийлж хамтдаа идээшилнэ. Эмэгчин гол, мөрний дээгүүр тавигдсан бетонон гүүрнүүдийн зай завсар, модны хөндий зэрэгт 6-р сарын сүүлч 7-р сарын эхээр төрнө. Гол, нуур усны ойролцоох бургас улиасан шугуй, хадтай газар бөөнөөрөө байршиж модны хөндий, хонгил, агуй зэрэгт өдрийг өнгөрөөнө. Эмэгчин үржлийн төрмөлөө модны хөндий, гүүрэн доор, байшингийн дээвэрт үүсгэнэ (Ариунболд, 2018).

Тоо толгой, нягтшил. Дархадын хотгорын Хуйтын агуйд 2016 оны хавар 3, 2017 оны өвөл 7, хавар нь 5 бодгаль тоолж байсан (Ариунболд, 2018) бөгөөд үүнээс өөр популяцийн тоо толгой, нягтшилын судалгааны баримт байхгүй байна.

Ховордлын шалтгаан. Усны мандлаас идэш тэжээлээ шүүрч хооллодог тул усны бохирдол, идэш тэжээлийн хомсдол нь түүний тоо толгойд сөргөөр нөлөөлж болзошгүй. Зуны бөөгнөрөл нь барилга байшин, бетон гүүрийг нураах үед, өвөл ичээлэх үедээ агуйд аялагч нарын сөрөг нөлөөнд өртөх эрсдэлтэй. Суурин амьдралтай тул амьдрах орчны алдагдал, мод огтлол (1.3.3), хортон устгал (5.1), дэлхийн дулаарал (6.1.1), усны бохирдол (6.3), гал түймэр (7.4), агуйн эвдрэл (7.7), эмгэг үүсгэгч (8.5), аялал жуулчлал (10.1) зэрэг нь сөрөг нөлөө үзүүлнэ.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Дорнодын уссаг багваахай 4,500 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 30% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ

- Үндэсний түвшинд бодлогод чиглэсэн зүйлийг хамгаалах эрх зүйн баримт бичгийг боловсруулах (1.2.2.2)
- Шинжлэх ухаанд тулгуурласан хамгаалллын арга хэмжээ авахад түүний популяцийн тоо толгой, хэмжээ (3.2), биологи, экологи (3.3), аюул занал (3.5), өөрчлөлтийн чиг хандлагын мониторинг судалгааг (3.9) нарийвчлан хийх шаардлагатай.
- Зүйлд чиглэсэн өвчин, эмгэг үүсгэгч, шимэгчдийн менежментийн үйл ажиллагаа (5.5), гений санг бүрдүүлэх (5.7.2) арга хэмжээг зохион байгуулах нь зүйтэй.

4.15. СААРАЛ СООТОН БАГВААХАЙ

Plecotus kozlovi (Bobrinskii, 1926)

Баг: Гардалавчтан (Chiroptera)
Овог: Багваахай (Vespertilionidae)
Англи нэр: Kozlov's Long-eared Bat
Ижил нэр: Саарал соотгой, *Plecotus mordax* Thomas, 1926



Ангилал зүйн тойм. Өмнө нь *P. austriacus* зүйлд хамааруулж байсан бөгөөд хожим Spitzenberger нар (2006) бүтээлдээ тусад нь биеэ даасан зүйл болгосон.

Таних шинж. Шууны урт 43-46.5 мм, жин 9.0-12.0 г (Ариунболд, 2018). Хэмжээ том, үс өтгөн, нуруу элсэн буюу цайвар шаргал, хэвлий цайвар, шээс бэлгийн сүв орчимдоо урт цагаан үстэй (Spitzenberger *et al.,* 2006).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Монголд бүртгэгдээгүй байв.

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Энэ зүйлийн популяцийн хэмжээ тодорхойгүй, харин тархац нутгийн хэмжээ 400,000 км^2 орчим тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Ж.Ариунболд, Д.Мөнхнаст (2025).
Үнэлгээг хянасан: Н.Батсайхан (2025).

Дэлхийн тархац. Монголын өмнөд нутаг, Өвөр Монголд Хар хот, Хятадын Шинжаангийн Такла Маканы цөл зэрэг Монголын өмнөд хагасаас Хятадын төв, баруун болон умард нутгуудад тархжээ (Spitzenberger *et al.,* 2006).

Монгол орны тархац, амьдрах орчин. Монголд Хангайн нурууны өвөрт Байдраг, Түйн голын хад цохионоос, Их Богд, Алтайн өвөр говьд Захуй, Зарманд тооройн шугуйгаас тэмдэглэсэн (Банников, 1954; Соколов и Орлов, 1980). Ховд голын хөндийд Онгоцны Улаан уул (Самьяа нар, 1993), Баруун тооройн баянбүрд, их Шаргын булаг, Зүүнгарын говьд Гүн Тамгын ус орчимд (Батсайхан нар, 2004), Өмнөговь аймгийн Булган сумын Дал, Гурвантэсийн Сухайтын булаг, Бөөн цагаан нуур (Dolch *et al.,* 2007), Өвөрхангай аймагт Баруунбаян-Улаан сумын Хүйтэн булаг, Богд сумаас урагш 40 км Хараатын худаг, Эхийн гол, Баянлиг сумын Цагаан агуй, хойд Цэнхэрийн агуй, Говь-Алтай аймагт Төгрөг сумын төв, Тостын нурууны өвөрт Хуршуутын булагт тэмдэглэгдсэн (Ариунболд, 2018). Манай орны өмнө болон баруун өмнө зүгийн хээр (4.4), цөлөрхөг хээр, цөлийн (8.2) бүсээр тархсан. Хадтай хавцал, шавар мөргөцөг, гол горхи, булгийн ойр орчимд улиас, бургас (1.4) бүхий орчинд амьдарна. Хүний суурьшил бараадан амьдарч байшин, зоорь (11.5), агуйд (7.1) орогноно (Ариунболд, 2018).



Амьдралын онцлог. Хадны ангал, модны хонгил, агуй дээврийн хөндий зэрэгт хоргодож гүн харанхуй болмогц ниснэ (Банников, 1954). Агуй, хадны хонгил, овооны чулуу, өвөлжөө, хаваржаа, байшин, саравчинд ганц нэг, цөөн тоогоор, зарим тохиолдолд 20-30, түүнээс ч олноороо амьдарна (Ариунболд, 2018).

Тоо толгой, нягтшил. Монгол орны популяцийн тоо толгой, нягтшилын талаарх мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Амьдрах орчны алдагдал (1), уул уурхай (1.3.1), тохиолдлын үхэл хорогдол (4), дэлхийн дулаарал (6.1.1), ган (7.1), шуурга (7.2), махчид (8.2), аялал жуулчлал (10.1) зэрэг нь сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай. Жил дараалсан ган гачиг, булаг, шандын ширгэлт, татралт нь энэ зүйлийн тоо толгой хорогдох шалтгаан болно.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр саарал соотон багваахай 4,800 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 25% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ

- Үндэсний түвшинд бодлогод чиглэсэн зүйлийг хамгаалах эрх зүйн баримт бичгийг боловсруулах (1.2.2.2)
- Шинжлэх ухаанд тулгуурласан хамгааллын арга хэмжээ авахад түүний популяцийн тоо толгой, хэмжээ (3.2), биологи, экологи (3.3), аюул занал (3.5), өөрчлөлтийн чиг хандлагын мониторинг судалгааг (3.9) нарийвчлан хийх шаардлагатай.
- Хамгаалалтад тухайлсан газруудыг авах, түүнд чиглэсэн үйл ажиллагаа (4.4.1), мөн өвчин, эмгэг үүсгэгч, шимэгчдийн менежментийн үйл ажиллагаа (5.5), гений санг бүрдүүлэх (5.7.2) арга хэмжээг зохион байгуулах нь зүйтэй.

4.16. БОР СООТОН БАГВААХАЙ

Plecotus ognevi (Kishida, 1927)

Баг: Гардалавчтан (Chiroptera)
Овог: Багваахай (Vespertilionidae)
Англи нэр: Ognev's Long-eared Bat, Siberian Long-eared Bat
Ижил нэр: Бор соотгой, *Plecotus uenoi* Imaizumi and Yoshiyuki, 1969.



Ангилал зүйн тойм. *Plecotus auritus* (Linnaeus, 1758) нь *Plecotus ognevi* гэсэн зүйл болохыг морфологи, молекул биологийн хавсарсан судалгааны үр дүнд тогтоожээ (Spitzenberger *et al.,* 2006).

Таних шинж. Биеийн урт 40.1-59.5 мм, сүүлний урт 32.4-52.3 мм, шууны урт 39.7-43.1 мм, жин 4.2-14.0 г. Нуруу тал хүрэнээс бор шаргал, хэвэл цайвар саарал (Ариунболд, 2018).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Монголд бүртгэгдээгүй байв.

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Тархац нутаг уудам, тоо толгойн элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ тодорхойгүй. Тархац нутгийн хэмжээ нь 730,000 км^2 орчим тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Ж.Ариунболд, Д.Мөнхнаст (2025).
Үнэлгээг хянасан: Н.Батсайхан (2025).

Дэлхийн тархац. Алтай, төв болон зүүн Сибирь, Алс Дорнод (Сахалин, Курил), Манжуур, умард Монголд тархсан (Стрелков, 2006).

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол Алтай, Их нууруудын хотгор, Хөвсгөл, Хангай, Хэнтийн нуруу зэрэг Монгол орны умард нутгаар өргөн тархсан (Банников, 1954; Соколов и Орлов, 1980; Stubbe and Chotolchu, 1968; Klopfer, 1994; Соколов и др., 1985; Tinnin *et al.,* 2002; Самьяа нар, 2003; Dolch *et al.,* 2007), Монгол Дагуурын хээр, Дорнод Монгол (Dolch *et al.,* 2021b)-д тэмдэглэгдсэн. Ой тайга (1.4), ойт хээр, уулын хээр, тал хээрийн бүсэд (4.4) тархсан ч цөлөрхөг хээрт ховор тохиолдоно. Гол усны ойролцоох байшингийн дээврийн хөндий, модны хонгил, агуйд орогноно. Өвөл газар доорх агуй (7.1), уурхай, хонгил, хөндийд өвөлжинө (Ариунболд, 2018).



Амьдралын онцлог. Нам өндөрт далавчаа удаан дэвж нисэх ба агаарт тогтож чадна. Нисэлт дундаа агаараас болон мод бут, ургамал дээрээс идэш тэжээлээ барина. Ганц нэгээрээ болон цөөн хэдээрээ нийлж ан хийнэ. Ангуучлахдаа модны орой хавиар эргэлдэн ниснэ. Нисэх өндөр нь цаг агаар, шөнийн бүрэнхий зэргээс хамаарна. Дархадын хотгорын Хуйтын агуйд ганц нэгээрээ байрлаж, бөөгнөрөл үүсгэлгүйгээр ичээлсэн байв (Ariunbold, 2016b; Ариунболд, 2018).

Тоо толгой, нягтшил. Дархадын хотгорын Хуйтын агуйд 2016 оны хавар 8 бодгаль тоологдсон (Ариунболд, 2018)-оос өөр популяцийн тоо толгой, нягтшилын мэдээ байхгүй.

Ховордлын шалтгаан. Манай орны ойн сангийн хэмжээ буурч, ойн түймэр, хөнөөлт шавжтай химийн аргаар тэмцэж буй зэрэг нь сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Энэ зүйл нь суурин амьдралтай, агуйд ичээлдэг тул амьдрах орчны алдагдал, мод огтлол (1.3.3), хортон устгал (5.1), дэлхийн дулаарал (6.1.1), усны бохирдол (6.3), гал түймэр (7.4), агуйн эвдрэл (7.7), эмгэг үүсгэгч (8.5), аялал жуулчлал (10.1) зэрэг нь сөрөг нөлөө үзүүлнэ.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр бор соотон багваахай 4,500 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 20% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ

- Үндэсний түвшинд бодлогод чиглэсэн зүйлийг хамгаалах эрх зүйн баримт бичгийг боловсруулах (1.2.2.2)
- Шинжлэх ухаанд тулгуурласан хамгааллын арга хэмжээ авахад түүний популяцийн тоо толгой, хэмжээ (3.2), биологи, экологи (3.3), аюул занал (3.5), өөрчлөлтийн чиг хандлагын мониторинг судалгааг (3.9) нарийвчлан хийх шаардлагатай.
- Шинээр хамгаалалтад тухайлсан газруудыг авах, хамгаалалд чиглэсэн үйл ажиллагааг (4.4.1) зохион байгуулах, мөн өвчин, эмгэг үүсгэгч, шимэгчдийн менежментийн үйл ажиллагаа (5.5), гений санг бүрдүүлэх (5.7.2) судалгаа, арга хэмжээг зохион байгуулах нь зүйтэй.

4.17. БУУРАЛ САРМААХАЙ

Vespertilio murinus (Linnaeus, 1758)

Баг: Гардалавчтан (Chiroptera)
Овог: Багваахай (Vespertilionidae)
Англи нэр: Particolored Bat
Ижил нэр: *Vespertilio discolor*



Ангилал зүйн тойм. Ангилал зүйн хувьд тогтвортой зүйл. Монгол орны баруун өмнөд хэсгээр (Хятадын Шинжаан, Гансу мужтай ойр) *Vespertilio murinus murinus* Linnaeus, 1758, харин зүүн, зүүн өмнөд хилийн бүсэд (Өвөр Монголтой ойр) *Vespertilio murinus ussurensis* Wallin, 1969 гэх салбар зүйл тархсан (Ариунболд, 2018; Smith *et al.,* 2019). Манай оронд үүний салбар зүйлийн судалгааг нарийвчлан хийх шаардлагатай.

Таних шинж. Биеийн урт 55-75 мм, шууны урт 41-48 мм, жин 11-22 г. Дунд зэргийн биетэй сармаахай. Чих, хоншоор, сарьс хар. Нуруу хар хүрнээс улаан хүрэндүү ба буурал, мөнгөлөг сортой, өтгөн үстэй. Эм сармаахай хоёр хос хөхтэй ба энэ шинжээрээ дорнын сармаахайн эмэгчнээс ялгарна. Хүйсээс үл хамааран нэг популяцид хамаарах бодгалиудад морфологийн ялгаатай хэлбэр илрэх ба зарим бодгальд альбинизм ажиглагддаг (Ариунболд, 2018).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Тархац нутаг уудам, тоо толгой элбэг тул олон

улсад анхааралд өртөхөөргүй үнэлэгдсэн зүйл. Популяцийн хэмжээ буурч байгаа болон өргөн хүрээг хамарсан томоохон аюул занал тэмдэглэгдээгүй (Coroiu, 2016a). Бүс нутагт уудам тархацтай, тоо толгой элбэг тул энэ үнэлгээг хэвээр үлдээв.

Үнэлгээ хийсэн: Ж.Ариунболд, Д.Мөнхнаст (2025).

Үнэлгээг хянасан: Н.Батсайхан (2025).

Дэлхийн тархац. Афганистан, Албани, Армени, Австри, Азербайжан, Беларус, Бельги, Болгар, Хятад, Хорват, Чех, Дани, Эстони, Финланд, Франц, Гүрж, Герман, Грек, Унгар, Иран, Итали, Япон, Хойд Солонгос, Латви, Лихтенштайн, Литва, Люксембург, Молдова, Монгол, Монтенегро, Голланд, Хойд Македони, Норвег, Польш, Румын, Орос, Швед, Швейцар, Туркменистан, Турк, Украйн, Их Британи, Узбекистанд тархсан (Coroiu, 2016a).



Амьдралын онцлог. Бүрэнхий, шөнийн идэвхтэй, үдшийн бүрийгээс шөнө дунд хүртэл ангуучилна. Өндөрт хурдан шаламгай нисэж гөрөөлөх ба дунд зэргийн биетэй цох, эрвээхэй, хос далавчтан, хоовгоно зэрэг шавжаар хооллоно. Хүнд сонсогдохуйц дуу авиа гаргана. Ганц нэгээр байршихаас гадна, 100 хүртэлх тоотой бөөгнөрөл үүсгэнэ. Зарим тохиолдолд дорнын сармаахайтай хамт тохиолдоно. Эм сармаахай жил бүрийн 6-р сарын дунд, 7-р сарын эхээр 2-3 зулзага төрүүлнэ. Улаанбаатар хотын IV цахилгаан станцын байшингийн дээвэрт 11-р сард байршиж байснаас өөр өвлийн улиралд манай оронд бүртгэгдээгүй (Ариунболд, 2018; Smith *et al.,* 2010).

Тоо толгой, нягтшил. Тархац нутаг уудам хэдий ч элбэгшил бага (Coroiu, 2016a).

Ховордлын шалтгаан. Хүний суурьшил шүтэж байрших тул тодорхой зорилгогүйгээр нутгийн иргэд хөнөөнө. Ялангуяа 7-р сард нисгэл зулзагууд айлын гэр, байшин зэрэгт орох нь түгээмэл бөгөөд үүнээс улбаалан хүмүүс хөнөөх тохиолдол бүртгэгдсэн. Мөн төрмөл, үүр ноохойг нь эвдэх, утах, гэрийн муур ангуучлах зэрэг нь ховордуулах шалтгаанд тооцогдоно (Clark *et al.,* 2006; Ариунболд, 2018). Амьдрах орчны алдагдал, мод огтлол (1.3.3), гал түймэр (1.7), тохиолдлын үхэл хорогдол (4.1), хордуулах (4.1.2.3), ган гачиг (7.1), шуурга (7.2), гал түймэр (7.4), гадаргын усны хомсдол (7.7), махчид (8.2) зэрэг нөлөөлнө.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр буурал сармаахай 4,500 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 20% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ

- Үндэсний түвшинд бодлогод чиглэсэн зүйлийг хамгаалах эрх зүйн баримт бичгийг боловсруулах (1.2.2.2) шаардлагатай.
- Шинжлэх ухаанд тулгуурласан хамгаалллын арга хэмжээ авахад түүний популяцийн тоо толгой, хэмжээ (3.2), биологи, экологи (3.3), аюул занал (3.5), өөрчлөлтийн чиг хандлагын мониторинг судалгааг (3.9) нарийвчлан хийх шаардлагатай.
- Хамгаалалтад тухайлсан газруудыг авах, түүнд чиглэсэн үйл ажиллагаа (4.4.1) шаардлагатай.
- Байгальд гүйцэтгэх үүрэг, ач холбогдлыг олон нийтэд сурталчлан таниулах замаар үржлийн үеийн бөөгнөрлийг хамгаалах үйл ажиллагаа хэрэгжүүлэх нь зүйтэй.

4.18. ДОРНЫН САРМААХАЙ

Vespertilio sinensis (Peters, 1880)

Баг: Гардалавчтан (Chiroptera)
Овог: Багваахай (Vespertilionidae)
Англи нэр: Asian Particolored Bat
Ижил нэр: *Vespertilio murinus superans* Thomas, 1898; *Nyctalus noctula namiyei* Kuroda, 1920; *Vespertilio aurijunctus* Mori, 1928; *Vespertilio namiyei anderssoni* Wallin, 1962; *Vespertilio orientalis* Wallin, 1969; *Vespertilio superans* Thomas, 1898.



Ангилал зүйн тойм. Монголд тархсан энэ зүйлийг *Vespertilio superans* Thomas, 1898 хэмээн нэрлэж байсан. Дорнын сармаахайн зүйлийн нэр судалгааны бүтээл, ангилал зүйчдийн дунд зөрүүтэй тэмдэглэгдэж ирсэн. Horácek (1997) энэ зүйлийн ангилал зүй, нэршилтэй холбоотой баримтыг нягталж, *Vespertilio sinensis* Peters, 1880 болгосон.

Таних шинж. Том биетэй. Биеийн урт 67-75 мм, шууны урт 47-54 мм, жин 14-25 г. Чихний омгийн суурь хэсэг өргөсөж, гадагш нугаларсан. Цэцгийн суурь хэсэг өргөн. Ус тачир, өтгөн. Нуруун талын үс бараан хүрэн, өвхий цайвар хүрэн. Эм сармаахай нэг хос хөхтэй ба энэ шинжээрээ буурал сармаахайн эмэгчнээс ялгарна. Хүйсээс үл хамааран нэг популяцид хамаарах бодгалиудад бараан хүрэн, хар хүрэн, улбар болон цайвар сор бүхий буурал зүстэй (Ариунболд нар, 2011).

Үнэлгээ ба үндэслэл
Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).
Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Тархац нутаг уудам, популяци тусгаарлагдаагүй зүйл юм. Популяцийн хандлага тодорхойгүй (Fukui *et al.,* 2019c).

Дорнод Монголд 1,000 орчим бодгальтай төрмөл тохиолдоно (Ариунболд, 2018).

Үнэлгээ хийсэн: Ж.Ариунболд, Д.Мөнхнаст (2025).

Үнэлгээг хянасан: Н.Батсайхан (2025).

Дэлхийн тархац. Хятад, Япон, Өмнөд Солонгос, Хойд Солонгос, Монгол, Орос, Тайванд тархсан (Fukui *et al.,* 2019c).



Амьдралын онцлог. Бүрэнхий, шөнө идэвхтэй ба нисдэг шавжаар хооллоно. Дорнод Монголын хээрт тэр дундаа хилийн заставын барилга байгууламжийн хана, дээврийн хөндий дэх бөөгнөрөл хэдэн арваас хэдэн зуугаар тоологдоно. Заримдаа буурал сармаахайтай хамт бөөгнөрдөг. Эм нь жил бүрийн 6-р сарын адаг, 7-р сарын эхээр 1-2 зулзага төрүүлнэ. Ичээ, нүүдэл зэрэг нь судлагдаагүй (Ариунболд, 2018).

Тоо толгой, нягтшил. Монгол орны популяцийн хэмжээ, хандлага тодорхойгүй (Ариунболд, 2018; Fukui *et al.,* 2019c).

Ховордлын шалтгаан. Хээрийн бүсээр голдуу тархсан бөгөөд үүрлэх орчин хомсын улмаас хүний суурьшилд хүрч хүн, гэрийн тэжээвэр амьтадтай зэрэгцэн байршина. Үүнээс улбаалан хүн зориудаар хөнөөх, гэрийн муур барина. Хүний суурьшилд байрших тул хүний садаа (төрмөл, үүр ноохойг нь эвдэх, утах, хүн эгдүүцэж хороох, гэрийн муур ангуучлах г.м) нь ховордлын шалтгаан болно. Ялангуяа 7-р сард нисгэл зулзагууд айлын гэр, байшин зэрэгт орох нь түгээмэл бөгөөд үүнээс улбаалан хүмүүс хөнөөх тохиолдол бүртгэгдсэн (Clark *et al.,* 2006; Ариунболд нар, 2011; Ариунболд, 2018). Амьдрах орчны алдагдал (1), гал түймэр (1.7), тохиолдлын үхэл хорогдол (4.1), хордуулах (4.1.2.3), ган гачиг (7.1), шуурга (7.2), гал түймэр (7.4), гадаргын усны хомсдол (7.7), махчид (8.2.) зэрэг нь сөргөөр нөлөөлнө.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан. Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор баталсан Ховор амьтны жагсаалтад орсон тул төрийн захиргааны төв байгууллагаас олгосон зөвшөөрлөөр зөвхөн судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, эмчилгээний зориулалтаар агнаж, барьж болно. Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Дорнын сармаахай 8,400 төгрөг. Хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг. Монгол оронд тархсан гар далавчтаны зүйлүүдээс Монгол Улсын Улаан номд ховор зүйлээр бүртгэгдсэн цор ганц зүйл юм (Шийрэвдамба нар, 2013). Энэ зүйлийн тархац нутгийн 5% орчим нь тусгай хамгаалалттай газарт хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ

- Шинжлэх ухаанд тулгуурласан хамгааллын арга хэмжээ авахад түүний тоо толгой, хэмжээ (3.2), биологи, экологи (3.3), аюул занал (3.5), өөрчлөлтийн чиг хандлагын мониторинг судалгааг (3.9) нарийвчлан гүйцэтгэх.
- Хамгаалалтад тухайлсан газруудыг авах, түүнд чиглэсэн үйл ажиллагааг (4.4.1) төлөвлөх, хэрэгжүүлэх.
- Өвчин, эмгэг үүсгэгч, шимэгчдийн менежментийн үйл ажиллагаа (5.5), гений санг бүрдүүлэх (5.7.2) арга хэмжээг зохион байгуулах
- Мөн байгальд гүйцэтгэх үүрэг, ач холбогдлыг олон нийтэд сурталчлан таниулах замаар үржлийн үеийн бөөгнөрлийг хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх нэн шаардлагатай.

4.19. УМАРДЫН САРМААХАЙ

Cnephaeus nilssonii (Keyserling and Blasius, 1839)

Баг: Гардалавчтан (Chiroptera)
Овог: Багваахай (Vespertilionidae)
Англи нэр: Northern Bat
Ижил нэр: Умрын сарсаахай, *Vespertilio borealis* Nilsson, 1838; *Vepertilio nilssoni* Keyserling and Blasius, 1839.



Ангилал зүйн тойм. Ангилал зүйн хувьд тогтвортой зүйл. *Eptesicus, Histiotus* төрлийн ангилал зүйн асуудлыг морфологи, молекул өгөгдөл (филогени, дивергенцийн цаг, генетик зай болон эхолокаци)-д тулгуурлан төрлийн түвшинд дахин үнэлж, өмнө нь *Eptesicus* төрөлд хамаардаг хуучин тив (Old World) болон Монгол оронд тархсан *Eptesicus nilssonii*, *E. gobiensis*, *E. pachyomus* зүйлүүдийг *Cnephaeus* төрөлд хамааруулсан (Claudio *et al.,* 2023).

Таних шинж. Биеийн урт 52-64 мм, шууны урт 38-42 мм. Төрөл дотроо жижиг биетэй,

чих, хоншоор, сарьсны өнгө хар. Чих богино, ирмэг дугуй. Нурууны үсний уг хар бараан, үзүүр бордуу, зогдор хэсэг шаргал сортой, өөхий цайвар саарлаас хүрэвтэр. Биеийн хэмжээ, төрх, өнгө зүсэнд хүйсийн ялгаа илрэхгүй.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Дэлхийн популяцийн хандлага тогтвортой (Coroiu *et al.,* 2016b). Монгол оронд өргөн тархсан, түгээмэл тохиолдох зүйл тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Ж.Ариунболд, Д.Мөнхнаст (2025).

Үнэлгээг хянасан: Н.Батсайхан (2025).

Дэлхийн тархац. Австри, Азербайжан, Беларус, Бельги, Болгар, Хятад, Хорват, Чех, Дани, Эстони, Финланд, Франц, Гүрж, Герман, Унгар, Иран, Ирак, Итали, Япон, Өмнөд Солонгос, Хойд Солонгос, Киргизстан, Латви, Лихтенштайн, Литва, Люксембург, Монгол, Нидерланд, Норвег, Польш, Румын, Орос, Словак, Словени, Швед, Швейцар, Турк, Украйнд тархсан (Coroiu *et al.,* 2016b).



Амьдралын онцлог. Зун, намар бүрэнхийд моддын оройгоор нисэж гөрөөлнө. Харин өвлийн улиралд Сөөгт, Хуйт зэрэг агуйд ганц нэгээр тогтмол ичээлнэ. Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газарт орших Болорын агуйд 3 бодгаль ичээлсэн тохиолдол бүртгэгдсэн. Түүнчлэн хотын ойролцоох ойд хүний бүтээсэн элдэв төрлийн барилга байгууламжид орогноно. Зарим тохиолдолд 20-30 хүртэлх тооны эм бодгалиуд нийлж төрмөл үүсгэх нь бий.

Тоо толгой, нягтшил. Монгол орон дахь популяцийн хэмжээ тодорхойгүй.

Ховордлын шалтгаан. Тархац нутгийн зарим хэсэг дэх төрмөл, ичээ зэрэг нь хүний сөрөг нөлөөнд өртөж, тоо толгой нь цөөрч болзошгүй. Амьдрах орчны алдагдал, мод огтлол (1.3.3), тохиолдлын үхэл хорогдол (4.1), хортон устгал (5.1), дэлхийн дулаарал (6.1.1), гал түймэр (7.4), агуйн эвдрэл (7.7), эмгэг үүсгэгч (8.5), аялал жуулчлал (10.1) зэрэг нь сөргөөр нөлөөлнө.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр умардын сармаахай 4,500 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 15% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ

- Үндэсний түвшинд бодлогод чиглэсэн зүйлийг хамгаалах эрх зүйн баримт бичгийг боловсруулах (1.2.2.2)
- Шинжлэх ухаанд тулгуурласан хамгааллын арга хэмжээ авахад түүний популяцийн тоо толгой, хэмжээ (3.2), биологи, экологи (3.3), аюул занал (3.5), өөрчлөлтийн чиг хандлагын мониторинг судалгааг (3.9) тусгайлан хийх шаардлагатай.
- Хамгаалалтад тухайлсан газруудыг авах, түүнд чиглэсэн үйл ажиллагаа (4.4.1), мөн өвчин, эмгэг үүсгэгч, шимэгчдийн менежментийн үйл ажиллагаа (5.5), гений санг бүрдүүлэх (5.7.2) арга хэмжээг зохион байгуулах нь зүйтэй.
- Олон нийтийг зөв мэдлэг, мэдээллээр хангах үйл ажиллагааг зохион байгуулах замаар энэ зүйлийн ичээ, төрмөлд хүний зүгээс үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах. Тухайлбал, Сөөгт, Хуйт зэрэг агуйг хамгаалалтад авах шаардлагатай.

4.20. ГОВИЙН САРМААХАЙ

Cnephaeus gobiensis (Bobrinskii, 1926)

Баг: Гардалавчтан (Chiroptera)
Овог: Багваахай (Vespertilionidae)
Англи нэр: Gobi Big Brown Bat
Ижил нэр: Говьсог сарсаахай, *Eptesicus nilssoni gobiensis.*



Ангилал зүйн тойм. Палеарктикын *Eptesicus* төрөлд хамаарч байсан зүйлүүдийг *Cnephaeus* төрөлд хамааруулсан (Claudio *et al.,* 2023). Энэ зүйлийг *Eptesicus nilssoni* зүйлээс салгаж бие даасан зүйл болгосон, Монголд *E. gobiensis gobiensis* Bobrynskoy, 1926 хэмээх номиналь хэлбэр тархдаг (Стрелков, 1986) гэж үзжээ. Морфологи, молекул генетикийн судалгаагаар, Монгол оронд *Eptesicus gobiensis gobiensis* салбар зүйл тархдаг болохыг тогтоосон. Энэ судалгаанд манай орны Алтайн өвөр говийн Гүн тамгын булаг (4 бодгаль), Бага Богд уулын өмнөд хэсэг (1 бодгаль), Хяргас нуурын зүүн өмнөд эрэг (2 бодгаль)-ээс цуглуулсан нийт 7 бодгалийн дээж хамрагдсан (Artyushin *et al.,* 2012; Srinivasulu *et al.,* 2019a).

Таних шинж. Умардын сармаахайгаас яльгүй том ч төрөл дотроо жижиг биетэйд тооцогдоно. Биеийн урт 51-59 мм, шууны урт 38-43 мм. Чих богино, ирмэг дугариг. Нуруун талын үс жигд бараан шаргал, өөхий цайвраас цагаан саарал. Хүйсээс хамаарч биеийн хэмжээ, төрх, зүс хувирахгүй.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).
2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Дэлхийн популяцийн хандлага тогтвортой (Coroiu *et al.,* 2016). Монгол оронд өргөн тархсан, түгээмэл тохиолдох зүйл (Srinivasulu *et al.,* 2019a) тул энэ зэрэглэлээр үнэлэв.
Үнэлгээ хийсэн: Ж.Ариунболд, Д.Мөнхназт (2025).
Үнэлгээг хянасан: Н.Батсайхан (2025).

Дэлхийн тархац. Афганистан, Хятад, Энэтхэг, Казахстан, Киргизстан, Монгол, Пакистан, Орос, Сири, Тажикстан, Туркменистан, Узбекистанд тархсан (Artyushin *et al.,* 2012; Srinivasulu *et al.,* 2019a).
Монгол орны тархац, амьдрах орчин. Их нууруудын хотгор, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Говь Алтайн уулс, Дундад Халхын хээр, Дорнод говиор тархсан. Энэ зүйл тархац нутгийнхаа хүрээнд нуур (5.7), цөөрөм, гол, булаг шанд, баянбүрд (5.9), худгийн ус шүтэж, тэдгээрийн ойролцоох хадны ангал, завсар (6), модны хонгил, малын чулуун хороо, саравч, өвөлжөө (11.2.) зэрэгт орогноно. Мөн Дорнод говийн зарим агуйд (7.1) ичээлнэ (Ariunbold, 2016a).



Амьдралын онцлог. Үдшийн бүрийгээс үүрийн гэгээ хүртэл идэвхтэй нисэлдэж тогтоол уснаас ундаалж, түүний орчимд ангуучилна. Агуйд амьдарна. Айлын өвөлжөөнд эм бодгалиуд бөөгнөрч төрмөл үүсгэнэ. Тухайн нутгийн уур амьсгал, цаг агаарын онцлогоос хамааран үржлийн хугацаа ялгаатай байх ба 6-7-р сарын дунд үе хүртэл зулзагална. Зулзагалах хугацаанд эр, эм бодгаль тусдаа амьдарна.

Тоо толгой, нягтшил. Монгол орон дахь популяцийн хэмжээ тодорхойгүй.
Ховордлын шалтгаан. Жил дараалсан ган гачиг, хуурайшилтаас улбаатай уст цэг хатах нь энэ зүйлд сөргөөр нөлөөлнө (Srinivasulu *et al.,* 2019a). Тухайлбал, хуурай гандуу бүс нутаг дахь булаг, шанд ширгэх, хатах зэрэг нь тухайн уст цэгээс ундаалах зүйлийн доторх болон зүйл хоорондын өрсөлдөөнийг нэмэгдүүлэх замаар популяцийн тоо толгойд сөргөөр нөлөөлнө. Их Нартын байгалийн нөөц газарт үдшийн бүрий (21:00)-ээс үүрийн гэгээ (04:00) орох хүртэл тогтоол усны орчимд идэвхтэй нисэж, ундаалж байв (Ариунболд, 2018). Говь, цөлийн бүсээр голдуу тархсан энэ зүйлд амьдрах орчны алдагдал (1), уул уурхай (1.3.1), тохиолдлын үхэл хорогдол (4.1), дэлхийн дулаарал (6.1.1), ган (7.1), шуурга (7.2), агуйн эвдрэл (7.7), махчид (8.2), аялал жуулчлал (10.1) зэрэг нь сөргөөр нөлөөнө.
Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр говийн сармаахай 4,500 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 20% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ. Тухайлбал, Говийн Их дархан цаазат газрын А, Б хэсэг, Говийн Бага дархан цаазат газрын А, Б хэсэг, Говь Гурван сайханы байгалийн цогцолборт газар, Тост, Тосонбумбын нуруу болон Их Нартын байгалийн нөөц газруудыг дурдаж болно.
Хамгаалах арга хэмжээ

- Үндэсний түвшинд бодлогод чиглэсэн зүйлийг хамгаалах эрх зүйн баримт бичгийг боловсруулах (1.2.2.2)
- Шинжлэх ухаанд тулгуурласан хамгааллын арга хэмжээ авахад түүний популяцийн тоо толгой, хэмжээ (3.2), биологи, экологи (3.3), аюул занал (3.5), өөрчлөлтийн чиг хандлагын мониторинг судалгааг (3.9) тусгайлан хийх шаардлагатай.
- Хамгаалалтад тухайлсан газруудыг авах, түүнд чиглэсэн үйл ажиллагаа (4.4.1), мөн өвчин, эмгэг үүсгэгч, шимэгчдийн менежментийн үйл ажиллагаа (5.5), гений санг бүрдүүлэх (5.7.2) арга хэмжээг зохион байгуулах
- Олон нийтийг зөв мэдлэг, мэдээллээр хангах үйл ажиллагааг зохион байгуулах замаар энэ зүйлийн ичээ, төрмөлд хүний зүгээс үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах. Мөн хуурай, гандуу бүс нутгийн уст цэгийг хашиж, хамгаалах нь зүйтэй.

4.21. ЧАНДАГА ТУУЛАЙ

Lepus timidus (Linnaeus, 1758)

Баг: Туулай хэлбэртэн (Lagomorpha)
Овог: Туулай (Leporidae)
Англи нэр: Arctic Hare
Ижил нэр: Чандага, Mountain Hare.





Ангилал зүйн тойм. Дэлхийд одоогоор 16 салбар зүйлийн чандага бүртгэгдээд байгаа (Angerbjoern, 2018) бөгөөд Монгол оронд *L. timidus transbaicalicus* Ognev, 1929 салбар зүйл тохиолддог (Дуламцэрэн, 1970).

Таних шинж. Биеийн урт 440-740 мм, чихний урт 75-100 мм, тавхайн урт 132-190 мм, биеийн жин 1,800-4,500 г. Бор туулайнаас илүү биерхүү. Зуны зүс ухаа саарал, бага зэрэг бор долгиотой, хэвлий саарал. Өвөл дун цагаан, зөвхөн чихний үзүүр нь хар. Чих урт гонзгой. Сүүл ахар дугариг, дээд тал нь саарал толботой, доод тал нь дун цагаан. Нүд бүлтгэр. Өмнөд мөч хойд мөчөөс богино. Тавхай урт өтгөн үстэй. Дээд үүдэн шүдний гадна талын тууш нарийн ховил хоёр шүдний нийлэх хэсэг рүү илүү шахаж байрлана (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).

2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Тархац нутаг уудам, тоо толгойн элбэг зүйл бөгөөд түүний популяцийн тоо хэмжээг бууруулагүй гэж үзсэн тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Д.Лхагвасүрэн, Н.Батсайхан, Э.Ундрахбаяр, Р.Самъяа, С.Шар (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Австри, Беларусь, Хятад, Эстони, Финланд, Франц, Герман, Ирланд, Итали, Япон, Казахстан, Латви, Лихтенштайн, Литва, Норвег, Польш, Орос, Словени, Швед, Швейцар, Украин, Их Британи болон Монголд тархсан (Smith and Johnston, 2019).

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол Алтай, Хөвсгөл, Хангай, Хэнтий, Монгол Дагуур, Хянганы салбар уулсын ой, өндөр уул, тагаар тархсан. Чандага туулай явган хус, сөөг, сөөгөнцөр, өвслөг ургамал элбэг, саруул шинэсэн ой, улиангар, хус, бургастай гол, горхины шугуй, сөөгөн төгөл, торлог (3.3), ширэнгэн холимог ойтой (1.1) газар шүтэж байршина (Соколов и Орлов, 1980; Дуламцэрэн, 1989; Батсайхан нар, 2022).



Амьдралын онцлог. Үдшийн бүрэнхий болон үүрээр, мөн сартай шөнө илүү идэвхтэй. Модны үндэс орчмын хөндий, хонгил, унанги, дархины доор, өтгөн сөөг, ширэнгэд шургаж орогноно. Зун ургамлын ургал хэсгээр, харин өвөл зулзаган модлог ургамлын нахиа, найлзуур, модны холтсоор идээшилнэ. Хавар 2-3 сар дамнан ороо нийллэг болж, эм чандага 45-51 хоног хээлээ тээнэ. Жилд 2 удаа төллөх ба нэг удаа дунджаар 2-5 бүжин төрүүлнэ. Хөхүүл үе 3 долоо хоног. Залуу чандага 8-9 сартай бэлэг боловсорно. Хоёр настай үржилд орно. Чандага туулай 10 орчим жил насална (Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Монгол орны чандага туулайны популяцийн элбэгшил, нягтшилын талаар судалгааны мэдээ, баримт байхгүй.

Ховордлын шалтгаан. Монгол орны агнуурын амьтны тоон мэдээллээс үзвэл, 1975-1984 онд жилд дунджаар 3,600 бодгаль агнаж байв (Адъяа, 2024). Олон улсын хэмжээнд уламжлалт анагаах ухаанд мах, арьсыг нь эм бэлдмэлийн түүхий эд болгон худалдах зорилгоор цөөн тоогоор хууль бусаар агнана (Хайдав, 1982; Clark *et al.,* 2006).

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд тухайлбал, энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2-т зааснаар чандага туулайг жил бүрийн 2 дугаар сарын 11-ний өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон. Үүнээс гадна, (10.1.2) агнуурын амьтны жим дээр нүх ухах, буу сойх, занга, сааль тавих, (10.1.5) амьтныг агаарын болон авто тээврийн хэрэгслээр хөөх, гэрэлтүүлэх, (10.1.8) ан агнах зориулалтын бус буу, сум хэрэглэх зэрэг арга, зэвсэг хэрэгслээр агнах, барихыг хориглодог.

Мөн Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр чандага туулай 18,000 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу).

Энэ зүйлийн тархац нутгийн 21% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн популяцийн тоо толгой, нягтшил (3.2), ангилал зүй (3.3) болон аюул заналын (3.5) судалгааг нарийвчлан хийх шаардлагатай. Чандага туулайн хууль бус худалдаа гарч буй бүс нутгуудад иргэд, малчдыг мэдлэг, мэдээллээр хангах сургалт, сурталчилгааны ажлуудыг (2.3) зохион байгуулах нь зүйтэй.

4.22. БОР ТУУЛАЙ

Lepus tolai (Pallas, 1778)

Баг: Туулай хэлбэртэн (Lagomorpha)
Овог: Туулайн (Leporidae)
Англи нэр: Tolai Hare
Ижил нэр: *L. brevinasus*, *L. gobicus*, *L. zaisanicus* (Wilson and Reeder, 2005), Боролзон туулай (Дуламцэрэн, 2003).





Ангилал зүйн тойм. *Lepus tolai*-г өмнө нь *Lepus capensis* эсвэл *Lepus europaeus*-д хамааруулж байсан (Wilson and Reeder, 2005) бөгөөд өдгөө найман салбар зүйлийг ялгасан (Cheng *et al.,* 2012) байна.

Таних шинж. Биеийн урт 390-580 мм, зун бор шарга, зулай, шанаа бор халтар, хэвлий саарал, өвөл зоо нурууны сор үс бор хүрэн. Том хар толботой богино сүүлтэй. Нүд бүлтгэр, өмнөд мөч хойд мөчөөс богино. Тавхай урт өтгөн үсээр бүрхэгдсэн. Дээд үүдэн шүдний гадна талын тууш нарийн ховил шүдний дунд хэсэгт байрлана (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Тархац нутаг уудам, тоо толгойн элбэг зүйл бөгөөд түүний популяцийн тоо хэмжээг

бууpаагүй гэж үзсэн тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Э.Ундрахбаяр, Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, Р.Самъяа, С. Шар.
Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Афганистан, Хятад, Иран, Казахстан, Киргизстан, Орос, Туркменистан, Узбекистан, Тажикстан болон Монголд тархсан (Smith and Johnston, 2019; Павлинов и др., 2002).

Монгол орны тархац, амьдрах орчин. Хангай, Хэнтийн нуруу, Хөвсгөлийн уулсын тайгаас бусад бүх нутагт тархана. Хээр, цөлөрхөг хээр, говийн бүсийн янз бүрийн хэв шинж бүхий (Соколов и Орлов, 1980; Цэвэгмид, Цэнджав, 2004) ойн зах (1.4), бутлаг, сөөглөг ургамалтай (3.4) болон үетэн давамгайлсан ургамалжилттай (4.4) газраар тархжээ.



Амьдралын онцлог. Олон янзын хэв шинжид тохиолдох бөгөөд хад, унасан модны хөндий, бут, сөөг болон тарвага, үнэгний хуучин нүхэнд орогноно. Үетэн, улалж, сөөгийн залуу нахиа, үндсээр хооллоно. Жилд хоёр удаа үржилд орж 2-6 бүжин төрүүлнэ. Нэг настайдаа үржилд орох бөгөөд байгальд 7 хүртэл жил насална (Батсайхан нар, 2022).

Тоо, толгой, нягтшил. Энэ зүйлийн тоо толгой, нягтшилын талаар мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Уламжлалт анагаах ухаанд мах, арьсыг нь хэрэглэх үүднээс агнадаг боловч олон улсын хэмжээний худалдаа бага. Хааяа үнэг, хярс зэрэг ангууч амьтанд тавьсан хавх, урхинд өртөх нь бий (Clark *et al.,* 2006). Мөн хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй амьдрах орчны доройтол (1), ахуйн хэрэгцээнд (3.1) болон эмийн бүтээгдэхүүнд ашиглах (3.2), ой хээрийн түймэр (7.4), дэлхийн дулаарал (6.1.1), ган зуд (7.1) зэрэг нь энэ зүйлд сөргөөр нөлөөлнө.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд тухайлбал, энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2-т зааснаар бор туулайг жил бүрийн 2 дугаар сарын 11-ний өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон. Мөн амьтныг (11.1.1) шуурга, ган, зуд, үер, мөндөр, түймэр зэрэг гамшигт нэрвэгдсэн болон гол, мөрөн, намаг, шаварт орох зэрэг биеэ хамгаалах чадваргүй болсон үед агнах, барих үйл ажиллагааг хориглодог.

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр бор туулай 16,000 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу).

Энэ зүйлийн тархац нутгийн 21% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн тархац нутаг, популяцийн тоо толгой болон хэмжээ, хандлага (3.2), биологи, экологи (3.3), учирч буй сөрөг нөлөөллийг нарийвчлан судлах шаардлагатай бөгөөд судалгаа, шинжилгээний ажлын үр дүнд суурилсан хамгааллын зүй зохистой арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх нь зүйтэй.

4.23. ДАГУУР ОГДОЙ

Ochotona dauurica (Pallas, 1776)

Баг: Туулай хэлбэртэн (Lagomorpha)
Овог: Огдой (Ochotonidae)
Англи нэр: Daurian Pika
Ижил нэр: *O. altaina*, *O. bedfordi*, *O. mursavi, O. latibullata, O. minor, O. ogotona* (Wilson and Reeder, 2005; Павлинов и Лисовский, 2012).





Ангилал зүйн тойм. Монгол дахь салбар зүйлийг нарийвчлан судлах шаардлагатай. Манай оронд *O. d. dauurica*, *O. d. altaina*, *O. d. mursaevi* салбар зүйлүүд байх боломжтой. *O. d. altaina* салбар зүйлийг эргэлзээтэй, харин Тувагийн *O. d. latibullata* салбар зүйлийг онцлог ялгаатай гэж үздэг (Павлинов и Лисовский, 2012).

Таних шинж. Бахим бөгөөд төрлийн хэмжээнд дунд зэргийн биетэй. Биеийн урт 170-220 мм, тавхай 25-29 мм, сүүлгүй. Биеийн жин 130-260 г. Чихний дэлбээ том дугариг, захаараа цагаан эмжээртэй. Зуны зүс бор шарга, саарал, өвөлдөө цайвар, сааралдуу болно. Хоншоорын мэдрүүл сахал үсний үрт 40-45 мм. Өглөө, үдшийн цагаар сонсогдох уянгалсан исгэрэлт энэ зүйлийг таних нэг шинж болно. Эзэнтэй нүхний орчим илрэх бөөрөнхий ялгадсаар нь огдой байгааг мэдэж болно.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Тархац нутаг уудам, тоо толгойн элбэг зүйл. Түүний тархац нутаг, популяцийн тоо хэмжээ буураагүй хэмээн үзэж өмнөх үнэлгээг хэвээр үлдээв.

Үнэлгээ хийсэн: Р.Самъяа, Н.Батсайхан, С.Шар, Д.Лхагвасүрэн, Э.Ундрахбаяр.

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Оросын Алтайн хязгаар, Тува, Сэлэнгийн сав, Байгалийн чанадах хээр (Павлинов и Лисовский, 2012), Хятад (Smith and Yan, 2013), Монголд тархжээ.

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол орны цөлийн бүсээс бусад тухайлбал, Алтайгаас Хянганы салбар уулсын зүүн зах хүртэлх хээр, хуурай хээр, цөлжүү хээрээр тархжээ (Соколов и Орлов, 1980; Цэвэгмид, Цэнджав, 2004; Батсайхан нар, 2022). *O. d. altaina* салбар зүйлийг Их нууруудын хотгорын өрнөд болон өмнөд нутгаас олсон (Stubbe and Chotolchu, 1968). Сэрүүн бүсийн хээрийн (3.4) үндсэн төлөөлөгч бөгөөд манай орны ойт хээр, уулын хээр, цөлжүү хээрийн үетэн, алаг өвст нугыг шүтэн амьдарна.



Амьдралын онцлог. Өвөл ичихгүй. Өдөр, үдшийн бүрэнхий, үүрээр идэвхтэй. Элдэв үетэн, улалж, алаг өвсний ургал болон цэцэгт хэсгээр хооллоно. Идэш тэжээлээ нөөцөлж хөөлнө. Үржлийн насны эм бодгаль үр төлийн хамт нэг үүрэнд суурин, харин эр бодгалиуд хэд хэдэн үлийг эзэмшинэ. Оroo нийллэг 4-р сарын дундуур эхэлж, үржлийн хугацаанд 1-2, зарим тохиромжтой жил 3 удаа төллөнө. Нэг удаад 5-7 бөмбөөлэй төрүүлнэ. Байгальд 4 хүртэл насална (Цэвэгмид, Цэнджав, 2004).

Тоо толгой, нягтшил. Дорнод Монголын хүрэн хөрст нам уулсын зүр өвст нугын хээрийн 1 га-д 18-20 толгой, заримдаа 30 хүртэл, хялгана-жижиг дэгнүүлт үетэн, хялганат хээрт 10-20 толгой, тэгш, ухаа гүвээт нутгийн нугын шимтэй шавранцар хүрэн хөрст алаг өвс бүхий жижиг дэгнүүлт үетэнт хээрт 25 хүртэл, хялгана-дааган сүүлт, хялгана-жижиг дэгнүүлт үетэнт хээрт 13-18 толгой, хазаар өвс-дааган сүүлт хээрт 17-21 толгой, Хангайн зүүн бие болон Хэнтий, төв нутгийн хар хүрэн хөрст алаг өвс-үетэнт хээрт 15-28 толгой, агь-алаг өвс-хялганат хээрт 18-23 толгой, алаг өвс-хялганат, хялгана-алаг өвст хээрт 17-21 ногдох нягтшилтай. Монгол Алтай, Говь Алтайн нурууны ам, хөндийн элсэнцэр хөрстэй алаг өвс-ботуульт, алаг өвс-жижиг дэгнүүлт үетэнт, агь-үетэнт хээрийн 1 га-д 8-10, хааяа 3-6 толгой ногдох нягтшилтай байдаг. Хангайн нурууны уулын хээрт дагуур огдойн нягтшил хамгийн өндөр бөгөөд 1 га-д 39 бодгаль хүрнэ (Цэнджав, 1976, 1985).

Ховордлын шалтгаан. Арьсыг гадаадад худалдаалах зорилгоор агнадаг байсан хэдий ч одоо энэ үйл ажиллагаа зогссон. Малын тоо толгой өссөнөөс бэлчээрийн талхагдал бий болж, үүний уршгаар орчны хомсдол нүүрлэж байгаа нь энэ зүйлийн амьдралд таагүй нөлөө үзүүлнэ (1.1.4.1). Хуурайшлын нөлөөгөөр гарах тал хээрийн түймэр дагуур огдойн хорогдолд нөлөө үзүүлнэ (7.4). Дорнод Монгол болон Монгол Дагуурын хээрт 2001, 2002, 2003 онд үлийн цагаан оготнын тоо толгойг зохицуулах зорилгоор хэрэглэж байсан Бромадиолон химийн хорт бодист дам өртөж хорогдох тохиолдол гарч байв.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Дагуур огдой 4,000 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 10% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Бэлчээр ашиглалтыг зохистой болгож доройтлоос сэргийлэх (4.2) нь энэ зүйл амьтны амьдрах орчныг хамгаалах гол арга хэмжээ болно. Хүний болгоомж, санамсаргүй үйлдлээс үүдэн тал хээрийн түймэр гарахаас урьдчилан сэргийлэх сурталчилгааны ажлыг (4.5) намар, хаврын хуурайшлын үеэр хэвлэл, мэдээллийн бүх хэрэгслээр тогтмол зохион байгуулж байх шаардлагатай.

4.24. ТАГИЙН ОГДОЙ

Ochotona alpina (Pallas, 1773)

Баг: Туулай хэлбэртэн (Lagomorpha)
Овог: Огдой (Ochotonidae)
Англи нэр: Alpine Pika
Ижил нэр: *O. changaica*, *O. nitida* (Wilson and Reeder, 2005). *O. ater* Eversmann, 1842; *O. nanula* Yakhontov et Formozov, 1992; *O. nitida* Hollister, 1912; *O. sayanica* Yakhontov et Formozov, 1992; *O. sushkini* Thomas, 1924 (Павлинов и Лисовский, 2012).



Ангилал зүйн тойм. Ангилал зүйн өөрчлөлт, асуудал одоогоор гараагүй байна.

Таних шинж. Биеийн урт 175-220 мм, тавхайн урт 25-35 мм, жин 160-350 г. Зуны зүс ухаа шаргаас ухаа бор, өвөл бараан саарал, хэвлий саарал. Сүүлгүй. Чих том дугариг, цайвар эмжээртэй. Амьдрах орчин, биеийн хэмжээ, зүс нь асганы огдойтой төстэй бөгөөд хойд тавхайн хэмжээ илүү урт байдгаар ялгагдана. Эрүүний мэдрүүл үс “сахал” 60-70 мм урт.

Үнэлгээ ба үндэслэл
Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).
Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).
2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Монгол орны уулархаг нутагт өргөн тархсан,

популяцийн тоо толгой бууражагүй тул өмнөх үнэлгээг хэвээр үлдээв.

Үнэлгээ хийсэн: С.Шар, Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, Э.Ундрахбаяр, Р.Самъяа (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Орос, Казахстан, Хятад, Монголд тархсан (Smith *et al.,* 2016; https://www.mammaldiversity.org).

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол Алтай, Хангай, Хөвсгөлийн уулсаар, Их нууруудын хотгор, Нууруудын хөндийн хойд нутгаар тархана (Цэвэгмид, Цэнджав, 2004). Тагийн огдой өндөр уулын таг, царам (6), хажуу бэлийн аса, голын гүн хавцлын хад чулуутай, бутлаг ургамалтай орчинд (3.4) байршина.



Амьдралын онцлог. Бүлээр амьдарна. Өдөр, үдшийн бүрэнхий, үүрээр идэвхтэй. Элдэв жижиг дэгнүүлт үетэн, улалж, сонгино, алаг өвсний ургал болон цэцэгт хэсгээр голчлон хооллоно. Ороо нийллэг 4-р сарын дунд үед болж, эм огдой 25 орчим хоног хээлээ тээнэ. Жилд 2 удаа, тааламжтай жилд 3 удаа төллөх ба нэг удаа дунджаар 2-3, заримдаа 4-5 бөмбөөлэй төрүүлнэ. Нэг настайдаа үржилд орно. Тагийн огдой 5 хүртэл жил насална (Соколов, 1973; Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Монгол орны уулархаг нутагт өргөн тархсан тоо толгойн хувьд элбэг зүйл.

Ховордлын шалтгаан. Монгол орны өндөр уулсаар хязгаарлагдмал популяци байгаа нь ховордлын гол шалтгаан болно. Сүүлийн жилүүдэд дэлхийн дулаарал нөлөөлөх хандлагатай (A.Smith, ам мэдээ). Арьсыг гадаадад худалдаалах зорилгоор агнадаг байсан бөгөөд энэ зүйлийн хувьд хор уршиг багатай юм (Wingard and Zahler, 2006).

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр тагийн огдой 4,000 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 22% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн тархац нутаг, популяцийн тоо толгой болон хэмжээ, хандлага (3.2), биологи, экологи (3.3), түүнд учирч буй сөрөг нөлөөллийг нарийвчлан судалсны үндсэн дээр хамгаллын зүй зохистой арга хэмжээг тодорхой төлөвлөж, хэрэгжүүлэх нь зүйтэй.

4.25. АСГАНЫ ОГДОЙ

Ochotona hyperborea (Pallas, 1811)

Баг: Туулай хэлбэртэн (Lagomorpha)
Овог: Огдой (Ochotonidae)
Англи нэр: Northern Pika
Ижил нэр: Асганы үхэр огдой (Дуламцэрэн, 2003); *O. mantchurica*, *O. svatoshi* (Wilson and Reeder, 2005).



Ангилал зүйн тойм. Өмнө нь *Ochotona alpina* зүйлд хамааруулдаг байсан бөгөөд хожим дуу авиа болон морфологийн хувьд ялгаатайг тогтоож, биеэ даасан зүйл болгосон (Smith and Weston, 1990).

Таних шинж. Дунд зэргийн хэмжээтэй бахим биетэй. Биеийн урт 133-190 мм, жин 60-195 г. Мэдрүүл үс "сахал" 42-55 мм. Ухаа, цайвар бор ба хэвлий цайвар. Хүзүүний хажуугаар бор толботой. Сүүлгүй. Чих том дугариг ба цайвар эмжээртэй. Тавхай үсээр хучигдсан.

Үнэлгээ ба үндэслэл
Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).
Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).
2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Тархац нутаг уудам, тоо толгойн элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй хэмээн үзэж өмнөх үнэлгээг хэвээр үлдээв.

Үнэлгээ хийсэн: Э.Ундрахбаяр, Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, С.Шар, Р.Самъяа (2025).
Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Орос, Хятад, Хойд Солонгос, Япон, Монголд тархсан (Smith and Lissovsky, 2016).

Монгол орны тархац, амьдрах орчин. Их Хянганы салбар уулс, Хэнтийн нуруу, Монгол Дагуурын хээрийн ойт нутгаар тархсан (Банников, 1953; Stubbe and Chotolchu, 1971; Дуламцэрэн, 1970; Соколов и Орлов, 1980). Тайгын (1.1) бутлаг ургамалтай (3.3) болон хад, асга бүхий газар (6) түүний тохиромжтой амьдрах орчин болно.



Амьдралын онцлог. Уулын хажуу, таг, бэлийн асга, нураг, голын хөндийн хавцалд элдэв сөөг, буттай газар байршин бүлээр амьдарна. Өдөр болон бүрэнхийд идэвхтэй. Элдэв зүйл алаг өвс, жижиг дэгнүүлт үетэн, сөөг, бутны үр, ургал болон цэцэгт хэсгээр голчлон хооллоно. Оroo нийллэг 4-р сарын дунд үед болж, 25 орчим хоног хээлээ тээнэ. Жилд 2 удаа төллөх ба нэг удаад 2-3 бөмбөөлэй төрүүлнэ. Нэг настайдаа үржилд орно. Асганы огдой 4 хүртэл жил насална (Батсайхан нар, 2022).

Тоо, толгой, нягтшил. Энэ зүйлийн тоо толгой, нягтшилын талаарх судалгааны мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Монгол орны өндөр уулсаар хязгаарлагдмал популяци байгаа нь ховордлын шалтгаан болж байна (A.Smith, аман мэдээ). Арьсыг нь гадаадад худалдаалах зорилгоор агнадаг байсан бөгөөд энэ нь хор нөлөө бага (Clark *et al.,* 2006; Wingard and Zahler, 2006). Ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар мод бэлтгэх (1.3.3), ой хээрийн түймэр (1.7), дэлхийн дулаарлаас (6.1.1) үүдэлтэй орны доройтол зэрэг нь сөрөг нөлөө үзүүлнэ.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр асганы огдой 4,000 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 36% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн тархац нутаг, популяцийн тоо толгой болон хэмжээ, хандлага (3.2), биологи, экологи (3.3), түүнд учирч буй сөрөг нөлөөллийг нарийвчлан судалсны үндсэн дээр хамгаллын зүй зохистой арга хэмжээг тодорхой төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлагатай.

4.26. МОНГОЛ ОГДОЙ

Ochotona pallasi (Gray, 1867)

Баг: Туулай хэлбэртэн (Lagomorpha)
Овог: Огдой (Ochotonidae)
Англи нэр: Pallas's Pika
Ижил нэр: *Ochotona pallasii* ssp. *pricei* Thomas, 1911 (Lissovsky and Smith, 2016).



Ангилал зүйн тойм. Одоогоор дэлхийд 3 салбар зүйл бүртгэгдээд байна. Монголд *O. p. pallasii* салбар зүйл тохиолдоно (Lissovsky and Smith, 2016).

Таних шинж. Биеийн урт 190-215 мм, тавхайн урт 29-33 мм, жин 120-280 г. Бие бахим, дунд зэргийн хэмжээтэй. Зүс ухаа бор шарга, хэвлий саарал юм уу шаргал. Хүзүүний хажуугаар ухаа толботой. Сүүлгүй. Чих том дугариг, цайвар эмжээргүй. Эрүүний мэдрүүл үс "сахал" ойролцоогоор 60 мм урт. Тавхай цайвар үсээр хучигдсан (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Тархац нутаг уудам, тоо толгойн элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй хэмээн үзэж өмнөх үнэлгээг хэвээр үлдээв.

Үнэлгээ хийсэн: Д.Лхагвасүрэн, С.Шар, Н.Батсайхан, Э.Ундрахбаяр, Р.Самъяа (2025).
Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Хятад, Орос, Монголд тархсан (Lissovsky and Smith, 2016).

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол Алтай, Хангайн өмнөд этгээд, Дундад Халхын төв ба баруун хэсэг, Говь Алтай, Зүүн гарын говь, Алтайн өвөр говь, Нууруудын хөндий, Умард говь, цөлийн хадат уулсаар тархжээ. Монгол огдой цөлийн дунд байрших уулын хээр, арцтай, хад чулуутай хажуу (6), бэлийн гуу жалга, өндөр уулс, цөлжүү хээрийн (4.4) үетэн, алаг өвст нутагт тохиолдоно (Дуламцэрэн, 1989; Батсайхан нар, 2022).



Амьдралын онцлог. Бүлээр амьдарна. Өдөр, үдшийн бүрэнхий, үүрээр идэвхтэй. Элдэв үетэн, улалж, алаг өвсний ургал болон цэцэгт хэсгээр голчлон хооллоно. Оroo нийллэг 4-р сарын дунд үед болж, 30 орчим хоног хээлээ тээнэ. Жилд 2 удаа, тааламжтай жилд 3 удаа төллөх ба нэг удаа дунджаар 5-8 бөмбөөлэй төрүүлнэ. Нэг настайдаа үржилд орно. Ихэвчлэн өглөө, оройн бүрэнхийд исгэрч дуут дохио өгөх нь түгээмэл. Нүхний амсар орчмоороо зууж даах хэмжээгээрээ олон тооны чулуу эсвэл адууны хомоол, аргал, харгана, сөөгийн мөчир овоолж, задгай нөмөргүй газар 40 см хүртэл өндөр “хэрэм” босгоно. Монгол огдой 4 хүртэл жил насална (Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Монгол огдойн нягтшил харилцан адилгүй. Хангайн бүс нутагт га-д 10-15-аас 30-40 бодгаль, Монгол Алтайд га-д 20-25-аас 30-35 бодгаль, Говь Гурван сайханд 1 га-д 30-70 бодгаль хүрнэ (Тарасов, 1950; Цэнджав, 1982; Nadrowski, 2002).

Ховордлын шалтгаан. Зэрлэг амьтны халдварт өвчний улмаас түүний тоо толгой болон тархац нутаг нь хумигдана (Wang *et al.,* 2024). Монгол орны тарваган тахлын голомт бүхий зарим бүс нутагт зориудаар хор цацаж устгах ажиллагаа зохион байгуулах тохиолдол бий.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Монгол огдой 4,000 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 17% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн тархац нутаг, популяцийн тоо толгой болон хэмжээ, хандлага (3.2), биологи, экологи (3.3), түүнд учирч буй сөрөг нөлөөллийг нарийвчлан судалсны үндсэн дээр хамгаалллын зүй зохистой арга хэмжээг тодорхой төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлагатай.

4.27. СҮҮЛЭРХЭГ ЗУРАМ

Urocitellus (Spermophilus) undulatus (Pallas, 1778)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Хэрэм (Sciuridae)
Англи нэр: Long-tailed Ground Squirrel
Ижил нэр: Урт сүүлт зурам, *S. altaica*, *S. eversmanni, S. jacutensis, S. menzbieri, S. stramineus, S. Transbaikalicus* (Thorington and Hoffmann, 2005).



Ангилал зүйн тойм. Энэ зүйлийг өмнө нь *Spermophilus parryii* зүйлд хамааруулж байсан (Thorington and Hoffmann, 2005).

Таних шинж. Биеийн галбир төрхөөр бозлог зурмаас гоолиг, урт саглагар сүүлээр ялгагдана. Биеийн урт 200-320 мм, сүүлний урт 100-160 мм, тавхайн урт 38-45 мм, биеийн жин 350 г. Зоо нуруу дагуу цайвар хүрээтэй жижиг цайвар толботой, зүс хул шарга. Зулай бараан, сүүлний дээд тал хар бараан, зах хэсэг нь цайвар эмжээртэй. Хойд тавхайн ул нүцгэн (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл
Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC)
Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Популяцийн элбэгшил, тархац нутаг уудам, зориуд агналт хийдэггүй зэрэг үзүүлэлтийг үндэслэн, анхааралд өртөхөөргүй хэмээн үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, Р.Самъяа, Э.Ундрахбаяр, С.Шар (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Казахстан, Орос, Хятад болон Монголд тархсан (Clark *et al.,* 2006).

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол Алтай, Говь Алтай, Хөвсгөл, Хангай, Хэнтий, Монгол Дагуурт тархсан. Сүүлэрхэг зурам уулын хээр, умардын болон сэрүүн бүсийн ойтой залгаа хээрийн экосистем (4.4), өндөр уулын тагийн нуга, голын хөндий, нугажуу хээрийн экосистем (5.1, 5.4), татмын нугын өвөрмөц экосистемд идээшин амьдарна. Бусад зүйл зурамтай харьцуулахад илүү чийглэг газрыг шүтдэг (Батсайхан нар, 2022).



Амьдралын онцлог. Гөлчгийтэй бүдүүн эм бүлээр амьдарна, харин эр зурам ганцаар зайцан байршина. Өдрийн идэвхтэй. Өвслөг ургамлын ногоон ургал хэсэг, үр, үндэслэг иш, шулуун далавчит шавжаар хооллоно. Намар 9-р сарын сүүлчээс 4-р сарын сүүлч хүртэл ичээлнэ. Ичээнээс гарсны дараа үржилд орж, эм зурам 25 хоног орчим хээлээ тээж 5-8 гөлчгий төрүүлнэ. Нэг настай бэлэг боловсорно. Бүдүүн эм нь хойд мөч дээрээ босож, хошхирч дуут дохио өгч сэрэмжлүүлнэ (Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Тоо толгой, нягтшилын мониторинг мэдээ хангалтгүй.

Ховордлын шалтгаан. Энэ зүйлийн идээшил амьдрах орчин мал бэлчээрлэлтээс улбаатай газрын доройтол (1.1.4.1), уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр чийглэг нугын өвөрмөц экосистем хумигдаж буй (7.1) нь түүний тархац, элбэгшил буурах боломжит шалтгаан байж болзошгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан. Тухайлбал, энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3-д зааснаар сүүлэрхэг (урт сүүлт) зурмыг жил бүрийн 10 дугаар сарын 16-ны өдрөөс дараа оны 8 дугаар сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон. Мөн (11.1.9) тарвага, зурам, тэдгээрийн түүхий мах, нойтон болон халдваргүйжүүлээгүй арьсыг хот, тосгонд оруулах үйл ажиллагааг хориглодог бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу).

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр сүүлэрхэг зурам 4,000 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 16% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Өндөр уулын тагийн нуга, томоохон голын хөндийд бэлчээрийн менежментийг зохистой (4.1, 4.2) хэрэгжүүлэх нь чухал арга хэмжээ болно.

4.28. БОЗЛОГ ЗУРАМ

Spermophilus pallidicauda (Satunin, 1903)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Хэрэм (Sciuridae)
Англи нэр: Pallid Ground Squirrel
Ижил нэр: Цайвар сүүлт зурам



Ангилал зүйн тойм. *Spermophilus erythogenys* зүйлээс салган бие даасан зүйл болгосон (Harrison *et al.,* 2003).

Таних шинж. Биеийн урт 235-260 мм, сүүлний урт 41-59 мм, тавхайн урт 34-49 мм. Биеийн жин 350 г. Биеийн галбир төрхөөрөө сүүлэрхэг зурмаас арай бахим, богино сүүлтэй. Нурууны өнгө илэрхий цайвар, элсэн саарал. Сүүл богино бөгөөд сүүлний дээд хэсэг цайвар, захаараа бараан эмжээргүй. Сүүлний доод хэсгийн үс нэг ижил шар туяатай. Нүдний дээд болон доод талд улаан толботой. Хойд тавхайн ул нүцгэн (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл
Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).
Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).
2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Монгол орны цөлөрхөг хээрийн бүсэд өргөн тархсан, тоо толгойн элбэг зүйл. Популяцийн

тоо хэмжээ буураагүй хэмээн үзэж өмнөх үнэлгээг хэвээр үлдээв.
Үнэлгээ хийсэн: Д.Лхагвасүрэн, С.Шар, Н.Батсайхан, Э.Ундрахбаяр, Р.Самъяа (2025).
Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Хятад болон Монголд тархсан (Smith and Jonston, 2017).

Монгол орны тархац, амьдрах орчин. Их Нууруудын хотгор, Нууруудын хөндий, Говь Алтайн нуруу, Зүүнгарын говь, Дорнод говьд тархсан. Монгол орны хялганат, хаяа үетэн, шарилж, сонгиножуу цөлжүү хээр, уулын хээрийн (4.4) экосистемд тохиолдоно (Дуламцэрэн, 1989; Батсайхан нар, 2022).



Амьдралын онцлог. Бүлийн амьдралтай, өдрийн идэвхтэй. Говийн хялгана, таана, шаваг зэрэг өвслөг ургамлын ногоон хэсэг, шавжаар хооллоно. 9-р сарын сүүлчээс 3-р сарын сүүлч хүртэл ичээлнэ. Ичээнээс гарсны дараа үржилд орж, эмэгчин нь хээлээ 25 хоног орчим тээж 5-р сард төллөнө. Жилд нэг удаа төллөж дунджаар 7-9 гөлчгий төрүүлнэ. Нэг настайдаа үржилд орно.

Байгалийн нөхцөлд 10 жил, тэжээмэл нөхцөлд 15 жил орчим насална. Нүх нь энгийн боловч нэлээд гүнзгий, амсар нь өргөн, голч нь 6-10 см. Бозлогийн нүх хэсэг хэсгээрээ алаг цоог тохиолдоно. Нүхний эргэн тойронд мөр, ялгадас зэрэг амьдралын элдэв ул мөр үлдээнэ (Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Энэ зүйл зурмын тоо толгой, нягтшилын судалгаа хийгдээгүй.

Ховордлын шалтгаан. Малын тоо толгойн хэт өсөлтөөс болж амьдрах орчны хомсдол болон идэш тэжээлийн хүрэлцээ буурч байгаа нь бозлог зурамны тоо толгойд нөлөөлж буй гол хүчин зүйл болно.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан. Харин энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.9-д зааснаар тарвага, зурам, тэдгээрийн түүхий мах, нойтон болон халдваргүйжүүлээгүй арьсыг хот, тосгонд оруулах үйл ажиллагааг хориглодог бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу).

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр бозлог зурам 4,200 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 14% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн популяцийн тоо толгой, нягтшил (3.2), биологи, экологи (3.3) болон аюул заналын (3.5) судалгааг нарийвчлан хийх шаардлагатай.

4.29. ДАГУУР ЗУРАМ

Spermophilus dauricus (Brandt, 1843)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Хэрэм (Sciuridae)
Англи нэр: Daurian Ground Squirrel
Ижил нэр: Зумбараа зурам (Дуламцэрэн, 2003); *S. mongolicus, S. romasus, S. umbratus, S. Yamashinae* (Wilson and Reeder, 2005).



Ангилал зүйн тойм. Тус төрөлд *Spermophilus alaschanicus*-тай хамтатган үздэг байсан ба хожим ялгаатай зүйл болохыг баталсан (Орлов и Даваа, 1975).

Таних шинж. Харьцангуй жижиг биетэй зурам. Биеийн урт 180-230 мм, жин 280 г. Зоо нуруу шаргал саарал, үс бараан сортой. Биеийн хажуу бөөр, шанаа цайвар шаргал. Зулай нь нуруунаас арай бараан. Сүүлний шувтарга хэсэг хар-цагаан эмжээртэй. Хойд тавхайн ул тачир, сийрэг үсээр бүрхсэн (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Тархац нутаг уудам, тоо толгойн элбэг зүйл.

Популяцийн тоо хэмжээ буураагүй.тул өмнөх үнэлгээг хэвээр үлдээв.

Үнэлгээ хийсэн: Э.Ундрахбаяр, Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, С.Шар, Р.Самъяа (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Орос, Хятад болон Монголд тархсан (Cassola, 2016).

Монгол орны тархац, амьдрах орчин. Дорнодоос Хэрлэн голын дунд хэсэг хүртэл сэрүүн бүсийн хээрт (4.2) тархаж байсан бол (Банников, 1953; Дуламцэрэн, 1970; Соколов и Орлов, 1980) бол өдгөө Төв Халхын хээрт Туул, Хараа голын сав дагуу тохиолдох болсон (Clark *et al.,* 2006; Н.Батсайхан, Р.Самъяа нарын хэвлэгдээгүй мэдээ). Уулын энгэр, хөндий, голын сав дагуу зөөлөн хөрстэй үетэн, үетэн алаг өвст хээрт амьдарна.



Амьдралын онцлог. Гөлчгийтэй эм бүлээр, харин эр бодгаль ганцаар амьдарна. Өдрийн идэвхтэй. Элдэв шавж, ялангуяа хатуу далавчит цох, тэдгээрийн авгалдайгаар түлхүү хооллодгоор бусад зурамнаас онцлог, үетэн ургамлын ногоон ургал хэсэг, алаг өвсний үр иднэ. Бие гүйцсэн эр 8-р сарын эхээр, эм бодгаль 9-р сарын эхээр, харин залуу бодгалиуд 9-р сарын сүүлчээс дараа оны 4-р сарын дунд үе хүртэл ичээлнэ (Дуламцэрэн, 1970; Батсайхан нар, 2022). Ичээнээс гарсны дараа үржилд орж, эм зурам нь 28 хоног орчим хээлээ тээнэ. Дунджаар 8, хаяа 10-13 гөлчгий төрүүлнэ. Хоёр настайдаа бэлэг боловсорно. Бүдүүн эм зурам хойд мөч дээрээ босож, хошхирч дуут дохио өгч сэрэмжлүүлдэг (Батсайхан нар, 2022).

Тоо, толгой, нягтшил. Энэ зүйлийн тоо толгой, нягтшилын талаар мэдээ, баримтгүй.

Ховордлын шалтгаан. Малын тоо толгой өссөний улмаас бэлчээр талхлагдаж, уг зүйлийн амьдрах орчныг доройтуулах боломжтой (тодорхой судалгаа шаардлагатай). Мөн уул уурхайн олборлолттой (1.3.1) холбоотой хүрээлэн буй орчны бохирдол, дэлхийн дулаарал (6.1.1), түүнээс үүдэлтэй ой хээрийн түймэр (1.7) зэрэг нь нөлөөлөгч хүчин зүйлс болно.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.9-д зааснаар тарвага, зурам, тэдгээрийн түүхий мах, нойтон болон халдваргүйжүүлээгүй арьсыг хот, тосгонд оруулах үйл ажиллагааг хориглодог бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу).

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Дагуур зурам 4,000 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 8% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн популяцийн тоо толгой болон хэмжээ (3.2), биологи, экологийн (3.3) судалгааг тусгайлан хийж, түүнд үндэслэн тал хээрийн газар ашиглалт, бэлчээр хамгаалах бодлогод суурилсан тодорхой үйл ажиллагаануудыг (4.1) төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлагатай.

4.30. ЖИРХ

Eutamias sibiricus (Laxmann, 1769)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Хэрэм (Sciuridae)
Англи нэр: Siberian Chipmunk
Ижил нэр: *T. altaicus*, *T. asiaticus*, *T. Jacutensis, T. Okadae, T. ordinalis гэх мэт* (Thorington and Hoffmann, 2005).



Ангилал зүйн тойм. Ангилал зүйн өөрчлөлт үгүй.

Таних шинж. Биеийн галбир төрх гоолиг, хэрмээс арай жижиг биетэй. Биеийн урт 130-170 мм, сүүлний урт 80-116 мм, тавхайн урт 31-38 мм, жин 60-120 г хүрнэ. Зоо нуруу дагуу тууш таван хар бараан өргөн судалтай, бараан судлын завсар хэсэг цайвар, биеийн хажуу, зулайн зүс хул шарга. Хэвлий цайвар. Зулай нь нуруунаас арай бараан. Сүүл саглагар, дээд талдаа гурван бараан нарийн судалтай, захаар нь цайвар эмжээртэй (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл
Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).
Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).
2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC).

Популяцийн элбэгшил, тархац нутаг уудам, зориуд агналт хийдэггүй зэрэг үзүүлэлтийг үндэслэн анхааралд өртөхөөргүй хэмээн үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, Р.Самъяа, Э.Ундрахбаяр, С.Шар (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Хятад, Япон, Казахстан, Ардчилсан Солонгос, Өмнөд Солонгос, Монгол болон Орост тархсан.

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол Алтай, Хөвсгөл, Хангай, Хэнтий, Дагуур, Хянганы салбар уулсын ойт (1.4) нутгаар тархсан. Жирх бүх хэв шинжийн ой, голын хөндийн шугуйд идээшин амьдарна. Заримдаа ойн доторх эсвэл захын асга, нурагтай газар тохиолдоно. Дорнод Монголын Нөмрөг голын хөндийд хад чулуутай, сөөглөг ургамалтай модгүй газар тохиолдох нь бий (Батсайхан нар, 2022).



Амьдралын онцлог. Өдрийн идэвхтэй. Модонд сайн авирна. Навчит модлог болон бутлаг ургамлын үр, жимс, шинэс, хушны самар, өвслөг ургамлын ургал хэсэг зэргээр хооллох ба шавж ялангуяа, шоргоолжны өндөг иднэ.

Жирх элдэв үр, шинэсний шилмүүс зэргийг өвлийн тэжээлд нөөцөлнө. Намар 10-р сард ичээнд орж, дараа оны 4-р сарын эхээр гарна. Ичээнээс гарсны дараа 4-р сарын дундуур ороо нийллэг болно. Эм жирх 35-40 хоног хээл тээж, жилд нэг удаа 4-6 гөлчгий төрүүлнэ. Нэг настайдаа үржилд орно (Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Тоо толгой, нягтшилын мониторинг мэдээ, баримт хангалтгүй.

Ховордлын шалтгаан. Энэ зүйлийн тархцын зарим нутагт байгалийн (7.4) болон хүний өдөөсөн түймэр (10.5), ойн сийрэгжүүлэх тайралтаас (1.3.3.3) үүдсэн амьдрах орчны хомсдол (1.1.1.3) бий болж байна. Сүүлийн хоёр арванд самар түүгчид (3.1.3) жирхийн нөөцөлдөг хушны үрийг цөлмөн ашиглаж байгаа нь ихээхэн сөрөг нөлөө үзүүлж байна.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр жирх 8,200 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 25% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Умардын болон сэрүүн бүсийн ойн экосистемийг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд шинээр хамруулах (4.4.1), хушны самар буюу үрийг цуглуулах газрыг хязгаарлах, өнжөөж ашиглах (4.2) арга хэмжээг хэрэгжүүлэх нь нэн чухал болно.

4.31. БАРААН ХЭРЭМ

Sciurus vulgaris (Linnaeus, 1758)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Хэрэм (Sciuridae)
Англи нэр: Eurasian Squirrel
Ижил нэр: Ижил нэр үгүй.



Ангилал зүйн тойм. Монгол орны бараан хэрмийн салбар зүйлийн судалгаа хийгдээгүй.

Таних шинж. Биеийн урт 160-280 мм, сүүлний урт 140-220 мм, чихний урт 27-36 мм, тавхайн урт 50-63 мм, жин 200-400 г. Өвөл хэрмийн чихний үзүүр хэсэг урт сахлаг цацагтай. Зуны зүс ухаа улаанаас хар бор, хэвлий цагаан, сүүл ухаа, хүрэн бор эсвэл хар. Өвлийн зүс саарал, бараан саарал эсвэл ухаа саарал. Сүүл урт саглагар. Хойд мөч урд мөчөөс илүү урт, бахим. Нүд бүлтгэр (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл
Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Ховордож болзошгүй (NT) (Clark *et al.,* 2006).
2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Тархац нутаг уудам, тоо толгойн элбэг зүйл бөгөөд популяцийн тоо хэмжээ буураагүй хэмээн үзэж анхааралд өртөхөөргүй зэрэглэлээр үнэлэв.
Үнэлгээ хийсэн: Д.Лхагвасүрэн, С.Шар, Н.Батсайхан, Э.Ундрахбаяр, Р.Самъяа (2025).
Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Албани, Австри, Беларусь, Бельги, Босни Херцеговина, Болгар, Хятад, Хорват, Чех, Дани, Эстони, Финланд, Франц, Герман, Грек, Унгар, Ирланд, Итали, Япон, Өмнөд Солонгос, Хойд Солонгос,

Латви, Лихтенштайн, Литва, Люксембург, Монтенегро, Нидерланд, Хойд Македон, Норвег, Польш, Португал, Румын, Орос, Серби, Словак, Словени, Испани, Швед, Швейцар, Турк, Украин, Их Британи болон Монголд тархсан (Gazzzard, 2023).

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол Алтай, Хөвсгөл, Хангай, Хэнтий, Хянганы салбар уулсын ойт нутгаар тархсан. Хэрэм элдэв хэв шинжийн ойд идээшин амьдрах боловч хуш, хуш-шинэсэн болон холимог ойг (1.4) илүү шүтнэ (Батсайхан нар, 2022).



Амьдралын онцлог. Өдрийн идэвхтэй. Модонд сайн авирна, дүүлнэ. Газарт ч хурдан харайж, дэгдэнэ. Хушны самар, бусад шилмүүст модны үр, сөөгийн жимс, мөөгөөр зонхилон хооллох авч, заримдаа жижиг шувууны өндөг, нялх ангаахайг иднэ. Хушны самар, бусад шилмүүст модны үр, мөөг зэргийг өвлийн тэжээлд нөөцөлнө. Орооо нийллэг 3-р сард болно. Эм нь 36-42 хоног хээл тээж, жилд 1-2 удаа төрөх ба нэг удаа 3-6 зулзага төрүүлнэ. Залуу бодгаль 10-12 сартай бэлэг боловсорно (Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Тоо толгой, нягтшилын сүүлийн үеийн мэдээ хомс. Хэнтийн нурууны Цагаан хадны хушин ойд 1965-1966 онуудад 1000 га-д 150 хэрэм, Хангайн нуруунд 1000 га-д 54 хэрэм тохиолдож байжээ (Сосорбарам, Болд 1968; Цэнджав, 1975). ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн судалгаагаар, 1 км^2 талбайд 14 орчим толгой хэрэм байгааг 1986 онд тогтоосон (Адъяа, 2024).

Ховордлын шалтгаан. Олон улсын зах зээлд хэрэмний үслэг арьсыг нийлүүлэхийн тулд зүй зохисгүй агнаж байжээ. Хятадын зах зээлд арьс нэлээд үнэтэй байдаг бөгөөд агнуурын тоо хэмжээ тодорхойгүй. Энэ зүйлийн тархцын зарим нутагт байгалийн болон хүний тавьсан түймэр, хушны самар түүх, ойн бусад дагалт баялгийн ашиглалт, мод бэлтгэлээс үүдэлтэй орчны доройтол, хомсдол зэрэг нь хорогдлын гол шалтгаан болно (Clark *et al.,* 2006).

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд тухайлбал, энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2-т зааснаар бараан хэрмийг жил бүрийн 2 дугаар сарын 11-ний өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон. Үүнээс гадна, (10.1.2) агнуурын амьтны жим дээр нүх ухах, буу сойх, занга, сааль тавих, (10.1.8) ан агнах зориулалтын бус буу, сум хэрэглэх зэрэг арга, зэвсэг хэрэгслээр агнах, барихыг хориглодог.

Мөн Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр бараан хэрэм 25,500 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ (1.1-ээс харна уу).

Энэ зүйлийн тархац нутгийн 26% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн популяцийн тоо толгой, нягтшил (3.2), биологи, экологи (3.3) болон аюул заналын (3.5) судалгааг нарийвчлан хийж, үүний үндсэн дээр зүй зохистой ашиглах, хамгаалах тодорхой арга хэмжээнүүдийг төлөвлөж, хэрэгжүүлбэл зохистой.

4.32. ДАГУУР НОМИН

Myospalax aspalax (Pallas, 1776)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Сохор номин (Spalacidae)
Англи нэр: False or Steppe Zokor
Ижил нэр: Сохор номин; *M. armandii*, *M. dybowskii*, *M. talpinus*, *M. Zokor* (Wilson and Reeder, 2005). *M. dybowskii* Tscherski, 1873; *M. talpinus* Pallas, 1811 (pro aspalax Pallas); *M. zokor* Desmarest, 1822 (Павлинов и Лисовский, 2012).



Ангилал зүйн тойм. *Mus aspalax* Pallas, 1776 хэмээн нэрлэж байсан ба төрлийн нэр өөрчлөгдөж *Myospalax* болсон. Пузаченко нарын (2009) судлаачид *M.aspalax* ба *M.armandii* зүйлийг бие даасан зүйлүүд гэж үзжээ. Харин Павлинов, Хляп (2012) нар эдгээр 2 зүйл нь аллопатрик салбар зүйл гэж бичжээ (Лисовский, 2019).

Таних шинж. Биеийн урт 166-198 мм, сүүлний урт 36-58 мм, тавхайн урт 30-37 мм, жин 260-320 г. Бие бахим. Зоо нуруу үнсэн саарал, үс өтгөн, зөөлөн. Толгой том, хоншоор өргөн, зарим бодгалийн дух цайвар толботой. Сүүл нүцгэн. Урд мөч хүчирхэг, бахим, малтуур хэлбэртэй, хумс махир.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Популяцийн тоо толгойн өөрчлөлтийн

талаар сүүлийн үеийн мэдээлэл хомс боловч харьцангуй уудам нутагт тархсан бөгөөд тархац нутгийнхаа хүрээнд элбэг тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: С.Шар, Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, Э.Ундрахбаяр, Р.Самъяа (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Хятад, Орос болон Монголд тархсан (Cassola *et al.,* 2016).

Монгол орны тархац, амьдрах орчин. Хангай, Хэнтийн нурууд болон Дагуурын хээр, Хянганы салбар уулсаар тархжээ (Дуламцэрэн нар, 1989; Батсайхан нар, 2022). В.Н.Скалон (1946) Хэнтий аймгийн нутагт Онон, Хурх голын хөндийд судалгаа хийж нүхний бүтэц, амьдрах орчны талаар багагүй мэдээ цуглуулжээ. Голын хөндийн (5.13) нуга, нугажуу хээр, ойн цоорхой, зах, элсэрхэг хөрс бүхий ухаа гүвээд байршимтгай.



Амьдралын онцлог. Өглөө, оройн цагаар шороо идэвхтэй түрнэ. Бүлээр амьдарна. Ичээлэхгүй. Хөрсөн доор яргаж, урт, олон салаа хонгил ухаж хооллон амьдарна. Хаяа гадаргууд ил гарна. Хонгилын гүн хатуу хөрстэй газар 15-25 см хүрнэ. Хонгилын урт дунджаар 7 м орчим, газар доорх үүрний байршлын дундаж гүн 86 см (Скалон, 1946). Урт хонгил ухаж, дээш түрж гаргасан хөрс шороо нь цувраа олон жижиг овоолго үүсгэнэ. Овоолгын суурь 1 м, өндөр 40-50 см. Нэг цувраа овоолго заримдаа 100 м хүртэл үргэлжилнэ. Элдэв ургамлын үндэс, үндэслэг иш зэрэг газрын доорх ургал хэсгээр хооллоно. Эм амьтан жилд нэг удаа 5-р сарын сүүлч, 6-р сарын эхээр 5-6 гөлчгий төрүүлнэ.

Тоо толгой, нягтшил. Популяцийн тоо толгой, нягтшилын мэдээ, баримт хангалтгүй.

Ховордлын шалтгаан. Энэ зүйлд уул уурхай (1.3.1), малын бэлчээрийн ашиглалт (1.1.4) атар газар эзэмших (1.1.1.3) үйл явц сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр дагуур номин 5,000 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 22% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Атар газар эзэмших, хадлан бэлтгэх үйл явцтай холбоотойгоор популяцийн үнэлгээ (3.9) хийж, хамгааллын арга хэмжээг тодорхойлж, хэрэгжүүлж байх шаардлагатай. Далд амьдралтай тул амьдрах орчны хомсдол үүсвэл тоо толгойн буурах эрсдэлтэй.

4.33. ХЭРГЭЛЗИЙ ОГОТНО

Stenocranius (Microtus) gregalis (Pallas, 1779)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Шишүүхэй (Cricetidae)
Англи нэр: Narrow-headed Vole
Ижил нэр: *Lasiopodomys gregalis* Pallas, 1779; *Mus gregalis* Pallas, 1779; *Microtus gregalis* Pallas, 1779.



Ангилал зүйн тойм. Сүүлийн үеийн молекул филогенезийн судалгаанд үндэслэн энэ зүйлийг *Stenocranius* төрөлд хамааруулсан (Petrova *et al.,* 2016).

Таних шинж. Биеийн урт 100-130 мм, сүүл 20-35 мм, жин 40 г хүрнэ. Бие жижиг. Сүүл богино. Нуруу бор саарлаас гүн бор, сор үсний төгсгөл бараан ба цагаан төгсгөлөөс үүсэх цоохордуу туяатай. Дагз, нурууны урд хэсгээр уусмал хар судал үл мэдэг илэрч болно. Толгой нарийхан. Өргөн тархалттай, янз бүрийн орчинд амьдрах чадвартай тул олон салбар зүйл хэлбэр үүсгэх политип зүйл. Нүдний хоорондох зай 3 мм-ээс бага ба энэ хэсэгт хянга тод илэрнэ (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC).

Тархац нутаг уудам, тоо толгойн элбэг зүйл бөгөөд популяцийн тоо хэмжээн буураагүй хэмээн үзэж энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Д.Лхагвасүрэн, С.Шар, Н.Батсайхан, Э.Ундрахбаяр, Р.Самъяа (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Хятад, Казахстан, Киргизстан, Монгол болон Орост тархсан (Amori, Kennerley, 2024).

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол Алтай, Говь Алтай, Хөвсгөл, Хангай, Хэнтий, Монгол Дагуур, Зүүнгарын говь, Дундад Халх, Дорнод Монгол, Хянганы бүс нутгаар тархана. Чийглэг нуга, бүх хэв шинжийн хээрийн экосистем (4.4), ойн захаар (1.4, 3.4) амьдарна. Шүүслэг ургамал ихтэй биотопыг хамгийн дуртай сонгоно. Хэт чийглэг орчинд газар дээр өтгөн өвсөн дунд ч үүрээ засна (Батсайхан нар, 2022)



Амьдралын онцлог. Дулааны улиралд хоногийн турш идэвхтэй. Хүйтний улиралд шөнийн идэвх багасна. Ургамлын ногоон хэсгээр хооллоно. Сонголт хийх нь бага тул амьдарч байгаа орчиндоо түгээмэл шүүслэг ургамлыг иднэ. Үржил 4-8-р сард үргэлжилнэ. Өвөлжсөн эм оготно нэг үржлийн хугацаанд 4-5 хүртэл төрөх боломжтой. Нэг удаад 2-13 гөлчгий гаргана. Хавар эртийн төл тэр жилдээ 2 хүртэл удаа төллөх боломжтой (Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Тоо толгой, нягтшилын судалгааны мэдээ, баримт байхгүй.

Ховордлын шалтгаан. Энэ зүйлийн тархцын зарим нутагт малын тоо толгой өссөнөөр бэлчээрийн талхлалтаас үүдэлтэй орчны доройтол (1.1.4.1) нүүрлэж болзошгүй (тодорхой мэдээ шаардлагатай). Булаг шандын ширгэлт, татралт, ган гачиг (7.1) энэ зүйлийн хорогдлын шалтгаан болно.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр хэргэлзий оготно 3,600 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 15% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн популяцийн тоо толгой, нягтшил (3.2), ангилал зүй (3.1), биологи, экологи (3.3) болон аюул заналын (3.5) судалгааг нарийвчлан хийх шаардлагатай. Мөн түүний доройтсон амьдрах орчныг (4) нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах нь зүйтэй.

4.34. МЭХЭЭРЧ ОГОТНО

Alexandromys oeconomus (Pallas, 1776)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Шишүүхэй (Cricetidae)
Англи нэр: Root Vole or Tundra Vole
Ижил нэр: *Microtus oeconomus M. altaicus*, *M. dauricus*, *M. koreni* (Wilson and Reeder, 2005).



Ангилал зүйн тойм. Өмнө нь энэ зүйлийг *Microtus* төрөлд хамааруулж байсан бөгөөд өдгөө *Alexandromys* төрөлд хамааруулах болсон (Liu *et al.,* 2016).

Таних шинж. Биеийн урт 115-120 мм, сүүл 40-50 мм, жин 30-65 г. Оготнын дэд овог дотроо бие томтой зүйл. Нуруу бараан, бор хүрэн, хэвлий мөнгөлөг саарал. Сүүл хоёр өнгөтэй байдгаараа бусад зүйлээс ялгаатай. Нүдний хооронд болон зулайн ясанд хянга тод илэрнэ (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006). 2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Тархац нутаг уудам, тоо толгойн элбэг бөгөөд популяцийн тоо хэмжээн буураагүй хэмээн үзэж өмнөх үнэлгээг хэвээр үлдээв.

Үнэлгээ хийсэн: Э.Ундрахбаяр, Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, С.Шар, Р.Самъяа (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Австри, Америк, Беларусь, Герман, Канад, Казахстан, Нидерланд, Литва Норвег, Орос, Польш, Словак, Украйн, Унгар, Финланд, Чех, Швед, Эстони болон Монголд тархсан (Linzey *et al.,* 2016).

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн нуруу, Их Хянганы салбар уулс, Монгол Дагуурын хээр зэрэг Монгол орны хойд болон зүүн хэсгийн (Дуламцэрэн, 1970; Соколов и др., 1985) сэрүүн бүсийн ой (1.4), тайгын (3.3) бутлаг, үетэн давамгайлсан ургамалжилттай (4.4) амьдрах орчныг шүтэн байршина. Монгол Алтайн нуруунд хус, шинэсэн ой болон голын татмын бургасан шугуйд тэмдэглэгдсэн (Лхагвасүрэн нар, 2023).



Амьдралын онцлог. Ой, ойт хээр, хуурай бүсийн нууруудын эрэг орчим зэрэг чийглэг амьдрах орчинд тохиолдоно (Дуламцэрэн, 1970). Бүрэнхий болон шөнийн идэвхтэй. Ургамлын ногоон хэсгээр хооллохын зэрэгцээ мод бутны холтос, мөчир, үр, жимс иднэ. Үүрээ нүхэнд засах хэдий ч зарим тохиолдолд хамгаалалт сайтай нууцлаг газар ил засна. Үржил 4-8-р сард явагдана. Хавар эрт төрсөн төл тэр жилдээ үржилд орно. Жилд 2-4 удаа төрөх бөгөөд нэг удаа 2-8 гөлчгий гаргана. Хээл тээх хугацаа 3 долоо хоног орчим. Байгалийн нөхцөлд 1.5 жил насална (Банников, 1953; Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Баян-Өлгий аймгийн Цэнгэл, Сагсай сумдын нутагт 100 баригч/хоногт 0.53±0.21 бодгаль ноогдож байв (Лхагвасүрэн нар, 2023). Төв аймгийн Алтанбулаг, Аргалант, Баянхангай сумдын нутгийн Хустайн нурууны байгалийн цогцолборт газрын ойт хээрт хийсэн судалгаагаар 100 баригч/хоног дахь харьцангуй элбэгшил 2005 онд 0.15, 2006 онд 0.13, 2007 онд 0.18, 2008 онд 0.3 тус тус байв (Самъяа нар, 2011).

Ховордлын шалтгаан. Ховордлын шалтгааны талаар мэдээлэл хангалтгүй (Clark *et al.,* 2006). Дэлхийн дулаарал (6.1.1) түүнээс үүдэлтэй ой хээрийн түймэр (7.4) зэрэг нь энэ зүйлд сөргөөр нөлөөлнө.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр мэхээрч оготно 3,600 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 18% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн популяцийн тоо толгой, нягтшил (3.2), биологи, экологийн (3.3) нарийвчилсан судалгаанд үндэслэн хамгааллын менежментийг тодорхойлж, хэрэгжүүлэх шаардлагатай.

4.35. ӨРГӨӨНЧ ОГОТНО

Alexandromys (Microtus) fortis (Buechner, 1889)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Шишүүхэй (Cricetidae)
Англи нэр: Reed Vole
Ижил нэр: *M. f. michnoi* Kastschenko, 1910; *M. f. pelliceus* Thomas, 1911 (Павлинов и Лисовский 2012; Kryštufek and Shenbrot, 2022).



Ангилал зүйн тойм. Сүүлийн үед *Alexandromys* Ognev, 1914 дэд төрлийг төрлийн түвшинд авч үзэх болсноор ширгийн болон Монгол оготно зэрэг олон зүйлийг энэ төрөлд багтаах болов (Lissovsky *et al.,* 2018; Kryštufek and Shenbrot, 2022). Манайд *A. f. michnoi* Kastschenko, 1910 салбар зүйл бий.

Таних шинж. Хамгийн том биетэй оготно. Бие гүйцсэн эр оготнын биеийн урт 149.4 ± 7.3 мм, сүүлний урт 50.6 ± 4.6 мм, жин 78.5 ± 10.1 г (n = 32) бол эмийнх (өмнөх дарааллаар) 135.4 ± 8.0 мм, 47.9 ± 4.8 мм, 60.4 ± 8.5 г (n=22). Нуруу бараан, бор, хэвлий мөнгөлөг саарал. Сүүлний дээд тал бараан, доод тал нь цайвар. Биеийн хэмжээ нь хүйсээрээ ялгаатай. Бие гүйцсэн зарим эрийн жин 110 г хүрнэ (Tserendavaa *et al.,* 2023).

Үнэлгээ ба үндэслэл
Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Clark *et al.,* 2006).
2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Сүүлийн үеийн судалгаагаар, энэ зүйл манай орны хойд, зүүн хойд, зүүн зүгийн ой, ойт хээрээр өргөн тархсан бөгөөд тоо толгойн элбэг болохыг тогтоосон тул анхааралд өртөхөөргүй гэж үнэлэв.
Үнэлгээ хийсэн: Р.Самъяа, Н.Батсайхан, С.Шар, Д.Лхагвасүрэн, Э.Ундрахбаяр (2025).
Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Хятадын зүүн хагас (Smith and Yan, 2013), Оросын Байгаль нуур орчим, Амар мөрөн, Приморийн хязгаар (Павлинов и др. 2002), Солонгосын хойг (Yeong -Seok *et al.,* 2018) болон Монголд тархсан.

Монгол орны тархац, амьдрах орчин. Хэнтийн зүүн хэсэгт Улз голын хөндий (Самъяа нар, 2014), Хустайн нуруу (Н.Батсайханы аман мэдээ), Баруун Хэнтийн Ерөө голын хөндийгөөс олдсон (Самъяа нар, 2002; Tserendavaa *et al.,* 2023). Сэрүүн бүсийн ой (1.4), ойт хээрийн сийрэг ойн чөлөө (3.4), голын хөндийн алаг өвст чийглэг нугад (5.3; 5.4) байршина.



Амьдралын онцлог. Ургамлын ногоон хэсгээр хооллоно. Хуурай газарт нийлмэл бүтэцтэй нүхэнд, чийгтэй орчинд газрын гадаргуу дээр өвсөн дунд үүр засна (Павлинов, 2002). Үүрэндээ тэжээл бага хэмжээгээр нөөцөлнө. Тохиромжтой жил 3 удаа төллөнө. Нэг удаад 2-10 гөлчгий төрүүлнэ. Хонин-нугын популяцид эр нь байнга давамгайлсан бөгөөд тооны хэлбэлзэл тод илэрнэ. Тухайлбал, 2011 онд хамгийн элбэг зүйл байв. Тоо толгой ховордсон жилүүдэд баригдсан амьтдын дотор эр давамгайлж байлаа (Tserendavaa *et al.,* 2023).

Тоо толгой, нягтшил. Тоо толгойн хэлбэлзэл ихтэй. Хонин-нугад 2011 онд хамгийн элбэг тохиолдож байсан бөгөөд 100 конус/хоногт 57.5 бодгаль байлаа. Хамгийн ховор 2001 онд 1.3 бодгаль байсан (Tserendavaa *et al.,* 2023). Тооны хэлбэлзэл нь цаг агаарын нөхцөл (7.3), зүйл хоорондын болон зүйлийн популяцийн зохицуулгатай (9.8) холбоотой.

Ховордлын шалтгаан. Энэ зүйлийн тархцын зарим нутагт малын тоо толгой өссөнөөс орчин нь доройтох (1.1.4.1), мөн зарим зүйлийн мэрэгчидтэй нөөцийн төлөөх өрсөлдөөнд (8.1) ордог байж болзошгүй. Түүнчлэн ой хээрийн түймрийн (7.4) улмаас түүний амьдрах орчны чанар доройтно.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр өргөөнч оготно 3,800 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 24% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн популяцийн тоо толгой, нягтшил (3.2), биологи, экологи (3.3) болон аюул заналын (3.5) судалгааг нарийвчлан хийж, үүний үндсэн дээр хамгаалах арга хэмжээг тодорхойлох нь зүйтэй.

4.36. ШИРГИЙН ОГОТНО

Alexandromys (Microtus) maximoviczii (Schrenck, 1859)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Шишүүхэй (Cricetidae)
Англи нэр: Maximowicz's Vole
Ижил нэр: *M. gromovi, M. ungurensis* (Musser and Carleton, 2005).



Ангилал зүйн тойм. Монгол орны умард нутаг дахь тархцын хүрээнд *Alexandromys maximowiczii ungurensis* (Kastschenko, 1913), харин Амар мөрний эх бүрэлдэх Онон голын сав газар, Халх, Нөмрөг голын савд *Alexandromys maximowiczii maximowiczii* (Schrenck, 1859) гэх салбар зүйл тус тус тархсан (Kryštufek and Shenbrot, 2022).

Таних шинж. Дунд зэргийн биетэй төлөөлөгчийн нэг. Биеийн урт 150-157 мм, сүүл 50-68 мм. Нуруу бараан, улаан хүрэндүү туяатай. Хэвлий хар саарал (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Монгол дахь тархац уудам, томоохон

голуудын сав газар элбэг тохиолддог бөгөөд популяцийн ихэнх хэсэг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдсан тул энэ зэрэглэлээр үнэлэв.
Үнэлгээ хийсэн: Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, Р.Самъяа, Э.Ундрахбаяр, С.Шар (2025).
Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Хятад, Монгол болон Орост тархсан.

Монгол орны тархац, амьдрах орчин. Хэнтий уулсын баруун болон зүүн этгээдээс эх авдаг голуудын хөндий, Монгол Дагуурын хээртэй залгаа орших Онон голын сав газар, Хянганы салбар уулсаас эх авдаг Нөмрөг, Халх, Дэгээ голын хөндийд тархсан. Манай орны зүүн хойд хэсгийн ой (1.4), түүнтэй залгаа орших хээрийн экосистемд (4.4) голын хөндийн татмын нуга, ойн цоорхой, ойн захын намаг, чийглэг хөрстэй, бургас, давжаа хусан ширэнгэ, нугын ургамалтай (5.3) газрыг шүтэн амьдарна (Батсайхан нар, 2022).



Амьдралын онцлог. Ургамлын ногоон хэсгээр хооллоно. Нүх нь гүн биш, энгийн бүтэцтэй. Идэш тэжээлээ их хэмжээгээр нөөцөлнө. Хээл тээх хугацаа 20-25 хоног (Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Ерөө, Онон, Нөмрөг голын татмын нугад элбэг баригддаг оготно.

Ховордлын шалтгаан. Ховордлын шалтгааныг илэрхийлэх мэдээ, баримт тодорхойгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр ширгийн оготно 3,800 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 29% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн популяцийн төлөв байдал (3.2), биологи, экологи (3.3), учирч болзошгүй эрсдэл, аюулын (3.5) талаар тусгайлан судалгаа хийх шаардлагатай. Мөн түүний боломжит амьдрах орчин бүхий томоохон голын цэвдэгт хөрстэй, татмын нугын өвөрмөц экосистемийг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд нэмэлтээр хамруулах нь зүйтэй.

4.37. МОНГОЛ ОГОТНО

Alexandromys mongolicus (Radde, 1862)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Шишүүхэй (Cricetidae)
Англи нэр: Mongolian Vole
Ижил нэр: *Microtus mongolicus, M. baicalensis* Fetisov, 1941; *M. poljakovi* Kastschenko, 1901; *M. xerophilus* Skalon, 1936.



Ангилал зүйн тойм. Сүүлийн үеийн судалгаагаар *Microtus* төрлийг *Alexandromys* төрөлд багтаан ангилах болсон (Liu et *al.,* 2023).

Таних шинж. Биеийн урт 123 мм, сүүл 40 мм хүрнэ. Нуруу гүн бор, бор хүрэн, хар хүрэн. Хэвлий бараавтар, үнсэн саарал, хар саарал. Сүүлний дээд, доод талын өнгө эрс ялгарна. Өвлийн үс өтгөн, сахлаг бөгөөд өвлийн зүсэнд хүрэн туяа давамгайлна. Сүүлний дээд талын өнгө нурууны хэсгээсээ ч бараан байх нь элбэг (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC).

Тархац нутаг уудам, тоо толгойн элбэг бөгөөд популяцийн тоо хэмжээ бууpaагүй хэмээн үнэлж өмнөх үнэлгээг хэвээр үлдээв.
Үнэлгээ хийсэн: Д.Лхагвасүрэн, С.Шар, Н.Батсайхан, Э.Ундрахбаяр, Р.Самъяа (2025).
Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Хятад, Монгол, Орост тархсан (Gassola, 2016).

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол Алтай, Хангайн нурууны умард ба дорнод этгээд, Хэнтий, Монгол Дагуур, Дорнод Монголын хээрийн умард болон зүүн өмнөд захаар тархсан. Ойт хээр (1.4), уулын хээрийн амьтан. Уулын энгэр, бэл, голын хөндийн ургамал нөмрөг сайтай чийглэг хөрстэй орчныг дагаж байршина. Хээрийн бүсэд (4.4) чийглэг нам дор газар байршина (Батсайхан нар, 2022).



Амьдралын онцлог. Шөнийн идэвхтэй. Нүхний байгууламж нь энгийн бүтэцтэй. Жилийн дулааны улиралд хэд хэдэн удаа үржилд орно. Нэг удаа 5-8 гөлчгий төрүүлнэ.

Идэш тэжээлийн бүрэлдэхүүнд олон зүйл ургамал орох боловч ургамлын үндэсний хэсгийг дуртай иднэ. Өвөлд бага зэрэг тэжээл нөөцөлнө.

Тоо толгой, нягтшил. Улз голын хөндийд 2012-2014 онд явуулсан хээрийн судалгаагаар, баригдсан хөхтөн жижиг амьтдын дотор монгол оготно тооны хувьд аль ч жилүүдэд давамгайлж байсан (Самъяа нар, 2014).

Ховордлын шалтгаан. Энэ зүйлийн ховордлын шалтгааны талаарх мэдээ, баримт хангалтгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Монгол оготно 3,600 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 41% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн популяцийн тоо толгой, нягтшил (3.2), ангилал зүй (3.1), биологи, экологи (3.3) болон аюул заналын (3.5) судалгааг нарийвчлан хийх шаардлагатай. Доройтсон бэлчээр болон амьдрах орчныг (4) нөхөн сэргээх арга хэмжээ зохион байгуулах нь зүйтэй.

4.38. УЛИЙН ЦАГААН ОГОТНО

Lasiopodomys brandtii (Radde, 1861)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Шишүүхэй (Cricetidae)
Англи нэр: Brandt's Vole
Ижил нэр: Цайвар улийч (Дуламцэрэн, 2003); *L. aga* Kastschenko, 1912; *Microtus brandtii* (Radde, 1861); *Arvicola brandtii* (Radde, 1861); *M. warringtoni* Miller, 1913.



Ангилал зүйн тойм. Ангилал зүйн маргаангүй. Сүүл богино, хумс урт, дээд эрүүний 3-р араа богино зэрэг шинжээр *Microtus* төрлөөс ялгаж, *Lasiopodomys* төрөлд хамааруулсан (Павлинов и Лисовский, 2012). Монголд *M.b.brandtii* (Radde, 1861), *M.b.hangaicus* (Bannikov 1948) гэх салбар зүйлүүд тархана.

Таних шинж. Биеийн урт 150 мм, сүүл 30 мм хүрнэ (Батсайхан нар, 2022). Биеийн зүс цайвар саарал, элсэн саарал, бор шаргал. Зоо нуруу болон хажуугийн сор үсний бараан төгсгөл их биеийн дэвсгэр өнгөнд үл мэдэг хар цоохор судал үүсгэнэ. Нүд том, бүлтгэр бөгөөд толгойн оройн хэсэгт ойр байрлана. Хэвлий жигд цайвар. Өдрийн идэвхтэй. Улий үүсгэн бүлээр амьдарна. "Час" "час" дуугаар дохио дамжуулдаг зэрэг нь энэ зүйлийг таних зан төрхийн өвөрмөц шинж болно.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Энэ зүйлийн тархалт уудам газар нутгийг хамрах ба популяцийн хэмжээ том, тоо толгойн элбэг. Тоо толгойн элбэгшсэн үед ургамлын



нөмрөгт сөрөг нөлөөтэй гэж үзэн тооны зохицуулга тасралтгүй хийсээр байна.

Үнэлгээ хийсэн: Р.Самъяа, Н.Батсайхан, С.Шар, Д.Лхагвасүрэн, Э.Ундрахбаяр (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Хятадын зүүн хойд нутаг (Smith and Yan 2013) болон Оросын Байгалийн чанад дахь хээр (Павлинов и др., 2002), Монголд тархсан.

Монгол орны тархац, амьдрах орчин. Хан Хөхийн нуруунаас Их хянган хүртэлх ойт хээрийн зах, хээрийн бүсээр тархсан (Авирмэд, 2003). Сүүлийн жилүүдэд тархалт хойшоо Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын нутаг, баруун урагш Говь-Алтай аймгийн Чандмань, Цогт, Эрдэнэ сумын нутаг руу түрсэн. Өндөр уулын хээр, Төв халхын хээрийн намхан уулс, зүүн бүсийн талархаг, гүвээрхэг нутагт бүх хэв шинжийн хээрээр (1.4) тархана. Өндөр уулын энгэр, бэл, хормой, голын хөндий, нуурын захын дагжуур хөрстэй дэрс, харганат хөндий, өвөлжөө, худгийн орчим байршина.

Амьдралын онцлог. Оготно дотроо хээрийн ил задгай орчинд амьдардаг, жинхэнэ өдрийн идэвхтэй зүйл. Олон үлий бөөгнөрсөн томоохон хэмжээний суурьшил үүсгэнэ. Тачир ургамалтай ил задгай газар амьдрах тул хойд хөл дээрээ зогсож алсыг харах, өөр хоорондоо дуут дохио өгч мэдээлэл дамжуулах нь тал хээрийн амьдралд зохицсон жинхэнэ социаль амьдралтай амьтны шинж болно. Ургамлын ногоон хэсгээр түлхүү хооллох ч идэш нь улирлаар солигдоно. Хавар эрт ургамлын үндэс иднэ. Үүрэндээ тэжээл нөөцөлнө. Жилийн турш идэвхтэй ч хүйтний улиралд газрын гадаргууд гарах нь ховор. Үржил 4-8-р сард үргэлжилнэ. Түрүү жилийн сүүлийн төллөлтийн өвөлжсөн залуу бодгалиуд дараа хавар популяцийн үржлийн цөмийг үүсгэнэ. Үржлийн хугацаанд нэг эм оготно 3-4 удаа төллөх ба төллөх бүрдээ 2-13 зулзага төрүүлнэ. Хавар эхний төрөлтийн залуу бодгалиуд тэр жилдээ үрждэг. Байгалийн нөхцөлд 1.5 жил насална.

Тоо толгой, нягтшил. Энэ зүйлийн тархац нутгийн нийт хэмжээ 40 сая га. Улаанбаатар хот орчимд хэт олшрол болоогүй үеийн оготнын нягтшил 180 бодгаль/га (Zoephel, 1993)–272 бодгаль/га (Dawaa, 1985). Хэт олширсон үед нэг га-д тохиолдох оготны тоо 500-аас дээш гарна. Дорнод аймагт өнгөрсөн зууны эхний хагаст хийсэн судалгаагаар, Чойбалсан хот орчим нэгэн ижил талбайд хэвийн үед 1 га-д 111 бодгаль, харин хамгийн олширсон 1943 оны жилийн намар 1 га-д 1,134 бодгаль хүрсэн бол дараа жилийн намар ижил талбайд 121 бодгаль болж буурчээ. Бага болон их нягтшлын хоорондын ялгаа 37 дахин байдаг (Кучерук, 2006).

Ховордлын шалтгаан. Тооны хэлбэлзэл улирлын, мөн олон жилийн давтамжтай. Бэлчээрийг зохистой ашиглаж сэргээх нь тоо толгойн өсөлтийг хязгаарлах гол арга зам. Их хэмжээний талбайд химийн хороор устгах арга хэмжээ авсан ч үр дүнд хүрээгүй (Dawaa, 1985). Энэ зүйлийн эсрэг тэмцэх ажлыг одоо ч “байгальд халгүй” аргаар жил бүр хэсэгчлэн зохион байгуулсаар. Тоо толгойг зохицуулах үүрэгтэй үнэг, хярс зэрэг амьтдыг агнаснаас түүний тоо толгой өсөх нөхцөл бүрдэнэ. Талхагдал ихтэй бэлчээрт оготны хэт олшрол үүсдэг ч хүрээлэн буй орчиндоо хохирол учруулах нь бага, харин нүх ухаж хөрсийг сийрэгжүүлж, хөрсийг бордон, агааржуулах, хөрсний үе давхаргыг холих, чийгийн хангамжийг нэмэгдүүлэх, идэш тэжээлийн хэлхээний чухал холбоос болдог зэрэг эерэг нөлөөтэй хээрийн түлхүүр зүйл. Олшролын дараагаас тухайн нутгийн ургамал нөмрөгийн бүрхэц, бүрэлдэхүүн, ургац нэмэгдэнэ.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг. Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр үлийн цагаан оготно 3,000 төгрөг. Тархац нутгийн 6% орчим нь улсын тусгай хамгаалалттай газарт багтдаг.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн популяцийн тогтвортой байдлыг хадгалахын тулд бэлчээрийг өнжөөх, хуваарьтай ашиглах зэргээр ургамал нөмрөг доройтохоос сэргийлэх шаардлагатай. Малын тоо толгой өсөх нь бэлчээр доройтох нэг гол шалтгаан. Доройтсон бэлчээрийг сэргээх (4.2), түүний тоо толгойг хязгаарлагч махчин хөхтөн, өдрийн махчин шувуудыг хамгаалах (5.6), орон нутгийн иргэдийн дунд малынхаа тоо толгойг бэлчээрийн даацдаа тохируулж ашиглах санаачилга өрнүүлэх, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх нь нэн чухал.

4.39. ОЙН ХҮРЭН ОГОТНО

Craseomys (Myodes) rufocanus (Sundevall, 1846)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Шишүүхэй (Cricetidae)
Англи нэр: Grey Red-backed Vole
Ижил нэр: *M. akkeshii, M. arsenjevi, M. bargusinensis, M. chanbaishanensis, M. irkutensis, M. kamtschaticus* (Musser and Carleton, 2005) зэрэг олон ижил нэр бий.



Ангилал зүйн тойм. Өнгөрсөн зууны үед төрлийн нэрийг *Aschizomys, Evotomys, Clethrionomys, Myodes* зэрэг олон ялгаатай нэрлэж байв. Монгол Улсын нутаг дэвсгэрт *C. irkutensis* салбар зүйл тархдаг (Kryštufek and Shenbrot, 2022).

Таних шинж. Төрөл дотроо том биетэй зүйл. Биеийн урт 135-145 мм, сүүлний урт 50 мм, жин 55 г. Нуруу, толгойн дээд хэсэг улаан хүрэн, биеийн хоёр хажуу болон шанаа хар саарал, хэвлий цайвар саарал. Сүүл сийрэг үстэй, дээд, доод талын өнгө үл мэдэг ялгаатай (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл
Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).
Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).
2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC).

Монгол дахь тархац уудам, элбэг зүйл. Дийлэнх популяци улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдсан зэрэг үзүүлэлтийг үндэслэн анхааралд өртөхөөргүй хэмээн үнэлэв.
Үнэлгээ хийсэн: Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, Р.Самъяа, Э.Ундрахбаяр, С.Шар (2025).
Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Монгол, Орос, Хятад, Умард Солонгос болон Японд тархжээ.

Монгол орны тархац, амьдрах орчин. Хэнтий, Монгол Дагуур, Хангай, Хөвсгөл, Монгол Алтай, Говь Алтайн уулсын шилмүүст болон гөвдөг холимог ойт нутгаар (1.4) тархжээ. Монгол орны умардын болон сэрүүн бүсийн ойн экосистем, өндөр уулын сийрэг ой, давжаа хус, бургасан төгөл зэрэг экосистемд өргөн тархсан. Элдэв хэв шинжийн ой, татмын шугуй, төгөл, ширэнгэд (5.3) тохиолддог (Батсайхан нар, 2022).



Амьдралын онцлог. Бүрэнхий болон шөнө идэвхтэй. Модонд сайн авирна. Газар ухах нь бага, ихэвчлэн ойн хөвхөн дундуур шургасан жим гаргана. Хаг, хөвд, сөөглөг, бутлаг ургамлын үр, жимс, цэцэг, нахиа, найлзууруар хооллох ба өвөл модны холтос ч иднэ.

Энэ төрлийн бусад зүйлтэй харьцуулахад ургамлын ногоон хэсгээр голлон хооллодог онцлогтой. Үүрээ газарт, ихэвчлэн модны үндэс доогуур, хонгил, хөндийд засна. Үржлийн үе 5-9-р сарын хооронд үргэлжилнэ. Жилд 2-3 удаа төрөх ба төрөх бүрдээ 2-10 гөлчгий гаргана (Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Тархац нутгийнхаа хүрээнд элбэг оготно.

Ховордлын шалтгаан. Ховордлын шалтгааны талаар тодорхой мэдээ, баримт хомс.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр ойн хүрэн оготно 3,600 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 19% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Ойн ашиглалтыг оновчтой болгох (4.2), түүний боломжит амьдрах орчин бүхий ойн элдэв экосистемийг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд нэмэлтээр хамруулах нь хамгааллын зохистой арга хэмжээ (4.4) болно.

4.40. ОЙН УЛААН ОГОТНО

Clethrionomys (Myodes) rutilus (Pallas, 1779)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Шишүүхэй (Cricetidae)
Англи нэр: Northern Red-Backed Vole
Ижил нэр: *Mus rutilus* Pallas, 1779; *Myodes rutilus* (Pallas, 1779).



Ангилал зүйн тойм. Судлаачид энэ зүйлийг дахин *Clethrionomys* төрөлд хамааруулах болсон (Kryštufek *et al .,* 2020).

Таних шинж. Биеийн урт 75-110 мм, сүүл 20-35 мм, жин 35 г хүрнэ. Зоо нуруу тод улаан, хүрэн улаан. Биеийн нуруу талын өнгө хажуу, хэвлий тал руугаа аажим бүдгэрнэ. Нуруу ба хэвлийн өнгөний хооронд тод илрэх зааг ялгарахгүй. Өвлийн зүс шаргалдуу хүрэн. Сүүл богино, битүү үсээр хучигдсан, үзүүртэй жижигхэн цацагтай. Тэр нь өвөл илүү тод болно. Сүүлний дээд тал хүрэн бор, доод тал нь цайвар шаргал. Гаднаас нь харахад тод улаан шаргал, богино сүүл зэргээр ойн хүрэн оготноос ялгана (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Монгол орны ойт нутгаар өргөн тархсан, тоо

толгойн элбэг бөгөөд популяцийн тоо хэмжээ буураагүй хэмээн үзэж өмнөх үнэлгээг хэвээр үлдээв.

Үнэлгээ хийсэн: Д.Лхагвасүрэн, С.Шар, Н.Батсайхан, Э.Ундрахбаяр, Р.Самъяа (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Канад, Хятад, Финланд, Япон (Хоккайдо), Казахстан, Хойд Солонгос, Норвег, Орос, Швед, АНУ (Аляск) болон Монголд тархсан (Linzey *et al.,* 2020).

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн ойт бүс нутаг, Монгол Дагуурын ойтой нутагт тархсан. Монгол орны умард сэрүүн бүсийн ойт нутгаар түгээмэл тохиолддог. Олон хэв шинжийн ой (1.4), ялангуяа шигүү шилмүүст ой, татмын ой, төгөл, ширэнгэд амьдарна. Энэ зүйлийн дэлхийн тархцын хамгийн өмнөд зах нь Монгол болно (Дуламцэрэн, 1970; Соколов и Орлов, 1980; Батсайхан нар, 2022).



Амьдралын онцлог. Ойд амьдардаг бусад зүйлийн нэгэн адил бүрэнхий, шөнө идэвхтэй. Зуны цагт өдөр ч үзэгдэнэ. Ургамлын үр, навч, нахиа, хаг, хөвдөөр хооллоно. Өвөл хөвд, модны холтос иднэ. Газарт нүх бараг ухахгүй. Модны хонгил, хөндий болон хадан завсар хөвд, өвсөөр үүр засна. Үржлийн үе 4-9-р сарын хооронд үргэлжилнэ. Жилд 2-3 удаа төрж, нэг удаад 4-8 гөлчгий гаргана (Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Харьцангуй өргөн тархалттай, элбэг зүйл. Хэнтийн нурууны Хонин нуга судалгааны суурин орчим 2009 онд хийсэн судалгаагаар, 100 конус/хоногт 0.5 бодгаль тохиолдож байжээ (Самъяа нар, 2010).

Ховордлын шалтгаан. Байгаль (7.4) болон хүний үйл ажиллагааны нөлөөгөөр үүсэх ойн түймрээс (10.5) шалтгаалж орчны хомсдол нүүрлэх боломжтой боловч энэ зүйлийн ховордлын шалтгааны талаарх мэдээлэл хангалтгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр ойн улаан оготно 3,600 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 21% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн популяцийн тоо толгой, нягтшил (3.2), биологи, экологи (3.3) болон аюул заналын (3.5) судалгааг нарийвчлан хийх шаардлагатай.

4.41. ОЙН ХӨВХӨЛЖИН

Myopus schisticolor (Lilljeborg, 1844)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Шишүүхэй (Cricetidae)
Англи нэр: Wood Lemming
Ижил нэр: Тайгын хөвхөлжин (Дуламцэрэн, 2003); *M. middendorfi*, *M. saianicus*, *M. vinogradovi* (Wilson and Reeder, 2005).



Ангилал зүйн тойм. Ангилал зүйн өөрчлөлтгүй.

Таних шинж. Биеийн урт 130 мм, сүүл 20 мм, жин 40 г. Биеийн галбир ойн оготнотой төсөөтэй боловч зүс зэгэл хөх саарал, хөхвөр, нурууны арын хэсэгтээ бор хүрэн, улаан хүрэн “тохомтой”. Хэвлий цайвар саарал. Өвлийн зүс бүхэлдээ цайвардуу болно. Сүүл богино. Урд тавхайн дотор талын хурууны хумс хавтгай, оньтой. Хөлийн тавхай үстэй. Сүүл үсээр бүтүү хучигдсан. Сүүлний дээд тал хар саарал, доод тал цайвар саарал (Банников, 1953; Дуламцэрэн, 1970; Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Ховордож болзошгүй (NT).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Энэ зүйлийн популяцийн тоо толгойн өөрчлөлт, хандлага, учирч буй аюулын талаарх

мэдээлэл хангалтгүй байна. Ой тайга, ойт хээрийн шилмүүст ой бүхий нутгаар өргөн тархсан тул анхааралд өртөхөөргүй гэж үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Э.Ундрахбаяр, Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, С.Шар, Р.Самъяа (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Норвег, Орос, Швед, Финланд, Хятад болон Монголд тархсан (Henttonen, 2016).

Монгол орны тархац, амьдрах орчин. Хангай (Stubbe and Chotolchu, 1968), Хөвсгөлийн Мөнх Сарьдаг уул, Хэнтий нуруугаар тархана (Соколов и др., 1985; Соколов и Орлов, 1980). Сэрүүн бүсийн элдэв хэв шинжийн ой, тайгын (1.4) бутлаг ургамалтай (3.4), үетэн давамгайлсан ургамалжилттай (4.4) орчинд байршина.



Амьдралын онцлог. Шилмүүст ойд амьдарна. Шөнийн идэвхтэй ба хөвдөн давхаргад гүйдлийн жим гаргана. Үржлийн үе 4-8-р сард үргэлжлэх ба зарим өвөл үржилд орно. Хаг, хөвд, ойм хэлбэртэн, өвслөг ургамлаар хооллоно. Хад, модны хонгилд хаг, хөвдөөр үүр засна. Хээл тээх хугацаа 21 хоног. Жилд 2-4 удаа төрөх ба 3-8 гөлчгий гаргана. 18-20 сар насална (Банников, 1953; Дуламцэрэн, 1970; Батсайхан нар, 2022).

Тоо, толгой, нягтшил. Энэ зүйлийн тоо толгой, нягтшилын талаар мэдээ, баримт байхгүй.

Ховордлын шалтгаан. Ахуйн болон үйлдвэрийн зориулалтаар мод бэлтгэх (1.3.3), дэлхийн дулаарлаас (6.1.1) үүдэлтэй хуурайшилт, ой хээрийн түймэр (7.4, 10.5) зэрэг нь энэ зүйлд сөргөөр нөлөөлнө.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр ойн хөхвөлжин 4,100 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 26% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн талаар тухайлсан судалгаа бага хийгдсэн байх тул үүнтэй холбоотойгоор биологи, экологи (3.3), популяцийн тоо толгой (3.2), амьдрах орчны статус (3.4) зэргийг нарийвчлан судалж, хамгааллын арга хэмжээг боловсруулах шаардлагатай.

4.42. ХАДНЫ БАРАГЧИН

Alticola semicanus (Allen, 1924)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Шишүүхэй (Cricetidae)
Англи нэр: Mongolian Silver Vole
Ижил нэр: *Alticola argentatus* (Sev, 1879), *A.alleni* (Wilson and Reeder 2005); *alleni* Argyropulo, 1933 (Павлинов и Лисовский, 2012).



Ангилал зүйн тойм. Урьд *A. argentatus* нэрийг түгээмэл хэрэглэж байв. Морфологийн хувьд *A. barakshin* ба *A.tuvinicus* зүйлийн завсрын шинжтэй (Rossolimo and Pavlinov, 1992), харин молекул генетикийн судалгаагаар, *A.strelzowi, A. barakshin* зүйл энэ зүйлээс салсан (Павлинов и Лисовский, 2012) гэж үзжээ. Лабораторийн нөхцөлд энэ зүйл *A. barakshin, A. argentatus* зэрэг бусад зүйлтэй үржилд ороогүй (Stubbe *et al.* 1994)

Таних шинж. Биеийн урт 140 мм, сүүл 38 мм, жин 42 г. Нуруу бүхэлдээ жигд мөнгөлөг хөх саарал, хэвлий цайвар. Нуруу болон хэвлийн өнгөний зааг тод илэрнэ. Үсээр жигд хучигдсан цайвар өнгийн богино сүүлтэй. Зарим бодгалийн сүүлний дээд, доод талын өнгө ялгарна (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл
Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).
Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).
2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC).

Энэ зүйл нэлээд өргөн тархсан, популяцийн төлөв хэвийн, ховордолд хүргэх тодорхой шалтгаан үгүй тул энэ зэрэглэлээр үнэлэв.
Үнэлгээ хийсэн: Р.Самъяа, Н.Батсайхан, С.Шар, Д.Лхагвасүрэн, Э.Ундрахбаяр (2025).
Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Оросын Тагны нуруу (Павлинов и Лисовский, 2012), Хятадын Өвөр Монголын Шилийн гол аймаг, Монгол Улстай хил залгаа хээр (Smith and Yan, 2012) болон Монголд тархсан.

Монгол орны тархац, амьдрах орчин. Хангай, Хэнтийн уулс, Орхон-Сэлэнгийн сав, Дундад Халхын хээр, Монгол Дагуурын зүүн нутаг, Дорнод Монголын хээрийн зүүн урд захын хад чулуутай уул толгодоор тархана. Хадны барагчин сэрүүн бүсийн хээрийн (1.4) янз бүрийн хэв шинжид хамаарах өндөр, нам уулс, толгодын асга, байц хад, хүрмэн чулуу, хад чулуутай газар (6) шүтэн амьдарна.



Амьдралын онцлог. Хад асга, ангал завсар, чулууны доогуур үүрлэж, бүлээрээ амьдарна. Хад асгын ойролцоо идээшилнэ. Хадны ангал, завсарт тэжээлээ нөөцөлнө. Хоногийн турш идэвхтэй. Өглөө эрт, орой үдшийн цагаар илүү идэвхтэй.

Үргамлын ногоон хэсгээр голчлон хооллоно. Үржил 5-8-р сард үргэлжлэх бөгөөд үржлийн насны эм 1-3 удаа төллөнө. Ихэвчлэн 2-8 хүртэл тооны гөлчгий гаргана. Хавар эрт гарсан төл тэр жилдээ бэлэг боловсорч үржилд орно (Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Монгол дахь тархац нутгийн хэмжээ өргөн уудам бөгөөд ойролцоогоор 336,500 км^2 (Kryštufek *et al.,* 2022) - 350,000 орчим км^2 талбайг эзэлнэ (Clark *et al.,* 2006). Тоо толгой, нягтшилыг тогтоосон тодорхой судалгаа үгүй боловч тархцын аль ч хэсэгт элбэг тохиолдох зүйл.

Ховордлын шалтгаан. Хээрийн өндөр, намхан уулс, толгодын хад чулуурхаг хэсэгт амьдрах учир бэлчээрийн талхагдалд өртөгдөх магадлал бага, иймээс мал аж ахуйн үйл ажиллагааны нөлөөгөөр ховордох шалтгаан үгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр хадны барагчин 3,600 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 8% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Хамгаалах тусгай арга хэмжээ шаардлага үгүй.

4.43. СОЁН БАРАГЧИН

Alticola macrotis (Radde, 1862)

Баг: Мэрэгч (Rodentia)
Овог: Шишүүхэй (Cricetidae)
Англи нэр: Large-eared Mountain Vole
Ижил нэр: *A. altaica*, *A. fetisovi*, *A. vicina*, *A. Vinogradovi* (Wilson and Reeder, 2005); A. *Altaica* Vinogadov, 1933; A. *fetisovi* Galkina and Epifantseva, 1988; A. *vinogradovi* Rasorenova, 1933 (Павлинов и Лисовский, 2012).



Ангилал зүйн тойм. *Aschizomys* (Miller, 1899) дэд төрөлд багтаасан нь бие даасан төрөл гэж үзэх боломжтой (Lebedev *et al.*, 2010). Митохондрын генетикийн судалгааны үр дүнд үндэслэн *M. glareolus* зүйлтэй төсөөтэй (Lebedev *et al.,* 2007) гэсэн ч бөөмийн генетикийн судалгааны дүнгээр батлагдаагүй (Бодров и Абрамсон, 2011). Харин толгойн ясны морфологи, шүдний шинжээр *Fetisovi* төрөлд багтах *A. macrotis* хэмээх бие даасан зүйл юм (Васильев и др., 2008).

Таних шинж. Биеийн урт 120 мм, сүүл 32-45 мм. Биеийн жин 24-40 г. Нуруу хүрэндүү туяатай бараан сааралдуу бор. Хэвлий саарал. Нуруу ба хэвлийн өнгөний шилжилт аажим явагдана. Сүүл жигд цайвар, цагаан байж болох боловч ихэнх тохиолдолд хоёр өнгөтэй, дээд тал нь бараан, заримдаа хар, доод тал нь цайвар. Нүд том, чихний дэлбэ сайн хөгжсөн.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Популяцийн тоо толгой, нягтшилын мэдээлэл хангалтгүй тул боловч тархац нутагтаа элбэг тохиолдох зүйл тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: С.Шар, Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, Э.Ундрахбаяр, Р.Самъяа (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Орос, Монгол, Хятад, Казахстанд тархсан (Batsaikhan *et al.,* 2016; https://www.mammaldiversity.org).

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол Алтайн нурууны Мөнххайрхан уул, Хангайн нурууны Тарвагатай (Соколов и др., 1980), Хөвсгөлийн Мөнх Сарьдаг (Литвинов, 1982; Литвинов и др., 1992), Говь-Алтайн болон Хэнтийн уулст тархжээ (Батсайхан нар, 2022). Энэ зүйл нь сайн судлагдаагүй ч өндөр уулын тагийн (5.11) болон субальпын бүсийн хадархаг (6) нутгаар элбэг.



Амьдралын онцлог. Хоногийн турш идэвхтэй. Ургамлын ногоон хэсэг, үр жимсээр хооллоно. Өвөл цасан доогуур жим гарган идэвхтэй амьдарна. Хад асгад үүрээ засна. Өвөл тэжээл нөөцөлдөг эсэх нь тодорхойгүй. Үржил 5-8-р сарын хооронд явагдана. Жилд 1-3 удаа төрнө. Нэг удаад 5-7 гөлчгий гаргана.

Тоо толгой, нягтшил. Популяцийн тоо толгой, нягтшилын мэдээ, баримт хангалтгүй. Тархац нутагтаа элбэг тохиолдоно.

Ховордлын шалтгаан. Ховордлын шалтгааны талаар мэдээлэл бага боловч мал бэлчээрлэлтийн нөлөө (1.1.4), ойтой газруудын байгалийн түймэр (7.4) боломжит аюул юм.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр соён барагчин 3,800 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 32% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Тархац нутаг төдийлөн өргөн бус тул популяцийн тоо толгой, нягтшил, биологи, экологийн судалгаанд (3.1-3.4, 3.9) үндэслэж хамгаалах арга хэмжээг (4.4.3) тодорхойлох шаардлагатай.

4.44. ТАВШГАР БАРАГЧИН

Alticola strelzowi (Kastschenko, 1899)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Шишүүхэй (Cricetidae)
Англи нэр: Strelzow's Mountain Vole
Ижил нэр: *A. depressus*, *A. desertorum* (Musser and Carleton, 2005).



Ангилал зүйн тойм. Монгол Улсын нутаг дэвсгэрт *A. s. depressus* хэмээх салбар зүйл тархсан (Kryštufek and Shenbrot, 2022).

Таних шинж. Биеийн урт 130 мм, сүүл 45 мм, жин 65 г. Зоо нуруу шар, улбар шар туяа бүхий үнсэн саарлаас бараан саарал. Хэвлий саарал. Шаргал, улбар шар туяа ихэвчлэн бие гүйцсэн амьтанд илэрнэ. Сүүл сахлаг үсэн бүрхүүлтэй, үзүүртээ цацагтай, жигд цагаан, шаргал. Гавлын яс дээрээсээ дарагдаж хавтгайрсан тул хайрцаг ясны өргөн нь өндрөөсөө 2 дахин их байна (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Энэ зүйл тархац нутгийн хүрээндээ түгээмэл тохиолддог бөгөөд популяцийн элбэгшил, нягтшил болон түүний тархац нутгийн дийлэнх хэсэг нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдсан зэрэг үзүүлэлтийг харгалзан энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, Р.Самъяа, Э.Ундрахбаяр, С.Шар (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Хятад (Шинжиан), Казахстан, Орос болон Монголд тархсан.

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол Алтайн нурууны төв болон умард салбар уулсаар тархсан. Алтайн уулсын энгэр, хажуу, хавцал, бэлээр хадан цохио, асга, нурагтай газар амьдарна.



Амьдралын онцлог. Хоногийн турш идэвхтэй. Өвөл хөөе хураана. Ургамлын ногоон хэсгээр ихэнхдээ хооллоно. Идэш тэжээлд нь олон зүйлийн шарилж чухал үүрэгтэй. Хад чулууны завсар, хөндий, хонгилд үүрээ засна. Хад, чулууны завсар хоорондын зайг хааж жижиг чулуугаар хаалт барина. Газар нутгийн онцлогоос хамаарч идэш тэжээл болох ургамлын зүйлийн бүрдэл өөрчлөгддөг. Жилд 1-2 удаа төрнө. Эхний төрөлтөөр гарах гөлчгийн тоо харьцангуй олон. Дунджаар нэг удаад 5-9 гөлчгий төрүүлдэг (Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Популяцийн нягтшил дундаж үзүүлэлттэй.

Ховордлын шалтгаан. Ховордлын шалтгааны талаар мониторинг мэдээ хангалтгүй боловч малын бэлчээрлэлтийн нөлөө (1.1.4.1) боломжит шалтгаан байж болно.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр тавшгар барагчин 3,800 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 20% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйл барагчин амьдардаг тусгай хамгаалалттай газар нутгуудад мал бэлчээрлэлтээс улбаатай газрын доройтлыг хязгаарлах арга хэмжээ авах (4.2) нь чухал.

4.45. ГОВЬ-АЛТАЙН БАРАГЧИН

Alticola barakshin (Bannikov, 1947)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Шишүүхэй (Cricetidae)
Англи нэр: Gobi-Altai Mountain Vole
Ижил нэр: Ижил нэр үгүй.



Ангилал зүйн тойм. Өмнө нь энэ зүйлийг *A. stoliczkanus, A. roylei* ба *A. argentatus* зүйлд хамааруулж байсан (Krystufek and Shenbrot, 2022). Морфологийн бичиглэл (Rossolimo, 1989), хромосомын тоо (Hielscher *et al.,* 1992), аллозим (Hille and Stubbe, 1996), амин хүчлийн дарааллын судалгаануудад үндэслэн (Lebedev *et al.,* 2007; Tanga *et al.,* 2018) бие даасан зүйл хэвээр үлдээсэн.

Таних шинж. Биеийн урт 110-120 мм, сүүл 19-26 мм. Хойд тавхайн урт 17-21 мм, чихний урт 15-19 мм, жин 31-40 г. Зоо нуруу боровтор, ухаа шаргал, хэвлий саарал. Нуруу ба хэвлийн өнгөний уулзвар дагуу хоёр тийш ууссан шаргал өнгө илрэх нь элбэг. Сүүл богино, тачир үсэн бүрхүүлтэй, дээд тал нь бараандуу (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Монгол орны баруун хэсгийн Алтайн уулархаг нутагт өргөн тархсан, тоо толгойн элбэг бөгөөд популяцийн тоо хэмжээ бууралгүй хэмээн үзэж энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Д.Лхагвасүрэн, С.Шар, Н.Батсайхан, Э.Ундрахбаяр, Р.Самъяа (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Хятад, Орос болон Монголд тархсан (Batsaikhan, 2016).



Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол Алтайн нуруу, Говь Алтайн нуруу, Зүүнгарын говь, Алтайн өвөр говийн уулархаг хэсэгт тархана. Өндөр уулын хээр, цөлжүү хээртэй залгаа орших говь, цөлийн хадат уулсаар (6) тохиолдоно (Банников, 1954; Батсайхан нар, 2022).

Амьдралын онцлог. Бүрэнхий, шөнийн идэвхтэй. Бусад барагчны нэгэн адил хадны завсар орогнох боловч нүх ашигладаг онцлогтой. Өвөлд зориулж хөөе хураана.

Тоо толгой, нягтшил. Тоо толгой, нягтшилын талаар тодорхой судалгаа байхгүй.

Ховордлын шалтгаан. Ховордлын шалтгааны талаарх мэдээлэл хангалтгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Говь-Алтайн барагчин 3,800 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 31% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн популяцийн тоо толгой, нягтшил (3.2), ангилал зүй (3.1), биологи, экологи (3.3) болон аюул заналын (3.5) судалгааг нарийвчлан хийх шаардлагатай.

4.46. ТУВА БАРАГЧИН

Alticola tuvinicus (Ognev, 1950)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Шишүүхэй (Cricetidae)
Англи нэр: Tuva Silver Vole
Ижил нэр: *A. argentatus* зүйлийг хожим салгаж *A. tuvinicus* Ognev, 1950, *A. semicanus хэмээх болсон* (Wilson and Reeder, 2005).



Ангилал зүйн тойм. *Alticola argentatus*-ын салбар зүйл гэж үзэж байсан бөгөөд хожим Rossolimo and Pavlinov (1992) нар бие даасан зүйл гэж тодорхойлсон.

Таних шинж. Биеийн урт 140 мм, сүүл 65 мм. Зоо нуруу бор саарал, хэвлий цайвар. Нүд, чих том ба мэдрүүл сахал толгойн уртаас илүү. Сүүл, чих, тавхайн ул үсээр хучигдсан. Сүүлний дээд тал шаргалдуу (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Энэ зүйлийн тархалт, амьдрах орчны талаар сүүлийн үед багагүй мэдээлэл хуримтлагдсан бөгөөд тархац нутагтаа элбэг тохиолдох зүйл тул анхааралд өртөхөөргүй хэмээн үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Э.Ундрахбаяр, Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, С.Шар, Р.Самъяа (2025).
Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Орос болон Монголд тархсан (Batsaikhan, 2016).

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол Алтайн нурууны баруун умард хэсэг, Хөвсгөлийн уулс болон Хангайн нурууны хойд хэсгээр тархана (Литвинов и Базардорж, 1992). Тайгын (1.1) бүсийн хад асгархаг орчин, бутлаг (3.4), үетэн давамгайлсан ургамалжилттай (4.4), өндөр уулын тагийн нуга, уулын хээрийн хад асгатай (6) хэсэгт амьдарна (Батсайхан нар, 2022).



Амьдралын онцлог. Бүлээр амьдрах бөгөөд эзэмшил нутгийн хэмжээ газар бүр харилцан адилгүй. Идэш тэжээлээ нөөцөлнө. Өвөл цасан дор идэвхтэй. Үржил 5-р сараас эхэлнэ. Жилд 1-2 удаа төрөх ба нэг удаад 4-5 гөлчгий гаргана (Батсайхан нар, 2022).

Тоо, толгой, нягтшил. Увс аймгийн Сагил сум (2019), мөн Түргэн суманд 2021, 2022 онуудад хийсэн судалгаагаар, 100 баригч/хоногт 0.47±0.29 бодгаль ноогдож байв (Лхагвасүрэн нар, 2022).

Ховордлын шалтгаан. Ховордлын шалтгааны талаарх мэдээ, баримт хангалтгүй байгаа бөгөөд дэлхийн дулаарлаас (6.1.1) үүдэлтэй байгалийн түймэр (7.4) болон хүний нөлөөтэй түймэр (10.5) зэрэг нь энэ зүйлд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Тува барагчин 3,800 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 39% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн биологи, экологи (3.3), популяцийн тоо толгой (3.2), амьдрах орчны статус (3.4) зэрэг судалгааг гүнзгийрүүлэн хийж, үүний үр дүнд үндэслэн хамгаалах арга хэмжээг (4.4.3) боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай.

4.47. ШАР ОВ

Eolagurus luteus (Eversmann, 1840)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Шишүүхэй (Cricetidae)
Англи нэр: Yellow Steppe Lemming
Ижил нэр: Овын шар оготно; *Lagurus luteus* (Eversmann, 1840), *Georychus luteus* (Eversmann, 1840).



Ангилал зүйн тойм. Ангилал зүй өөрчлөгдөөгүй.

Таних шинж. Биеийн урт 130-165 мм, сүүл 14-23 мм, жин 60-215 г. Бусад зүйлээс биеэр том. Биеийн ерөнхий галбир жижиг зурамтай илүү төсөөтэй. Өвөрмөц төрх, амьдралын онцлогоор нь бие даасан төрөлд оруулах болсон. Нуруу элсэн сааралдуу бор шаргал. Сор үсний үзүүр хар. Нуруу дагасан хар зураасгүй. Сүүл ахар.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Популяцийн тоо толгой, нягтшилын талаарх мэдээ, баримт хомс боловч Зүүнгарын говьд элбэг тохиолдох зүйл тул анхааралд өртөхөөргүй гэж үнэлэв.

Үнэлгээ хийсэн: С.Шар, Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, Э.Ундрахбаяр, Р.Самъяа (2025).
Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Хятад, Казахстан болон Монголд тархсан (Batsaikhan *et al.,* 2016; https://www.mammaldiversity.org).

Монгол орны тархац, амьдрах орчин. Зүүнгарын говьд өргөн тархсан (Соколов и др., 1980). Дорноговийн Их Нартын чулууны байгалийн нөөц газрын хойд хэсэгт мөн тэмдэглэгдсэн (Батсайхан нар, 2022). Цөл (8.3), цөлжүү хээрийн үетэн давамгайлсан ургамалтай (4.4) орчинд амьдарна.



Амьдралын онцлог. Хоногийн турш идэвхтэй бөгөөд ургамлын газрын дээрх ургал хэсгээр хооллоно. Зуны халуунд өдөр идэвх муутай. Суурин амьдралтай ч тоо толгойн ихэссэн жилүүдэд нүүдэл хийнэ. Зун бүлээр, өвөл ихэвчлэн ганц нэгээрээ саланги амьдарна. Зуны улиралд бүлээр амьдрах суурин нүхний орчим цөөн тооны амсартай түр зуур орогнох нүх ч бий.

Тоо толгой цөөрсөн жилүүдэд маш болгоомжтой, сонор соргог болно. Үржил 5-8-р сард болно. Хээл тээх хугацаа 17-19 хоног. Жилд 2-3 удаа төрөх ба нэг удаад 4-10 гөлчгий гаргана. Төрснөөс хойш 20-25 хоногийн дараа бэлэг боловсорно (Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Популяцийн тоо толгой, нягтшилын талаарх мэдээ, баримт хангалтгүй ба тархац нутаг багатай тул нарийвчилсан судалгаанууд (3.2-3.5, 3.9) хийх шаардлагатай.

Ховордлын шалтгаан. Говийн бүсийн амьдрах орчны хуурайшил, ган гачгийн (7.1, 7.3) улмаас түүний амьдрах орчны чанар цаашид доройтож болзошгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр шар ов 3,800 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 69% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн тархац нутаг, популяцийн тоо толгой, нягтшил (3.2), биологи, экологи (3.3) болон аюул занал (3.5) зэргийн талаар нарийвчилсан судалгааг хийж хамгаалах арга хэмжээг (4.4.3) боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай.

4.48. ТӨВӨД ОВ

Eolagurus przewalskii (Buechner, 1889)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Шишүүхэй (Cricetidae)
Англи нэр: Przewalski's steppe lemming lemming
Ижил нэр: *Eremiomys przewalskii* (Buechner, 1890); *Microtus przewalskii* (G. S. Miller, 1896); *Eolagurus przewalskii* Honacki, Kinman, & Koeppl, 1982; *Lagurus przewalskii* (G. M. Allen, 1924).



Ангилал зүйн тойм. Ангилал зүй өөрчлөгдөөгүй.

Таних шинж. Биеийн урт 195-200 мм, сүүл 9-20 мм, чих 4-5 мм, жин 58-80 грамм. Биеийн хэмжээгээр шар ооос том. Нуруун тал цайвар, элсэн шаргал, хааяа ялангуяа зуны үсэн бүрхүүлд улаавтар дэвсгэр өнгө илэрнэ. Өмнөд тавхайн эхний хуруу махир том хумстай. Сүүл ахар.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC).

Монгол орны өмнөд, баруун өмнөд бүс нутгийн цөл, цөлөрхөг хээрийн өргөн уудам бүс нутагт тархсан, тоо толгой элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй.

Үнэлгээ хийсэн: Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, Э. Ундрахбаяр, С.Шар, Р.Самъяа (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Хятад болон Монголд тархсан (Smith, 2016).

Монгол орны тархац, амьдрах орчин. Цөл ба заримдаг цөлийн бүсэд д.т.д 3100 м хүртэл тохиолдоно. Ихэвчлэн уулын хөндийн хотос, хоолой, хуурай сайр, сийрэг ургамал бүхий элсэрхэг, чулуурхаг, шаварлаг хөрстэй орчныг шүтэж амьдарна. Жинхэнэ цөл, хээржүү цөлийн (8.2) орчинд амьдарна.



Амьдралын онцлог. Шөнийн идэвхтэй, зундаа бүрэнхийд идэвхтэй. Ихэвчлэн ургамлын ногоон хэсгээр, заримдаа үрээр хооллоно. Ургамлын хатааж, нөөцөлнө. Бүлээр амьдарна. Үржил 3-9 сарын хооронд явагдана. Хээл тээх хугацаа 17-19 хоног. Жилд 2-3 удаа төрөх ба нэг удаад 3-11 гөлчгий гаргана (Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Популяцийн тоо толгой, нягтшилын мэдээ хангалтгүй, тархац нутаг багатай тул судалгаа (3.2-3.5, 3.9) шаардлагатай.

Ховордлын шалтгаан. Говь, цөлийн бүсэд уул уурхай (1.3.1), ган (7.1), харын зудтай өвөл зэрэг байгалийн хатуу нөхцөл (7.3) нөлөөлж болзошгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр төвөд ов 3,800 төгрөг. Энэ зүйлийн Монгол дахь тархац нутгийн 21% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Популяцийн тоо толгой, нягтшилын судалгаанд (3.2-3.5, 3.9) үндэслэж хамгаалах арга хэмжээг (4.4.3) тодорхойлох шаардлагатай.

4.49. СОХДОЙ ОГОТНО

Ellobius tancrei (Blasius, 1884)

Баг: Мэрэгчид (*Rodentia*)
Овог: Шишүүхэй (*Cricetidae*)
Англи нэр: Zaisan Mole Vole
Ижил нэр: Зээрд соxдой (Дуламцэрэн, 2003); Eastern Mole Vole; *E. kastschenkoi*, *E. ognevi*, *E. ursulus* (Wilson and Reeder, 2005).



Ангилал зүйн тойм. Филогенетикийн судалгааны үр дүн Монголд тархсан энэ зүйлийг дотор нь *Ellobius tancrei stricto* болон *Ellobius* (*talpinus*) *orientalis* хэмээх хоёр салбар зүйл болгон ангилсан (Lebedev *et al.,* 2020).

Таних шинж. Биеийн урт 80-125 мм, сүүл 9-15 мм, жин 38-60 г. Мөч сүүл бахим, богино. Өмнөд мөч урт хумстай (Дуламцэрэн, 1970). Нүд жижиг, чихний дэлбэгүй. Өтгөн жигд үсэн бүрхүүлтэй. Нуруун бор шаргал, хэвлий цайвар. Үүдэн шүд дорсгор уруулаас илүү гарна. Амьдарч буй өндөршлөөс хамаарч биеийн хэмжээ, жин өөрчлөгдөнө (Банников, 1953; Соколов и Орлов, 1980; Батсайхан нар, 2022). Энэ зүйлийн амьдарч буй газрыг намхан овоолго шороогоор нь амархан мэдэж болно.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Тархац нутаг уудам, популяцийн төлөв байдал тогтвортой, ховордуулах онцгой шалтгаан үгүй гэж үзээд өмнөх үнэлгээг хэвээр үлдээв.

Үнэлгээ хийсэн: Э.Ундрахбаяр, Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, С.Шар, Р.Самъяа (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Казахстан, Туркменистан, Узбекистан, Хятад, Монголд тархсан (Batsaikhan and Thinnin, 2016)

Монгол орны тархац, амьдрах орчин. Их нуруудын хөндий, Нууруудын хөндий, Монгол Алтай нуруу, Умард говь, Төв Халхын хээр, Дорнод говийн цөлөрхөг болон цөлийн бүсэд тархана (Соколов и Орлов, 1980). Монгол орны баруун умард, төв болон өмнөд хэсгийн хуурай хээр, заримдаг цөл, цөлийн (8.3) бутлаг, сөөглөг ургамал бүхий нам уулс, тэдгээрийн хөндий, тал газрын хуурай, дагжуур хөрстэй газарт амьдарна.



Амьдралын онцлог. Газар доогуур ярган амьдрахад зохицсон оготно. Богино нягт, зөөлөн үсэн бүрхүүлтэй. Ил гарч ирэх нь ховор, харанхуйд гарна. Газрын доорх үүр, хонгилдоо хоногийн турш идэвхтэй. Ургамлын үндсээр голлон хооллоно. Бүлээр амьдарна. Нэг суурьшилд ихэвчлэн хоёр бие гүйцсэн амьтан байх учир моногами гэж үзнэ. Хээл тээх хугацаа 3 долоо хоног. Жилд 2-3 удаа төрнө. Нэг удаад 2-8 гөлчгий гаргана (Батсайхан нар, 2022).

Тоо, толгой, нягтшил. Тоо толгой, нягтшилын талаар мэдээ, баримт байхгүй.

Ховордлын шалтгаан. Уул уурхай олборлолттой (1.3.1) холбоотойгоор амьдрах орчин доройтох, түүнийг дагасан хөрсний бохирдол (6.2.6), боловсруулах үйлдвэрлэл (1.4.1) болон газрын тээвэр (1.4.4), дэд бүтцийн хөгжил зэргээс гадна, дэлхийн дулаарлаас (6.1.1) үүдэлтэй ган (7.1), байгалийн бусад хүчин зүйлс энэ зүйлд сөргөөр нөлөөлж болзошгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр сохдой оготно 3,600 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 14% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн популяцийн тоо толгой, нягтшил (3.2), биологи, экологи (3.3) болон аюул заналын (3.5) талаар нарийвчилсан судалгааг хийж хамгаалах арга хэмжээг (4.4.3) боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай.

4.50. ЦОМЧ ШИШҮҮХЭЙ

Allocricetulus curtatus (Allen, 1925)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Шишүүхэй (Cricetidae)
Англи нэр: Mongolian Hamster
Ижил нэр: *beljaevi* Argyropulo, 1932; *microdon* Ognev, 1925.



Ангилал зүйн тойм. Энэ төрөл дотроо 2 зүйлтэй. Манай орны баруун, баруун өмнөд нутгаар *A. eversmanni* Brandt, 1859 зүйл байх боломжтой. А.Г.Банников (1954) цомч шишүүхэйг *A. eversmanni* зүйлийн салбар зүйл гэж үзсэн. А.В.Гуреева (2015) нарын эрлийзжүүлэлтийн туршилт судалгаагаар, аллопатрик тархалт, хромосомын тоогоор ялгаатай ч энэ хоёр зүйл хоорондоо үрждэг нь зүйлийн тусгаарлалт үүсээд удаагүй болохыг илтгэнэ.

Таних шинж. Биеийн урт 150 мм, сүүл 21 мм, жин 95 г. Биеийн галбираар саарал шишүүхэйн бусад зүйлтэй төсөөтэй боловч биеэр том. Нүд том, бүлтгэр (Павлинов и др., 2002; Батсайхан нар 2022). Зоо нуруу бор саарал, хэвлий цайвар. Сүүл угаараа бүдүүн, богино. Сүүлний уг орчмын урт сор үснүүд сүүлний уртын хагаст хүрнэ. Завжны уутандаа хоолоо зөөнө.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Энэ зүйлийн тархац нутаг уудам, популяцийн төлөв байдал хэвийн, ховордуулах тодорхой шалтгаангүй хэмээн үзэж өмнөх үнэлгээг хэвээр үлдээв.

Үнэлгээ хийсэн: Р.Самъяа, Н.Батсайхан, С.Шар, Д.Лхагвасүрэн, Э.Ундрахбаяр (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Хятадын хойд хэсэг (Шинжань, Ганьсу муж, Өвөр Монгол) (Smith and Yan, 2013), Оросын Тувагийн өмнөд хэсэг буюу Увс нуурын хотгорын хойд зах (Павлинов и др., 2002) болон Монголд тархсан.

Монгол орны тархац, амьдрах орчин. Алтайн нурууны хойд хэсэг, Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, Умард говь, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, зүүн хойш хээрийн бүсэд нэвтрэн Хэрлэн голын өмнөд зах хүртэл тархана (Банников, 1954; Батсайхан нар 2002). Цөлөрхөг хээрийн (8.3) гол төлөөлөгч (Банников, 1954) гэж үздэг. Хуурай хээрийн хээржүү цөл, цөлжүү хээрийн хатуу дагжуур хөрстэй чулуурхаг, бударгана, бударгана-үетэнт уулын бэл, элсэрхэг хотгор, хөндий даган байршина.



Амьдралын онцлог. Гүн биш, олон салаатай нүхэнд орогноно. Шөнийн идэвхтэй. Өвөл урт хугацаагаар ичихгүй ч үе үе богино хугацаанд физиологийн үйл ажиллагааны эрчим буурч, тайван байдалд орох байдлаар *A. eversmanni* зүйлээс ялгагдана. Өвөл, намрын улиралд жин буурах хандлага ажиглагдаагүй (Feoktistova *et al.,* 2012). Өвлийн тэжээлээ нүхэндээ нөөцөлнө. Ургамлын үр, шавжаар голчлон хооллоно. Жилд 2-3 удаа төллөнө. Төлөрхөг чанар өндөр. А.Г.Банников нэг удаад 14 тооны хөврөл илрүүлж байжээ. Түүнчлэн айлын гэр, сууцанд нэвтэрч хүнсний зүйлийг бусниулах, будааг нөөцлөх тохиолдол илэрнэ (Банников, 1954).

Тоо толгой, нягтшил. Тархац нутгийн нийт талбай 766,000км^2 (Kryštufek and Shenbrot, 2025). Оюу Толгой орчмын хяналтын талбайд 100 амьд баригч/хоногт 1.1±0.4 бодгаль тохиолдох нягтшилтай (Shar *et al.,* 2020) байжээ.

Ховордлын гол шалтгаан. Малын тоо толгой өссөнөөс нөөцийн төлөөх өрсөлдөөн болон орчны доройтол бий болж, мөн булаг шандын ширгэлт, ган зэрэг нь энэ зүйлд нүүрлэж буй аюул занал болж байна.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр цомч шишүүхэй 3,900 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 15% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийг хамгаалах тусгайлсан арга хэмжээ шаардлагатай.

4.51. ХӨХ ШИШҮҮХЭЙ

Cricetulus barabensis (Pallas, 1773)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Шишүүхэй (Cricetidae)
Англи нэр: Striped Dwarf Hamster
Ижил нэр: *C. manchuricus*, *C. mongolicus*, *C. Obscurus. Mus barabensis* (Pallas, 1773); *C. furunculus* Pallas, 1779; *C. ferrugineus* Argyropulo, 1941; *C. pseudogriseus* Iskhakova, 1974; *C. xinganensis* Wang, 1980; *C. tuvinicus* Lebedev, Lissovsky and Iskhakova, 2008 (Павлинов и Лисовский, 2012).



Ангилал зүйн тойм. Хромосомын судалгааны үр дүнд үндэслэн *C. pseudogriseus* Iskhakova, 1974 хэмээх зүйлээс ялгаж, бие даасан зүйл болгожээ (Громов, Баранова, 1981; Павлинов и Россолимо, 1987; Лисовский, 2019).

Таних шинж. Биеийн урт 85-124 мм, сүүлний урт 20-33 мм, хойд тавхайн урт 14-17 мм, чихний урт 13.5-18 мм. Биеийн жин 40-60 г. Биеийн галбир төрхөөрөө бусад шишүүхэйтэй төсөөтэй ч биеэр жижиг, сүүл богиновтор. Биеийн нуруун тал тод цайвар-хүрэн, шаргал туяатай. Нуруу дагуу бараан судалтай байдгаараа бусад зүйлээс ялгарна. Чихний ирмэг цагаан эмжээртэй, сүүлний дээд тал бараан, доод тал цайвар. Тавхайн уланд сийрэг үстэй.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Тархац нутаг өргөн, тоо толгойн элбэг зүйл тул анхааралд өртөхөөргүй гэж үнэлэв.

Үнэлгээ хийсэн: С.Шар, Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, Э.Ундрахбаяр, Р.Самъяа (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Хятад, Ардчилсан Солонгос, Өмнөд Солонгос, Орос болон Монголд тархжээ (Batsaikhan *et al.,* 2016; https://www.mammaldiversity.org).



Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол Алтайн нурууны умард нутаг, Увс нуурын хотгор, Хангай, Хөвсгөл, Хэнтий, Монгол Дагуур, Дорнод Монгол, Дундад халх, Хянганы салбар уулсаар тархсан. Тархац нутгийн талбай 40,000 км^2 орчим (Clark *et al.,* 2006). Хээрийн элдэв хэв шинжийн экосистем (4.4), цөлжүү хээрт тохиолдоно.

Амьдралын онцлог. Шөнө идэвхтэй. Олон амсартай гүн биш нүхэнд орогноно. Өвөл ичээлэхгүй бөгөөд хөөе хураана. Зүйл бүрийн өвслөг ургамлын үр, навч, шавж иднэ. Жилд 2-3 удаа төрнө. Нэг удаад 6-8 гөлчгий төрүүлнэ.

Тоо толгой, нягтшил. Тархац нутаг өргөн, тоо толгойн элбэг зүйл.

Ховордлын шалтгаан. Байгалийн (7.4) болон хүний нөлөөтэй үүссэн түймрээс (1.7) амьдрах орчны хомсдолд орж болзошгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр хөх шишүүхэй 3,900 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 12% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Монгол орны хээрт өргөн тархацтай, тоо толгойн хувьд элбэг зүйл тул одоогоор хамгааллын арга хэмжээ шаардлагагүй.

4.52. УРТ СҮҮЛТ ШИШҮҮХЭЙ

Cricetulus longicaudatus (Milne-Edwards, 1871)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Шишүүхэй (Cricetidae)
Англи нэр: Long-tailed Dwarf Hamster
Ижил нэр: *C. andersoni*, *C. chiumalaiensis*, *C. dichrootis. C. griseiventris, C. kozhantschikovi, C. nigrescens* (Musser and Carleton, 2005).



Ангилал зүйн тойм. Монголд *Cricetulus l. griseiventris* хэмээх салбар зүйл тохиолддог (Kryštufek and Shenbrot, 2025).

Таних шинж. Биеийн галбир төрхөөрөө бусад шишүүхэйтэй төсөөтэй ч сүүл илэрхий урт. Биеийн урт 90-116 мм, сүүлний урт 33-46 мм, хойд тавхайн урт 14-16 мм, чихний урт 15-19 мм. Биеийн жин 40-60 г. Нуруу нь саарлаас хар сааралд хувирна. Нуруу дагаж бүдэг, үл мэдэх бараан судал ажиглагддаг. Чихний ирмэгээр цагаан эмжээртэй, сүүлний дээд тал бараан, доод тал цайвар зэрэг шинжээрээ бусад шишүүхэйнээс ялгагдана (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Тархац нутаг уудам, хааяагүй элбэг зүйл тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Н. Батсайхан, Д.Лхагвасүрэн, Р.Самъяа, Э.Ундрахбаяр, С.Шар (2025).
Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Хятад, Ардчилсан Солонгос, Өмнөд Солонгос, Орос болон Монголд тархсан.

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол Алтай, Говь Алтай, Их Нууруудын хотгор, Нууруудын хөндий, Хангай, Хэнтий, Монгол Дагуур, Дундад Халх, Умард говийн бүс нутагт тархсан. Уулархаг нутгийн хад чулуутай орой, хажуу, жалга болон хээр, цөлжүү хээрийн экосистемд бэсрэг уулсаар байршина.



Амьдралын онцлог. Бүрэнхий, шөнө идэвхтэй. Олон амсартай гүн биш нүхэнд орогнох бөгөөд нүхээ голдуу хад чулуун доогуур ухна.

Өвөл ичээлэхгүй бөгөөд хөөе хураана. Элдэв зүйлийн өвслөг ургамлын үр, навч, шавжаар идээшилнэ. Жилд 2-3 удаа төрөх ба төрөх бүрдээ 4-9 гөлчгий төрүүлнэ. Байгалийн нөхцөлд 2 жил хүртэл амьдарна (Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Тархац нутаг уудам, элбэг зүйл.

Ховордлын шалтгаан. Малын бэлчээрлэлтээс улбаатай газрын доройтол (1.1.4.1) амьдрах орчны хомсдолд хүргэж болзошгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр урт сүүлт шишүүхэй 3,900 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 15% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн тархац нутгийн дийлэнх хэсэгт олон тооны мал жилийн бүх улиралд бэлчээрлэж, газрын доройтол нүүрлэж байгаа тул бэлчээр ашиглалтыг зохистой болгох (4.2) шаардлагатай.

4.53. БОР ШИШҮҮХЭЙ

Nothocricetulus (Cricetulus) migratorius (Pallas, 1773)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Шишүүхэй (Cricetidae)
Англи нэр: Grey Hamster or Grey Dwarf Hamster
Ижил нэр: Бордуу шишүүхэй, *Cricetulus migratorius* (Pallas, 1773), *Mus migratorius* (Pallas, 1773).



Ангилал зүйн тойм. Сүүлийн үеийн молекул филогенезийн судалгаагаар *Cricetulus* төрлийн зарим зүйлийг *Nothocrecitulus* төрөлд хамааруулах болсон (Lebedev *et al.,* 2018).

Таних шинж. Биеийн урт 96-130 мм, сүүлний урт 20-35 мм, хойд тавхайн урт 14-18 мм, чихний урт 16-21 мм. Биеийн жин 60 г хүрнэ. Биеийн галбир төрхөөрөө бусад шишүүхэйтэй төсөөтэй. Сүүлний дээд болон доод талууд ижилхэн цайвар, биеийн нуруун тал үнсэн саарал, чих жигд нэг өнгөтэй зэрэг гадна шинжээрээ бусад шишүүхэйнээс ялгагдана (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Тархац нутаг уудам, тоо толгойн элбэг бөгөөд популяцийн тоо хэмжээн буураагүй хэмээн үзэж энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Д.Лхагвасүрэн, С.Шар, Н.Батсайхан, Э.Ундрахбаяр, Р.Самъяа (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Афганистан, Азербайжан, Болгар, Хятад, Грек, Энэтхэг, Иран, Исламын Бүгд Найрамдах Улс, Ирак, Израил, Иордан, Казахстан, Ливан, Молдова, Пакистан, Румын, Орос, Сири, Турк, Украин болон Монголд тархсан (Kryštufek *et al.,* 2016).

Монгол орны тархац, амьдрах орчин. Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алашань говь, Дорнод говьд тархжээ. Цөлийн баянбүрд, хайлааст сайр, сөөглөг ургамалтай говь цөлийн нам уулс (8.3), тэдгээрийн хөндий орчмын нутагт байршина (Батсайхан нар, 2022).



Амьдралын онцлог. Шөнийн идэвхтэй. Хоёр амсартай гүн биш нүхэнд орогноно. Өвөл ичээлэхгүй бөгөөд их хэмжээний хөөе хураана. Элдэв зүйлийн өвслөг ургамлын үр, шавж иднэ. Жилд 2-3 удаа төллөх бөгөөд төрөх бүрдээ 3-10 гөлчгий төрүүлнэ. Байгалийн нөхцөлд 2 жил хүртэл амьдардаг (Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Тоо толгой, нягтшилын судалгаа байхгүй.

Ховордлын шалтгаан. Энэ зүйлийн ховордлын шалтгааны талаарх мэдээ, баримтгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр бор шишүүхэй 4,500 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 39% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн популяцийн тоо толгой, нягтшил (3.2), ангилал зүй (3.1), биологи, экологи (3.3) болон аюул заналын (3.5) судалгааг нарийвчлан хийх шаардлагатай.

4.54. ОРОГ ЗУСАГ

Phodopus campbelli (Thomas, 1905)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Шишүүхэй (Cricetidae)
Англи нэр: Campbell's Hamster
Ижил нэр: *beljaevi* Argyropulo, 1932; *microdon* Ognev, 1925; *P. crepidatus* Hollister, 1912; *P. tuvinicus, Cricetulus campbelli* (Thomas, 1905); *Phodopus sungorus campbelli* (Thomas, 1905); *Cricetiscus campbelli* (Thomas, 1905).



Ангилал зүйн тойм. Энэ зүйлийг *Phodopus sungorus* зүйлийн салбар зүйл хэмээн үзэж байгаад филогеографын судалгаа болон эрлийзжүүлэлтийн шинжилгээгээр, тус зүйлийн бие даасан байдлыг баталгаажуулжээ (Феоктистова 2008). Энэ хоёр зүйлийн тархалт аллопатрик бөгөөд тархалтын зах Алтайн нуруугаар зааглагдана. Сүүлийн үед энэ зүйлийн төрлийг *Cricetiscus* (Kryštufek, Shenbrot, 2025) гэж бичих болсон ч энэ удаад хуучин уламжлалт төрлөөр нь үлдээв.

Таних шинж. Биеийн ерөнхий галбир шишүүхэйн бусад зүйлтэй төсөөтэй. Биеийн урт 89 ± 1.2 мм, сүүл 11.1 ± 0.3 мм, жин 27.6 ± 0.8 г хүрэх бол зүүн бүлгийнх арай бага, дээрх дараалаар 86.2 ± 1.1 мм, сүүл 7.5 ± 0.1 мм, жин 23.2 ± 0.9 г (Феоктистова, 2008). Сүүл богино, хойд тавхай үсээр бүрхэгдсэн байдаг нь *Phodopus* төрлийн гол шинж. Баруун бүлэгт хамаарах орог зусгийн зоо нурууны бор саарал дэвсгэр өнгөний дээгүүр нуруу дагасан бараан судалтай. Өвлийн зүс илүү цайвар. Завжны уутны ард болон хэвлийдээ үнэрийн булчирхайтай.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Энэ зүйлийн тархац нутаг уудам, популяци том, хаана ч тоо толгойн тогтвортой. Хорогдох тодорхой шалтгаангүй учир хуучин үнэлгээг хэвээр үлдээв.

Үнэлгээ хийсэн: Р.Самъяа, Н.Батсайхан, С.Шар, Д.Лхагвасүрэн, Э.Ундрахбаяр (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Хятадын хойд хэсэг, Оросын Тува, Хакасс, Алтайн хязгаар, Монголд тархсан (Феоктистова, 2008).

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол орны төв, зүүн, өмнө зүгийн жинхэнэ хээр, хуурай хээр, цөлжүү хээрээр түгээмэл тархана. Баруун Монголд Увс нуурын хотгорт бүртгэжээ (Феоктистова, 2008; Батсайхан нар, 2022). Монгол Алтайн нурууны Даян нуур орчим тэмдэглэгдсэн (Р.Самъяа, С.Шар нарын аман мэдээ). Сэрүүн бүсийн жинхэнэ хээр, хуурай хээр, цөлжүү хээрээр (4.4) түгээмэл тархана. Хээрийн бүсэд янз бүрийн орчин шүтэн амьдарна. Уулархаг нутагт д.т.д. 3,500 м хүртэл өндөрт тохиолдоно (Швецов и др., 1980). Айлын гэр, сууц, ногооны талбайд элбэг тохиолдоно (Банников, 1954; бидний ажиглалт).



Амьдралын онцлог. Энгийн бүтэцтэй, олон амсартай нүхэнд үүрлэнэ. Нүхний амсар эгц доошоо чиглэх бөгөөд 20-30 см гүнд нэг ерөнхий хонгилд нэгдэнэ. Шөнийн идэвхтэй. Холимог идэштэн. Идэш тэжээлд ургамлын үр зонхилох ч шавж, ургамлын вегетатив хэсэг багагүй хувийг эзэлнэ. Идэш тэжээлээ нөөцөлнө. Хээл тээх хугацаа 18 хоног. Төрсөн дор ороо орно. Үр тогтсон өндгөн эс 2-5 хоногийн дараа савны хананд бэхлэгдэнэ. Жилд 3-4 удаа төллөх ба төрөх бүрдээ 6-8 зулзага төрүүлнэ. Хавар эрт төллөсөн залуу бодгалиуд эрт бэлэг боловсорно (Феоктистова, 2008).

Тоо толгой, нягтшил. Тархац өргөн ба тоо толгой тогтвортой. Тувагийн өмнөд хэсэг Эрзиний районд Тере кол нуурын орчим 1986-1987 онуудад хийсэн зориудын тооллогоор 1 га-д 1 бодгаль нягтшил илрүүлжээ (Суров и др., 1990). Өгий нуур орчимд 2004 онд 210 амьд баригч/шөнө-д 14 бодгаль баригдаж байсан бол 2006 онд энэ орчим 60 амьд баригч/шөнө 6 бодгаль баригдаж байжээ. Харин Баян-Өнжүүл орчим 315 баригч/шөнө-д 3 бодгаль (Феоктистова, 2008), Оюу Толгойн уурхай орчмын хяналтын талбайд 100 амьд баригч/хоногт 2.7 ± 0.6 бодгаль байв (Shar *et al.,* 2020).

Ховордлын шалтгаан. Малын тоо толгой өссөнөөс нөөцийн төлөөх өрсөлдөөн, орчны доройтол бий болж байгаа бөгөөд мөн үе үе тохиолдох ган энэ зүйлийн амьдралд сөрөг нөлөө үзүүлэх ч тоо толгойн буурах шалтгаан болохгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр орог зусаг 3,900 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 14% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Хамгаалах зорилгоор тусгай арга хэмжээ авах шаардлагагүй. Доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх (4.2), ашиглалтыг зохистой болгох нь орог зусгийн амьдрах орчныг хамгаалахад эерэг нөлөө үзүүлнэ.

4.55. ЭЛСНИЙ ЗУСАГ

Phodopus roborovskii (Satunin, 1903)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Шишүүхэй (Cricetidae)
Англи нэр: Desert Hamster or Roborovski's Hamster
Ижил нэр: *P. bedfordiae*, *P. praedilectus*, *P. Przewalskii* (Wilson and Reeder,2005). *Cricetulus rodorovskii* (Satunin, 1903), *P. cricetiscus* Thomas, 1917 (Павлинов и Лисовский, 2012).



Ангилал зүйн тойм. Төрлийн нэр *Cricetulus* байснаа *Phodopus* болж өөрчлөгдсөн.

Таних шинж. Биеийн урт 75-92 мм, сүүлний урт 8-12 мм, хойд тавхайн урт 10-12 мм, чихний урт 14-15 мм. Биеийн жин 14-20 г. Биеийн галбираараа бусад шишүүхэйтэй төсөөтэй. Нуруу нилдээ шаргал саарал, биеийн хажуу болон хэвлий тод цагаан, нурууг дагасан нарийн хар судалгүй зэрэг шинжээр орог зусгаас ялгана.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Монгол орны говь, цөлийн бүсээр уудам нутагт тархсан, тоо толгойн элбэг зүйл тул анхааралд өртөхөөргүй гэж үнэлэв.

Үнэлгээ хийсэн: С.Шар, Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, Э.Ундрахбаяр, Р.Самъяа (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Хятад, Казахстан, Орос болон Монголд тархсан (Cassola, 2016; https://www.mammaldiversity.org).

Монгол орны тархац, амьдрах орчин. Их нуурын хотгор, Нууруудын хөндий, умард говь, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алашаа, Дорнод говьд түгээмэл тархана. Умард говийн цөлийн хээрээс урагшлан цөлийн бүсийн өмнөд хэсэгт хүрнэ (Маллон, 1985). Элсэрхэг хөрстэй, загт хотгор, цөлжүү (8.2) хээрт байршимтгай, элссэг амьтан.



Амьдралын онцлог. Шөнийн идэвхтэй. Нүх нь гүехэн, амсар нь тэдийлэн мэдэгдэхгүй. Өвөлд урт хугацааны ичээнд орохгүй. Элдэв зүйлийн өвслөг, сөөглөг ургамлын үр, шавж иднэ. Жилд 3-4 удаа төллөх бөгөөд төллөх бүрдээ 3-9 гөлчгий төрүүлнэ. Хээл тээх хугацаа 21 хоног. Байгалийн нөхцөлд 2 жил хүртэл насалдаг.

Тоо толгой, нягтшил. Тоо толгой, нягтшил ихтэй элбэг тохиолдох зүйл. Өмнөговийн Цогтцэций сумын нутагт 2017 онд хийсэн хээрийн судалгааны явцад 100 амьд баригч/хоногт 19.5±1.6 бодгаль баригдсан элбэгшилтэй байв (Shar *et al.,* 2020).

Ховордлын шалтгаан. Малын тоо толгой өсөж байгаагаас шалтгаалан түүний амьдрах орчин доройтож (1.1.4.1) болзошгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр элсний зусаг 3,900 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 26% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Монгол орны говь, цөл, цөлжүү хээрт өргөн тархацтай, тоо толгойн хувьд элбэг зүйл тул хамгаалах зорилгоор тусгай арга хэмжээ авах шаардлагагүй. Харин доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх (4.2), бэлчээрийн менежментийг сайжруулах нь зохистой.

4.56. МОНГОЛ ЧИЧҮҮЛ

Meriones unguiculatus (Milne-Edwards, 1867)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Хулгана (Muridae)
Англи нэр: Mongolian Gerbil
Ижил нэр: *M. chihfengensis, M. koslovi, M. selenginus*; Mongolian Jird (Musser and Carleton, 2005).



Ангилал зүйн тойм. Зарим судлаачид салбар төрөл *Pallasiomys* хэмээн тэмдэглэсэн нь бий (Musser and Carleton, 2005).

Таних шинж. Биеийн урт 130 мм, сүүл 100 мм, жин 60-73 г. Нуруу элсэн шаргал, саарлаас шаргалдуу бор, хүрэн бор. Хэвлий саарал. Хэвлийн үсний уг хар бараан. Хумс нь бараан. Сүүлний дээд тал богино хар бараан үстэй, төгсгөлдөө хар эсвэл хар бор өнгийн цацагтай (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Энэ зүйл чичүүл Монгол орны хуурай хээр, цөлжүү хээр, уулын хээр, нугажуу хээр, хээржүү цөлийн экосистемийн уудам нутагт тархацтай, элбэг зүйл тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, Р.Самъяа, Э.Ундрахбаяр, С.Шар (2025).
Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Монгол, Орос, Хятадад тархсан.

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол Алтайн нурууны зүүн хойд зах, Их Нууруудын хотгор, Нууруудын хөндий, Дундад Халхын хээр, Дорнод говь, Дорнод Монгол, Хангайн нурууны зүүн захаар тархана. Хээрийн бүх хэв шинжийн экосистемд (4.4) тархах ба гол мөрний хөндий дагаж, ойтой залгаа хээрийн экосистем рүү нэвтэрдэг. Үет ургамал, харгана, бударгана бүхий элсэрхэг хөрстэй хуурай хээр, цөлжүү хээрийн экосистемд элбэг. Хот суурин газрын ойролцоо ч тохиолдоно (Батсайхан нар, 2022).



Амьдралын онцлог. Хоногийн турш идэвхтэй. Бүлээр амьдардаг, социаль зан төрхтэй. Нийлмэл бүтэцтэй нүхэнд амьдрах ба гүн нь 150 см хүрнэ. Үлийн цагаан оготнын хуучин нүхийг ашиглах нь бий. Ургамлын янз бүрийн хэсгээр хооллох ч зуны улиралд ургамлын ногоон хэсэг, өвөл, хавар үрийг иднэ. Идэш тэжээлээ нөөцөлнө. Өвөл ичээлэхгүй. Хээлээ тээх хугацаа 25-30 хоног. Жилд 1-2 удаа төллөх ба төрөх бүрдээ 3-8 гөлчгий гаргана. Байгалийн нөхцөлд 1-2 жил хүртэл насална (Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Энэ зүйлийн тоо толгой хэлбэлзэл ихтэй. Зарим жил олширч, уудам газар нягтшил ихтэй тархана.

Ховордлын шалтгаан. Уур амьсгалын өөрчлөлтөөс улбаатай жил дараалсан ган (7.1), малын бэлчээрлэлтээс улбаатай газрын доройтол (1.1.4.1) нөлөөлж болзошгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Монгол чичүүл 3,600 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 12% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Тархац нутгийн хүрээг тэлэх боломжтой амьдрах орчныг хамруулж, улсын тусгай хамгаалалтай газар нутгийн сүлжээг өргөтгөх (4.4.4), бэлчээрийн менежментийг сайжруулах (4.2) нь хамгааллын арга хэмжээ болно.

4.57. ШАР ЧИЧҮҮЛ

Meriones meridianus (Pallas, 1773)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Хулгана (Muridae)
Англи нэр: Midday Gerbil
Ижил нэр: *Mus meridianus* (Pallas, 1773), *M. psammophilus* (Milne-Edwards, 1868–1874), *M. meridianus* (Pallas, 1773), *M. penicilliger* (Heptner, 1933)



Ангилал зүйн тойм. Молекул биологи болон толгойн ясны хэмжилтийн судалгаагаар *M. meridianus* зүйлийг *M. psammophilus (*Milne-Edwards, 1868–1874), *M. meridianus* (Pallas, 1773) болон *M. penicilliger* (Heptner, 1933) хэмээх гурван бие даасан зүйл болгон салгасан (Nonova *et al.,* 2020). Энэхүү үнэлгээ нь *M. meridianus* хэмээх хуучнаар нэг зүйлийг үнэлсэн үнэлгээ буюу дээрх гурван шинэ бие даасан зүйлүүдийг бүгдийг хамруулсан үнэлгээ болно.

Таних шинж. Биеийн урт 120 мм, сүүл 110 мм. Бие гүйцсэн бодгалийн жин 60 г хүрнэ. Төрөл дотроо биеэр бага. Нуруу шаргалдуу бор хүрэн, хааяа саарал дэвсгэртэй элсэн шаргал, хэвлий цагаан. Хэвлийн үс нь угаараа цайвар. Хумс цайвар, шаргал. Сүүл их биеийн нурууны хэсэгтэй адил өнгөтэй бөгөөд нэгэн жигд. Сүүлний төгсгөлд цацаг үс муу илэрнэ. Хойд тавхай уландаа үстэй. Сонсголын хэнгэрэг яс сайн хөгжсөн.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Монгол орны Дундад халхын хээрээс говь хүртэл өргөн тархсан, тоо толгойн элбэг бөгөөд популяцийн тоо хэмжээн буураагүй тул өмнөх үнэлгээг хэвээр үлдээв.

Үнэлгээ хийсэн: Д.Лхагвасүрэн, С.Шар, Н.Батсайхан, Э.Ундрахбаяр, Р.Самъяа (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Афганистан, Хятад, Иран, Исламын Бүгд Найрамдах Улс, Казахстан, Киргизстан, Орос, Тажикстан, Туркменистан, Узбекистан болон Монголд тархсан (Батсайхан нар, 2022).

Монгол орны тархац, амьдрах орчин. Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, Говь Алтай, Дорнод говь, Алтайн Өвөр говь, Зүүнгарын говь, Дундад Халхын хээрийн өмнөд сэжүүрээр тархсан. Хуурай хээр, цөлжүү хээр, хээржүү цөл, хэт гандуу цөлийн (8.3) элсэрхэг хөрстэй аараг толгод, хотгор, цайдам, баянбүрд, хөндий, тэгш газар бараадна (Дуламцэрэн, 1989; Батсайхан нар, 2022).



Амьдралын онцлог. Хүйтний улиралд хоногийн турш идэвхтэй. Харин дулааны улиралд өглөө эрт, орой бүрэнхийд идэвхтэй. Ганц нэгээрээ болон жижиг бүл үүсгэн амьдарна. Ихэвчлэн сөөглөг ургамлын доогуур цөөн амсартай нүх ухаж орогноно. Үр, жимсээр голлон хооллох ч дулааны улиралд ургамлын ногоон хэсгийг иднэ. Үржлийн үе хавар 3-4-р сараас намар 8-р сар хүртэл үргэлжилнэ. Бие гүйцсэн эмэгчин жилд 2-4 удаа төрнө. Нэг удаад 3-7 зулзага төрүүлнэ. Байгалийн нөхцөлд 1-2 насалдаг (Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Тоо толгой, нягтшилын талаар тодорхой судалгаагүй ч хамгийн элбэг тохиолдох зүйлийн нэг.

Ховордлын шалтгаан. Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэгт малын тоо толгой өссөнөөр бэлчээрийн талхагдлаас үүдэлтэй амьдрах орчны доройтол (1.1.4.1) нүүрлэж болзошгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр шар чичүүл 3,600 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 24% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Популяцийн тоо толгой, нягтшил (3.2), ангилал зүй (3.1), биологи, экологи (3.3) болон аюул заналын (3.5) судалгааг нарийвчлан хийх шаардлагатай.

4.58. МОРИН ЧИЧҮҮЛ

Rhombomys opimus (Lichtenstein, 1823)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Хулгана (Muridae)
Англи нэр: Great Gerbil
Ижил нэр: *Meriones opimus* (Lichtenstein, 1823), *R. alaschanicus*, *R. nigrescens*, *R. pallidus* (Wilson and Reeder, 2005).



Ангилал зүйн тойм. Монголд *R.opimus nigrescens* (Satunin, 1902) салбар зүйл тархана.

Таних шинж. Биеийн урт 200 мм, жин 250 г. Хамгийн том биетэй чичүүл. Өдрийн идэвхтэй. Бүлээрээ нийлмэл зохион байгуулалт, бүтэц бүхий суурьшил үүсгэнэ. Идэвхтэй суурьшилд нүхний амсар дээр сул шороо, түүний дээр чичүүлийн ул мөр тод илэрнэ. Зоо нуруу, хажуу хар саарал сортой элсэн шаргал, хэвлий цайвар. Сүүлний өнгө их биеийнхтэй адил, төгсгөл хэсэгтээ бараан өнгийн цацагтай (Батсайхан нар, 2022). Сүүл биеийн урттай ойролцоо. Аюул ойртсон үед хойд хөл дээрээ хагас зогсож чанга дуугаар исгэрч, урд хөлөөрөө газар дэвсэлнэ. Дээд үүдэн шүдний гадаргуу дээр хоёр ховил илэрнэ.

Үнэлгээ ба үндэслэл
Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).
2025 онд Анхааралд өртөхөөргүй (2025). Энэ зүйлийн тархалт дэлгэр, популяцийн хэмжээ том. Популяцийн хэмжээ тогтвортой гэж үзээд үнэлгээг хэвээр үлдээв.
Үнэлгээ хийсэн: Р.Самъяа, Н.Батсайхан, С.Шар, Д.Лхагвасүрэн, Э.Ундрахбаяр (2025).
Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Афганистаны хойд хэсэг, Иран, Казахстан, Киргизстан, Пакистан, Тажикстан, Туркменистан, Хятадын төв хэсгийн хойд зах, баруун хойд хязгаар, Монголд тархсан (Clark *et al.*, 2006; Smith and Yan, 2013; Liu *et al.,* 2024).

Монгол орны тархац, амьдрах орчин. Нууруудын хөндий, Шаргын говь, Умард говь, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алашаа говиор тархана (Батсайхан нар, 2022). Шаргын говь нь морин чичүүлийн тархцын хойд хил болно. Жинхэнэ цөл, хэт гандуу цөлийн (8.3) заг, сухайтай элсэн довцог, уул, толгод хоорондын хөндийгөөр том, жижиг суурьшил үүсгэнэ. А.Г.Банников (1954) морин чичүүлийн амьдрах орчны (а) чулуурхаг цөлийн дундах элсэн манхан, сухай, өтгөн загтай элсэн довцог, сондуул, (б) толгод хоорондын давсархаг хөрстэй бударганатай хөндий гэсэн хоёр үндсэн хэв шинжийг тодорхойлжээ.



Амьдралын онцлог. Загийн мөчир, найлзуур, үр зонхилох ба заггүй газар хотир, бударгана, тэсэг, шар мод зэрэг цөлийн ургамлаар хооллоно. Нүхэндээ хөөе хураана. Жилийн турш идэвхтэй ч өвөл газрын дээрх идэвх эрс багасна. Нийлмэл бүтэцтэй суурьшил үүсгэнэ. Цаг агаар, улирлаас хамаарч байршлаа солино. Тоо толгойн олон жилийн болон улирлын хэлбэлзэл илэрнэ. Хавар үржилд орж, жилдээ 2 удаа төллөнө. А.Г.Банников (1954) морин чичүүлийн үржил хожуу 5-р сарын сүүлээр эхэлдэг онцлогтой гэжээ. Нэг удаад ихэвчлэн 5-6, дээд тал нь 9 гөлчгий гаргана. Говийн ургамлын нөхөн ургалтад эерэг, сөрөг нөлөө үзүүлнэ.

Тоо толгой, нягтшил. Суурьшил өөр хоорондоо зайтай тасархайтсан байх ч зарим нутагт томоохон талбай эзэлсэн суурьшил үүсгэнэ. А.Г.Банников (1954) элсэн дов, сондуултай хөндийд 1 га талбайд 447-2,892 нүх тоолжээ. Нэг суурьшилд 15-20 нүхний амсар нэг бодгальд хамаарна гэж үзээд 1 га дахь нягтшил 150-200 бодгаль гэж тооцоолжээ. Улаан нуурын хөндийд бүлийн суурьшил (колони) өөр хоорондоо ялгагдах боломжтой зайтай бөгөөд 1 га-д дунджаар 80-90 амсар тоологдож байжээ.

Ховордлын шалтгаан. Тархалт, тоо толгой тогтвортой байгаа бөгөөд ховордох шалтгаан одоогоор үгүй. Уур амьсгалын дулаарал, хуурайшилтын улмаас (7.1) түүний тархац нутаг хумигдах магадлалтай.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр морин чичүүл 4,300 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 36% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн биологи, экологийн (3.3) судалгааг нарийвчлан хийж, үүний үндсэн дээр хамгаалах тусгайлсан арга хэмжээг төлөвлөх нь зүйтэй.

4.59. ЧИГЧИЙ ХУЛГАНА

Micromys minutus (Pallas, 1771)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Хулгана (Muridae)
Англи нэр: Eurasian Harvest Mouse
Ижил нэр: *Mus minutus* (Pallas, 1771), *M. minimus*, *M. soricinus*, *M. ussuricus.* (Wilson and Reeder, 2005); *M. batarovi* Kastschenko,1910; *M. flavus* Kerr, 1792; *M. kytmanovi* Kastschenko, 1910; *M. sareptae* Hilzheimer, 1911; *M. ussuricus* Barret-Hamilton, 1899 (Павлинов и Лисовский, 2012).



Ангилал зүйн тойм. Төрлийн нэр *Mus minutus* (Pallas, 1771) байсан бөгөөд одоо *Micromys* болж өөрчлөгдсөн (Лисовский, 2019).

Таних шинж. Жижиг биетэй хулгана. Биеийн урт 100-125 мм, сүүлний урт 90 мм хүрэх бөгөөд тавхайн урт 22 мм хүрэхгүй. Биеийн жин 20-40 г. Хэвлий сааралдуу. Биеийн галбир төрхөөрөө бусад хулгануудтай төсөөтэй. Нуруу ухаавтар элгэн хүрэн, зоо нурууг дагасан хар судалтай байдгаар нь бусад зүйлээс ялгана.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Ховордож болзошгүй (NT).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Харьцангуй хязгаарлагдмал зурвас газар тархацтай боловч амьдрах орчинд гэнэтийн өөрчлөлт ороогүй нөхцөлд популяцийн төлөв байдал тогтвортой хадгалагдах учир энэ зэрэглэлээр үнэллээ.

Үнэлгээ хийсэн: С.Шар, Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, Э.Ундрахбаяр, Р.Самъяа (2025).
Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Армени, Австри, Азербайжан, Беларусь, Босни Херцеговина, Болгар, Хятад, Хорват, Чех, Дани, Эстони, Финлянд, Франц, Гүрж, Герман, Унгар, Энэтхэг, Итали, Япон, Ардчилсан Солонгос, Өмнөд Солонгос, Латви, Литва, Македони, Нидерланд, Польш, Румын, Орос, Серби Монтенегро, Словени, Словак, Испани, Швед, Швейцар, Тайваны арал, Турк, Украин, Их Британи, Монголд тархсан (Kryštufek, 2019).

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол Алтай, Хөвсгөл, Хэнтий, Монгол дагуур, Хянганы салбар уулсаас эх авсан голуудын савд тархжээ (Батсайхан нар, 2023). Улз голын саваас олдсон. Монгол оронд нарийн зурвас газар хязгаарлагдмал тархацтай. Голын хөндийн нуга (5.1), өтгөн өвстэй шугуйд (4) голдуу байршиж амьдарна.



Амьдралын онцлог. Ихэвчлэн өдөр идэвхтэй. Өвөл овоолсон өвс, сүрлийн доогуур орж хоргодно. Бага зэргийн хөөе хураана.

Элдэв зүйлийн өвслөг ургамлын үр, шавж иднэ. Жилд 3-4 удаа төллөх бөгөөд төллөх бүрдээ 5-8, зарим тохиолдолд 12 хүртэл тооны гөлчгий төрүүлнэ. Хээл тээх хугацаа 20 орчим хоног. Байгалийн нөхцөлд 2 жил хүртэл насална. Өвслөг ургамлын иш, бутлаг ургамлын мөчир дээр газраас 0.5-1.0 м-ээс хэтрэхгүй өндөрт бөөрөнхий хэлбэртэй, 60-130 мм диаметртэй, өвсөн үүр засаж дүүжилнэ. Ургамлын ишийг дамжин сайн авирах чадвартай.

Тоо толгой, нягтшил. Популяцийн тоо толгой, нягтшилын мэдээ, баримт хангалтгүй.

Ховордлын шалтгаан. Байгалийн түймэр (7.4), малын тэжээл бэлтгэх зорилгоор хадлан бэлтгэх (1.3.4) зэрэг үйл ажиллагааны улмаас амьдрах орчны хомсдол (1) бий болж, улмаар ховордож болзошгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр чигчий хулгана 4,100 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 27% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Популяцийн тоо толгой, нягтшилын судалгаанд (3.2; 3.9) үндэслэж хамгаалах арга хэмжээг тодорхойлох шаардлагатай.

4.60. ХЭЭРИЙН ХУЛГАНА

Apodemus agrarius (Pallas, 1771)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Хулгана (Muridae)
Англи нэр: Striped Field Mouse
Ижил нэр: *A. albostriatus, A. caucasicus, A. chejuensis, A. coreae зэрэг олон ижил нэр бий* (Musser and Carleton, 2005).



Ангилал зүйн тойм. Удам төрлийн холбоог тодорхойлдог молекул биологийн анализ хийсэн судалгааны үр дүнд хээрийн хулгана нь *Apodemus chevrieri* хэмээх зүйлтэй хамгийн ойр төрлийн холбоотой ангилал зүйн бүлэг хэмээн тогтоожээ (Musser and Carleton, 2005).

Таних шинж. Биеийн урт 100-125 мм, сүүлний урт 90 мм хүрэх бөгөөд тавхайн урт 22 мм, чихний урт 11-16 мм. Биеийн жин 20-40 г. Хэвлий сааралдуу. Биеийн галбир төрхөөрөө бусад хулгануудтай төсөөтэй. Биеийн нуруун тал ухаа, элгэн хүрэн өнгөтэй, зоо нурууг дагасан хар судалтай байдгаар нь бусад зүйлээс ялгана (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Тархац нутаг харьцангуй уудам, түгээмэл зүйл. Түүний тархац газрын дийлэнх нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдсан. Малын бэлчээрлэлтийн нөлөө бараг үгүй зэрэг үзүүлэлтийг үндэслэн анхааралд өртөхөөргүй хэмээн үнэлэв.
Үнэлгээ хийсэн: Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, Р.Самъяа, Э.Ундрахбаяр, С.Шар (2025).
Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Армени, Австри, Азербайжан, Беларусь, Босни Херцеговина, Болгар, Хятад, Хорват, Дани, Эстони, Финланд, Гүрж, Ардчилсан Солонгос, Өмнөд Солонгос, Латви, Литва, Польш, Румын, Орос, Серби Монтенегро, Словак, Тайваны арал, Турк, Украин, Монголд тархсан (https://www.mammaldiversity.org).

Монгол орны тархац, амьдрах орчин. Их Хянганы өрнөд салбар уулс, Халх, Нөмрөг Дэгээ голын сав газар тархжээ. Ойн цоорхой, голын хөндийн татмын нуга, шугуй шүтэн (4.4; 5.3) амьдардаг.



Амьдралын онцлог. Ихэвчлэн бүрэнхий, шөнө идэвхтэй. Гүехэн, 3-4 амсар бүхий нүхэнд амьдарна. Жилийн турш идэвхтэй. Хад, модон доогуур орогнох тохиолдол бий. Ургамлын үр, ургал эрхтэн, шавж иднэ. Өвөлд олон зүйл ургамлын үр нөөцөлнө. Жилд 3-4 удаа төллөх бөгөөд төллөх бүрдээ 5-7 гөлчгий төрүүлнэ. Хээл тээх хугацаа 27-29 хоног. Байгалийн нөхцөлд 2 жил хүртэл насална (Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Энэ зүйл тархац нутгийнхаа хүрээнд харьцангуй элбэг.

Ховордлын шалтгаан. Түүний тархац нутгийн дорнод хэсэгт уур амьсгалын өөрчлөлт, хуурайшилтаас улбаатай байгалийн түймрийн (7.4) улмаас амьдрах орчны хомсдол (1) нүүрлэж, популяцийн нягтшилд нөлөө үзүүлж болзошгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр хээрийн хулгана 3,800 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 32% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Байгалийн болон хүний санамсаргүй үйлдлээс улбаатай түймрийн хөнөөлийг хязгаарлах (4.1; 4.2), урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа чухал.

4.61. АЗИЙН ХУЛГАНА

Apodemus peninsulae (Thomas, 1907)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Хулгана (Muridae)
Англи нэр: Korean Field Mouse
Ижил нэр: Модон галай (Дуламцэрэн, 2003); *A. giliacus*, *A. majusculus, A. rufulus* (Wilson and Reeder, 2005).



Ангилал зүйн тойм. Сүүлийн үеийн молекулын судалгаагаар *Apodemus, Alsomys* (Азийн хулгана энэ ангилалд багтаж байгаа), *Sylvaemus* гэсэн гурван төрөлд багтаж байгаа ч хувьслын нийтлэг шинжийг үндэслэн нэгдсэн ангилал зүйн судалгаа хийх хүртэл нэг төрөлд хамааруулах болсон (Mezhzherin, Tereshchenko, 2023)cytb.

Таних шинж. Биеийн урт 100-124 мм, сүүлний урт 83-111 мм, хойд тавхайн урт 22-26 мм, чихний урт 13-18 мм. Биеийн жин 45 г хүрнэ. Биеийн нуруун тал нилдээ хүрэн-шаргал, хэвлий цайвардуу саарал (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC).

Тархац нутаг уудам, тоо толгойн элбэг зүйл. Популяцийн тоо хэмжээ буураагүй тул Анхааралд өртөхөөргүй хэмээн үнэлэв.
Үнэлгээ хийсэн: Э.Ундрахбаяр, Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, С.Шар, Р.Самъяа (2025).
Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Орос, Өмнөд Солонгос, Хойд Солонгос, Хятад, Япон болон Монголд тархсан (Batsaikhan *et al.,* 2016).

Монгол орны тархац, амьдрах орчин. Хөвсгөл, Хангай, Хэнтийн нурууд, Их хянганы уулсаар, Монгол Дагуурын ой, ойт хээр, хээрийн бүсээр элбэг тархжээ (Дуламцэрэн, 1970; Дуламцэрэн *et al.,* 1989; Соколов и Орлов, 1980). Сэрүүн бүсийн элдэв хэлбэрийн ой, тайга (1.1) болон хээрийн бүсийн голын хөндий, татмын бургасан шугуй, бутлаг (3.4), үетэн давамгайлсан (3.4) зэрэг олон янзын хэв шинжид тохиолдоно.



Амьдралын онцлог. Ойн цоорхой, голын хөндийн чийглэг шугуйд байршин амьдарна. Гэр, сууц, агуулахад тохиолдоно. Бүрэнхий ба шөнийн идэвхтэй боловч өдөр тохиолдоно. Нүхэнд амьдарна. Жилийн туршид идэвхтэй. Ихэвчлэн өвслөг ургамлын үр, буурцаг иднэ. Өвөлд олон зүйлийн ургамлын үр нөөцөлнө. Хээл тээх хугацаа 27-29 хоног. Жилд 2 удаа төллөх бөгөөд төллөх бүрдээ 6-7 гөлчгий төрүүлнэ. Байгалийн нөхцөлд 2 жил хүртэл насална (Батсайхан нар, 2022).
Тоо, толгой, нягтшил. Сэлэнгэ аймгийн Ерөө болон Мандал сумдын нутаг дахь Хонин нуга судалгааны сууринд хийсэн ойн жижиг хөхтний судалгаагаар, 2008 онд 100 конус/хоногт 1.1, 2009 онд 100 конус/хоногт 10.0, 2010 онд 100 конус/хоногт 37.9 бодгаль тус тус баригджээ. Төв аймгийн Алтанбулаг, Аргалант, Баянхангай сумдын нутгийн Хустайн нурууны байгалийн цогцолборт газарт хийсэн судалгаагаар, харьцангуй элбэгшил 2004 онд 0.6, 2005 онд 0.5, 2006 онд 0.1, 2007 онд 0.18, 2008 онд 0.09, 2009 онд 0.12 бодгаль байв (Самъяа нар, 2011).

Ховордлын шалтгаан. Дэлхийн дулаарал (6.1.1), түүнээс үүдэлтэй байгалийн түймэр (7.4) болон хүний санамсаргүй үйлдлээс улбаатай түймэр (1.7), ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалттай мод огтлолт (1.3.3) зэрэг нь энэ зүйлийн амьдрах орчинд сөргөөр нөлөөлнө.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Азийн хулгана 3,600 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 17% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн биологи, экологийн (3.3) судалгааг тусгайлан хийж, популяцийн тоо толгой (3.2), амьдрах орчны статусыг (3.4) тодорхойлох нь чухал.

4.62. ЦӨЛИЙН АЛАГДААХАЙ

Orientallactaga balikunica (Hsia and Fang, 1964)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Алагдаагхайа (Dipodidae)
Англи нэр: Balikun Jerboa
Ижил нэр: Өмнөговийн алагдаага; *Allactaga bullata balikuna* Hsia and Fang, 1964; *Allactaga nataliae* (Соколов, 1981; Wilson and Reeder, 2005). *Allactaga balikunica* (Holden and Musser, 2005).



Ангилал зүйн тойм. *Allactaga bullata*-ийн салбар зүйлээс салгаж, *Allactaga balikunica* Hsia and Fang, 1964 хэмээх бие даасан зүйл болгосон (Lebedev *et al.,* 2012) ба *Orientallactaga balikunica* гэх болжээ (Wilson *et al.,* 2017).

Таних шинж. Биеийн урт 113-136 мм. Нуруу долгиотсон маягийн бараан, толгойн дээд хэсэг цайвардуу саарал. Сүүлний угийн дээд хэсэг бараандуу бор саарал, доод хэсэг нь цайвар. Сүүл нь туушдаа жигд нарийн бөгөөд арьсан дороо өөхөн давхарга байхгүй. Хойд мөчид 5 хуруутай (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл
Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).
Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).
2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC).

Монгол орны өмнөд говь, цөлийн бүсэд өргөн тархсан, тоо толгойн элбэг тул энэ зэрэглэлээр үнэлэв.
Үнэлгээ хийсэн: С.Шар, Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, Э.Ундрахбаяр, Р.Самъяа (2025).
Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Хятад болон Монголд тархсан (Smith, 2016; https://www.mammaldiversity.org).

Монгол орны тархац, амьдрах орчин. Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алашаа говьд тархана. Монгол орны өмнөд хэсэгт *A.bullata* зүйлтэй симпатрикаар оршдог (Wilson and Reeder, 2005). Хэт гандуу болон жинхэнэ цөл, хээржүү цөлийн (8.2) орчинд амьдарна.



Амьдралын онцлог. Шөнө идэвхтэй. Түр буюу байнгын нүхэнд орогноно. Өвөл ичээлнэ. Ургамлын үр болон булцуу, ургал хэсгээр хооллоно.

Ичээнээс гарсны дараа оroo нийллэгт орно. Хээл тээх хугацаа 25-35 хоног. Жилд 1 удаа төллөж 2-8 зулзага төрүүлнэ. Байгалийн нөхцөлд 2-3 жил орчим насална (Соколов, 1973; Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Говийн бүсэд өргөн тархсан, элбэг тохиолдох зүйлийн нэг. Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт 2017 онд хийсэн хээрийн судалгааны үед 1 га-д 0.8 бодгаль ноогдох нягтшилтай байв (Shar *et al.,* 2020).

Ховордлын шалтгаан. Говь, цөлийн бүсэд уул уурхай (1.3.1), ган (7.1), харын зудтай өвөл зэрэг байгалийн хатуу нөхцөл (7.3) нөлөөлж болзошгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр цөлийн алагдаахай 3,800 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 41% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Монгол орны говь, цөл, цөлжүү хээрт өргөн тархацтай, тоо толгойн хувьд элбэг зүйл хэдий ч түүний биологи, экологийн (3.3) судалгааг нарийвчлан хийж, хамгааллын арга хэмжээг тодорхойлж байх нь зүйтэй.

4.63. ГОВИЙН АЛАГДААХАЙ

Orientallactaga (Allactaga) bullata (Allen, 1925)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Алагдаахай (Dipodidae)
Англи нэр: Gobi Jerboa
Ижил нэр: Энэ зүйлд ижил нэр үгүй (Holden and Musser, 2005).



Ангилал зүйн тойм. *Allactaga bullata*-ийн салбар зүйлээс *Allactaga balikunica* Hsia and Fang, 1964 хэмээх бие даасан зүйл болгон салгасан (Lebedev *et al.,* 2012).

Таних шинж. Биеийн гадаад төрхөөрөө бусад алагдаахайтай төсөөтэй. Биеийн урт 120-140 мм, сүүлний урт 142-172 мм, хойд тавхайн урт 57-68 мм, чихний урт 28-39 мм, биеийн жин 70-90 г. Ерөнхий зүс бор саарал. Гуяны цагаан толбо нь жижгэвтэр. Сүүлний үзүүрийн цацаг үсний хар хэсгийн өмнө талд цайвар цагариг маягийн үстэй, сүүлний цацгийг доод талаас нь харахад хар өнгийн үсний дундуур сүүлний дагуу байрласан цагаан зурвас үстэй зэрэг содон шинжээр нь бусад алагдаахайнаас ялгах боломжтой (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Монгол орны өмнөд нутагт илрэх жинхэнэ цөл, хээржүү цөл, цөлжүү хээрийн экосистемд түгээмэл тохиолддог, элбэг зүйл төдийгүй тархац нутгийн нэлээд хэсэг нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдсан тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, Р.Самъяа, Э.Ундрахбаяр, С.Шар (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Хятад болон Монголд тархжээ.

Монгол орны тархац, амьдрах орчин. Их Нууруудын хотгор, Нууруудын хөндий, Алашань говь, умард говь, Дорнод говьд тархсан. Элдэв сөөг, өвслөг ургамалтай жинхэнэ цөл, хээржүү цөл, цөлжүү хээрийн экосистемд (8.3) нам уулс хоорондын тэгш хөндий, уудам хотгор, сайр хоорондын дэнжийн хайрган хучлагатай газар амьдарна (Батсайхан нар, 2022).



Амьдралын онцлог. Бүрэнхий, шөнө идэвхтэй. Өвөл ичээлнэ. Гүнээрээ 20-25 см, уртаараа 3.5 м нүх ухаж орогноно. Голдуу өвслөг, сөөглөг ургамлын үр, буурцаг, шавжаар хооллоно. Ичээнээс гарсны дараа оroo нийллэгт орох ба эм бодгаль нь нэг төрөхдөө 2-5 зулзага төрүүлнэ (Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Монгол орны жинхэнэ цөл, хээржүү цөл, цөлжүү хээрийн экосистемд өргөн тархсан, элбэг тохиолдох зүйл.

Ховордлын шалтгаан. Говь, цөлийн бүсэд уул уурхай (1.3.1), уур амьсгалын өөрчлөлтөөс улбаатай жил дараалсан ган (7.1), олон тооны малын бэлчээрлэлтээс үүдэлтэй газрын доройтол (1.1.4.1) нөлөөлж болзошгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр говийн алагдаахай 4,300 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 25% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Түүний тархац нутгийн хүрээнд бэлчээрийн менежмент (4.1; 4.2) хийх нь хамгаалалын арга хэмжээ болно.

4.64. ШИВЭР АЛАГДААХАЙ

Orientallactaga sibirica (Forster, 1778)

Баг: Мэрэгчид (*Rodentia*)
Овог: Алагдаахай (*Dipodidae*)
Англи нэр: Siberian Jerboa
Ижил нэр: Шивэр алагдаага (Дуламцэрэн, 2003); *A. s. saltator* (*A. s. semideserta* гэж ч үздэг), *A. s. sibirica, A. s. Bulganensis* (Соколов и др., 1998; Шенброт, 1991; Шенброт и др., 1995).



Ангилал зүйн тойм. Өмнө нь энэ зүйлийг A*llactaga* төрөлд хамааруулдаг байсан бол өдгөө O*rientallactaga* төрөлд хамааруулах болсон (Lebedev *et al.,* 2013)V.S., Bannikova, A.A., Pagıs, M., Pisano, J., Michaux, J.R. & Shenbrot, G.I. (2012.

Таних шинж. Монголд тархаж буй алагдаагын зүйлүүдээс биеийн хэмжээгээр том. Биеийн урт 125-180 мм, сүүлний урт 172-230 мм, тавхайн урт 64-81 мм, чихний урт 36-55 мм, жин 85-170 г. Нуруу саарал туяа бүхий цайвар. Гуяны цагаан толбо нь том. Сүүлний үзүүрийн цацаг үсний хар хэсгийн өмнө талд цагариг маягийн цайвар үстэй, сүүлний цацгийг доод талаас нь харахад хар үсний дундуур сүүлний дагууд байрласан нарийн цагаан зурвастай зэрэг содон шинжээр нь бусад алагдаагаас ялган таньж болно. Сүүлний үзүүр тод цагаан (Банников, 1953; Дуламцэрэн, 1970; Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Тархац нутаг уудам, тоо толгойн элбэг зүйл бөгөөд популяцийн тоо хэмжээн буураагүй хэмээн үзэж өмнөх үнэлгээг хэвээр үлдээв.

Үнэлгээ хийсэн: Э.Ундрахбаяр, Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, С.Шар, Р.Самъяа (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Казахстан, Туркменистан, Хятад, Киргизстан, Узбекистан болон Монголд тархсан (Batsaikhan *et al.,* 2016).

Монгол орны тархац, амьдрах орчин. Ойт хээр, хээр, хуурай хээр, говь цөлийн бүсээр өргөн тархсан (Mallon, 1985). *A. s. sibirica* салбар зүйл дорнод болон умард Монголд тухайлбал, Сэлэнгэ мөрний ай сав нутгаар, харин *A. s. saltator (A. s. semideserta* багтсан) *салбар* зүйл Монгол орны баруун умард, өмнөд, өрнөд нутгаар тархсан. *A. s. bulganensis* салбар зүйл зөвхөн Зүүнгарын говьд тохиолдоно (Г.Шенбротын аман мэдээ). Цөл, цөлөрхөг хээр (8.3), хуурай хээрийн бутлаг ургамалтай (3.4), үетэн давамгайлсан ургамалжилттай (4.4) олон янзын хэв шинж бүхий орчинд амьдарна.



Амьдралын онцлог. Амьдарч буй орчиндоо газрыг гүехэн (2-3 см) малтаж олон тооны малтац үлдээнэ. Шөнийн идэвхтэй. 70-150 см-ийн гүнд 500 см урт нүх ухаж орогноно. Нүхний гаднах амсрын диаметр 6 см орчим. Ургамлын ногоон навч, үр, буурцаг, шавжаар хооллоно. Ичээнээс гарсны дараа үржилд орно. Жилд 1 удаа төрөх ба 3-6 зулзага төрүүлнэ (Батсайхан нар, 2022).

Тоо, толгой, нягтшил. Өмнөговь аймгийн Ханбогд сумын Оюу толгой орчим (N43°01’57”; E106°47’15”) 2017, 2018 онд хийсэн судалгаагаар, нэг га тутамд 1.04 бодгаль нягтшилтай байв (Shar *et al.,* 2020). Мөн Увс аймгийн Түргэн сумын нутагт 100 баригч/хоногт 0.36±0.27 бодгаль ноогдож байсан бол Мянган Угалзатын байгалийн цогцолборт газар, түүний орчны бүсэд шөнийн шугаман замналд 1 га талбайд уулын хээрт 0.85, хуурай хээрт 1.26 бодгаль нягтшилтай байсан (Лхагвасүрэн нар, 2023). Зүүнгарын говийн жижиг хөхтөн амьтдын бүлгэмдлийн 2002-2010 оны судалгаагаар, энэ зүйлийн нягтшил га-д 0.1-0.35 бодгалийн хооронд хэлбэлзэж байв (Самъяа нар, 2011).

Ховордлын шалтгаан. Уудам орон зайд олон янзын амьдрах орчинд дасан зохицож амьдардаг зүйл бөгөөд түүний ховордлын шалтгаан, сөрөг нөлөөллийн талаарх судалгааны мэдээ, баримт хомс.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Шивэр алагдаахай 3,800 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 16% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн биологи, экологийн (3.3) судалгааг нарийвчлан хийж, хамгааллын тусгай арга хэмжээг тодорхойлж байх нь зүйтэй.

4.65. ТАВАН ХУРУУТ АТИГДААХАЙ

Cardiocranius paradoxus (Satunin, 1903)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Алагдаахай (Dipodidae)
Англи нэр: Five-toed Pygmy Jerboa
Ижил нэр: Five-toed Jerboa



Ангилал зүйн тойм. Монотип зүйл.

Таних шинж. Өвөлжсөн бодгалийн биеийн урт 69 мм, сүүлний урт 90 мм, жин 18 г. Жижиг биетэй алагдаага. Хойд мөч 5 хуруутай. Захын хуруу урт, газарт шүргэдэг онцлогтой. Чих богино, сонсголын хоолой үүсгэнэ. Толгой болон толгойн ясны сонсголын хэнгэрэг том. Нүх жижиг. Мэдрэгч сахал үстэй. Сүүл жигд тачир үсээр бүрхэгдэнэ. Сүүлэндээ өөх хуримтлуулна. Эр, эм нь биеийн хэмжээгээр ойролцоо. Зоо нурууны зүс элсэн саарал, бор саарал, хэвлий цайвар.

Үнэлгээ ба үндэслэл
Олон улсын үнэлгээ: Эмзэг (VU) (A1c).
Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Clark *et al.,* 2006).
2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Тархац нутаг уудам, тархалтын аль ч хэсэгт

популяцийн хэмжээ тогтвортой, тооны хэлбэлзэл бага учир анхааралд өртөхөөргүй хэмээн үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Р.Самъяа, Н.Батсайхан, С.Шар, Д.Лхагвасүрэн, Э.Ундрахбаяр (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Хятадын төв хэсгийн хойд, баруун хойд хязгаарт, Казахстан, Оросын Тувагийн баруун өмнөд захаар болон Монголд тархжээ (Соколов и др., 1996; Батсайхан нар, 2022).

Монгол орны тархац, амьдрах орчин. Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, умард говь, Өмнөговь, Дунд говь, Дорнод говийн цөл, цөлөрхөг хээрийн бүсээр өргөн тархана (Батсайхан нар, 2022). В.Е.Соколов нар (1996) цөл, цөлөрхөг хээрийн бүсэд 52 байршлаас энэ зүйлийн цуглуулга хийжээ. Цөл, цөлөрхөг хээрийн (8.3) өндөр, нам уулсын хоорондох хөндий, энгэр, бэл, хормой дагаж элсэрхэг, дагжуур хөрстэй, таана, баглуур, бударгана зэрэг ургамал сийрэг ургасан чулуурхаг, тэгшивтэр тал, дэнж, элсэрхэг довцог, уулын энгэр бэлийн сөөг, сөөгөнцөр ургамалтай жалга судаг, голын сайраар байршина (Соколов и др., 1996; Батсайхан нар, 2022).



Амьдралын онцлог. Шөнийн идэвхтэй. Өвөл ичнэ. Ургамлын үр, шавжаар хооллоно. Бусад жижиг атигдаахайтай харьцуулахад ходоодонд ургамлын ногоон хэсгийн үлдэгдэл байнга илэрнэ. Үржил эхлэх хугацаа тодорхойгүй. Үр төл нь 7-р сарын сүүлч, 8-р сард олширно. Жилд 1 удаа төллөх ба 1-5, дунджаар 3 гөлчгий төрүүлнэ. Гантай жил үржил саатна. Намар сэрүү орох үеэр ичнэ. Алтайн өвөр говийн хойд нутагт 1986 онд барьсан өвөлжсөн 40 бодгалийн шүдний элэгдлээр 2-3 настай гэж тодорхойлжээ (Соколов и др., 1996).

Тоо толгой, нягтшил. Тохиромжтой орчинд 1 га-д 2-5 бодгаль, дээд тал нь 6 бодгаль, шөнө машинаар гэрэлтүүлэхэд 10 км тутамд 1 бодгаль тохиолдож байжээ (Соколов и др., 1996). Оюу толгой уурхайн орчмын хяналтын талбайд машинаар гэрэлтүүлсэн тооллогоор 1 га-д 1.2 бодгаль бүртгэгдсэн (Shar *et al.,* 2020).

Ховордлын гол шалтгаан. Бэлчээрийн доройтол (1.1.4.1), ган, ширүүн аадар бороо зэрэг байгалийн гамшиг (7.1, 7.2) ховордуулах шалтгаан болно.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр таван хуруут атигдаахай 4,500 төгрөг. Монгол Улсын Улаан номд ховор зүйлээр бүртгэгдсэн (Шагдарсүрэн нар, 1987; 1997).

Энэ зүйлийн тархац нутгийн 26% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн популяцийн төлөв байдал (3.2), биологи, экологи (3.3), амьдрах орчны (3.4) судалгааг нарийвчлан хийж, учирч болзошгүй аюулыг (3.5, 5.6) тогтоож, улмаар хамгаалллын арга хэмжээг төлөвлөх нь зүйтэй.

4.66. ЭЛСЧ САВАГДААХАЙ

Dipus sagitta (Pallas, 1773)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Алагдаахай (Dipodidae)
Англи нэр: Hairy-footed Jerboa
Ижил нэр: Савагдаахай; *D. halli*, *D. lagopus*, *D. zaissanensis* (Wilson and Reeder (2005); *Mus sagitta* (Pallas, 1773); *D. innae* Ognev, 1930; *D. kalmikensis* Kazantseva, 1940; *D. nogai* Satunin, 1907; *D. sowerbyi* Thomas, 1908 (Павлинов и Лисовский, 2012).



Ангилал зүйн тойм. Зүйлийн түвшинд ангилал зүйн өөрчлөлт ороогүй. Харин сүүлийн үед савагдаахайн салбар зүйлүүдийн эволюци хэрхэн явагдсаныг судлаачид митохондрын болон бөөмийн ДНХ-ийн судалгааны үр дүнд үндэслэн *D.s.deasyi* салбар зүйлээс салаалж *Lagopus* ба *Sagitta* гэсэн хоёр бүлэг үүссэн бөгөөд *Sagitta* бүлгээс *D.s.ubsanensis* нэлээд эрт салсан, харин *D.s.bulganensis* харьцангуй хожуу салсан салбар зүйлүүд болохыг дурдаж, эдгээр нь хэдийгээр эрт салсан ч үржлийн хувьд тусгаарлагдаагүй (Lisenkova *et al.,* 2023) гэжээ.

Таних шинж. Биеийн урт 110-158 мм, сүүлний урт 140-178 мм, тавхайн урт 55-70 мм, чихний урт 18-25 мм, чих харьцангуй богино, жин 46-128 г. Нуруун тал цайвардуу элсэн шаргал, хэвлий цагаан. Үүдэн шүд шар. Сүүлний үзүүрийн цацаг сайн хөгжсөн. Хойд

мөчид нь 3 хуруутай. Тавхайн улны хэсэгт цайвар өнгийн урт сагсгар үстэй зэрэг гадна шинжүүдээр бусад алагдаагаас хялбархан ялгарна.

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Монгол орны өмнөд говь, цөлийн бүсэд өргөн тархсан, тоо толгойн элбэг учир энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: С.Шар, Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, Э.Ундрахбаяр, Р.Самъяа (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Хятад, Иран, Казахстан, Орос, Туркменистан, Узбекстан, Афганистан болон Монголд тархсан (Batsaikhan *et al.,* 2016; https://www.mammaldiversity.org).



Монгол орны тархац, амьдрах орчин. Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, Зүүнгарын говь, Дундад Халхын хээр, умард говь, Алашань говь, өмнө, дунд, Дорнод говь, хагас цөлийн бүсээр түгээмэл тархсан (Маллон, 1985; Соколов и др., 1996).

Монгол орны говь, жинхэнэ цөл, цөлжүү хээр, хэт гандуу цөлд (8.3) тохиолдоно.

Амьдралын онцлог. Шөнө идэвхтэй. Гүн нүх ухаж орогноно. Өвөл ичээлнэ. Элдэв зүйлийн сөөг, өвслөг ургамлын үр, ногоон хэсэг, шавж зэргээр хооллоно. Ичээнээс гарсны дараа үржилд орно. Жилд 1 удаа төрж 2-5 зулзага төрүүлнэ.

Тоо толгой, нягтшил. Монгол орны говь, цөл, цөлжүү хээрийн бүсэд өргөн тархацтай, тоо толгойн элбэг зүйл. Өмнөговь аймгийн 2017 онд хийсэн хээрийн судалгааны явцад Цогтцэций сумын нутагт 1 га-д 0.5 бодгаль ноогдох нягтшилтай байв (Shar *et al.,* 2020).

Ховордлын шалтгаан. Ховордох шалтгаан одоогоор тодорхойгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр элсч савагдаахай 3,800 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 25% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Монгол орны говь, цөл, цөлжүү хээрт өргөн тархацтай, тоо толгойн хувьд элбэг зүйл тул одоогоор хамгааллын тусгайлсан арга хэмжээ шаардлага үгүй.

4.67. ЗЭГЭЛ АЛАГДААГАНЦАР

Pygeretmus pumilio (Kerr, 1792)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Алагдаахай (Dipodidae)
Англи нэр: Dwarf Fat-tailed Jerboa
Ижил нэр: *Alactagulus pumilio* (Kerr, 1792)



Ангилал зүйн тойм. Дэлхийд 5 салбар зүйл бүртгэгдээд байгаа бөгөөд Монголд *P. p. bullatoides* Shenbrot 1995 хэмээх салбар зүйл тохиолдоно (Wilson *et al.,* 2017).

Таних шинж. Биеийн урт 95-135 мм, сүүлний урт 125-175 мм, тавхайн урт 40-56 мм, жин 30-78 г. Зоо нуруу элсэн шаргал, цээж болон хэвлий тод цагаан. Сүүлэндээ цацагтай бөгөөд сүүлний үзүүр цагаан. Чих харьцангуй богино. Хойд мөчид 5 хуруутай (Wilson *et al.,* 2017; Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл
Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).
Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).
2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC).

Тархац нутаг уудам, тоо толгойн элбэг зүйл бөгөөд популяцийн тоо хэмжээн буураагүй хэмээн үзэж энэ зэрэглэлээр үнэлэв.
Үнэлгээ хийсэн: Д.Лхагвасүрэн, Н.Батсайхан, С.Шар, Э.Ундрахбаяр, Р.Самъяа (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Орос, Казахстан, Узбекистан, Туркменистан, Иран, Хятад болон Монголд тархсан (Tsytsulina *et al.,* 2016).

Монгол орны тархац, амьдрах орчин. Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алашань говь (8.3), Нууруудын хөндийд тархжээ. Сайр, цайдам, хотгортой залгаа дэнж, хөндийд сийрэг сөөглөг газар түлхүү идээшилнэ (Батсайхан нар, 2022).



Амьдралын онцлог. Шөнө идэвхтэй. Нэлээд гүн 5-6 м орчим урттай нүх ухаж орогноно. Өвөл ичээлнэ. Идэш тэжээлийн зонхилох хэсгийг ургамлын ногоон хэсэг эзэлнэ. Ичээнээс гарсны дараа үржилд орно. Жилд 2 удаа төрөх ба төрөх бүрдээ 2-4 зулзага төрүүлнэ (Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Тоо толгой, нягтшилын судалгаа хомс.

Ховордлын шалтгаан. Тодорхойгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр зэгэл алагдааганцар 3,800 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 38% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Популяцийн тоо толгой, нягтшил (3.2), биологи, экологи (3.3) болон аюул заналын (3.5) судалгааг нарийвчлан хийх шаардлагатай.

4.68. ӨӨХӨН СҮҮЛТ АТИГДААХАЙ

Salpingotus crassicauda (Vinogradov, 1924)

Баг: Мэрэгчид (*Rodentia*)
Овог: Алагдаахай (*Dipodidae*)
Англи нэр: Thick-tailed Pygmy Jerboa
Ижил нэр: Гувруу (өөхлөг) тажигдаахай (Дуламцэрэн, 2003); *S. gobicus* (Wilson and Reeder, 2005).



Ангилал зүйн тойм. Ангилал зүйн хувьд өөрчлөлт үгүй.

Таних шинж. Бие гүйцсэн бодгалийн биеийн урт 49-57 мм, сүүлний урт 87-117 мм, тавхайн урт 21-27 мм, чихний урт 5-8 мм, жин 7-24 г. Сүүлний үс тачирхан, зөвхөн үзүүртээ үл мэдэг урт цацаг үстэй. Сүүл бүдүүн, өөхөн хуримтлалтай. Сүүлний үзүүрт цацаггүй. Нуруу элсэн шаргалдуу, хэвлий цагаан. Тавхайн улны хэсэгт цайвар үстэй (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл
Олон улсын үнэлгээ: Эмзэг (VU) (A1c).
Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Clark *et al.,* 2006).
2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Энэ зүйлийн тархац нутаг уудам бөгөөд ихэнх газарт ердийн тохиолдох зүйл учир анхааралд өртөхөөргүй гэж үнэлэв.
Үнэлгээ хийсэн: Э.Ундрахбаяр, Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, С. Шар, Р.Самъяа (2025).
Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Казахстан, Хятад болон Монголд тархсан (Chiozza and Kennerley, 2016).

Монгол орны тархац, амьдрах орчин. Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алашань говь, Умард болон Дорнод говийн цөлөрхөг хээр, цөлийн бүст нийт 31 байршлыг тэмдэглэжээ (Соколов и др., 1996). Хуурай хээр, цөлжүү хээр, хээржүү цөл, хэт гандуу цөлийн (8.3) элсэрхэг хөрстэй аараг толгод, хотос, хөндий, цайдам, баянбүрдээр байршина.



Амьдралын онцлог. Цөл болон заримдаг цөлийн шаварлаг, наанги хөрстэй нутагт байршина. Шөнийн идэвхтэй. Өвөл ичээлнэ. Идэш тэжээлийн зонхилох хэсгийг ургамлын ногоон хэсэг эзэлнэ. Ичээнээс гарсны дараа үржилд орно. Жилд 2 удаа төрөх ба төрөх бүрдээ 2-4 зулзага төрүүлдэг (Батсайхан нар, 2022).

Тоо, толгой, нягтшил. Зүүнгарын говийн жижиг хөхтөн амьтдын бүлгэмдлийн судалгаа (2002-2010 он)-аар зүйлийн элбэгшил 100 баригч/хоногт 0.1-0.5-ын хооронд хэлбэлзэж байв (Самъяа нар, 2011).
Алтайн өвөр говьд 1979-1986 онд 10 км авто замналын дагуу 2-7.5 бодгаль, Галбын говьд 1 га-д 3-5 бодгаль нягтшилтай байжээ (Соколов и др., 1996).

Ховордлын шалтгаан. Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэгт ашигт малтмалын хайгуул, ашиглалт, олборлолт (1.3.1) явагдаж байгаагаас үүдэн түүний амьдрах орчны чанар муудах, мөн дэлхийн дулаарлаас (6.1.1) үүдэлтэй гангийн (7.1) давтамж нэмэгдэж, булаг шанд ширгэж, татрах нь тус зүйлд сөргөөр нөлөөлөх болсон.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр өөхөн сүүлт атигдаахай 4,500 төгрөг. Монгол Улсын Улаан номд ховор зүйлээр бүртгэгдсэн (Шагдарсүрэн нар, 1987; 1997).

Энэ зүйлийн тархац нутгийн 28% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Харьцангуй бага судлагдсан тул биологи, экологи (3.3), популяцийн тоо толгой, нягтшил (3.2), амьдрах орчны статус (3.4) болон аюул занал (3.5) зэргийг нарийвчлан судалж хамгааллын арга хэмжээг тодорхойлж, хэрэгжүүлэх шаардлагатай.

4.69. МОНГОЛ ДААХАЙ

Stylodipus andrewsi (Allen, 1925)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Алагдаахай (Dipodidae)
Англи нэр: Mongolian Jerboa
Ижил нэр: Монголжин даахай; *Scirtopoda andrewsi* (Allen, 1925), *Stylodipus telum andrewsi* (Allen, 1925).



Ангилал зүйн тойм. *Scirtopoda* төрөлтэй ижил байсан. Харин сүүлийн үеийн генетикийн судалгааны үр дүнд үндэслэн Төв Азийн Монгол, Хятадын баруун хойд нутгуудад тархсан *Stylodipus andrewsii* зүйл нь эртний гаралтай бие даасан зүйл болохыг тогтоожээ (Lebedev *et al.,* 2023).

Таних шинж. Биеийн урт 128-136 мм, сүүлний урт 142-148 мм, хойд тавхайн урт 54-55 мм, чихний урт 17 мм, биеийн жин 45-95 г. Сүүлний цацгийн үзүүрт бараавтар үстэй, тавхайн ул хэсэгт бараавтар богино үстэй, чихний ард мэдэгдэхүйц цагаан толботой.

Үнэлгээ ба үндэслэл
Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).
Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Монгол орны говь, цөлийн бүсэд өргөн тархацтай, тоо толгойн элбэг зүйл бөгөөд тархац нутгийн талбай 20,000 км^2-аас их тул анхааралд өртөхөөргүй гэж үнэлэв.

Үнэлгээ хийсэн: С.Шар, Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, Э.Ундрахбаяр, Р.Самъяа (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Хятад болон Монголд тархсан (Batsaikhan *et al.,* 2017; https://www.mammaldiversity.org).

Монгол орны тархац, амьдрах орчин. Их нууруудын хотгор, Увс нуурын хотгор, Нууруудын хөндий, Алашаа говь, умард говь, Дорнод говьд тохиолдоно (Соколов и др., 1998). Цөлжүү хээр, цөлийн (8.3) элсэрхэг болон хайрган хучлагатай орчинд амьдарна (Батсайхан нар, 2022).



Амьдралын онцлог. Шөнө идэвхтэй. 5-6 м орчим урттай нүх ухаж орогноно. Өвөл ичээлнэ. Идэш тэжээлийн зонхилох хэсгийг ургамлын үр, шавж эзэлнэ. Ичээнээс гарсны дараа үржилд орно. Жилд 1 удаа төрж 3-4 зулзага төрүүлнэ (Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Монгол орны цөлжүү хээрт тархац нутаг нь өргөн бөгөөд тоо толгойн элбэг зүйл.

Ховордлын шалтгаан. Ховордох шалтгаан одоогоор тодорхойгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Монгол даахай 3,800 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 18% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд (тухайлбал, Хар-Ус нуурын байгалийн цогцолборт газар г.м) хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Монгол орны говь, цөл, цөлжүү хээрт өргөн тархацтай, тоо толгойн хувьд элбэг зүйл тул одоогоор хамгааллын арга хэмжээ шаардлагагүй гэж үзэв.

4.70. ЗАГАЛ ЭЛБЭНХ

Nyctereutes procyonoides (Gray, 1834)

Баг: Мах идэштэн (Carnivora)
Овог: Чоно (Canidae)
Англи нэр: Raccoon Dog
Ижил нэр: *N. albus*, *N. koreensis*, *N. viverrinus* (Wilson and Reeder, 2005).



Ангилал зүйн тойм. Монголд *N. p. ussuriensis* салбар зүйл тархсан гэж үздэг.

Таних шинж. Биеийн урт 65-80 см, жин 12 кг. Зүс нь цайвар бор хүрэн, нурууны сор үс хар, хар хүрэн, ноолуур өтгөн, нуруугаа дагасан тод хар судалтай, тэр нь хойшлох тусмаа бүдгэрч толбо мэт болно. Дал сэрвээг дамнасан тоононолжин хар толботой урт ноолуурхаг үсэн бүрхүүлтэй, арьс нь бөх бат (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл
Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).
2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Тархац нутаг уудам, тоо толгойн элбэг бөгөөд популяцийн тоо хэмжээн буураагүй хэмээн үзэж өмнөх үнэлгээг хэвээр үлдээв.
Үнэлгээ хийсэн: Б.Мөнхцог (2025).
Үнэлгээг хянасан: (2025).

Дэлхийн тархац. Франц, Нидерланд, Герман, Норвег, Швейцар, Австри, Чех, Швед, Польш, Унгар, Словак, Финланд, Румын, Латви, Литва, Эстони, Украйн, Орос, Беларусь, Молдова, Казахстан зэрэг улсад нутагшуулсан бөгөөд Хятад, Монгол,

Вьетнам, Өмнөд Солонгос, Хойд Солонгос, Япон болон Узбекистанд тархсан (https://www.mammaldiversity.org).

Монгол орны тархац, амьдрах орчин. Их Хянганы уулс, Халх, Нөмрөг голын савд тохиолдоно. Түүнчлэн Хэнтий нурууны зүүн бие, Монгол Дагуур, Төв Халхын хээрээр дайран урсдаг Улз, Онон, Хэрлэн, Дөч голын сав нутгаар тархана. Мөн Дорнод Монголын Хөх нуур, Дорнод говийн зүүн хойд нутагт тэмдэглэгджээ. Энэ зүйлийн тархац нь Монгол орны зүүн хэсгийн холимог ойн бүсийн бутархаг өндөрлөг газар дагуу тэлэн тархаж байна.



Амьдралын онцлог. Жижиг мэрэгчид, хоёр нутагтан, мөлхөгчид, шавж, зөөлөн биетэн, загас, ургамлын гаралтай болон сэг зэмээр хооллоно. Өвөл хүйтэрч, идэш тэжээл ховордсон үе болох 12-р сараас 3-р сар хүртэл ичдэг боловч их өлсвөл сэрж, ичээнээс гарч гөрөөлөх удаа ч бий. Ичээний өмнөхөн ороо хөөцөлдөө эхэлж, 4-5-р сард уулын энгэр бэл, ойн зах, гол горхины хөндий, цэнгэг уст цөөрмийн эрэг хавьд голдуу орхигдсон нүхэнд, заримдаа өөрөө үүр засаж 6-8 гөлөг төрүүлнэ. Гуужилт 3-р сарын дунд үеэс эхэлж 5-р сарын сүүлчээр хуучин үсээ хаяж, 11-р сард үс хөрс нь гүйцнэ (Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Манай оронд тоо толгойн элбэг, уудам тархац нутагтай боловч нягтшил багатай.

Ховордлын шалтгаан. Одоогоор мах, үслэг арьсных нь хэрэгцээ бага байгаа ч хараа хяналтгүй агнана. Бага нягтшилтай популяцид агнуур нэлээд хүчтэй нөлөөлдөг. Гэрийн нохойд бариулахаас гадна, саркоптик хамуунд (*Sarcoptes scabies*) өртөнө (Kauhala and Saeki, 2004).

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд тухайлбал, энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2-т зааснаар загал элбэнхийг жил бүрийн 2 дугаар сарын 11-ний өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон. Үүнээс гадна, (10.1.2) агнуурын амьтны жим дээр нүх ухах, буу сойх, занга, сааль тавих, (10.1.5) амьтныг агаарын болон авто тээврийн хэрэгслээр хөөх, гэрэлтүүлэх, (10.1.8) ан агнах зориулалтын бус буу, сум хэрэглэх зэрэг арга, зэвсэг хэрэгслээр агнах, барихыг хориглодог.

Мөн Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр загал элбэнх 447,000 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу).

Энэ зүйлийн тархац нутгийн 10% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн биологи, экологи (3.3), популяцийн тоо толгой, нягтшил (3.2) болон аюул занал (3.5) зэргийг нарийвчлан судалж, үүний үндсэн дээр хамгаллын арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлагатай. Мөн хортон мэрэгчид, шавжийг идэж тоо толгойг нь хэвийн байлгах, хадлан бэлчээрийг хамгаалж, тариалангийн ургацыг нэмэгдүүлдэг чухал ач холбогдолтой амьтан гэдгийг иргэд, малчид, аж ахуйн, байгууллагуудад сайтар ойлгуулах, мэдээллээр хангаж сурталчлах, улмаар тохиолдлоор агнах явдлаас урьдчилан сэргийлэх нь чухал.

4.71. НОХОЙ ЗЭЭХ

Gulo gulo (Linnaeus, 1758)

Баг: Мах идэштэн (Carnivora)
Овог: Суусар (Mustelidae)
Англи нэр: Wolverine
Ижил нэр: *G. arctos*, *G. borealis*, *G. luteus* (Wilson and Reeder, 2005).



Ангилал зүйн тойм. *Gulo gulo* (Linnaeus, 1758) хэмээх ганц зүйл Монгол орон тархжээ.

Таних шинж. Биеийн урт 65-87 см, сүүл 17-26 см, жин 10-25 кг. Зарим тохиолдолд томхон эр нь 31 кг хүрнэ. Эр нь эмээс биеэр 10 хувь том, жингээр 30 хувь илүү. Богино хөлтэй, өргөн дугуйдуу толгойтой, жижиг нүд, богино дугуй чих зэрэг нь баавгайтай төсөөтэй. Таван хуруутай том саврын тавхайгаар тулан явдаг нь гүн цасанд явах хөдөлгөөнийг хөнгөвчилнө. Нас бие гүйцсэн нохой зээх нь дунд зэргийн хэмжээний нохойтой тэнцэхүйц. *Mustelidae* овгийн хуурай газар дээрх хамгийн том төлөөлөгч болно. Зузаан, тослог, бараан арьс нь хүйтнээс сайн хамгаална. Заримынхан нүүр хэсэг нь мөнгөлөг сааралдуу, мөрнөөс 2 хажуу хавирга хэсгийг даган сүүлний дээд талд нийлсэн цайвар судалтай (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл
Олон улсын үнэлгээ: Эмзэг (VU), A2c.
Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Тархац нутаг уудам, тоо толгойн элбэг бөгөөд популяцийн тоо хэмжээн буураагүй хэмээн үзэж өмнөх үнэлгээг хэвээр үлдээв. Хэрвээ популяцийн хэмжээ, хандлага, ховордлын шалтгааны талаар илүү тодорхой мэдээ, баримт хуримтлагдвал дахин үнэлж ховордлын зэрэглэлийг ахиулах боломжтой.
Үнэлгээ хийсэн: Б.Мөнхцог (2025).
Үнэлгээг хянасан: (2025).

Дэлхийн тархац. Канад, Америк, Норвег, Швед, Финланд, Эстони, Орос, Хятад болон Монголд тархсан (https://www.mammaldiversity.org).

Монгол орны тархац, амьдрах орчин. Хэнтий, Хөвсгөлийн ойт хээр, тайгын бүсэд тохиолдоно (Банников, 1954; Дуламцэрэн 1970). Хангай нурууны хойд хэсэг, Монгол Дагуурын хээр, Монгол Алтайн уулсаар хаяа үзэгддэг (Дуламцэрэн нар, 1989).



Амьдралын онцлог. Тэнэмэл амьдралтай. Баян-Өлгий аймгийн Сийлхэмийн нуруунд үүрлэн суурин амьдарч буй бүл бий. Сэг зэмээр хооллоно, жижиг амьтад барьж, шавж иднэ.

Тоо толгой, нягтшил. Тархац нутаг уудам, тоо толгойн элбэг бөгөөд популяцийн тоо хэмжээн буураагүй хэмээн үздэг боловч тусгайлан хийсэн судалгаа, мэдээ, баримт хомс. Популяцийн чиг хандлага болон ховордлын шалтгааны талаарх илүү нарийн мэдээлэл цуглуулах шаардлагатай.

Ховордлын шалтгаан. Монгол орны нөхцөлд нохой зээхийн ховордлын шалтгаан тодорхойгүй.

Гэрийн мал руу довтлох, хавх занганд орсон амьтдыг идэх, агнуурын холбогдолтой шувуу, хөхтөн амьтдыг хороох зэрэг хөнөөл учруулдаг амьтан гэж үздэг.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд тухайлбал, энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2-т зааснаар нохой зээхийг жил бүрийн 2 дугаар сарын 11-ний өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон. Үүнээс гадна, (10.1.2) агнуурын амьтны жим дээр нүх ухах, буу сойх, занга, сааль тавих, (10.1.5) амьтныг агаарын болон авто тээврийн хэрэгслээр хөөх, гэрэлтүүлэх, (10.1.8) ан агнах зориулалтын бус буу, сум хэрэглэх зэрэг арга, зэвсэг хэрэгслээр агнах, барихыг хориглодог.

Мөн Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр нохой зээх 1,410,000 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу).

Энэ зүйлийн тархац нутгийн 14% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн тархац нутаг, биологи, экологи (3.3), популяцийн тоо толгой, нягтшил (3.2) болон аюул занал (3.5) зэргийг нарийвчлан судалж, үүний үндсэн дээр хамгааллын арга хэмжээг тодорхой төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлагатай. Мөн энэ зүйлийн ач холбогдол, танин мэдэхүй, хамгаалахад чиглэсэн мэдлэг, боловсролыг албан болон албан бус сургалтаар олгох (2.1), олон нийтийн мэдээллийн хэрэгслээр (2.2; 2.3) өргөн олон нийтэд сурталчилж, зүй зохистойгоор танин мэдүүлэх нь чухал.

4.72. ӨМХИЙ ХҮРНЭ

Mustela eversmannii (Lesson, 1827)

Баг: Мах идэштэн (Carnivora)
Овог: Суусар (Mustelidae)
Англи нэр: Steppe Polecat
Ижил нэр: *M. larvatus*, *M. lineiventer*, *M. tiarata* (Wilson and Reeder, 2005).



Таних шинж. Биеийн урт 35 см, сүүлний урт 20 см, жин 0.5 кг. Толгой жижиг, хоншоор богиновтор, мохоодуу. Чих том, угаараа өргөн, дэлбэгэрдүү дугуй. Мөчид богино. Сүүл урт сагсгар. Зоо нуруу, биеийн хажуу халиун бор дэвсгэр дээр элдэв хэлбэрийн цайвар толбуудтай. Хүзүү халтар бараан. Хэвэл бараан. Хоолойноос завж, нүдийг дайрсан өргөн бараан зурвастай. Чихалзуураас нүд, чихний завсраар шургасан тууш, тод цагаан зурвас бий. Уруул, эрүү чихний урд тал цагаан (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Тархац нутаг уудам, тоо толгойн элбэг бөгөөд популяцийн тоо хэмжээн буураагүй хэмээн үзэж өмнөх үнэлгээг хэвээр үлдээв.

Үнэлгээ хийсэн: Б.Мөнхцог (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Чех, Польш, Серби, Монтенегро, Словен, Румын, Украйн, Болгар, Беларусь, Орос, Молдова, Казахстан, Хятад, Монгол, Гүрж, Армени, Азербайжан, Туркменистан, Узбекистан, Тажикстан, Киргизстанд тархсан (https://www.mammaldiversity.org).

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол орны баруун өмнөд хэсгээс бусад бүх нутагт тархана. Мөн Хэнтий, Хөвсгөл, Хангай нурууны зарим хэсэг болон Монгол Дагуурын ойт хээрт тохиолдоно (Банников, 1954; Дуламцэрэн, 1970; Соколов и Орлов, 1980). Дов сондуулт хотгор, харгана, хялганат элсэрхэг хээр, заримдаа уулын бэлийн хадтай толгод, сайр, сархиа, задгай ус, баянбүрдийн ойролцоо элдэв мэрэгч, ялангуяа чичүүл, огдой элбэгтэй газар идээшин амьдарна.



Амьдралын онцлог. Голдуу өглөө үдэш, заримдаа өдөр гүйж, элдэв мэрэгч, чичүүл, огдойгоор хооллоно. Өмнөговийн Зүүн сайхан уулын өвөр бэлээс 6-р сард барьсан бодгаль хул чичүүл, Увсын Тэс голын адгаас 11-р сард барьсан бодгаль үхэр огдой идсэн байв. Өмнөговийн Баяндалай сумын нутагт 5-р сард элсэн довцгийн нүхэн үүрэнд 4 сөөдгий тохиолдож байв.

Тоо толгой, нягтшил. Тоо толгой, нягтшилын тухай мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Олон улсын болон орон нутгийн хэмжээнд арьсыг худалдаалах зорилгоор агнана. Агнуурын бэлтгэлээр 1958-1960 онд 6,000 гаруй бодгалийг агнасан (Stubbe, 1965). Бусад зүйлд тавьсан хавх занганд хааяа өртөнө. Мөн уул уурхайн ашиглалт, бэлчээрийн талхагдал, цөлжилт, ган зэрэг хүчин зүйлс сөрөг нөлөө үзүүлнэ.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд тухайлбал, энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2-т зааснаар өмхий хүрнийг жил бүрийн 2 дугаар сарын 11-ний өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон. Үүнээс гадна, (10.1.2) агнуурын амьтны жим дээр нүх ухах, буу сойх, занга, сааль тавих, (10.1.8) ан агнах зориулалтын бус буу, сум хэрэглэх зэрэг арга, зэвсэг хэрэглээр агнах, барихыг хориглодог.

Мөн Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр өмхий хүрэн 42,000 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу).

Энэ зүйлийн тархац нутгийн 12% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн тархац нутаг, биологи, экологи (3.3), популяцийн тоо толгой, нягтшил (3.2) болон аюул занал (3.5) зэргийг нарийвчлан судалж, үүний үндсэн дээр хамгааллын арга хэмжээг тодорхой төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлагатай. Мөн энэ зүйлийг хортон мэрэгчид, шавжийг идэж тоо толгойг хэвийн байлгах, хадлан бэлчээрийг хамгаалах, тариалангийн ургацыг нэмэгдүүлэх зэрэг ач холбогдолтой амьтан гэдгийг иргэд, малчид, аж ахуйн нэгж, байгууллагуудад сайтар ойлгуулах, хамгаалахад чиглэсэн мэдлэг, боловсролыг албан болон албан бус сургалтаар олгох (2.1), олон нийтийн мэдээллийн хэрэгслээр (2.2; 2.3) өргөн олон нийтэд сурталчилж, зүй зохистойгоор танин мэдүүлэх нь чухал.

4.73. ХОТНЫ ЕЕН

Mustela nivalis (Linnaeus, 1766)

Баг: Мах идэштэн (Carnivora)
Овог: Суусар (Mustelidae)
Англи нэр: Least Weasel
Ижил нэр: *M. alpinus*, *M. mictrous*, *M. typicus* (Wilson and Reeder, 2005).



Ангилал зүйн тойм. Ангилал зүйн хувьд маргаан багатай.

Таних шинж. Суусрын овгийн хамгийн жижиг биетэй төлөөлөгч. Биеийн урт 11-26, сүүл 2-7 см, жин 45-200 г. Дулааны улиралд нуруу хэсэг хүрэн бор, хэвлий шаргал туяатай цагаан. Сүүл богино, жигд бор. Сүүлний үзүүр хар биш. Завж бараан толботой. Сэрүүн бүсэд хотны үений өвлийн зүс цав цагаан болно. Тавхай уландаа үстэй (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Тархац нутаг уудам, тоо толгойн элбэг бөгөөд популяцийн тоо хэмжээн буураагүй хэмээн үзэж өмнөх үнэлгээг хэвээр үлдээв.

Үнэлгээ хийсэн: Б.Мөнхцог (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Европын олонх орон (Ирландаас бусад), Африкийн хойд хэсэг, Ази, хойд Америкийн хойд нутгаар болон Японы Хоншу, Хоккайдо аралд тархжээ (Wilson and Reeder, 2005).

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол орны төв болон умард нутгаар нэлээд өргөн тархсан (Банников, 1954; Дуламцэрэн, 1970), Дорнод Монголын тал хээр нутагт элбэг бөгөөд Хангайн нурууны баруун өмнөд хэсэг, Улаанбаатар хотын ойр орчимд тохиолдоно. Цагаан үентэй бараг ижил амьдрах орчинд тохиолдох боловч идэш тэжээлийн хувьд өрсөлдөөн бага.



Амьдралын онцлог. Хоногийн турш идэвхтэй. Ихэвчлэн оготноор хооллоно. Идэш тэжээлээ нөөцөлнө. Эзэмшил нутгийн хэмжээ идэш тэжээлийн хүрэлцээнээс хамаарч хэлбэлзэнэ. Хадны хонгил, завсар, овоолсон чулуун дотор эсвэл нүхэнд үүр засаж орогноно. Ихэвчлэн ганц нэгээрээ амьдарна. Хээл тээх хугацаа 35 орчим хоног. Оготно элбэг жил хоёр, түүнээс ч олон удаа төрнө. Нэг төрөхдөө 3-12 нүдээ нээгээгүй гөлтрөг гаргана (Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Монгол орон даяар хийсэн тоо толгой, нягтшилын судалгааны мэдээ, баримт үгүй.

Ховордлын гол шалтгаан. Ховордлын гол шалтгааны талаарх мэдээ, баримт хангалтгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд тухайлбал, энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2-т зааснаар хотны үенг жил бүрийн 2 дугаар сарын 11-ний өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон. Үүнээс гадна, (10.1.2) агнуурын амьтны жим дээр нүх ухах, буу сойх, занга, сааль тавих, (10.1.8) ан агнах зориулалтын бус буу, сум хэрэглэх зэрэг арга, зэвсэг хэрэгслээр агнах, барихыг хориглодог.

Мөн Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр хотны үен 39,000 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу).

Энэ зүйлийн тархац нутгийн 8% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн тархац нутаг, популяцийн тоо толгой, нягтшил (3.2), биологи, экологи (3.3) болон аюул заналын (3.5) судалгааг нарийвчлан хийж, үүний үндсэн дээр хамгааллын арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлагатай.

4.74. ЦАГААН ҮЕН

Mustela erminea (Linnaeus, 1758)

Баг: Мах идэштэн (Carnivora).
Овог: Суусар (Mustelidae)
Англи нэр: Stoat or Eurasian Ermine
Ижил нэр: *M. alascensis*, *M. herminea*, *M. Vulgaris* (Wilson and Reeder, 2005).





Ангилал зүйн тойм. Ангилал зүйн хувьд маргаан багатай.

Таних шинж. Биеийн урт 16-38, сүүл 6-12 см, жин 350 г. Бие туяхан, урт нарийхан. Мөч богино. Сүүл биеийн уртын 1/3 орчим. Үсэн бүрхүүл өтгөн боловч сахлаг биш. Зуны улиралд нуруу, биеийн хажуу тал боровтор хүрэн, хэвлий шаргалдуу туяатай цайвар. Өвлийн улиралд цасан цагаан болох ба хэвлийн хойд хэсгээр шаргалдуу туяатай. Сүүлний төгсгөлийн хэсэг жилийн бүх улирлын турш хар, хар хүрэн (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).
2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Тархац нутаг уудам, тоо толгойн хувьд буураагүй хэмээн үзэж өмнөх үнэлгээг хэвээр үлдээв.

Үнэлгээ хийсэн: Б.Мөнхцог (2025).
Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Канад, Америкийн Нэгдсэн Улс, Ирланд, Португал, Испани, Франц, Их Британи, Бельги, Нидерланд, Герман, Норвег, Лихтенштайн, Швейцар, Люксембург, Итали, Дани, Австри, Чех, Словени, Хорват, Швед, Польш, Босни Герцеговин, Унгар, Серби, Монтенегро, Словак, Албани, Финланд, Грек, Румын, Македон, Латви, Литва, Эстони, Украйн, Болгар, Беларусь, Турк, Орос, Молдова, Гүрж, Азербайжан, Казахстан, Узбекистан, Афганистан, Пакистан, Тажикстан, Хятад, Энэтхэг, Киргизстан, Балба, Монгол, Японд тархсан (https://www.mammaldiversity.org).

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол орны төв болон баруун хойд нутгаар элбэг, зүүн хэсгийн тал нутгаар ховор тархсан (Банников 1954; Дуламцэрэн, 1970; Соколов и Орлов, 1980).



Амьдралын онцлог. Голдуу оготно, шавж идэштэн, хулгана зэрэг жижиг хөхтнөөр хооллоно. Хаяа гүрвэл, хоёр нутагтан, загас, шувуу зооглох нь ч бий. Бүрэнхий, шөнийн идэвхтэй. Модонд авирч, усанд сайн сэлж чадна. Модны хонгил, нүх, хадны завсар, овоолсон чулуун дотор үүрээ засаж орогноно. Бие гүйцсэн эрийн ангуучлах нутгийн хэмжээ 15-20 га хүрнэ. Гэхдээ идэш тэжээл ховор үед үүнээс ч их байж болно. Ороо нийллэг 3-4-р сард юм уу зуны сүүлээр болно. Хээл тээх далд үетэй. Хавар нэг удаагийн төрөлтөөр дунджаар нүдээ нээгээгүй 5-6 гөлтрөг гаргана (Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Монгол орон даяар өргөн хийгдсэн тархац нутаг, тоо толгой, нягтшил, популяцийн төлөв байдлын судалгааны мэдээ, баримт хомс.

Ховордлын гол шалтгаан. Орон нутаг болон олон улсын хэмжээнд арьсыг худалдаална. Энэ зүйлийг 1958 оноос 1960 оны хооронд жилд 860-1,750 бодгалийг агнаж байжээ (Stubbe, 1965). Олон улсын хэмжээнд арьсыг нь худалдаалсаар байна (Wingard and Zahler, 2006).

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд тухайлбал, энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2-т зааснаар цагаан үенг жил бүрийн 2 дугаар сарын 11-ний өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон. Үүнээс гадна, (10.1.2) агнуурын амьтны жим дээр нүх ухах, буу сойх, занга, сааль тавих, (10.1.8) ан агнах зориулалтын бус буу, сум хэрэглэх зэрэг арга, зэвсэг хэрэгслээр агнах, барихыг хориглодог.

Мөн Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр цагаан үен 39,000 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу).

Энэ зүйлийн тархац нутгийн 10% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн тархац нутаг, популяцийн хэмжээ, төлөв байдал (3.2), биологи, экологи (3.3) болон аюул заналын (3.5) судалгааг нарийвчлан хийж, үүний үндсэн дээр хамгааллын арга хэмжээг тодорхойлж, хэрэгжүүлэх нь зүйтэй.

4.75. ОЙН СОЛОНГО

Mustela sibirica (Pallas, 1773)

Баг: Мах идэштэн (Carnivora)
Овог: Суусар (Mustelidae)
Англи нэр: Siberian Weasel
Ижил нэр: *M. horsfi eldii*, *M. manchurica*, *M. peninsulae* (Wilson and Reeder, 2005).



Ангилал зүйн тойм. Ангилал зүйн хувьд маргаан бага.

Таних шинж. Биеийн урт 25-39 см, сүүл 14-18 см, жин 650-820 г. Өвлийн үсэн бүрхүүл өтгөн, сахлаг, ерөнхий зүс улбар шаргал. Хамар дээгүүрээ бор судалтай, уруул, эрүүн доогууруа цайвар. Зуны зүс арай бараандуу хүрэн болно. Өвөл хөлийн ул үсээр бүрхэгдэнэ. Толгой уртавтар. Зарим бодгалийн хоолой цагаан толботой (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).

2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Тархац нутаг өргөн уудам, тоо толгойн бууруагүй хэмээн үзэж өмнөх үнэлгээг хэвээр үлдээв.

Үнэлгээ хийсэн: Б.Мөнхцог (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Орос, Пакистан, Хятад, Энэтхэг, Балба, Монгол, Бутан, Мьянмар, Өмнөд Солонгос, Хойд Солонгос, Тайланд, Лаос, Вьетнам болон Тайванд тархсан (https://www.mammaldiversity.org).

Монгол орны тархац, амьдрах орчин. Хэнтий, Хангай, Хөвсгөл орчим, Алтайн нурууны баруун хойд хэсгийн ойт нутгуудаар тархсан. Мөн Монгол Дагуурын хээрээр тохиолдоно (Сүхбат, Шагдаржав, 1990).



Амьдралын онцлог. Бүрэнхий, шөнийн идэвхтэй. Жижиг хөхтнөөр голчлон хооллоно. Хамгийн том олз нь хэрэм, чандага туулай. Хоёр нутагтан, мөлхөгч, шувуу зэрэг бусад сээртэн ойн солонгын идэш тэжээлд хоёрдугаар зэргийн холбогдолтой. Өвлийн сүүлч, хаврын эхээр ороо орно. Модонд авирч, усанд сайн сэлнэ. Модны хонгил, унасан дархи, хадан завсар төллөнө. Хээл тээх хугацаа 28-30 хоног. Жилд нэг удаа 2-10 гөлтрөг гаргана. Идэш тэжээл хомсдоход илүү нүүдэл хийх тохиолдол бий (Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Монгол орон даяар өргөн хүрээнд хийгдсэн тархац нутаг, тоо толгой, нягтшил, популяцийн төлөв байдлын талаарх судалгааны мэдээ, баримт хомс.

Ховордлын гол шалтгаан. Олон улсын хэмжээнд арьсыг худалдаалдаг тул хараа хяналтгүй агнана. Ойн булгатай идэш тэжээл, байршил нутгийн төлөө өрсөлдөөнд орно. Байгалийн болон хүний санамсаргүй үйлдлээс улбаатай ой хээрийн түймрийн улмаас түүний амьдрах орчин доройтох нь ховордлын шалтгаан болно.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд тухайлбал, энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2-т зааснаар ойн солонгыг жил бүрийн 2 дугаар сарын 11-ний өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглосон. Үүнээс гадна, (10.1.2) агнуурын амьтны жим дээр нүх ухах, буу сойх, занга, сааль тавих, (10.1.8) ан агнах зориулалтын бус буу, сум хэрэглэх зэрэг арга, зэвсэг хэрэгслээр агнах, барихыг хориглодог.

Мөн Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр ойн солонго 39,000 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу).

Энэ зүйлийн тархац нутгийн 13% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн тархац нутаг, популяцийн хэмжээ, төлөв байдал (3.2), биологи, экологи (3.3) болон аюул заналын (3.5) судалгааг нарийвчлан хийж, үүний үндсэн дээр хамгааллын арга хэмжээг тодорхойлж, хэрэгжүүлэх нь зүйтэй.

4.76. ХЭЭРИЙН СОЛОНГО

Mustela altaica (Pallas, 1811)

Баг: Мах идэштэн (Carnivora)
Овог: Суусар (Mustelidae)
Англи нэр: Mountain weasel or Alpine weasel
Ижил нэр: *M. alpina*, *M. birulai*, *M. raddei* (Wilson and Reeder, 2005).



Ангилал зүйн тойм. Ангилал зүйн хувьд маргаантай асуудал байхгүй.

Таних шинж. Биеийн урт 19-26 см, сүүл 8-15 см, жин 210-255 г. Биеийн хэлбэр, хэмжээгээр ойн солонго болон цагаан үений завсрын шинжтэй. Өвлийн үсэн бүрхүүл богино (тачир), бүрзгэр, ерөнхий зүс цайвар шаргал, хамрын үзүүрээс чихний хоорондох зай хүртэл бор саарал. Уруул, эрүүн доогуураа цайвар. Зуны зүс тод шаргал (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл
Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).
Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Анхааралд өртөхөөргүй (LC) (Clark *et al.,* 2006).
2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Тархац нутаг өргөн уудам, тоо толгойн элбэг бөгөөд популяцийн хэмжээн буураагүй хэмээн үзэж өмнөх үнэлгээг хэвээр үлдээв.
Үнэлгээ хийсэн: Б.Мөнхцог (2025).
Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Орос, Казахстан, Пакистан, Хятад, Энэтхэг, Монгол, Солонгосын хойгт тархсан (https://www.mammaldiversity.org).

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол орны төв болон зүүн хэсгийн ой, тал хээрийн бүсэд элбэг тохиолддог (Банников, 1954; Дуламцэрэн, 1970; Соколов и Орлов, 1980). Монгол Алтай, Хангай, Хөвсгөлийн тайга, ой хээрийн бүсээр тааралдах боловч ховор үзэгдэнэ.



Амьдралын онцлог. Өдөр, шөнийн аль ч үед идэвхтэй. Жижиг хөхтнөөр голчлон хооллоно. Хоёр нутагтан, мөлхөгч, шувуу зэрэг сээртэн хээрийн солонгын идэш тэжээлд хоёрдугаар зэргийн холбогдолтой. Мэрэгчдийн нүх, модны ёроол, хад, чулуун доогуур орогноно. Хурдан харайхаас гадна, мод, бутанд авирч, усанд сайн сэлнэ. Хаврын эхээр ороо орно. Хээл тээх хугацаа 40 орчим хоног. Жилд нэг удаа төллөж, 5-6-р сард 7-8 гөлтрөг гаргана (Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Монгол орны хэмжээнд хийсэн тархац нутаг, тоо толгой, нягтшил, популяцийн төлөв байдлын талаарх судалгааны мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Заарт харх гэх мэт зүйлүүдэд тавьсан хавх занганд орно. 1959-1960 онд жилд 1,000 бодгаль агнаж байжээ (Stubbe, 1965). Одоогоор хууль бус агнуур буурч байгаа ч олон улсад бага хэмжээгээр худалдсаар байна (Wingard and Zahler, 2006).

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд тухайлбал, энэ хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2-т зааснаар агнуурын амьтны жим дээр нүх ухах, буу сойх, занга, сааль тавих, (10.1.8) ан агнах зориулалтын бус буу, сум хэрэглэх зэрэг арга, зэвсэг хэрэгслээр агнах, барихыг хориглосон.

Мөн Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр хээрийн солонго 39,000 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу).

Энэ зүйлийн тархац нутгийн 9% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн тархац нутаг, популяцийн хэмжээ, төлөв байдал (3.2), биологи, экологи (3.3) болон аюул заналын (3.5) судалгааг нарийвчлан хийж, үүний үндсэн дээр хамгааллын арга хэмжээг тодорхойлж, хэрэгжүүлэх нь зүйтэй.

4.77. ХАДНЫ СУУСАР

Martes foina (Erxleben, 1777)

Баг: Мах идэштэн (Carnivora)
Овог: Суусар (Mustelidae)
Англи нэр: Beech Marten
Ижил нэр: Суусар булга, *M. domestica*, *M. intermedia*, *M. rosanowi* (Wilson and Reeder, 2005).



Ангилал зүйн тойм. Ангилал зүйн талаарх баримт хомс.

Таних шинж. Биеийн урт 25-54 см, сүүл 25-35 см, жин 1.1-2.3 кг. Биеийн зүс ерөнхийдөө сааралдуу хүрэн. Мөн чанартаа саарал өнгийн ноолуур сор үсний дундуур нэвт харагдах учир сааралдуу суурьтай хүрэн зүс зонхилно. Өвхий цагаан, хааяа шаргалдуу туяатай байх бөгөөд төгсгөлдөө салаалж, өмнөд мөчиндөө хүртэл үргэлжилнэ. Сүүл болон хөл их биеийн өнгөнөөс илүү бараан. Чихний дэлбэ харьцангуй том.

Үнэлгээ ба үндэслэл
Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).
Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Clark *et al.,* 2006).
2025 онд Анхааралд өртөхөөргүй (LC). Энэ зүйлийн популяцийн тоо толгой, төлөв байдал, хандлага, учирч буй аюулын талаар мэдээ, баримт хангалтгүй боловч тархац нутаг нь өргөн уудам, тохиолдоц нь элбэг тул

энэ зэрэглэлээр үнэлэв.
Үнэлгээ хийсэн: Б.Гантулга, Б.Мөнхцог (2025).
Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Португал, Испани, Франц, Нидерланд, Герман, Лихтенштайн, Швейцар, Люксембург, Итали, Дани, Австри, Чех, Словени, Хорват, Польш, Босни Герцеговин, Унгар, Серби, Монтенегро, Словак, Албан, Грек, Румын, Македон, Украйн, Болгар, Беларусь, Турк, Орос, Молдова, Гүрж, Армен, Иран, Азербайжан, Казахстан, Туркменистан, Афганистан, Пакистан, Хятад, Киргизстан, Балба, Монголд тархсан (https://www.mammaldiversity.org).

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол Алтай, Говь Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говийн уулс, Хан Хөхийн нуруу, Хангайн нуруу, Соёны нуруу, Хорьдол сарьдаг, Нууруудын хөндийн бэсрэг уулс, Умард говь, Дорнод говийн умард хэсгийн уул толгодоор өргөн тархсан (Банников, 1954; Дуламцэрэн, 1970; Chotolchu *et al.,* 1980; Нямзав 2020, 2022). Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийг газраас Алтай болон Соёны нуруудад 2016-2022 оны хооронд 21 ууланд хийсэн автомат камерийн судалгааны үр дүнгээр энэ зүйл нь 245 удаагын тохиолдлоор 21 ууланд бүгдэд нь бүртгэгдсэн бөгөөд нийт зэрлэг амьтдын тохиолдлын 2.41%-ийг эзэлж байсан түгээмэл тархацтай зүйл байв. Хадны суусар нь дундажаар 2410м (SD: 452м) өндөрт хад асга ихтэй газруудад голчлон бүртгэгдсэн бөгөөд тохиолдоцод нь бартаа (хад, асга), өндөршил болон ургамалжилтын индекс гол нөлөө үзүүлж байв (Нямзав 2020, 2022).



Амьдралын онцлог. Ихэвчлэн шөнийн идэвхтэй. Хаяа өдрийн цагаар ч гөрөөлнө. Жижиг мэрэгчдээр голлон хооллох боловч шувуу, шавж, чийгийн улаан, жимс, жимсгэнэ иднэ. Хаданд авирахдаа сайн. Орхигдсон нүх, хадны хонгил, завсарт орогноно. Суурин газарт ч амьдарна. Оroo хөөцөө зун болно. Хээл тээх хугацаа 236-274 хоног. Хавар 4-р сарын сүүлчээр ихэвчлэн 3-4, хаяа 8 хүртэл хойв гаргана. Байгальд 12-14 насална.

Тоо толгой, нягтшил. Энэ зүйлийн популяцийн хэмжээ, тоо толгой, нягтшил, хандлагын талаарх мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Арьсыг нь дотоодод хэрэглэхээс гадна, олон улсын хэмжээнд худалдах зорилгоор хууль бусаар агнана. Өвөлжөөнд нөөцөлсөн идэшний махыг идэх тул хавх, занганд орж эндэх нь элбэг.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуульд заасны дагуу Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор баталсан Ховор амьтны жагсаалтад орсон бөгөөд ховор амьтныг төрийн захиргааны төв байгууллагаас олгосон зөвшөөрлөөр (7.5.1) судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, эмчилгээний зориулалтаар агнаж, барьж болно.

Мөн Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр хадны суусар 945,000 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу).

Энэ зүйлийн тархац нутгийн 21% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн тархац нутаг, популяцийн төлөв байдал (3.2), биологи, экологи (3.3), амьдрах орчин (3.4) болон учирч болзошгүй аюул (3.5, 5.6) зэргийн судалгааг нарийвчлан хийх шаардлагатай. Үүний үндсэн дээр хамгаалллын арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх нь зүйтэй.

4.78. ХЭВЛҮҮН АТААХАЙ

Sorex araneus (Linnaeus, 1758)

Баг: Шавж идэштэн (Eulipotyphla)
Овог: Атаахай (Soricidae)
Англи нэр: Common Shrew
Ижил нэр: *Sorex averini* Zubko, 1937 (Hutterer and Kryštufek, 2016).



Ангилал зүйн тойм. Хромосомын полиморфизм ихтэй. Хромосомын эдгээр хэлбэрийн нэгийг нь саяхан бие даасан зүйл (*S. antinorii*) болгон салгасан (Wilson and Reeder, 2005).

Таних шинж. Биеийн урт 52-82 мм, сүүлний урт 33-52 мм, хойд тавхайн урт 12-14 мм, жин дунджаар 9.9 г. Нурууны хэсэг харавтар бор, бие гүйцсэн бодгалийн нуруу хэвлийн өнгө эрс ялгарна. Хэвлий нь саарал туяа бүхий цайвар. Чих үснээсээ цухуйх төдий. Дээд эрүүний завсрын эхний 3 шүд хэмжээгээрээ ойролцоо (Зайцев и др., 2014; Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Монголд бүртгэгдээгүй байсан.

2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Тархац нутаг хязгаарлагдмал, популяцийн хэмжээ, төлөв байдал, хандлага, энэ зүйлд учирч буй аюул заналын талаарх мэдээ, баримт хангалтгүй тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Д.Лхагвасүрэн, С.Шар, Н.Батсайхан, Э.Ундрахбаяр, Р.Самъяа (2025).
Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Албани, Андорра, Австри, Беларусь, Бельги, Босни Херцеговина, Болгар, Хорват, Чех, Дани, Эстони, Финланд, Франц, Герман, Грек, Унгар, Казахстан, Латви, Лихтенштайн, Литва, Люксембург, Молдова, Монтенегро, Нидерланд, Хойд Македон, Норвег, Польш, Румын, Орос, Серби, Словак, Словени, Испани, Швед, Швейцар, Турк, Украин, Их Британи болон Монголд тархсан (Hutterer and Kryštufek, 2016).

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол оронд Саяны салбар уулс, Дархадын хотгор болон Хөвсгөл нуурын зүүн эрэгт тархжээ. Умард болон сэрүүн бүсийн ой (1.1), ойт хээр, гол, нуурын чийглэг татмын нугад (5.1) тохиолддог (Базардорж нар, 1976; Соколов и Орлов, 1980; Батсайхан нар, 2022).



Амьдралын онцлог. Бүрэнхий, шөнийн идэвхтэй. Нугаламгүй амьтад, гол төлөв шавжаар хооллоно. Ороо нийллэг 5-8-р сард болж, хээлээ 18-28 хоног тээнэ. Жилд 2-3 удаа төрж, төрөх бүрдээ 4-10 гөлчгий гаргана. Байгальд 12-20 сар насална (Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Энэ зүйлийн популяцийн элбэгшил, нягтшилын талаарх судалгааны мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Ой хээрийн түймэр (1.7), хууль бус мод бэлтгэлээс (1.3.3.1) үүдэлтэй амьдрах орчны доройтол, усны бохирдол (6.3.7) зэрэг нь энэ зүйлд сөргөөр нөлөөлж байж болзошгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр хэвлүүн атаахай 5,400 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 61% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн тархац нутаг, популяцийн хэмжээ, төлөв байдал (3.2), биологи, экологи (3.3) болон аюул заналын (3.5) судалгааг нарийвчлан хийж, үүний үндсэн дээр хамгаалллын арга хэмжээг тодорхойлж, хэрэгжүүлэх шаардлагатай.

4.79. АЛТАЙН ЧАЦУУЛИН

Talpa altaica (Nikolsky, 1883)

Баг: Шавж идэштэн (Eulipotyphla)
Овог: Чацуулин (Talpidae)
Англи нэр: Altai Mole
Ижил нэр: *T. gusevi*, *T. irkutensis*, *T. Saianensis, T. salairica, T. sibirica, T. tymensis* (Hutterer, 2005).



Ангилал зүйн тойм. Ангилал зүйн хувьд өөрчлөлт, маргаан багатай.

Таних шинж. Биеийн урт нь толгойн хамт 117-190 мм, сүүлний урт 20-34 мм, хойд тавхайн урт 17-24 мм. Биеийн гадаад төрхөөрөө дагуур номинтой төсөөтэй. Зүс хар хүрэн буюу хар. Үс нь өтгөн, зөөлөн. Өмнөд мөчид малтуур хэлбэртэй, хүчирхэг урт хумстай. Мөчид богино, бахим. Нүд онигор. Дээд эрүүний соёо бусдаасаа илэрхий урт (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Clark *et al.,* 2006).

2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Алтайн чацуулины тархац нутаг хязгаарлагдмал боловч популяцийн хэмжээ, төлөв байдал, хандлагын талаар мэдээ, баримт хангалтгүй байгаа тул өмнөх үнэлгээг хэвээр үлдээв.

Үнэлгээ хийсэн: Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, Р.Самъяа, Э.Ундрахбаяр, С.Шар (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Орос болон Монголд тархсан.

Монгол орны тархац, амьдрах орчин. Хөвсгөл, Монгол Алтайн зүүн умард салбар уулсаар тархсан. Голын хөндий, нуга, ойн цоорхой, захын хөвсгөр зөөлөн, чийглэг хөрстэй газар (5.3) амьдарна (Батсайхан нар, 2022).



Амьдралын онцлог. Хоногийн турш идэвхтэй. Өвөл ичээлэхгүй. Ямагт хөрсөн доор амьдрахдаа идэш тэжээл эрж хөрсийг яргаж, хонгил бэлтгэнэ. Чийглэг хөвсгөр зөөлөн хөрсөнд тэжээлийн нүхээ өнгөцхөн ухах тул бараг гаднаасаа мэдэгдэнэ. Хуурай хатуу хөрсөнд 15-25 см хүртэлх гүнд яргаж, хонгилоор явна. Хөрсний нугаламгүй амьтад, шавжийн авгалдай, ялангуяа чийгийн улаан хорхойгоор зонхилон идээшилнэ. Хээлээ 28-30 хоног тээж, 5-6-р сард 3-6 гөлчгий гаргана. Байгалийн нөхцөлд 4-5 жил орчим насална (Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Монгол оронд энэ зүйлийн тархац нутаг харьцангуй хязгаарлагдмал боловч тухайн орчиндоо элбэг тохиолдоно.

Ховордлын шалтгаан. Малын бэлчээрлэлтээс улбаатай газрын доройтол (1.1.4.1), уур амьсгалын өөрчлөлтөөс (7.1; 7.3) үүдэлтэй амьдрах орчны доройтол нь энэ зүйлд сөргөөр нөлөөлж болзошгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуульд нэн ховор амьтнаар орсон бөгөөд төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр зөвхөн эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх зориулалтаар агнаж, барьж болно (7.2). Үүнээс бусад зориулалтаар нэн ховор амьтныг агнаж бэлтгэсэн арьс, яс, бусад түүхий эдийг худалдах, худалдан авахыг хориглодог (7.3).

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Алтайн чацуулин 15,000 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу).

Энэ зүйлийн тархац нутгийн 43% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн популяцийн хэмжээ, төлөв байдал (3.2), биологи, экологи (3.3) болон аюул заналын (3.5) судалгааг нарийвчлан хийж, үүний үндсэн дээр хамгаллын арга хэмжээг тодорхойлж, хэрэгжүүлэх шаардлагатай. Мөн түүний идээшил амьдрах орчныг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд нэмэлтээр хамруулах нь хамгаллын чухал арга хэмжээ болно.

4.80. САРТГАР ХАМАРТ БАГВААХАЙ

Murina hilgendorfi (Peters, 1880)

Баг: Гардалавчтан (Chiroptera)
Овог: Багваахай (Vespertilionidae)
Англи нэр: Hilgendorf's Tube-nosed Bat
Ижил нэр: Шивэр ацмар, Цорго хамарт багваахай, Сибирь бишгүүрхамарт, Ацай; *Harpiocephalus leucogaster* Kastschenko, 1908; *ssp. Sibirica*; *Murina ognevi* Bianchi 1916; Murina sibirica Kastschenko, 1905.



Ангилал зүйн тойм. Энэ зүйлийг *Murina leucogaster hilgendorfi* салбар зүйлээс бие даасан зүйл болгон салгасан (Yoshiyuki, 1989).

Таних шинж. Биеийн урт 49-60 мм, жин 8.5-11.0 г. Хамрын сүв нь урагш сунасан хоолой хэлбэрийн арьсан гуурсны үзүүрт нээгдэнэ. Чихний орой дугуй, цайвар хүрэн. Чихний цэцэг нарийн урт, шовх үзүүртэй. Далавч богино, өргөн, унжиргүй. Бие нь үсэрхэг, хойд мөч хоорондын сарьсны дээд тал нь нягт шигүү үсээр, доод тал нь сийрэг үсээр бүрхэгдсэн. Нуруу хүрэн саарал, хэвлий үл мэдэг цайвар, үсний үзүүр нь гялгар цагаан сортой (Ариунболд, 2018; Dolch *et al.,* 2021b).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Монголд бүртгэгдээгүй байсан.

2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Монгол оронд энэ зүйл зургаан байршилд тэмдэглэгдээд байгаа бөгөөд түүний тархац нутаг, популяцийн хэмжээ, төлөв байдал, хандлага, учирч буй аюул заналын талаар мэдээ, баримт хомс тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Ж.Ариунболд, Д.Мөнхнаст (2025).

Үнэлгээг хянасан: Н.Батсайхан, С.Гомбобаатар (2025).

Дэлхийн тархац. Орос, Казахстан, Монгол, Зүүн хойд Хятад, Солонгосын хойг болон Япон хүртэл тархжээ (Ариунболд нар, 2015).

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол орны Хэнтий (Мандал, Ерөө гол), Монгол Дагуурын хээрийн Онон, Балж голын савд цөөн тоогоор тэмдэглэгдсэн, хязгаарлагдмал тархацтай, ховор тохиолдох зүйл (Dolch *et al.,* 2021b; Ариунболд нар, 2015). Германы судлаач Беатрикс Вунтке Амарбаясгалан хийдийн ойролцоогоос тэмдэглэжээ (Беатрикс Вунткын аман мэдээ). Сэрүүн бүсийн навчит болон шилмүүст ойд амьдрах (1.4) бөгөөд өвөл агуйд (7.1) ичээлнэ.



Амьдралын онцлог. Идээшлэх үедээ нам нисэж ургамал, газрын гадарга дээрээс шавж барьдаг онцлогтой. Барьсан олзоо сүүлний сарьс, сүүлээрээ тумлайдан хойд мөчид хоорондын сарьсан дотор толгойгоо шургуулан өвөрмөц байдлаар хооллодог (Ариунболд, 2018).

Тоо толгой, нягтшил. Монгол орны хэмжээнд энэ зүйлийн популяцийн тоо толгой, нягтшилын талаарх судалгааны мэдээ, баримт байхгүй.

Ховордлын шалтгаан. Манай орны ойн сангийн хэмжээ буурч, ойн түймэр, хөнөөлт шавжтай химийн аргаар тэмцэж буй зэрэг нь сөрөг нөлөө үзүүлж байх боломжтой. Мөн суурин амьдралтай бөгөөд агуйд ичээлэн амьдрах (Ботвинкин и др., 2003) энэ зүйлд амьдрах орчны алдагдал, мод огтлолт (1.3.3), хортон устгал (5.1), агуйн эвдрэл (7.7), эмгэг үүсгэгч (8.5), аялал жуулчлал (10.1) зэрэг нь сөргөөр нөлөөлж байж болзошгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр сартгар хамарт багваахай 4,700 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 25% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд (тухайлбал, Хан-Хэнтий, Зэд-Хантай-Бүтээлийн нуруу, Ноён уулын дархан цаазат газрууд, Онон-Балжийн байгалийн цогцолборт газар г.м) хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Үндэсний түвшинд бодлогод чиглэсэн зүйлийг хамгаалах эрх зүйн баримт бичгийг боловсруулах (1.2.2.2), шинжлэх ухаанд тулгуурласан хамгааллын арга хэмжээний хүрээнд популяцийн тоо толгой, хэмжээ, хандлага (3.2), биологи, экологи (3.3), өвчин, эмгэг үүсгэгч, шимэгчид (5.5) болон аюул заналын (3.5) судалгааг тусгайлан хийж, үүний үндсэн дээр хамгаалах арга хэмжээг тодорхой төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлагатай.

4.81. ИКОННИКОВЫН БАГВААХАЙ

Myotis ikonnikovi (Ognev, 1912)

Баг: Гардалавчтан (Chiroptera)
Овог: Багваахай (Vespertilionidae)
Англи нэр: Ikonnikov's Myotis
Ижил нэр: Бяцхан багваахай, *Myotis fujiensis* Imaizumi, 1954; *Myotis hosonoi* Imaizumi, 1954; *Myotis ozensis* Imaizumi, 1954; *Myotis yesoensis* Yoshiyuki, 1984.



Ангилал зүйн тойм. *Mystacinus* бүлэгт хамаарах бөгөөд салбар зүйлийн талаар судалгаа хийгдээгүй байна.

Таних шинж. Монгол орны хамгийн жижиг гардалавчтан. Биеийн урт 35-48.5 мм, сүүлний урт 28.7-38.7 мм, шууны урт 31.4-33.8 мм, жин дунджаар 4.9 г. Далавчны сарьс хөлийн хурууны гадна уг орчимд холбогдоно, даравчны угийг дагасан унжир маягийн тод төвгөртэй, чих үзүүрээрээ дугариг, чив маш нарийн, нурууны үс хар хүрнээс улаан хүрэн, хэвлий цайвар бор саарал, нүүрний хэсэг өтгөн шигүү үстэй. Биеийн ерөнхий төрхөөрөө ойсог багваахай болон хээрийн багваахайтай маш төсөөтэй ч үл ялиг жижиг биетэй (Ариунболд, 2018).

Үнэлгээ ба үндэслэл
Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Clark *et al.,* 2006).
2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Энэ зүйлийн тархац, популяцийн хэмжээ, төлөв байдал, хандлага, учирч буй аюул заналын талаарх мэдээлэл дутмаг хэвээр байна.
Үнэлгээ хийсэн: Ж.Ариунболд, Д.Мөнхнаст (2025).
Үнэлгээг хянасан: Н.Батсайхан, С.Гомбобаатар (2025).

Дэлхийн тархац. Зүүн Казахстан, Алтай, Соёны уулс, Тува, Зүүн Сибирь, Байгаль нуурын чанад, Шилка голын хөндий, Уссурын орчим, зүүн ба умард Монгол, Манжуур, зүүн хойд Хятад, Солонгос болон Сахалин, Кунашир, Хоккайдо арлуудад тэмдэглэжээ (Horaček *et al.,* 2000).

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол орны Хянганы уулс (Банников, 1954), Булган аймагт Орхон голын орчимд тэмдэглэжээ (Dolch *et al.,* 2007). Хараа голын эх, Буйр нуур, Онон, Балж гол, Айрхан нуур, Хануйн гол, Ерөө гол, Шоргоолжийн гол, Цөх гол, Зэлтэр гол, Ноён уул, Дархадын хотгор зэрэг газруудад тархсан (Ариунболд, 2018). Ой бүхий нутгаар тархсан бөгөөд ой тайга, ойт хээр, уулын хээр, голын хөндийн хадан хавцал, хайлаас, бургас дагаж байршина. Зуны улиралд модны хөндийд, хааяа байшин барилгад (11.5) орогноно. Өвөл газар доорх агуй (7.1), уурхай, хонгил, хөндийд ичээлнэ (Ариунболд, 2018).



Амьдралын онцлог. Балж голын хөндийд 8-р сарын дунд үед эрэгчин нь эмэгчинтэй хөөцөлдөн нисэж байв. Нар шингэсний дараагаас эргэлттэй тайван нисэж ангуучилна. Цөөн тоогоор тохиолдоно. Биологи бага судлагдсан (Ариунболд, 2018).

Тоо толгой, нягтшил. Монгол орны популяцийн тоо толгой, нягтшилын талаар судалгаа байхгүй.

Ховордлын шалтгаан. Манай орны ойн сангийн хэмжээ буурч, ойн түймэр, хөнөөлт шавжтай химийн аргаар тэмцэж буй зэрэг нь сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Мөн суурин амьдралтай бөгөөд агуйд ичээлэн амьдардаг энэ зүйлд амьдрах орчны алдагдал, мод огтлолт (1.3.3), хортон устгал (5.1), агуйн эвдрэл (7.7), эмгэг үүсгэгч (8.5), аялал жуулчлал (10.1) зэрэг нь сөргөөр нөлөөлнө.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Иконниковын багваахай 4,800 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 30% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд (тухайлбал, Улаан тайга, Хан-Хэнтий, Зэд-Хантай-Бүтээлийн нуруу, Ноён уулын дархан цаазат газрууд, Онон-Балжийн байгалийн цогцолборт газар г.м) хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Үндэсний түвшинд бодлогод чиглэсэн зүйлийг хамгаалах эрх зүйн баримт бичгийг боловсруулах (1.2.2.2), популяцийн тоо толгой, хэмжээ, хандлага (3.2), биологи, экологи (3.3) болон аюул заналын (3.5) судалгааг тусгайлан хийж, үүний үндсэн дээр хамгаалах арга хэмжээг тодорхой төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлагатай.

4.82. БҮРЭНХИЙН ХОНГОР БАГВААХАЙ

Nyctalus noctula (Schreber, 1774)

Баг: Гардалавчтан (Chiroptera)
Овог: Багваахай (Vespertilionidae)
Англи нэр: Noctule
Ижил нэр: Хонгор бүрэнхийч*; Vespertilio noctula* Schreber, 1774.



Ангилал зүйн тойм. Монгол орны баруун өмнөд хил залгаа (Хятадын Шинжаан) нутагт *Nyctalus noctula mecklenzurzevi* Kuzyakin, 1934 гэх салбар зүйл тархсан (Smith *et al.,* 2010) бөгөөд Монгол оронд энэ салбар зүйл тохиолдох боломжтой (Ариунболд, 2018).

Таних шинж. Биеийн урт 60-82 мм, шууны урт 48-58 мм, жин 18-40 г (Павлинов и др., 2002). Монгол оронд тархах гардалавчтануудаас хамгийн том биетэйд тооцогдоно. Эм нь эрээс биеэр том. Үс зөөлөн, өтгөн, урт. Нурууны үс алтан шаргал, хүрэн шаргалаас хар хүрэн, хэвлий цайвар хүрэн (Ариунболд, 2018; Dolch *et al.,* 2021a).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Clark *et al.,* 2006).

2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Энэ зүйлийн дэлхийн тархалтын баруун зах нь Монгол орон болно. Ховд, Үенч голын сав дагуу хоёр

байршилд цөөн бодгаль бүртгэгдсэнээс өөр мэдээлэл үгүй.
Үнэлгээ хийсэн: Ж.Ариунболд, Д.Мөнхнаст (2025).
Үнэлгээг хянасан: Н.Батсайхан (2025).

Дэлхийн тархац. Албани, Андорра, Армени, Австри, Азербайжан, Беларусь, Бельги, Босни Херцеговина, Болгар, Хятад, Хорват, Кипр, Чех, Дани, Ватикан, Унгар, Иран, Ирак, Израил, Итали, Казахстан, Латви, Ливан, Лихтенштайн, Литва, Люксембург, Мальта, Монако, Монтенегро, Марокко, Мьянмар, Голланд, Хойд Македон, Норвег, Оман, Польш, Румын, Орос, Сан Марино, Серби, Словак, Словени, Испани, Швед, Швейцар, Турк, Украйн, Их Британи болон Монголд тархсан (Csorba *et al.,* 2016).

Монгол орны тархац, амьдрах орчин. Алтайн ар говьд Ховд голын хөндийн Онгоцны Улаан уулнаас анх тэмдэглэсэн (Самъяа нар, 1993) бөгөөд Зүүнгарын говьд Үенч голын саваас мөн олджээ (Dolch *et al.,* 2021b). Одоогоор эдгээрээс өөр газарт бүртгэгдээгүй. Голдуу нам дор газрын навчит ойг (1.4) шүтэн байршина. Элдэв барилга байгууламж болон модны хонгилд орогноно. Мөн хүний суурьшилд хурдан дасах ба хот суурин (11.5) газарт үзэгдэх нь түгээмэл (Smith *et al.,* 2010).



Амьдралын онцлог. Бүрэнхий, шөнийн идэвхтэй бөгөөд үдшийн бүрийгээс шөнө дунд хүртэл идэвхтэй ангуучилна. Өндөрт хурдан шаламгай нисэж гөрөөлөх ба дунд зэргийн биетэй цох, эрвээхэй, хос далавчтан, хоовгоно зэрэг шавжаар хооллоно.
Хүнд сонсогдохуйц дуу авиа гаргана. Ганц нэгээр байршихаас гадна, 100 хүртэл тоотой бөөгнөрөл үүсгэнэ. Эм сармаахай жил бүрийн 6-р сарын дунд, 7-р сарын эхээр 2-3 зулзага төрүүлнэ. Алс хол зайд нүүдэл хийнэ (Smith *et al.,* 2010; Ариунболд, 2018).

Тоо толгой, нягтшил. Монгол орны баруун хэсэгт хоёр байршилд 1974 -2010 онд нийт 11 бие гүйцсэн бодгаль (10 эр, 1 эм) тэмдэглэсэн (Самъяа нар, 1993; Ариунболд, 2018; Dolch *et al.,* 2021b) бөгөөд түүний тоо толгой, нягтшилын талаар мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Амьдрах орчны алдагдал (1), уул уурхай (1.3.1), ган (7.1) зэрэг сөргөөр нөлөөлнө.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Бүрэнхийн хонгор багваахай 4,700 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэг Хар-Ус нуур болон Булган гол-Их Онгогийн байгалийн цогцолборт газруудад хамрагдсан.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн тархац нутаг, амьдрах орчин, популяцийн тоо толгой, хэмжээ, хандлага (3.2), биологи, экологи (3.3) болон аюул заналын (3.5) судалгааг тусгайлан хийж, үүний үндсэн дээр хамгаалах арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлагатай. Мөн гардалавчтаны байгальд гүйцэтгэх үүрэг, ач холбогдлыг олон нийтэд сурталчлан таниулах нь хамгаалах үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой.

4.83. ХОЖУУ САРМААХАЙ

Cnephaeus pachyomus (Tomes, 1857)

Баг: Гардалавчтан (Chiroptera)
Овог: Багваахай (Vespertilionidae)
Англи нэр: Mouse-like Serotine
Ижил нэр: Хожуу сарсаахай, *Vespertilio turcomanus* (Eversmann, 1838).



Ангилал зүйн тойм. Палеарктикын *Eptesicus* төрөлд хамаарч байсан зүйлүүдийг *Cnephaeus* төрөлд хамааруулан ангилах болсон (Claudio *et al.,* 2023). Мөн *E. serotinus pachyomus* салбар зүйлийг морфологи, филогенетик, генетик (mDNA, nuDNA)-ийн өгөгдөлд тулгуурлан *E. pachyomus* (Tomes, 1857) гэж бие даасан зүйл болгосон (Juste *et al.,* 2013; 2022).

Таних шинж. Төрөл дотроо том биетэй, биеийн урт 60-74 мм, шууны урт 46-55 мм, жин 13-20 г. Унжир тааруу хөгжилтэй, тэвх тод ажиглагдахгүй. Сүүлний үзүүрийн хоёр нугалам сарьстай холбогдоогүй. Биеийн зүс цайвраас ухаа шаргал, нуруу хул шаргал бөгөөд уг, үзүүрийн өнгө үл ялгарна. Өехий цайвар (Ариунболд, 2018; Dolch *et al.,* 2021a).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Үнэлэх боломжгүй (NA) (Clark *et al.,* 2006).

2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Хожуу сармаахай Алтайн өвөр говь, Борзонгийн говьд Зулганайн баянбүрд, Бяруухайн булаг, Дэлийн ус зэрэг цөөн тооны газарт бүртгэгдсэн. Энэ зүйлийн тархац нутаг хязгаарлагдмал, тоо толгойн цөөн, ховор тохиолдох зүйл. Энэ зүйл сармаахайн дэлхийн болон Монгол орон дахь популяцийн хэмжээ тодорхойгүй.

Үнэлгээ хийсэн: Ж.Ариунболд, Д.Мөнхнаст (2025).

Үнэлгээг хянасан: Н.Батсайхан, С.Гомбобаатар (2025).

Дэлхийн тархац. Хятад, Тайван, Лаос, Мьянмар, Тайланд, Вьетнам, Энэтхэг, Пакистан, Иран болон Монголд тархсан (Srinivasulu *et al.,* 2019b).

Монгол орны тархац, амьдрах орчин. Алтайн өвөр говь, цөлийн бүсэд ус бүхий уулсын хавцал (6), баянбүрд (5.9) бараадан хад, модны хонгил, агуй (7.1), өвөлжөө, хашаа саравч (11.2), элдэв төрлийн байгууламжид орогноно. Тодруулбал, одой хайлаас (*Ulmus pumila*), тоорой (*Populus diversifolia*), заг (*Haloxylon ammodendron*), олон цэцэгт сухай (*Tamarix ramosissima*) бүхий (3.4.) амьдрах орчныг шүтэн байршина.



Амьдралын онцлог. Манай орны тодорхой бүс нутагт цөөн тоогоор тэмдэглэгдсэн, хязгаарлагдмал тархацтай, ховор зүйл. Эм бодгалиуд бөөгнөрч элдэв барилгын дээвэр зэрэгт орогноно. Зун 7-р сард эр, эм бодгаль тусдаа амьдарна (Dolch *et al.,* 2017; Ариунболд, 2018; Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Дэлхийн болон Монгол орон дахь энэ зүйлийн популяцийн хэмжээ, хандлага тодорхойгүй.

Ховордлын шалтгаан. Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэгт уул уурхайн үйл ажиллагаа явагдаж, мөн уур амьсгалын өөрчлөлтөөс улбаатай говийн баянбүрд хатаж, хуурайшиж байгаа нь түүний амьдрах орчныг доройтуулж байна. Зарим эм бодгалиуд элдэв барилга байшингийн дээвэрт орогнодог (Ариунболд, 2018) нь гэрийн муур, хүний сөрөг нөлөөнд өртөх эрсдэлийг нэмэгдүүлнэ. Түүнчлэн тохиолдлын үхэл хорогдол (4.1), дэлхийн дулаарал (6.1.1), ган (7.1), шуурга (7.2), гадаргын усны хомсдол (7.7), махчид (8.2) зэрэг нь түүнд сөргөөр нөлөөлнө.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр хожуу сармаахай 4,500 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 10% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд (тухайлбал, Говийн Бага дархан цаазат газар, Говь Гурвансайханы байгалийн цогцолборт газар, Тост, Тосонбумбын нурууны байгалийн нөөц газар г.м) хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн тархац нутаг, популяцийн тоо толгой, хэмжээ, хандлага (3.2), биологи, экологи (3.3), өвчин, эмгэг үүсгэгч, шимэгчид (5.5.) болон аюул заналын (3.5) судалгааг тусгайлан хийж, үүний үндсэн дээр хамгаалах арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх нь чухал. Түүнчлэн хүнээс үзүүлэх сөрөг нөлөөг багасгах, олон нийтийг зөв мэдлэг, мэдээллээр хангах үйл ажиллагааг зохион байгуулах, мөн хуурай, гандуу бүс нутгийн уст цэгийг хашиж, хамгаалах шаардлагатай.

4.84. МАНЖУУР НОМИН

Myospalax psilurus (Milne-Edwards, 1874)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Сохор номин (Spalacidae)
Англи нэр: North China Zokor
Ижил нэр: *M. epsilanus*, *M. spilurus* (Musser and Carleton, 2005).



Ангилал зүйн тойм. Ангилал зүй нь Огнев (1947)-оос хойш өөрчлөлт ороогүй.

Таних шинж. Бие бахим. Биеийн урт 198-223 мм, сүүлний урт 33-54 мм, тавхайн урт 30-37 мм, жин 280-350 г. Зоо нуруу үнсэн саарал. Толгой том, хоншоор өргөн, дух цайвар толботой. Сүүл нүцгэн. Урд мөч хүчирхэг, шүдтэй малтуур хэлбэртэй, харьцангуй урт, махир хумстай. Үүдэн шүдний (I1) дотор тал ухаадастай (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Clark *et al.,* 2006).

2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Популяцийн тоо толгойн өөрчлөлтийн талаарх мэдээлэл хангалтгүй тул мэдээлэл дутмаг хэмээн үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, Р.Самъяа, Э.Ундрахбаяр, С.Шар (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Хятад, Орос болон Монголд тархсан.

Монгол орны тархац, амьдрах орчин. Хянганы салбар уулсын өрнөд этгээдэд Нөмрөг голын сав газраар тархсан. Голын хөндийн нуга, нугажуу хээр, элсэрхэг хөрстэй нам ухаа гүвээгээр (4.4, 5.3) илүү байршимтгай.



Амьдралын онцлог. Өглөө, оройн цагаар шороогоо идэвхтэй түрнэ. Бүлээр амьдарна. Хөрсөн доор яргаж, урт, олон салаа хонгил ухаж амьдарна. Хонгилын гүн хатуу хөрстэй газар 20-40 см хүрнэ. Урт хонгил ухаж, дээш түрж гаргасан хөрс шороо нь цувраа олон жижиг овоолго үүсгэнэ. Нягтшил элбэг үед хааяагүй олон овоолго ажиглагдана. Овоолгын өндөр 40-50 см хүрнэ. Хааяа гадаргууд ил гарна.
Элдэв ургамлын үндэс, үндэслэг иш зэрэг газрын доорх ургал хэсгээр хооллоно. Эм бодгаль жилд нэг удаа 5-6-р сард 2-4 гөлчгий төрүүлнэ (Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Популяцийн элбэгшил, нягтшил зарим жил олширч уудам газар идэвхтэй овоолго гаргадаг.

Ховордлын шалтгаан. Шалтгаан тодорхойгүй боловч зарим гандуу жил хээрийн түймэрт (7.4) түүний амьдрах орчин нь өртөнө.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Манжуур номин 5,400 төгрөг. Энэ зүйлийн тархац нутаг бүхэлдээ улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн популяцийн төлөв байдал (3.2), биологи, экологи (3.3), учирч болзошгүй эрсдэл, аюулын (3.5) талаар тусгайлан судалгаа хийх шаардлагатай. Мөн түймрийн эрсдэлээс (4.1, 4.2) урьдчилан сэргийлсэн арга хэмжээг зохион байгуулах нь нэн чухал.

4.85. УМАРДЫН ОГОТНО

Alexandromys (Microtus) middendorffii (Poljakov, 1881)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Шишүүхэй (Cricetidae)
Англи нэр: Mongolian Vole
Ижил нэр: *Arvicola middendorffii* Poljakov, 1881; *Microtus hyperboreus* Vinogradov, 1934; *Microtus middendorffi* (Poliakov, 1881).



Ангилал зүйн тойм. *Өмнө нь энэ зүйл оготныг Microtus төрөлд хамааруулж байсан бөгөөд сүүлийн үеийн молекул биологийн судалгаанд үндэслэн Alexandromys төрөлд хамааруулан ангилах болсон* (Liu *et al.,* 2016). Дэлхийд 3 *салбар зүйл бүртгэгдээд байгаа бөгөөд Монгол оронд A. m. middenfdorffii* Poljakov, 1881 *гэх салбар зүйл тохиолддог (Shenbrot and Krasnov, 2005; Wilson et al., 2017).*

Таних шинж. Биеийн урт 99-150 мм, сүүл 21-42 мм, чих 10-15 мм, тавхайн урт 15-22 мм, жин 20-70 г. Эр нь эмээсээ биеэр том. Нуруу болон толгойн дээд хэсэг нь цайвар улаавтар бороос хар хүрэн. Хэвлий үнсэн саарал, хар саарал. Сүүлний дээд, доод талын өнгө эрс ялгарна (Wilson *et al.,* 2017).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Монголд бүртгэгдээгүй байсан.

2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Монгол орны Хөвсгөл нуурын хойд хэсэгт нэг л удаа тэмдэглэгдсэн, тархац нутаг, тоо толгойн өөрчлөлт, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй байгаа тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Д.Лхагвасүрэн, С.Шар, Н.Батсайхан, Э.Ундрахбаяр, Р.Самъяа (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Орос болон Монголд тархсан (Moroldoev, 2024).

Монгол орны тархац, амьдрах орчин. Хөвсгөл нуурын хойд хэсэг Жаргалант голын доод хэсгийн жижиг Хөх нуур орчим бүртгэгдсэн (Moroldoev, 2024). Ой (1.1), ойт хээрийн (1.4) амьтан. Ойн зах, голын эргийн ургамлан нөмрөг сайтай чийглэг хөрстэй орчныг дагаж байршина (Wilson *et al.,* 2017; Moroldoev *et al.,* 2024).



Амьдралын онцлог. Хоногийн турш идэвхтэй хэдий ч зуны цагт ихэвчлэн шөнийн идэвхтэй. Нүхний байгууламж нь энгийн бүтэцтэй. Жилийн дулааны улиралд 5-8-р сарын хооронд хэд хэдэн удаа үржилд орно. Нэг удаа 1-11 (дунджаар 4.5-9) гөлчгий төрүүлнэ. Идэш тэжээлийн бүрэлдэхүүнд олон зүйл ургамал орох боловч ургамлын ногоон хэсгийг дуртай иднэ. Өвөлд бага зэрэг тэжээл нөөцөлнө (Tsytsulina *et al.,* 2016; Wilson *et al.,* 2017).

Тоо толгой, нягтшил. Энэ зүйлийн тоо толгой, нягтшилын талаар мэдээ, баримт байхгүй.

Ховордлын шалтгаан. Байгалийн (7.4) болон хүний санамсаргүй үйлдлээс үүдэлтэй түүмрийн (10.5) улмаас орчны хомсдол нүүрлэх боломжтой боловч энэ зүйлийн ховордлын шалтгааны талаарх мэдээлэл хангалтгүй байна.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутаг бүхэлдээ улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Популяцийн тоо толгой, нягтшил (3.2), ангилал зүй (3.1), биологи, экологи (3.3) болон аюул заналын (3.5) судалгааг нарийвчлан хийх шаардлагатай.

4.86. БАРААН ОГОТНО

Microtus arvalis (Pallas, 1778)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Шишүүхэй (Cricetidae)
Англи нэр: Common Vole
Ижил нэр: *Mus arvalis* (Pallas, 1779), *M. arvensis*, *M. meridianus*, *M. Terrestris* (Wilson and Reeder, 2005); *M. arvensis* Schinz, 1840 (pro arvalis Pallas, 1778); *M. brevirostris* Ognev, 1924; *M. caucasicus* Satunin, 1896; *M. duplicatus* Miller, 1912; *M. ghalgai* Krassovsky, 1929; *M. macrocranius* Ognev, 1924; *M. obscurus* Eversmann, 1841; *M. ruthenus* Ognev, 1950; *M. transuralensis* Serebrennikov, 1929; *M. vulgaris* Desmarest, 1822 (Павлинов и Лисовский, 2012).



Ангилал зүйн тойм. Ангилал зүйн өөрчлөгдөөгүй. Харин M.arvalis нь *M.obscurus*-тай генетикийн хувьд бага ялгаатай боловч бие даасан зүйл (Булатова и др., 2013; Mahmoudi *et al.,* 2017) гэжээ.

Таних шинж. Биеийн урт 130 мм, сүүл 50 мм хүрнэ. Нуруу саарал дэвсгэр өнгө зонхилох боловч бор хүрэн, улаан өнгийн туяа илэрнэ. Эрс тэс уур амьсгалтай нутагт том биетэй салбар зүйлүүд тархана. Нүдний ухархай хооронд хянгагүй (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл
Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).
Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Clark *et al.,* 2006).
2025 онд Мэдээлэл дутмаг (DD).

Энэ зүйлийн Монгол орон дахь тархац төдийлөн өргөн бус, популяцийн хэмжээ, тоо толгойн мэдээлэл хангалтгүй тул мэдээлэл дутмаг хэмээн үнэлэв.

Үнэлгээ хийсэн: С.Шар, Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, Э.Ундрахбаяр, Р.Самъяа (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Албани, Андора, Австри, Беларусь, Бельги, Босни Херцеговина, Болгар, Хорват, Чех, Дани, Эстони, Финлянд, Франц, Герман Унгар, Итали, Люксембург, Латви, Литва, Македони, Молдова, Нидерланд, Польш, Румын, Орос, Серби Монтенегро, Словени, Словак, Испани, Швейцар, Украин, Их Британи болон Монголд тархсан (Amori *et al.,* 2024; https://www.mammaldiversity.org).

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол орны баруун, баруун хойд хэсэгт тэмдэглэгдсэн (Соколов и др., 1985). Монгол Алтайн нурууны төв хэсэг, түүний салбар уулс, Хангайн нурууны умард салбар уулс, Хөвсгөлийн Дархадын хотгороор тархсан (Батсайхан нар, 2022). Ойт хээр, хээр, нам уулсын хээрт (4.4) чийглэг орчинд тархана.



Амьдралын онцлог. Колони үүсгэн бүлээр амьдарна. Нийлмэл бүтэцтэй олон амсартай үлийд орогноно. Идэш тэжээлийн бүрдэл жилийн улирал, амьдарч байгаа нутгийн байгалийн онцлогоос хамаарч хэлбэлзэнэ. Зуны улиралд ургамлын ногоон хэсгээр, харин өвөл, хаврын улиралд үндэсний хэсгээр голлон хооллоно. Нэг удаад 5-7 гөлчгий гаргана (Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Энэ зүйлийн популяцийн тоо толгой, нягтшилын талаарх мэдээ, баримт хангалтгүй.

Ховордлын шалтгаан. Ховордлын шалтгаан тодорхойгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр бараан оготно 3,800 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 27% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн тархац нутаг, амьдрах орчин, популяцийн хэмжээ, төлөв байдал, хандлага (3.2), биологи, экологи (3.3) болон аюул заналын (3.5) судалгааг тусгайлан хийж, үүний үндсэн дээр хамгаалах арга хэмжээг тодорхойлж, хэрэгжүүлэх шаардлагатай.

4.87. УЛИЙН БОР ОГОТНО

Lasiopodomys mandarinus (Milne-Edwards, 1871)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Шишүүхэй (Cricetidae)
Англи нэр: Mandarin Vole
Ижил нэр: *L. kishidai*, *L. pullus*, *L. Vinogradovi* (Wilson and Reeder (2005); *Microtus mandarinus* Milne-Edwards, 1871; *Arvicola mandarinus* Milne-Edwards, 1871; *L. mandrianus*; *L. vinogradovi* Fetisov, 1936 (Павлинов и Лисовский, 2012).



Ангилал зүйн тойм. Генетикийн хувьд болон морфологийн хувьд *Lasiopodomys brandtii* зүйлтэй ойролцоо. Түүнийг экологи, зан төрхийн шинжид үндэслэн өөр салбар төрөлд хамааруулсан (Громов и Ербаева, 1995).

Таних шинж. Биеийн урт 116 мм, сүүл 25 мм хүрнэ. Нуруун тал бараандуу бор. Сор үсний төгсгөл хар. Сүүлний дээд тал боровтор, доод тал нь цайвар шаргал. Нүдний ухархай хооронд хянга илрэхгүй (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Clark *et al.,* 2006).

2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Энэ зүйлийн тархац нутаг, тоо толгой, нягтшилын талаарх мэдээ, баримт хангалтгүй тул мэдээлэл дутмаг хэмээн үнэлэв.

Үнэлгээ хийсэн: С.Шар, Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, Э.Ундрахбаяр, Р.Самъяа (2025). b

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Хятад, Монгол, Хойд Солонгос, Өмнөд Солонгост тархсан (Batsaikhan *et al.,* 2016; https://www.mammaldiversity.org).

Монгол орны тархац, амьдрах орчин. Орхон, Сэлэнгийн сав, Хангай нуруунаас олдсон. Монгол орон дахь тархцын судалгаа маш бага. Одоогоор Хангайн нурууны зүүн умард хэсэгт зурвас газар тархсан (Батсайхан нар, 2022). Орхон, Сэлэнгийн сав газарт алаг өвс-үетэнт хээрт (4.4) амьдарна.



Амьдралын онцлог. Оготнууд дотроос газрын доорх амьдралтай өвөрмөц зүйл. Ургамлын үндэс, ялангуяа далан түрүүний үндсийг сорчлон иднэ. Идэш тэжээл нөөцөлнө. Идэш тэжээлдээ хүрэх газрын доорх хонгил жимтэй.

Тоо толгой, нягтшил. Популяцийн тоо толгой, нягтшилын мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Сүүлийн жилүүдэд малын тоо өссөний улмаас бэлчээрийн талхагдлын (1.1.4.1) нөлөөгөөр амьдрах орчин нь хомсдож (1.1) болзошгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр үлийн бор оготно 4,000 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 9% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн тархац нутаг хязгаарлагдмал, популяцийн хэмжээ, тоо толгой тодорхойгүй тул энэ чиглэлээр популяцийн төлөв байдал (3.2), биологи, экологи (3.3) болон аюул заналын (3.5) судалгааг тусгайлан хийж, үүний үндсэн дээр хамгаалах арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай.

4.88. ХӨХ ОВ

Lagurus lagurus (Pallas, 1773)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Шишүүхэй (Cricetidae)
Англи нэр: Steppe Lemming or Steppe Vole
Ижил нэр: *L. abacanicus* Serebrennikov, 1929; *L. agressus* Serebrennikov, 1929; *L. migratorius* Gloger, 1841; *L. saturatus* Ognev, 1950 (Павлинов и Лисовский, 2012) *Mus lagurus* (Pallas, 1773).



Ангилал зүйн тойм. Ангилал зүйн маргаан үгүй. Морфологи болон генетик үзүүлэлтээрээ *Eolagurus* Argyropulo, 1946 төрөлтэй илүү ойр. Монголд *L. l. altorum* (Thomas, 1912) салбар зүйл тархсан.

Таних шинж. Биеийн урт 125 мм, сүүл 15 мм, жин 40 г. Биеийн гадаад галбир, богино сүүл зэргээрээ хөвхөлжинтэй төсөөтэй. Зоо нуруу бараан саарал, бор шаргал, элсэн шаргал, хэвлий шаргал туяатай цайвар саарал. Нурууны голоор үргэлжлэх тод хар судал бүх насны бодгальд илэрнэ. Чих богино, үсэн бүрхүүлээс дөнгөж цухуйна (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл
Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Clark *et al.,* 2006).
2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Энэ зүйлийн тархац нутаг хоорондоо тусгаарлагдсан хэд хэдэн тасархай хэсгээс бүрдэнэ. Популяцийн төлөв байдал, тоо хэмжээ, аюулын талаар шинэ мэдээлэл хангалтгүй тул өмнөх үнэлгээг хэвээр үлдээв.
Үнэлгээ хийсэн: Р.Самъяа, Н.Батсайхан, С.Шар, Д.Лхагвасүрэн, Э.Ундрахбаяр (2025).
Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Украйны нутаг дахь Днепр мөрний хөндий, Казахстаны Балкаш нуурын зүүн хэсэг, Зайсан нуур, Алатау, Тарвагатай, Тэнгэр уулын орчим, Киргизын Иссык-кул нуур, Орост Уралын өмнөд хэсгээс Алтай, Тува хүртэл, Хятадын Шинжааны баруун хойд хэсэг, Монголд тархсан (Павлинов и Лисовский, 2012; Smith and Yan 2013; Kryštufek *et al.*, 2022).

Монгол орны тархац, амьдрах орчин. Зүүнгарын говь, Увс нуурын хотгор, Шаргын говь, Тамчийн даваа зэрэг газраас бүртгэгдсэн (Соколов и др., 1980; Лебедев и др., 2019; Батсайхан нар, 2022). Хуурай хээр, цөлжүү хээр, цөлийн (8.3) наанги хөрстэй хотгор, нам толгод хоорондын сөөг, сөөгөнцөр ургамалтай хөндий даган байршина (Батсайхан нар, 2022).



Амьдралын онцлог. Бүлээр томоохон суурьшил үүсгэнэ. Газрын өнгөн хэсэгт олон салаалсан нийлмэл бүтэцтэй нүхэнд орогноно. Үржил хавар эрт эхэлж намрын сүүл хүртэл үргэлжилнэ. Жилд 2-4 (Батсайхан нар, 2022), заримдаа 6 хүртэл (Павлинов и др., 2002) төллөнө. Нэг удаад ихэвчлэн 5-7 зулзага төрүүлнэ. Ургамлын ногоон хэсэг, үндсээр хооллоно. Тоо толгойн хэлбэлзэл тод илэрнэ. Тоо толгой ихэссэн үед нүүдэллэнэ.

Тоо толгой, нягтшил. Энэ зүйлийн тоо толгой, нягтшилын талаарх мэдээ, баримт хомс. Тоо толгойн хэлбэлзэл ихтэй. Одоогоор манай орны хэмжээнд өөр хоорондоо тусгаарлагдаж тасархайтсан цөөн газар тохиолдоно.

Ховордлын шалтгаан. Энэ зүйлийн тархац нутгийн зарим хэсэгт малын тоо толгой өссөнөөс үүсэх орчны доройтол (1.1.4.1) болон зарим зүйлийн мэрэгчидтэй нөөцийн төлөөх өрсөлдөөн (8.1) ховордлын шалтгаан байж болзошгүй. Булаг шандын ширгэлт, олон жил дараалсан ган (7.1) энэ зүйлд аюул учруулах магадлалтай. Тусгаарлагдсан жижиг популяцийн тооны хэлбэлзэл (9.1-9.5) эрсдэл үүсгэнэ.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр хөх ов 3,800 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 36% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд (тухайлбал, Говийн Их дархан цаазат газрын Б хэсэг, Шаргын нөөц газар, Булган гол-Их Онгогийн байгалийн цогцолборт газар, Увс нуурын ай савын дархан цаазат газар г.м) хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Хамгааллын статусыг тодорхой болгохын тулд популяцийн төлөв байдал (3.2), үржил, экологи (3.3) амьдрах орчин (3.4), учирч байгаа аюул занал (3.5) зэргийг нарийвчлан судлах шаардлагатай. Үүний үр дүнд үндэслэн хамгаалах арга хэмжээг тодорхойлж, оновчтой төлөвлөх боломжтой болно.

4.89. УСЧ ОГОТНО

Arvicola amphibius (Linnaeus, 1758)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Шишүүхэй (Cricetidae)
Англи нэр: Eurasian Water Vole
Ижил нэр: *Arvicola terrestris* Linnaeus, 1758; *Mus amphibius* Linnaeus, 1758.



Ангилал зүйн тойм. Усч оготнын (*A. amphibius*) бүлгийн амьтдын ангилал зүй нэлээд ээдрээтэй. Генетик болон биологийн судалгаанд үндэслэн *Arvicola italicus*-ийг бие даасан зүйл болгон салгасан (Castiglia *et al.,* 2016).

Таних шинж. Биеийн урт 240-250 мм, сүүл 90-130 мм, жин 150-350 г. Евразийн уугуул оготнын дотроос хамгийн том биетэй төлөөлөгч. Биеийн хэмжээ, өнгө зүсний хувьд ихээхэн хувьсамтгай, полиморф зүйл. Нуруун жигд хар бор, хар зүстэй. Үсэн бүрхүүлд ноолуур, сор үс сайн ялгарна. Хэвлий цайвардуу. Урт сүүл нь сийрэг, ширүүн үсээр бүрхэгдэнэ. Хойд хөлийн тавхайн хоёр хажуугаар өтгөн ширүүн үстэй байх нь сэлэхэд тустай. Үүдэн шүдний гадарга шар (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Clark *et al.,* 2006).
2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Энэ зүйлийн тархац хязгаарлагдмал, популяцийн тоо толгойн өөрчлөлтийн хандлага, учирч буй аюулын талаарх мэдээлэл хангалтгүй тул энэ зэрэглэлээр үнэлэв.
Үнэлгээ хийсэн: Д.Лхагвасүрэн, С.Шар, Н.Батсайхан, Э.Ундрахбаяр, Р.Самъяа (2025).
Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Афганистан, Албани, Армен, Австри, Азербайжан, Беларусь, Бельги, Босни Херцеговина, Болгар, Хятад, Хорват, Чех, Дани, Эстони, Финланд, Франц, Гүрж, Герман, Грек, Унгар, Иран, Исламын Бүгд Найрамдах Улс, Ирак, Израил, Итали, Казахстан, Латви, Лихтенштайн, Литва, Люксембург, Молдова, Монтенегро, Нидерланд, Хойд Македон, Норвег, Польш, Румын, Орос, Серби, Словак, Словени, Швед, Швейцар, Сири, Турк, Украин, Их Британи болон Монголд тархсан (Gazzard, 2023).

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол Алтайн нурууны баруун болон умард, Хөвсгөлийн ойт бүс нутгаар (1.4) тархсан.



Ус бараадаж амьдарна (5.1-5.3). Усанд сэлж, шумбах чадвартай. Амьдрах орчноо улирлаар сольдог онцлогтой. Өөрөөр хэлбэл, дулааны улиралд усны ойролцоо, өвөл хуурай газарт амьдарна (Батсайхан нар, 2022).

Амьдралын онцлог. Хоногийн турш идэвхтэй. Гэхдээ дулааны улиралд бүрэнхийн болон шөнийн цагт илүү идэвхтэй. Усны болон намгархаг газрын ургамлаар голлон хооллоно. Амьтны гаралтай зүйл бага хэрэглэнэ. Хуурай газар нүх ухаж үүр ноохой бэлтгэнэ. Өтгөн зэгс шагшуургатай газар хөвдөг үүр засах ч тохиолдол бий. Өвөлд идэш тэжээл нөөцөлнө. Үржлийн хугацаа 3-10-р сарын хооронд үргэлжлэх боловч газар бүр харилцан адилгүй. Хээл тээх хугацаа 21-22 хоног. Жилд 2-5 удаа төрөх бөгөөд нэг удаадаа 2-10 гөлчгий гаргана. Гөлчгий нь 3 долоо хоногийн настайгаас эхлэн бие дааж амьдарна. Байгальд 4 хүртэл насална (Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Тоо толгой, нягтшилын судалгаа байхгүй.

Ховордлын шалтгаан. Энэ зүйлийн ховордлын шалтгааны талаарх мэдээ, баримт хангалтгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр усч оготно 3,800 төгрөг. Энэ зүйлийн тархац нутгийн 35% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн популяцийн тоо толгой, нягтшил (3.2), ангилал зүй (3.1), биологи, экологи (3.3) болон аюул заналын (3.5) судалгааг тусгайлан хийж хамгаалах арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай.

4.90. ДОРНЫН СОХДОЙ

Ellobius (talpinus) orientalis (Pallas, 1770)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Шишүүхэйн (Cricetidae)
Англи нэр: Northern Mole Vole
Ижил нэр: *E. kastschenkoi*, *E. ognevi*, *E. ursulus* (Wilson and Reeder, 2005).



Ангилал зүйн тойм. Филогенетикийн судалгааны үр дүнгээр Монгол орны умард говь, Дорно говьд тархсан хэсгийг *Ellobius tancrei stricto*-аас салгаж *Ellobius* (*talpinus*) *orientalis хэмээх бие даасан* зүйл болгосон (Lebedev *et al.,* 2020).

Таних шинж. Мөч сүүл бахим, богино. Өмнөд мөч урт хумстай. Нүд жижиг, чихний дэлбэгүй. Өтгөн жигд үсэн бүрхүүлтэй. Нурууны өнгө бор шаргал, хэвлий цайвар. Үүдэн шүд дорсгор уруулаас илүү гарна. *Ellobius tancrei* зүйлээс зүс ухаа цайвар бөгөөд морфологийн ерөнхий хэмжээс ойролцоо. Овоолго шороо гаргана.

Үнэлгээ ба үндэслэл
Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).
Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Монголд бүртгэгдээгүй байсан.

2025 онд Мэдээлэл дутмаг (DD). *Ellobius tancrei* зүйлээс тусдаа бие даасан зүйл гэж үзсэн (Lebedev *et al.,* 2020) бөгөөд түүний тархац нутгийн хил хязгаарыг нарийвчлан тогтоогоогүй, судалгаа бага хийгдсэн тул энэ зэрэглэлээр үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Э.Ундрахбаяр, Н.Батсайхан, Д.Лхагвасүрэн, С.Шар, Р.Самъяа (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Зүүн өмнөд Европ, Иран, Казахстан, Туркменистан, Узбекстан болон Монголд тархсан (Rusin, 2023).

Монгол орны тархац, амьдрах орчин. Монгол орны төв болон зүүн өмнөд нутгийн цөл, цөлжүү хээр, заримдаг цөл (8.3), хуурай хээрт (4.4) бутлаг, сөөглөг ургамалтай нам уулс, тэдгээрийн хөндий, тал газрын хуурай, дагжуур хөрстэй газарт амьдарна.



Амьдралын онцлог. Хуурай хээр, заримдаг цөлийн хуурай, дагжуур хөрстэй газарт амьдарна. Газар доогуур ярган амьдрахад зохицсон оготно. Богино нягт, зөөлөн үсэн бүрхүүлтэй. Ил гарч ирэх нь ховор. Гарахдаа харанхуйд гарна. Газрын доорх үүр, хонгилдоо хоногийн турш идэвхтэй. Ургамлын үндсээр голлон хооллоно. Бүлээр амьдарна.

Тоо, толгой, нягтшил. Энэ зүйлийн тоо толгой, нягтшилын талаар мэдээ, баримт хомс.

Ховордлын шалтгаан. Уул уурхайн үйл ажиллагаанаас (1.3.1) үүдэлтэй амьдрах орчны доройтол, хөрсний бохирдол (6.2.6), боловсруулах үйлдвэрлэл (1.4.1) болон зам тээвэр (1.4.4) зэрэг дэд бүтцийн хөгжлийн нөлөөллөөс гадна, дэлхийн дулаарал (6.1.1), ган гачиг (7.1) зэрэг байгалийн хүчин зүйлс энэ зүйлд сөргөөр нөлөөлж болох юм.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутгийн 18% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн тархац нутгийг нарийвчлан тогтоож, биологи, экологи (3.3) болон аюул заналын (3.5) судалгааг тусгайлан хийж, үүний үндсэн дээр хамгаалах арга хэмжээг тодорхойлж, хэрэгжүүлэх нь чухал. Ялангуяа уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой илрэх сөрөг нөлөөллийг (3.4) үнэлэх шаардлагатай.

4.91. ДАВЖАА АЛАГДААХАЙ

Scarturus (Allactaga) elater (Lichtenstein, 1828)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Алагдаахай (Dipodidae)
Англи нэр: Small Five-Toed Jerboa
Ижил нэр: Давжаа алагдаага, *Allactaga elater* (Lichtenstein, 1825); *Dipus elater* (Lichtenstein, 1825).



Ангилал зүйн тойм. Өмнө нь *Allactaga* төрөлд хамааруулж байсан бөгөөд сүүлийн үеийн молекул биологийн судалгаанд үндэслэн *Scarturus* төрөлд хамааруулах болсон. Давжаа алагдаахайн 6 салбар зүйл бүртгэгдсэнээс Монгол оронд *S. e. zaisanicus* Shenbrot, 1991 гэх салбар зүйл нь тохиолдоно (Wilson *et al.,* 2017).

Таних шинж. Биеийн урт 90-120 мм, сүүлний урт 140-190 мм, тавхайн урт 43-58 мм, чихний урт 29-43 мм, жин 32-77 г. Биеийн гадаад төрхөөрөө бусад алагдаахайтай төсөөтэй ч биеэр жижиг харагдана. Нуруун тал нь боровтор элсэн шаргал. Сүүлний цацгийн хар үсний урд цагаан үсгүй шинжээрээ бусад алагдаахайнаас ялгагдана (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Устаж болзошгүй (EN) (Clark *et al.,* 2006).

2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Манай орны хэмжээнд энэ зүйлийн тархац нутаг, амьдрах хэлбэр, популяцийн хэмжээ, төлөв байдал, хандлагын талаарх судалгааны мэдээ, баримт хомс байгаа тул мэдээлэл дутмаг хэмээн үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Д.Лхагвасүрэн, С.Шар, Н.Батсайхан, Э.Ундрахбаяр, Р.Самъяа (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Орос, Азербайжан, Гүрж, Иран, Казахстан, Киргизстан, Узбекистан, Туркменистан, Тажикстан, Афганистан, Хятад болон Монголд тархсан (Shenbrot *et al.,* 2016).

Монгол орны тархац, амьдрах орчин. Зөвхөн Зүүнгарын говь цөлд тархсан (8.3). Наанги шаварлаг юм уу чулуурхаг хөрстэй, хужир, марцтай цөлд байршин амьдарна (Дуламцэрэн, 1989; Shenbrot *et al.,* 2016; Батсайхан нар, 2022).



Амьдралын онцлог. Шөнө идэвхтэй. Ганц амсартай, 1-1.5 м урттай нүхэнд орогноно. Өвөл ичээлнэ. Өвслөг ургамлын навч, үндэс, булцуу, үр зэргээр голдуу хооллоно. Ичээнээс гарсны дараа үржилд орно. Жилд 1 удаа төрж 2-8 зулзага төрүүлнэ (Батсайхан нар, 2022).

Тоо толгой, нягтшил. Тоо толгой, нягтшилын судалгаа байхгүй.

Ховордлын шалтгаан. Тодорхойгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуульд нэн ховор амьтнаар орсон бөгөөд төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр зөвхөн эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх зориулалтаар агнаж, барьж болно (7.2). Үүнээс бусад зориулалтаар нэн ховор амьтныг агнаж бэлтгэсэн арьс, яс, бусад түүхий эдийг худалдах, худалдан авахыг хориглодог (7.3).

Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор батлсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр давжаа алагдаахай 6,500 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу).

Монгол Улсын Улаан номд нэн ховор зүйлээр бүртгэгдсэн (Шийрэвдамба нар, 2013). Энэ зүйлийн тархац нутгийн 67% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн популяцийн тоо толгой, нягтшил, хандлага (3.2), ангилал зүй (3.1), биологи, экологи (3.3) болон аюул заналын (3.5) судалгааг нарийвчлан хийх шаардлагатай.

4.92. КОЗЛОВЫН АТИГДААХАЙ

Salpingotus kozlovi (Vinogradov, 1922)

Баг: Мэрэгчид (Rodentia)
Овог: Алагдаахай (Dipodidae)
Англи нэр: Kozlov's Pygmy Jerboa
Ижил нэр: Ижил нэр үгүй.



Ангилал зүйн тойм. Ангилал зүйн хувьд маргаантай асуудал бага.

Таних шинж. Биеийн урт 68 мм, сүүл 135 мм хүрнэ. Сүүл биеийн уртаас 2 дахин урт бөгөөд нарийн, үсээр жигд хучигдана. Эм нь эрээсээ том. Сүүлний тачир үсэн бүрхүүлд сийрэг байрлалтай урт үс ялгарч харагдах ба сүүлний төгсгөл тийш урт үс илүү нягт байрлалтай. Сүүлний төгсгөлд үл мэдэг цацаг үс илэрнэ. Хойд тавхай 3 хуруутай бөгөөд өтгөн үсээр бүрхэгдэж "сойз" хэлбэртэй болно. Тавхайн үс хумс руугаа чиглэсэн налуу байрлалтай. Мэдрэгч үс урт. Нуруу элсэн шаргал, хэвлий цайвар (Батсайхан нар, 2022).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Ховордож болзошгүй (NT).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Clark *et al.,* 2006).

2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Популяцийн хэмжээ, өсөлт, тархалтын чиг хандлага болон

нүүрлэж буй аюулын талаарх мэдээлэл урьдын адил хангалтгүй байгаа тул мэдээлэл дутмаг гэж үнэлэв.

Үнэлгээ хийсэн: Р.Самъяа, Н.Батсайхан, С.Шар, Д.Лхагвасүрэн, Э.Ундрахбаяр (2025).

Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Хятад (Өвөр Монгол, зүүн Тянь Шаны өмнөд хэсэг, Тарим, Хамын нам дор газар) болон Монголд тархсан (Соколов и др., 1996; Clark *et al.,* 2006; Smith and Yan, 2013)

Монгол орны тархац, амьдрах орчин. Ховор бөгөөд бага судлагдсан зүйл. Алтайн өвөр говь, Зүүнгарын говь, Алашань говь, Дорнод говиос 16 цэгт тэмдэглэсэн (Соколов нар 1996; Батсайхан нар, 2022). Жинхэнэ цөлийн (8.2) төлөөлөгч бөгөөд хэт гандуу цөлөөр ховор. Загтай элсэн манхан, манхан элсний захын сул элстэй хармагтай хотгор, цайдмын захаар байршина. Армаг тармаг заг, хармаг, бударганатай нарийн ширхэгтэй элсэрхэг орчинд илүүтэй байршина.



Амьдралын онцлог. Өвөлдөө ичнэ. Үржил хожуу явагдана. Алтайн өвөр говьд тухайн жилийн залуу бодгаль 7-р сарын дундуур үзэгдэж эхлэх ба 7-р сарын сүүлч, 8-р сарын эхээр элбэгшинэ. Нэг удаад 1-3 зулзага төрүүлнэ. Үржлийн нэг улиралд давтан төрдөг эсэх нь тодорхойгүй. Цаг агаар, идэш тэжээлийн хүрэлцээнээс хамаарч зарим жил үржилд орохгүй тохиолдол бий. Идэш тэжээлд ургамлын үр, шавж зэрэг тэжээллэг зүйл зонхилно. Нүх гүехэн бөгөөд энгийн бүтэцтэй. Ихэвчлэн ганцаар амьдарна (Соколов и др., 1996).

Тоо толгой, нягтшил. Өмнөговийн Гурвантэсээс зүүн тийш загтай элсэн манханд зуны 7-8-р сард 1 га-д 3-4 бодгаль, манханы захын хармагтай хотгор хотост 3-4 бодгаль, элсэрхэг хайргатай орчинд 5 бодгаль хүртэл тохиолдоно. Баяндалай сумаас зүүн тийш 68 км-т 1984 оны 7-р сард шөнийн 1 цагийн явган замналд 6 бодгаль, Номгоны Таван алдын худаг орчимд загтай элсэн довцог дундуур 1 цагийн хугацаанд 8 бодгалийг тус тус барьж байв (Соколов и др., 1996).

Ховордлын гол шалтгаан. Уул уурхайн (1.3.1) нөлөөгөөр амьдрах орчинд доройтол үүсэх, ган гачиг (7.1) зэрэг байгалийн хүчин зүйл Козловын атигдаахайн амьдралд сөрөг нөлөө үзүүлэх үндэслэлтэй боловч баталгаатай тогтоогдоогүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуульд заасны дагуу Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор баталсан Ховор амьтны жагсаалтад орсон бөгөөд ховор амьтныг төрийн захиргааны төв байгууллагаас олгосон зөвшөөрлөөр (7.5.1) судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, эмчилгээний зориулалтаар агнаж, барьж болно.

Мөн Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр Козловын атигдаахай 6,000 төгрөг. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу).

Монгол Улсын Улаан номд ховор зүйлээр бүртгэгдсэн (Шийрэвдамба нар, 2013). Энэ зүйлийн тархац нутгийн 41% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн популяцийн төлөв байдал (3.2), биологи, экологи (3.3), амьдрах орчны (3.4) судалгааг нарийвчлан хийж, учирч болзошгүй аюулыг (3.5, 5.6) тогтоож, энэ бүгдийн үндсэн дээр хамгааллын арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх нь зүйтэй.

4.93. МАНГИС ДОРГО

Arctonyx collaris (Cuvier, 1825)

Баг: Мах идэштэн (Carnivora)
Овог: Суусар (Mustelidae)
Англи нэр: Hog Badger
Ижил нэр: *A. consul*, *A. obscurus*, *A. taxoides* (Wilson and Reeder, 2005).



Ангилал зүйн тойм. Мангис дорго *Arctonyx collaris* Cuvier, 1825 гэх нэг зүйл манай оронд бий.

Таних шинж. Дорго нь Mustelidae овгийн богино хөлтэй, бахим, мах идэштэн амьтан юм.

Үнэлгээ ба үндэслэл
Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).
Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Мэдээлэл дутмаг (DD) (Clark *et al.,* 2006).
2025 онд Мэдээлэл дутмаг (DD). Энэ зүйлийн тархац нутаг, популяцийн хэмжээ, төлөв байдал, хандлага, учирч буй аюулын талаарх судалгааны мэдээ, баримт хангалтгүй байгаа тул энэ зэрэглэлээр үнэлэв.
Үнэлгээ хийсэн: Б.Мөнхцог (2025).
Үнэлгээг хянасан: С.Гомбобаатар, Д.Өсөхжаргал (2025).

Дэлхийн тархац. Хятад, Энэтхэг, Монгол, Бутан, Мьянмар, Тайланд, Малайз, Индонез, Лаос, Камбож, Вьетнамд тархсан (https://www.mammaldiversity.org).

Монгол орны тархац, амьдрах орчин. Энэ зүйлийн арьсыг Монгол орны зүүн хэсгээс 1980-аад онд олсон (Stubbe *et al.,* 1998).



Амьдралын онцлог. Ууртай догшин авиртай ба өөрийгөө болон үр зулзагаа хамгаалахад энэ зан төрх сайн илэрдэг. Мэрэгчдийн нүхийг араас нь мөшгөн гайхалтай хурднаар ухдаг ба идэш хоолоо нууж нөөцөлнө. Үржлийн тухай мэдээ, баримт байхгүй.

Тоо толгой, нягтшил. Энэ зүйлийн тархац нутаг, популяцийн тоо толгой, нягтшил, хандлагын талаарх мэдээ, баримт хангалтгүй.

Ховордлын гол шалтгаан. Ховордлын гол шалтгааны талаарх мэдээлэл хангалтгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд тухайлбал, энэ хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2-т зааснаар амьтны жим дээр нүх ухах, буу сойх, занга, сааль тавих, (10.1.5) амьтныг агаарын болон авто тээврийн хэрэгслээр хөөх, гэрэлтүүлэх, (10.1.8) ан агнах зориулалтын бус буу, сум хэрэглэх зэрэг арга, зэвсэг хэрэгслээр агнах, барихыг хориглосон.

Мөн Засгийн газрын 2023 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр мангис дорго 1,200,000 төгрөг. Ахуйн зориулалтаар агнах, барих тохиолдолд энэ экологи-эдийн засгийн үнэлгээний 20-40%-аар тооцож амьтны нөөц ашигласны төлбөрийг төлнө. Хэрвээ хууль тогтоомж зөрчвөл энэ үнэлгээг хоёр дахин өсгөж (37.2) амьтны аймагт учирсан хохирлыг нөхөн төлүүлж (37.1), хуульд заасан хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу).

Энэ зүйлийн тархац нутгийн 1% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагджээ.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн популяцийн төлөв байдал (3.2), биологи, экологи (3.3), амьдрах орчин (3.4) болон учирч болзошгүй аюул (3.5, 5.6) зэргийн судалгааг нарийвчлан хийх шаардлагатай. Үүний үндсэн дээр хамгааллын арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх нь зүйтэй.

4.94. ШОВХЧИХТ БАГВААХАЙ

Myotis blythii (Tomes, 1857)

Баг: Гардалавчтан (Chiroptera)
Овог: Багваахай (Vespertilionidae)
Англи нэр: Lesser Mouse-eared Myotis
Ижил нэр: *Myotis oxygnathus* Monticelli, 1885.



Ангилал зүйн тойм. Оросын баруун хойд Алтайд *Myotis blythii altaicus* (Dzeverin and Strelkov, 2008) гэх салбар зүйл тархсан (Дзеверин и Стрелков, 2008) гэж үздэг бөгөөд харин манай орны хувьд салбар зүйлийн судалгааг хийх шаардлагатай.

Таних шинж. Төрөл дотроо харьцангуй том биетэй, чихний цэцэг нь өргөн, үзүүр нь мохоодуу, толгойн нүүрний хэсэг нүцгэн, арьс ягаан, тавхайн урт шилбэний хагасаас илүү, далавч том, өргөн. Далавчны сарьсны хормой хойд хөлийн хуруугуны угаар холбогдоно. Үсний урт жигд бус, уг нь хар, нуруу саарал, саарал шаргалаас цайвар хүрэн, хэвлий цайвар саарал. Нүд болон хамрын хоорондын том биш хос төвгөртэй. Тавхайн урт нь шилбэний хагастай бараг тэнцүү, унжир маш нарийн, богино (Ариунболд, 2018; Dolch *et al.,* 2021a).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Монголд бүртгэгдээгүй байсан.

2025 онд Үнэлэх боломжгүй (NA). Энэ зүйл Монгол орноос цор ганц бодгаль тэмдэглэгдсэн тул тархац, популяцийн тоо толгой, хандлага, учирч буй аюулын талаарх мэдээ, баримт хангалтгүй.

Үнэлгээ хийсэн: Ж.Ариунболд, Д.Мөнхнаст (2025).

Үнэлгээг хянасан: Н.Батсайхан, С.Гомбобаатар (2025).

Дэлхийн тархац. Өмнөд Европ, Өмнөд Франц, Португали, Испани, Австри, Чех, Словак, Өмнөд Украин, Кавказ, Газар дундын тэнгис, Балканы орнууд, Турк, Ойрх Дорнод, Иран, Ирак, Афганистан, Төв Ази, Өмнөд Туркестан, Казахстан, Узбекстан, Киргиз, Тажикстан, Алтайн уулс, Зүүн хойд Хятад, Өвөр Монгол, Палестин, Иран, Энэтхэг, Хойд Африк, Мороко, Умард Алжир, Тунист тархсан (Horačeк *et al.,* 2000).

Монгол орны тархац, амьдрах орчин. Ховдын Булган голын саваас ганц бодгалийг барьж тэмдэглэсэн (Ариунболд, 2018; Dolch *et al.,* 2021a). Байшингийн дээврийн хөндий, агуй, заримдаа модны хөндийд орогноно (Smith *et al.,* 2010).



Энэ зүйлийг барьж тэмдэглэсэн голын сав дагуу лавр навчит улиас (*Populus laurifolia*) бүхий хад чулуут өндөр уулсын хөндий нь д.т.д 1437 м өндөртэй, боржин чулуут өндөр уулын хаяа (6) байв (Ариунболд, 2018).

Амьдралын онцлог. Монгол оронд судлагдаагүй. Энэ зүйл багваахай хэдэн зуу, хэдэн мянгаар тоологдох том бөөгнөрөл үүсгэнэ (Афанасьев и др., 1953).

Тоо толгой, нягтшил. Монгол оронд энэ зүйлийн популяцийн хэмжээ, нягтшилын талаарх судалгаа байхгүй.

Ховордлын шалтгаан. Ховордлын гол шалтгааны талаарх мэдээлэл хангалтгүй. Амьдрах орчны алдагдал (1), агуйн эвдрэл (7.7), аялал жуулчлал (10.1.) зэрэг хүчин зүйлс нөлөөлөх боломжтой ч судалгааны баримт үгүй.

Хамгаалсан байдал. Амьтны тухай хуулиар түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулсан бөгөөд хэрвээ хууль тогтоомж зөрчвөл хариуцлага хүлээлгэдэг (1.1-ээс харна уу). Энэ зүйлийн тархац нутаг Булган гол-Их Онгогийн байгалийн цогцолборт газарт хамаарна.

Хамгаалах арга хэмжээ. Энэ зүйлийн тархац нутаг, популяцийн тоо толгой, хэмжээ, хандлага (3.2), биологи, экологи (3.3) болон аюул занал (3.5) болон өвчин, эмгэг үүсгэгч, шимэгчид (5.5) зэргийн талаарх судалгааг нарийвчлан хийх шаардлагатай.

4.95. СТРЕЛКОВЫН СООТОН БАГВААХАЙ

Plecotus strelkovi (Spitzenberger, 2006)

Баг: Гардалавчтан (Chiroptera)
Овог: Багваахай (Vespertilionidae)
Англи нэр: Strelkov's Long-eared Bat
Ижил нэр: Хиргис соотгой



Ангилал зүйн тойм. Энэ зүйл баруун Азийн *Plecotus austriacus wardi* (Thomas, 1911) гэх салбар зүйлд хамаардаг байсан бөгөөд хожим Spitzenberger нар (2006) морфологи, молекул генетикийн судалгааны үр дүнд бие даасан зүйл болохыг тогтоосон.

Таних шинж. Биеийн урт 46-65 мм, шууны урт 42-49 мм, жин 6.2-9.3 г. Хоншоор хар, сарьс бор хүрэн, бие хүрэн сааралдуу. Нурууны үс сааралдуу, мөн үл мэдэгдэм хүрэн шаргал туяатай. Хүзүү, чихний уг орчмын үсэн бүрхүүл хэвлийн адил цагаан, цайвар (Spitzenberger *et al.,* 2006; Dolch *et al.,* 2021b).

Үнэлгээ ба үндэслэл

Олон улсын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй (LC).

Бүс нутгийн үнэлгээ: 2006 онд Монголд бүртгэгдээгүй байсан.

2025 онд Үнэлэх боломжгүй (NA). Одоогоор хоёр байршилд, цөөн тоотой бодгаль тэмдэглэгдсэн. Дэлхийн тархалтын зүүн

хойд зах нь манай орон болно. Энэ зүйлийн тархац, популяцийн тоо толгой, хандлага, учирч буй аюул заналын талаарх мэдээлэл дутмаг тул энэ зэрэглэлээр үнэлэв.
Үнэлгээ хийсэн: Ж.Ариунболд, Д.Мөнхнаст (2025).
Үнэлгээг хянасан: Н.Батсайхан (2025).

Дэлхийн тархац. Афганистан, Хятад, Иран, Казахстан, Киргизстан, Монгол, Тажикстанд тархсан (Srinivasulu *et al.,* 2020).

